

# Оршил судалгаа

# Төсөөлөл ба ойлголт

***(1 Хичээл)***

***Зэвсэгт мөргөөлдөөний талаар таны төсөөлөл юу вэ?***

***Зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэх зовлон, хүндрэл, бэрхшээлийг хязгаарлах оролдлогуудын талаарх таны бодол?***

***Хүний нэр хүнд гэж юу вэ?***

## ТӨСӨӨЛӨЛ БА ОЙЛГОЛТ:

Сурагчид зэвсэгт мөргөлдөөний талаар болон түүнийг хязгаарлах оролдлогуудын талаар юу мэдэж, юу бодож явдаг талаар мэдэж авах . . . . . . . . . . . . . . . . . . . . . 18

## ОЙЛГОЛТУУД:

Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт
Хүний нэр хүнд

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Хэлэлцүүлэг
Сонсох
Хүндэтгэлтэйгээр санал үл нийлэх
Үндэслэлтэйгээр бусдын санал бодлыг дэмжих

**ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙГ СУДЛАХ НЬ**
**ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА**

**ОРШИЛ:**

Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт

**БҮЛЭГ 1: ХҮМҮҮНЛЭГИЙН ТӨЛӨВ**

Судалгаа 1A: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ? [хүмүүнлэгийн үйлсийн жишээ]

Судалгаа 1B: Хүмүүнлэгийн үйлс [дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой]

Судалгаа 1C: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма [жишээ дилемма]

**БҮЛЭГ 2: ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ**

Судалгаа 2A: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах [фото зураг, зургийн эвлүүлэг, үндсэн дүрэм]

Судалгаа 2B: Түүхэн хууль дүрмүүд [дайны тухай хуулиуд]

Судалгаа 2C: “Цэрэг” хүүхдүүд [зургийн эвлүүлэг, дүрс бичлэг, газрын зураг]

Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина [дүрс бичлэг, газрын зураг]

**БҮЛЭГ 3: ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Судалгаа 3A: Зөрчлийг тодорхойлох нь [дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой]

Судалгаа 3B: Байлдагчийн байр сууринаас харахад [жишээ дилемма]

Судалгаа 3C: Хэн хариуцлага хүлээх вэ?

Судалгаа 3D: Хэргийн судалгаа – Ми Лай [дүрс бичлэг ба дүрд тоглох]

**БҮЛЭГ 4: ШУДАРГА ЁСНЫ БАТАЛГАА**

Судалгаа 4A: Шударга ёсны суурь шалтгаан [уншлага]

Судалгаа 4B: Олон улсын шүүхийн хувьсал [уншлага]

**БҮЛЭГ 5: ДАЙНЫ ҮР ДАГАВРУУДАД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ НЬ**

Судалгаа 5A: Дайны хор хөнөөлөөс үүдэн гарах хэрэгцээ [зургийн эвлүүлэг]

Судалгаа 5B: Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх

Судалгаа 5C: Хоригдлуудыг хамгаалах [дүрс бичлэг]

Судалгаа 5D: Гэр бүлийн холбоог сэргээх [зургийн эвлүүлэг]

Судалгаа 5E: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй [жишээ дилемма]

**ТӨГСГӨЛ:**

Дүгнэлт судалгаа: Цаашид юу хийх хэрэгтэй вэ? [дүрс бичлэг]

## Хичээлийн агуулга

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| НИЙТ БҮЛГҮҮДЭД | | | | |
|---|---|---|---|---|
| ОЙЛГОЛТУУД | УР ЧАДВАРУУД | | | |
| Хүний нэр хүнд<br>Хүмүүнлэгийн зан үйлд учрах саад тотгорууд<br>Дилемма<br>Үр дагавар<br>Олон талт төлөв байдал | Хэлэлцүүлэг<br>Сонсох<br>Хүндэтгэлтэйгээр санал үл нийлэх<br>Үндэслэлтэйгээр бусдын санал бодлыг дэмжих<br>Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх<br>Эрх зүйн үндэслэл | Төлөвшил<br>Дүрд тоглох<br>Түүхэн үйл явдалд анализ хийх<br>Түүхэн үйл явдлыг ярих<br>Дилеммад анализ хийх<br>Асуудлыг тодорхойлох | Үр дагаврыг тодорхойлох<br>Үр дагаврыг илрүүлэх<br>Асуудалд анализ хийх<br>Хэрэгцээг тодорхойлох<br>Шийдвэр гаргах<br>Тэмдэглэл хөтлөх | Хамрах хүрээг тооцоолох<br>Хүчин чармайлтыг тооцоолох<br>Бүлгээр ажиллах<br>Төлөвлөлт<br>Төслийн үнэлгээ |

### БҮЛГҮҮД

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| ОРШИЛ СУДАЛГАА | Зэвсэгт мөргөлдөөний талаар таны төсөөлөл юу вэ?<br>Зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэх гачигдал зовлон, хүндрэл бэрхшээлийг хязгаарлах оролдлогуудын талаарх таны бодол?<br>Хүний нэр хүнд гэж юу вэ? | Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт<br>Хүний нэр хүнд<br>Дилемма | Төсөөлөл ба ойлголт | ◆ Хүмүүнлэгийн эрх зүйн суурь, үндсэн ойлголтуудын талаар мэдэж байх.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүйг судлах явцад тулгарах зарим асуултуудад хариулахад амаргүй гэдгийг мэдэж байх.<br>◆ Хүний нэр хүндийг урьдчилан тодорхойлох. | ◆ Хүний нэр хүнд гэдэг ойлголт хамгийн чухал бөгөөд энэхүү гарын авлагад (“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь”) дахин дахин хөндөгдөх болно.<br>◆ Хүмүүнлэгийн Эрх Зүйг судлах явцад тулгарах зарим асуултуудад зөвхөн ганц зөв хариулт, эсвэл амархан хариулт гэж байхгүй. Энэхүү гарын авлагын нэг зорилго нь ийм асуултуудыг тодорхойлж судлахад оршино. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 1<br>Хүмүүнлэгийн төлөв | Хөндлөнгөөс ажиглагч гэдэг нь?<br>Хөндлөнгөөс ажиглагчдад ямар дилемма тулгардаг вэ?<br>Хөндлөнгөөс ажиглагчид ямар нөлөө үзүүлж чадах вэ?<br>Хүмүүнлэгийн үйлсийн мөн чанар юу вэ? | Хөндлөнгөөс ажиглагч<br>Хүмүүнлэгийн үйлс<br>Нийгмийн дарамт | 1A<br>Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ? | ◆ Хөндлөнгөөс ажиглагчийн зүгээс бусдын үйлдэлд үзүүлж болох нөлөөг ойлгох.<br>◆ Хүчирхийллийн үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үйлдэл хийж буй хөндлөнгөөс ажиглагчийн жишээг мэдэж байх. | ◆ “Хөндлөнгөөс ажиглагчид” гэдэг нь хүчирхийллийн үед үл таних хүмүүсийн амь нас, нэр хүндийг хамгаалахын тулд аливаа үйлдэл хийж чаддаг энгийн хүмүүсийг хэлнэ.<br>◆ Хөндлөнгөөс ажиглагчид нь ихэвчлэн өөрт учирч болох хохирол, эрсдэлийг үл харгалзан үйл ажиллагаанд оролцдог.<br>◆ Энгийн хүмүүс хаана ч байсан эмзэг хүмүүсийг хамгаалан хүнлэг бус үйлдлийн эсрэг зогсдог. |
| | | | 1B<br>Хүмүүнлэгийн үйлс | ◆ Хүмүүнлэгийн үйлсийн тухай ойлголт.<br>◆ Аливаа хүний амь нас, нэр хүнд эрсдэлтэй үед юу хийх вэ гэдэг талаар нийгмийн зүгээс учруулах дарамт нөлөөллийг ойлгох.<br>◆ Мэдээ, мэдээлэл болон өдөр тутмын амьдрал дахь хүмүүнлэгийн үйлсийг ялган таних чадвартай болох. | ◆ “Хүмүүнлэгийн үйлс” гэдэг нь ихэвчлэн ердийн нөхцөлд хамгаалагдаад байдаггүй, амь нас, нэр хүндэд нь аюул тулгарсан хүмүүсийг хамгаалахаар хийгдэж буй үйлдлийг хэлнэ. Ихэнх тохиолдолд эрсдэлтэй байдаг.<br>◆ Хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилго бүхий хүмүүнлэгийн үйлс нь зарим нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан бэрхшээлтэй учирдаг. |
| | | | 1C<br>Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма | ◆ Хүний нэр хүндэд аюул учрах үед байлцсан хөндлөнгөөс ажиглагчдад тулгарч болох хүндрэлүүдийг таньж мэдэх.<br>◆ Дилеммад анализ хийж сурах. | ◆ Ихэнх хүмүүнлэгийн үйлсийн үед хүн өөрөө эрсдэлд орох, эсвэл өөрт нь буюу хамгаалах гэсэн хүнд нь янз бүрийн гарз учирч болзошгүй учир хамгаалах уу, болих уу гэсэн сонголт хийх хэцүү байдалд ордог.<br>◆ Аль ч сонголт нь хамаарах хүмүүст төвөгтэй, удаан хугацаанд үргэлжлэх үр дагаврыг авчирч болно. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 2<br>Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт | Ямар хязгаарлалтууд хэрэгтэй байдаг вэ? Яагаад?<br>Эдгээр хязгаарлалтууд хаанаас хийгддэг вэ?<br>Дайныг хязгаарлах хуулиуд хэрхэн бий болдог вэ? | Дайны хязгаарлалт<br>Энгийн иргэд, байлдагч бус хүмүүс (байлдаанд оролцохооргүй болсон хүмүүс)<br>Хүний эрх<br>Хамгаалалт<br>Хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ<br>Үл ялгаварлах зэвсэг<br>Долгионт үр нөлөө | 2A<br>Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах | ◆ Зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй мөрдөгдөх дүрмийн зарим шалтгааныг ойлгож авах.<br>◆ Хүний эрхийн хууль болон хүмүүнлэгийн эрх зүйн харилцан нөхөх чанарыг ойлгож авах.<br>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим үндсэн дүрмүүдийг мэдэж байх. | ◆ Хүмүүнлэгийн эрх зүй нь зэвсэгт мөргөлдөөний үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилготой. Энэ нь хэрэгцээгүй зовлон шаналлыг багасгах, түүнчлэн байлдагч бус хүмүүс ялангуяа байлдаанд оролцохоо больсон хүмүүсийг хамгаалахын тулд дайны арга, хэрэгслийг хязгаарлах замаар хэрэгжинэ.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүй болон хүний эрхийн хууль аль аль нь хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үндсэн зорилготой. Хүмүүнлэгийн эрх зүй нь зөвхөн зэвсэгт мөргөлдөөн зэрэг тодорхой нөхцөл байдалд үйлчлэхээр зохиогдсон байдаг бол хүний эрхийн хууль нь ямар ч үед хэрэглэгддэг. |
| | | | 2B<br>Түүхэн хууль дүрмүүд | ◆ Янз бүрийн газар нутаг, цаг үед хүмүүс зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах зорилгоор хууль дүрэм боловсруулсаар ирсэн гэдгийг мэдэж авах.<br>◆ Өмнөх үеийн хуулиудад заасан хориглолт, шаардлагуудын зарим жишээг мэдэж байх.<br>◆ Хүмүүнлэгийн хэм хэмжээний хувьсал болон үйл явдлуудын хоорондох харилцааг танилцуулах. | ◆ Дайны гай зовлонг хязгаарлах гэж ертөнцийн өнцөг булан бүрт хүмүүс хичээн зүтгэж байна.<br>◆ Хэрэгцээгүй зовлон шаналлыг багасгаж, эвдрэл сүйрлийг хазаарлахын тулд хүч хэрэглэхийг хориглосон хууль дүрэм байсныг түүх гэрчилдэг. |
| | | | 2C<br>“Цэрэг” хүүхэд | ◆ Хүүхдүүдийг байлдагч болгон ашиглаж байгаа практик аргын хэм хэмжээ, түүний үр дагаврын талаар мэдэж байх.<br>◆ Цэрэгт элсүүлэх насны доод хязгаарыг тогтоох шаардлагыг ойлгох.<br>◆ 15-аас доош насны хүүхдүүдийг зэвсэгт бүлэгт элсүүлэх нь хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн хэрэг бөгөөд одоогоор насны доод хязгаарыг өсгөн 18 болгохоор хүчин чармайж байгаа талаар мэдэж авах. | ◆ Зэвсэгт мөргөлдөөний үед хүүхдүүдийг хамгаалах ёстой. Цэрэгт элсүүлэх насны доод хязгаарыг тогтоох нь хамгаалалтын нэг хэлбэр юм.<br>◆ Олон улсын жишгээр насны доод хязгаар 15 байдаг. “Сайн дурын” ч бай, хүчээр ч бай 15-аас доош насны хүүхдүүдийг цэрэгт элсүүлэх нь дайны гэмт хэрэг юм.<br>◆ Олон улс даяар одоогийн байдлаар насны доод хязгаарыг өсгөн18 болгохоор хүчин чармайж байна. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 2<br>Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт *(үргэлжлэл)* | | | 2D<br>Хүний эсрэг газрын мина | ◆ Үл ялгаварлах бөгөөд хэрэгцээгүй зовлон шаналал учруулдаг тодорхой төрлийн зэвсгүүдийг ямар учраас хориглодгийг ойлгох.<br>◆ Газрын минийг хэрэглэснээр гарах үр дагаврыг (“долгионт үр нөлөө”) илрүүлэх чадвартай байх.<br>◆ Олон нийтийн үзэл бодол, тэднийг дайчлах нь хэрхэн хүмүүнлэгийн эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулж болох талаар ойлголттой байх. | ◆ Газрын мина, биологийн ба химийн зэвсэг нь байлдагчид болон энгийн иргэдийг үл ялгаварлах бөгөөд хэрэгцээгүй зовлон шаналал авчирдаг учраас эдгээрийг хориглодог.<br>◆ Газрын минад өртөгсөд эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохироод зогсохгүй хувь хүмүүс, тэдний гэр бүл, ойр орчныхон, улмаар улс орон болон олон улсын нийгэмлэг нийгэм, эдийн засгийн хор уршгийг амсдаг.<br>◆ Газрын минийг үйлдвэрлэх, хэрэглэхийг хориглох тухай 1997 оны Оттавагийн гэрээ нь олон нийтийг дайчилсны үр дүнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хувьсан хөгжиж болдгийн нэг жишээ юм. |
| БҮЛЭГ 3<br>Хуулийн хэрэгжилт | Ихэвчлэн ямар дүрэм зөрчигддөг? Яагаад?<br>Байлдагчид ямар дилемматай тулгардаг вэ?<br>Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн биелүүлж байгааг хянах хариуцлагыг хэн хүлээх вэ? | Хуулийн зөрчил<br>Энгийн иргэн/байлдагчийн ялгаа<br>Гинжин нөлөө | 3A<br>Зөрчлийг тодорхойлох нь | ◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим зөрчлүүдийг таньж мэдэх чадвартай байх.<br>◆“Гинжин нөлөө” бүхий үр дагаврын тухай ойлголтыг хэрэглэн зөрчил зөрчлөө төрүүлдгийг жишээгээр танин мэдэх. | ◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дүрмүүд нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд хэрэглэгдэхээр тусгайлан зохиогдсон байдаг.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлүүд нь ихэвчлэн дараа дараагийн зөрчлүүдийн гинжин нөлөөг үүсгэж байдаг.<br>◆ Хүмүүс зарим зөрчлүүдэд янз бүрийн шалтгаан байдаг гэж үздэг, тухайлбал өшөө авах, хүмүүс олноор суурьшсан газар байлдах, энгийн иргэд дайснуудад тусалж байна гэж бодох, дээд албан тушаалтнуудын хууль бус захирамж тушаал зэрэг орно. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 3<br>Хуулийн хэрэгжилт<br>*(үргэлжлэл)* | | | 3B<br>Байлдагчийн байр сууринаас харахад | ◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг дагаж мөрдөх нэг зорилго нь тулалдааны нөхцөлд гарч болох дилемма, үр дагаврууды таньж мэдэх.<br>◆ Энгийн иргэн ба байлдагч этгээдийн ялгаа тодорхой бус үед хүмүүнлэгийн эрх зүйг сахихад гарах бэрхшээлүүдийг таньж мэдэх. | ◆ Зэвсэгт мөргөлдөөний үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дүрмүүдийг дагаж мөрдөхөд янз бүрийн дилемма учирдаг.<br>◆ Энгийн иргэд болон байлдагчдыг ялгахад хэцүү учраас олон дилемма үүсдэг.<br>◆ Заримдаа хүмүүс энэ ялгааг санаатайгаар бүрхэг болгодог бол бусад тохиолдолд хүмүүс суурьшсан газар байлдах үед энэ ялгаа нь өөрөө тодорхой бус болдог. |
| | | | 3C<br>Хэн хариуцлага хүлээх вэ? | ◆ Эдгээр дүрмүүдийг сахиж мөрдөж байгаа эсэхийг хянах үүргийг цэргийн ямар хүмүүс хүлээдэг талаар ойлголттой байх.<br>◆ Энэ үүрэг хариуцлагыг хэрхэн биелүүлдгийг тодорхойлох. | ◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн сахихад олон хүний гүйцэтгэх ёстой үүрэг хариуцлага гэж бий. Хэдийгээр ганц хүн дангаараа хүмүүнлэгийн эрх зүйг зөрчиж чадах боловч, уг эрх зүйг хүндэтгэн сахиж буйг баталгаажуулахад засгийн газрын түшмэлүүд, цэргийн удирдагчид, байлдагч зэрэг хүмүүсийн хамтын хүчин чармайлт шаардлагатай.<br>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хөхиүлэн дэмжих нь аливаа үндэстний эрхэм дээд эрх ашигт нийцнэ. |
| | | | 3D<br>Хэргийн судалгаа —<br>Ми Лай:<br>Юу нь буруудсан?<br>Юу нь зөвдсөн? | ◆ Хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчил тохиолдоход энгийн хүмүүс ямар хариу үйлдэл хийдэг талаар ойлголттой байх.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүйн хэрэгжилт, албадан хэрэглэхтэй холбогдсон зарим дилемма, асуудлуудыг ойлгож авах. | ◆ Байлдагч хүмүүс эрх зүйн бус тушаалыг биелүүлэх албагүй.<br>◆ Орчин үеийн байлдааны бодит нөхцөл байдал нь хүмүүнлэгийн эрх зүйг хэрэгжүүлэхэд төвөг учруулж болдог.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн өөрийн цэргийн хүчний гишүүдийг шударгаар шүүхэд улс орнуудад бэрхшээл тулгарч болдог. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 4<br>Шударга ёсны баталгаа | Яагаад шударга ёс хэрэгтэй байдаг вэ?<br>Шударга ёсонд яаж хүрэх вэ?<br>Яллагдагчийг хэн шүүх ёстой вэ? | Хэрэгжилт<br>Албадан хэрэглэх<br>Энгийн иргэн/ байлдагчийн ялгаа<br>Эрх зүйн бус захирамж тушаал<br>Нийгмийн дарамт<br>Хувь хүний хариуцлага<br>Удирдагчийн хариуцлага<br>Дайны гэмт хэрэг<br>Шүүхэд оролцох эрх, тавигдах шаардлага | 4A<br>Шударга ёсны суурь шалтгаан | ◆ Хүмүүнлэгийн эрх зүйг зөрчигчдийн эсрэг арга хэмжээ авах нь зэвсэгт мөргөлдөөний дараах нийгмийн сайн сайханд хэрхэн нөлөөлж болохыг ойлгож авах. | ◆ Хүмүүнлэгийн эрх зүй нь уг хуулийг ноцтойгоор зөрчигч буюу зөрчихийг тушаасан этгээдийг шударгаар шүүхийг шаарддаг.<br>◆ Женевийн Конвенцид нэгдсэн улс бүр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг түгээн дэлгэрүүлэх, хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг. |
| | | | 4B<br>Олон улсын шүүхийн хувьсал | ◆ Дайны гэмт хэрэгтнүүдийг шударгаар шүүх гэсэн олон улсын хүчин чармайлтын хувьсал хөгжлийг ойлгох.<br>◆ Дайны гэмт хэрэгтэй холбоотой зарим асуудлуудыг мэдэж байх. | ◆ Дайны гэмт хэргийг шүүж шийтгэх эрх мэдлийг хэнд хариуцуулахтай холбоотой олон асуудлуудыг шийдэх явцад олон улсын эрүүгийн шүүх үүсч хөгжсөн.<br>◆ Шүүгчид гэм буруутайг тогтоохдоо шүүгдэгч этгээд яллагдаж буй эрх зүйн зөрчлийг санаатайгаар үйлдсэн эсэхийг харгалзан үздэг. Бусдын тушаалаар үйлдсэн буюу ижил төстэй зөрчлийн урьдах жишээ нь хууль зөрчигчийг гэм буруугаас чөлөөлөх шалтгаан болж чадахгүй. |
| БҮЛЭГ 5<br>Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь | Дайны үр дагаврууд гэж юу вэ?<br>Тэдгээрт хариу үзүүлэхэд ямар хүчин чармайлт шаардагддаг вэ?<br>Хүмүүнлэгийн үйл ажиллагааны явцад ямар дилемма гардаг вэ? | Үндсэн хэрэгцээ<br>Материаллаг бус хэрэгцээ<br>Дүрвэгсэд, шилжин нүүсэн хүмүүс<br>Төвийг сахих үзэл<br>Шударга байдал | 5A<br>Дайны хор хөнөөл, сүйрлээс үүдэн гарах хэрэгцээ | ◆ Дайн дажин амьдралын ердийн хангамжийг хэрхэн алдагдуулдаг талаар ойлгож авах.<br>◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас үүсэх гай зовлонгоос сэргийлэх, зовлонг нимгэлэхэд шаардлагатай хүмүүнлэгийн үйл ажиллагааны цар хүрээг мэдэж байх. | ◆ Зэвсэгт мөргөлдөөн их хэмжээний эд баялагийн хохирол авчирч, амьдралын ердийн хангамжийг алдагдуулдаг.<br>◆ Зэвсэгт мөргөлдөөний үед хүний амь нас, нэр хүндэд аюул учирч, улмаар тусгай хамгаалалт хэрэгтэй болдог.<br>◆ Хүмүүнлэгийн байгууллагууд хамтран ажилласнаар амьдралын ердийн хангамжийг нөхөн сэргээж чаддаг. |

# ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 5<br>Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь<br>*(үргэлжлэл)* | | | 5B<br>Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх | ◆ Аюулгүй байдал зэрэг шилжин нүүлтээс үүсэх хэрэгцээ шаардлагыг хангахад хэр хэмжээний хүчин чармайлт хэрэгтэйг мэдэж авах.<br>◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ, шаардлагыг хангахад туслах, хамгаалах үйл ажиллагааны олон талыг ойлгож авах. | ◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахад асар их төлөвлөлт, хүчин чармайлт шаардагддаг.<br>◆Ус, хүнс, орон байр, эмнэлэгийн тусламж зэрэг зайлшгүй биологийн хэрэгцээнээс гадна нийгэм, сэтгэл зүйн хэрэгцээг хангах шаардлага гардаг. Эдгээр нь хүнийг аль болох бие даасан байдлаа даруй сэргээхэд нь туслах зорилготой. |
| | | | 5C<br>Хоригдлуудыг хамгаалах | ◆ Хоригдлуудын амь нас, нэр хүндийг хамгаалах хүмүүнлэгийн эрх зүйн зарим аргуудыг мэдэж авах.<br>◆ Хоригдлуудыг хамгаалахад хүмүүнлэгийн ажилтнуудад учирдаг зарим дилеммаг ойлгох. | ◆ Зэвсэгт мөргөлдөөний үеэр олзлогдон, хоригдсон хүмүүсийн амь нас, нэр хүнд эрсдэлтэй байдаг.<br>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хоригдлуудыг хамгаалахыг, мөн дээрх хамгаалалтыг баталгаажуулах зорилгоор хүмүүнлэгийн төлөөлөгчид тэднийг шоронд эргэж очихыг шаарддаг.<br>◆ Хоригдлуудыг эргэж буй хүмүүнлэгийн ажилтнуудад шийдэхэд хэцүү дилемма олон тулгардаг. |
| | | | 5D<br>Гэр бүлийн холбоог сэргээх | ◆ Дайнаас болж тарж бутарсан гэр бүлийнхний хүнд нөхцөл байдлын талаар мэдэж байх.<br>◆ Дайнаас болж тарж бутарсан гэр бүлийнхнийг дахин нэгтгэхэд шаардлагатай хүчин чармайлтын хэм хэмжээний талаар ойлгож авах. | ◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас олон тооны хүмүүс гэр бүлийнхнээсээ холбоо барих ямар ч аргагүйгээр хагацдаг.<br>◆ Хүмүүнлэгийн эрх зүй нь тарж бутарсан гэр бүлийнхнийг дахин нэгтгэх зэргээр гэр бүлийн холбоог сэргээх, хэвээр үлдээх үйл ажиллагааг шаарддаг.<br>◆ Гэр бүлийн гишүүдийг олж тогтоон дахин нэгтгэх нь олон үе шаттай. |

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

| БҮЛЭГ | АСУУЛТ | ОЙЛГОЛТ | СУДАЛГАА | ЗОРИЛТ | ГОЛ САНАА |
|---|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 5<br>Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь<br>*(үргэлжлэл)* | | | 5E<br>Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй | ◆ Хүмүүнлэгийн үйл ажиллагааны удирдамж болох “төвийг сахих” болон “шударга” зэрэг зарим зарчмуудыг мэдэж байх.<br>◆ Хүмүүнлэгийн ажилтан үүрэгт ажлаа явуулж байх үед тулгарах зарим дилеммаг ойлгох. | ◆ Хүмүүнлэгийн байгууллагуудад зан үйлийн зарим төрөлжсөн хууль дүрэм шаардлагатай байдаг.<br>◆ Хүмүүнлэгийн ажилтан мөргөлдөгч талуудын итгэлийг олж авахын тулд төвийг сахиж, шударга ёсыг эрхэмлэх ёстой.<br>◆ Хүмүүнлэгийн ажилтнууд ажиллаж байх үедээ ёс зүйн дилемматай тулгардаг. Хэдийгээр хамгийн оновчтой хариулт, шийдвэр олдохгүй байж болох авч, юу ч хийхгүй байна гэдэг нь бас л ямар нэгэн үр дагавартай шийдвэр гэдгийг ойлгох нь чухал юм. |
| ДҮГНЭЛТ СУДАЛГАА | Хүний нэр хүндийг эрхэмлэн дээдлэх явдлыг та хэрхэн хөхиүлэн дэмжиж чадах вэ?<br>Өөрчлөлт гаргахын тулд та юу хийж чадах вэ?<br>Бусдын мэдлэгийг та хэрхэн дээшлүүлж чадах вэ? | Залуучуудыг дайчлах нь<br>Зорилтот хүн ам<br>Төслийн зорилго<br>Нийгмийн хүчин чадал ба баялаг<br>Хүний нэр хүнд | Цаашид юу хийх хэрэгтэй вэ? | ◆ Хүний нэр хүндийг хөхиүлэн дэмжих төслийн төлөвлөлтийн талаар сурсан мэдлэгээсээ амьдралд хэрэгжүүлэх.<br>◆ Хүний нэр хүндийг хөхиүлэн дэмжих зорилго бүхий төсөл хэрэгжүүлэх | ◆ Хүний нэр хүндийг идэвхтэй дэмжихийн төлөө хийгдэх ажил олон байгаа бөгөөд ур чадвар, сонирхолдоо тохирсон төсөлд оролцох боломжтой юм.<br>◆ Бусдын нэрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэх үед тэдний байр суурийг харгалзаж үзэх нь чухал байдаг.<br>◆ Төсөл хэрэгжих явцад тогтмол хугацаанд үр дүнд үнэлгээ өгөх, ирээдүйн төлөвлөгөө тоймлон гаргах нь тустай байдаг. |

# Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт

Энэхүү оршил хэлэлцүүлэг нь багш нарт, сурагчдын дайн ба дайнаас үүдэх зовлон, хүндрэл бэрхшээлийг хязгаарлах оролдлогуудын талаарх мэдлэг, ойлголт болон хандлагыг мэдэж авахад чиглэгдсэн ба уг хөтөлбөрийн жинхэнэ өнгө аясыг жишээгээр дамжуулан танилцуулах зорилготой. Өөрөөр хэлбэл, багш нар сурагчидтай хамтран хэцүү асуултуудыг судалсны үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлэг хийж эдгээр асуудлуудыг ойлгохыг оролдоно. Хичээлийн энэхүү үе шатанд заавал "зөв хариулт" гэж байхыг шаардахгүй.

Хэрвээ цаг байвал, "Дайныг хууль бус болгож болохгүй гэж үү?" гэсэн өгөгдсөн сэдвээр 15 минутын судалгаа явуулж болох юм. Эсвэл уг сэдэв хөндөгдсөн хичээл дээр цаг тухайд нь судалж болно.

"Дайн" гэдэг нь хамгийн багадаа 2 орны хооронд гарч буй зэвсэгт мөргөлдөөнийг хэлдэг. Харин " зэвсэгт мөргөлдөөн" нь илүү өргөн цар хүрээг хамардаг бөгөөд иргэний дайн гэх мэт дотоодын зэвсэгт мөргөлдөөнийг ч багтаадаг. Энэхүү хичээлд дээрх 2 хэлбэрийг бие биенээ нөхөн гүйцэлдүүлэх байдлаар хэрэглэж байгаа.

**Зорилго:**
- Хүмүүнлэгийн эрх зүйн суурь, үндсэн ойлголтуудын талаар мэдэж байх
- Хүмүүнлэгийн эрх зүйг судлах явцад тулгарах зарим асуултуудад хариулахад амаргүй гэдгийг мэдэж байх
- Хүний нэр хүндийг урьдчилан тодорхойлох

**Багш нарт:**
- Хэлэлцүүлгийн асуултууд
- Дайныг хууль бус болгох оролдлогуудын талаар

**Бэлтгэх ажил:**
- Арга зүйн удирдамж дээрх хэлэлцүүлгийн талаар болон эхний сургалт семинарыг уншина.
- Боломжтой бол сургалтын дүрс бичлэгийн холбогдох хэсгийг үзнэ.

**Хугацаа:**
45—60 минутын нэг хичээл

**1. Танилцуулга болон уур амьсгал бүрдүүлэлт**
(5 минут)

Сурагчдад энэхүү хичээлийн зорилго нь тэднийг ОУХЭЗ—г судлахдаа өмнө ямар бодолтой байгааг нь мэдэхэд чиглэгдэж байгааг тайлбарлана. Тийм ч учраас сурагчид энэхүү хичээлийн талаар ямар нэгэн мэдлэг, мэдээлэлтэй байх албагүй ба хэрвээ тухайн асуудлаар өөрийн санаа бодлоо илэрхийлэхийг хүсэхгүй буюу тааламжгүй байвал ярихгүй байж болно.
Сурагчдыг хэлэлцүүлгийн дүрэм журамтай танилцуулна:

- Нэгнийгээ ярьж дуустал нь анхааралтай сонсох хэрэгтэй
- Бусдын үзэл бодолтой санал нийлэхгүй байгаа бол өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх бөгөөд бусдыгаа болон тэдний үзэл бодлыг хүндэтгэх хэрэгтэй.

**2. Хэлэлцүүлэг явуулах (30—45 минут)**

Хүний нэр хүнд гэдэг ойлголт нь хүмүүнлэгийн эрх зүйн гол цөм нь юм. ОУХЭЗ—г бүрдүүлж буй хууль тогтоомжууд (хүний эрх ч мөн адил) нь хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилготой.

Хүний нэр хүнд ойлголтын тухай эхний хэдэн асуултанд хариулах холбогдох үг, хэллэгийг брейнсторминг буюу оюуны довтолгоон хийхдээ багш нарт зориулсан эх сурвалж болох "Хэлэлцүүлгийн асуултууд"—ыг ашиглана.

Дараа нь доорх асуултуудаар хэлэлцүүлгээ эхэлнэ үү. Хэлэлцүүлгийн үеэр сурагчид өөрсдийн үзэл бодлоо шалтгаан болон тодорхой жишээгээр баяжуулан илэрхийлэх хэрэгтэй.

**3. Хаалт: Зэвсэгт мөргөлдөөний үеийн хүний нэр хүнд** (10 минут)

- Дүгнэлт яриагаа хүний нэр хүнд ойлголтоор дуусгана.

**Боломжит асуултууд:**

- Зэвсэгт мөргөлдөөний үед хүний нэр хүнд гэж юуг хэлж байна вэ?
- Дайнд оролцох нь энгийн иргэд болон байлдагчдын нэр хүндэд хэрхэн нөлөөлж байна вэ?

Сурагчдаас, *"хүний нэр хүнд"* ойлголтын тодорхойлолтыг боловсруулахыг хүснэ. Тэдний гаргасан тодорхойлолтыг жагсаан бичээд, бүх хичээлийн туршид хэрэглэнэ.

**ГОЛ САНААНУУД**

- Хүний нэр хүнд гэдэг ойлголт хамгийн чухал бөгөөд энэхүү гарын авлагад ("Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах") дахин дахин хөндөгдөх болно.
- Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах явцад тулгарах зарим асуултуудад зөвхөн ганц зөв хариулт, эсвэл амархан хариулт гэж байхгүй. Энэхүү гарын авлагын нэг зорилго нь ийм асуултуудыг тодорхойлж судлахад оршино.

**"Хялбар хариултгүй асуултууд" булан**

**Хичээлийн явцад сурагчид та бүхнээс зайлшгүй тавигдах асуултуудыг асууж болно. Жишээлбэл, "Дайны эсрэг хууль дүрэм гаргаж болохгүй гэж үү?", "Хэн нь хүмүүсийг хууль мөрдүүлдэг болгох вэ?" гэх мэт.**

**Ангидаа дээрх асуултуудыг бичээд хадах тусгай зай гаргана. Эдгээр асуултуудад хариулах нь ярьигтай байж болох юм. Сурагчдад хичээлийн явцад дээрх асуултуудыг авч үзэх болно гэдгийг хэлээрэй.**

**Хялбар хариултгүй асуултуудын жагсаалтыг гаргаад хичээлийн явцад аль болох баяжуулан, тухайн асуулттай холбоотой хичээлийн үеэр уг асуултын талаар хэлэлцэж заншаарай.**

# Нэмэлт дасгал

**Мэтгэлцээн/Хэлэлцүүлэг: Дайныг хууль бус болгож болохгүй гэж үү?**

Энэхүү хэлэлцүүлэг нь дайны хууль дүрэмтэй байвал ямар вэ гэсэн үзэл санаанд хариулт өгнө. Тухайлбал, "Дайны үед ямар зан үйлтэй байх талаар хууль тогтоомж гаргана гэдэг нь үнэн хэрэг дээрээ үнэн хэрэг дээрээ дайныг хуульчилж байгаа хэрэг биш гэж үү?", "Дүрэм журмууд нь дайныг тоглоом шиг болгодоггүй гэж үү?", "Дайныг яагаад зүгээр л хууль бус болгож болдоггүй юм бэ?" зэрэг асуултуудад зохих хариултуудыг өгөх болно.

Эдгээр асуултуудыг хэлэлцэхдээ доорх зүйлсийг анхааралдаа авна уу:

- Хэрвээ дэлхий дахин зэвсэгт мөргөлдөөнийг хууль бус болгочвол, дайны хууль хэрэггүй болох болно.
- Зэвсэгт мөргөлдөөнийг хууль бус болгосноор үед нэгэн орон өөр орныг эзлэн авбал яах вэ? Хууль дүрмийг хэрхэн сахиулах вэ? Дайн хийхээс зайлсхийсэн түүхэн оролдлогуудын талаар юу мэдэх вэ?

Хэрвээ хэлэлцүүлгийг хангалттай хугацаагаар явуулбал, сурагчдын энэхүү хэлэлцүүлэг нь дайныг хууль бус болгосон ч үүнийг хэрэгжүүлэх нь маш хэцүү юм гэсэн дүгнэлтэнд хүрэх болно. [Багш нарт зориулсан эх сурвалжаас "Дайныг хууль бус болгох оролдлогууд"—ын тухай уншина уу.]

Хэлэлцүүлгийн дараа өөрсдийн хийсэн дүгнэлт, дүгнэлтийн шалтгаанараа эссэ бичнэ.

ОУУЗХ—ны вебсайтны "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хуудсан дээр эссэг тавьж болно.

**Харилцаа холбоо – Туршлага судлах сурвалжлага**

Дайны улмаас галд өртсөн, өлсгөлөнд нэрвэгдсэн, шархдаж, хөдөлмөрийн чадвараа алдсан, гэр бүлээсээ салсан, барьцаалагдсан, алга болсон буюу олзлогдож байсан хэн нэгнийг урьж ярилцлага авч болно. Энэхүү туршлагыг дүрслэн бичнэ. Тухайн хүний юу бодож, мэдэрч байсан болон түүний амь нас, нэр хүнд нь ямар аюул учирч байсан, хэрвээ тусламж дэмжлэг авсан бол тэр бүхнийг нь сурагчдаар бичүүлнэ.

Ярилцлагын бичлэгийг хичээлийн явцад зэвсэгт мөргөлдөөний хохирогчдын тухай хэлэлцэх үед хэрэглэж болно.

**Бичлэг ба тайлбар – Хүний нэр хүндийн өмнө хүлээх хариуцлага**

Доорх ишлэлүүдийн аль нэгийг сонгон хэлэлцэнэ үү:

- Мөрдөлт мөшгилтөд өртсөн хүмүүсийг аврахаар яагаад эрсдэлтэй алхам хийсэн бэ гэж асуухад залуу эр:
  Миний аав надад дэлхий бол нэгэн том гинж гэдэг байлаа. Хэрвээ нэг л жижиг хэсэг нь тасрах юм бол гинж эвдэрнэ, хэзээ ч дахиж ажиллахгүй.
- Оросын их зохиолч Достоевский ингэж бичжээ:
  Бид бүгд нэг нэгнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстй.
- Энэхүү ишлэлүүд ямар утгатай вэ? Санал нийлж байна уу? Яагаад? Эсвэл санал нийлэхгүй байгаа бол яагаад?
- Дээрх ишлэлүүдийн утга санааг зэвсэгт мөргөлдөөнд хэрхэн хэрэглэж болох вэ?
- Дээрх ишлэлүүдтэй утга санаа нэг аливаа зүйр үг, хэллэг мэдэх үү?

# Хэлэлцүүлгийн асуултууд:

**Хүний нэр хүнд**

Хүний нэр хүнд гэж юу вэ? Та нар үүнийг хэрхэн тодорхойлох вэ?

**Дайн**

"Дайн" буюу "зэвсэгт мөргөлдөөн" гэсэн үгийг сонсоход хамгийн түрүүнд ямар төсөөлөл ойд чинь бууж байна вэ?
Өнөөдөр дэлхий дахинд хаана, ямар дайн болж байна вэ?
Өнгөрсөн ямар дайнуудын тухай та нар мэдэх вэ?
Дайн гэж юу вэ?

**Дайн байлдааны арга хэрэгсэл**

Зэвсэгт мөргөлдөөний үед бүх зүйлийг хүлээн зөвшөөрдөг үү?
Зэвсэгт мөргөлдөөний үед ямар нэгэн төрлийн зэвсгийг хориглох ёстой юу?
Ямар төрлийн зэвсгүүдийг хориглох ёстой вэ? Яагаад?

**"Дайсны" тухай ойлголт**

Дайсан гэж хэнийг хэлэх вэ? Тодорхойлно уу?
Зэвсэгт мөргөлдөөний үед дайсныг хамгаалах уу?

**Энгийн иргэд**

Энгийн иргэд гэж хэн бэ?
Зэвсэгт мөргөлдөөний үед энгийн иргэдэд хэрхэн хандах хэрэгтэй вэ? Яагаад?
Энгийн иргэд рүү халдаж байсан тохиолдол бий болов уу?
Энгийн иргэд рүү халдсан халдлагыг зөвтгөх үндэс байгаа юу? Яаж?
Хэрвээ энгийн иргэн дайсныг зэвсгээр хангаж байвал яах вэ?

**Хүүхдүүд**

Яагаад хүүхдүүд зарим тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд оролцдог вэ?
Дайнд оролцогчдод насны доод хязгаар тогтоох хэрэгтэй юу?
Тийм бол, насны доод хязгаар хэд байх ёстой вэ?
Дайтах ажиллагаанд хүүхдүүд оролцохыг зөвтгөж болох уу?

Жич: Газрын мина, биологийн, химийн ба атомын зэвсэг гэх мэт тодорхой зэвсгүүдийг ямар учраас хориглодог болохыг судлах нь хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн 2 зарчмыг ойлгоход ач холбогдолтой юм. Эдгээр нь: (1) Хэрэгцээгүй зовлон шаналлаас зайлсхийх, (2) Үл ялгаварлах зэвсгүүдийг (энгийн иргэд болон тэдний объект, мөн түүнчлэн байлдагчид болон цэргийн объектийг ялгахгүйгээр устгадаг) хориглох зарчмууд юм.

Газрын мина, биологийн ба химийн зэвсгүүд нь энгийн иргэд, цэрэг дайчдыг ялгаварлаж чаддаггүй ба ноцтой хор хөнөөл учруулдаг тул дээрх зэвсгүүдийг чандлан хориглодог.

**Шархадсан байлдагчид**

Шархадсан дайсны цэрэгтэй хэрхэн харьцах ёстой гэж та нар боддог вэ?

**Хоригдлууд**

Дайсны талын олзлогдогчидтой хэрхэн харьцах ёстой вэ? Яагаад?
Хэрвээ тухайн олзлогдогч танай гэр бүлд ямар нэгэн муу юм хийсэн бол, яах байсан бэ?
Олзлогдогчдоос мэдээлэл олж авахын тулд тамлан зовоож болох уу?
Хэрвээ тийм бол ямар нөхцөлд?

**Эмэгтэйчүүд**

Эмэгтэйчүүд ер нь дайн байлдаанд шууд оролцож байна уу?
Энэ тухай юу гэж бодож байна вэ?
Дайны үед энгийн иргэн эмэгтэйчүүд тусгай хамгаалалтанд байх хэрэгтэй юу? Ямар төрлийн хамгаалалтууд байх ёстой вэ?

**Бусад хамгаалагдах ёстой хүмүүс**

Дайны үед өөр ямар хүмүүс хамгаалалтанд байх ёстой вэ? Хэн? Яагаад?

**Дайны үед хамгаалалтанд авах ёстой газрууд**

Ямар ч халдлагад өртөх ёсгүй газрууд гэж байдаг уу?
Ямар газрууд? Яагаад?
Эмнэлэг ба эмнэлгийн тоног төхөөрөмж рүү халдахыг хүлээн зөвшөөрч болох уу?
Яагаад тийм, эсвэл үгүй гэж?
Шашны газрууд руу халдаж болох уу?
Яагаад тийм, эсвэл үгүй гэж? Хэрвээ тийм бол ямар нөхцөлд?
Хүмүүсийн орон сууц, хот суурин газар болон дэд бүтцийг устгаж болох уу?
Яагаад тийм, эсвэл үгүй гэж?

**Хууль эрх зүй**

Хууль эрх зүй гэж юу вэ?
Хууль эрх зүй хаанаас урган гардаг вэ?
Зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэх зовлон, хүндрэл бэрхшээлийг хязгаарлах хууль тогтоомжууд байх хэрэгтэй юу? Хэрвээ тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
Тийм хууль ер нь байдаг болов уу?
Байдаг бол, уг хуултар юуг заасан байдаг вэ?

**Хүмүүнлэгийн байгууллагууд**

Дайны үед хүмүүсийг хамгаалан тэдэнд тусалдаг ямар нэгэн байгууллагууд байдаг болов уу?
Тийм ямар байгууллагыг мэдэх вэ? Тэд юу хийдэг вэ?

**Хүний нэр хүнд**

Зэвсэгт мөргөлдөөний үед хүний нэр хүнд гэж юу вэ?

# Дайныг хууль бус болгох оролдлогууд

*Хүн төрөлхтний 3400 гаруй жилийн бичигдэн үлдсэн түүхэн замналын туршид ердөө л 250 жил нь дайн дажингүй, ямар амгалан байжээ. 1945 оноос хойш гэхэд л дэлхий дахинд 400 орчим зэвсэгт мөргөлдөөн гарсан байна.*

*—Эх сурвалж:: Шинэ Зеландын Улаан Загалмайн сургалтын хөтөлбөрөөс*

### Дэлхийн 1—р Дайны дараа

**Үндэстнүүдийн Холбооны Гэрээ, 1919 он**

Хэлэлцэн тохирогч Эрхэм дээд талууд,

Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, олон улсын энх тайван, аюулгүй байдалд хүрэхийн тулд

- Аливаа үл ойлголцол, зөрчилдөөн маргааныг дайны бус, энхийн замаар шийдвэрлэх үүрэг хариуцлага ухамсарласнаар,
- үндэстнүүдийн хооронд нээлттэй, шударга, өөр хоорондоо хүндэтгэлтэйгээр харьцан харилцсанаар,
- Засгийн газар хоорондын зан үйлийн бодит журам болох олон улсын эрх зүйн талаарх ойлголтыг бэхжүүлснээр,
- Шударга ёсыг сахиулан, гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүрэг хариуцлагаа чандлан сахиснаар

Үндэстнүүдийн Холбооны энэхүү гэрээнд нэгдэн орсноор хүлээн зөвшөөрнө.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ:

Аливаа дайн ба дайны заналхийлэл нь Үндэстнүүдийн Холбооны онцгой анхааралд байхаар тунхаглагдсан бөгөөд Холбоо нь улс үндэстнүүдийн энх тайван байдлыг чандлан сахихад шаардлагатай гэж үзэж буй үр дүнтэй, нухацтай арга хэмжээг авах болно.

12 ДУГААР ЗҮЙЛ:

үндэстнүүдийн Холбооны гишүүн орнууд нь, хоорондын харилцааг тасалдуулж болзошгүй аливаа зөрчилдөөн маргааныг Аюулгүйн Зөвлөлд өргөн барих буюу хөндлөнгийн шүүх болон шүүхийн журмаар зохицуулахыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд шүүх болон арбитрын шийдвэр буюу Зөвлөлийн дүгнэлтээс хойш 3 сарын дотор дайн хийхгүй байх үүргийг харилцан хүлээнэ.

15 ДУГААР ЗҮЙЛ:

Хэрвээ Зөвлөлийн шийдвэр нь Зөвлөлийн бүх гишүүдийн зүгээс санал нэгтэй батлагдвал, Холбооны гишүүд нь аливаа зөрчилдөөн маргааныг дайны замаар шийдэхгүй, Зөвлөлийн шийдвэрийг хүндэтгэн мөрдөх үүргийг хүлээнэ.

Хэрвээ Зөвлөлийн шийдвэр нь бүх гишүүдийн зүгээс санал нэгтэй батлагдахгүй бол, Холбооны гишүүн улс нь шударга ёс, хүний эрхийг сахиулан хангахын тулд өөрийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авах болно.

[Хэдийгээр энэхүү гэрээ нь дайн болон хүч хэрэглэхийг бүрэн дүүрэн хориглоогүй боловч, дайныг зөвшилцөх хэмжээнд хүртэл хязгаарлах тодорхой дэг журмыг тодорхойлсон юм. Үнэндээ, дайныг хууль бус болгох хамгийн анхны олон улсын хэмжээний эрх зүйн акт нь 1928 оны Келлог—Бриандын Пакт юм.]

# Дайныг хууль бус болгох оролдлогууд –2

### Дэлхийн 2–р Дайны дараа

**Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, 1945 он**

УДИРТГАЛ:

Нэгдсэн Үндэстний Улс Түмэн Бид,

- Бидний үед хүн төрөлхтөн хоёр удаа өгүүлшгүй гай зовлон учруулсан дайны гамшгаас хойд үеийнхнийг ангижруулах,
- Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэд итгэх итгэл болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд түүнчлэн том, жижиг үндэстэн адил тэгш эрхтэй хэмээх итгэлийг дахин нотлох,
- Шударга ёсыг сахих, гэрээ болон олон улсын эрх зүйн бусад эх сурвалжаас үүдэн гарах аливаа үүргийг хүндэтгэн мөрдөх нөхцлийг бүрэлдүүлэх,
- Илүү эрх чөлөөтэй байдалд нийгмийн дэвшлийг урагшлуулах, амьдралын түвшинг сайжруулахад тус дөхөм үзүүлэх

ЗОРИЛГЫН ҮҮДНЭЭС

Хүлээцтэй байх, найрсаг хөршийн ёсоор эв эеийг сахин хамтдаа аж төрөх,

- Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахын төлөө хүчээ нэгтгэх,
- Зарчим батлах, арга тогтоох замаар зэвсэгт хүчнийг гагцхүү нийтийн ашиг тусынхаас бусад зорилгод хэрэглэхгүй байх...

2 ДУГААР ЗҮЙЛ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр харшлах ямарваа бусад үйлдлийг цээрлэнэ...

42 ДУГААР ЗҮЙЛ

Аюулгүйн Зөвлөл олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах буюу сэргээн тогтооход шаардагдах арга хэмжээг агаар, ус, хуурай замын хүч хэрэглэн авах эрхтэй.

51 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс зэвсэгт халдлагад өртвөл олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад шаардагдах арга хэмжээг Аюулгүйн Зөвлөлөөс авах хүртэл өөрийгөө бие даан буюу бусадтай хамтран хамгаалах салшгүй эрхийг энэхүү дүрэм хэрхэвч хөндөхгүй.



# Бүлэг 1

# Хүмүүнлэгийн төлөв

**(5 Хичээл)**

***Хөндлөнгөөс ажиглагч гэж хэн бэ?***

***Хөндлөнгөөс ажиглагчдад ямар дилемма тулгардаг вэ?***

***Хөндлөнгөөс ажиглагчид ямар нөлөө үзүүлж чадах вэ?***

***Хүмүүнлэгийн үйлсийн мөн чанар юу вэ?***

## СУДАЛГААНУУД:


1A: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ ? (3 Хичээл). . . 42
1B: Хүмүүнлэгийн үйлс (1 Хичээл). . . 46
1C: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма (1 Хичээл). . . 56


## ОЙЛГОЛТУУД:

Хөндлөнгөөс ажиглагч
Дилемма
Хүмүүнлэгийн үйлс
Нийгмийн дарамт

**Нийт бүлгүүдэд:**
Хүний нэр хүнд
Хүмүүнлэгийн зан үйлд учрах саад тотгорууд
Дилемма
Үр дагаврууд
Олон талт төлөв байдал

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Төлөвшил
Дүрд тоглох
Түүхэн үйл явдалд дүн шинжилгээ хийх
Түүхэн үйл явдлыг ярих
Дилеммад дүн шинжилгээ хийх
Үр дагаврыг тодорхойлох

# Судалгаа 1 А. Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

Судалгаа 1А—д голчлон дайн буюу хүчирхийллийн үед, жирийн үед хамгаалагдаад байдаггүй хүмүүсийн амь нас, нэр хүндийг хамгаалахаар өөрсдөд нь тохиолдох эрсдэл, гарз хохирлыг үл харгалзан ажилласан эгэл жирийн хүмүүсийн тухай өгүүлнэ.

Хичээлээр үзэх жишээ өгүүллүүд нь бодит түүхэн үйл явдлууд учраас өгүүлэмж, цаг хугацаа, байрлал, мөргөлдөөний хэлбэр (зэвсэгт мөргөлдөөн, арьс өнгөөр ялгаварласан хүчирхийлэл, хүүхэд залуучуудын гэмт хэргийн бүлэглэлүүд гэх мэт), хамгаалагчийн иргэншил зэрэг өөр өөрийн онцлогтой бөгөөд гол үзэл санаануудыг тайлбартайгаар оруулсан. Жишээг асуултуудтай нь хамт Алхам 3 — "Жишээ судлах"—аас харна уу.

Бүлэгтээ зориулж хэд хэдэн түүхэн жишээ сонгоно. Идэвхтэй оролцоог дээшлүүлэхэд нь анхааран дүрд тоглох, бүлгийн хэлэлцүүлэг, дүн шинжилгээ хийх, илтгэл тавих зэрэг заах аргуудаар дамжуулан сурагчдад хөндлөнгөөс ажиглагчдын үйл ажиллагаа, үзүүлэх нөлөөг гүн гүнзгий ойлгуулах зорилгоор наад зах нь 2 хичээлээр эдгээр түүхэн жишээнүүдийг судална.

**Зорилго:**
- Хөндлөнгөөс ажиглагчийн зүгээс бусдын үйлдэлд үзүүлж болох нөлөөг ойлгох
- Хүчирхийллийн үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үйлдэл хийж буй хөндлөнгөөс ажиглагчийн жишээг мэдэж байх

**Ашиглах материалууд:**
- Түүхэн үйл явдлууд
- Янз бүрийн түүхэн үйл явдлууд дээр гарах орон нутгийг танилцуулахад хэрэглэх дэлхийн газрын зураг (боломжтой бол)

**Багш нарт:**
- Түүхэн үйл явдлуудын талаарх нэмэлт мэдээлэл

**Бэлтгэл ажил:**

Ашиглах түүхэн жишээг сонгон дэс дараалалд оруулна.

Арга зүйн удирдамжаас, түүхэн үйл явдлуудыг ашиглах, дүрд тоглох болон цомхон бүлгээр ажиллах, түүнтэй холбоотой сургалтын зөвлөмжүүдийг уншина.

Боломжтой бол сургалтын дүрс бичлэгийн холбогдох хэсгийг үзнэ үү.

**Хугацаа:**
- 45—60 минутын 2—3 хичээл

*Бидэнд цаг үргэлж ёс суртахууны сонголт хийх хэрэг гардаг. Бид ихэнхдээ ямар нэгэн түүх, ном, эсвэл хэн нэгнээс болж хүний төлөө, амьдралын төлөө өөр сонголтыг хийх боломжтой болдог.*

— Элий Вийзель, Халамжлах эр зориг

### Алхам 1. Брейнсторминг буюу оюуны доволгоон хийх (5 минут)

➤ Амь нас, нэр хүнд нь эрсдэлд байгаа хэн нэгнийг аврахын тулд ямар нэгэн аюултай, түгээмэл бус үйлдлийг хийхэд юу хэрэгтэй вэ?

### Алхам 2. Хөндлөнгөөс ажиглагчийг тодорхойлох (5 минут)

Хөндлөнгөөс ажиглагч гэдэг нь "Тухайн үйл явдалд оролцоогүй боловч бусдын амь нас, нэр хүндэд аюул учирсан үед байлцсан этгээд. Хөндлөнгөөс ажиглагч нь тухайн үйл ядалд шууд буюу шууд бусаар оролцох эсэхээ өөрөө шийдвэрлэнэ" гэж тодорхойлно.

**Алхам 3. "Жишээ судлах":** (сонгосон жишээнээс шалтгаалан хугацаа нь ялгаатай байх ба хэрэглэх аргууд нь ч өөр байна)

**Боломжит аргууд:**

- Бүлэг бүр өөр хоорондоо ялгаатай жишээ уншиж хэлэлцээд дараа нь биед биедээ ярьж өгнө.
- Түүхэн явдлуудад гарч буй хүмүүсийн тухайн үйлдлийг хийх болсон учир шалтгааныг олж илрүүлэх зорилгоор сурагчдад дүрүүдийг оноож, тухайн үйл явдлаар жүжигчилсэн тоглолт хийлгүүлнэ.
- Түүхэн үйл явдлыг сурагчдад уншиж өгөхдөө, тэднээр өгүүллэгт гарч буй хүмүүс юу хийх хэрэгтэй талаар хэлэлцүүлэх зорилгоор өгүүллэгийн шийдвэрлэх мөчид (↔ гэсэн тэмдэгтэй газар) түр зогсоно.

[Жишээг дарааллуулах зөвлөмж 1А—5 хуудаснаас эхэлнэ.]

**Түүхэн жишээг тайлагнах, хэлэлцэхэд хэрэглэх асуултууд:**

- Үйл явдал хаана, хэзээ болсон бэ?
- Энэ нөхцөл байдалд хүний амь нас, нэр хүнд нь хэрхэн эрсдэлд орсон бэ?
- Аврагчид ямар саад бэрхшээлтэй тулгарсан бэ?
- Хөндлөнгөөс ажиглагчид нь хэн байсан, мөн тэд ямар сонголт хийсэн бэ? Яагаад? Ямар дарамт шахалт, эрсдэлтэй тулгарсан бэ?
- Хөндлөнгөөс ажиглагчдын үйлдэл ямар үр дагаварт хүргэсэн бэ? Эхлээд? Дараа нь?

**Төгсгөл – Түүхэн үйл явдлуудыг судлах сүүлийн хичээлийн дараа** (15 минут)
Сурагчдад төдийлөн мэдээлэгдээд байдаггүй болохоос иймэрхүү үйл явдлууд дэлхийн өнцөг булан бүрт болж байдаг гэдгийг сануулаарай.

*Муу муухай зүйлд хайхрамжгүй хандсаг байдал маань биднийг гэмт хэргийн хамсаатан болгодог билээ.*

— Эжил Аарвик, 1986 онд Нобелийн энх тайвны шагнал гардуулж байх үедээ

Сурагчдад доорх даалгаврыг өгнө үү:

- Сурагчид үзэж судалсан эдгээр бодит амьдрал дээр тохиолдсон явдлуудын нөхцөл байдлыг нэгтгэн тоймлох
- Хөндлөнгөөс ажиглагчдын даван туулсан саад бэрхшээл, учирсан эрсдэл болон тэдний бусдыг хамгаалах оролдлогын үр дүнд гарсан нөлөөг эргэн дүгнэх

**Боломжит асуулт:**

- Сургууль, хөрш, гэр бүлийнхэнд тань тохиолдсон явдлуудаас хөндлөнгөөс ажиглагч хэн нэгний амь нас, нэр хүндийг аварсан жишээ мэдэх үү?

Эрдэмтэн Эрвин Штаубын, бусдын зан үйлд үзүүлэх хөндлөнгөөс ажиглагчийн нөлөөллийн талаар хэлсэн дараах үгсийг уншина уу. Сурагчдаас ишлэл бүрийн утга санааг илэрхийлэхүйц нотолгоог өмнө нь судалсан түүхэн жишээнүүдээс гаргаж ирэхийг хүснэ.

*Хөндлөнгөөс ажиглагчид бусдад маш хүчтэй нөлөө үзүүлж чаддаг. Үйл явдлын гол утга санааг тодорхойлж, бусдыг энэрэл, үл хайхрал руу хөтлөн аваачиж чаддаг.*

◆◆◆

*Сэтгэл зүйн судалгаанаас үзэхэд хэсэг бүлэг хүмүүсийн зан үйлээс нэг л гажих юм бол зөвшилцөл, нийцлийн хэм хэмжээ багасдаг. Хөндлөнгөөс ажиглагч онцгой тохиолдолд тухайн нөхцөл байдал нухацтай гэдгийг мэдээлэх, эсвэл, бусдыг ямар нэгэн үйлдэл хийхийг уриалах үед бие биедээ гар сунгаж туслах магадлал илүү ихэсдэг байна.*

◆◆◆

*Төр засгийн хандлага ч гэсэн хөндлөнгөөс ажиглагч, хувь хүн, бүлэг хүмүүс болон бусад засгийн газруудын нөлөөгөөр өөрчлөгдөж болно.*

— Эрвин Штауб, Муу муухайн үр үндэс

**ГОЛ САНААНУУД**

- *"Хөндлөнгөөс ажиглагчид" гэдэг нь хүчирхийллийн үед үл таних хүмүүсийн амь нас, нэр хүндийг хамгаалахын тулд аливаа үйлдэл хийж чаддаг энгийн хүмүүсийг хэлнэ.*
- *Хөндлөнгөөс ажиглагчид нь ихэвчлэн өөрт учирч болох хохирол, эрсдэлийг үл харгалзан үйл ажиллагаанд оролцдог.*
- *Энгийн хүмүүс хаана ч байсан эмзэг хүмүүсийг хамгаалан хүнлэг бус үйлдлийн эсрэг зогсдог.*

### Түүхэн үйл явдлууд

Дараах жишээнүүд нь дэлхийн өнцөг булан бүрт болж өнгөрсөн бодит амьдралын түүхэн үйл явдлууд бөгөөд эдгээрийн нийтлэг шинж чанар нь зэвсэгт мөргөлдөөн болон бусад төрлийн хүчирхийллээс үүдэлтэй хүний амь нас, нэр хүндэд учирсан аюулт нөхцөл байдлыг багтаасан явдал юм.

*Асуудал болгон надад шууд нөлөөлөөд байх шиг. Хэрвээ хаа нэгэн тосгонд хэн нэгэн нь ямар ч шүүхийн байцаалтгүйгээр саатуулагдсан бол би яагаад ч юм өөрийгөө энэ асуудалд хариуцлага хүлээх ёстой гэж бодоод зүгээр сууж чаддаггүй. Яагаад гэвэл энэ асуудлыг зүгээр л энэ бол миний асуудал биш хэмээн өнгөрөөж болохгүй.*

— Юнити Даутай хийсэн ярилцлага, Амнести хөдөлгөөн, 1999 оны өвөл

Тухайн үйл явдал бүрийн хөндлөнгөөс ажиглагч нь:

- эгэл жирийн хүн байна
- өөрийн амь нас, амар тайван амьдралаа аюулд учруулж болзошгүй
- энгийн нөхцөлд хамгаалаад байдаггүй хэн нэгнийг хамгаалдаг

Энэ хэсэгт жишээ үйл явдлуудыг хичээлдээ ашиглах буюу өөрийн мэддэг төстэй жишээг ч хэрэглэж болно.

Бусад жишээг Олон Улсын Улаан Загалмайн Хорооны вебсайт дээрх "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хуудаснаас авч болно.

Үйл явдал бүр хүмүүнлэгийн төлөв байдлыг өөр өөр өнцгөөс судлах боломж олгож байгаа бөгөөд доорх хүснэгтээс жишээ бүрийн онцлог, ашиглах зааврuудыг харж болно. Сурагчдыг жишээ үйл явдлуудын талаар дүгнэлт хийхэд нь туслахын тулд дараах дэс дараалаар танилцуулахыг зөвлөж байна.

| Үйл явдлын онцлог: | Гарчиг: | Ашиглах зөвлөмж |
|---|---|---|
| Энгийн иргэдийн үймээн самуунаас болж аюулд учирсан хүүхэд залуучууд | Модон сандал дээр ганцаараа | Сургуулийн орчин тойрон дахь хохирогчийн тухай өгүүлэгдэж байгаа тул зарим сурагчдад ойлгоход хялбар, сайн эхлэл болно. |
| Хүүхэд залуучуудын хүчирхийлэл | Зоригт мухлагийн эзэн | Хүмүүнлэгийн хариу үйлдэл нь хувийн ашиг сонирхлоос илүү чухал. |
| Хөндлөнгөөс ажиглагчийн гайхамшигт нөлөө | Дайны хор уршиг<br>Гэрч айсуй | Нэг хөндлөнгөөс ажиглагчийн богино ба урт хугацааны үр нөлөөг харуулж байгаа тул гинжин үр дагаврыг олж илрүүлэхэд тохиромжтой. |
| Хүмүүнлэгийн зан үйлийн өсөлт, хөгжил | Алхам алхмаар | Аврагчдын хүмүүнлэгийн зан үйлд гарч буй өсөн нэмэгдэх өөрчлөлтийг судлах боломж олгох ба 4 оролцогчийн тусламжтайгаар дүрд тоглуулах боломжтой. |
| Үндэс угсааны хуваагдал | Лагерьт хоригдогсдын зовлонг нимгэлэгч тосгоныхон | Зэвсэгт мөргөлдөөнийг тодорхой хэмжээгээр тодорхойлох үндэс угсааны ялгааг амсч буй хүмүүсийн эрсдэлд байгаа бусдадаа тусалж байгааг харуулна. |

Түүх бүрийг нэмэлт тайлбар дагалдана. Зарим түүхүүдийн санал болгож буй шийдвэрлэх мөчүүдийг ↔ тэмдгээр тэмдэглэсэн болно.

*Эсэргүүцэл байхгүй байгаа нь гэмт хэрэгтнүүдэд өөрсдийн үйлдлээ зөв гэж итгэх итгэлийг улам төрүүлдэг.*

— Эрвин Штауб, Муу муухайн үр үндэс

## Санал болгож буй дэс дараалал болон үйл ажиллагаа

### Хүний нэр хүндэд аюул заналхийлэл учруулах нь

"Модон сандал дээр ганцаараа" буюу "Зоригт мухлагийн эзэн" (35—45 минут)

Сурагчдаас дээрх түүхэн үйл явдлуудтай төстэй өөрсдийнх нь амьдралд болсон үйл явдал, туршлагынх нь (хичээлийн анхны өдөр, өөр сургуульд шинээр орох, танил, найрсаг бус хөршийн холбоонд байх гэх мэт) талаар асуугаарай. Сурагчид, эдгээр нөхцөл байдалд байхдаа юу бодож, мэдэрч байсан болон тэдгээрийн цаад шалтгааны талаар жагсаан бичих ёстой.

Түүхийг уншина. Хэлэлцүүлгийг эхлэхээс өмнө, сурагчдаар, жишээ явдалд өгүүлэгдэж буй эрсдэлд орсон залуу үйл явдал өрнөхтэй зэрэгцэн юу бодож байсан талаарх санал бодлыг нь бичүүлнэ үү.

Сурагчдын сэтгэгдлийн талаар хэлэлцүүлэг явуулахдаа нөхцөл байдлын аюултай байдал болон хүний нэр хүндэд учирч буй аюул заналхийлэлд анхаарлыг нь төвлөрүүлэхэд тусална.

Дараа нь аврагч юу бодож байсан байж болох тухай бичүүлнэ үү. Мухлагийн эзэн болон, Грейс Лорчийн хувьд нөхцөл байдал ямар байсан бол? Тэд ямар эрсдэл буюу дарамттай учирсан бэ? Юу тэр хүнд тухайн үйлдлийг хийхэд нь түлхэц болсон бол?

**Боломжит асуултууд:**

- Аврагч ямар бэрхшээлтэй учирсан бэ?
- Хүн бүр ямар шийдвэр гаргасан гэж бодож байна вэ?
- Аюул учрахад хүргэсэн хүмүүс өөрсдөө юу гэж бодож байсан бол?
- Хүмүүнлэгийн үйлс ямар нөлөө үзүүлсэн бэ? (Довтлогчид цаашид юу хийх бол? Цугласан олон яагаад Элизабет Экфордыг хамгаалахад нь Грейс Лорчийг зогсоогоогүй вэ?)

Мухлагийн эзэн буюу Грейс Лорчийн хувьд аюулд өртсөн залууг хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй болсон талаар хэлэлцүүлэг үүсгэнэ үү.

Дээрх түүхүүдийг сурагчдын өөрсдийнх нь амьдралтай холбож, иймэрхүү явдалтай учирч байсан эсэхийг нь асууна. Хэрвээ учирч байсан бол юу бодож, мэдэрч байсныг нь асууна уу. Тэд эмзэг хүмүүст ер нь тусалж байсан болов уу?Тийм бол тэд юу хийхээр бодож байсан болон яг юу хийснийг нь асууна.

*Шоронгийн хүйтэн ханануудын дунд, хамгийн эцсийн тэвчээр барагдах мөчид, харгалзагчдын хэн нэгнээс хүмүүнлэг сэтгэлийн илрэлийг нэгхэн хором ч болтугай олж мэдрэх нь цаашид тэвчих сэтгэлийн тэнхээ олж авахад минь хангалттай байдаг байсан.*

— Нельсон Мандела, Эрх чөлөө хүртэлх урт зам

### Гинжин үр дагаврыг олж илрүүлэх

"Дайны хор уршиг" (30—45 минут)

Энэхүү түүхийг, 1859 оны Сольферино дахь тулааны дараа хүмүүс үй олноороо хэрхэн зовж зүдэрч байгааг тохиолдлоор ажигласан бөгөөд хариу үйлдэл хийсэн хүний тухай түүх хэмээн танилцуулна уу. Болсон явдлыг хэлэлцэх үедээ сурагчдыг дайн тулааны талбарыг хөндлөнгөөс ажиглагчийн нүдээр харахад нь тусална.

> *Сурагчдаас энэхүү үйл явдлын юу нь тэдний гайхашралыг төрүүлж байгааг, мөн яагаад гэдгийг нь асууна уу.*

Жишээ нь: Тэрхүү шархадсан болон үхэх гэж буй хүмүүст туслах ямар ч хүн байгаагүй гэж үү, эсвэл тэдэнд туслахаар тухайн нутгийн нэг ч хүн ирээгүй гэж үү г. м.
Сурагчдаар, бусдын үйлдэлд зөвхөн нэг хүний үйлдлийн үзүүлж буй нөлөөллийг үнэлүүлнэ үү.

# Судалгаа 1 А. Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

**Боломжит асуултууд:**

- Нэг хөндлөнгөөс ажиглагчийн зан үйл нь бусдын зан үйлд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Хөндлөнгөөс ажиглагчид, тусламж эрсэн гуйлтыг үл тоомсорлох, амь тавьж буй цэргийн эд зүйлсийг хулгайлах гэх зэргээр хүнлэг бус үйлдэл хийх үед ямар гинжин үр дагавар гарч болох вэ?

Сурагчид жишээн дээр гарсан хүмүүнлэгийн үйлс болон түүнээс үүдсэн бусад хүмүүнлэгийн үйлсүүдийг хооронд нь холбон жагсаан бичсэнээр үйлдлүүдийн "гинжин нөлөө"—ний сүлжээг үүсгэж болох юм. Жишээ үйл явдлаас олж харсан гинжин холбоог өөрсдөөр нь тайлбарлуулаарай.

Мөн сурагчдаас, аажим аажмаар Улаан Загалмай Улаан Хавирган Сар Хөдөлгөөний үйл ажиллагааг дэлхий дахинаа үүсгэсэн гинжин нөлөө бүхий холбоог төсөөлөн бодохыг хүсээрэй.

**Хүмүүнлэгийн үйлс өсөн нэмэгдэхийн хирээр, хүмүүнлэгийн хариу үйлдэл хэрхэн бэхжиж байна вэ?**

"Алхам алхмаар" (цомхон бүлгээр дүрд тоглох) (45 минут)

Хэлэлцүүлгээ эхлэхдээ хүмүүсийг хүмүүнлэгийн аргаар хариу үзүүлэхэд нь юу нөлөөлдөг талаар ярилцана уу.

- Амь нас, нэр хүнд нь эрсдэлд орсон хэн нэгнийг хамгаалахын тулд ямар нэгэн хүндрэлтэй, аюултай, нийтлэг бус зүйл хийхэд юу шаардлагатай вэ?

> Жишээ нь: хувь хүний эр зориг, ёс суртахууны буюу шашны итгэл, боломжит аюулыг үл тоомсорлох байдал, өөрөө ч бас тиймэрхүү байдалтай зовж зүдэрч үзсэн байх гэх мэт.

Сурагчдаар уншсан түүхийнхээ талаар эсвэл өөрт тохиолдсон ижил төстэй туршлагынх нь талаар ярихыг уриална.

"Алхам алхмаар" өгүүллэгийг танилцуулна уу. Дараа нь сурагчдад 4 гол дүр оноогоод өөрсдийгөө тухайн дүрийн оронд тавьж, дүрүүд тухайн үйл явдлын эгзэгтэй мөчид юу бодож, мэдэрч байсан талаарх бодлуудыг нь бичүүлнэ үү.

5—10 минутын дараа, дүрээр хуваагдсан бүлгүүдийн дунд доорх асуултуудаар бүлгийн ярилцлага зохион байгуулна:

- Дүрд нь тоглож байгаа хүн тань юу хийхийг оролдож байна вэ? Яагаад?
- Дүрд нь тоглож байгаа хүнд тань үйл явдлын эгзэгтэй мөчид ямар итгэл найдвар, айдас төрж байна вэ?

Сурагчдаар үйл явдлыг жүжигчлэн тоглуулна уу.

Дүрд тоглох үйл явцыг доорх маягаар хийж болно:

> Энэхүү үйл явдал нь 1942 онд эзлэгдсэн Польшид болсон ба Жерези, Штефа хоёр Иренаг нэг өрөө байрандаа хэдэн сарын турш нуусан юм. Энэ орой Жерези ажлаасаа ирлээ. Түүний хувьд аюул эрсдэл улам нэмэгдсэн байлаа.

*Сайн сайхан ч гэсэн муу муухайтай адилаар ихэвчлэн өчүүхэн зүйлээс эхэлдэг. Баатрууд төрж гардаггүй, тэд хувьсдаг. Аврагчид ихэнх тохиолдолд хэн нэгэнд туслах үйлсээ өчүүхэн амлалт, жишээ нь, хэн нэгнийг 1—2 хоногоор нуух зэргээр эхэлдэг. Гэвч тэд тэрхүү анхны алхмаа хийх л юм бол, яваандаа өөрсдийгөө ядарсан, зовсон нэгэнд тусалж буй хүн гэдгээ мэдрэн бүхнийг өөрөөр харж эхэлдэг.*

— Эрвин Штауб, Муу муухайн үр үндэс

# Судалгаа 1 А. Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

> *Өмнөх туршлагуудаасаа бид, хүмүүс өөрсдөөс нь дорой буурай, зовж шаналж буй нэгнийхээ эрх ашгийн төлөө тэмцэхэд, тэдний эсэргүүцэл үр дүнтэй байдгийг олж мэдсэн юм ... Бидний зүтгэл, дарлагчдын үзэл санааг өөрчилж чадахгүй ч, зовлонд нэрвэгсдэд бага ч атугай тайтгарал, баяр баясгалан авч ирдгээрээ ач холбогдолтой билээ.*
>
> Элий Вийзель, Ньюсдей

Дүрд тоглосны дараа, сурагчдын дунд өөрсдийн санал сэтгэгдэл болон хүмүүсийн хийсэн сонголтуудыг юу гэж бодож байгаа талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ үү.

**Боломжит асуултууд**

- Хийсэн сонголтынхоо талаар юу гэж бодож байна вэ? Яагаад?
- Бусад 3 дүрийн хийсэн сонголтын талаар юу гэж бодож байна вэ?

Жишээ үйл явдал дахь аврагчийн үйлдлийн үе шатуудыг тодорхойлно уу. Хүмүүсийн хоорондын харилцан адилгүй байдал (зан ааш) нь тэдэнд, ямар нэгэн эрсдэлтэй учрах үедээ өөр өөр хариу үйлдэл үзүүлэхэд нь нөлөөлдгийг сурагчдад сайтар ойлгуулахын тулд доорх асуултуудыг хэлэлцүүлнэ үү:

- Иренаг амьд үлдэхэд нь хүн бүр хэрхэн хувь нэмрээ оруулсан бэ?
- Нэг хүний үзүүлж буй ач тус, бусдын ижил үйлдэлд хэрхэн нөлөөлж байна вэ?
- Яагаад зарим нь хийх ёстой зүйлсийг хийж чадаж байхад, зарим нь чадахгүй байна вэ?
- Энэхүү өгүүллэгийн гарчиг ямар утга илэрхийлж байна вэ?

## Хүмүүнлэгийн үйлс дэлхий дахинаа

Сурагчид сурч, мэдэж авсан зүйлсээ, янз бүрийн хүчирхийллийн үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үйлдэл хийсэн энгийн хүмүүсийн тухай өгүүлж буй өөр түүхүүдэд ашиглаж чаддаг болох хэрэгтэй. Эдгээр жишээ үйл явдлууд янз бүрийн зохиогч, байршил, нөхцөл байдлуудад болж байдаг. Тухайлбал:

| Жишээ үйл явдал | Агуулга | Хаана | Зохиогч |
|---|---|---|---|
| Лагерьт хоригдогсдын зовлонг нимгэлэгч тосгоныхон | Дайн | Босни | Сэтгүүлч |
| Гэрч айсуй | Иргэний самуун | Өмнөд Африк | Нельсон Манделагийн намтар |
| Зоригт мухлагийн эзэн | Гудамжны хүчирхийлэл | Тайланд | Багш |

Өөрсдийн улс орны түүх, орон нутгийн мэдээний эх сурвалжаас, мөн www.ICRC.org вебсайтын "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хуудас дээрээс нэмэлт түүхэн үйл явдлуудыг харж болно.

# Нэмэлт дасгал

**Түүхэн үйл явдлуудыг судлан цуглуулах**

Өөрийн орны түүх, домог, шашин зэргүүдэд хамгаална гэж бодож байгаагүй хүмүүсийг хамгаалсан хөндлөнгөөс ажиглагчдын тухай түүхэн баримтуудыг судална уу.
➤ Тэд яагаад ийм үйлдэл хийх болов? Үр дүн нь юу байв?
Сурагчид судалж цуглуулсан түүхүүдээрээ ном, товхимол, үзүүлэн гаргаж болно.

**Суутнуудын хэлсэн сургааль үгс:**

14—р зууны Суфи яруу найрагч Желалуддин Румигийн доорх сургаалийн утга санааг өөрийнхөөрөө тайлбарлана уу.

*Хүмүүст гэрэл гэгээ, аврагч завь эсвэл сайн сайхан өөд мацах шат нь болж яв.*

Энэхүү сургаалийн утга санааг зургаар, үгээр болон үзэл санаанд нь тулгуурласан дуу зохион илэрхийлж болно.

Брейнсторминг ашиглан хүмүүнлэгийн үзэл санааг илэрхийлсэн зүйр цэцэн болон сургааль үгсийг нэрлэнэ үү. Эдгээр үгс хүмүүнлэгийн үзэл санаатай хэрхэн уялдаж байгааг тайлбарлана. Жишээ нь, сурагчдын нэг нь "Алтны дэргэд гууль шарлана" гэсэн зүйр үгийг санал болговол, бусад сурагчид энэхүү зүйр үгийн утга санааг аливаа хүн бусдын жишээг дагадаг бөгөөд хажууд байгаа хүнийхээ зан чанар, тухайлбал хүмүүнлэг зан үйлийг үлгэрлэн дууриадаг гэдгийг авч хэлэлцэнэ.

Хүмүүнлэгийн үзэл санааг тусгасан уламжлалт зүйр цэцэн үгсийг гэр бүлийнхэн болон бусад эх сурвалжаас цуглуулна. Дээрх үгс, хэллэгүүдээр товхимол, цуглуулга хамтран хийцгээнэ үү.

*Өшөө эрэхийн оронд, сайн дууриал үзүүл.*

*—Жибутийн нэгэн оюутан*

*Энэрэлийн сайхан сэтгэл эх дэлхийг нэгтгэж байдаг.*

*—Тайландын нэгэн оюутан*

*Аугаа зөгнөгчийн "Хадис" хэмээх бүтээлд ийнхүү өгүүлдэг: Хэрэв чи ямар нэгэн шударга бус байдлыг олж харвал өөрийн гараараа өөрчлөхийг хичээ, тэгээд болохгүй бол үг хэлээрээ оролдоод үз, тэгээд бүр болохгүй бол эцэст нь сэтгэл зүрхээрээ оролд. Энэ нь чиний хийж чадах зүйлсийн өчүүхэн нэгэн хэсэг.*

*—Египетийн нэгэн оюутан*

*Өөр лүү нь дүрвэн нисэж ирэх шувууг анчин хүртэл алж чадахгүй.*

*—Японы зүйр үг*

**Үр дагавруудыг олж тогтоох**

Хүний амь нас, нэр хүндийг хамгаалж буй хөндлөнгөөс ажиглагчдын нөлөөлөлд дүн шинжилгээ хийнэ.

Доорхоос аль нэгийг нь сонгож, гинжин нөлөөний сүлжээг харуулах диаграм хийнэ үү.

➤ хэн нэгний өмнөөс хөндлөнгөөс ажиглагчийн дүрд тоглосон таны үйлдэл
➤ хэн нэгэн нь хөндлөнгөөс ажиглагчийн хувьд хийсэн үйлдэл

Хөндлөнгөөс ажиглагчийн үйлдлийг сүлжээний голын тойрог дотор бичээд, энэхүү үйлдлийн үр нөлөөг, тойргийг аль болох олон хүн, үйл явдалтай холбох замаар зурж үзүүлнэ үү.

# "Дайны хор уршиг" өгүүллэгийн нэмэлт тайлбар




Сольферино бол өнөөгийн Италийн хойд хэсэгт оршдог бяцхан хот юм. Хэдийгээр Италийн хойгийн оршин суугчид нийтлэг хэл, соёлтой боловч Итали улс нь Ромын эзэнт гүрний мөхлөөс хойш 1860—аад он хүртэл нэгдмэл нэгэн улс болж амжаагүй байсан ажээ. Энэхүү хойг дээр олон тооны жижиг вант улсууд оршин тогтнож байсан ба тэднийг хүчирхэг хөршүүд болох Франц болон Австри улсууд ихэвчлэн ноёрхсоор иржээ. Тэд Италийн хойд хэсгийг эзэлж авахыг оролддог байсан боловч Сольферино хот болон зэргэлдээ тосгоныхон Францууд ч биш, Австри хүмүүс ч биш байв.

Францын хувьсгал, Францчуудын хойд Италийг эзэлж байсан үе чухамдаа гадаадын эрхшээлээс ангид тусгаар Итали улсыг нэгтгэн бий болгох хөдөлгөөний очийг бадраажээ. Эрх чөлөөний төлөө энэхүү тэмцлийн үед 1848 оныг хүртэл олон тооны хувьсгал гарсан боловч төдийлөн амжилт олоогүй бөгөөд Австрийн цэргүүд хойд болон төв Италийн газар нутгийн ихэнхийг нь эзлэн авч зөвхөн II Виктор Эммануэль хааны захирч байсан Пьемонтын хаант гүрэн буюу Сардиниа улс л тусгаар тогтнолоо хадгалан үлдэж чадсан юм.

Жишээний үндэс суурь болсон үйл явдлууд: 1850—иад онд Пьемонт, Франц хоёр цэргийн эвсэл байгуулснаар Австрийг Пьемонтод дайн зарлуулж, харин Франц Пьемонтод туслахаар төлөвлөж байсан юм. Төлөвлөгөө ч хэрэгжиж, Австри улс 1859 онд Пьемонтын эсрэг дайн зарлав. Сольфериногийн тулаанд, III Наполеоноор удирдуулсан Франц, Сардиниагийн арми I Эзэн Хаан Франсис Жозефийн Австрийн цэргийн хүчтэй тулалджээ. 1859 оны 6 сарын 24—ний өдөр Австрийн цэргүүд арга буюу ухрах хүртэл олон өдрийн албадсан дайралтанд өлсөж ядарсан 300 мянга гаруй цэрэг Сольферино хот болон эргэн тойронд бүтэн өдөржингөө тэмцжээ. Тулалдаан болсон хөндий хүчтэй аадар бороо, морьдын туурай болон байлдааны хөлд дарагдан эмх замбараагүй шаварт намаг болон хувирчээ. Маргааш нь хөндий олон мянган цогцос, үхэл амьдралын ирмэг дээр амь тэмцэж буй цэргүүдээр дүүрсэн байлаа.

# "Гэрч айсуй" өгүүллэгийн нэмэлт тайлбар







Өмнөд Африк улс нь Африк тивийн хамгийн урд хэсэгт оршдог бөгөөд 43.5 сая хүн амтай.

1652 онд Голландчууд Африкт колони байгуулах хүртэл, Өмнөд Африк олон тооны овог аймгууд оршин суудаг өлгий нутаг нь байв. 1814 онд Британичууд Голландчуудыг бут цохин, Өмнөд Африкийг өөрсдийн мэдэлд оруулснаар, 19—р зууны төгсгөл гэхэд Британичуудын эзэлсэн газар нутаг хүрээгээ одоогийн зүүн болон хойд хил хязгаар хүртэл тэлжээ. 1910 онд Британийн Хамтын Нөхөрлөлийн Орнуудын гишүүн Өмнөд Африкийн Холбоо байгуулагдсан ба улмаар засгийн газар, эдийн засагт цагаан арьстнууд ноёрхож ирэв. Засгийн газар нь аажмаар цагаан арьстнуудын байр суурь, эрх мэдлийг бэхжүүлж, 1948—1994 он хүртэл Өмнөд Африкийн засгийн эрх барьсан Үндэсний Нам цагаан арьстнуудын эрх ашгийг хамгаалсан хууль баталсаар байлаа. Арьс өнгөөр ялгаварлан үзэх энэхүү системийг "Апартейд" гэдэг бөгөөд арьс өнгөний ангилалаар хүмүүсийн амьдрах газраа сонгох, ажлын байраар хангагдах, сурч боловсрох, улс төрд оролцох эрхийг нь хязгаарладаг.

Жишээний үндэс суурь болсон үйл явдлууд: Африкийн Үндэсний Конгресс (АҮК) нь 1912 онд Өмнөд Африкийн өнгөт арьстнуудад тэгш эрх олгох зорилгоор байгуулагдсан. 1960 онд Өмнөд Африкийн засгийн газар Британийн Хамтын Нөхөрлөлөөс гарч, апартейдийг цааш нь бэхжүүлэх алхмаа хийжээ. Тийнхүү 1970—1980 онд, Өмнөд Африкийн засгийн газарт олон улсын зүгээс үзүүлдэг их хэмжээний дэмжлэг, тусламж буурч эхэлсэн бөгөөд энэ үед дэлхий дахины хандлага, засгийн газрын хүчирхийллийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллүүдээс үндэслэн апартейдийн эсрэг чиглэжээ.

1990 он гэхэд апартейд систем нуран унах нь тодорхой болжээ. АҮК гэх мэт апартейдийн эсрэг байгууллагууд хууль ёсны болж тэдний удирдагчид шоронгоос суллагдан, цөллөгөөс эргэн ирсэн юм. Апартейд системийг дэмжиж байсан ихэнх хууль тогтоомж хүчингүй болж, засгийн газар, улс төрийн дийлэнх намууд шинэ үндсэн хууль боловсруулан олонхын удирдлагын тогтолцоонд шилжих асуудлыг хэлэлцэж эхэлжээ. Гэвч хэлэлцээр 1992 оны 6 сард, АҮК засгийн газраа өөрсдийг нь дэмжигчдийн эсрэг гаргасан халдлагад оролцсон хэмээн буруушааснаар уналтанд орсон юм. Гэсэн хэдий ч, 1993 оны 3 сард засгийн газар цагдаа нарын АҮК—ийн гишүүдийг хамгаалах үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрснөөр хэлэлцээр дахин сэргэсэн юм. Ийнхүү апартейд систем устаж, 1994 онд анхны чөлөөт сонгууль явагдсан билээ.

# "Модон сандал дээр ганцаараа" өгүүллэгийн нэмэлт тайлбар




Литл Рок нийслэлтэй Арканзас муж нь АНУ—ын өмнөд хэсэгт оршдог бөгөөд 1950—иад оны сүүлээр хүн амын 77 хувь нь цагаан арьстнууд, 22 хувь нь Африк гаралтай Америкчууд буюу хар арьстнууд эзэлж байв.

1954 оноос өмнө Америкийн өмнөд мужуудын ихэнх сургуулиуд Африк гаралтай Америк хүүхдүүд, цагаан арьстан хүүхдүүдтэй хамт нэг сургуульд сурахыг хориглодог байсан ба хар арьстан хүүхдүүдэд зориулагдсан сургууль, цагаан арьстнуудын сургуулиас бага хэмжээний санхүүжилт авдаг, байнга засвар хийх шаардлагатай тулгардаг байсан бөгөөд наад захын хангамжаар дутмаг байлаа. 1954 онд АНУ—ын Дээд шүүхээс сургуулиудыг арьс өнгөөр ялгах нь хууль бус хэмээн шийдвэрлэсэн ба "зөвхөн цагаан арьстнуудад" зориулсан сургуулиудыг "аль болох түргэн" Африк гаралтай Америкчуудад нээлттэй байлгахаар болжээ.

Жишээний үндэс суурь болсон үйл явдлууд: Дээд шүүхийн шийдвэрийг дагаж мөрдөхийн тулд, Литл Рок хотын сургуулийн зөвлөл бүх цагаан арьстнуудын дунд сургуулийг хар арьстан сурагчдыг хүлээн зөвшөөрч болохыг мэдэгдэв. 1957 оны 9—р сарын хичээлийн анхны өдөр, хар арьст 9 сурагч Литл Рокийн Төв дунд сургуульд элсэн орохоор зэхэж байв. Хичээлийн жилийн нээлтийн урьд өдөр нь, сургуулийн эрхлэгч, тэдгээр сурагчдын эцэг эхэд хэрвээ хүүхдүүдээ дагуулж ирвэл хамгаалах хариуцлагыг хүлээхгүй хэмээн мэдэгджээ. Арканзас мужийн захирагч үүнтэй холбогдуулан хүчирхийллийн аюул гарч болзошгүй хэмээн үзэж Үндэсний Хамгаалалтын Албыг (мужийн захиргааны эрх мэдэлд байдаг цэргийн хүчин) Литл Рок руу илгээжээ. Харамсалтай нь хичээлийн жилийн анхны өдөр Үндэсний Хамгаалалтын Алба хар арьст сурагчдыг сургууль руу оруулаагүй ба цагаан арьстнууд сургуулийн эргэн тойронд сурагчдыг орохыг эсэргүүцэн цугларсан байлаа.

# "Алхам алхмаар" өгүүллэгийн нэмэлт тайлбар




Дэлхийн 2–р дайны эхэн үед Польш улс 375 000 километр квадрат газар нутагтай байжээ. Польшийн газар нутгийн хэсгийг Нацист Герман болон Зөвлөлт Холбоот улс өөрсдийн газар нутаг хэмээн шаардаж байв.

Дэлхийн 2–р дайнаас өмнө, Польшид Герман, Орос, Украйны бага үндэстнүүд амьдардаг байжээ. Тэр үед Европт яллагдсан, тэндээс цөллөгдсөн Еврейчүүд Польш руу дүрвэдэг байлаа. Тэд Польшид шашнаа хадгалан үлдэж, өөрсдийн сургуулиа байгуулжээ. Польш дахь Еврейчүүд Польшийн удирдлагуудтай онцгой харилцаатай байсан учраас Польшид Еврейчүүдийн томоохон хотхон цэцэглэн хөгжжээ. Дэлхийн 2–р дайн эхлэх үеэр, 3 350 000 Еврейчүүд Польшид амьдарч байсан бол дайн дуусахад ердөө л 90 000 нь амьд үлджээ.

1939 оны 9–р сарын 1–нд Германчууд Польш руу довтолсноор Дэлхийн 2–р дайн эхэлж, үүнээс 3 долоо хоногийн дараа ЗХУ ч мөн Польшийг эзэлж авчээ. Польшийн засгийн газар Лондон руу зугтсан бол зэвсэгт хүчний ихэнх хэсэг нь Германчуудтай тэмцлээ үргэлжлүүлэхээр Европын орнууд руу дүрвэжээ. Германчуудын эсрэг тэмцэх Польшийн нууц бүлэг ялангуяа Варшав хотод ихээхэн идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байлаа. 1941 оны 6–р сард Нацист Герман ЗХУ болон Польшийн ЗХУ–д эзлэгдсэн хэсгийг байлдан эзэлсэн бол 6–р сарын сүүл гэхэд Польшийн бүх нутаг дэвсгэр Германчуудын түрэмгийлэлд өртөн эзлэгджээ.

Жишээний үндэс суурь болсон үйл явдлууд: Польшид Нацистууд олон тооны хорих лагерь барьсан ба эдгээр лагериуд нь Польшийн Еврейчүүд, бусад орнуудаас авчирсан Еврейчүүд болон Германчуудын эсрэг боссон Польшуудыг хөнөөхөд зориулагдаж байлаа. Варшавын 450 000 Еврейчүүд эхлээд "Еврейчүүдийн хороолол" хэмээн нэрлэх хотоос зайдуу хэсэгт бөөнөөр хоригдож байгаад дараа нь тэндээсээ хорих лагериуд руу цөллөгджээ.

1944 оны 8–р сарын 1–ээс эхлэн, Польшийн нууц бүлгэмүүд өөрсдийн тактикаа өөрчлөн Нацистуудын эсрэг нээлттэйгээр, зэвсгээр байлдаж эхэлжээ. Мөн оны 10–р сарын 2–нд, Польшийн тэмцэгчдийн удирдагч бууж өглөө. Үүний дараа Нацистууд Варшавын оршин суугчдыг Германы лагериуд руу зөөж, заримыг нь Польшийн бусад хот тосгод руу албадан нүүлгэжээ.

# "Зоригт мухлагийн эзэн" өгүүллэгийн нэмэлт тайлбар




Тайланд бол Зүүн Өмнөд Азид, баруун хойд хэсгээрээ Мъянмар буюу Бирм улстай, зүүн хойд хэсгээрээ Лаостай, зүүн талаараа Камбож, Малайзтай, өмнөд талаараа Тайландын тэнгисийн булантай хил залгаа оршдог улс юм. Тайландын нийслэл хот нь Бангкок бөгөөд хамгийн том хот.

Дэлхийн 2—р дайнаас өмнө Тайландын эдийн засаг хөдөө аж ахуй дээр тогтдог байв. Сүүлийн жилүүдэд Тайландын эдийн засаг улам бүр аж үйлдвэржин хотжилт ихэсчээ. Энэхүү өөрчлөлт нь улс орны нийт баялагийг сайжруулсан боловч, нийгмийн олон асуудлуудыг бий болгожээ. Байгаль орчны асуудал болон газрын хүрэлцээгүй байдал нь Тайчуудыг хөдөөнөөс хот руу олноор нүүхэд нөлөөлж, хот руу шилжин ирэгсдийн зарим нь ажилд орж чадсан бол ихэнх нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэнээр хотын орон гэргүй хүмүүс болон гэмт хэргийн тоо өссөн байна. Тайландад, ялангуяа Бангкок болон бусад томоохон хотуудад залуучуудын гэмт хэргийн бүлгүүдтэй холбоотой асуудал газар авсаар байна.

# "Лагерьт хоригдогсдын зовлонг нимгэлэгч тосгоныхон" өгүүллэгийн нэмэлт тайлбар




Босни—Герцеговини нь Холбооны Бүгд Найрамдах Югослав улс болон Хорваттай хил залгаа оршдог. Баткович тосгон Сараево хотын зүүн хойд хэсэгт, Югославт харъяалагддаг Серби улстай зэргэлдээ оршдог.

1991 оны хүн амын тооллогоор, 4 365 000 хүн Босни—Герцеговинид амьдарч байсан ба тэдний 31% нь Сербчүүд болон Сербийн Үнэн Алдартны шашны гишүүд, 49% нь эцэг өвгөд Оттоманы эзэнт гүрний үед итгэл үнэмшлээ өөрчилсөн Лалын шашинтнууд байжээ. Хүн амын үлдсэн хэсэг нь Ромын Католик шашинтай Хорватууд байв.

Босни ба Герцеговини нь 15—р зууны дунд үеэс Оттоманы эзэнт гүрний ноёрхолд байсан бөгөөд 1908 онд буюу эзэнт гүрэн задарсны дараа Австри—Унгарын эзэнт гүрэнд нэгджээ. Дэлхийн 1—р дайны төгсгөлөөр Австри—Унгарын эзэнт гүрэн задран унахад Босни—Герцеговини нь Серби, Хорват, Словенчүүдийн вант улсын (хожим Югославын хаант улс хэмээн нэрлэгдэх болсон) нэгэн муж болон нэгджээ. 1945 онд Босни—Герцеговини нь Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав улсын нэгэн бүгд найрамдах улс болжээ. Югослав улс дэлхийн 2—р дайны үед, Германы түрэмгийллийн эсрэг гол зэвсэгт эсэргүүцлийн хөдөлгөөнийг явуулж байсан партизануудын удирдагч Иосип Броз Титогоор удирдуулж байжээ.

Удирдагч Тито 1980 онд таалал төгсч, Зөвлөлт Холбоот Улсын хүч суларснаар үндсэрхэг үзлийг дэвэргэх таатай нөхцөл бүрдэж дотоодын хямрал үүсчээ. Улмаар 1991 онд Словени болон Хорват Югославаас албан ёсоор салан тусгаарлах болсноо зарлажээ.

Жишээний үндэс суурь болсон үйл явдлууд: 1992 оны хавар, Босни—Герцеговинийн Лалын шашинтнууд болон Хорват үндэстнүүд Югославаас салан тусгаарлахаар саналаа өгсөн ч санал асуулгыг эсэргүүцэн Боснийн Сербчүүд өөрсдийн засгийн газраа бүрдүүлжээ. Сербийн зэвсэгт хүчний дэмжлэгтэйгээр тэд Боснийн Лалын шашинтнууд болон Хорватуудтай байлдсан юм. Энэ үед энгийн иргэдийг хорих лагерьт саатуулах, алан хядах, тэдний эсрэг террорист үйл ажиллагаа явуулах зэргээр "үндэстэн угсаатны цэвэрлэгээ" гэж нэрлэгддэг тактикийн дагуу, амьдарч байсан газар нутгаас нь хөөн гаргажээ. Энэхүү ярвигтай 3 талт иргэний дайн 1995 оны Дейтоны энх тайвны хэлэлцээрт гарын үсэг зурж, гал зогсоох хүртэл үргэлжилжээ.

# Дайны хор уршиг

1859 оны 6—р сарын 24—нд Австри, Францын армиуд Италийн хойд зүгт орших Сольферино хотод байлджээ. 16 цагийн дараа 36 000 цэрэг шархдаж, амь насаа алдсан байна. 1859 онд хэдийгээр хүний биед хохирол учруулах зэр зэвсгийн хүчин чадал нэмэгдсэн байсан боловч, шархадсан цэргүүдийг асран тэтгэх үйл ажиллагаанд дэвшилт гараагүй байжээ.

Байлдаан болсон үдэш, Швейцарийн иргэн Анри Дюнан хувийн хэргээр Сольферинод иржээ. Түүний бизнес уналтад ороод байсан тул тэрээр Францын эзэн хаан түүнд тусална хэмээн найдан, дайн болвол эзэн хаан өөрийн биеэр ирнэ гэдгийг мэдэж байсан тул тэрхүү завшааныг ашиглан түүнтэй дайралдаж магад хэмээн горьдон Сольферинод иржээ. Гэвч, түүнийг Сольфериногийн хөндий дахь дайн байлдааны аймшигт дүр зураг угтан авчээ. Түүний дуртгалын зарим хэсгээс сонирхуулахад:

Шөнө дундын нам гүмийг эвдэн өвчин зовиур, зовлон шаналалын дуу алдалт, ёолот сонсогдож байлаа. Зүрх зүсэм дуу хоолой энд тэндээс аврал эрэн дуудна.

Нар мандах үеэр дайны талбар цэрэг эрсийн болон хүлэг морьдын цогцсоор хучигдаж, хөөрхийлөлтэй шархадсан цэргүүдийн царай хувхайн цайрч, туйлын ихээр эцэж ядарцгаасан байлаа. Халдварлаж эхэлсэн ил шархтай зарим цэргүүд өвдөлтөөсөө болоод галзуурах шахаж байв. Тэд өөрсдийн энэхүү зовлон шаналлаас аль болох хурдан аврагдахыг эцсийн мөчөө хүртэл гуйцгааж байлаа. Усгүйн зовлон хамгийн том асуудлуудын нэг байсан бөгөөд гуу жалгууд хатаж хувхайрч, цэргүүдэд зөвхөн бохирдсон, давстай ус л үлдсэн байв.

↔

Дюнан өөрөөс нь ус гуйн дуудацгаах шархадсан цэргүүдийн дунд явж байхдаа тэдэнд хүмүүс ямар бага анхаарал халамж үзүүлж буйг олж харжээ. Тэрээр нутгийн эмэгтэйчүүдийг цуглуулан шархадсан цэргүүдэд хоол хүнс, ус авчруулахын тулд тэднийг баг болгон хувааж, нэг хэсгээр нь шархыг цэвэрлүүлэх арга хэмжээ авч шархдагсдыг эмчлэх боломжтой болгож, сүм дотор хээрийн эмнэлэг байгуулж, цэргүүдэд шархны боолт, хоол хүнс, эмнэлгийн хэрэгсэл, эм зэргийг хөрш зэргэлдээх хотуудаас авчран, хүүхдүүдээр хувингаар ус зөөлгөн, сэтгүүлч, жуулчид, гүнтэн, шоколад үйлдвэрлэгчид гэх мэт баян ядуу, дээд, доод зиндааны янз бүрийн ажил мэргэжилтэй хүмүүсийг эгнээндээ нэгтгэжээ. Ингэснээр, эдгээр хүмүүс шархдагсдыг асран сувилах, уух ус, хоол хүнсээр хангах, амь тавих гэж буй хүний ар гэрт нь хагацлын захиа бичиж өгөх зэргээр өөрсдийн чадах бүхнээрээ туслах болсон юм. Энэ үед Дюнаны ажигласнаар, тусалж буй хүмүүст шархдагсдын яс үндэс, уг гарал нь огт хамаагүй болж, тэд бүгдээрээ нэгэн ахан дүүс мэт болцгоосон байжээ.

Дюнан зүүн талдаа хүнд шархтай, эдгэрэх найдлагагүй 20 настай нэгэн цэрэгтэй учрав. Түүнд ус өгөхөд тэрээр баярлан авч, нүдэндээ нулимс дуслуулан байж иймхүү хэлжээ: "Эрхэм ээ, та аавд маань ээжийг сайн тайтгаруулаарай гэж захиа бичиж өгөөч." Дюнан түүний гуйсан ёсоор эцэг эхэд нь захидал илгээжээ. Энэ бол тэдний хүүгээсээ авсан цорын ганц мэдээ байлаа.

Дюнаны бизнес амжилтгүй болж, тэр өдрөөс л Францын эзэн хаантай уулзах бодлоо ч таягдан хаяжээ. Харин тэрээр юу үзэж харсан тухайгаа илэрхийлсэн, бас энгийн нэгэн саналыг дэвшүүлсэн "Сольфериногийн Дуртгал" хэмээх дурсамж номоо бичиж үлдээжээ. Тэрхүү санал нь:

Дайн байлдааны үед шархадсан цэргүүдийг асран халамжлах зорилгоор, тэдэнд зүрх сэтгэлээ зориулсан, сайтар бэлтгэгдсэн сайн дурын идэвхтнүүдээр дамжуулан тусламж үзүүлдэг нийгэмлэгүүдийг энхийн цагт бий болгож болохгүй гэж үү?



# Гэрч айсуй

1993 оны 4—р сард апартейдийн эсрэг Өмнөд Африкийн тэмцэл ямар нэгэн цуст мөргөлдөөнгүйгээр ялалтаар өндөрлөв. Тэмцлийн гол удирдагч, Африкийн Үндэсний Конгресс (АҮК)—ийн тэргүүн Нельсон Мандела 27 жил хоригдсоны дараа шоронгоос суллагдан, Ерөнхийлөгч F.W. де Клерктэй, удирдлагыг олонхын гарт шилжүүлэх талаар хэлэлцээр хийжээ.

4—р сарын 10—нд АҮК—ийн нэрт удирдагч Крис Хани Жоханесбург хотын Боксбург дахь гэрийнхээ өмнө төө орчим зайнаас буудуулан алагдсан юм. Гэмт хэрэгтнүүд Ханиг өөрсдийн гэмт үйлдлийн бай болгон сонгон авсан шалтгаанаа түүний үхэл улс орныг эмх замбараагүй байдалд оруулан улмаар улс төрийн баруун жигүүр төрийн эрх мэдлийг гартаа авах боломжийг олгох магадлалтай хэмээн тайлбарлаж байлаа.

Дээрх үйл явдлын талаар Мандела өөрийн намтар номондоо ийнхүү бичсэн байдаг:

Крисийн үхэл надад болон хөдөлгөөнд маш хүнд цохилт байлаа. Тэрээр Өмнөд Африкийн залуучуудын хувьд тэдний сонсдог, тэдний хэлээр ярьдаг баатар эр байсан юм. Хэлэлцсэн тохиролцооны цаана байгаа цадиггүй, дуулгаваргүй залуучуудыг идэвхжүүлж хөдөлгөөнд оруулж чаддаг ганц хүн бол тэр л байсан юм.

Улс орны байдал маш хурцадмал байлаа. Залуучууд түүний төлөө амиа золиослохоос ч буцахааргүй байсан тул Крис Ханигийн үхэл арьс өнгөөр ялгаварласан дайнд ч хүргэж болзошгүй гэсэн айдас улс орныг нөмөрч авлаа. Аллага хэлэлцээрийн явцыг нураах зорилготой цөхрөлт оролдлого байсан юм.

Аллага болсон өдөр нэгэн эмэгтэй цагдаа руу утасдан алуурчны автомашины дугаарыг мэдэгджээ. Хамгийн сонирхолтой нь тэрээр цагаан арьстай эмэгтэй байлаа.

Энэхүү үйл явдал болсон орой Манделагаас ард түмэндээ хандан радиогоор үг хэлэхийг хүссэн юм. Тэрээр өөрийн намтартаа тэр үед хэлсэн үгээ ингэж тэмдэглэсэн байдаг:

Энх тайван, хэлэлцээрийн үйл явц дундаа тасалдаж болохгүй гэж би хэлсэн. Өөрийн захиран тушаах бүхий л эрх мэдлийн хүрээнд би ийнхүү хэлсэн юм:

Би ард түмнээ тайван байцгааж, Крис Ханигийн гэгээн дурсгалыг, энх тайвны төлөө сахилга батыг хангах замаар хүндэтгэхийг уриалж байна. Энэ үдэш би хар, цагаан арьст Өмнөд Африкийн хүн бүрт өөрийн сэтгэл зүрхний угаас хандаж байна. Үзэн ядалт, нэг талыг баримталсан үзлээр дүүрсэн нэгэн цагаан арьстан манай оронд ирж, бид бүхнийг гамшгийн ирмэгт авчирсан шударга бус хэргийг үйлдсэн билээ. Гэтэл, цагаан арьст өөр нэгэн бүсгүй, энэхүү аллагыг шударга үнэнээр шийдүүлэхийн тулд өөрийн амь насаараа дэнчин тавьж байна.

Энэхүү алан хядлага улс орны хэмжээнд үймээн самуун, арьс өнгөний дайн дэгдээж чадаагүй ба энх тайвны гэрээ хэлэлцээрүүд үргэлжилжээ.

Асуулт: Энэхүү эмэгтэй зориглон гарч ирснээрээ өөртөө ямар эрсдэл хүлээсэн бэ?



# Модон сандал дээрээ ганцаараа

1954 оныг хүртэл АНУ–ын зарим мужуудад хар арьст сурагчдыг цагаан арьст сурагчидтай нэг сургуульд суралцахыг хориглосон хуулиуд хүчин төгөлдөр хэвээр байлаа. АНУ–ын Дээд Шүүх арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах хуулиудыг улс орон даяар хориглох шийдвэр гаргахад, Арканзас мужийн захирагч энэхүү тушаалыг дагаж мөрдөхгүй гэдгээ мэдэгджээ. Тэрээр негр хүүхдүүд Сентраль ахлах сургуульд орохоор завдах юм бол хотын гудамжаар цус урсах болно хэмээжээ.

Харин Литл Рок хотын сургуулийн зөвлөл өөр төлөвлөгөөтэй байлаа. 1957 оны хичээлийн жилийн эхэнд, дан ганц цагаан арьстнуудын Сентраль ахлах сургууль 9 хар арьстан сурагчдыг элсүүлэхийг зөвшөөрөв. Элизабет Экфорд тэдний нэг байлаа.

Литл Рок сургуулийн захиргаа эдгээр 9 сурагчдын эцэг эхийг, сургууль дээр хүүхдүүдээ дагуулан ирэхгүй байхыг хүсчээ. Учир нь Африкын Америк эцэг эхчүүд тэнд очсоноор эсэргүүцэл үзүүлэхээр хуран цугласан олны бухимдлыг улам дэвэрээнэ хэмээн айж байлаа. Эцэст нь, эдгээр 9 сурагч нэгэн хуульчийг дагалдан сургууль руу явахаар болжээ. Харин Элизабет дээрх зохицуулалтын талаар мэдээгүй өнгөрсөн байна.

Хичээлийн эхний өдөр хотын Сентраль ахлах сургуулийн ойролцоо автобуснаас буун сургууль руу явах замдаа тэрээр уурлан бухимдсан цагаан арьстнууд болон хотын захирагчийн дээрх 9 сурагчийг сургууль руу ороход нь саад болох зорилгоор илгээсэн зэвсэглэсэн цэргүүдийг харжээ. Элизабет Арканзас мужийн цэргүүдийн араас алхаад орвол аюулгүй байж магад хэмээн бодсон боловч цэргүүд түүнийг буцаажээ.

Цугласан хүмүүс миний араас элдвээр дуудан доромжилсоор байлаа. Гэнэт миний өвдөг чичрэн, би цаашаа явж чадах эсэхдээ эргэлзэж эхэлсэн. Энэ бол миний амьдралдаа алхсан хамгийн урт зам байлаа. Тэгсэн хэдий ч би харуулууд намайг хамгаална хэмээн бодож төдийлөн их айгаагүй.

Сургуулийн өмнө ирээд харуулд дөхөж очиход тэр намайг үл ойшоон урагшаа харж, дотогшоо оруулаагүй. Би юу хийхээ ч мэдэхгүй байлаа. Тэр үед өөр нэгэн харуул цагаан арьст сурагчдыг дотогш оруулсаар байлаа. Би түүний өмнүүр дотогш орох гэтэл тэр над руу бороохойгоо далайлгасан.



Энэ үед хэн нэгний, "Түүнийг шийтгэ, түүнийг шүүтгэ" гэсэн дуу хадлаа. Би тэр үед ядаж нэг ч гэсэн хүний найрсаг царайг олж харахыг ямар их хүсч байсан гээч... Гэтэл, нэгэн эмэгтэйтэй харц тулгарахад тэр миний нүүр лүү нулимж орхив. Яахаа мэдэхээ больсон би гудамжны үзүүр ширтэн, автобусны буудлын сандлыг олж харлаа. Тэр зүг хар хурдаараа гүйн очиж, сандал дээр суулаа. Цугласан олны зарим нь "Түүнийг мод руу чир" хэмээн Элизабетийн араас орилсоор буудал хүртэл даган явжээ. Энэ нь "түүнийг дүүжил" гэсэн үг байлаа.

Тэрээр сандал дээр сууж байсан мөч нь түүнд үүрд мөнх, хэзээ ч дуусахгүй юм шиг санагджээ. Энэ үед Грейс Лорч хэмээх нэгэн цагаан арьст эмэгтэй цугласан олны дундаас гарч ирээд Элизабеттэй ярилцав. Элизабет түүн рүү аажмаар эгцлэн хараад босч явав. Үл таних эмэгтэй ойролцоох автобусны буудал хүртэл дагалдаж хамт явснаар Элизабет цугласан олноос ийнхүү зугтаж чаджээ.

Асуулт: Цугласан олон яагаад Грейс Лорчийг Элизабетийн аюулгүй байдлыг хангахад нь саад болоогүй вэ?

# Алхам алхмаар

Нацист Герман дэлхийн 2—р дайны үед Польшийг эзлэн авах үед, цэргийн хүчин Еврейчүүдийг боолчлох, устгах бодлого барьж байв. Польшид Еврейчүүдийг нуун орогнуулсан хүмүүсийг цаазаар авах ялтай байлаа. Заримыг нь олны өмнө талбай дээр дүүжлэн хороож бусдад анхааруулга болгон үзүүлдэг байжээ. Гэсэн хэдий ч, зарим хүмүүс Еврейчүүдэд туслах замыг сонгосоор л байлаа. Католик шашинтан үйлдвэрийн ажилчин Штефа өөрийн танихгүй хэн нэгнийг аврахаар гайхамшигт зүйл хийсэн нэгэн юм.

1942 онд Польшийн нууц бүлгэмд ажилладаг цагдаа Ламински, Штефагийн нөхөр Жерезигээс, Ирена хэмээх Еврей бүсгүйг хэд хоног нууж өгөөч хэмээн гуйжээ. Хосууд нэг өрөө байрандаа орогнох нууц газар бэлдэж өгөв. Хэдхэн өдөр нь хэдэн долоо хоног болж, хэдэн долоо хоног нь улмаар хэдэн сар үргэлжилжээ. Хэдэн сарын дараа, Жерези Иренаг явахыг шаардсан боловч Штефа, еврей бүсгүйг гэртээ цаашид ч нуух болно хэмээн эсэргүүцжээ. Уурлан бухимдсан Жерези гэрээсээ явахдаа Штефад, түүнийг Еврей бүсгүйг нууж байгааг нь цагдаад мэдэгдэнэ хэмээн сүрдүүлжээ.

**Штефа юу хийсэн бэ?**

Би Ламински руу утасдаж, тэр нөхөртэй маань уулзахаар явсан юм. Тэрээр Жерезид: "Миний буу энэ байна. Хэрвээ чи Ирена, Штефа хоёрын талаар мэдэгдэх л юм бол, чи 5 минут ч амьдрахгүй шүү. Эхний сум л чиний толгойг онох болно" гэжээ Үүний дараа нөхөр маань буцаж ирээгүй, ингэснээр бидний гэрлэлт цуцлагдсан ч, Ламински цагдаа бидэнд тусалсаар байсан юм.

**Штефа өөрт учирч болзошгүй аюулын талаар мэдэж байсан уу?**

Мэдээж би мэдэж байсан. Еврей хүнийг нуусан хүнд юу тохиолдож болохыг бүгд маш сайн мэдэж байлаа. Ирена, "Би та нарт их дараа болж байна. Би явсан нь дээр" гэдэг байсан ч би хариуд нь "Одоог хүртэл бид чамайг амжилттай нууж чадсан юм чинь цаашдаа ч бид чадах юм билүү. Чи яаж бууж өгч чадаж байна аа?." гэж хэлдэг байсан. Би түүнийг зүгээр л тэгээд явуулж чадахгүйгээ мэдэж байлаа.

1944 онд, Варшавын оршин суугчид Нацистуудын ээрхийллийн эсрэг тэмцсэн боловч ялагдлаар төгсч, өс хонзонгоо авахын тулд Нацистууд хүүхэдтэй эхчүүдээс бусад бүх энгийн иргэдийг орон байрнаас нь нүүлгэн хөөж эхэлжээ. Иренагийн хувьд хэдийгээр нүүрээ битүүлдэг байсан ч гэсэн Еврей гэж танигдах болохоор, нүүлгэн шилжүүлэг нь үхэлтэй адил байлаа. Энэхүү аюулыг мэдэрсэн Штефа туйлын хүнд шийдвэр гаргажээ. Тэрээр уйлан байж ийнхүү үргэлжлүүлэн ярьсан юм:

↔

Биднийг нүүлгэн шилжүүлэх гэж байхад, би Иренагаас хүүхдийг минь авахыг хүссэн юм. Би түүнд, "Би чамтай хамт байхыг хичээх болно. Хэрэв бид төөрөлдвөл миний хүүхдийг өөрийн хүүхэд шигээ л хайрлаж халамжлаарай" гэж захисан юм. Герман офицер түүний хүүхэдтэй байхыг хараад байр луугаа буцахыг нь зөвшөөрсөн юм. Яагаад ч юм намайг ч гэсэн Иренатай явахыг зөвшөөрсөн юм.

**Штефа хүүхдээсээ хагацах эрсдэлд яаж орсон бэ?**

Ирена хүүхдийг минь сайн асарна гэж би мэдэж байсан. Хажуугаар нь, надад юу тохиолдож болох байсныг хэн ч мэдэхгүй. Би ч мөн амь насаа алдаж болох байлаа.

**Асуулт:Иренаг амьд үлдэхэд хүн болгон ямар хувь нэмэр оруулсан бэ?**





# Зоригт мухлагийн эзэн

Бангкок хотын нэгэн гудамжны буланд үргэлж бүлэг хөвгүүдийн зодоон цохион болдог байжээ. Нэгэн өдөр, механикийн сургуулийн хэсэг хөвгүүд өөр сургуулийн хөвгүүнийг зодохоор зам уруудан араас нь нэхэн хөөж эхлэв. Хөөрхий хөвгүүн аврал эрэн гүйж явлаа. Тэрээр замын булан дахь нэгэн мухлагт хүрч очжээ. Хөөж яваа хөвгүүд нь энэхүү дэлгүүрийн байнгын үйлчлүүлэгчид юм.

Аз болоход, мухлагийн эзэн энэ бүгдийг ажиглаж байжээ. Хөөрхий хүү түүний хаалгыг тогшив.

↔

Тэрээр хүүг хурдхан арын хаалгаараа сэмхэн оруулан дэлгүүр дотроо нуужээ.

Мухлагийн эзэн, дэлгүүрээр нь үйлчлүүлдэг хөвгүүд түүнийг дайсныг нь нуусныг олж мэдвэл яах бол гэсэн бодолд автсангүй. Хөвгүүд түүнийг зугтаж явсан бандийг аварсан гэж мэдвэл өөрийнх нь бизнесийн ашигт хэрхэн муугаар нөлөөлж болох байсан ч энэ нь түүнийг зогсоогоогүй юм.

Асуулт: Хаалган дээр нь ирсэн хүүг харсан мухлагийн эзэнд ямар сонголтууд байсан бэ? Сонголт бүрийн үр дагавар нь юу байж болох байсан бэ?

# Лагерьт хоригдогсдын зовлонг нимгэлэгч тосгоныхон



Баткович тосгон, Босни—Герцеговини, 1993 оны 1 сарын 24

Өнгөрсөн зунжингаа, Лал болон Хорват хоригдлуудыг ачсан автобус, ачааны машинууд Илийа Гайичийн ногооны талбайг дайрсан нарийхан замаар явдаг байлаа. Улсын үр тариа хураах нөөцлөх газар хорих лагерь барих үедээ зэвсэгт хүчин тосгоныхонтой огт зөвлөлдөөгүй байжээ. Гайич Балканы түүхийн хамгийн эмгэнэлт явдал дахин давтагдах вий хэмээн ихэд айж байв.

"Хорих лагерь хэзээ ч хэнд ч сайныг авчирдаггүй" хэмээн 4000 гаруй хүн амтай Баткович тосгоны хуралдааны дарга, 62 настай Серби өвгөн ярилаа. Тэрээр "Ийм юм болж байхыг хараад үнэхээр эвгүй байлаа" гэжээ.

↔

Зодуулсан, алуулсан хүмүүсийн тухай мэдээ ихсэх тусам өвгөн болон бусад тосгоны удирдагч нар эсэргүүцэхээр шийдлээ. Түүний түүх зогсолтгүй үргэлжилсэн харгис, хэрцгий дайны яригдаагүй түүхүүдийн нэг билээ. Мөн элэг нэгт ард иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлэхийн төлөө өөрсдийгөө эрсдэлд оруулсан Сербчүүдийн ч гэсэн түүх юм.

"Бид нар сайн санааны үйлдэл хийхийг хүссэн. Бид, манай хоригдлуудад нөгөө тал ингэж хандаасай гэж боддог шигээ тэдэнд мөн тиймээр хандаасай гэж хүсч байсан юм".

9—р сарын эхээр Гайич хэсэг төлөөлөгчдийг дагуулан Биелина дахь армийн жанжин штабийн газар очин, хоригдлуудтай зүй бусаар харьцан зодож байгаа харгалзагч нарыг халахыг шаарджээ. "Тэдгээр харгалзагч нар эндхийн хүмүүс биш, тэдний гэр бүлийнхнээс дайнд нэрвэгдсэн байсан болоод л тэд өшөөгөө авахыг хүсч байсан юм. Тийм ч учраас бид захиргаанаас орон нутгийн хүмүүсийг харгалзагчаар тавина уу хэмээн хүссэн юм" хэмээн Гайич хэлэв.

Цэргийн командлагч эхэндээ маш их дургүйцэж, тэр ч байтугай өөрсдийг нь хариуцсан даргынхаа нэрийг хүртэл хэлэхээс татгалзаж байлаа. Тэдний ярианы өнгө улам хурцдахад төлөөлөгчдийн нэг нь цэргийн командлагч нарт, "Бид нар Ясеновацийг хүсэхгүй байна" гэлээ. Ясеновац гэдэг нь дэлхийн 2—р дайны үед Хорват фашистуудын барьсан хорих лагерь бөгөөд олон арван мянган Серби, Еврей, цыгануудыг алагдсан газар юм.

"Ямар ч сайн хүн ингэж хэлэх байсан юм" хэмээн хожим нь Гайич дурсана. "Тосгонд юу болсноос болж хүмүүс биднийг буруушаахыг хүсээгүй, бид тосгоныхоо нэр хүндийг л авч үлдэхийг хүсч байлаа".

Ашиглах материал 6—6

Харгалзагч нар хажууд нь байсан болохоор, хоригдлууд өмнө нь тэдэнд хэрхэн зэрлэг балмад авирладаг байсан талаар төдийлөн нээлттэй ярихгүй байв. Гэвч тэд өмнө нь суллагдсан саатуулагсдын хэлж байсанчлан тэднийг зузаан хавтгай модоор балбасан тухай, туйлын муу ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлөөс улаан суулга өвчин үүсэн хурдацтай тархаж буй тухай болон тэнд 18—аас доош, 60—аас дээш настай хүн байхгүй гэсэн бодол зочилж буй төлөөлөгчдөд төрүүлэх сайтар боловсруулан тактик хэрэглэж буй талаар ярьж өгчээ.

Саатуулагсдын хэлж байгаагаар, 9—р сар хүртэл зодож, зүй бусаар харьцаны улмаас наад зах нь 20 хоригдол амь насаа алджээ. Гэсэн хэдий ч тосгоныхон оролцож эхэлснээр байдал харьцангүй сайжирч чадсан байна.

Ерөнхий нөхцөл байдал хэвээр үлдсэн ч хэдэн зуун саатуулагсад долоо хоногийн 6 өдөр ойролцоох үйлдвэрт ажиллан, цалингүй ч гэсэн арай илүү сайн хоол идэх боломжтой болжээ. Хоригдлууд харгалзагч нарыг сайшааж, харгалзагч нар ч тэднийг үгийг хүлээн авдаг болжээ. Драголич хэмээх шинэ харгалзагч, "Бид хоригдлуудыг зодох хэрэггүй юм шиг санагддаг, бид тэдэнтэй зүгээр л юм ярьдаг" гэв. Тэд хоригдлуудын байранд зурагт тавиад зогсохгүй, шинэ жилээр сливовиц хэмээх жимсний дарс хэдэн лонхыг авчирч өгчээ.

"Миний бодлоор, Сербчүүд хүн бүрийн хэлдэг шиг тийм ч муу хүмүүс биш байх" хэмээн Гайич хэлж байлаа. "Иймэрхүү жишээ зөвхөн Баткович ч бус өөр олон газар байдаг байх" хэмээн тэр яриагаа өндөрлөсөн юм.

Асуулт: Хөндлөнгөөс ажиглагчдад ямар сонголт болон нийгмийн дарамт учирсан бэ?

# Судалгаа 1 В. Хүмүүнлэгийн үйлс

Судалгаа 1А—д, сурагчид хөндлөнгөөс ажиглагчдын тухай янз бүрийн жишээ үйл явдлуудтай танилцаж, тэдний дүрд тоглож, дүн шинжилгээ хийсэн билээ. Харин Судалгаа 1В нь сурагчдыг эдгээр түүхүүдийн зүрх нь болж байсан хүмүүнлэгийн зан үйл, өөрөөр хэлбэл хүмүүнлэгийн үйлсийн ойлголтыг тодорхойлох, эргэн харах боломжийг олгож байгаа юм.

Энэхүү судалгаанд хүмүүнлэгийн үйлсийг, "ихэвчлэн ердийн нөхцөлд хамгаалагдаад байдаггүй хувь хүний амь нас, нэр хүндийг хамгаалахаар хийгдэж буй эрсдэл, гарз хохирол дагалдах магадлал ихтэй үйлдэл" гэж тодорхойлсон.

Хүмүүнлэгийн үйлсийг тодорхойлж, болзошгүй эрсдэл, саад тотгорын хэм хэмжээг авч үзсэний үндсэн дээр, сурагчид зэвсэгт мөргөлдөөний үеийн хүмүүнлэгийн үйлсүүдийн бодит жишээг судлах ба тулгарсан эрсдэл, саад бэрхшээлүүдийг хэлэлцэх болно.

**Зорилго:**

- Хүмүүнлэгийн үйлсийн ухагдахууныг ойлгож авах
- Аливаа хүний амь нас, нэр хүнд эрсдэлтэй байгаа нөхцөлд юу хийх вэ гэдэг асуудал дээр нийгмийн зүгээс учруулах дарамтын нөлөөллийг ойлгох
- Мэдээ мэдээлэл болон өдөр тутмын амьдрал дахь хүмүүнлэгийн үйлсийг ялган таних чадвартай болох

**Ашиглах материалууд:**

- Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой — 1

**Бэлтгэл ажил:**

Багш нарт 10: "Түүх, мэдээ цуглуулах"—ийг үзнэ үү.
Энэхүү судалгаанд хэрэглэгдэж буй доорх 2 ойлголтоор үзүүлэн бэлдэнэ үү.

1. Хүмүүнлэгийн үйлсийн шинж чанарууд
2. Нийгмийн дарамт

**Хугацаа:**

- 45—60 минутын нэг хичээл

**Алхам 1. Хүмүүнлэгийн үйлсийн ухагдахуун** (15 минут)

Хүмүүнлэгийн үйлсийн доорх 3 шинж чанарыг танилцуулаад сурагчдаар, шинж чанар бүрийг илэрхийлэх Судалгаа 1А—д өгүүлэгдсэн түүхүүдээс жишээ гаргуулна уу.

**Хүмүүнлэгийн үйлсийн шинж чанарууд**

- Хүний амь нас, нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн
- Тэр бүр хамгаалаад байдаггүй хүнийг хамгаалах
- Хувийн эрсдэл, гарз хохирол дагалдах магадлалтай

Хүмүүнлэгийн үйлсүүд нь хохирогчийг хамгаалахын тулд ихэвчлэн нийгмийн дарамтын эсрэг үйлдэл хийх хэрэгтэй болдог. Аливаа хүмүүнлэгийн үйлсийг дэмжсэн буюу түүний эсрэг нийгмийн дарамт хэрхэн хүчтэй болохыг доорх нийгмийн дарамтыг дүрсэлсэн шулуун зураасыг ашиглан үзүүлнэ үү.

**Нийгмийн дарамт**

Хамгаалахын эсрэг ←————→ Хамгаалахын төлөө

## Судалгаа 1 B. Хүмүүнлэгийн үйлс

Судалсан түүхүүд болон сурагчдын мэддэг үйл явдлуудыг ашиглан, доорх асуултуудыг сурагчдад тавина уу:

- Уг үйлдлийг доорх шулуун зураасны хаана нь тавих вэ, яагаад?
- Нийгмийн нөхцөл байдал аливаа хүний амь нас, нэр хүндийг хамгаалахаар зориглон хийсэн үйлдэлд хэрхэн нөлөөлж байна вэ?

[Жишээ нь: "өөрийгөө л хичээ" гэсэн нийгмийн дарамт, эсвэл мөрдөлт мөшгилтөд гар бие оролцохыг дэмжсэн нийгмийн дарамт нь хохирогчийг хамгаалах үйлдлийг улам хүндрүүлдэг.]

### Боломжит асуултууд:

- Яагаад бусад хөндлөнгөөс ажиглагчид огтхон ч туслаагүй байсан бэ?
- Хөндлөнгөөс ажиглагчийн үйлдэл, бусад хүмүүсийн туслах болов уу хэмээн хүсэн хүлээж байсан байдлыг хэрхэн өөрчилсөн бэ?
- Жишээ үйл явдалд гарсан хөндлөнгөөс ажиглагчдыг тусална гэж хүмүүс яагаад бодоогүй вэ? Бусдад туслахын тулд тэд ямар нийгмийн дарамтыг эсэргүүцэх хэрэгтэй болсон бэ?
- Соёл, анги давхарга болон шашин шүтлэг хүмүүсийг хохирогчдод туслах, эс туслахад нөлөө үзүүлсэн ямар түүхэн жишээ байна вэ?
- Нийгмийн дарамтын сайн болон муу үр нөлөөллийн жишээг олж чадах уу?

Сурагчдад өмнөх судалгаа хичээлээр дүн шинжилгээ хийсэн жишээ үйл явдлууд болон тэдний мэдэж болох бусад жишээг эргэн сануулна уу.



### Алхам 2. Сүүлийн үед болсон зэвсэгт мөргөлдөөний хүмүүнлэгийн үйлсүүдийг авч үзэх (20 минут)

"Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой – 1" – ийг танилцуулна уу.

Энэхүү түүхийн хэсгүүдийг сурагч бүрт оноож, сурагчид оногдсон хэсэгт гарч буй хүмүүнлэгийн үйлсийг тодорхойлон бичнэ. Дараа нь доорх асуултуудын дагуу тухайн болсон үйл явдлыг товчхон тайлбарлана:

- Юу болсон бэ?
- Нийгмийн дарамтыг дүрсэлсэн шугамын аль хэсэгт нь тухайн үйлдлийг тавих вэ? Яагаад?

Жич: Хэрэв шаардлагатай гэж үзвэл, дайны үеийн нөхцөл байдал болон сэтгэл зүй нь хэрхэн хүмүүнлэгийн үйлсийн эсрэг дарамтыг бий болгож байна вэ гэдгийг харуулахын тулд эхлээд анги нийтээрээ уг түүхийн нэг хэсгийг хэлэлцэнэ үү.

Тэдний хийсэн ажлыг авч хэлэлцэнэ.

### Боломжит асуулт:

➤ Эрсдэлд байгаа хүнийг мэдэхгүй байх нь, эсвэл, тухайн хүн бидний дайсан гэж бодож байгаа үед ямар нэгэн ялгаа бий юу?

### Алхам 3. Үйлдэл хийх эсэхээ шийдвэрлэхэд гардаг хүндрэлүүдийг үнэлэх (10 минут)

Хүмүүнлэгийн үйлсийн гурав дахь шинж чанар болох "Хувийн эрсдэл, гарз хохирол дагалдах магадлал" – ын талаар ярилцана уу.

# Судалгаа 1 В. Хүмүүнлэгийн үйлс

➤ Үүнд ямар эрсдлүүд байж болох вэ?
[ Жишээ нь; сэтгэл хөдлөлийн, нийгмийн, сэтгэл зүйн болон бие махбодийн ]

Сурагчдаар ямар нэгэн хүмүүнлэгийн үйлсийг сонгуулаад, тэрхүү үйлдэлд тулгарч болзошгүй эрсдэл, хүндрэлүүдийг жагсаан бичүүлнэ үү.

Аливаа хүний хүмүүнлэгийн хариу үйлдэлд хувь хүний зан чанарын ялгаатай байдал болон амьдралын нөхцөл байдлын ялгаатай байдал хэрхэн нөлөөлдгийг ойлгоход нь сурагчдад тусална.

**Хаалт** (5 минут)

Хүмүүнлэгийн үйлсийн шинж чанаруудыг эргэн тоймлох замаар дүгнэлт хийнэ. Хэрэв боломжтой бол, шинж чанар бүрийг сурагчдын татсан жишээн дээр тайлбарлан үзүүлнэ.

*Францын Хувьсгалын үед цаазаар авах ялаар шийтгүүлсэн хүмүүсийг аварсан Скарлет Пимпернелийн тухай би нэгэн ном уншсан юм. Тэрээр эрсдэлд дуртай хүн юм шиг санагдсан. Миний бодлоор, түүний хувь хүний онцлог шинж чанар нь ийм үйлдэл хийхэд нь түлхэц болсон байхаа.*

—Нэгэн Америк оюутан

**ГОЛ САНААНУУД**

- "Хүмүүнлэгийн үйлс" гэдэг нь ихэвчлэн ердийн нөхцөлд хамгаалагдаад байдаггүй, амь нас, нэр хүндэд нь аюул тулгарсан хүмүүсийг хамгаалахаар хийгдэж байгаа үйлдлийг хэлнэ. Ихэнх тохиолдолд эрсдэлтэй байдаг.
- Хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилго бүхий хүмүүнлэгийн үйлс нь зарим нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан бэрхшээлтэй учирдаг.

# Нэмэлт дасгал

**Түүх ба соёл**

Өөрийн мэддэг хүмүүнлэгийн ямар нэгэн үйлсийн тухай бичнэ үү. (өөрт тохиолдсон үйл явдал, кино, радио, телевиз, түүх болон дэлхий дахинаа болж өнгөрсөн үйл явдлуудаас жишээ авч болно)

Сурагчид Арслан Зүрхт Ричардыг эмчилж буй Салах Эль Диний түүх болон 20—р зууны үлгэр дууриал болсон Оскар Шиндлерийн түүхэн жишээг иш татаж байв.

**Хэвлэл мэдээлэл**

Хүмүүнлэгийн үйлстэй холбоотой янз бүрийн түүхэн үйл явдлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээс хайна уу. Олсон мэдээллээрээ товхимол буюу ханын сонин хийж болно.

Тухайн хүмүүнлэгийн үйлс хэзээ, хаана болсон талаар олсон мэдээллийн тоймыг бичих ба мэдээллийн эх сурвалжуудыг тодотгоно.

Дээрх үйлдлүүдэд, хүмүүнлэгийн үйлсийн доорх гурван шинж чанарт тулгуурласан дүн шинжилгээ хийнэ үү:

- Хүний амь нас, нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн
- Тэр бүр хамгаалаад байдаггүй хүнийг хамгаалах
- Хувийн эрсдэл, гарз хохирол дагалдах магадлалтай

# Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой– 1

Сүүлийн үед болсон дайнд оролцсон хүмүүс өөрсдийн хийсэн, үзэж харсан болон сонссон хүмүүнлэгийн үйлсүүдийн талаар ийнхүү ярьж байна.

1 Нөхрийг минь дайснууд баривчлан саатуулах лагерьт хорьж байхад дайсны талын нэгэн хүн нөхөрт маань хоол хүнс, хувцас хунар авчирч өгснийг хэн ч мэдээгүй юм. Тэр миний нөхрийг суллаж явуулж чадаагүй ч чадах чинээгээрээ л тусалсан. Би тэр хүнтэй уулзахсан гэж боддог.

–Дайнд нөхөр нь ор сураггүй алга болсон эмэгтэй

2 Манай тосгонд дайсны талын нэгэн гэр бүл амьдардаг байшин байлаа. Манай аав тэр байшинг хамгаалдаг байсан бөгөөд би түүгээр бахархдаг юм. Хүмүүс тэднийг алахыг, бас хөөн зайлуулахаар янз бүрээр оролддог байсан ч аав маань тэднийг хамгаалсан юм.

–Нэгэн эх

3 Би бөмбөгдөлтөд өртөж гэр нь нурсан нэгэн хүнд туслахаар очсон. Тэр хүн миний гэр бүлийн нэг гишүүний амийг хөнөөсөн байсан ч миний хүнлэг чанар намайг ийм зүйл хийхэд хүргэсэн юм. Тэр намайг түүнийг миний хамаатныг алсан гэдгийг мэдэж байгааг мэдээгүй л дээ. Гэсэн хэдий ч би түүнд тусалсан юм.

–Нэгэн шашны удирдагч

4 Бид дайсны талын хөгшин хоригдлууд, энгийн иргэдтэй хамт байлаа. Тэд өндөр настай байсан учраас бид хүний ёсоор харьцаж байв. Тэднийг суллан явуулж болохгүй байсан ч тэдэнтэй элдэг зөөлөн харьцаж байлаа. Бид юу болохыг шийддэг хүмүүс ч биш. Гэвч тэд бидэнтэй илүү аюулгүй, хамгаалалттай орчинд байсан юм.

–Нэгэн цэрэг

5 Бидний дотны хүмүүсийн маань амийг хөнөөсөн дайсны олон шархадсан цэргүүдийг баривчилсан боловч, тэднийг эмнэлэгт аваачин асрамжилсан юм. Манай шашинд дайны хоригдлуудын амийг хөнөөх болон тэдэнд муу зүйл хийхийг хориглодог юм.

–Өмнө нь тэмцэгч байсан нэгэн мужаан

6 Эргэж ирэх эсэхээ ч мэдэхгүйгээр, танихгүй хүмүүсийн төлөө өөрсдийн амьдралыг эрсдэлд оруулдаг, хүмүүнлэгийн харуул жолооч нар ч мөн тэнд байсан юм.

–Нэгэн сэтгүүлч

7 Би 14 настай байхдаа нэгэн хянан шалгах цэг дээр харуул хийдэг байв. Нэг удаа машин зогслоо. Тэдний бичиг баримтыг шалгаж байхдаа тэдгээр хүмүүсийн нэг нь Лалын шашинтан болохыг нь илрүүлсэн ч бичиг баримтыг нь хурдхан буцааж өгөөд, жолоочид цаашаа яв хэмээн хэллээ. Хэрвээ би түүнийг Лалын шашинтан болох талаар мэдээлвэл түүний хувьд бүх юм дууслаа гэсэн үг. Би төлөв төвшин айлын охин, хүнлэг ёсны үнэ цэнийг мэдэрч өсөж хүмүүжсэн хүн учраас энэ бүхнийг хийсэн юм.

–Нэгэн хуучин байлдагч

–Хуучны байлдагч

8 Манай цэргүүд тосгоноос 500 энгийн иргэдийг шоронд хорихоор авч явав. Уг нь ийм зүйл хий гэж тушаагаагүй гэдгийг би мэдэж байсан болохоор, цэргүүдэд энэ талаар хэлсэн ч тэд миний хэлснийг үл тоомсорлов. Тэр ч байтугай, намайг буудахад бэлэн байлаа. Би захирагчдаа нөхцөл байдлын талаар хэлэхэд тэрээр энэ бүхнийг зогсоохын тулд буу хэрэглэ хэмээн буу өглөө. Би тэр бууг ашиглан энэ бүх хэргийг зогсоож чадсан. Тэдгээр энгийн иргэд одоо хүртэл амьд байгаа.

–Нэгэн цэрэг

9 Би хүүхэдтэйгээ зугтааж буй нэгэн эмэгтэйтэй тааралдсан. Түүнд будаа ч байхгүй хов хоосон нэг сав л байв. Байдал туйлын хүнд байлаа. Би түүнээс ямар учраас дайны бүс рүү явж байгааг нь асуухад тэрээр өөрийн тосгон рүү явмаар байгаа тухайгаа хэллээ. Би түүнд: "Та будаа ч байхгүй ганц тогоогоор яхав дээ. Миний ууттай будааны талыг ав даа" гэж хэлээд будааныхаа талыг нь түүнд өгсөн. Тэрээр надад талархал илэрхийлээд, мартагдахааргүй нэгэн үгийг хэлсэн юм. Тэр өмнө нь над шиг ийм сайн цэрэгтэй огтхон ч тааралдаж байсангүй гэж хэлсэн дээ.

–Нэгэн цэрэг

10 Ялагдсан цэргүүд манай хотоор дамжин зугтаж байлаа. Хэдийгээр тэд бидний дайсан ч гэлээ, манай хотынхон чадах чинээгээрээ тэдэнд тусламж, тэдний бүх хэрэгцээт зүйлсийг өгсөн. Тэд маш их талархаж байсан ба бид тэднийг хил дээр аваачиж хилээр гаргах үед, телевизийн баг бичлэг хийж, тэдэнд эрүүл мэндийн болон бусад тусламжийг үзүүлж байлаа.

–Дайны улмаас бэлэвсэрсэн эмэгтэй

11 Миний хүү хэдэн хүмүүс хорьсны долоо, найм нь алга болсон байв. Аавыгаа алдсан учраас "Би тэднийг зодоод хашраагаад өгнө." гэж хүү маань хэлж байлаа. Гэвч дараачийн өдөр нь тэрээр би тэднийг суллаад явуулчихсан гэсээр орж ирсэн юм даа.

–Нэгэн эх

Эх сурвалж: *Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой*–г Олон Улсын Улаан Загалмайн Хорооны "Хүмүүс Дайнд" аяны судалгаанаас авав.

## Судалгаа 1 С. Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

Судалгаа 1А болон 1В—д сурагчид хөндлөнгөөс ажиглагчдад аливаа үйлдлийг хийхээс нь өмнө тулгардаг саад бэрхшээл, эрсдлүүдийн болон эцэстээ сонгож хийсэн үйлдлүүдийн богино ба урт хугацааны үр дагаврууд, үр нөлөөг тусгасан бодит хүмүүнлэгийн үйлсүүдийг авч үзсэн билээ.

Судалгаа 1С—д "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн дилемма гэдэг ойлголтыг сурагчдад танилцуулж, хүмүүнлэгийн үйлсүүдийг дэлгэрүүлэн судлахад ашиглах юм. Энэхүү судалгаа нь сурагчдад өөрсдийгөө хөндлөнгөөс ажиглагчдын оронд тавьж үзэн, хүмүүнлэгийн үйлсийг хийх эсэх шийдвэр гаргах үйл явцыг сурагчдаар өөрсдөөр нь мэдрүүлж, тэднээс оролцогч бүх хүмүүсийн санаа бодлыг бодолцсоны үндсэн дээр зорилго болон боломжит үр дагавруудыг шинжлэх боломжийг олгоно.

Ихэнх хүмүүнлэгийн үйлсүүд дилеммаг өөртөө агуулдаг боловч, дилеммаг заах явдлыг энэхүү бүлгийн эхэнд төдийлөн чухалчлаагүй билээ. Учир нь, хүмүүнлэгийн үйлсийн талаар дүн шинжилгээ хийх сэтгэхүйн үйл явцыг ногдуулахаасаа өмнө сурагчдад, хүмүүнлэгийн үйлсийн жинхэнэ мөн чанар, урсгалыг ойлгож үнэлэх боломжийг олгохыг хүссэнтэй холбоотой юм.

---

**Зорилго:**

- Хүний нэр хүндэд аюул учрахад гэрчилж байгаа хөндлөнгөөс ажиглагч ямар ярвигтай байдалд орж болохыг мэдэх
- Дилеммад хэрхэн дүн шинжилгээ хийх талаар сурч авах

**Ашиглах материалууд:**

Дилемма: Түүнд зугаатай байлаа
Дилеммаг гүнзгийрүүлэн судлах дасгал хуудас

**Бэлтгэл ажил:**

Багш нарт зориулсан арга зүйн удирдамжийн дилеммаг хэрхэн ашиглах талаарх санамж болон даддага сургалт 3—ийг эргэж нэг харна уу.
Боломжтой бол сургалтын дүрс бичлэгийн холбогдох хэсгийг үзнэ.

**Хугацаа:**
— 45—60 минутын нэг хичээл

---

**Алхам 1. Дилемма гэсэн ойлголтыг танилцуулна уу (10 минут)**

Дилемма гэсэн ойлголтыг илэрхийлсэн доорх түгээмэл зүйр үг, хэллэгүүдийг хэрэглэнэ үү:
"Хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий", "Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу"

Дилемма гэж юу болох талаар сурагчдыг санаа бодлоо дэвшүүлэхийг уриална.
Дилемманы жишээ гаргуулж, яагаад тийм жишээ болж байгааг нь тайлбарлуулна уу.

Дилемманы онцлог шинжүүдийг тодорхойлно:

Сонгох хувилбар бүхий үйлдлүүдээс аль нэгийг нь сонгохыг шаардаж буй нөхцөл байдал (юу ч хийхгүй байхыг сонгох ч мөн орно)
Бүх хувилбарууд давуу болон сул талуудтай

Дилемманы "хүнд нөхцөл байдлаас хамгийн зөв, сайн үр дүнд хүрэх" гэсэн ойлголт нь ямар ч боломжгүй юм шиг санагддаг, яагаад гэвэл:

Хувилбар бүр асуудал үүсгэх хандлагатай юм шиг харагддаг
Тухайн хувилбарын үр дагаврууд тодорхой бус байдаг гэдгийг сурагчдад сануулан хэлэх хэрэгтэй.

# Судалгаа 1 С. Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

Бүлэгт гарсан жишээ үйл явдлуудын аль нэгийг буюу сурагчдын санал болгосон жишээг ашиглан дилеммад хариу үзүүлэх хувилбаруудыг сурагчдаар гаргуулна уу.

Хувилбар бүрийн хувьд, доорх асуултуудыг судална:

- Санал болгосон үйлдлүүдийн хүлээгдэж буй үр дагавар нь юу вэ?
- Өөр үр дагаврууд байж болох уу? (Үр дүнд нь гарч болзошгүй үр дагавруудын гинжин холбоог судлах)
- Нөхцөл байдлын мэдэгдэхгүй байгаа, урьдчилан мэдэж болзошгүй зүйлс нь юу вэ?
- Өөр хэн оролцож байна вэ? Тэдэнд таны үйлдэл хэрхэн нөлөөлөх бол? Тэд үйлдлийг тань хэрхэн үзэж, хүлээн авах бол? Бусдын энэхүү үзэл бодол үр дүнд нь хэрхэн нөлөөлөх вэ?

**Алхам 2. Вендигийн хүмүүнлэгийн дилемманы ярвигтай асуудлыг судлах** (30 минут)

"Түүнд зугаатай байлаа" өгүүллэгээр дилемманы талаарх Вендигийн баримтыг танилцуулна уу.

Сурагчдыг, шоронгийн гадаа хүлээн зогсож буй Вендигийн оронд өөрсдийгөө тавьж, доорх 2 асуултанд бичгээр хариулахыг хүснэ үү:

- Хэрэв тэд Венди байсан бол юу хийх талаар бодох байсан бэ?
- Тэдний сонгосон үйлдлийн үр дагаврууд нь юу байж болох вэ?

Сурагчдад дээрх асуултын хариуг бичих хэсэг хугацаа өгсний дараа, Вендид тулгарсан дилемма болон хөндлөнгөөс ажиглагчийн хувьд түүний үүрэг, тэр юу хийж болзошгүй байсан талаарх хэлэлцүүлгийг сурагчдын дунд эхлүүлнэ үү.

Вендигийн ажиглаж харснаар, тэрхүү хоригдлын хувьд нөхцөл байдал ямар байсан бэ гэдгийг анхаарлын төвдөө авч үзсэнээр хэлэлцүүлэг эхэлнэ.

➤ Венди болон харгалзагчийн аль аль нь хоригдлын нэр хүндийн талаар ямар бодолтой байна вэ?

"Дилеммаг гүнзгийрүүлэн судлах дасгал хуудас"—ийг ашиглан Вендигийн дилеммаг шийдвэрлэх санаануудыг гаргана уу. Сурагчдын гаргасан хувилбар бүрийн хувьд, гарч болзошгүй үр дагавруудыг санал болгохыг сурагчдаас хүснэ:

- Хоригдлын хувьд
- Шоронд хоригдож буй найзтайгаа уулзах гэсэн Вендигийн найдварын хувьд
- Шоронгийн харгалзагчийн одоогийн болон ирээдүйн зан үйлийн хувьд
- Шоронд хоригдож буй хар арьстан найзынх нь хувьд

**Боломжит асуултууд:**

➤ Энэхүү үйлдэл нь хүмүүнлэгийн гэдэг утгаараа ямар эерэг үр дагавруудыг авчрах вэ?

➤ Энэхүү хувилбарыг сонгосноор ямар нэгэн зүйл муугаар эргэж болох уу? Хэний хувьд?

✓ тэмдгээр, хүмүүнлэгийн гэдэг утгаараа эерэг үр дагавруудыг, Х тэмдгээр хортой үр дагавруудыг тэмдэглэж болно.

*Санамж: Хэрэв сурагчдад тань тохиромжтой бол, тэдэнд энэхүү бодит амьдрал дээр болсон үйл явдлыг ойлгоход нь туслахын тулд, Венди болон шоронгийн ажилтнуудыг өөрсдийн бүлэг, шоронд хоригдогчдыг, улс төр, эдийн засаг болон цэргийн хувьд тэдний бүлгийн эрхшээл хяналтан дор байгаа өөр нэгэн бүлэг хэмээн авч үзэхийг санал болгож болно.*

*Эсэргүүцэл байхгүй байгаа нь гэмт хэрэгтнүүдэд өөрсдийнх үйлдэл зөв гэж итгэх итгэлийг улам төрүүлдэг.*
— Эрвин Штауб,
Муу муухайн үр үндэс

Хэлэлцүүлгийн дараа сурагчдад, хэрэв тэд Вендигийн оронд байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ гэдгийг тунгаан бодох хэдэн минут олгоно уу. Дараа нь тэднээр өөрсдийн гаргасан шийдвэрийг нь бичүүлж, тухайн сонголтыг хийх болсон шалтгааныг нь тайлбарлуулна.

Сурагчдыг, гаргасан шийдвэр болон шалтгаанаа өөр хоорондоо хуваалцахыг санал болгоно уу.

**Алхам 3. Хаалт: Гадаад болон дотоод хүчин зүйлс (5 минут)**

Сурагчдаар доорх 4 жагсаалт хийлгүүлэх замаар дүгнэлт хийнэ үү:

**Сэтгэл хөдлөл ба ухамсар**

1. Вендигийн шийдвэрт нөлөөлсөн 2. Шоронгийн хуягийн шийдвэрт нөлөөлсөн

**Нөхцлүүд**

(Цаг хугацааны хязгаарлагдмал байдал, хүчний ялгаатай байдал, байршлын нөлөөлөл)

3. Вендигийн шийдвэрт нөлөөлсөн 4. Шоронгийн хуягийн шийдвэрт нөлөөлсөн

Дилемманы дээрх шинж чанаруудын талаар ярилцсаны дараа, сурагчид бусдын хэрэгцээ шаардлагыг хангах аливаа оролдлогуудад хувийн үзэл бодол болон гадаад нөхцөл байдал хэрхэн нөлөөлдгийг ойлгож авах болно.

**ГОЛ САНААНУУД**

- Ихэнх хүмүүнлэгийн үйлсийн үед хүн өөрөө эрсдэлд орох, өөрт нь буюу хамгаалах гэсэн хүнд нь янз бүрийн гарз учирч болзошгүй учир хийх үү, болих уу гэсэн сонголт хийх хэцүү байдалд ордог.
- Аль ч сонголт нь хамаарах хүмүүст төвөгтэй, удаан хугацаанд үргэлжлэх үр дагаврыг авчирч болно.

# Түүнд зугаатай байлаа

Өмнөд Африкт арьсны өнгөөр ялгаварлах үзэл буюу апартейд хүчтэй байх үед, цагаан арьст Венди улс төрийн хэргээр шоронд хоригдож буй хар арьст найзтайгаа уулзахаар оролдож байв. Шоронгийн ажилтан цагаан арьстнууд тэнд хэзээ ч цагаан арьстан хар хоригдлыг эргэхийг зөвшөөрдөггүй гэдгийг дуулгалаа. Шоронгийн дарга түүнтэй уулзахаар өрөөндөө дуудав. Вендигийн нөхөр хотын нэгэн сонины редактор байснаас ч тэр үү, түүнд найзтайгаа уулзах зөвшөөрөл олгожээ. Тэрээр шоронгийн хонгилд очин, найзыгаа хүлээж зогслоо. Цаашид юу болсон талаар тэр ингэж ярьжээ.

Би тэнд найзыгаа хүлээн зогсохдоо шоронгийн бор шаргал хувцастай нэгэн хар арьст хоригдол хонгилын үзүүр хэсэгт зогсч байхыг харлаа. Тэр их айж түгшсэн, хүлцэнгүй дорой бөгөөд ямар нэгэн цагаан арьст "Баас"*—ын зан байдал, сонирхолд нь нийцүүлэхээр хүлээж байгаа хүн шиг харагдаж байлаа. Түүнийг тэнд зогсоод хүлээж бай гэсэн бололтой. Нэгэн цагаан арьст хуяг гэнэт гарч ирэн, хоригдлын хажуугаар өнгөрөхдөө түүн рүү маш заналхийлэлтэйгээр дайрч, чангаар орилж эхлэв. Тэрхүү хуяг огтхон ч уурласан шинжгүй байсан бөгөөд харин ч жаахан зугаацаж авахаар шийдсэн бололтой. Хоригдол хуягын цохилтоос өөрийн биеийг халхавчлан хоёр гараа нэгэн зэрэг дээш өргөв. Нэг гараа гэдсээрээ ороож нөгөө гараа толгой дээрээ өргөн асуусан асуултууд, түүнийг албаар янзыг нь үзэж, өдсөн доротжлолд нь ээрч түгдрэн, арай ядан хариу өгч, түүний доог тохуу болж байлаа.

Тэгж байтал хуяг санаа нь амарсан янзтай миний зүг чиглэн ирлээ .Тэр намайг өөрийг нь ширтэн харж байгааг мэдээд над рүү харахад түүний огтхон ч ичихгүй байгаа нь, тэр ч байтугай, түүний нүднээс намайг цагаан арьстан учраас өөрийнх нь дөнгөж сая хийсэн үйлдлүүдийн шууд хамсаатан хэмээн бодсон нь илт байв.

Тэрээр хэсэг сэлгүүцээд, залхсан байдалтай хажуугаар өнгөрч нэг хэсэг алга болчихоод дахин хар арьст залуу рүү очлоо. Түүнийг ойртох тусам хоригдол айн дальдчиж, хоёр гараа хамгаалах байрлалдаа аваачив. Хуяг байдгаараа баясч байлаа. Үзэгч /би/ түүнийг улам таатай баярлахад хүргэсэн бололтой.

Баас* — Хариуцагч, апартейд буюу арьсны өнгөөр ялгаварлах системийн үед "дарангуйлагч" гэсэн утгатай байжээ.

Эх сурвалж: Бико, Дональд Вүүдс, Паддингтон хэвлэлийн газар, Лондон, 1978 он

**Венди юу хийх ёстой гэж бодож байна вэ?**

**Эргэцүүлэн бодох бусад зүйлс**:

- Хуяг
- Хоригдол
- Хоригдож буй Вендигийн найз
- Шоронгийн дарга

# Дилемма: дасгал хуудас

| | |
|---|---|
| **Асуудал:** | |
| Үйлдэл | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| Үйлдэл | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| Үйлдэл | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| **Шийдвэр болон уг сонголтыг хийх болсон шалтгаанууд:** | |

# Хэвлэлийн хуудас

**Зорилго:** Хүний амь нас, нэр хүндийг хамгаалах хэрэгцээ шаардлагын талаар сурч мэдэж буй зүйлээ өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэхийг идэвхжүүлэх

1. Мэдээнээс хүмүүнлэгийн үйлстэй холбоотой үйл явдал, жишээ түүхүүдийг хайж олно уу.

2. Юу болсныг товчоор тайлбарлана уу.

- Хэний нэр хүнд эрсдэлд байна вэ?
- Тусламж үзүүлэхэд ямар саад бэрхшээлүүд учирч байна вэ?
- Хэн тусламж үзүүлсэн бэ? Тэд яагаад туслах болсон шалтгааныхаа талаар юу гэж хэлсэн бэ?

**Үнэлгээний аргууд:**

⅄ Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:
"Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь" хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх бололцоог олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

⅄ Сурагчдын ажлын хавтас:

Нэгдүгээр бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

➤ Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

Нэгдүгээр бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20—30 минут), эсвэл 2—3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно.

   ➤ Аливаа хүчирхийллийн гэрч болж буй хөндлөнгөөс ажиглагчийн жишээг материалуудаас сонгох буюу өөрөө зохио. Өөрийгөө хөндлөнгөөс ажиглагчийн оронд тавь. Чи ямар сонголт хийх вэ? Үр дагавар нь юу вэ? Юу хийхээр шийдсэн бэ, яагаад?

   ➤ Хүмүүнлэгийн зан үйлийг яаж хөгжүүлж болох вэ? Хүмүүнлэгийн үйлс хийхэд тулгардаг саад бэрхшээлийг болон тэдгээрийг даван туулахад яагаад хэцүү байдгийг (эсвэл хэрхэн даван туулж болох талаар) хэлэлцэнэ үү.

2. Товч хариулах асуултууд: Хоёр асуулт сонгоно.

   ➤ Хөндлөнгөөс ажиглагч, хүмүүнлэгийн үйлс болон диллемаг тодорхойлно уу.

   ➤ Мэдээллийн хэрэгслээр цацагдсан хүмүүнлэгийн үйлсийн жишээг хэлнэ үү. Чиний бодлоор, энэхүү жишээ нь яагаад хүмүүнлэгийн үйлс болж чадаж байна вэ?

   ➤ Хүмүүнлэгийн үйлсийн алхам алхмаар хэмжигдэх мөн чанар гэж юу вэ?

Сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

**Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:**

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- үзэл санаагаа бататгах тодорхой бодитой жишээ гаргах
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

**Хүмүүнлэгийн төлөв байдал/ерөнхий**

- Конгрессийн номын сан: улс орнуудын судалгааны цувралууд
  http://lcweb2.loc.gov/frd/cs/cshome.html#toc

- Британника нэвтэрхий толь
  http://britannica.com

- Funk and Wagnalls
  http://www.funkandwagnalss.com

- Yahoo! өдөр тутмын мэдээллүүд
  http://dailynews.yahoo.com/full_coverage/

- "Эмнести Интернэшнл" олон улсын хүний эрхийн байгууллага
  http://www.amnesty.org
  Араб, Англи, Франц, Испани хэлээр

- Хүний Эрхийн Харуул
  http://www.hrw.org

  Араб, Хятад, Англи, Франц, Португали, Орос, Испани хэлээр

**Хүмүүнлэгийн үйлсүүд**

- Алберт Швайцерийн хуудас
  http://www.pcisys.net/—jnf

- Өршөөл уучлалын судалгааны аян
  http://www.forgiving.org

- Еврейчүүдийг хүйс тэмтрэх явдлын (Holocaust) талаар багш нарт өгөх зөвлөмж: Аврагчид
  http://fcit.coedu.usf.edu/holocaust/people/rescuer.htm

- Еврей оюутнуудын онлайн судалгааны төв
  http://www.us—israel.org/jsource/Holocaust/rescuetoc.html

- Энхийг сахиулагчид
  http://www.myhero.com/peacemakers

  Хүүхдүүд өөрсдийн хүндэлдэг баатруудын тухай хийсэн вебсайт. Эдгээр баатруудын дотор дэлхий дахины, үндэсний болон угсаатны энх тайванд хувь нэмрээ оруулсан хувь хүмүүс байгаа.
- Нобелийн Энх Тайвны Шагнал
  http://www.nobel.no/indexen.html
  Англи ба Норвеги хэлээр

- Яд Вашем: Holocaust—ийн золиослогдогч болон баатруудын дурсгалын газар
  http://www.us—israel.org/jsource/Holocaust/rescuetoc.html

  Энэхүү судалгаан дээр жишээ болон хэрэглэгдсэн тусгаар орнууд, мөргөлдөөн болон түүхэн үйл явдлуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх онлайн эх сурвалжуудаас авахыг зөвлөж байна:

**Дайны хор уршиг**

- Олон Улсын Улаан Загалмайн Хорооны түүх
  http://www.icrc.org/eng/history
  Англи, Франц, Испани хэлээр

- Сольфериногийн тулаан (сүүлийн үеийн сонингууд дээр нийтлэгдсэн баримтууд)
  http://hillsdale.edu/debt/History/Documents/War/19e/late/1859—Solferino.ht

**Модон сандал дээр ганцаараа**

- Иргэний эрхийн хууль ба Түүх (АНУ—ын Хууль Зүйн Яам)
  http://www.usdoj.gov/kidspage/crt/crtmenu.htm

  Хүүхэд залуучуудад зориулсан вебсайт.
- Литл Рокын Ахлах Сургуулийн 40 жилийн ойд зориулсан хуудас
  http://www.centralhigh57.org

**Гэрч айсуй**

- Шударга үнэн, зөвшилцлийн комисс
  http://www.truth.org.za

- Yahoo! Бүрэн нийтлэл: Өмнөд Африк
  http://asia.fullcoverage.yahoo.com/fc/Asia/South_Africa

- Yahoo! Бүрэн нийтлэл: Шударга үнэн, зөвшилцлийн комисс
  http://dailynews.yahoo.com/full_coverage/world/south_africa_truth_and_reconciliation_commission

- 20—р зууны дайны гэмт хэргүүд: Өмнөд Африк дахь шударга үнэн ба зөвшилцөл
  http://www.npr.org/programs/specials/warcrimes/index.html

**Алхам алхмаар**

- Польш: Тэвчээрийн хэвлэл мэдээлэл судлах төвийн музей
  http://motlc.wiesenthal.org/pages/t061/t06162.html

- Варшав дахь Еврейчүүдийн хорооллын бослого (АНУ—ын Holocaust—ын дурсгалын музей)
  http://www.ushmm.org/outreach/wgupris.html
  Хүүхэд залуучуудад зориулсан вебсайт.

**Лагерьт хоригдогсдын зовлонг нимгэлэгч тосгоныхон**

- Олон Улсын Шударга Ёсны Эвсэл
  http://www.cij.org/icty/icty.html
- ABC Ньюс: Балканчуудыг судалж буй анхан шатны сурагчдад зориулсан удирдамж
  http://abcnews.go.com/sections/world/balkans_content
- Хуучин Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх
  http://www.un.org/icty

**Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой**

- Хүмүүс дайнд
  http://www.onwar.org



# Бүлэг 2

# Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт

*(7 Хичээл)*

*Ямар хязгаарлалтууд хэрэгтэй болдог вэ? Яагаад?*

*Эдгээр хязгаарлалтууд хаанаас хийгддэг вэ?*

*Дайныг хязгаарлах хуулиуд хэрхэн бий болдог вэ?*

## СУДАЛГААНУУД:


Судалгаа 2А: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах (2 хичээл). . . 73
Судалгаа 2В: Түүхэн хууль дүрмүүд (1 хичээл). . . 88
Судалгаа 2С: Цэрэг хүүхдүүд (2 хичээл). . 104
Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина (2 хичээл). . 118


## ОЙЛГОЛТУУД:

Дайны хязгаарлалт
Энгийн иргэд, байлдагч бус хүмүүс (байлдаанд оролцохооргүй болсон хүмүүс)
Хүний эрх
Хамгаалалт
Хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ
Үл ялгаварлах зэвсэг
Долгионт үр нөлөө

**Нийт бүлгүүдэд:**
Хүний нэр хүнд
Хүмүүнлэгийн зан үйлд учрах саад тотгорууд
Дилемма
Үр дагаврууд
Олон талт төлөв байдал

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Төлөвшил
Асуудалд анализ хийх
Үр дагаврыг илрүүлэх
Хамрах хүрээг тооцоолох
Шийдлүүдийг тодорхойлох

# Судалгаа 2А: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах

1—р Бүлэгт бид энгийн хүмүүсийн өөрийн санаачилгаар бусдын амь нас, нэр хүндийг хамгаалахаар хийсэн янз бүрийн хүмүүнлэгийн үйлсүүдийн тухай үзсэн бол одоо 2А судалгаа хичээлээр, хохирогчид болон эмзэг хүмүүсийг хамгаалахын тулд зэвсэгт мөргөлдөөний үед тэдэнд хэрхэн хандах зан үйлийн дүрэм журмын талаар үзэх болно. Судалгааны эх сурвалж болгон ашиглах зургууд нь онцгой нөхцөл байдлыг авч үзнэ. Жишээ нь, хоригдол болсон цэргүүдийг харуулсан байна. Зэвсэгт мөргөлдөөнд ялагчид болон ялагдагчдын оронд өөрсдийгөө тавьж үзэн, тэднийг ойлгоход сурагчдад дөхөмтэй учраас эдгээр зургуудыг сонгосон юм. Зургийн эвлүүлэг нь цаашлаад дайны нөхцөл байдлын цар хүрээг өргөжүүлж авч үзнэ. Сурагчид зэвсэгт мөргөлдөөнөөс урган гарч ирэх нөхцөл байдлыг судалснаар, хүний амь нас, нэр хүндийг хамгаалахад хэрэгтэй хууль журмуудыг өөрсдөө санаачлах болно.

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй (ОУХЭЗ) нь хуулийн нэгэн томоохон бие бүрэлдэхүүн юм. Энэхүү хичээлээр бид өсвөр үеийнхний сурах нөхцөл байдалд холбоотой ОУХЭЗ—н үндсэн дүрмүүдийг танилцуулахыг хичээсэн билээ. Сурагчид эдгээр дүрмүүдийн цаана оршиж буй учир шалтгааныг олж илрүүлэхээс гадна дээрх дүрмүүдийг өөрсдийн санал болгосон дүрмүүдтэй харьцуулах боломжтой. Мөн энэхүү судлах хичээл нь ОУХЭЗ хүний эрхтэй хэрхэн холбогдож буйг харуулах юм. Өөрөөр хэлбэл, сурагчид ОУХЭЗ ба хүний эрхийн аль алинд нь хамаарагддаг, зэвсэгт мөргөлдөөний үед ч хамгаалагдах ёстой нийтлэг үндсэн эрхүүдтэй танилцах болно.

**Зорилго:**
- Зэвсэгт мөргөлдөөний үед мөрдөх дүрэм хэрэгтэй болдгийн зарим шалтгааныг ойлгож авах
- Хүний эрхийн хууль ба хүмүүнлэгийн эрх зүйн уялдаа холбоог ойлгож авах
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим үндсэн дүрмүүдийг мэдэж авах

**Ашиглах материалууд:**
- Зураг: Нүдээ боолгосон олзлогдогч
- Зургууд: Олзлогдогчдын марш (2 хувилбар)
- Зургийн эвлүүлэг 2А (Номны хавтсанд байгаа)
- ОУХЭЗ—н үндсэн дүрмүүд юу вэ?
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Түгээмэл Тун—хаглал
- Эртний түүхийн 2 жишээ үйл явдал



**Багш нарт:**
- ОУХЭЗ ба хүний эрхийн хууль — агуулга ба бие биенээ харилцан бүрдүүлэх нь
- Сурагчид тань асуувал...

**Бэлтгэл ажил:**
*Арга зүйн удирдамж* — Багш нарт 6—аас фото зураг хэрхэн ашиглах талаарх материалыг үзнэ үү.
Сургалт 4—5—ыг дахин уншаад боломжтой бол сургалтын холбогдох дүрс бичлэгийг
үзнэ үү.

**Хугацаа:**
- 45—60 минутын 2 хичээл

**1. Шилжилт** (5 минут)
Доорх асуултаар товчхон хэлэлцэнэ үү:

- Хүмүүнлэгийн үйлсийн шинж чанаруудын талаар юу санаж байна вэ?
- Хүмүүнлэгийн үйлсүүдэд ямар бэрхшээл, хүндрэлүүд тулгарч байсан бэ?

# Судалгаа 2А: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах

➤ Зэвсэгт мөргөлдөөний үед хүмүүнлэгийн үйлсүүдэд ямар нэмэлт хүндрэлүүд гарч болзошгүй вэ?
*Жишээ нь, өс хонзон авах дур хүсэл, мэдээллийн хомсдол, хангамжийн дутагдал, айдас, хүчтэй үзэн ядалт...*\



Сурагчдад, энэхүү судалгаагаар зэвсэгт мөргөлдөөний үеийн дүрэм журмын хэрэгцээ шаардлага болон ямар дүрэм журмууд байж болох талаар авч үзнэ гэдгийг сануулна уу.

**2. Цэргийн олзлогчид болон олзлогдогчдын туулж өнгөрүүлсэн туршлага** (15 минут)
“Нүдээ боолгосон олзлогдогч" зургийг сурагчдад танилцуулна уу. Сурагчдаас, өөрсдийгөө олзлогдогч буюу түүний харгалзагчийн оронд тавьж үзэхийг хүсээд, өөрсдийн бодлыг нь бичүүлнэ үү.

➤ Олзлогдогч юу бодож байгаа бол? Харгалзагчийн хувьд?

Сурагчдыг хамтрагчтайгаа бодлоо хуваалцан хэлэлцүүлэг өрнүүлүүлнэ.

Доорх асуудлуудыг нэг нэгээр нь авч үзэхээр хэлэлцүүлэгт санал болгоно уу:

➤ Олзлогдогч чиний ах гэж төсөөл. Түүнд хэрхэн хандаасай гэж хүсч байна вэ? Яагаад?
➤ Олзлогдогч байлдааны үеэр чиний найзыг хөнөөсөн гэж төсөөл.

Түүнд хэрхэн хандаасай гэж хүсч байна вэ? Яагаад?

Дээрх үйл явцыг “Олзлогдогчдын марш" зургуудын аль алинд нь ашиглана уу.

Бүлгийн ярилцлага:

➤ Зэвсэгт мөргөлдөөний үед олзлогдогчдод хэрхэн хандах ёстой вэ?
➤ Хоригдлууд маш чухал мэдээллийг мэдэж байгаа гэж бодъё. Энэ нь тэдэнд хандах хандлагад нөлөөлөх болов уу?
➤ Хоригдлын нэр хүнд хэрхэн эрсдэлд орсон байна вэ? Харгалзагчийнх?

*Хамгийн их эзэмдсэн сэтгэл хөдлөл бол гайхан цочирсон айдас, хүрээлэн буй харийн орчин, эцсийн хувь заяа нь яаж эргэхийг мэдэхгүй байх явдал юм. Найз нөхөд, гэр бүлээсээ хагацах энэхүү мөч нь цаг хугацааны тодорхой бус байдал. Хэр удаан үргэлжлэх юм бэ? Үүрд үү?*

— Олзлогдсон онгоцны нисгэгчийн бодол



**3. Зэвсэгт мөргөлдөөний үед, хоригдлуудыг хамгаалахын тулд ямар дүрмүүд байх хэрэгтэй вэ?** (15 минут)

Зэвсэгт мөргөлдөөний үед хоригдлуудад ямар дүрмүүд хэрэгтэй гэж бодож байгаа болон дүрэм бүрийн учир шалтгааны талаар сурагчдаар бичүүлнэ үү.

Сурагчдын санал болгосон дүрмүүдийн жагсаалтыг гаргана уу.
Тэдний санал болгосон дүрмүүдийг хэлэлцэнэ — Санал нийлж байгаа эсэх? Яагаад?

*Олзлогдогч бол чиний дүү. Бурхан тэнгэрийн таалаар тэр одоо чиний гарт, чамд зүтгэж байна. Нэгэнт тэр чиний өршөөл дор байгаа тул, түүнийг чамтай адил хооллож, хувцаслаж байгаа эсэхэд анхаар. Түүнээс өөрийнх нь хүчин чадлаас хэтэрсэн ажлыг бүү шаард.*

— Зөнч Мухаммед (МЭ 570—632)

**4. Зэвсэгт мөргөлдөөнд өөр ямар дүрмүүд хэрэгтэй вэ?** (10 минут)

Зургийн эвлүүлгийг танилцуулна уу. Сурагчид зургуудыг сайтар судалсаны дараа, шаардлагатай нэмэлт дүрмүүдийн санал оруулж болно.
Доорх асуултуудыг бодолцон бүлгийн боловсруулсан дүрмүүдийн цогц жагсаалтыг хэлэлцэнэ үү:



**Боломжит асуултууд:**
➤ Дүрэм журам хэрхэн дайны гашуун туршлагуудыг өөрчлөх вэ?
➤ Эдгээр дүрэм журмуудыг хэрэгжүүлэхэд ямар хүндрэлүүд гарч болзошгүй вэ?
➤ Байлдаанд оролцохооргүй болсон хүмүүст ямар дүрэм үйлчилдэг вэ?

"Байлдаанд оролцохооргүй болсон хүмүүс" (*hors de combat*) ойлголтыг сурагчдад "дайны жагсаалаас гарагчид" хэмээн тодорхойлно уу. Байлдагчид олзлогдсон, шархадсан, өвчтэй болсны улмаас байлдах чадваргүй болдог бөгөөд ОУХЭЗ–н онцгой хамгаалалтан дор байх ёстой.



**5. ОУХЭЗ–н үндсэн дүрмүүдийг судлах** (15 минут)

"ОУХЭЗ–н үндсэн дүрмүүд юу вэ?" хэсгийг сурагчдад танилцуулна уу.
Доорх асуудлуудыг хэлэлцэнэ:

➤ ОУХЭЗ–н дүрэм бүрийн хувьд, эдгээр дүрмүүд байхгүй байсан бол юу болох байсан бэ?
➤ Эдгээр дүрмүүдийн аль нь, өөрийн чинь бичсэн дүрмүүдтэй төстэй байна вэ?

**6. ОУХЭЗ ба хүний эрх** (25 минут)

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй ба хүний эрхийн хууль нь хүнийг хамгаалах үндсэн дүрмүүдийг бататгасан байдаг гэдгийг тайлбарлаж өгнө.



Сурагчдаас, хүний эрхийн талаар юу мэддэг талаар хүний эрхүүдийн жагсаалтыг бичүүлэх замаар мэдэж авна уу.

"Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал"–ыг сурагчдад танилцуулна.

Сурагчдаар хүний эрхүүдийг болон ОУХЭЗ–н дүрмүүдийг цомхон бүлгээр судлуулна уу.

➤ Ямар төрлийн хамгаалалтууд нь хүний эрх болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд нийтлэг байдаг вэ?

Бүлгүүдийн хэлэлцүүлэг болон тайланг нэгтгэнэ үү.

Дээрх 2 хуулийг дүрслэхийн тулд огтлолцож буй хоёр гонзгой тойрог зурна уу. Сурагчдаар, хүний эрхийн болон ОУХЭЗ–н нийтлэг дүрмүүдийн жишээг хоёр тойргийн огтлолцож буй хэсэгт бичүүлнэ үү. (Багш нарт зориулсан материал болох "ОУХЭЗ ба хүний эрхийн хууль – агуулга ба харилцан уялдаа"–г харна уу.)

**7. ОУХЭЗ–н үндсэн дүрмүүдийг санахад амар болгох** (10 минут)

Сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан, үндсэн дүрэм бүрийг товчхоноор дүгнэсэн богино хэллэгүүд болон уриа лоозонг боловсруулна уу. Жишээ нь, "Бууж өгсөн хоригдлуудыг амь хэлтрүүлье", "Өвчтэй болон шархдагсдыг халамжилъя", "Эмблемийг хүндэтгэцгээе" гэх мэт.

"Харилцаа холбоо/Залуучуудын үйл ажиллагаа" нэмэлт дасгалууд нь сурагчдад дээрх хэллэгүүдийг цааш нь боловсруудахад дөхөмтэй.

**ГОЛ САНААНУУД**

♦ Хүмүүнлэгийн эрх зүй нь зэвсэгт мөргөлдөөний үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилготой. Энэ нь хэрэгцээгүй зовлон, шаналлыг бууруулж, байлдагч бус хүмүүс, ялангуяа байлдаанд дахин оролцохооргүй болсон хүмүүсийг хамгаалахын тулд дайн тулааны арга, хэрэгслийг хязгаарлах замаар хэрэгжинэ.

♦ Хүмүүнлэгийн эрх зүй болон хүний эрхийн хууль аль аль нь хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үндсэн зорилготой. Хүмүүнлэгийн эрх зүй нь зөвхөн зэвсэгт мөргөлдөөн зэрэг тодорхой нөхцөл байдалд үйлчлэхээр зохиогдсон байдаг бол хүний эрхийн хууль нь ямар ч үед хэрэглэгддэг.

**Хэрэв ямар нэгэн цэрэг зэвсэггүй бол түүнийг бүү шархдуул.**

**ОУХЭЗ !**

**Хэрэв ямар нэгэн цэрэг шархдан хэвтэж байвал, түүнийг шаварт бүү орхи.**

**ОУХЭЗ !**

**Хэрэв бөмбөг дэлбэрвэл, түүнд шашны газар бүү өртөг.**

**Хэрэв би хэн нэгнийг аврахад, миний цэргүүд түүнийг хөнөөхийг завдвал, би тэдэнд "Зогс, зогс, түүн рүү бүү гал нээ" гэж хэлнэ.**

**ОУХЭЗ !**

**Хэрэв чи л энгийн иргэдийг хамгаалахгүй бол тэд сая саяараа үрэгдэх болно.**

**ОУХЭЗ !**

**Олзлогдогчийг бүү үл тоомсорло.**

**Амьдралын төлөө ОУХЭЗ, ОУХЭЗ, ОУХЭЗ, ОУХЭЗ !**
**Амьдралын төлөө ОУХЭЗ, ОУХЭЗ, ОУХЭЗ, ОУХЭЗ !**

— "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн сурагчдын зохиосон реп дуу

# Нэмэлт дасгал

## Түүх:



“Эртний түүхийн 2 жишээ үйл явдлууд" өгүүллэгийг ашиглан түүхийн хуудсийг сөхөн харна уу. Дараа нь өөрийн амьдарч буй тив, улс орны өнгөрсөн үеийн соёл иргэншлийн түүхийн талаарх баримтуудыг цуглуулан дараах асуултанд хариу өгөх бяцхан мэдээлэл бэлдэнэ үү:

➤ Тэд ялагдсан дайсанд хэрхэн ханддаг байсан бэ?

## Хэвлэл мэдээлэлтэй холбох:

Сонин, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан, “үүний эсрэг хууль байх ёстой" хэмээн бодогдуулсан аливаа зэвсэгт мөргөлдөөний талаарх мэдээлэллийг цуглуулаад чухам ямар хууль хэрэгтэй гэж бодож байгаагаа бичнэ үү.

ЭСВЭЛ:

Дүрэм журам хэрэглэгдэх аливаа нөхцөл байдлын талаарх мэдээг цуглуулан, тус бүрт нь дүрмүүд дээр үндэслэн, тэдгээрийн яагаад хэрэгжиж байгаа болон хэрэгжихгүй байгаа шалтгааныг тайлбарлана уу. Мэдээллийн цуглуулгаа шинэ мэдээллээр баяжуулж, ханын самбар гаргана уу.

## Урлаг:

“Нүдээ боолгосон олзлогдогч" фото зургийн дагуу сурагчдаар хөшөө болон тоглуулж болох юм. Тэд зурган дээрх дүрүүдэд хувиран, ойролцоогоор 1 минут хөдөлгөөнгүй байх хэрэгтэй.
Ингэх явцдаа бусад сурагчдыг дүр бүрийн ард зогсоон тэдний (олзлогч ба олзлогдогчын) юу бодож, мэдэрч байгаа талаарх дүгнэлт санал бодлыг нь сонсоно.

ЭСВЭЛ:

Дайны дүрмийг зөрчиж байгаа болон мөрдөж байгааг уран тодоор харуулсан урлагийн бүтээлийг хараад төрж буй мэдрэмжээ цаасан дээр буулган бичих, эсвэл жүжигчилсэн хэлбэрээр тайлбарлана. Иймэрхүү урлагийн бүтээлийн жишээ нь Пабло Пикассогийн “Гэрника", Жон Сингер Саржентийн “Хордуулсан нь" зэрэг уран зургууд юм.

➤ Юу болоод өнгөрөв? Зурган дээр өөр юу болж байна вэ?
➤ Уран бүтээлч зургаараа юу хэлэх гээд байна вэ?

Эдгээр зургуудыг цэрэг татлагын зурагт хуудас болон телевизийн реклам сурталчилгааны зургуудтай харьцуулан харна уу.

ЭСВЭЛ:

Дайны болон дараах үеийн цэргүүдийн бичсэн шүлэг, яруу найргийг унших хэрэгтэй.
➤ Яруу найрагчийн хэлэх гэсэн санаа юу вэ? Энэхүү санаа нь, дээрх уран зураг дээрх зураачийн санаатай, эсвэл хичээлийн үед санал болгосон таны дүрмүүдтэй хэр төстэй буюу тэднээс ялгаатай байна вэ?

## Харилцаа холбоо/ Залуучуудын Хөдөлгөөн:

ОУХЭЗ—н үндсэн дүрмүүдийг түгээн сурталчлах янз бүрийн аргуудыг эрж олно. Үүнд: үг хэллэг, уриа лоозонг зурагт хуудас болгон хэвлэх, радио реклам хийх, реп болон поп дуу зохиох гэх мэт орно.

"Үндсэн дүрмүүд"—ийг сургууль, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх арга замуудыг бреинсторминг хийснээр олж илрүүлнэ. Ийнхүү дэвшүүлсэн санаануудаас аль нэгийг нь төсөл болгон сонгон авч болно. /"Цаашид юу хийх хэрэгтэй вэ?" гэсэн төгсгөлийн хэсэгт сурагчдын төслүүдийн талаар илүү их мэдээлэл бий./



**Нүдээ болгоосон олзлогдогч –** Бослого гаргагчдад олзлогдсон Малигийн нэгэн цэрэг. Тэрээр Тукемэм дэх халдлагаас амьд үлдсэн цорын ганц хүн юм. Энэхүү олзлогдогчийн хувь заяа эсрэг талын офицерийн өөрийн хүмүүстээ өгөх тушаалаас хамаарна



**Олзлогдогчдын марш** — Лаосын Эрх Чөлөөний Алдарт Армийнханд олзлогдсон цэргүүдийн цуваа. Энэ цэрэгт өгсөн тушаалаас эдгээр олзлогдогсдын хувь заяа шалтгаална




**Олзлогдогчдын марш** — Америкийн хүчинд олзлогдсон Герман цэргүүд, Норманда. Франц улс, 1944 оны 6—7 сард. Энэ цэрэгт өгсөн тушаалаас эдгээр олзлогдогсдын хувь заяа шалтгаална

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**1** Аливаа халдлага нь байлдагчид болон цэргийн байнуудаар л хязгаарлагдах ёстой.

1.1 Энгийн иргэд рүү дайрч болохгүй.
1.2 Энгийн иргэдийн обьектууд руу (байшин, эмнэлэг, сургууль, мөргөлийн газар, соёлын буюу түүхийн хөшөө дурсгал гэх мэт) дайрч болохгүй.
1.3 Цэргийн байны бамбай болгон энгийн иргэдийг ашиглахыг хориглоно.
1.4 Байлдагчдыг энгийн иргэдийн дүрд хувирахыг хориглоно.
1.5 Энгийн иргэдийн өлсгөлөнг дайтах арга болгон хэрэглэхийг хориглоно.
1.6 Энгийн иргэдийн амьд үлдэхэд зайлшгүй шаардлагатай обьектууд рүү (хоол хүнс, тариалангийн талбай, ундны усны байгууламж гэх мэт) дайрахыг хориглоно.
1.7 Хэрэв энгийн иргэдэд ихээхэн хэмжээний хохирол учруулах бол усны далан, хаалт буюу атомын цахилгаан станц руу дайрахыг хориглоно

**2** Энгийн иргэд ба цэргийн обьектууд болон хүмүүсийг ялгаварлахгүйгээр хөнөөдөг, үлэмж хохирол, зовлон учруулах аливаа дайралт буюу зэвсгийг хориглоно.

2.1 Химийн болон биологийн, нүд сохлогч лазерын зэвсэг, хүний биед рентгений туяагаар илэрдэггүй хэлтэрхийнүүдээр гэмтэл учруулах зэвсэг, аливаа хорт бодис, хүний эсрэг газрын мина зэрэг тодорхой төрлийн зэвсгүүдийг хориглоно.
2.2 Амьд хүн үлдээхгүйгээр устгахыг заналхийлэх болон тушаахыг хориглоно.

**3** Энгийн иргэд, шархадсан байлдагчид болон хоригдлуудыг өршөөн хамгаалж, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.

3.1 Ямар ч хүн биеийн болон сэтгэл санааны тамлал, бие махбодийн шийтгэл буюу харгис эсвэл гутаан доромжилсон харьцаа эдлэх ёсгүй.
3.2 Сексийн хүчирхийллийг хориглоно.
3.3 Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрдсийн эрхшээлд байгаа эсрэг талын шархадсан болон өвчтэй дайсанд халамж үзүүлэх, тэднийг хайж олох ёстой.
3.4 Бууж өгсөн буюу дайнд оролцохоোргүй болсон дайсныг хороох буюу шархдуулахыг хориглоно.
3.5 Хоригдлуудыг хүндэтгэн, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.
3.6 Хүн барьцаалахыг хориглоно.
3.7 Энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. –"Үндэстэн угсаатны цэвэрлэгээ"–г хориглоно.
3.8 Дайсны гарт байгаа олзлогдсон хүмүүс нь гэр бүлийнхэнтэйгээ мэдээлэл солилцох, хоол хүнс, эмнэлгийн халамж болон сэтгэл санааны дэмжлэг гэх мэт хүмүүнлэгийн тусламж авах эрхтэй.
3.9 Жирэмсэн эмэгтэй, нярай эх, харгалзагчгүй хүүхэд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэн тусгай хамгаалалтанд байх ёстой.
3.10 ОУХЭЗ нь 15–аас доош насны хүүхдүүдийг цэрэгт татах буюу цэргийн үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
3.11 Хүн бүр шударгаар шүүгдэх эрхтэй (шударга шүүх, хэвийн процедур гэх мэт). Хамсруулан шийтгэхийг хориглоно.

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**4 Эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс, байгууламжуудыг (эмнэлэг, клиник, түргэн тусламж гэх мэт) хүндэтгэн үзэж хамгаалан, тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь боломжит бүхий л тусламжаар хангах ёстой.**

**4.1 Улаан Загалмай буюу Улаан Хавирган Сарын эмблем, таних тэмдгүүд нь эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс болон байгууламжуудын хамгаалалтыг билэгдэнэ. Ийм тэмдэгтэй хүмүүс буюу обьект руу дайрахыг хориглоно. Түүнчлэн энэхүү тэмдгүүдийг хуурамчаар ашиглахыг хориглоно.**

**4.2 Эрүүл мэндийн нэгжүүд болон тээвэрлэлт нь дайсны талд хор уршиг учруулах аливаа үйлдэл хийхийг хориглоно.**

**4.3 Шархадсан болон өвчтэй хүмүүсийг эмчлэхэд, эрүүл мэндийн байдлаас нь бусад тохиолдлоор давуу эрх олгохыг хориглоно.**

## Тодорхойлолтууд

**Дагалдах хохирол**: энгийн иргэд амь насаа алдах, бэртэх, эд зүйлсийн хохирол амсахаас хамгаалах, түүнчлэн хохирлыг аль болох багасгах урьдчилсан арга хэмжээ авсан хэдий ч үйлдсэн довтлогооноос тохиолдлоор үүссэн гарз хохирол

**Байлдаанд оролцохооргүй болсон этгээд:** олзлогдсон, шархадсан, өвчтэй эсвэл хөлөг онгоц нь сүйрэлд өртсөний улмаас дахин байлдах боломжгүй болсон байлдагчд

**Энгийн иргэд:** байлдагч бус бүх хүмүүс. (Сэжиглэгдсэн үед ч гэсэн тухайн хүн энгийн иргэнд тооцогдоно.) Хэрэв энгийн иргэд, дайсагнагч талуудын аль нэгний талд орж, ямар нэгэн дайсагналын үйлдэл хийвэл дайтагч болж хувирах ба хамгаалагдах эрхээ алдана.

**Энгийн иргэдийн обьектууд:** цэргийн бай болоогүй бүх обьектууд. Хэрэв энгийн иргэдийн обьект нь цэргийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашиглагдвал тэдгээр нь цэргийн бай гэж тооцогдох ба хамгаалалтаа алдана.

**Байлдагч:** зэвсэгт хүчний гишүүн буюу цэргийн үйл ажиллагаанд шууд оролцож буй хүн

**Цэргийн бай**: Шинж чанар, байрлал, ашиглагдах зорилгоороо цэргийн үйл ажиллагаанд үр ашигтай хувь нэмэр оруулж буй, учруулсан хор хөнөөл нь тодорхой зэвсэгт хүчний давуу талыг олгож байгаа байлдагчид болон обьектууд

## Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь хүн бүрт доорх эрхүүдийг тунхаглажээ:

- Хүний эрх ба нэр хүндийн эрх тэгш байдал
- Амьд явах, аюулгүй байх
- Эрх чөлөөтэй байх, үндэслэлгүй баривчлах, саатуулах, улс орны хил дотроо хаана ч гэсэн оршин суух, шилжин нүүх
- Боолчлол, зарцлалаас чөлөөлөгдөх
- Эрүү шүүлт, харгис хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа, шийтгэлээс чөлөөлөгдөх
- Хувийн асуудал, гэр бүл болон холбоо харилцаанд хөндлөнгөөс оролцох явдлаас чөлөөлөгдөх
- Гэрлэх, гэр бүл зохиох
- Үзэл бодол, шашин шүтлэг, өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө
- Энх тайван замаар хурал хийх, холбоо байгуулах
- Таатай нөхцөлд ажиллах, амрах, чөлөөт цагаа өнгөрөөх
- Эрүүл мэнд, сайн сайхан байдалд нийцсэн амьдралын жишгээр амьдрах
- Боловсрол эзэмших
- Олон нийтийн амьдралд чөлөөтэй оролцох

# Эртний түүхийн 2 жишээ

## МЭӨ 147 онд Картаж бууж өгсөн нь

Сүүлдээ, хүн ам 500,000 – аас 50,000 болон буурахад тэд бууж өгсөн юм. Амьд үлдэгсэд боол болон худалдаалагдаж, хот тоо томшгүй цэргүүдийн дээрэм, тонуулд өртжээ.

Хотыг сүйтгэхэд дурамжхан байсан Скипио (нэгэн цэргийн омог) Ром руу тэдний эцсийн тушаалыг авахаар хүн илгээсэн боловч, Ромын сенат, зөвхөн Картажаар зогсохгүй, түүний эргэн тойронд оршдог хараат бүх газар нутгийг бүрэн устгаж, газар шороог нь хагалахыг, мөн түүнчлэн давс цацан тэр хавийг хараан зүхэхийг тушаажээ. Хот 17 хоногийн турш шатан үнс болсон юм.

*Эх сурвалж: Дюрант, Вилл, Цезарь ба Крист, Соёл Иргэншлийн Түүх, 3–р боть, Симон ба Шустер, Нью Йорк, 1944 он*

## Хот–улс МЭӨ 416 онд бууж өгсөн нь

Ийнхүү Мелос арлынхан бууж өгөхөөс өөр аргагүй байдалд оржээ. Булаан эзлэгчид, цэргийн насны бүх хүмүүсийг хөнөөж, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг боол болгожээ. Тэд уг арлыг колоничилж, өөрсдийн 500 гаруй хүнийг суурьшуулжээ.

*Эх сурвалж: Тусидидес, Пелопоннезийн дайн, 5–дугаар ном*

**Эзлэгдсэн хүмүүсийг хамгаалах зан үйлийн хууль дүрэм гарахаас өмнө**

- **Ямар ирээдүй тэднийг угтаж байсан бэ?**
- **Ямар сонголт тэдэнд байсан бэ?**

## ОУХЭЗ ба Хүний эрх – агуулга ба бие биенээ харилцан бүрдүүлэх нь

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй (ОУХЭЗ) ба хүний эрхийн хууль нь бие биенийгээ нөхдөг. Эдгээр хуулиуд хүний нэр хүндийг хамгаалах зорилготой боловч, хамгаалах нөхцөл байдал, арга зам нь ялгаатай байдаг билээ.

Хүний эрхийн хууль нь хэзээ ч, ямар ч нөхцөл байдалд, тухайн улсын шүүх засаглалд харъяалагдах бүх хүмүүст үйлчилдэг бөгөөд зорилго нь, төр дур зоргоороо авирлах үед хувь хүмүүсийг хамгаалах явдал юм. Тийм учраас, хүний эрхийн хууль нь зэвсэгт мөргөлдөөний үед ч мөрдөгддөг. Гэсэн хэдий ч, Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Гэрээ, Хүний Эрхийн тухай Америкийн болон Европын Конвенц зэрэг хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүд нь, зэвсэгт мөргөлдөөн яах аргагүй нэгэн хэлбэр нь болох "үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн нийгмийн онцгой байдал"—д, хатуу чанд нөхцөлтэйгөөр, зарим эрхүүдэд хязгаарлалт хийдэг. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн эрх чөлөө (хөдөлгөөн хийх, эрх чөлөөтэй байх, холбоо байгуулах гэх мэт) нь нийгмийн онцгой байдлын үед, гагцхүү тухайн нөхцөл байдлын зайлшгүй хурцадмал байдлын хэм хэмжээний хүрээнд л (газар нутгийн болон түр зуурын) хязгаарлагдах буюу түр зогсоож болох юм. Хэдийгээр тийм боловч, ямар ч нөхцөл байдалд, ямар ч цаг үед үл хөндөгдөх "гол цөм" болсон эрхүүд гэж байдаг билээ.

Нөгөө талаас, зэвсэгт мөргөлдөөний үед, хуулийн онцгой систем болох ОУХЭЗ үйлчилж эхэлдэг. Гагцхүү зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгддэг дүрмүүдийн цогц болох энэхүү хуулийн зорилго нь дайнд хохирогдогчдыг (энгийн иргэд, шархадсан болон өвчтэй, олзлогдогч, шилжин нүүсэн хүмүүс гэх мэт) хамгаалах ба цэргийн ажиллагааны зан үйлийг зохицуулах явдал юм. Зөвхөн онцгой байдалд үйлчилдэг гэдэг утгаараа ямар нэгэн нөхцөл, болзол заалгүйгээр даган мөрдөгдөх ёстой. Ихэнх заалтууд нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнд зориулагсан байдаг бол, цөөн хэдэн заалтууд нь олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэгддэг. Хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн зорилго нь байлдагч бус хүмүүс болон цаашид байлдахааргүй болсон байлдагчдын (олзлогдсон, шархадсан буюу өвчтэйн улмаас) амь нас, эрүүл мэнд, нэр хүндийг хамгаалж, мөргөлдөөнд оролцогч талуудын дайн тулалдааны арга хэрэгслүүдийг өөрсдийн сонголтоор хэрэглэх эрхийг хязгаарлах явдал болно. ОУХЭЗ—н гол зорилт бол, зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэн гарах зовлон шаналал, гарз хохирлыг хязгаарлах явдал билээ. Энэ ч утгаараа, ОУХЭЗ—г зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхүүдийн "гол цөм"—ийг хамгаалах эрх зүй гэж ойлгож болно. Эдгээр үндсэн хамгаалалтуудад, амьд явах, боолчлол, эрүү шүүлтийг хориглох, хүнлэг бус харьцаа болон буцаан хэрэглэх хүчин чадалтай хууль ашиглахыг хориглох зэрэг орно. Үндэсний онцгой байдлын үед хүчингүй болгож болох бусад эрхүүдээс (үг хэлэх, холбоо, хөдөлгөөн байгуулах эрх) ялгаатай нь, ОУХЭЗ—ээр олгогдсон "гол цөм" эрхүүдийн хамгаалалт нь хэзээ ч түдгэлзүүлшгүй юм.

Хэрэв бид бүх хөндөгдөшгүй эрхүүдийг нэгттэн харвал, хүний зайлшгүй эдлэх ёстой үндсэн эрхүүд нь ОУХЭЗ болон хүний эрхийн хуулийн аль алинаар нь баталгаажсан байгааг олж харах болно.



## Хүний эрхийн хууль

Хүний эрхийн хуулийн анхны ул мөр 18—р зуунаас улбаатай. Чухамдаа, 1789 оны Францын Хүний ба Иргэний Эрхийн Тунхаглал, 1791 оны Америкийн Хүний Эрхийн Бичиг нь хүний эрхийн хуулийн эхлэл байсан билээ. Дараагаар нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), 1948 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын нөлөөн дор, хүний эрхийн хууль нь жинхэнэ утгаараа хөгжиж эхэлжээ. 1966 онд хоёр чухал гэрээнд гарын үсэг зурсан байна: Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Гэрээ (хүний эрхийн анхны үе) ба Эдийн Засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай Олон Улсын Гэрээ (хүний эрхийн хоёрдугаар үе).

Нэгдүгээр гэрээ нь бусад олон гэрээ хэлэлцээр, эрх, эрх чөлөөний талаарх үндэсний дүрмүүдийн загвар, жишиг стандарт нь болсон юм. Нөгөө талаас, хоёрдугаар гэрээний үр нөлөөлөл нь улс орон бүрийн хөгжлийн чадавхи болон бүсийн шинж чанараар хязгаарлагдаж байна.

Хүний эрхийн гуравдугаар үе нь хөгжих эрх, энх тайван байх эрх, эрүүл орчинд амьдрах эрх зэрэг шинэ түгээмэл эрхүүдээс бүрдэнэ. Гэвч, ихэнх хуульчид эдгээрийг жинхэнэ эрх хэмээн авч үздэггүй.

Хүний эрхийг бүсийн байгууллагууд ч мөн тунхаглажээ: Хүний эрхийн хамгаалалт болон Үндсэн Эрх Чөлөөний тухай Европын Конвенц (1950 — Европын Холбооны Зөвлөл), Америкийн Хүний Эрхийн Конвенц (1969 — Америкын Улсуудын Холбоо), Хүний ба Ард Түмний Эрхийн тухай Африкийн Дүрэм (1981 — Африкийн Эв Нэгдлийн Байгууллага). Мөн Кайрогийн Хүний Эрхийн Тунхаглалыг (1990 — Исламын Шашинт Улсуудын Байгууллага) харна уу.

Доорх баримт бичгүүдийн ихэнх нь үр нөлөө бүхий шүүх засаглалыг байгуулсанаар (Европын Хүний Эрхийн Шүүх, Америк хоорондын Хүний Эрхийн Шүүх), эсвэл хагас шүүх засаглалаар (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Хороо, Африкийн Хүний ба Ард Түмний Эрхийн Комисс), эсвэл, мэдээлэгч байгууллагуудаар (НҮБ—ийн Хүний Эрхийн Комисс) дамжуулан эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх механизмээр хангагдсан байдаг.

## Хүний Эрхийн Хуулийн Үндсэн Баримт Бичгүүд

| | |
|---|---|
| 1926: | Боолчлолын тухай Конвенц |
| 1930: | Албадсан буюу Албадан Хөдөлмөр Эрхлэлтийн тухай Конвенц (ОУХБ) |
| 1948: | Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал |
| 1948: | Төрлөөр устгах (Геноцид) Гэмт Хэргийн Сэргийлэлт болон Шийтгэлийн тухай Конвенц |
| 1950: | Хүний эрхийн хамгаалалт болон Үндсэн Эрх Чөлөөний тухай Европын Конвенц |
| 1965: | Бүх Төрлийн Арьсны Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Явдлыг Арилгах тухай Олон Улсын Конвенц |
| 1966: | Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Гэрээ |
| 1969: | Америкийн Хүний Эрхийн Конвенц |
| 1979: | Эмэгтэйчүүдийн эсрэг Бүх Төрлийн Ялгаварлан Гадуурхах Явдлыг Арилгах тухай Олон Улсын Конвенц |
| 1981: | Хүн ба Ард Түмний Эрхийн тухай Африкийн Дүрэм |
| 1984: | Эрүү Шүүлт болон бусад Хэрцгий, Хүнлэг Бус, Гутаан Доромжилсон Харьцаа ба Шийтгэлийн эсрэг Конвенц |
| 1989: | Хүүхдийн Эрхийн Конвенц |
| 2002: | Зэвсэгт мөргөлдөөний үед хүүхдүүдийн оролцооны тухай Хүүхдийн Эрхийн Конвенцын Нэмэлт Протокол |

## Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй (ОУХЭЗ)
### (Дайн буюу зэвсэгт мөргөлдөөний хууль)

- Зэвсэгт мөргөлдөөний үед хүчирхийлэл хэрэглэх явдалд хязгаарлалт тавьдаг гэрээ хэлэлцээр, зан заншлаас бүрдсэн Олон Улсын зарчмуудын цогц нь дараах зорилготой:

  **Цэргийн ажиллагааны зан үйлийг зохицуулах;** ялангуяа, дайн байлдааны арга, хэрэгслийг хязгаарлах

  **Дайнд оролцоогүй буюу цаашид оролцохгүй хүмүүсийг хамгаалах,** өөрөөр хэлбэл, энгийн иргэд

- Цэргийн хэрэгцээ болон хүмүүнлэгийн зарчим хоорондын (бодит болон прагматик) тэнцвэр

ОУХЭЗ нь аливаа хүчирхийллийг өөр хүчирхийлэл үйлдсэнээр хариу үзүүлэхийг хориглодог.

## ОУХЭЗ–н үндсэн баримт бичгүүд

| | |
|---|---|
| 1868 | Санкт Петербургийн Тунхаглал |
| 1899 | Гаагийн Конвенц |
| 1949 | Женевийн Конвенц |
| 1954 | Соёлын өмчийг Хамгаалах тухай Конвенц |
| 1977 | Нэмэлт протоколууд |
| 1980 | Ердийн зэвсгүүдийн хэрэглээний тухай Конвенц |
| 1993 | Химийн зэвсгүүдийн тухай Конвенц |
| 1995 | Сохлогч лазер зэвсгүүдийн тухай протокол |
| 1997 | Хүний эсрэг минуудын тухай Конвенц |
| 1998 | Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрэм |
| 2002 | Олон улсын эрүүгийн байнгын шүүхийг байгуулснаар Ромын Статутыг (дүрэм) хүчинтэй болгох эхлэл тавигдав |

# Судалгаа 2В: Түүхэн хууль дүрмүүд

Судалгаа 2В нь хууль тогтоомж, багц дүрмүүдийг боловсруулах замаар дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах өнгөрсөн зуунууд дахь хүн төрөлхтний хүчин чармайлтын түгээмэл байдлыг дүрслэхэд зориулагдсан билээ. Санал болгож буй дэс дараалаар бол, сурагчид, дүрэм журмуудын хэрэгцээ шаардлага болон өнөөгийн дүрэм болох олон улсын хүмүүнлэгийн эрх зүйтэй танилцсаныхаа дараа, өнгөрсөн үеийн хууль тогтоомж, дүрмүүдийг авч үзэх юм.

---

**Зорилго:**
- Янз бүрийн газар нутаг, цаг хугацаанд хүмүүс зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах зорилгоор хууль, дүрмийг боловсруулж байжээ гэдгийг мэдэж авах
- Өмнөх үеийн хуулиудад заасан шаардлага, хоригуудын зарим жишээг мэддэг болох
- Хүмүүнлэгийн хэм хэмжээнүүдийн хувьсал, хөгжил ба үйл явдлуудын хоорондын харилцааг харуулах

**Ашиглах материалууд:**
- Амьтны болон байлдагчийн хууль дүрмүүд
- Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ
- ОУХЭЗ—н үндсэн дүрмүүд юу вэ?
- Дэлхийн газрын зураг (боломжтой бол)

**Хугацаа:**
- 45—60 минутын 1 хичээл

---

**1. Зэвсэгт мөргөлдөөнд зориулсан дүрмүүдийг бий болгох хүчин чармайлтуудын хамгийн эртний баримт жишээ юу вэ?** (10 минут)

Дээрх асуултыг сурагчид эргэцүүлэн бодоод өөрсдийн хариултын шалтгааныг тайлбарлаж, үзэл бодлоо хоорондоо хэлэлцэх юм. [Энд цорын ганц зөв хариулт гэж байхгүй. Учир нь, иймэрхүү оролдлогууд нилээд эртнээс улбаатай гэдгийг ойлгуулах явдал юм.]

"Амьтны болон байлдагчийн хууль дүрмүүд"

**2. Түүхэн хууль дүрмүүд** (25 минут)

"Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ"—г танилцуулна уу.

**Боломжит асуултууд:**
- Ямар дүрмүүд нэгээс илүү хууль дүрэм дээр ажиглагдаж байна вэ?

  *[Жишээ нь: байлдаанд оролцоогүй буюу оролцохооргүй болсон хүмүүс болох "байлдагч бус хүмүүс"—ийг хамгаална, зарим зэвсгүүдийг хориглоно.]*

- Эдгээр хууль дүрмүүд өөрт нь багтаж буй дүрмүүдийн шалтгааныг тайлбарласан байна уу? Юу гэж тайлбарласан байна вэ?
  [Жишээ нь, байлдагчийн нэр төрийг тусгасан хууль дүрэм гэх мэт]
- Санал болгосон дүрэмтэйгээ төстэй дүрмүүдийг эдгээр хууль дүрмүүд дотроос олж харсан уу?
- Эдгээр хууль дүрмүүдийг, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн дүрмүүдтэй харьцуулна уу.

**3. Дэлхийн газрын зурган дээр ажиллах**
(10 минут)

Дэлхийн газрын зурган дээр хууль дүрмүүдийн анх бий болсон газар нутгуудыг заана уу.

*Олзлогдогчдод сайнаар хандаж, тэднийг асран тэтгэ.*

—Дайны Урлаг, Сүн Тзү (МЭӨ 496—544)

**ГОЛ САНААНУУД**

- Дайны гай зовлонг хязгаарлах гэж ертөнцийн өнцөг булан бүрт хүмүүс хичээн зүтгэж байна.
- Хэрэгцээгүй зовлон шаналлыг багасгаж, эвдрэл сүйрлийг хазаарлахын тулд хүч хэрэглэхийг хориглосон хууль дүрэм байсныг түүх гэрчилдэг.

## Нэмэлт дасгал

**Хэвлэл мэдээлэл/Уран зохиол:**

Гэр бүлийнхэн буюу олон нийтээсээ сонссон ямар нэгэн тэмцэлд оролцож байсан хүмүүсийн тухай дуртай түүхээ тунгаан бодно уу. Кино дэлгэцээр, театр, телевизээр үзэж байсан, радиогоор сонсож байсан түүхүүд ч байж болно. Түүгээр ч барахгүй, амьтны түүх, домог туульс, шашны түүх, эсвэл зохиомол түүх ч байж болно.

- Уг тэмцэлд оролцож буй хүмүүст ямар үйлдлүүд хориотой болохыг сануулсан хууль дүрэм байсан уу?
- Тэд уг хууль дүрмийг чандлан мөрдсөн үү? Эдгээр хуулиудыг даган мөрдөх нь (эсвэл зөрчих нь) ямар үр нөлөө үзүүлсэн бэ?

**Түүх:**

Илүү дэлгэрэнгүй судалгаа хийхийн тулд "Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ"—нээс аль нэгийг нь сонгоно уу. Уг жишээний хаана, хэзээ бичигдснийг шалгана уу. Хэн зохиосон болон ямар нөхцөл байдалд энэхүү хуулийг анх танилцуулж байсан талаар хэр их зүйл мэдэж авч чадахаа үзээрэй.

ЭСВЭЛ

"Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ"—н дээр гарч буй аль нэг улс оронд, уг хууль дүрмүүд мөрдөгдөж байсан үед болсон нэгэн зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдлыг сонгон авна. Уг зэвсэгт мөргөлдөөнийг ном, интернет, кино зэргийг ашиглан дэлгэрүүлэн судална уу. Тэгээд хууль дүрмүүдийг чандлан мөрдөж байсан болон зөрчиж байсан байлдагчдын жишээ баримтыг олж хайна. Тухайн газар нутаг, цаг үед эдгээр хууль дүрмүүд ямар нөлөө үзүүлж байсныг өөрсдөө дүгнэн шийдээрэй.

# Амьтны болон байлдагчийн хууль дүрмүүд



### Чоно тулалдаанд ялагдагчынхаа амийг хэлтрүүлдэг

Чоно ганц тулалдаанаар сүргийн захирагч болохын төлөө тулалдах үед, ялагч нь хүлцэнгүй номхон болсноор бууж өгснөө мэдэгдэж буй ялагдагч чонийг хөнөөдөггүй ажээ.

—Чонын Боловсрол Судалгааны төвөөс авав. www.wolfcenter.org



### Тулалдаж буй хулд загас бууж өгөхдөө "хар дарцаг хийсгэдэг"

Атлантын далайн залуухан хулд загас голын хэсэгхэн газрыг булаацалдан муудалцах үед, булаацалдаанд амжилтгүй болсон нэгэн нь өөрийн арьсыг болон нүдний тойргийг хар бараан болгох замаар бууж өгдөг байна. Хожигч нь тэгээд л тайвширдаг.

"Энэ бол тулалдааны үед дохио өгөх гайхамшгийн нэг хэсэг юм" хэмээн хулд загасны биологич Жон Э. Торп өгүүлж байна. "Өнгөний хувирал нь биед ямар нэгэн шарх учруулахгүйгээр өөрсдийн ялгаагаа мэдрүүлэхэд тусалдаг."

—Шинжлэх ухааны мэдээллээс авав, С. Мильюс,1999 он

- ➤ **Хүмүүст бууж өгч байгаагаа илэрхийлсэн дохио байдаг уу?**
- ➤ **Амьтдын зүйлын хувьд, ялагдагчийг хөнөөгдөх буюу шархдалгүйгээр бууж өгөхийг нь зөвшөөрөхөд ямар нэгэн үнэ цэнэ байна уу?**

### Сэлмийг хянах нь



Хүчирхийлэл, ялангуяа эрчүүдийн үйлдэж буй хүчирхийлэл бол хүний нийгмийг хамгийн их заналхийлж буй зүйл билээ. Хүчирхийллийг дүрэм журмаар хянах хэрэгтэй. Энэ бол бидний мэддэг нийгэм бүрийн хүн судлалын үндсэн уггвар нөхцөл болдог билээ. Хүчирхийлэл нь ихэвчлэн, байлдагчдын давхаргад нуугдаж байдаг. Зэвсэг хэрэглэхийн тулд бид эхлээд сургагда бэлтгэгдэх хэрэгтэй. Сэлэм нь тодорхой дэг жаяг ялгаварлан үзэх үзэл дээр үндэслэн хэрэглэгддэг ариун зэмсэг юм. Түүнийг эмх замбараагүйгээр хэрэглэж буй хүмүүс сэлмийг гутаадаг. Энэ нь зөвхөн Христийн ёс заншилд төдийгүй, Лалын ёс заншил, Японы бие хамгаалах урлагын ёс заншилд уламжлагдан ирсэн эртний ёс заншил юм.

Өөрөөр хэлбэл, хүчирхийлэл нь хүн амын бүх олон нийтийг ихээр заналхийлсэн тул, тэд үүнийг хянах арга замыг хайх хэрэгтэй байсан учраас л дайны тухай хуулиуд ихэнх иргэншлүүдэд маш эртнээс улбаатай гэж би боддог юм. Иймд тэд, тодорхой дүрмүүдийг даган мөрдөх ёстой байлдагчдын анги давхаргад хүчирхийллийг шургуулжээ.

—Майкл Игнатиеф, Байлдагчийн нэр сүр: Угсаатны дайн ба орчин үеийн ухамсар, 1999 он

- ➤ **"Байлдагчдын давхарга" гэж юуг хэлж байна вэ?**
- ➤ **Нийгэм ямар хүмүүс зэвсэг авч явах хэрэгтэйг тодорхойлох нь зүйтэй гэдэгтэй санал нийлж байна уу?**

# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

*МЭӨ 8–р зуун – Эртний Грек*
Лелантины талд болсон дайны үеэр, тэмцэлдэгч талууд нь харвагч сумуудыг хэрэглэхийг хориглох талаар зөвшилцжээ.

*МЭӨ 7–р зуун – Эртний Грек*
Нэгдүгээр Ариун Дайны дараа, ялагч улсууд нь бүслэгдсэн Грек ардуудыг ахин хэзээ ч ус болон хоол хүнсээр таслахгүй хэмээн андгайлжээ.

*МЭӨ 6–р зуун – Эртний Грек*
Улс хоорондын мөргөлдөөнүүдийг зохицуулагч хэлэлцээрт доорх зүйлс багтана:

- Дайсагналд заримдаа тохиромжгүй үе байдаг: ялангуяа Олимпын тоглолтын баяр ёслолд зориулж тунхагласан дайны түр зогсоолтыг сайтар ажиглах ёстой.
- Тодорхой хүмүүстэй, тодорхой газар нутагт дайсагналцах нь тохиромжгүй байдаг: халдашгүй ариун газрууд, бурханы ивээлд орсон халдашгүй хүмүүс, ялангуяа, элч нар болон хүсэлт гаргагчдыг хүндэтгэх хэрэгтэй.
- Хэрэв дайсны талынхан хүсвэл, амь үрэгдсэн дайсныг эргүүлэн өгөх хэрэгтэй: Цогцсыг эргүүлэн авахыг хүснэ гэдэг бол ялагдсантай эн тэнцүү юм.
- Дайны олзлогдогчийг шуудхан л хөнөөх, эрэмдэг болгохын оронд тэдэнд төлөөс өгвөл чөлөөлж болох талаар санал болгох хэрэгтэй.
- Бууж өгсөн өрсөлдөгчийг залхаан цээрлүүлэх явдлыг хязгаарлах хэрэгтэй.
- Дайн бол байлдагчдын хоорондын хэрэг явдал юм, иймд байдагч бус хүмүүс аливаа халдлагын тэргүүн бай болох ёсгүй билээ.
- Аливаа тулалдаан нь зуны зуслангийн цагт явагдах нь зүйтэй.
- Харвагч сум зэрэг явган цэргийн бус зэсгийн хэрэглээг хязгаарлах нь зохистой.

–ЭНГИЙН ЁС ЗАНШЛААС



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

## МЭӨ 1-р зуун — Энэтхэг

90. Тулалдаанд өстөн дайсантайгаа байлдах үедээ, модонд нуусан, өргөстэй, хордуулсан, эсвэл гал дүрэлзэн асч буй үзүүртэй зэвсгээр түүнийг бүү цохитун.

91. Тулалдаанд өндөрлөг газарт авиран гарсан нэгнийг, тайган хүнийг, өршөөл эрэн хоёр алга хавсран гуйж буй хүнийг, үсээ намируулан зугтаж буй нэгнийг, сууж буй хэн нэгнийг, "бууж өглөө" гэж буй хэн нэгнийг бүү өвтгөтүн.

92. Унтаж буй хэн нэгнийг ч, хуягт хувцсаа гээсэн хэн нэгнийг ч, нүцгэн хэн нэгнийг ч, зэвсэглээгүй хэн нэгнийг ч, тулалдаанд оролцохгүйгээр ажиглаж буй хэн нэгнийг ч, өөр нэгэн өстөн дайсантайгаа тулалдаж буй хэн нэгнийг ч бүү өвтгөтүн.

93. Зэвсэг нь эвдэрсэн хэн нэгнийг ч, уй гунигт шаналж буй хэн нэгнийг ч, зовлонтойгоор шархадсан хэн нэгнийг, айж буй хэн нэгнийг ч, тулалдаанаас зугтаж буй хэн нэгнийг ч бүү өвтгөтүн, харин дээрх бүх нөхцлүүдэд, нэр төрт байлдагчийн үүргийг санаж биелүүлэгтүн.

—МАНУ—гийн хууль



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

*7—р зуун — Ойрхи Дорнод 90*

Байлдаанд ялсан тохиолдолд, зугтан гүйж буй цэрэг буюу шархадсан хүнийг бүү хөнөө, Еврей биш гэдгийг нь бүү илчил, хувийн эрхэнд бүү халд, цогцсыг бүү эрэмдэглэ, зөвшөөрөлгүйгээр ямар ч байшин руу бүү нэвтэр, бусдын өмчийг бүү албадан хураа, хэдийгээр чамайг болон чиний удирдагчыг доромжилсон байлаа ч эмэгтэйчүүдийг бүү тамлан зовоо, тэднийг битгий айлган сүрдүүл, Нигүүлсэлд нь багтахын тулд цаг үргэлж Бурхан тэнгэрийг санаж яв.

—ХАЛИФ АЛИ ИБН АБИТАЛЕБ

Урвалт, хэтэрхий овлигогүй ааш, итгэл эвдэх, эрэмдэг болгох зэрэг зан үйлийг цээрлэ, жаахан хүүхдүүд, хөгшдийг бүү хөнөө, дал модыг хэзээ ч битгий огтол, шатаа, жимсний модыг бүү огтол, ямаа, үхэр болон тэмээг хүнсний бус зорилгоор хэзээ ч битгий нядал. Мөргөлд өөрийн биеэ зориулсан хүнтэй таарвалдвал, түүнийг зөнд нь орхи.

—ХАЛИФ АБУ БАКР АЛ—СИДДИК



*12—16—р зуун — Европ*

"Морьтон баатруудын Зуун"—д хүлэгт баатруудын зан авирыг зохицуулах тодорхой дэг жаяг бүхий дүрэм журам олоход хэцүү байсан хэдий ч, тийм хууль байсан гэдэг нь тодорхой байгаа юм. Зөвхөн төгс төгөлдөр эр хүний даган мөрдөж чадах эдгээр хуулиудаар сайшаагдсан, эр зориг, өр зөөлөн сэтгэл, ойлголцол ба энэрэнгүй сайхан сэтгэлийн жишээнүүд байдаг. Эдгээр хуулиудад морьтон баатруудыг, сул дорой (феодалын нийгэмд өвчтэй хүмүүсийг ч мөн энэхүү ангилалд багтаадаг байжээ), дарлагдсан болон бэлэвсэн нэгнийг халамжлан энэрэх хэрэгтэй хэмээн заасан байдаг.

# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

### *13–р зуун – Европ*

Дайны хуулиар, Сүм нь, хулгавч нум хэрэглэхийг хориглосон байдаг, учир нь, энгийн ардуудын эгнээнээс гарсан харваачдын зайнаас онилсон суманд унах нь морьтон баатруудад зохисгүй юм.

Цэргийн хуулиар, тусгай цэргийн буюу Хааны шүүхүүд (Английн Морьтон Баатруудын Шүүх, Францийн Парисийн Их Хурал), зэвсгийн хуулиудыг зөрчсөн ял зэмлэлүүдийг хэлэлцэн шийдвэрлэх ба хуульч, өмгөөлөгчид нь албан ёсны өмгөөллүүдээрээ өөрсдийн гаргасан дүрэм тогтоолыг бататган, тодруулдаг байлаа. Мэдээж, морьтон баатрууд болон элч нар зэвсгийн хуулийн шинжээчид болон үлдсэн юм. Тэдний мэдүүлгүүд нь, хуулийг тодорхойлох болон зарим онцгой тохиолдлуудад эдгээр хуулийг хэрэглэх явдалд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байлаа. Олон улсын морьтон баатруудын ёс заншлын нэгэн бие бүрэлдэхүүн хэсэг болох цэргийн хуулийн статус байсныг дээрх зүйлс тусгаж байна.

"Бурхан тэнгэрийн амар амгалан"–д зааснаар бол, Сүм нь, шашны ариун газрууд, санваартан, тариачид, эмэгтэйчүүд, хүүхдүүд, аялагчид болон бадарчингуудад халдахыг хориглодог байжээ.
"Бурхан тэнгэрийн энхийн хэлэлцээр"–т зааснаар бол, Сүм нь, ням гариг болон гэгээн өдрүүд гэх мэт тодорхой өдрүүдэд дайтахыг хориглодог байжээ.

### *15–р зуун–Англи*

... Гэгээн Сүмээс, уг Сүмд харъяалагдаж буй аливаа эд материал болон чимэг хэрэглэлүүдийг дээрэмдэн тонуулдах буюу Гэгээн Сүмийн, шашны болон ямар ч хүнийг (хэрэв зэвсэглээгүй л бол) хөнөөх, эмэгтэйчүүдийг хөнөөх болон тэдэнд хүч хэрэглэхийг хориглох ба зөрчсөн этгээдэд хөнөөх ял оноono. Мөн Гэгээн Сүмийн хүнийг олзлон баривчилсан (хэрвээ тэрээр зэвсэглээгүй бол) хүнд шоронд хорих ял оногдуулах ба түүний хувь заяаг Хааны таалал мэднэ.

–Хаан Генрих V–ийн дайны хууль тогтоомжуудаас, 1419 он



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

### *17—р зуун — Нидерланд*
Олон улсын нийгэм гэдэг нь бүрэлдэхүүн улс гүрэн, удирдагчид нь өөр хоорондоо дүрэм журмаа харилцан биелүүлнэ гэсэн ойлголцлын үндсэн дээр нэгдсэн хамтын нийгэмлэг билээ. Энэхүү олон үндэстний *эрх зүй нь улс орнуудын мөрдөхөөр зөвшилцсөн хууль тогтоомжуудаас бүрдэх бөгөөд бүх хүмүүс, үндэстнүүдэд хүчин төгөлдөр үйлчилдэг юм.*
*—ГРОТИУС*

### *17—р зуун—Япон*
*Гуравдагч хүчин зүйл бол бусдыг хайрлах, хүлцэх, энэрэх гэсэн нигүүлсэнгүй сэтгэл юм. Нигүүлсэл нь удирдагч нарын өмнө тавигддаг онцгой шаардлагуудын нэг билээ. Сул дорой буюу ялагдсан нэгэнд үзүүлж буй нигүүлсэл нь байлдагчийн өөрөө өөрийгөө хамгийн нэр төртэй авч яваа хэрэг болно, тийм ч учраас, олзлогдогстой зүй бусаар харьцах нь энэхүү хүчин зүйлийн эсрэг хэрэг болно.*

*— БУШИДО БУЮУ ЯПОНЫ УЛАМЖЛАЛТ БАЙЛДААНЫ УРЛАГ*



### *18—р зуун — Европ*

*40—р заалт:...Шоронд хоригдогсод нь...7 хоног тутам сайн сүрлээр шинэчилж байх ахуйн нөхцөл сайтай оромжинд хоригдох...зэрэг тусламжийн эд материалаар хангагдах эрхтэй.*

*41—р заалт:...Шархагдагсдыг зэвсэгт мөргөлдөөнд оролцогч 2 тал хоёулаа асран тэтгэх ёстой... эм, хоол хүнс авч өгөх ёстой... генералаар зөвшөөрөгдсөн аюулгүй байдлын баталгаатай мэс засалч болон үйлчлэгчтэй байхыг зөвшөөрөх ёстой...Мөн шоронд хоригдогсод нь газраар болон усан замын аль тохиромжтойгоор нь генералын хамгаалалтан дор эх нутагтаа буцаагдах ёстой.*

*42—р заалт: ...2 талын өвчтэй хүмүүсийг хорих ёсгүй бөгөөд эмнэлгийн газарт аюулгүй нөхцлөөр хангахаас гадна харгалзагчийг байлцуулж болно. Өвчтөн нь харгалзагчийн удирдлага дор ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр, хамгийн шулуун замаар гэртээ буцаагдах эрхтэй.*

*44—р заалт:..Хоригдлуудыг цэрэгт хүчээр татаж хэрхэвч болохгүй.*

*45—р заалт:..Шор онд хоригдогч нь баривчлагдан хоригдож байгаа тухай мэдээллийг дартасгүй захиагаар холбогдох хүмүүст илгээх эрхтэй.*
*—Франкфуртын Гэрээ, Конвенц, 1743 он*

# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

### *18–р зуун – Франц*
*Хэрэв дайны зорилго нь дайсагнагч улсыг устгах бол, дайсагнагч талыг хамгаалж буй дайчид цэргүүдийг зэвсэглэсэн үед нь хөнөөж болно, харин тэд бууж өгөх юм бол дайсан буюу дайсны хэрэгсэл байхаа больж, хэн ч амь насыг нь хөнөөх эрхгүй болно.*

*–РУССОГИЙН НИЙГМИЙН ГЭРЭЭ, 1762 ОН*

### *Аман зан үйл – Сенегал*
*Дайны ёс зүйг залуу язгууртан хөвгүүн бүрт, ирээдүйд дайчид болох учраас багаас нь заан сургадаг байжээ. Газар хэвтэж буй дайсныг хэзээ ч битгий хөнөө, учир нь газарт хэвтсэнээр тэд өөрдсийн сул дорой байдлаа хүлээн зөвшөөрч байна хэмээн залуу хөвгүүдэд заан сургадаг байжээ.*

### *Аман зан үйл – Сомали*
*"Жаднаас хэлтрүүлэгдэх нь" гэсэн нэртэй хуулинд бүх цаг үед, ялангуяа зэвсэгт мөргөлдөөний үед халдах ёсгүй бөгөөд халамжлан асрах ёстой хүмүүсийг ангилсан байдаг бөгөөд энэхүү ангилалд эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан, өвчтөн, зочид, шашны болон энх тайвны зүтгэлтнүүд багтдаг байжээ.*

### *Ам дамжсан уламжлал – Мали, Хойд Волта болон Сахелийн бүсийн орнууд*
*Хэн ч зэвсэглээгүй байгаа дайсныг хөнөөх эрхгүй. Гагцхүү баривчлах л эрхтэй.*

### *Ам дамжсан уламжлал: – Нигер*
*Дан ганц хүүхэд эмэгтэйчүүдээс бүрдсэн тосгон руу дайрна гэдэг бол дайн биш, энэ бол хулгай юм, харин бид хулгайчид биш.*

### *18–р зуун – Төв Африк*
*"Лапир"–ийн хуулиар, дайны үед нэр төртэй байлдах нь энгийн иргэд буюу тэдний хүнсний хангамжанд хэзээ ч хор хүргэхгүй гэсэн үг байлаа.*



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

*19—р зуун — Америкийн Нэгдсэн Улс*

*61—р зүйл: Эсрэг талдаа буюу бууж өгсөн хэн нэгэнд өршөөл үзүүлдэггүй цэргүүд бусад баривчлагдсан цэргүүд болон шархадан чадвараа алдсан дайсны цэргүүдийг хөнөөх эрхгүй.*

*75—р зүйл: Дайны олзлогдогсдыг аюулгүй байдлыг нь хангах үүднээс шоронд цагдан хорихоос бусдаар санаатайгаар зовоон тамлах, гутаан доромжлохыг хориглоно. Олзлогдогсдыг шоронд хорих, тэдэнтэй хэрхэн харьцах талаарх нөхцөл нь хоригдох хугацаанд аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагаас хамаарна.*

*76—р зүйл: Дайны олзлогдогсдыг зүй зохистой хоолоор хооллон, тэдэнд хүнлэг ёсны байр суурингаас хандах хэрэгтэй. Тэднийг зэрэглэл, албан тушаалаас нь хамааран олзлогч талын төрийн ашиг тусын төлөө ажиллахыг шаардаж болно.*

*79—р зүйл: Олзлогдогч шархадсан цэрэг бүрийг эмнэлгийн албаны ажилчдын ур чадварыг бүрэн дүүрэн ашиглан эмчлэх хэрэгтэй.*

*—ЛИЙБЕРИЙН ХУУЛЬ, 1863 ОН*

*19—р зуун — Шинэ Зеланд*

*1—р дүрэм: Хэрэв дайсан шархадсан буюу баригдсан эсвэл, бууны бөгс, сэлмийн үзүүрээ өгөн бууж өгвөл түүнийг өршөөж болно.*

*2—р дүрэм: Хэрэв ямар нэгэн Пакеха ёс төдий цэрэг байж, зэр зэвсэггүй явж байвал түүнийг баривчлан хуулийн дагуу шийтгэж болно.*

*3—р дүрэм: Хэрэв дайсны цэрэг айн зугтаж шашны номлогчийн гэрт зэвсэглэн орсон байлаа ч түүнийг өршөөх болно. Би түүнтэй харьцахгүй.*

*4—р дүрэм: Зэвсэглээгүй дайсны талынхан, Пакеханууд болон эмэгтэйчүүд, хүүхдүүдийг өршөөгтүн.*

*—МАОРИ БАЙЛДАГЧИЙН ХУУЛЬ, 1864 ОН*



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

*19–р зуун – Орос*

*Цэрэг дайчид дайсны цэргийг зэрэмдэглэх буюу хөнөөх замаар өөрсдийн зорилгодоо хүрч болох юм. Харин дайсны цэргийг тамлан зовоосноор юм уу, насан туршид нь тахир дутуу болгосноор ямар нэгэн цэрэг дайны үр ашиг гарахгүй. Хэрэгцээгүй зовлон учруулах зэвсгийг хориглоно. (...) Өөр нэгэн чухал зорилго бол зэр зэвсгийн хор хөнөөлийг зөвхөн дайны талбар болон тэнд дайтаж буй байлдагчдаар хязгаарлах явдал бөгөөд энгийн иргэд зэрэг гэмгүй иргэдэд, зэр зэвсгийн хор хөнөөлийг хүрэх ёсгүй юм. (...) 400 граммаас доош жинтэй дэлбэлэгч сумыг хэрэглэхийг хориглоно.*

*–Санкт Петербургийн Тунхаглал, 1868 он*



# Дайны үеийн хууль дүрмүүдийн жишээ

### *20—р зуун — Хятад*

*Бүх үйлдэлдээ тушаалыг дага. Хүмүүсээс ганц утас, зүү ч бүү ав. Барьсан бүхнээ тушаа. Эелдэг харьц. Худалдаж авсан зүйлийнхээ үнийг шударгаар төл. Зээлсэн болгоноо эргүүлэн өг. Учруулсан хохирол болгоноо эргүүлэн төл. Хүмүүсийг бүү цохь, бүү занч, бүү хараал хэл. Үр тариаг битгий сүйтгэ. Эмэгтэйчүүдтэй өөрийн дураар бүү харьц. Олзлогдогчидтой зүй бусаар бүү харьц.*

*—ЖУ ДЭ — МАО ЗЕДУН "ЦЭРГҮҮДЭД ЗОРИУЛСАН ДҮРЭМ", 1935 ОН.*



# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**1** Аливаа халдлага нь байлдагчид болон цэргийн байнуудаар л хязгаарлагдах ёстой.

1.1 Энгийн иргэд рүү дайрч болохгүй.
1.2 Энгийн иргэдийн обьектууд руу (байшин, эмнэлэг, сургууль, мөргөлийн газар, соёлын буюу түүхийн хөшөө дурсгал гэх мэт) дайрч болохгүй.
1.3 Цэргийн байны бамбай болгон энгийн иргэдийг ашиглахыг хориглоно.
1.4 Байлдагчдыг энгийн иргэдийн дүрд хувирахыг хориглоно.
1.5 Энгийн иргэдийн өлсгөлөнг дайтах арга болгон хэрэглэхийг хориглоно.
1.6 Энгийн иргэдийн амьд үлдэхэд зайлшгүй шаардлагатай обьектүүд рүү (хоол хүнс, тариалангийн талбай, ундны усны байгууламж гэх мэт) дайрахыг хориглоно.

**2** Энгийн иргэд ба цэргийн обьектууд болон хүмүүсийг ялгаварлахгүйгээр хөнөөдөг, үлэмж хохирол, зовлон учруулах аливаа дайралт буюу зэвсгийг хориглоно.

1.7 Хэрэв энгийн иргэдэд ихээхэн хэмжээний хохирол учруулах бол усны далан, хаалт буюу атомын цахилгаан станц руу дайрахыг хориглоно
2.1 Химийн болон биологийн, нүд сохлогч лазерын зэвсэг, хүний биед рентгений туяагаар илэрдэггүй хэлтэрхийнүүдээр гэмтэл учруулах зэвсэг, аливаа хорт бодис, хүний эсрэг газрын мина зэрэг тодорхой төрлийн зэвсгүүдийг хориглоно.
2.2 Амьд хүн үлдээхгүйгээр устгахыг заналхийлэх болон тушаахыг хориглоно.

**3** Энгийн иргэд, шархадсан байлдагчид болон хоригдлуудыг өршөөн хамгаалж, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.

3.1 Ямар ч хүн биеийн болон сэтгэл санааны тамлал, бие махбодийн шийтгэл буюу харгис эсвэл гутаан доромжилсон харьцаа эдлэх ёсгүй.
3.2 Сексийн хүчирхийллийг хориглоно.
3.3 Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрдсийн эрхшээлд байгаа эсрэг талын шархадсан болон өвчтэй дайсанд халамж үзүүлэх, тэднийг хайж олох ёстой.
3.4 Бууж өгсөн буюу дайнд оролцохооргүй болсон дайсныг хороох буюу шархдуулахыг хориглоно.
3.5 Хоригдлуудыг хүндэтгэн, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.
3.6 Хүн барьцаалахыг хориглоно.
3.7 Энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. —“Үндэстэн угсаатны цэвэрлэгээ”—г хориглоно.
3.8 Дайсны гарт байгаа олзлогдсон хүмүүс нь гэр бүлийнхэнтэйгээ мэдээлэл солилцох, хоол хүнс, эмнэлгийн халамж болон сэтгэл санааны дэмжлэг гэх мэт хүмүүнлэгийн тусламж авах эрхтэй.
3.9 Жирэмсэн эмэгтэй, нярай эх, харгалзагчгүй хүүхэд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэн тусгай хамгаалалтанд байх ёстой.
3.10 ОУХЭЗ нь 15—аас доош насны хүүхдүүдийг цэрэгт татах буюу цэргийн үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
3.11 Хүн бүр шударгаар шүүгдэх эрхтэй (шударга шүүх, хэвийн процедур гэх мэт). Хамсруулан шийтгэхийг хориглоно.

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**4 Эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс, байгууламжуудыг (эмнэлэг, клиник, түргэн тусламж гэх мэт) хүндэтгэн үзэж хамгаалан, тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь боломжит бүхий л тусламжаар хангах ёстой.**

**4.1 Улаан Загалмай буюу Улаан Хавирган Сарын эмблем, таних тэмдгүүд нь эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс болон байгууламжуудын хамгаалалтыг билэгдэнэ. Ийм тэмдэгтэй хүмүүс буюу обьект руу дайрахыг хориглоно. Түүнчлэн энэхүү тэмдгүүдийг хуурамчаар ашиглахыг хориглоно.**

**4.2 Эрүүл мэндийн нэгжүүд болон тээвэрлэлт нь дайсны талд хор уршиг учруулах аливаа үйлдэл хийхийг хориглоно.**

**4.3 Шархадсан болон өвчтэй хүмүүсийг эмчлэхэд, эрүүл мэндийн байдлаас нь бусад тохиолдлоор давуу эрх олгохыг хориглоно.**

## Тодорхойлолтууд

**Дагалдах хохирол**: энгийн иргэд амь насаа алдах, бэртэх, эд зүйлсийн хохирол амсахаас хамгаалах, түүнчлэн хохирлыг аль болох багасгах урьдчилсан арга хэмжээ авсан хэдий ч үйлдсэн довтлогооноос тохиолдлоор үүссэн гарз хохирол

**Байлдаанд оролцохооргүй болсон этгээд:** олзлогдсон, шархадсан, өвчтэй эсвэл хөлөг онгоц нь сүйрэлд өртсөний улмаас дахин байлдах боломжгүй болсон байлдагчид

**Энгийн иргэд:** байлдагч бус бүх хүмүүс. (Сэжиглэгдсэн үед ч гэсэн тухайн хүн энгийн иргэнд тооцогдоно.) Хэрэв энгийн иргэд, дайсагнагч талуудын аль нэгний талд орж, ямар нэгэн дайсагналын үйлдэл хийвэл дайтагч болж хувирах ба хамгаалагдах эрхээ алдана.

**Энгийн иргэдийн обьектууд:** цэргийн бай болоогүй бүх обьектууд. Хэрэв энгийн иргэдийн обьект нь цэргийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашиглагдвал тэдгээр нь цэргийн бай гэж тооцогдох ба хамгаалалтаа алдана.

**Байлдагч:** зэвсэгт хүчний гишүүн буюу цэргийн үйл ажиллагаанд шууд оролцож буй хүн

**Цэргийн бай**: Шинж чанар, байрлал, ашиглагдах зорилгоороо цэргийн үйл ажиллагаанд үр ашигтай хувь нэмэр оруулж буй, учруулсан хор хөнөөл нь тодорхой зэвсэгт хүчний давуу талыг олгож байгаа байлдагчид болон обьектууд

# Судалгаа 2С: "Цэрэг" хүүхдүүд

Энэхүү судалгаа нь сурагчдад олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хурцаар тавигдаж буй асуудлуудын нэг болох хүүхдүүдийг байлдагч болгон цэрэгт элсүүлэхийн эсрэг дүрмүүдийг гүн гүнзгий танилцуулах болно. Тухайлбал, 15—аас доош настай хүүхдүүдийг зэвсэгт бүлэгт элсүүлэхийг хориглодог. Судалгаа нь хүүхэд нас ба хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг авч үзсэнээр эхэлнэ. Дараа нь, "цэрэг" хүүхдүүдийн туршлага, тэдгээр туршлагын хүүхдүүд болон нийгэмд учруулж буй үр дагавруудыг тунгаан бодуулах зорилгоор кино, түүхэн үйл явдлуудыг авч үзэх болно. Эцэст нь, дэлхий дахинаа хүүхдүүдийг хэрхэн байлдагч болгон ашиглаж байгааг харуулснаар, энэ нь биднээс хол, бусдын асуудал биш гэдгийг сурагчид ойлгох бизээ.



**Зорилго:**
- Хүүхдүүдийг цэрэг болгон ашиглаж байгаа практикийн цар хүрээ, үр дагаврын тухай мэдэж авах
- Цэрэгт элсүүлэх насны доод хязгаарыг тогтоох шаардлагыг ойлгох
- 15—аас доош насны хүүхдүүдийг зэвсэгт бүлэгт элсүүлэх нь хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн хэрэг бөгөөд энэ шаардлагыг 18 болгож өсгөхөөр чармайж буй талаар мэдэх

**Ашиглах материалууд:**
- Зургийн эвлүүлэг 2С (номын арын хавтсанд байгаа)
- График: Байлдагчдын хувьд насны хамгийн доод хязгаар хэд байх ёстой вэ?
- Дүрс бичлэг/Тайлбар.: "Би буцаж очмооргүй байна"
- Газрын зураг: "Цэрэг" хүүхдүүдтэй орнууд — 1999 оны байдлаар
- Уншлага: Зургаан "цэрэг" хүүхэд
- Жишээ тохиолдлууд: Зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүүхдүүд

> *Хүүхдүүд бол (...) яс үндэс, шашин шүтлэгээсээ үл хамааран бүгд ариун нандин зүйл билээ. Хүүхдийг хамгаалах нь бидний үүрэг.*
>
> *-Доктор Аднан Хубаллах "Хүчирхийллийн нян", 1996*

**Хугацаа:**
- 45—60 минутын 2 хичээл

**1. Хүүхдүүд ба тэдний хэрэгцээ** (10 минут)

**Боломжит асуултууд:**
- "Хүүхэд" гэж хэн бэ?
- Хэдэн настайгаас нь эхлээд "хүүхэд" гэж дуудахаа больдог вэ? (Өсвөр настан гэж хэн бэ? Насанд хүрсэн хүн?)
- Хүүхдүүйн үндсэн хэрэгцээ юу вэ?
- Хэрэв эдгээр хэрэгцээ хангагдахгүй бол юу болж болох вэ?



**2. Байлдагчдын насны доод хязгаар?** (15 минут)

Дэлхийн өнцөг булан бүрийн "цэрэг" хүүхдүүдийг харуулсан зургийн эвлүүлгийг танилцуулна уу. Сурагч бүрийг эсвэл бүлэг бүрээр аль нэгэн зургийг сонгуулаад, яагаад сонгох болсон шалтгааныг нь асууна.

**Боломжит асуултууд:**
- Энэхүү зургийг хараад ямар сэтгэгдэл төрөв?
- Зурган дээрх хүүхдүүд хэдэн настай бол?

Сурагчдыг бүлгүүдэд хуваагаад, бүлэг тус бүрийг доорх асуултуудыг хэлэлцсэний эцэст, цэрэгт элсүүлэх насны хамгийн доод хязгаарын талаар нэгдсэн саналд хүрэхийг хүснэ үү:

➤ Зэвсэгт хүчинд элсүүлэхэд насны хязгаар хэрэгтэй юу?
➤ Энэхүү насны хязгаар нь хэд байх ёстой вэ? Яагаад?

"Байлдагчдын хувьд насны хамгийн доод хязгаар хэд байх ёстой вэ?" графикийг сурагчдад танилцуулна уу.

➤ Цэрэгт элсүүлэх насыг хязгаарлах тухай олон улсын эрх зүй байх хэрэгтэй гэж бодож байна уу? Яагаад?

**3. Хууль юуг өгүүлнэ вэ?** (15 минут)
Бүлгүүдийг эргэн нэгтгээд, үр дүнг харьцуулна уу. Сурагчдаар өөрсдийнх нь хийсэн дүгнэлтүүдийг, өнөөгийн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд заасан насны хамгийн доод хязгаартай харьцуулуулна уу:

*Мөргөлдөөнд оролцогч талууд 15 нас хүрээгүй хүүхдийг дайтах ажиллагаанд шууд оролцуулахгүй байх үүднээс бүхий л арга хэмжээ авна. Мөргөлдөөнд оролцогч талууд 15 нас хүрсэн боловч 18 нас хүрээгүй хүмүүсийг цэрэгт татахдаа аль болох ах настайг нь авахыг эрмэлзэнэ.*

1949 оны Женевийн Конвенцийн, 1977 оны нэмэлт
Нэгдүгээр Протоколын 77 – р зүйл

Сурагчдад, энэхүү хуультай харшилдан, 15 – аас доош настай хүүхдүүдийг цэргийн бүлэгт элсүүлэх явдал дэлхийн олон оронд үргэлжилсээр л байгаа гэдгийг дахин нэг сануулна уу.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн тухай 1989 оны Конвенцид хүүхдийг "насыг нь тухайн улсын хуулинд түүнээс доош гэж заагаагүй бол 18 нас хүрээгүй хүн" гэж тодорхойлсныг тайлбарлана. Гэсэн хэдий ч, хүүхэд болон зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулсан 38 – р зүйлд, цэргийн ажиллагаанд элсүүлэх, оролцуулах насны хамгийн доод хязгаарыг 15 гэж заасан байдаг. ОУХЭЗ (Женевийн Конвенцийн Нэмэлт 1, 2 – р Протоколууд) – д ч насны хамгийн доод хязгаарыг дээрхтэй ижлээр заасан байдаг. 1998 онд, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн дүрэмд, 15 – аас доош настай хүүхдийг цэрэгт татах болон аливаа дайтах ажиллагаанд ашиглах явдлыг дайны гэмт хэрэг гэж үзнэ хэмээн тодорхойлжээ.

10 – аад жилийн олон улсын хүчин чармайлтын эцэст 2002 оны 2 – р сарын 12 – нд, зэвсэгт мөргөлдөөний үед хүүхдийн оролцооны талаар заасан Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Нэмэлт Протокол хүчинтэй болов. Энэхүү протокол нь зэвсэгт хүчний цэргийн албан татлагын насны доод хязгаарыг 18 болгон өсгөж, сайн дураар элсэх насыг 16 болгожээ.

Протоколд заасны дагуу, улс орнууд зэвсэгт хүчний гишүүд нь 18 нас хүрээгүй тохиолдолд тэднийг дайтах ажиллагаанд шууд оролцуулахгүй байх бүхий л арга хэмжээ авах хэрэгтэй. Түүнчлэн, төрийн зэвсэгт хүчнээс ялгаатай зэвсэгт бүлэг нь, ямар ч нөхцөлд, 18 – аас доош насны хүмүүсийг дайтах ажиллагаанд ашиглах буюу элсүүлэхгүй байх ёстой.

Эцэст нь, протоколын хэрэгжилт нь байлдагч хүүхдүүдэд нөхөн сэргээх болон нийгэмд эргэн ороход шаардлагатай зохих тусламж үзүүлэх болно.
2002 оны 4 – р сарын байдлаар, дээрх протоколд 100 улс орон гарын үсэг зурсан боловч зөвхөн 19 нь соёрхон баталжээ.

*[2 сая гаруй өсвөр насны хүүхдүүд Дэлхийн 2–р дайнд цэрэг болон хүчин зүтгэж байсан гэсэн тооцоо байдаг. Хүн хүчээ их хэмжээгээр алдсаны улмаас Герман хөвгүүд цэрэг болцгоож байжээ.]*
*1944 онд хүчтэй довтлон урагшилж байсан Холбоотны зэвсэгт хүчинд мөхөсдөх болсон Германы армийг ухрах үед, Залуучуудын Гитлерийн ахлагчийн хувьд надад 600–800 өсвөр үеийнхнээс бүрдсэн хэд хэдэн байлдааны ангиудыг хариуцуулан даалгасан юм. Намайг, Райнд хамгаалалтыг бэхжүүлэхээр илгээгдсэн, Дэлхийн 1–р дайны ахмад дайчны оронд тавих гэж байсан юм. "Энэ бол боломжгүй зүйл, би 17 нас ч хүрээгүй байгаа шүү дээ" хэмээн би хариулж байлаа.*

– Нэгэн Герман залуу цэрэг

**4. Яагаад хүүхдүүд байлдагч болдог вэ?** (15 минут)
Доорх асуудлаар хэлэлцэнэ үү:

**Олон улсын эрх зүй нь, хүүхдүүдийг зэвсэгт бүлэгт элсүүлэхийг хориглосоор байхад, яагаад хүүхдүүд байлдагч болсоор байна вэ?**

**Боломжит асуултууд:**

- ➤ Чиний бодлоор, яагаад зарим зэвсэгт бүлгүүд хүүхдүүдийг байлдагч болгон ашигладаг вэ?
- ➤ Яагаад хүүхэд залуучууд цэргийн бүлэгт нэгдэн ордог вэ?

[Жишээ хариултуудыг дор үзүүлэв]

**Яагаад цэргийн командлагчид тэднийг хүсдэг вэ:**

- ➤ Тэд асуулт асуудаггүй, зөвхөн тушаалыг л биелүүлдэг
- ➤ Тэднийг амархан хянаж болно
- ➤ Тэднийг золиосолж болно
- ➤ Цэргүүд хэрэгтэй
- ➤ Тэд аюулыг бүрэн дүүрэн ухаардаггүй

**Яагаад хүүхэд залуучууд элсч болзошгүй вэ:**

- ➤ Өс хонзон, уур хилэн
- ➤ Эцэг эх/гэр бүлийн дэмжлэг байхгүй байх
- ➤ Өөрөө өөрийгөө хамгаалах
- ➤ Ядуурал, амьд үлдэх арга хэрэгсэл
- ➤ Дайн тулалдаан, дайны баатрууд, золиослолд ач холбогдол өгдөг ёс заншил
- ➤ Үе тэнгийнхний дарамт

*Сайндурынгэхшалтгаанаар цэрэгт элсдэг хүүхдүүд бий. Гэвч, цэрэгт өөрийн хүслээр элсэнэ гэж байхгүй гэдгийг хүмүүс ойлгох ёстой гэж би боддог. Учир нь, үүнийг хийх болсон хүүхдүүдийн ихэнх нь шаардлагагаар буюу урьд нь хохирогч болж байсан, эсвэл, аюулгүй байдалдаа санаа зовсны улмаас сайн дураараа элсдэг. Хамгаалах гэр бүлгүй, харгалзагчгүй хүүхдүүд, өлсгөлөнгөөс үхнэ хэмээн айж буй хүмүүс юм уу, эрүүл мэндийн хангалтгүй халамж авч байгаа хүмүүс ихэвчлэн цэргийн үйл ажилагааг эрж хайдаг.*

*—Доктор Майк Веселлс*

**5. “Цэрэг” хүүхдүүдийг ашиглахын үр дагавар** (30 минут)
“Би буцаж очмооргүй байна” дүрс бичлэгийг танилцуулан үзүүлнэ үү.
Бичлэг үзүүлснийхээ дараа, сурагчдаас төрсөн бодол, сэтгэгдлийг нь асууна уу:

**Боломжит асуултууд:**

- ➤ Чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- ➤ Авраам хэдэн настай вэ? Тэр хэзээ цэрэг болсон бэ?
- ➤ Тэр хэрхэн цэрэг болсон бэ? (Хүүхдийн бодол, командлагчийн бодол)
- ➤ Комфортыг цэрэг болоход юу түлхэц болсон бэ? Залуу эмэгтэй цэргүүдэд ямар нэмэлт эрсдлүүд тулгарч болох вэ?
- ➤ Цэрэг хүүхдүүд насанд хүрсэн цэргүүдээс хэрхэн ялгаатай авирлах хандлагатай байдаг вэ?
- ➤ Энэхүү цэрэг хүүхдийн үзэж туулсан туршлага, түүний үр дагавар нь юу вэ?
- ➤ Хүүхдийг дайн болон зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын үр дагавар нь юу вэ? Хүүхдийн хувьд? Түүний гэр бүлийнхний хувьд? Нийгмийн хувьд?
- ➤ Дүрс бичлэгэн дээр, хэний нэр хүнд нь нөлөөнд автаж байна вэ? Хэрхэн?

**6. “Цэрэг” хүүхдүүдийг ашиглаж буй дэлхий дахины жишээ** (10 минут)

➤ Ямар орнуудад цэрэг хүүхдүүд байдаг гэж сонссон вэ?

"Цэрэг хүүхдүүдтэй орнууд — 1999 оны байдлаар" газрын зургийг сурагчдад танилцуулна уу.

➤ Энэхүү газрын зургаас чи ямар дүгнэлтэнд хүрсэн бэ?

**ГОЛ САНААНУУД**

◆ Зэвсэгт мөргөлдлөөний үед хүүхдүүдийг хамгаалах ёстой. Цэрэгт элсүүлэх насны доод хязгаарыг тогтоох нь хамгаалалтын нэг хэлбэр юм.

◆ ОУХЭЗ нь зэвсэгт хүчинд сайн дураар болон албадлагаар элсэх насыг 15 гэж тогтоосон. Олон Улсын Эрүүгийн Шүүхийн дүрмийн 8—р зүйлд зааснаар, 15—аас доош насны хүүхдүүдийг цэрэгт элсүүлэх нь дайны гэмт хэрэг юм.

◆ 2002 оны 2—р сараас Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Нэмэлт Протокол хүчинтэй болж эхэлсэн. Энэхүү протокол нь цэргийн албан татлага буюу элсүүлэх насны доод хязгаарыг 18 нас болгон, сайн дураар элсэх насыг 16 хүртэл нэмэгдүүлжээ.

# Нэмэлт дасгал

**Хүүхдүүд ба бүлэг дээрэмчид**

“Цэрэг хүүхдүүд” гэсэн нэр томъёо нь арми, партизан бүлгүүд буюу иргэний цэргүүд зэрэг зэвсэгт хүчинд элссэн хүүхдүүдийг хэлдэг. Энэхүү нэр томъёо нь гудамжны бүлэг дээрэмд холбогдсон хүүхэд залуучуудад хэрэглэгддэггүй юм.

Судалгаа ба хэлэлцүүлгийн сэдвүүд:

**Бүлэг дээрэмчдийн хүчирхийлэл ба хүүхдүүдийн оролцоо:**

➤ Гудамжны дээрэм нь чиний амьдарч буй газар нутагт хэр зэрэг том асуудал болж байна вэ?
➤ Хүүхдүүд зэвсэглэсэн дээрмийн ажиллагаанд оролцдог уу? Оролцож байгаа хүүхдүүд хэдэн настай байдаг вэ?

**Хүүхэд залуучуудыг элсүүлэх нь:**

➤ Яагаад хүүхдүүд бүлэглэсэн дээрэм, танхайралд оролцдог вэ?
➤ Тэд эдгээр дээрэмд сайн дураараа оролцдог уу, эсвэл тэднийг хүчээр татан оруулдаг юм болов уу?
➤ Хүүхдүүдийг зэвсэгт хүчинд болон бүлэглэсэн дээрэмд элсүүлэх явдлуудын хооронд чи ямар нэгэн ижил төстэй зүйлийг олж харж байна уу?

**Үр дагавар ба долгионт нөлөө** (богино ба урт хугацаанд):

➤ Бүлэг дээрэмчдийн гишүүн хүүхдүүдийн хувьд
➤ Шууд оролцоогүй бусад хүүхдүүдийн хувьд
➤ Олон нийт, нийгмийн хувьд

**Хүмүүнлэгийн үйлсүүд:**

➤ Бүлэг дээрэмчдийн хүчирхийллийн нөхцөл байдалтай холбоотой ямар нэгэн хүмүүнлэгийн үйлсүүдийн түүхэн жишээ мэдэх үү?

**Дэлхийн өнцөг булан бүрийн “цэрэг” хүүхдүүдийн тухай түүхэн жишээ**

Зургаан “цэрэг” хүүхдийн тухай түүхийг уншина уу:
➤ Зао Тун ба Мёо Виний түүх (2 хүү)
➤ “Сюзан” (1 охин)
➤ Ренука ба Малар (11 настай 2 охин)
➤ Самуэль (12 настай хүү)




Дээрх түүхүүдийн аль нэгийг цомхон бүлгээр хэлэлцээд, бичмэл тэмдэглэгээ, зураг болон жүжигчилсэн хэлбэрээр ангийнхандаа танилцуулна. Дүрд тоглох үедээ чухал хэсэгтээ “хөшөө” болон зогсч тухайн үйл явдлыг онцолно.

Түүний дараа, доорх асуудлуудаар хэлэлцэнэ:

➤ Энэ хүүхэд юу туулж өнгөрүүлсэн байна вэ?
➤ Хүүхдийн эргэн тойронд ямар нөлөө үзүүлнэ гэж бодож байна вэ?
Цэрэг болох нь эдгээр хүүхдүүдийн амьдрал болон ирээдүйд нь ямар үр нөлөө үзүүлсэн бэ?

## Нэмэлт дасгал

**Харилцаа холбоо:**

Байлдагчдын насны хамгийн доод хязгаар хэд байх ёстой талаарх 16 орны хүмүүсийн үзэл бодлыг тусгасан графикийг эргэн харна уу. Өөрийн оршин сууж буй нутаг орондоо дээрх асуултаар судалгаа явуулж, үр дүнгүүдийг нь график дээрх үзүүлтүүдтэй харьцуулна уу.

**Түүхэн судалгаа**

Хүүхэд нас гэж юу вэ? — Түүхийг судалсны үндсэн дээр, “хүүхэд” гэдэг тодорхойлолт цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгдсөн болохыг олж мэдээд, олсон зүйлсээ ангийнхандаа танилцуулна уу. Судалгааны асуултууд дараах байдалтай байж болно:




➤ Хүүхдүүдэд насанд хүрэгчдээс хэрхэн өөрөөр хандаж байсан бэ?
➤ Хэдэн настай хүнийг насанд хүрэгчид тооцож байсан бэ?
➤ Насанд хүрэгчийг тодорхойлох шалгуур үзүүлэлт нь юу байсан бэ?

ЭСВЭЛ

**Хүүхдийг цэрэгт элсүүлж байсан түүх** — Өнгөрсөн үед “цэрэг” хүүхдүүдийг хэрхэн ашигладаг байсан талаар судалгаа хийж, элсүүлэх арга барилыг нь судална уу.

➤ Ямар нийгмийн, соёлын, үзэл суртлын болон эдийн засгийн хүчин зүйлс үүрэг гүйцэтгэж байна вэ?

Олон нийтийн анхаарлыг татсан маш цөөн тохиолдолд, “цэрэг” хүүхдүүд заримдаа бэлэг тэмдэг болсон байдаг. Жишээ нь: Жоан Д'Арк, Библийн үеийн залуу Девид гэх мэт.

ЭСВЭЛ

**Зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүүхдүүд** — Өнгөрсөн ба/буюу одоо үеийн, эрх тэгш байдал, эрх чөлөө болон амьд үлдэхийн төлөөх тэмцэлд хүүхдүүдийн шууд ба шууд бус оролцооны жишээ явдлуудын талаар судална уу.

Хүүхдүүдийн оролцооны талаарх тохиолдлуудыг, 3 жишээ зураг, түүх, хэвлэл мэдээлэл болон интернетээс олж болно. Судалгаан дээрээ түшиглээд, олж мэдсэн зүйлсээ доорх байдлаар танилцуулж болно:




➤ Мэтгэлцээнээр
➤ Жүжигчилсэн хэлбэрээр
➤ Тэмцэлд оролцсон хүүхдийн буюу түүний эцэг эхийн бичсэн захиан хэлбэрээр

**Өнөө үеийн үйл явдлууд/Хүүхэд залуучуудын үйлдэл:**

Өнөөгийн “цэрэг” хүүхдүүдийн асуудлын талаар судалгаа хийнэ үү. Дэлхий дахинаа болон танай оронд, “цэрэг” хүүхдүүдийг ашиглахыг зогсоохын тулд ямар арга хэмжээ авч байгааг тодруулна уу. Жишээ нь, “цэрэг” хүүхдүүдийг халах, тэднийг нийгэмд нь эргүүлэн буцаах, боловсрол олгох оролдлогууд гэх мэт...

Энэхүү судалгааг эхлүүлэхэд тустай эх сурвалжууд нь ОУУЗХ, НҮБ—ын Хүүхдийн Сан, Хүний
Эрхийн Харуул зэрэг байгууллагуудын вебсайтууд болно.

“Цэрэг” хүүхдүүдийн талаарх асуудлуудыг, уран зургаар, зургаар, хөгжим болон жүжгээр илэрхийлнэ үү.

Хуулийг даган мөрдөхөд юу хийх хэрэгтэй байгааг судална.

# Байлдагчдын хувьд насны хамгийн доод хязгаар хэд байх ёстой вэ?




1998—1999 онд ОУУЗХ "Дайны тухай хүмүүсийн бодол" нэртэй судалгаа гаргасан ба энэхүү судалгаанд 16 орон хамрагдсан юм (Эдгээрийн 12—т нь саяхан зэвсэгт мөргөлдөөн болж өнгөрсөн байна). Дээрх график нь судалгаанд оролцогчдын үзэл бодлыг тусгасан байна.

# Би буцаж очмооргүй байна

*Өгүүлэгч: Өнөөдөр, дэлхийн өнцөг булан бүрт 300 000 гаруй хүүхэд ямар нэгэн байдлаар зэвсэгт мөргөлдөөнд оролцож байна. Хамгийн бага нь 7 настай болох эдгээр охид, хөвгүүд төрийн зэвсэгт хүчин болон бослого гаргагчдын сөрөг хүчин, партизаны армид насанд хүрэгчидтэй эн зэрэгцэн хүчин зүтгэж байна.*

**"Цэрэг хүүхэд" байсан Комфорт Казель**



Тэд миний ахыг, эмээг бас бяцхан дүүг минь алсан. Тийм ч болохоор би хийх ёсгүй зүйлээ хийх болсон, ийм зүйл танд ч тохиолдож болно шүү дээ.

Ямар ч хүн хэн нэгэн аавыг чинь, эсвэл ээжийг чинь хороосон гэвэл чи —"би өшөөгөө авахыг хүсч" байна, ээжийгээ эргүүлж авна, аварна гэсэн ч энэ нь аль хэдийнэ оройтсон. Би эмээдээ маш их хайртай байсан, миний эмээ намайг хайрлаж халамжилдаг байсан. Тийм ч болохоор би энэ замыг сонгосон юм. Гэхдээ би энэ бүхнийг хийе гэж хийгээгүй юм шүү. Би өөрийгөө чөлөөлмөөр байна, оюун санаагаа цэвэршүүлмээр байна, бас хөөрхөн хүүхдүүдтэй болмоор байна. Би хийх ёсгүй зүйлийнхээ эсрэг хэзээ ч зогсож байгаагүй. Үгүй ээ.

**Авраам**

Авраам: Миний нэр Гитлер алуурчин, гэхдээ жинхэнэ нэр маань Авраам.

Сурвалжлагч: Яагаад Гитлер алуурчин гэж?

Авраам: Энэ миний байлдааны нэр. Ойн ширэнгэд байхад тэд нар надад энэ нэрийг өгсөн юм.



Сурвалжлагч: Чамд энэ нэрийг хэн өгсөн бэ?

Авраам: Миний дарга.

Сурвалжлагч: Гитлер гэж хэн бэ?
Авраам: Би мэдэхгүй. Тэд миний аавыг алсан учраас би тийшээ явсан юм. Бас найзууд маань бүгд тийшээ явсан учраас, би найзуудтайгаа хамт явсан.

Сурвалжлагч: Чи аавыг чинь алсан хүнийг хайж олохыг хүссэн юм уу?
Авраам: Тийм ээ.

Сурвалжлагч: Чи түүнийг хэн хөнөөснийг мэддэг юм уу?

Авраам: Мэднэ.

Сурвалжлагч: Тэгээд чи юу хийсэн бэ?

Авраам: Би түүнийг харахад, тэр надтай байлдахаар ирсэн, тэгээд би түүнийг алсан. Дараа нь ойн ширэнгэд очиж тэдэнтэй нийлж, тэдний төлөө байлдсан. Тэд намайг юу хийснийг харсан учраас надад буу өгсөн.

Сурвалжлагч: Чи олон хүн алагдаж байхыг харсан уу?
Авраам: Тийм.

# Би буцаж очмооргүй байна

Авраам: Маш олон хүнийг харсан. Байлдаагүй, бослогонд оролцоогүй олон хүнийг бослого гаргагчдын босс нь алсан.

Сурвалжлагч: Чи өөрөө олон хүнийг хөнөөсөн үү?

Авраам: Тийм ээ.

Сурвалжлагч: Хэд?

Авраам: Хэдэн арван хүнийг.

Сурвалжлагч: Яаж?

Авраам: Тэд нар над руу дайрч намайг алахыг завдсан учраас.

Сурвалжлагч: Тэгээд чи тэднийг яаж хөнөөсөн бэ?

Авраам: Тэд зэвсэглэсэн байсан. Намайг урагшлахад тэд нар гарч ирэнгүүт, "Чоно" гал нээсэн, тэгээд бид тэднийг буудсан. Тэд миний аавыг алсан учраас би цэрэг болохыг хүссэн юм.

## Хурандаа Ээжийн Адис

Хурандаа Ээжийн Адис: Миний нэр Хурандаа Абу Бакар Камарра, гэхдээ намайг голдуу Хурандаа Ээжийн Адис гэж дууддаг.



Миний удирдлаганд 978 эрчүүд байдаг. Тэдний 176 нь "алуурчин Гитлер". Тэд 9, 10, 11 настай, хамгийн том нь 12 настай. Тэд гүнзгийрүүлсэн бүлэгт хамрагддаг, өөрөөр хэлбэл тэд дайны үед урд шугаманд байлддаг.

20–23 насны залуучуудад тодорхой үүрэг даалгавар өгөхөд тэд ихэвчлэн айж, биелүүлэхээс татгалздаг. Харин "алуурчин Гитлер" мэтийн бяцхан цэргүүд юунаас ч айдаггүй.

Би тэдэнд итгэдэг, тэд миний өгсөн ямар ч тушаалыг биелүүдэг учраас. Хэрвээ би, "За "алуурчин Гитлер" минь, тэр хүнийг бариад ир" гэвэл тэд баривчлаад л ирнэ. "Тэрийг гүйцэтгэ" гэвэл тэд хөнөөж л орхино. Тийм болохоор би тэдэнд юунаас ч илүү итгэдэг.

## Авраам

Авраам: Дайн дажингүй бүх зүйл сайхан байлаа. Гэвч дайн болж, аав, дүү маань алагдаж, ээж минь алга болсон. Тэгээд л би ганцаараа явсан юм.

Сурвалжлагч: Өмнө нь гэртээ юу хийдэг байсан бэ?

Авраам: Би гэрийнхэнтэй хамт амьдран сургуульд явдаг байсан.

Сурвалжлагч: Чи цаашид юу хийхийг хүсч байна вэ?

Авраам: Сургуульд явж ямар нэгэн албан хаагч болмоор байна.

Сурвалжлагч: Том болоод ямар хүн болмоор байна вэ?

Авраам: Би оффист ажилламаар байна.

# Би буцаж очмооргүй байна

Сурвалжлагч: Чи ахиад байлдмаар байна уу? Буцаж явахыг хүсч байна уу?

Авраам: Ахиж явна гэж үү? Үгүй, би яасан ч ахиж тийшээ явахгүй.

Сурвалжлагч: Гэвч чиний хурандаа Абу Бакар чамайг тийшээ буцан явж байлдах хэрэгтэй гэж хэлж байгаа шүү дээ.



Авраам: Тиймээ, би явах ёстой, гэвч би буцаж явахыг хүсэхгүй байна.

Сурвалжлагч: Гэвч чи тушаалыг нь биелүүлэхгүй бол чамайг ална шүү дээ.

Авраам: Тиймээ, гэхдээ би явахгүй байлаа гэхэд тэр намайг алж чадахгүй, яагаад гэвэл бид нар одоо ойн ширэнгэн дотор биш хүмүүсийн дунд байгаа болохоор тэр намайг албал хүмүүс түүнийг олоод баривчлах
болно.

Сурвалжлагч: Тэгээд чи юу хийе гэж бодож байна.

Авраам: Мэдэхгүй байна.

*Ямар нэгэн муу зүйлийг хийхэд цөөн хэдэн хүний үйлдэл хангалттай бус, хүмүүсийн ихэнх хувь нь ядаж ямар нэгэн үл хайхарсан байдал үзүүлэх хэрэгтэй. Харин үл хайхарсан байдалтай байна гэдэг бол бид бүхний амархан хийж чаддаг зүйл билээ.*

— Цветан Тодоров

# "Цэрэг" хүүхдүүдтэй орнууд – 2004 оны байдлаар

**Дэлхий даяар 300 000 гаруй цэрэг хүүхдүүд байдаг**




Эх сурвалж: **Олон Улсын Боловсролын Мэдээллийн Сүлжээ болон Цэрэг Хүүхдүүдийг Ашиглахыг Зогсоох Холбооны** эмхэтгэн хэвлэсэн мэдээлэл. Энэхүү мэдээлэл нь ОУУЗХ–ны албан ёсны байр суурийг тусгахгүй болно.

# Зургаан "цэрэг" хүүхэд

### Зао Тунгийн түүх

Би өөрийн хүсэлтээр биш хүчээр цэрэгт татагдсан. Нэгэн орой бид тосгондоо видеогоор тоглолт үзэж байтал армийн 3 түрүүч бидэн дээр ирсэн. Тэд бидэнд ямар нэгэн үнэмлэх, биеийн байцаалт байгаа эсэхийг асуугаад цэрэгт орохыг хүсч байгаа эсэхийг асуусан. Бид насанд хүрээгүй тул ямар нэгэн үнэмлэх байхгүй байгаа гэж хэлсэн. Харин нэг найз маань цэрэгт явахыг хүсч байна гэж хэлсэн.

Би цэрэгт явахыг хүсэхгүй байна гэдгээ хэлэн тэр орой гэртээ харьсан боловч, армийн татлагын алба дараагийн өдөр нь тосгонд ирж хоёр хүн шинээр элсэхийг шаардав. Цэргийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтэй бол мөнгө төл, төлж чадахгүй бол заавал цэрэгт татагдах болно гэж сүрдүүлсэн. Манай гэрийнхэн мөнгө төлж чадаагүй тул бидний 19 хүүхэд цэрэгт татагдан армийн сургалтын төв рүү явсан юм даа.

### Мёо Виний түүх

Бидэнд мансууруулах бодис өгснийхөө дараа тэд биднийг дайны талбар луу явахыг тушаасан. Бидэнд ямар төрлийн мансууруулах бодис болон согтууруулах ундаа өгснийг бид мэдээгүй ч, маш их ядарч, ам цангаж, өлссөн байсан учраас уусан юм.

Бид бүхэл бүтэн 2 өдөр халуун наранд эцэж цуцатлаа алхсан. Дайны талбарт ямар ч сүүдэртэй газар байгаагүй, модод шатаж, их бууны бөмбөг энд тэндгүй дэлбэрч байлаа. Би маш их айж бас цангаж байсан бөгөөд зарим маань хэт их ядарснаасаа болж ухаан алдан унаж байлаа. Гэвч офицерууд ардаас биднийг зодож байсан тул, бид урагшаа явахаас өөр аргагүй байсан юм. Энэ үеэр нэг маань алагдсан.

### Сюзаны түүх (жинхэнэ нэр нь биш)

Бидний 139 охиныг нэгэн шөнө сургуулиас маань үл таних хүмүүс авч явсан ба долоо хоногийн дараа намайг нэгэн хүнд тушаан өгсөн юм. Тэр хүн 30 настай байсан бөгөөд надтай хамт өөр нэгэн охиныг бас түүнд өгсөн. Би хуаранд очих үедээ тэмбүү өвчинтэй болсон байлаа.

Нэг хүү оргохыг оролдсон боловч баригдсан юм. Биднийг авч явсан хүмүүс тэр хүүг саваа модоор зодон алахыг бидэнд тушаасан. Би түүнийг алахаас татгалзсан боловч тэд алахгүй бол намайг буудна гэсэн, тэр ч байтугай буугаа над руу тулгасан тул би тэдний тушаасныг хийхээс өөр аргагүй байдалд орсон. Тэд биднийг тэр хүүгийн цусыг гаран дээрээ нялахыг шаардаж байсан ба үүнийг хийснээрээ үхлээс айхгүй болно, ингэснээрээ зугтаахгүй гэж хэлж байсан юм. Бусдын амь насыг хороосон минь сэтгэлийн шарх болон үлдсэн юм. Миний гарт амь насаа алдсан тэр хөөрхий жаал хүүгийн тухай би байнга зүүдэлдэг. Тэр зүүдэнд минь ирж, намайг ямар ч буруугүй байхад минь яах гэж хөнөөсөн юм бэ гэж хэлдэг, тэгээд би тэсэлгүй уйлдаг.

# Зургаан "цэрэг" хүүхэд

## Ренукагийн түүх

Ботслого гаргагчид сар бүр манай сургууль дээр ирж ярьдаг байсан. Тэд биднийг өөрсдийн эгнээндээ орохыг ятган ард түмнээ төрийн цэргийн армиас чөлөөлөх нь та нарын үүрэг гэж хэлдэг байсан. Бид нар маш ядуу зүдүү бөгөөд ихэвчлэн хоолгүй хонодог байсан юм л даа. Би 11 настай байхдаа нэг өдөр маш их өлсөөд аав ээждээ хэлэлгүйгээр гэрээсээ яваад босслого гаргагчдын байгаа газар очсон юм. Тэд надад хоол өгсөн, гэхдээ би дайны талбарт тулалдахаас нааш дахиж гэрийнхнийгээ хараагүй.

2 жилийн дараа, би байлдаанд явахын тулд дан эмэгтэйчүүдээс бүрдсэн байлдах ангид хуваарилагдсан юм. Бид байлдсан хэдий ч төрийн армийн цэргүүдэд дийлэгдэж, манай байлдах ангийн цэргүүдээс надаас бусад нь бүгд амь үрэгдсэн. Би баригдахгүйн тулд цианидийн үрлээ залгих ёстой байсан боловч би үхэхийг хүсээгүй юм.

## Маларийн түүх

Намайг 3 настай байхад аав минь зүрхний өвчнөөр нас барж, 6 настай байхад ээж минь өвдөөд эмнэлгээс буцаж ирээгүй. Тийм ч учраас би авга ахтайгаа хамт амьдрах болсон юм. 8 настай байхад минь, бослого гаргагчдын бүлгээс нэгэн эмэгтэй ирж намайг сургуульд оруулна, харж хандана хэмээн надаас өөртэй нь хамт явахыг хүссэн юм. Бид их ядуу амьдардаг байсан болохоор би тэр эмэгтэйтэй явбал арай дээр болох юм шиг санагдаад байлаа. Дээр нь би эрх чөлөөний төлөө тэмцэлд ямар нэгэн байдлаар өөрийн хувь нэмрээ оруулахыг хүссэн юм.

Би 12 настай байхдаа дайнд сайн дураараа явсан юм. Би эх орноо хамгаалахыг хүсч байлаа.

Өнгөрсөн сард, засгийн газрын цэргүүд манай хоргодох байр луу тэслэгч бөмбөг хаясан юм. Энэхүү бөмбөгдөлтийн үед надтай хамт байсан 10 охин бүгд амь насаа алдсан. Одоо би хэдийгээр шоронд байгаа ч гэсэн шоронгоос гарах юм бол дахин байлдах болно. Яагаад гэвэл тэдгээр цэргүүд манайхан руу довтлон хөнөөсөн учраас.

## Самуэлийн түүх

Христийн шашинт иргэн–цэргүүдийн бүлэглэлийн удирдагчын гэрт хэсэг залуу байлдагчид цугларан тэдэн дээр айлчилсан сэтгүүлчдэд өөрсдийн тулалдсан байлдааны талаар ярьж, гараар хийсэн буу, тэслэх бөмбөгүүдээ үзүүлж гайхуулдаг байлаа.

Самуэль хүү 12 настай. Үгээ байн байн таслан, нэлээн цухалдангуй өнгөөр ярихдаа тэрээр олон байлдаан, тулаадаанд орж байсан тухайгаа ярьж байв. "Ээж минь явахыг хориглосон байсан ч гэсэн би байлдахаар явах байсан" гэж байв. Самуэль бол "Агас" буюу орчуулбал, "Бурханы хайртай сүмийн хөвгүүд" хэмээн нэрлэгддэг залуу байлдагчдаас бүрдсэн бүлгийн хамгийн залуу нь билээ. Тэдний үүрэг даалгавар бол лалын шашинт гэр бүлүүд болон сүмд гал тавин устгах, хүхэр, гар бууны дарь болон металь хэсгүүдийг ашиглан тэсрэх бөмбөг дэлбэлэх явдал юм. Насанд хүрсэн байлдагчид тэднийг хурдан шаламгай бөгөөд эр зоригтой хэмээн сайшаадаг байв.

Гадаадын сэтгүүлчид Самуэлиэс юуны төлөө байлдаж байгаа талаар нь асуухад, хажууд нь байсан нэгэн хүн "Христийн шашинтнуудыг хамгаалахын тулд" хэмээн хариулсан бөгөөд залуу хөвгүүд ч түүний үгийг давтан хэлжээ. Түүнээс арай ахмад найзууд нь илүү чөлөөтэй байсан бол Самуэлийн байгаа байдал нэг л хавчигдмал, сул, үлбэгэр байсан юм. Чөлөөт цагаараа юу хийдэг вэ гэсэн асуултанд тэрээр "Тэсрэх бөмбөг хийдэг" хэмээн хариулсан юм.

# Зэвсэгт мөргөлдөөнд дайчлагдсан хүүхдүүд

## Совето оюутнуудын бослого

Женевийн Конвенцид нэгдсэн улс орнууд нь зэвсэгт мөргөлдөөний үед баривчлагдсан, түрэмгийлэн эзлэгдсэн энгийн иргэд болон өвчилж шархадсан, олзлогдсон, хөлөг онгоцны сүйрэлд өртсөн буюу бусад шалтгаанаар дайны талбараас гарсан хүмүүсийг оролцуулан дайн байлдаанд идэвхтэй оролцохгүй байгаа хүмүүст, тэднийг арьсны өнгө, шашин шүтлэг, итгэл үнэмшил, хүйс, гарал үүсэл, хөрөнгийн байдал, аливаа бусад төстэй шалгуураар ялгаварлан гадуурхахгүйгээр хандах үүргийг хүлээлгэсэн билээ.

Апартейд буюу арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахыг Женевийн Конвенцийн Нэмэлт Нэгдүгээр Протоколд олон улсын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн доторх дайны гэмт хэрэг хэмээн авч үздэг. Нэгдүгээр Нэмэлт Протокол нь апартейд болон "арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл дээр үндэслэсэн, хувь хүний нэр хүндийг нь гутаах зэрэг бусад хүнлэг бус үйлдлүүдийг" ноцтой зөрчил (зөвхөн олон улсын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний үед боловч) хэмээн жагсаасан байдаг.



# Зэвсэгт мөргөлдөөнд дайчлагдсан хүүхдүүд

## Вест Банк болон Газар дахь зэвсэгт бослого



Рафад Палестин хүүхдүүд Израил цэргүүд рүү чулуу шидэж байгаа нь, Өмнөд Газын зурвас, 2000 оны 12-р сарын 17

# Зэвсэгт мөргөлдөөнд дайчлагдсан хүүхдүүд

## Дэлхийн 2–р дайны үеийн эсэргүүцэгч байлдагчид



Дэлхийн 2—р Дайны үед, Варшавын Еврейчүүдийн хороолол дахь Еврейчүүдийн төлөө тэмцэж байсан эсэргүүцэгч байлдагчид

# Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина

Энэхүү судалгаанд, сурагчид үл ялгаварлах зэвсгүүд хэрэглэснээр гарах үр дагавар болон гарз хохирол учруулах шинэ замуудыг бий болгогч зэр зэвсгийн үйлдвэрлэлийн тасралтгүй хөгжлөөс үүдэн гарч буй олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд тулгарч буй бэрхшээлүүдийг гүнзгийрүүлэн авч үзэх болно. Үр дагаварын хэлбэрүүдийн талаар учирлан тайлбарлах, газрын минад өртөгсдийн баримтуудыг унших, үзэж танилцах болон шинээр олон улсын хууль бий болгохоор олон нийтийн аян хэрхэн зохиогдож байгаа талаар судлах зэрэг үйл ажиллагаа хамрагдана.



**Зорилго:**

- Ялгах чадваргүй бөгөөд хэрэгцээгүй шаналал учруулдаг тодорхой төрлийн зэвсгүүдийг хориглодгийн учрыг ойлгох
- Газрын минийг хэрэглэхийн үр дагаврыг ("долгионт нөлөө") илрүүлж чаддаг болох
- Олон нийтийн үзэл бодол, хөдөлгөөн нь хүмүүнлэгийн эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой байдгийг ойлгох



**Ашиглах материалууд:**

- Дүрс бичлэг/Тайлбар: Газрын мина хүний амь нас хөнөөсөөр байна.
- Баримт хуудас: Хүний эсрэг газрын минийн тухай
- Газрын зураг: Газрын минад өртсөн улс орнууд.
- Мери Вэйрхамтай хийсэн ярилцлага.
- Мэдээллийн хураангуй: Он цаг: 2000 оны 9 дүгээр сар.

**Багш нарт:**

- Оттавагийн Гэрээ, 1 дүгээр зүйл.

> 1. *Аливаа зэвсэгт мөргөлдөөний үед ашиглах дайны арга хэрэгслийг сонгож авах мөргөлдөөнд оролцогч талуудын эрх хязгаартай.*
> 2. *Үлэмж хэмжээний гэмтэл, зовиур учруулах дайлдааны арга хэрэгсэл, зэр зэвсэг, сум, бодис хэрэглэхийг хориглоно.*
>
> – Зүйл 35. 1977 оны нэмэлт Протокол

**Бэлтгэл ажил:**

*Аргазүйн удирдамж* — "Дилеммаг ашиглах нь" хэмээх багш нарт зориулсан 4—р хэсэг дэх долгионт нөлөө ба үр дагавруудыг хэрхэн таниулах тухай материалуудыг харна.

**Хугацаа:**

45—60 минутын 2 хичээл.

**1. Тодорхой зэвсгүүдийг хориглох үндэслэл** (15 минут)

Сурагчдад энэ асуултыг оршил судалгаанаас дахин сануулна:

➤ "Зэвсэгт мөргөлдөөнд зарим зэвсгийг хориглох ёстой юу? Ямар зэвсгүүдийг? Яагаад?"

**Боломжит асуултууд:**

➤ Үл ялгаварлах гэж юу гэсэн үг вэ? Байг онилсон гэдэг нь ямар утгатай вэ?

➤ "Байгаа онохгүй байх" ба "үл ялгаварлах" хоёрын ялгаа нь юу вэ?

➤ Ялгах чадваргүй ямар зэвсгүүд байдаг вэ?

( Жишээ нь: хүний эсрэг газрын мина, химийн зэвсэг...)

# Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина

Дараах зүйлсийн хоорондын ялгааг хэлэлцэнэ үү:

- Зэвсэгт мөргөлдөөний үед хуулиар зөвшөөрөгдсөн ба зөвшөөрөгдөөгүй байнууд
- Байг онохгүй байх
- Тухайн зэвсэг онилсон байг онох эсэхийг хянах боломжтой байх
- Тухайн зэвсэг эцэстээ хэнийг/юуг онох талаар ямар ч хяналтгүй байх



**2. Газрын мина ба түүний үр дагаварууд** ( 30 минут )
"Газрын мина хүний амь нас хөнөөсөөр байна" дүрс бичлэг нь хүний эсрэг газрын минийн нөлөөгөөр бий болсон эвдрэл сүйрлийг харуулах ба сурагчдад уг минийг хувь хүмүүс, гэр бүлийнхэн, орон нутаг, улс орны хэмжээнд хэрэглэснээс үүдэн гарах хор уршгийг олж илрүүлэх боломж олгоно.




Дүрс бичлэг үзсэний дараа сурагчдад санал бодлоо илэрхийлэх цаг гаргаж өгөх хэрэгтэй.
Тэгээд тэдний юу мэдэж авсныг нь судална:

- Газрын мина яаж ажилладаг вэ?
- Газрын минад өртөгсөд яаж шархдан гэмтсэн бэ?
- Одоо та газрын минийн талаар юу мэдэхийг хүсч байна вэ?

Уг бичлэгийг хоёр дахь удаа үзүүлэх бөгөөд энэ удаад сурагчдын анхаарлыг хувь хүмүүст нөлөөлж буй үргэлжилсэн хор уршгууд дээр төвлөрүүлнэ: биеийн/эрүүл мэндийн, боловсролын, нийгмийн, эдийн засгийн, сэтгэлзүйн.

| Дүн шинжилгээний түвшин | Үр дагаврын хэлбэр | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Эрүүл мэндийн | Боловс–ролын | Нийг–мийн | Эдийн засгийн | Сэтгэл–зүйн |
| Хувь хүн | | | | | |
| Гэр бүл | | | | | |
| Орон нийт | | | | | |
| Улс | | | | | |
| Дэлхий | | | | | |

Хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн өргөжүүлж, долгионт үр дагавруудын талаар ярилцаж болно.

### Боломжит асуултууд:

- Аливаа үр дагавар бусдыгаа төрүүлж байгааг харж байна уу?
- Өөр хэнд нөлөөлж байна вэ? Ямар арга замаар? Ямар үр дагавар гарч болох вэ?
  (Жишээ нь: Өртөгсдийн бие махбодын гэмтэл (гар хөлгүй буюу сохор болох гэх мэт) гэр бүлийн болон орон нутгийн эдийн засгийн байдалд хэрхэн нөлөөлж байна? Нийгмийн байдалд? Сэтгэлзүйн сайн сайхан байдалд?
- Долгионт үр дагавруудыг гаргаж ирэх явцад цаашдаа дэлхийн хэмжээнд ямар үр дагавруудыг харж байна вэ?

*1980 оны Конвенцийн 4 дүгээр протокол батлагдахын өмнөхөн их хэмжээгээр үйлдвэрлэгдэх гэж байсан ердийн ангийн буу шиг жижиг хэмжээтэй нүд сохлогч лазерийн зэвсгүүд нь маш түргэн хугацаанд эдгэршгүй сохролтыг үүсгэх чадвартай лазерийн туяаг олон мянган километр газар цацдаг ажээ. Уг протокол нь байнгын сохролтыг үүсгэгч лазерийн зэвсгүүдийн хэрэглээ болон тээвэрлэлтийг тусгайлан хориглодог. Энэ нь байлдааны зарим жигшмээр муухай арга хэрэгслийг дайны талбарт хэрэглэгдэхээс нь өмнө хориглосон түүхэн дэх 2 дахь явдал юм. (Дэлбэрэгч сумнууд нь сайжруулагдсаныхаа дараахан 1868 онд хориглогдсон байсан билээ.)*

–ОУУЗХ, 1998 он

**3. Дэлхий дахины дүр зураг** (20 минут)

Асуудлын цар хүрээг авч үзэхийн тулд “Хүний эсрэг газрын мина”—ын тухай баримт хуудсыг болон “Газрын минад өртсөн улс орнууд” —ыг харуулсан газрын зургийг ашиглана.

**Боломжит асуултууд:**

➤ “Дэлхий дахины дүр зураг” нь дүрс бичлэгээс олж харсан хувь хүмүүсийн нөлөөлөлд юуг нэмж байна вэ?
➤ Газрын минийн хэрэглээнд хэн хариуцлага хүлээх вэ? (үйлдвэрлэгчид, засгийн газар, цэргүүд...)
➤ Газрын минатай холбогдуулан юу хийж болох вэ? (Жишээлбэл: мина цэвэрлэгээ, олон улсын гэрээний батламж, аюулын тухай мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн боловсролын хөтөлбөрүүд, нэрвэгдэгсдийг нөхөн сэргээх эмчилгээ... )

**4. Олон улсын эрх зүйг бий болгоход юу шаардлагатай вэ?** (25 минут)

Брейнсторминг хийнэ:

➤ Төрийн албан хаагч бус хүмүүс ОУХЭЗ—г бэхжүүлэхийн тулд юу хийж чадах вэ?

Санамж:

➤ Төрийн бус байгууллагууд (ТББ) ба тэдний гүйцэтгэх үүрэг
➤ Хэвлэл мэдээлэл болон нийтийн соёл бусдын санаа бодолд хэрхэн нөлөөлж байна

“Мери Вэйрхамтай хийсэн ярилцлага” болон мэдээллийн хураангуйг хэлэлцүүлэхээр ашиглана.

➤ Жирийн хүмүүс эрх мэдэл бүхий хүмүүст дуу хоолойгоо хэрхэн сонсгож чадсан бэ?
➤ Тэд ямар саад бэрхшээлүүдийг даван туулсан бэ?
➤ Оттавагийн Гэрээ ямар нөлөө үзүүлсэн бэ?
➤ Газрын минийг хориглох аянд оролцсон хэн нэгнийг мэдэх үү? Тэр юу хийсэн бэ?
➤ Та үүнтэй ижил төстэй асуудлыг бий болгох магадлал бүхий өөр зэвсэг мэдэх үү?

**ГОЛ САНААНУУД**

◆ Газрын мина, биологийн ба химийн зэвсэг нь байлдагчид болон энгийн иргэдийг үл ялгаварлах бөгөөд хэрэгцээгүй зовлон шаналал авчирдаг учраас эдгээрийг хориглодог.
◆ Газрын минад өртөгсөд амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирохоод зогсоохгүй хувь хүмүүс, тэдний гэр бүл, ойр орчныхон, улмаар улс орон болон олон улсын нийгэмлэг нийгэм, эдийн засгийн хор уршгийг амсдаг.
◆ Газрын минийг үйлдвэрлэх, хэрэглэхийг хориглох тухай 1997 оны Оттавагийн гэрээ нь олон нийтийг дайчилсны үр дүнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хувьсан хөгжиж болдгийн нэг жишээ юм.

# Нэмэлт дасгал

**Математик**

Газрын минийн нөлөөний цар хүрээг судлахын өмнө "Хүний эсрэг газрын мина"—ыг унших даалгавар өгнө. Түүнийгээ дагалдуулан математикийн бодлого (сурагчдынхаа чадварт тохируулан) зохиож бодуулна.

**Жишээ даалгавар**

Унших материал дахь тоон үзүүлэлтийг ашиглан эдгээр математикийн бодлогуудыг бодож яаж тооцоолсноо тайлбарлана.

1. Дунджаар жилд хичнээн хүн газрын минад өртөж байна вэ?
2. Дэлхийн хэмжээнд суурилагдсан байгаа минуудыг эргүүлэн гаргах ажилд ойролцоогоор хэдий хэр мөнгө зарцуулагдах вэ?
3. Нэг мина худалдан авах үнэ ба нэг минийг эргүүлэн гаргах зардал хоёрын харьцаа хэд вэ?
4. Газрын минад өртөн эрхтэн дутуу болосгдоос эмчилгээний зардлаа төлөхийн тулд хичнээн нь өрөнд орж байна вэ?
5. 6 настай хүүхдийг 18 нас хүртэл нь хиймэл эрхтэнтэй байлгахын тулд хэдий хэр зардал шаардагдах вэ?
6. Дээрх 6 настай хүүхдийн эцэг эх нь 4 ам бүл тэжээхийн тулд сард 40$ олдог бол тэр айлын жилийн орлогын хэдэн хувь нь зөвхөн уг хүүхдийн хиймэл эрхтэнд зарцуулагдах вэ?
7. Өөрсдөө математикийн бодлого зохиож бод.

**Түүх**

Түүхийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдуулан хэрэглэгдэж буй зэвсгийн мөн чанарыг судална уу:

➤ Шинжлэх ухаан, технологийн ямар дэвшлүүд тэдгээрийг бий болгосон бэ?
➤ Байлдагчид зэвсэг хэрэглэж байгаагаа юу гэж үздэг вэ?
➤ Тэдгээрийг хэрэглэхэд ямар горьдлого, дүрэм буюу заншил нөлөөлж байна вэ?

**Зохион бичлэг**

Дүрс бичлэгэнд гарч буй хүмүүсээс (Ванна, Амелия) хэн нэгнийг эсвэл өөр хэн нэгэн хүнийг сонгоод түүнийгээ гол баатраа болгосон товч өгүүлэл зохионо. Өгүүлэлдээ уг хүн минад өртсөний дараа хэрхэн зэрэмдэг болсон байгааг дүрслэн гаргах хэрэгтэй.

**Шинжлэх ухаан**

Байлдааны арга, хэрэгсэлд гарч буй технологийн өөрчлөлтын гүйцэтгэх үүргийг судална.

➤ Үл ялгаварлах зэвсэг болох явдалд юу нөлөөлдөг вэ?

## Нэмэлт дасгал

**Орон нутгийн байгууллагууд**

Мина цэвэрлэгээ, газрын минийн талаар мэдлэг дээшлүүлэх хөтөлбөр буюу минад өртөгсдөд эрүүл мэндийн болон сэтгэлзүйн тусламж үзүүлэх зэрэг үйл ажиллагаатай явуулдаг өөрсдийн оршин суугаа газар, улсад байдаг ямар нэгэн байгууллагыг тодорхойлно. Тэдний ажлын талаар олж мэдээд бусаддаа мэдээлэл хийнэ үү.

**Минад нэрвэгдсэн тосгонд зориулсан үйл ажиллагааны төлөвлөгөө зохиох**

➤ Минад өртөгсдөд туслах, дахин мина дэлбэрэх аюулаас сэргийлэхийн тулд энэ тосгонд юу хийх хэрэгтэй вэ?

Уг тосгон дайны үед тэргүүн шугаман дээр байлаа. Тосгоныг эзэлсэн цэргүүд босогчдыг эргэн ирж хоол хүнсээ залгуулахаас нь сэрэмжлэн тосгоны эргэн тойрны ойд мина тавьжээ. Одоо дайн дууссан боловч уг минууд газарт булаастай хэвээр үлджээ. Тосгоны оршин суугчид ойд мина байгаа гэдгийг мэддэг боловч дулаацах, хоол унд хийхийн тулд түлээний мод зөөсөөр байна. Тэд түлээ түүхээр ой руу орох боловч эцэстээ амь үрэгдэж эсвэл шархдаж байна. Тосгонд мөн цэргүүд явахдаа минуудыг цэвэрлэлгүй орхисон хуучин хянан шалгах цэгүүд ч бий. Тэдгээрт “Аюултай! Мина бий!” гэсэн тэмдэг байдаг ч хүүхдүүд тэнд тоглосоор л байна.

Бүлэгт хуваагдаад эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болох төлөвлөгөө зохионо. Уг төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, мина цэвэрлэгээ, минын талаар мэдлэг дээшлүүлэх боловсрол (сургуульд, тосгоны хүмүүстэй хамтран, гэх мэт.) болон нөхөн сэргээх хөтөлбөр зэргийг тусгаж болно. Энэ бүхэн нь хэнд зориулагдан хийгдэж байна?

Өөрийн хийсэн төлөвлөгөөг бүлгийн бусад гишүүдэд танилцуулна. Нөхцөл байдлыг харуулахын тулд тосгоны газрын зургийг зохиож хийнэ.

# Оттавагийн Гэрээ
# 1997 оны 9 дүгээр сарын 18

## ХҮНИЙ ЭСРЭГ МИНИЙН ХЭРЭГЛЭЭ, ХАДГАЛАЛТ, НӨӨЦЛӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛТ БА ДАМЖУУЛАЛТ, УСТГАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

### *1 дүгээр зүйл*

### *Ерөнхий журам*

1. Оролцогч Улс бүр ямар ч нөхцөлд дараах үйлдлүүдийг хориглоно:

а) хүний эсрэг газрын мина хэрэглэх;
б) хүний эсрэг газрын минийг шууд буюу шууд бусаар сайжруулах, үйлдвэрлэх, нөгөө талаар худалдаж авах, хуримтлуулах, хадгалах буюу бусдад дамжуулах;
в) энэхүү Конвенцийн Оролцогч Улсад хориглогдсон аливаа үйл ажиллагаанд хэн нэгнийг ямар нэгэн байдлаар туслах, дэмжих буюу урамшуулах.

2. Оролцогч Улс бүр энэхүү Конвенцийн заасны дагуу бүх төрлийн хүний эсрэг газрын минийг устгах буюу тэдгээрийн устгалыг бататгах үүрэг хүлээнэ.

# Газрын мина хүний амь нас хөнөөсөөр байна

## Ванна

(Эмнэлэг дээр)

Зочин: Энэ бүхэн яаж болж өнгөрсөн бэ?
Ванна: Би тахиануудаа хооллож байсан.
Зочин: Чи тэдэнд сайн хандаад, хангалттай хоол өгөөд байвал тэд чамд мөнгө олж өгдөг, тийм үү?
Ванна: Тиймээ.

(гэр лүүгээ явах замд)

Тосгоныхон:
Миний бяцхан охин, буцаад иржээ. Зоригтой байгаарай, чи эргээд бусад хүүхдүүд шиг явдаг болноо. Инээгээрэй, эргэн тойрноо хар, хүүхэд минь.

Би түүний хөлийг харлаа. Шинээр арьс төлжиж байна. Шинэ арьс нь илүү дээр харагдаж байгаа ч түүнд сорви үлдэнэ. Шархны ул мөрийг эмээр арилгаж болох юм. Арьс нь аяндаа төлжихөөр байв.

(усан дотор хүүхдүүдтэй хамт)

Ваннад тусалж буй охин: Гутлаа аваарай, бохир хэвээрээ л байна. Одоо өмсөж болноо.

## Өгүүлэгч:

Камбужид хүн амын 230 хүн тутмын нэг нь буюу 35000 гаруй хүн эрхтэн дутуу болсон байна. Олон хүн шаардлагатай эмнэлгийн тусламж авахаасаа өмнө шархнаасаа болон цус алдалтаас болж нас бардаг байна.

Дэлхийн хэмжээнд хичнээн мина газарт байгааг болон хичнээн хүнийг авч одсон талаар хэн ч тодорхой хэлж мэдэхгүй. Одоогоор цэвэрлэгдээгүй байгаа 100 сая гаруй мина бий гэсэн тооцоо байна. Энэ асуудал нь Латин Америкаас Ази хүртэлх бүх тивийг хамарч байгаа билээ.

Газрын минаас үүдэлтэй нийтлэг гэмтлүүд нь гар, хөлгүй болох юм. Олон хүн харах чадвараа алдах буюу дахин хэзээ ч жирийн амьдралаар амьдарч чадахааргүй болж байна.

Минад өртөгсөд ихэнхдээ хуучин аж амьдралаа дахин олж авч чаддаггүй бөгөөд нөхөн сэргээх эмчилгээний нийгмийн болон санхүүгийн өртөг нь голдуу ард түмэн давж гарахааргүй өндөр байдаг.

Газрын минийн хор уршиг хэзээ ч дуусдаггүй. 25 настайдаа хөлгүй болсон хүнд 65 нас хүртэл нь 10 хиймэл хөл шаардлагатай болно. Хүүхдэд 6 сар тутамд шинэ хөл шаардагдах болно.

Газрын мина нь технологийг буруу хэрэглэсний үр дүн юм. Ядуу буурай орны хувьд үүний өртөг нь хүн ардын болон эдийн засгийн хувьд дааж давшгүй хүнд байдаг.

Сомалийн мөргөлдөөн нь цэргийн салбарт хэрэглэх боломжтой газрын минийн олон янзын технологи байгааг харуулж байна. Үүний ихэнх нь баруунд үйлдвэрлэгджээ. [мина руу заав] Египет, Белги, Англи, Пакистан, Орос, Америк ба Чехословак.

# Газрын мина хүний амь нас хөнөөсөөр байна

Энд байгаа хоёр зүйл нь хүүхдүүдэд тулгарч буй гол асуудлыг бий болгож байна. Яг үнэндээ тэдгээр нь мянга мянгаараа газарт булагдсан байгаа.

Метал илрүүлэгчид нь орчин үеийн хуванцар минуудыг мэдэрч чадахгүй учраас мина цэвэрлэгчид газрыг ямх ямхаар самнах хэрэгтэй юм. Үүний тулд теннисний талбайн хэмжээний газар 3 хүнтэй баг сар хүртэлх хугацаагаар ажиллах шаардлагатай болно.

Зарим минийг доллар хүрэхгүй үнээр худалдан авч болох боловч зөвхөн нэг минийг цэвэрлэхийн тулд мянган доллар зарцуулах шаардлагатай болдог. Бүхэл бүтэн улсыг самнахын тулд хангалттай тооны хүнийг сургаж бэлтгэх нь удаан хугацаа, асар их хэмжээний хөрөнгө мөнгө шаарддаг.

Уг асуудлыг хэрхэн шийдэх тухайд мина экспортлох явдлыг зогсоохоос эхлээд байлдааны гэрээний болон дотоодын мөргөлдөөн дэх тэдгээрийн хэрэглээг удирдах олон улсын хэмжүүрийг улам нарийвчлах зэрэг саналууд тавигдаж байна.

## Амелия
(тосгонд)

12 настай Амелия охин хараагүй бөгөөд тахир дутуу болжээ. Тэр хүний эсрэг газрын минад өртсөн олон зуун хүний нэг юм. Түүний үе тэнгийн бусад хүүхдийн адил, Амелия хоолоо бэлдэхээр түлээ түүдэг байжээ. Гэвч тэнд дайсан хүлээгээд хэвтэж байлаа; Нэг өдөр секунд ч хүрэхгүй хугацаанд түүний амьдрал орвонгоороо эргэсэн юм.

(Нөхөөн сэргээх эмнэлэг дээр)

Энэ бол Амелия дахиж алхахад болон өөрийн эрэмдэг байдалтайгаа зохицон амьдрахад суралцаж буй газар юм.

# Хүний эсрэг газрын мина гэж юу вэ?

52 орны 100 гаруй компани хэдэн зуун төрлийн хүний эсрэг газрын мина үйлдвэрлэж байна. Тэдний гол зорилго бол цэргүүдийг зэрэмдэглэх явдал юм. Нэг мина дээр гишгэхэд л гинжин нөлөө идэвхжинэ гэсэн үг.

Ерөнхийдөө 2 төрлийн хүнийн эсрэг газрын мина байна, тэсрэгч мина ба бутрагч мина юм. Тэсрэгч минууд нь голдуу 10см—ээс бага диаметртэй байх бөгөөд хөлийн гишгэлтийн жингээр цэнэглэгдэнэ. Бутрагч минууд нь маш өргөн хэмжээний газар жижиг хэсгүүдийг цацдаг байна. Зарим нь 25 метрийн "хөнөөх бүс"—тэй байдаг бөгөөд хүрэх юм бол 200м радиустай хол газарт ч гэсэн хор хөнөөл учруулах чадвартай. Тэдгээр нь нэг эсвэл 2 гарыг бугуйгаар нь таслах бөгөөд цээж болон нүүр нүдийг ч гэмтээдэг.

### Хүний эсрэг газрын минийн асуудал юунд хүргэж болох вэ?

Өнөөдөр дэлхийн хэмжээнд сая сая мина золиослогдогчоо хүлээгээд хэвтэж байна. Хичнээн ширхэг байгааг тооцоолоход бэрхшээлтэй. Минуудыг суурилуулж байх үеийн цөөн тооны үнэн зөв мэдээлэл хадгалагдаж үлдсэн байна. Афганистанд жишээлбэл, сая сая минууд онгоц болон ачааны машинуудаар хаа сайгүй тараан суурилагдсан байна.

### Нийгэм болон эдийн засгийн өртөг нь юу вэ?

НҮБ—ын үзэж байгаагаар зөвхөн нэг миныг буцааж гаргахад 300—1000$ шаардагдана. (Нэг минийг худалдаж авах өртөг нь 3—30$) Дунджаар 7 хоног тутамд 500 хүн газрын минад өртөж байна. Олон Улсын Улаан Загалмайн Хороо нь минад өртөгсдийн 2/3—с илүү нь шаардлагатай эмнэлэгийн үйлчилгээний төлбөрийг төлөхийн тулд өрөнд орж байгааг тооцоолон гаргажээ. Ихэнхи тахир дутуу бологсдын хувьд хиймэл эрхтний өртөг нь тэдний төлж чадах хэмжээнээс илүү байдаг. Жишээлбэл: Хүүхдийн хиймэл эрхтэн 6 сар тутамд, том хүнийх 3—5 жилд солигдож байх хэрэгтэй. 10 настайдаа гэмтсэн хүүхдэд 50 нас хүртлээ хамгийн багадаа 25 хиймэл эрхтэн шаардагдана. Хиймэл эрхтэн ойролцоогоор нэг нь 125$—ын үнэтэй байдаг бол энэ тоо нь нийтдээ 3,125$ болно. Нэг хүнд ногдох дундаж орлого нь сард 15—20$ байдаг улс орнуудын хувьд эрхтэн дутуу болгсод суга таяг авах л боломж байна. Эдийн засгийн өөр сонголтгүй байдалд зарим хүмүүс минажүүлсэн талбайг ашиглах эсвэл минажүүлсэн ойгоос түлээ түүх зэрэг эрсдэлтэй тулгарч байна. Боснид жишээлбэл минад өртөгсөдийн 30% нь минатай болохыг мэдэж байсан газруудад гэмтэл авсан байна.

### Хүний эсрэг газрын минатай холбоотой өөр бусад зардлууд бий юу?

Газрын минуудаас үүсэлтэй ослууд нь биемахбодын гэмтэлээс гадна сэтгэл зүйн ноцтой үр дагаваруудыг бий болгож байна. Энэ нь хүүхдүүд болон өсвөр насныхны хувьд үнэхээр хүнд бөгөөд том хүмүүст ч гэсэн биеийн бэрхшээлээ давж туулахад нь ч хэцүү байдаг. Мөн гэр бүлийн хувьд ч ноцтой үр дагаварууд гардаг бөгөөд учир нь газрын минийн осол нь хүүхдүүдийг сургуулиас нь холдуулж, гэр бүл болгсдын тоог бууруулж, том хүмүүсийг амьдрах мөнгө олоход нь саад болдог. Газрын минууд нь дэлхийн хамгийн ядуу буурай олон орны утга учир бүхий хөгжилд нь асар том саад тотгор болдог; зам, талбай, гүүр, бүхэл бүтэн орон нутаг мөргөлдөөний уршгаар минажүүлэгдсэн байна. Мөн газрын минууд нь тодорхой зорилгоор энгийн ард иргэдийн эсрэг алан хядах ажиллагааны зэвсэг болж хэрэглэгдэх нь ихэсч байна. Үр дүнд нь, газрын мина нь дүрвэгсдийн асуудал, үр өгөөжтэй тариан талбайг устгах, тээвэр харилцаанд саад болох зэрэг асуудлуудыг бий болгож байна. Доройтсон эдийн засгийн хязгаарлагдмал нөөц баялаг нь мина цэвэрлэгээний хүчин чармайлт болон өртөгчдийн халамжинд хэрэглэгдэж байна. Олон газар, орон нутгуудад сэргээн засварлах, эв найрамдлыг бий болгох болон удаан хугацааны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нь бүгд хэрэгтэй байгаа боловч хэрэгжих боломжгүй байна.

### Минатай тэмцэх үйл ажиллагаа

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд мина цэвэрлэх, минийн талаар мэдлэг эзэмшүүлэх болон өртөгсдөд туслах хөтөлбөрүүдийг НҮБ, Олон Улсын Улаан Загалмайн Хороо болон олон тооны засгийн газрууд хэрэгжүүлж байна.

Эх сурвалж: Аюулгүй — Зурвас вэб хуудас — http://www.mines.gc.ca ба
*"Айдасгүй алхах нь"*, Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн газар, 1998 он

# Газрын минад өртсөн улс орнууд



# Мери Вейрхэмтэй хийсэн ярилцлага

## Хүний эрхийн манаанд

*Юу таныг газрын минад сонирхолтой болгоход хүргэсэн бэ?*

Шинэ Зеландад 1980—аад онд бид номхон далайн бүсэд хийгдэж буй цөмийн туршилтууд болон цөмийн зэвсэг ачсан усан онгоцуудын талаар ихэд санаа зовнидог байлаа. Би энэ бүх үйл явдалтай хамт өссөн. Их сургуульд ороод Атом Судлаачдын сэтгүүлд гарсан газрын минийн тухай нэгэн нийтлэлийг уншаад ямар гайхалтай зэвсэг болохыг нь мэдсэн. Тиймээс би энэ талаар судалж үзсэн боловч юу ч олж мэдэж чадаагүй. Энэ бол бусад зэвсгүүдийг нийлүүлээд үзсэн ч илүү олон хүнийг хөнөөсөн зэвсэг байсан бөгөөд үүний талаар ямар арга хэмжээ авч, чухам юу хийж байгааг мэдмээр байлаа. Тэгээд би энэ талын эрдмийн ажил хийж эхэлсэн боловч асуудлын хувьд зөвхөн төвийг сахисан ажиглагч байх нь хэцүү юм байна гэдгийг ойлгосон.

*Тэр үед та хэдэн настай байсан бэ?*

Би тэр үед улс төр судлаач мэргэжлээр их сургуулиа дөнгөж төгсч байлаа. Би газрын минийн асуудлыг судлахаар тэтгэлэг хүссэн бөгөөд үүний зэрэгцээ манай төр засаг энэ асуудлыг зэвсэггүй болгох талаас нь улс төр, олон улсын болон дипломат түвшинд юу хийж байгааг мэдэхийг хүссэн юм.
Би эхний тэтгэлэгийн мөнгөө тэр үед энэ асуудлыг судалж байсан хүмүүстэй уулзаж ярилцах ажилд зарцуулсан бөгөөд эхний хүн маань Жоди Виллиам болон Газрын минийг хориглох олон улсын аяны ажлыг үүсгэн байгуулагч зарим хүмүүс байсан юм. Би мөн Женев дэх Улаан Загалмайн Нийгэмлэг болон ЮНИСЕФ—ийн хүмүүстэй уулзсан. Би хоосон цүнхтэй явсан хэдий ч цүнх дүүрэн судалгааны ажилтай минь холбоотой олон янзын ном, материал, тайлан мэдээлэлтэй буцаж ирсэн юм.

*Энэ нь таны хувьд кампанит ажил, дур хүслээс илүү эрдмийн ажил байсан уу?*

Тиймээ, би үүнийг төвийг сахисан байрнаас харахыг хүсч байсан. Тиймээс ч Шинэ Зеландад болсон газрын минийг хориглох тухай олон нийтийн кампанит ажлын уулзалт дээр би арын суудалд дэвтэрээ бариад сууж байсан. Тэд намайг хараад, "Та уулзалтанд зориулж хэдэн минут гаргаач" гэсэн. Тиймээс би тэдэнтэй хэдэн минут ярилцсан. Дараагийн уулзалтан дээр тэд "Бидний хэвлэлийн илтгэлийг бичиж өгөхгүй юу?" гэж асуусан. Тэгээд би тэдний хэвлэлийн илтгэлийг бичсэн бөгөөд парламентийн гишүүдэд бичиж байснаа, төлөөлөгч болсноо, улмаар Женевт болох ердийн зэвсгийн конвенцийн гэрээний уулзалтанд оролцохоор сонгогдсоноо ч мэдээгүй байсан юм. (...) Тэгээд би энэхүү өмгөөлөн хамгаалах үүрэг зайлшгүй зүйл гэдгийг ойлгосон бөгөөд тэр үед би энэ зэвсгийг үл ялгаварладаг, хүнлэг бус, жигшмээр зэвсэг гэдэгт итгэж, зөвхөн эрдмийн ажил хийлгүйгээр өөр илүү том өөрчлөлт хийх хэрэгтэй гэсэн өөрийн шийдвэрээ гаргасан байлаа.

*Газрын минийн эсрэг хийгддэг кампанит ажил юугаараа ялгаатай вэ?*

Газрын минийн эсрэг хийгддэг кампанит ажлын гол онцлог нь гэвэл уг ажлыг "мэргэжилтэнүүд" хийдэггүйд байсан. Бидний мэргэжилтэнүүд бол уг зэвсэгт өртөн зэрэмдэг болсон бөгөөд энэ түүхийг бусдад хэлэхийн тулд амьдарсаар ирсэн хүмүүс, мөн үүнийг судалсан над шиг хүмүүс, өдөр бүр зэвсэг цэвэрлэхээр гэрээсээ гардаг тэр л хүмүүс юм. Энэ кампанит ажил нь жирийн бус зүйлсийг бий болгодог жирийн хүмүүст хамааралтай бөгөөд энэ асуудалд үнэхээр санаа тавин ямар нэг юм хийхийг хүсдэг хүмүүст зориулагдаагүй байсан бол хаана ч болохгүй байх байлаа.

*Энэ ажлыг яагаад дипломатуудад даатгаад орхиогүй юм бэ?*

Дипломатууд бусад үндэстнүүдтэй хэлэлцээр хийдэг. Тэд эх орондоо байгаа удирдагчдынхаа зааврын дагуу ажилладаг. Хэрэв тэд ард түмний шахалтаар ямар нэгэн зүйл хийх болвол төрийн манлайлагч нь зөвхөн тэдэнд заавар өгөх үүрэгтэй. Тиймээс,

# Мери Вейрхэмтэй хийсэн ярилцлага

## Хүний эрхийн манаанд

зөвхөн өөрсдийнх нь ард түмний үзэл бодлын шаардлага байгаа цагт л дипломатуудыг хөдөлгөх боломжтой юм.

Кампанит ажлууд нь олон тооны өргөдөл гомдол цуглуулах, түүнийг олон нийтийн хэлбэрээр танилцуулахад чиглэгдсэн орон нутгийн иргэдийн хөдөлмөр зүтгэлийг агуулж байгаа юм. Тэд улс төрчид, парламентийн гишүүдийг минад өртсөн газруудад аваачдаг бөгөөд мөн хэвлэлийхэнтэй хамтран ажилладаг. Хэн ч эдгээр зүйлийг зохион байгуулж чадна.

*Гэвч, ямар нэг зүйлд санаа тавьдаг энгийн нэг хүн юу хийх тухайгаа яаж мэдэх вэ?*

Тэгвэл, Шинэ Зеландад юу болсныг харъя л даа. Олон улсын хуралд явсан нэг хүн буцаж ирээд уулзалт хийсэн. Энэ бол таны хийж чадах зүйлийн нэг, зүгээр л уулзалтын тухай зарлаад хэн ирэхийг хар. Өөрийн орон нутгийн сургууль, их сургууль ч юм уу, аль эсвэл өөрийн хотдоо уулзалт зохиож, энэ асуудалтай холбогдож болох өөр өөр байгууллагуудыг оролцуул. Шинэ Зеландад эдгээр нь Нэгдсэн Үндэстний Холбоо, зарим нэг Ахмад дайчдын Холбоо, Ногоон Энхтайван зэрэг зарим байгаль орчны бүлгүүд, Хүүхдийн Төлөө Төв зэрэг хүмүүнлэгийн байгууллагууд болон Улаан Загалмайн Нийгэмлэг зэрэг байлаа. Тэгээд нэг уулзах газар товлоод тэднийг цуглуул. Хүмүүсийг нэг өрөөнд цуглуулаад асуудалд үр өгөөжтэйгээр хандаад ирэхэд та үүнийг хэрхэн хэрэгжүүлэх стратегиа гаргаж чадах болно. Энэ нь олон янзын түвшинд болдог. Тийм учраас ширээний эргэн тойронд өөр өөр төлөөллийг байлцуулах нь чухал бөгөөд тэд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрсдийн мэдлэг чадвараа нэмэрлэх болно. Тэр үед төр засгийн байгууллагууд ба төрийн бус байгууллагуудын дэлхийн даяар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудыг мэдээлж байсан Газрын Минийг Хориглох тухай олон улсын кампанит ажлыг зохицуулагч Жоди Виллиамын ажил бидэнд их тус нэмэр болсон юм. Энэ хөдөлгөөнд оролцсон хүмүүс бусад хүмүүс юу хийж байгаа талаар их зүйлийг мэдэж, олон шинэ санаа, эрч хүчийг олж авсан бөгөөд хөдөлгөөнөөс гадна өөрсдөө бие даан ямар нэг зүйлийг хийж чадахын хажуугаар хамтарсан үйл ажиллагаануудыг ч зохион байгуулж чадаж байлаа.

*Төрийн бус байгууллагууд бусад улс орнуудтай хэрхэн хамтарч ажилласан бэ?*

Кампанит ажлын эхэнд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн тодорхой хүрээг хамрах нь чухал байсан юм. Бидний уриалж байгаа зүйл маш энгийн бөгөөд тодорхой байх нь чухал байлаа. Энэ нь хүний эсрэг минуудыг хэрэглэх, үйлдвэрлэх, бусдад дамжуулах болон нөөцлөхийг бүхэлд нь хориглох явдал байсан юм. Тэгээд улс орон бүрийн тодорхой хүмүүст засгийн газартайгаа хамтран юу хийхээ шийдэх асуудлыг өөрсдөд нь үлдээдэг байлаа. Тэр бүгдэд дээрээс ямар нэг заавар өгдөггүй байсан. Гэвч Жоди маш олон оронд очиж ажилласан юм. Гаднаас хэн нэгэн ирж ажиллахад олон нийт болон төр засгийн анхаарлыг илүү ихээр татдаг байлаа. Тэр очсон улсынхаа кампанит ажлыг зохион байгуулагчид болон төрийн бус байгууллагуудтай уулзалт хийхээс гадна мөн тухайн улсын ерөнхий сайд, гадаад хэргийн сайд, парламентийн спикер, батлан хамгаалахын сайд зэрэг албаны хүмүүстэй уулздаг байв. Тэрээр "энэ бол олон улсын ард түмний хамтран хэрэгжүүлж буй зүйл бөгөөд та бүхний тус дэмжлэгийг бид үнэхээр энэ үйл ажиллагаанд зориулагдахыг хүсэж байна" гэж хэлдэг байв.

*Энэхүү шинэ төрлийн дипломат хүрээнд (нөлөө багатай улс орнууд болон төрийн бус байгууллагуудыг хамарсан) олон улсын хүмүүнлэгийн эрх зүй цаашид хөгжих боломжтой юу?*

Та бүхэн үүнийг олон янзаар хэрэглэгдэж буйг аль хэдийнээ харж байгаа байх (жишээ нь: уг кампанит ажлаар 18 нас хүрээгүй хүүхдийг цэрэгт татах явдлыг зогсоосон). Газрын минийн кампанит ажлын хувьд бусад асуудлуудтай шууд холбох боломжгүй олон хүчин зүйлс байгаа боловч олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ирээдүйг бий болгох явцад бидний мэдэж авсан зарим сургамжуудыг хүмүүс сайн мэдэж байгаа.

# Мери Вейрхэмтэй хийсэн ярилцлага

## Хүний эрхийн манаанд

*Тэгвэл энэ шинэ дипломат харилцаа ямар үр дүнг бий болгосон бэ?*

1997 оны 12 дугаар сард Канад улсын Оттава хотод гэрээнд гарын үсэг зурахаар 122 орны төлөөлөгчид ирсэн байлаа. Дараа нь энэ тоо 139 болж нэмэгдсэн бөгөөд энэ нь уг олон улсын гэрээнд оролцолгүй үлдэж байгаа өөр 50 улс байгааг харуулж байгаа юм. Гэвч тэдгээр 139 орны дотор маш олон тооны мина үйлдвэрлэгчид байсан болон өмнө нь мина хэрэглэгчид байсан улсууд багтаж байгаа бөгөөд одоогоор бид уг гэрээнд нэгдэгч улсуудыг газрын мина хэрэглэж байгаа талаар дахин ямар нэг баталгаа олж чадаагүй байна.

Улс орнуудыг хүний эсрэг минийн нөөцөө устгахыг уриалсан их өөдрөг 4 жилийн хугацаат төлөвлөгөө байна. Ойролцоогоор 105 улсад 250 сая орчим хүний эсрэг мина нөөцлөгдсөн байгаа. Энэ устгал нь хийхэд маш их тоо бөгөөд олон тооны мина нь гэрээнд оролцоогүй улс орнуудад байрлаж байна (Хятадад 110 сая, Орост 60—70 сая, Америкт 12 сая). Гэвч гэрээнд нэгдсэн улсуудад байгаа минууд устгагдсаар байгаа билээ.
Эх сурвалж: хувь хүний ярилцлага, 2000 оны 10—р сар

**Газрын минийг хориглох тухай олон улсын кампанит ажлыг (ICBL) Зохион байгуулсан Төрийн бус байгууллагууд (ТББ) 1992**

Саад бэрхшээл Интернейшнл
Хүний Эрхийн Манаа
Медико Интернейшнл
Минийн Зөвлөгөө өгөх Бүлэг
Хүний эрхийн төлөө Эмч нар
Вьетнамын Ахмад дайчдын Америк Сан

**Удирдах Зөвлөл одоогоор өргөжсөн байдал**

Газрын минийг хориглох тухай Афганы кампанит ажил
Тусламжийн Холбоо
Газрын минийг хориглох тухай Камбожийн кампанит ажил
Газрын минийг хориглох тухай Колумбын кампанит ажил
Газрын минийг хориглох тухай Германы Санаачлага
Саад бэрхшээл Интернейшнл
Хүний Эрхийн Манаа
Газрын минийн эсрэг Кенийн Эвсэл
Газрын минээс амьд үлдэгсдийн сүлжээ
Дэлхийн Лютеран Холбоо
Канадын Мина эсрэг Үйл Ажиллагаа
Норвегийн Ард түмний Тусламж
Газрын минийг хориглох тухай Өмнөд Африкийн кампанит ажил

# Он цаг: 2000 оны 9 дүгээр сар

**Газрын минийг хориглох тухай дэлхийн нийтийн гэрээний амжилт үр дүнгээ өгч эхлэв.**

Газрын минийн хэрэглээг хориглосон дэлхий нийтийн гэрээ нь эхний жил хагасын дотор мэдэгдэхүйц амжилттай байсан боловч өнөөдөр минийн эсрэг зогсдог байгууллага (...) онцгой асуудалтай газрууд байсаар байгааг олон нийтэд мэдээлж байна. (...)

Энэ тайланг үйл ажиллагаагаараа 1997 онд Нобелийн Энх тайвны Шагналыг хүртсэн Газрын Минийг хориглох тухай олон улсын кампанит ажлыг хэрэгжүүлэгчид гаргасан юм. Уг мэдээллийг Газрын минийг хориглох тухай гэрээг баталж гарын үсэг зурсан улс орнуудын Женевт болох уулзалтын үеэр дараагийн долоо хоногт танилцуулах юм.

1121 хуудас бүхий уг тайлан зэвсгийн худалдаа бараг бүхэлдээ зогссон бөгөөд энэ жил буюу өнгөрсөн жилд газрын мина тээвэрлэлт хийгдээгүй болохыг мэдэгджээ.

Мэдээнд, өнгөрсөн жилийн 3 дугаар сарын 1—нд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сая мина устгасныг тооцвол өнөөг хүртэл нийтдээ 22 сая мина устгагдаад байгааг илтгэжээ. Мөн 105 оронд 250 сая орчим мина нөөцлөгдсөөр байгааг тооцоолон гаргажээ.(...)
Нас баргасад болон гэмтэгсдийн тоог "бүдүүн тойм, бүрэн бус" аргаар тооцоолон гаргасан боловч эдгээр хүмүүсийн тоо нь Афганистан, Босни, Камбож болон Мозамбик улсуудад илэрхий буурсан байгааг харуулжээ.

Гэсэн хэдий ч 71 оронд газрын минад хүмүүс өртсөөр байгаа бөгөөд эдгээр орны талаас илүү нь энхийг сахиулагч орнууд байгааг цохон тэмдэглэсэн байна.
Гэрээ хэрэгжиж эхэлснээс хойш 11 төр засаг, бослого гаргагчдын 30 бүлэглэлийн гаргасан 20 мөргөлдөөнд зэвсэг хэрэглэгдсэн байх магадлалтай байгааг уг тайлан өгүүлжээ.

# Хэвлэлийн хуудас

Зорилго: Сурагчдад олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн талаар мэдсэн зүйлээ хэвлэлүүд дэх дайны холбогдолтой мэдээллүүдтэй уялдуулан холбож ойлгоход нь туслах

1. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйтэй ямар нэгэн байдлаар холбогдсон мэдээллүүдийг олж авах
2. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой 3—5 үгийг олж, доогуур нь зурах буюу дугуйлах (жишээ нь: энгийн иргэд, газрын мина, дүрвэгсэд, цэрэг хүүхдүүд...)
3. Үг бүрийг *Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь* хөтөлбөрийн явцад ойлгож мэдсэн зүйлстэйгээ уялдуулж хар
4. Энэ нийтлэлд гарч буй нөхцөл байдалд хүний нэр хүнд хэрхэн эрсдэлд орж байна вэ?

- ➤ Хэний нэр хүнд эрсдэлд орж байна вэ?
- ➤ Ямар хууль дүрэм, хэрвээ байдаг бол, ийм байдалд үйлчлэх вэ?

**Үнэлгээний аргууд:**

- Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:

"*Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь*" хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх боломжийг олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

- Сурагчдын ажлын хавтас:

Хоёрдугаар бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

- Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

2–р бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20–30 минут), эсвэл 2–3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно.

➤ **ОУХЭЗ гэж юу вэ, яагаад үүнийг сайжруулсан бэ?**

➤ **ОУХЭЗ ба хүний эрхийн хууль хоорондын харилцаа нь юу вэ?**

2. Товч хариулах асуултууд: Хоёр асуулт сонгоно.

➤ Энгийн иргэд ОУХЭЗ–ээр хамгаалагддаг 3 арга замыг тодорхойлно уу.

➤ Хүүхэд цэрэг болсноор гарах 4 үр дагаврыг нэрлэнэ үү.

➤ Яагаад үл ялгаварлах зэвсгийг хууль бус болгох шаардлагатай вэ? Тийм зэвсгүүдийн жишээ 2–ыг гаргана уу.

Сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

**Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:**

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- үзэл санаагаа бататгах тодорхой бодитой жишээ гаргах
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

- Авалон Төсөл: хууль, түүх, дипломатийн материалууд
  http://www.yale.edu./lawweb/avalon/avalon.htm

1899 оны Гаг–д болсон Олон улсын Энхтайвны Чуулган болон Нюрнбергийн Шүүхийн материалууд багтсан.

- ОУУЗХ–ны ОУХЭЗ–н гэрээ ба протоколууд
  http://www.icrc.org/ihl
  ОУХЭЗ–н ихэнхи баримт материалын цуглуулга болон Женевийн Конвенц, Лиеберийн хууль, эдгээр гэрээ протоколуудад гарын үсэг зурсан улс орнуудын жагсаалт. Англи Франц, Испани хэл дээр.

- Олон Улсын Хүний Эрхийн баримт бичгүүд (НҮБ)
  http://www.unhchr.ch/html/intlist.htm

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Зэвсэгт Мөргөлдөөний ба Гэнэтийн Аюул Ослын үед Эмэгтэйчүүд Хүүхдүүдийг Хамгаалах тухай Тунхаглал, ОУХЭЗ, дайны хоригдол, дүрвэгсдэд холбогдох конвенцууд, Англи, Франц, Испани хэл дээр.

**ОУХЭЗ мэдээнд**

Интернет хайлт хийхдээ "ОУХЭЗ" болон "Хүмүүнлэгийн эрх зүй" нэр томёъоноос илүү "Дайны гэмт хэргүүд" нэр томъёог хэрэглэхийг бид санал болгож байна.

- Амнести Интернейшнл номын сан – сэдэвчилсэн индекс
  http://web.amnesty.org/web/contents.nsf/pagesbycountrytitle/gbrthemeshome
  "Хүмүүнлэгийн эсрэг гэмт хэргүүд" хэсэг нь ОУХЭЗ–н сүүлийн үеийн мэдээг агуулна.

- Yahoo
  http://dailynews.yahoo.com/full_coverage/
  Yahoo нь Reuter's агентлагийн мэдээг оруулдаг бөгөөд бүс нутгийн болон үндэсний мэдээллийн агентлагуудтай холбоотой ажилладаг.

- Улс орнуудын хэвлэл мэдээллийн Yahoo лавлах.
  http://dir.yahoo.com/news_and_media/by_region/countries/

- Бүс нутгийн хэвлэл мэдээллийн Yahoo сан
  http://dir.yahoo.com/news_and_media/by_region/regions/

- Online хэвлэлүүд
  http://www.newspaper.com

**2С. Цэрэг хүүхдүүд**

- ОУУЗХ–ны ОУХЭЗ–н гэрээ ба протоколуудын мэдээллийн сан
  http://www.icrc.org/ihl

- Олон Улсын Хүний Эрхийн баримт бичгүүд (НҮБ)
  http://www.unhchr.ch/html/intlist.htm

ОУХЭЗ–н болон хүний эрхийн тухай олон улсын гэрээ протоколууд, цэрэг хүүхдүүдтэй холбоотой материалуудыг багтаасан ойлгоход хялбар 2 цуглуулга.

Англи, Франц, Испани хэл дээр.

- Цэрэг Хүүхдүүдийг Ашиглахыг Таслан Зогсоох Эвсэл.
  http://www.child–soldiers.org

- Амнести Интернейшнл номын сан – сэдэвчилсэн индекс
  http://web.amnesty.org/web/contents.nsf/pagesbycountrytitle/gbrthemeshome
  Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хэсэг нь цэрэг хүүхдүүдийн тухай сүүлийн үеийн мэдээг агуулна.

- Хүний Эрхийн Манаа: Цэрэг хүүхдүүд
  http://www.hrw.org/hrw/campaigns/crp/index.htm
  Энэ асуудлын талаарх сүүлийн үеийн мэдээллийн баялаг сан

- Хүүхдийн Төлөө Төв. Шведийн цэрэг хүүхдүүдийн тухай баримт бичгийн сан.
  http://www.rb.se/childwardatabase/
  Англи, Швед хэл дээр

- Хүүхдүүд болон зэвсэгт мөргөлдөөний асуудал хариуцсан ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөл: Цэрэг хүүхдүүд (НҮБ)
  http://www.un.org/special–rep/children–armed–conflict/soldiers.htm

**2D. Газрын мина**

- ОУУЗХ
  http://www.gva.icrc.org/eng/mines

- Газрын минийг хориглох тухай олон улсын кампанит ажил.
  http://www.icbl.org
  Араб, Англи, Герман, Итал, Япон, Португали, Орос, Испани хэл дээр.

- Нуугдсан алуурчид: Дэлхий даяарх газрын минийн хямрал (АНУ–н Төрийн Департамент)
  http://www.state.gov/www/global/arms/rpt_9809_demine_toc.html

- Газрын минийг хянах нь
  http://www.icbl.org/lm/
  Англи, Франц, Испани хэл дээр.

- НҮБ–н минийн эсрэг үйл ажиллагааны хэсэг.
  http://www.un.org/Depts/dpko/mine/index.html

- Газрын минийг хориглох тухай кампанит ажил (Хүний эрхийн манаа)
  http://www.hrw.org/campaigns/mines/1999/index.htm
  Энэ асуудлын талаарх сүүлийн үеийн мэдээллийн баялаг сан



# 3 Бүлэг

# Хуулийн хэрэгжилт

*(6 Хичээл)*

*Ихэвчлэн ямар дүрэм зөрчигддөг? Яагаад?*

*Байлдагчид ямар дилемматай тулгардаг вэ?*

*Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг хүндэтгэн биелүүлж байгааг хянах хариуцлагыг хэн хүлээх вэ?*

## СУДАЛГААНУУД:


Судалгаа 3A: Зөрчлийг тодорхойлох нь (1 хичээл). . . 135

Судалгаа 3B: Байлдагчийн байр сууринаас харахад (2 хичээл). . . 149

Судалгаа 3C: Хэн хариуцлага хүлээх вэ? (1 хичээл). . . 153

Хэргийн судалгаа: Ми Лай - Юу нь буруудсан? Юу нь зөвдсөн? (2 хичээл). . . 186


## ОЙЛГОЛТУУД:

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн зөрчлүүд
Энгийн иргэн/байлдагчийн ялгаа
Гинжин нөлөө

**Нийт бүлгүүдэд:**
Хүний нэр хүнд
Хүмүүнлэг зан үйлд учрах саад тотгорууд
Дилемма
Үр дагаврууд
Олон талт төлөв байдал

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Төлөвшил
Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх
Бүлгээр ажиллах
Дилеммад анализ хийх
Үр дагавруудыг тодорхойлох

# Судалгаа 3 А. Зөрчлийг тодорхойлох нь

2 дугаар бүлэгт сурагчид Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн (ОУХЭЗ) үндсэн дүрмүүдийн талаар судалсан билээ. Тэд дүрэм журам яагаад шаардлагатай болон тэдгээр нь зөрчигдсөн тохиолдолд хохирогчдод учрах үр дагавруудын талаар тодорхой мэдлэг олж авсан. 3 дугаар бүлэг нь сурагчдад хүмүүс яагаад дүрэм зөрчиж байгаа талаар дайнд оролцож буй хүмүүсийн тухай бодит мэдээллийг ашиглан тайлбарлах болно. Сурагчид үр дагавруудын гинжин нөлөө гэсэн ухагдахууныг хуулийн нэг зөрчил хэрхэн бусдадаа нөлөөлж байгааг тодорхойлохдоо хэрэглэнэ. Төгсгөлд нь, зөрчлүүдийг хязгаарлах арга замуудыг үнэлж, брейнсторминг хийнэ.

**Зорилго:**

- ОУХЭЗ—н зарим зөрчлүүдийг таньж мэдэх чадвартай байх
- "Гинжин нөлөө" бүхий үр дагаврын тухай ойлголтыг хэрэглэн зөрчил зөрчлөө төрүүлдгийг жишээгээр танин мэдэх

**Ашиглах материалууд:**

- Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой — 2
- Хүснэгт: Ямар дүрэм зөрчигдсөн бэ?
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**Хугацаа:**
45—60 минутын нэг хичээл

**Алхам 1. Ямар дүрэм зөрчигдсөн бэ? Яагаад?** (сурагчид хос хосоороо) (20 минут)




- Сурагчдад "Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой — 2" — оос 3, 4 мэдэгдлийг даалгавар болгоно. Тэд 2 дугаар бүлгээс "Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн дүрмүүд юу вэ?" гэсэн асуултад хариулах чадвартай болсон байна.




Сурагчид хүснэгт дээр үндсэн дүрэм болон зөрчигдсөн гэж үзэж буй дүрмүүдийг олж тогтоон, зөрчлүүдийг тодорхойлж бичнэ.

(Жишээ нь: мэдэгдэл 11— д дурдагдсан үйлдэл нь 3.4, 3.11, ба 4.1 дүрмүүдийг зөрчиж байна. )




Сурагчдаар яагаад тодорхой дүрэм журам зөрчигдөж байгаа талаар хүмүүсийн тайлбарласан учир шалтгааныг ойлгохын тулд мэдэгдлүүдийг судлуулах хэрэгтэй.

Ижил төстэй шалтгаануудыг нэгтгэн бүлэг болгоод, тэдгээрийн нийтлэг чанаруудыг судална.
[Боломжит учир шалтгаануудад дараах орно: аюулгүй байдал, цэргийн давуу тал, яагаад гэвэл эсрэг тал үүнийг хэрэглэсэн, өс хонзон, цөхрөл буюу бусад төрлийн сэтгэл хөдлөл, нөөц баялагийн хомсдол, учир нь тэд энэ хуулийн тухай мэдээгүй байсан, гэх мэт]

**Алхам. 2 Зөрчил зөрчлөө төрүүлэх нь** (15 минут)

Сурагчдад нэг зөрчил ба түүний үр дагавар болон дагалдах өөр нэг зөрчлийн холбоог харуулсан мэдэгдэл баримт олохыг хүснэ.

[Жишээ нь: нэг тал буугаа эмнэлгийн дээвэр дээр байрлуулбал, үр дүнд нь нөгөө тал эмнэлэг рүү гал нээх болно; эсвэл нэг тал олзны хүмүүсийг хороовол нөгөө тал үүний хариуд мөн л олзны хүмүүсийг хороох болно; эсвэл олзлогчийн олзны хүнтэй харьцсан хэрцгий байдал нь олзны хүнийг амиа алдахад хүргэж, улмаар өөр бусад олзлогчид түүний тушаалыг дагах зэргээр нөлөөлж болно.]

# Судалгаа 3 А. Зөрчлийг тодорхойлох нь

Хэд хэдэн жишээн дээр ажилласны дараа сурагчдад өөрсдийн тодорхойлсон зөрчлүүд нь хэрхэн өөр бусад зөрчлүүдийг бий болгож байгаа талаар хоорондоо харилцан ярилцах цаг гаргаж өгөх хэрэгтэй. Хүснэгтийн доод талд байгаа хоосон зайг санал бодлоо тэмдэглэхэд ашиглаж болно.

Сурагчид хос хосоороо зөрчил зөрчлөө хэрхэн төрүүлж байгаа талаар ойлгосон зүйлээ баталгаажуулахын тулд зөрчлүүдээс үүдэлтэй үр дагавруудын өөрсдийн гаргасан гинжин нөлөөг тайлбарлаж болно. ( "Үр дагавруудын гинжин нөлөө" нэмэлт дасгалыг харна уу.)

**Алхам 3. Бид ирээдүйд гарч болзошгүй зөрчлүүдийг хязгаарлаж чадах уу?** (10 минут)

Бүлгээрээ нэг нэг зөрчил сонгож авна. Тэгээд тэр зөрчлийг хязгаарлах арга замуудыг хоорондоо хэлэлцэнэ.

Сурагчдад санал бодлоо жагсааж бичсэний дараа тэдгээрт үнэлгээ өгөх боломж олгоно уу.

- Гаргасан санал буюу хязгаарлах арга зам бүр нь ямар үр дагавруудыг бий болгох боломжтой байна вэ? Эргээд эдгээр үр дагаврууд нь юунд хүргэж болох вэ?
- Гаргасан саналуудыг ихэнх улс үндэстэн хүлээн зөвшөөрнө гэж бодож байна уу? Яагаад зөвшөөрөх вэ? Яагаад зөвшөөрөхгүй вэ? Тэдгээрийг хэрхэн үнэлэх бол?

(Жишээ нь: тушаах, бэлтгэх, шийтгэх зэрэг хязгаарлах арга зам)

**Хаалт**

Дүгнэлт: Сурагчид зарим нийтлэг зөрчлүүд, тэдгээрийн учир шалтгаан болон зөрчил зөрчлөө хэрхэн төрүүлж байгаа зэргийг мэдэж авсан байгаа. Нэг зөрчлийн улмаас нөгөө зөрчил бий болох тохиолдолд ихэнхдээ хоёр дахь зөрчил нь эхнийхээсээ илүү ноцтой байдаг байна — зөрчлийн хурцадмал байдал.

Хэлэлцүүлэг:

➤ Зөрчлийн хурцадмал байдлын илрэлийн талаар жишээ гаргаж чадах уу?

**ГОЛ САНААНУУД**

- ♦ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн дүрмүүд нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд хэрэглэгдэхээр тусгайлан зохиогдсон байдаг.
- ♦ Хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлүүд нь ихэвчлэн дараа дараагийн зөрчлүүдийн гинжин холбоог үүсгэж байдаг.
- ♦ Хүмүүс зарим зөрчлүүдэд янз бүрийн шалтгаан байдаг гэж үздэг, тухайлбал өшөө авах, хүмүүс олноор суугаа газар байлдах, энгийн иргэд дайснуудад тусалж байна гэж бодох, дээд албан тушаал бүхий хүмүүсийн гаргасан хууль бус захирамж тушаал зэрэг орно.

*Дөнгөж бэлтгэл төгсөөд ирсэн залуухан офицер гудамжаар алхаж явлаа. Нэгэн баярын өдөр байсан юм. Бид ердөө л эргэн тойронд бүх зүйл сайхан байгаа эсэхийг ажиглан харсан 5 цэрэг явж байлаа. Гэтэл минут хэрийн хугацаанд биднийг дөрөв, таван мянган хүн хүрээлэн авч чулуу шидэж эхлэх нь тэр. Тэд бүгд ихууртай байсан ба учир нь дүрвэгсдийн хотхонд хэн нэгэн нь шархадсан байсан бололтой. Бүгд их улайрсан байсан тул амь насанд үнэхээр аюултай байлаа. Би цэргүүдээ тэндээс яаж авч зугтахаа бодох хэрэгтэй байв. Надад зөвхөн жинхэнэ сумтай буу л байсан бөгөөд би цэргүүдээ тэндээс гаргах хэрэгтэй байсан юм. Тиймээс би буудлаа, хөл рүү нь буудлаа. Би өөрийгөө тэндээс гаргахын тулд арав, арван хоёр удаа буудсан бөгөөд эцэст нь бид тэднээс мултарч чадсан юм.*

*— эзлэгдсэн газар алба хааж байсан офицер*

*Яагаад цэргүүд буруу гэдгийг нь мэдсээр байж энгийн иргэд иргэд рүү дайрдаг юм бэ? Тэд хүний үгээр хийж байгаа эсвэл тэд нарт том зүйл амласан байхаа. Тэднийг муу муухай зүйл хийхийг өдөөн хатгасан байна. Тиймээс тэд олон юм боддоггүй. Миний ойлгохгүй байгаа зүйл бол тэдний ухаан санаанд юу нөлөөлж байгаа нь юм.*

—ОУХЭЗ—н зөрчилд хэлмэгдэгч

## Нэмэлт дасгал

Мэтгэлцээнийг шүүгчийн үнэлгээ ба дүгнэлтээр дуусгана.

Тэгээд дараах асуултыг хэлэлцэнэ үү:

- Энэхүү мэтгэлцээн ОУХЭЗ—г хэр зэрэг тусгасан гэж бодож байна вэ?
- Үргэлж зөрчигддөг хэдий ч үнэ цэнээ алдаагүй байгаа хуулиудын өөр жишээ бий юу? (жишээнүүд нийгмийн амьдралаас болон шашны уламжлалт ёсноос улбаатай байж болно)

ЭСВЭЛ

Нигерийн нэгэн багшийн дорх мэдэгдлийг дэмжиж байгаа буюу эсэргүүцэж байгаа талаар мэтгэлцэнэ.

*Цэргүүд энгийн иргэдийг хөнөөхийг хориглосон хууль байдаг бол, энгийн иргэд цэргүүдэд туслахыг хориглосон хууль бас байх ёстой.*

Өөрийн байр сууриа бодолцохдоо анхаарах нь:

- таны байр сууринаас ямар үр дагавар гарахыг тооцох
- цэргүүдэд "туслах " гэдэгт юу орж байгааг тодорхойлох

> *Хууль давалгаалан ирж буй түрлэгийн эсрэг далан босгодог. Тэгээд түрлэг удаан хугацааны турш гарч чадахгүй. Тэр даралт үзүүлсээр, түлхсээр, боломж гармагц даланг нураан нэвтрэн орж ирнэ. Заримдаа энэ нь даланг авч одно. Тэр нь зөрчигдсөн, үр нөлөөгүй болсон хууль маань байх болно. Энэ нь түүний хувь заяа. Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хуулийг л жинхэнэ хууль гэж боддог хэн боловч энэ дэлхийгээс өөр ертөнцөд амьдрах ёстой.*
>
> — Д. де Бечиллон

# Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой –2

## Сүүлийн үеийн дайнд оролцож байсан хүмүүс өөрсдийн учирсан, нүдээр харсан буюу сонссон хууль бус зөрчлүүдийн тухай ярьж байна.

1. Цэргүүд дүрэмт хувцсаа энгийн хувцсаар сольсон тохиолдол маш олон. Тийм үед аль нь үнэхээр энгийн иргэн байсныг яаж мэдэх билээ? Тиймээс, хэрэв хот руу дайрах болбол хөдөлж буй бүхнийг устгах хэрэгтэй болдог.

   *–нэгэн цэрэг*

2. Бид эцэст нь гэр бүлүүд рүү дайрч эхэлсэн. Тэд 3 сартай нялх хүүхдийг хороох зэргээр манай хүмүүст ч мөн адил зүйлийг хийж байсан нь биднийг үүнийг хийхэд хүргэсэн.

   *–хуучин байлдагч*

3. Хэрэв би бусад хүмүүс манай олзны хүмүүсийг хороож байгаа тухай мэдээ авбал нөгөө талаас баригдсан хэнээс ч болов түүний төлөөсийг авах болно.

   *–хээрийн командлагч*

4. Энгийн хүмүүс хоол хийгээд байлдаж буй цэргүүдэд авчирч өгч байгаа нь тэд ч бас дайнд тулалдаж байна гэсэн үг. Хоолгүйгээр цэргүүд бидэнтэй тулалдах хүч олж чадахгүй. Тиймээс дүрэмт хувцастай хувцасгүй тэд бүгд цэргүүд. Цэргүүдэд хоол залгуулж буй энгийн хүмүүс зэвсэглээгүй ч гэсэн армийн гишүүд юм. Тиймээс цэргүүдэд тэднийг хөнөөх эрх байгаа.

   *–хээрийн командлагч*

5. Цэргүүдэд дайнд олзлогдсон хоригдлыг хороох ёстой мэт санагддаг. Дайны үед хаа сайгүй авч явах учраас тэр чамд илүүдэл ачаа болдог. Чи тэр хүнийг хариуцах ёстой болно, тиймээс хариуцлагаас мултрахын тулд түүнийг хороодог.

   *–төрийн бус байгууллагын ажилтан*

6. Өөр нэг асуудал бол төлөвлөлтийн дутмаг байдал, учир нь олзны хүн баригдсан байхад түүгээр яах ёстойгоо мэддэггүй. Эцэстээ олзны хүнийг хөнөөдөг. Бид чинь партизаны дайнд тулалдаж явсан шүү дээ.

   *– хуучин саатуулагдагч*

7. Холбооны хүчнүүд тосгодыг эзэлж чадаагүй; тиймээс тэд тосгон руу очих хүмүүнлэгийн тусламжуудыг зогсоосон. Тэр нь өлсгөлөнг нэмэгдүүлэх стратеги байсан бөгөөд энэ нь буруу юм.

   *– хуучин байлдагч*

8. Дайны үед ахлагч “хүмүүсийн тариаланг хэзээ ч сүйтгэж болохгүй" гэж сануулдаг байсан. Гэвч дараа нь байдал өөрчлөгдсөн. Байлдааны гол бодлого эдийн засгийг нь сүйрүүлэх явдал болсон. Хэрэв том зүйлийг нь бусниулж чадахгүй бол хүмүүсийн өмч хөрөнгө рүү халдахыг цэргүүдэд тушаадаг байв. Бүхий л зүйлийг сүйтгэн үнсэн товрог болгох явдал нь дайснаа ялах гол арга нь болж байлаа.

   *– хуучин байлдагч*

9. Зэвсэгт хүчин энгийн иргэд рүү халдах болсон нь энгийн иргэдэд ямар байсныг ойлгоогүй учраас гэж би боддог. Цэргүүд энгийн иргэд ч бас партизан гэж гомдолж, заримдаа тэднийг нутгийн босогчидтой хамтран ажиллаж байна гэж боддог. Цэргүүд зарим айлуудыг босогчдод хоол хүнс залгуулж, магадгүй нэгдэн ажилладаг байх гэж боддог учраас дайснуудтай нь хамтарсны төлөө гэр бүлийнхнийг бүгдийг нь хороодог байв.

   *– гэр бүлийнх нь гишүүн сураггүй алга болсон эмэгтэй*

# Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой –2

**10.** Шашны газар луу дайрах нь дайны зөвхөн нэг хэсэг юм. Байлдагчид эдгээр газруудыг халдашгүй ариун бөгөөд дайснууд нуугдаж байж болно гэж боддог. Өөрөөр хэлбэл сүм дотор цэрэг байх л бол тэр сүм биш гэсэн үг.

*–нэгэн цэрэг*

**11.** Алан хядлага нь нэг ёсны өс авах явдал юм. Эхлээд хэн нэгэн цэрэг Улаан Загалмайн тээвэрлэж явсан шархтай босогчийг булаан авч хороосон байг. Тэгвэл бусад босогчид нь хэн нэгэн цэргийг өш хонзонгийн улмаас хороон о. Тэд Улаан Загалмайг аль аль талаас шархадсан хүнийг зөөхийг нь болиулахын тулд тийм зүйл хийсэн. Нэг тал нь үүнийг хийхэд, нөгөө тал нь мөн л тэгдэг.

*– хуучин байлдагч*

**12.** Арми нь энгийн иргэдээр амьд халхавч хийж болохгүй. Гэвч дайны үед ийм явдал болж л байдаг. Жишээлбэл, тэд их буугаа сүмийн орой дээр эсвэл энгийн хүмүүсийн амьдардаг томоохон байшингийн дээр байрлуулдаг. Дагаж мөрдөх ёстой зүйлээ хэн ч мөрддөггүй байлаа. Биднийг аюул заналхийлж байсан учраас бид тэдгээр байшин руу гал нээсэн.

*– Түр саатуулагч байсан*

**13.** Хүчиндүүлсэн охид байсан, одоо тэд эцэггүй хүүхдүүдтэй. Энэ бол хэзээ ч шийдвэрлэшгүй гэмт хэрэг юм.

*–тосгоны оршин суугч*

**14.** Бид нэг газраас нөгөө рүү нүүж байхдаа усыг хордуулах даалгавар авсан байсан. Энэ бол дайны нэг хэсэг, амьд үлдэх арга зам байлаа. Баригдах л юм бол тэд дайсан учраас чамайг хөнөөх болно. Гэвч хүмүүсийн ихэнх нь гарах газаргүй болсон, нэг газраас нөгөө рүү нүүж яваа гэмгүй хүмүүс байдаг. Тэдэнд итгэл найдвар, хоол хүнс байхгүй; тиймээс тэднийг хордуулах нь буруу зүйл юм.

*– хуучин байлдагч*

**15.** Олзны хүмүүс ухаан санаа нь саруул биш хүмүүсийн халддлагад өртөж байдаг гэж би боддог. Миний хүргэн ах дайснуудад олзлогдох үед тэд олзны хүмүүстэй зүй бусаар харьцдаг байсан. Тэд олзны хүмүүс нэг л өдөр хэрхэн харьцаж байсныг нь бусдад хэлэхээс эмээдэг. Тиймээс ч олон хоригдол алуулсан. Ердөө л гэм буруугаа халхлахын тулд.

*–бэлэвсэн эхнэр*

**16.** Шашны буюу түүхэн газруудыг устгах нь дайны нэгэн хэсэг. Яагаад гэвэл дайны үед та нар юунд ч санаа тавихгүй, ялахын тулд өмнөө тааралдсан юм бүхнийг устгахыг хүснэ.

*–дүрвэгсдийн лагерийн удирдагч байсан багш*

**17.** Энгийн хүмүүсийг хоол хүнс, усаар хангахыг зогсоох нь байлдааны нэг стратеги, энэ бол сайн зүйл. Тэдэнд хоол хүнс авахыг нь зөвшөөрөхгүй байна гэдэг нь тэд усгүй сул дорой болно гэсэн үг. Ямар ч хууль дүрэмгүйгээр шүү!!!

*–олзлогдсон байлдагч*

**18.** Та дайсны автомат бууг өөрийн байлгах ёстой байж гэж бодъё. Гэвч дайснууд тэр буугаа алдахгүйн тулд энгийн иргэдийг түүний дээр байрлуулсан байна гэж бодъё. Мэдээж та цэргийн объектыг буудах болно.Тэгээд энгийн хүмүүсийн амь нас ч үрэгдэх болж байна.

*– сэтгүүлч*

**19.** Цэргүүдийн энгийн хүмүүсийг хөнөөх нэг шалтгаан бол, цэргүүд хүнд шархдагсадтай шаналсан үедээ энгийн иргэдийг дуудаад, булшны нүх ухуулдаг. Ухаж дууссаны дараагаар тэднийг хороодог, яагаад гэвэл энгийн иргэд энэ бүхнийг өдүүлэгчдийн талынхан байдаг гэж тэд боддог. Тэд уурандаа үүнийг хийдэг. Ийм зүйлийг голдуу эрх мэдэл багатай, дайны тухай боловсролгүй цэргүүд хийдэг.

*– хээрийн командлагч*

# Ямар хууль зөрчигдсөн байна вэ?

| Хэн нэгэн нь ямар буруу зүйл хийснийг дүрсэлнэ үү. | | | Зөрчигдсөн дүрмүүд |
|---|---|---|---|
| Жишээ:№1. Цэргүүд энгийн иргэд болж харагдсан. Энгийн иргэд байсан хэдий ч хөдөлж буй бүхнийг эсрэг талын цэргүүд хөнөөсөн.<br><br>Баримт №___<br><br>Баримт №___<br><br>Баримт №___ | | | 1.4 ба 2 |
| **Хэн нэгний буруу хийсэн нэг зүйлийг бичнэ үү.** | **Зөрчигдсөн дүрмүүд** | **Дагалдах зөрчлийг нэрлэнэ үү.** | **Зөрчигдсөн дүрмүүд** |
| №1 – Цэргүүд энгийн иргэд болж харагдсан. | 1.4 | Эсрэг талын цэргүүд хөдөлж буй бүгд рүү дайрсан. Тэгэхээр нөгөө тал энгийн иргэдийг бөмбөгдөн хариу барьж болзошгүй. | 2, 1.1, 1.2 |

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**1** Аливаа халдлага нь байлдагчид болон цэргийн байнуудаар л хязгаарлагдах ёстой.

1.1 Энгийн иргэд рүү дайрч болохгүй.
1.2 Энгийн иргэдийн обьектууд руу (байшин, эмнэлэг, сургууль, мөргөлийн газар, соёлын буюу түүхийн хөшөө дурсгал гэх мэт) дайрч болохгүй.
1.3 Цэргийн байны бамбай болгон энгийн иргэдийг ашиглахыг хориглоно.
1.4 Байлдагчдыг энгийн иргэдийн дүрд хувирахыг хориглоно.
1.5 Энгийн иргэдийн өлсгөлөнг дайтах арга болгон хэрэглэхийг хориглоно.
1.6 Энгийн иргэдийн амьд үлдэхэд зайлшгүй шаардлагатай обьектууд рүү (хоол хүнс, тариалангийн талбай, ундны усны байгууламж гэх мэт) дайрахыг хориглоно.
1.7 Хэрэв энгийн иргэдэд ихээхэн хэмжээний хохирол учруулах бол усны далан, хаалт буюу атомын цахилгаан станц руу дайрахыг хориглоно

**2** Энгийн иргэд ба цэргийн обьектууд болон хүмүүсийг ялгаварлахгүйгээр хөнөөдөг, үлэмж хохирол, зовлон учруулах аливаа дайралт буюу зэвсгийг хориглоно.

2.1 Химийн болон биологийн, нүд сохлогч лазерын зэвсэг, хүний биед рентгений туяагаар илэрдэггүй хэлтэрхийнүүдээр гэмтэл учруулах зэвсэг, аливаа хорт бодис, хүний эсрэг газрын мина зэрэг тодорхой төрлийн зэвсгүүдийг хориглоно.
2.2 Амьд хүн үлдээхгүйгээр устгахыг заналхийлэх болон тушаахыг хориглоно.

**3** Энгийн иргэд, шархадсан байлдагчид болон хоригдлуудыг өршөөн хамгаалж, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.

3.1 Ямар ч хүн биеийн болон сэтгэл санааны тамлал, бие махбодийн шийтгэл буюу харгис эсвэл гутаан доромжилсон харьцаа эдлэх ёсгүй.
3.2 Сексийн хүчирхийллийг хориглоно.
3.3 Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрдсийн эрхшээлд байгаа эсрэг талын шархадсан болон өвчтэй дайсанд халамж үзүүлэх, тэднийг хайж олох ёстой.
3.4 Бууж өгсөн буюу дайнд оролцохооргүй болсон дайсныг хороох буюу шархдуулахыг хориглоно.
3.5 Хоригдлуудыг хүндэтгэн, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.
3.6 Хүн барьцаалахыг хориглоно.
3.7 Энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. —“Үндэстэн угсаатны цэвэрлэгээ”—г хориглоно.
3.8 Дайсны гарт байгаа олзлогдсон хүмүүс нь гэр бүлийнхэнтэйгээ мэдээлэл солилцох, хоол хүнс, эмнэлгийн халамж болон сэтгэл санааны дэмжлэг гэх мэт хүмүүнлэгийн тусламж авах эрхтэй.
3.9 Жирэмсэн эмэгтэй, нярай эх, харгалзагчгүй хүүхэд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэн тусгай хамгаалалтанд байх ёстой.
3.10 ОУХЭЗ нь 15—аас доош насны хүүхдүүдийг цэрэгт татах буюу цэргийн үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
3.11 Хүн бүр шударгаар шүүгдэх эрхтэй (шударга шүүх, хэвийн процедур гэх мэт). Хамсруулан шийтгэхийг хориглоно.

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**4 Эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс, байгууламжуудыг (эмнэлэг, клиник, түргэн тусламж гэх мэт) хүндэтгэн үзэж хамгаалан, тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь боломжит бүхий л тусламжаар хангах ёстой.**

**4.1 Улаан Загалмай буюу Улаан Хавирган Сарын эмблем, таних тэмдгүүд нь эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс болон байгууламжуудын хамгаалалтыг билэгдэнэ. Ийм тэмдэгтэй хүмүүс буюу обьект руу дайрахыг хориглоно. Түүнчлэн энэхүү тэмдгүүдийг хуурамчаар ашиглахыг хориглоно.**

**4.2 Эрүүл мэндийн нэгжүүд болон тээвэрлэлт нь дайсны талд хор уршиг учруулах аливаа үйлдэл хийхийг хориглоно.**

**4.3 Шархадсан болон өвчтэй хүмүүсийг эмчлэхэд, эрүүл мэндийн байдлаас нь бусад тохиолдлоор давуу эрх олгохыг хориглоно.**

## Тодорхойлолтууд

**Дагалдах хохирол**: энгийн иргэд амь насаа алдах, бэртэх, эд зүйлсийн хохирол амсахаас хамгаалах, түүнчлэн хохирлыг аль болох багасгах урьдчилсан арга хэмжээ авсан хэдий ч үйлдсэн довтлогооноос тохиолдлоор үүссэн гарз хохирол

**Байлдаанд оролцохооргүй болсон этгээд:** олзлогдсон, шархадсан, өвчтэй эсвэл хөлөг онгоц нь сүйрэлд өртсөний улмаас дахин байлдах боломжгүй болсон байлдагчд

**Энгийн иргэд:** байлдагч бус бүх хүмүүс. (Сэжиглэгдсэн үед ч гэсэн тухайн хүн энгийн иргэнд тооцогдоно.) Хэрэв энгийн иргэд, дайсагнагч талуудын аль нэгний талд орж, ямар нэгэн дайсагналын үйлдэл хийвэл дайтагч болж хувирах ба хамгаалагдах эрхээ алдана.

**Энгийн иргэдийн обьектууд:** цэргийн бай болоогүй бүх обьектууд. Хэрэв энгийн иргэдийн обьект нь цэргийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашиглагдвал тэдгээр нь цэргийн бай гэж тооцогдох ба хамгаалалтаа алдана.

**Байлдагч:** зэвсэгт хүчний гишүүн буюу цэргийн үйл ажиллагаанд шууд оролцож буй хүн

**Цэргийн бай**: Шинж чанар, байрлал, ашиглагдах зорилгоороо цэргийн үйл ажиллагаанд үр ашигтай хувь нэмэр оруулж буй, учруулсан хор хөнөөл нь тодорхой зэвсэгт хүчний давуу талыг олгож байгаа байлдагчид болон обьектууд

## Судалгаа 3 В. Байлдагчийн байр сууринаас харахад

3А судалгаанд, сурагчид олон тооны зөрчлүүдийг тодорхойлон, хүмүүс яагаад заримдаа Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн дүрмүүдийг зөрчдөг тухай ярилцсан. Одоо тэд орчин үеийн дайны явцад цэргүүдэд тулгарч буй бодит жишээнүүдэд тулгуурласан дилеммануудыг судлах болно. Дайнд өдөр тутам тэмцэж буй цэргүүд үргэлж дайны хууль болон өөрсдийн аюулгүй байдал буюу хариуцаж буй цэргүүдийнхээ аюулгүй байдал хоёрын хоорондын мөргөлдөөнтэй холбоотой шийдвэр гаргах ёстой болдог.

Ихэнх дилемманууд байлдагчид ба энгийн иргэд хоорондын ялгаа тодорхойгүй байх үед тулгардаг. Заримдаа уг ялгааг байлдагчид аюулгүй байдал буюу давуу тал олж авахын тулд зориуд далдалсан байдаг. Заримдаа энэ ялгаа нь орчин үеийн дайны шинж чанараас хамаараад тодорхойгүй болдог явдал бий. Энэхүү судалгаа нь дилеммаиы төрлүүдийг авч үзэхийн зэрэгцээ дилемма нь хэрхэн байлдагчид ба энгийн иргэд хоорондын ялгаа тодорхой бус байгаагаас үүсч байгааг, мөн уг ялгааг хэвээр хадгалж үлдэх нь ОУХЭЗ—н хүчин төгөлдөр байдалд ямар чухал болохыг харуулахыг зорьсон юм.

**Зорилго:**

- Дайны нөхцөл байдалд ОУХЭЗ—г хүндэтгэн сахихад гарч болох дилеммаг тодорхойлж чаддаг болох
- Байлдагч, энгийн иргэний ялгаа тодорхойгүй байх үед ОУХЭЗ—г дагаж мөрдөхөд тулгарах асуудлуудыг тодорхойлж чаддаг болох

**Ашиглах материалууд:**

- Дилеммад орох:

Би одоо яах вэ?
Би үүнийгээ зогсоох хэрэгтэй юу?
700 хоригдлууд ба идэх юм маш бага үлдсэн
Тэр эмэгтэйн хэлж байгаа зүйл үнэн бол яах вэ?*
Энэ машиныг бид яах хэрэгтэй вэ?*
Би тосгон руу гал нээнэ гэж үү?*

- Дилеммаиы дасгал хуудас
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн дүрмүүд юу вэ?



**Багш нарт:**

- Зарим дилеммаиы төгсгөл

**Бэлтгэл ажил**

Хоёр буюу түүнээс дээш дилемма сонгож авна (хичээлийн цагийг яаж ашиглахаар төлөвлөсөн, түүндээ тохируулан). Байлдагчдыг энгийн иргэдээс ялгахдаа хоёрдмол утга илэрхийлж буй од (*)—оор тэмдэглэсэн хэлбэрийн дилемма нэгээс хоёрыг оруулаарай.

*Арга зүйн удирдамж* — "Дилеммаг ашиглах нь" хэмээх Багш нарт 4—ийн үр дагавруудыг хэрхэн заах тухай материалыг эргэн харна уу.

**Хугацаа:**

45—60 минутын 2 хичээл.

# Судалгаа 3 В. Байлдагчийн байр сууринаас харахад

**Алхам 1. Байлдагчдад тулгарч буй дилеммаг авч үзэх нь** (бүлгийн ажил) (20—25 минут)

Бүлэг бүрт нэг дилемма онооно. Ямар үйлдэл хийхээ шийдэхдээ дараах асуудлуудыг бодолцох ёстой:

- олон төрлийн боломжит үйлдлүүд
- үйлдэл бүрийн боломжит үр дагаврууд
- хүмүүнлэгийн зорилго ба ОУХЭЗ—н шаардлага
- холбогдох хүмүүс болон тэдгээрийн санал бодол
- сэтгэл хөдлөл болон хандлага нь үр дагаварт хэрхэн нөлөөлж болох
- тэдний шийдвэрт нөлөөлсөн нөхцөлүүд (цаг хугацааны хавчигдмал байдал, орчин тойрны аюул болон эрх мэдэл буюу холбогдох бусад хүмүүст нөлөөлөх харьцангуй түвшин)

10—15 минутын дараа бүлгүүдээс ямар үйлдэл хийхээр болсныг нь асууна. Юуг сонгосон болон яагаад сонгосон тухайгаа бичихийг хүснэ.

**Алхам 2. Гаргасан шийдвэрээ тайлагнах** (20—30 минут)

Бүлгүүд тайлагнаж бичихдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй:

- ОУХЭЗ—г дагаж мөрдөх үедээ тулгарсан дилемманы **нөхцөлийг** гаргаж ирэх
- Уг нөхцөл байдалд хэрэгжүүлж болох ямар нэг ОУХЭЗ—н **дүрмийг** дурьдах
- Сонгосон **үйлдлийг** тодорхойлох
- Уг сонголтыг хийсэн **учир шалтгааныг** тайлбарлах

Жич: Энэхүү судалгааны төгсгөл дэх "Зарим дилемманы төгсгөл" хичээл нь хоёр өөр нөхцөл байдалд юу болсон тухай өгүүлэх бөгөөд сурагчдад тэдгээр дилеммаг тайлагнасны дараа уншиж өгч болох юм.

**Алхам 3. Байлдагч ба энгийн иргэний ялгаа** (10 минут)

Женевийн Конвенцийн Нэмэлт Протокол 1—ийн 48 дугаар зүйлийг танилцуулна.

Сурагчдаас дараах жишээнүүдийг асуух замаар тэдэнд энэхүү хуулийг ойлгоход нь тусална:

- Зэвсэгт мөргөлдөөний үед хэнийг энгийн иргэн гэж үзэх вэ?
- Энгийн иргэний объект ба цэргийн объект гэж юу вэ?

Цэргүүд ОУХЭЗ—г дагаж мөрдөх явцад тулгарч буй дилеммад хоёр талт жишээнүүд хэрхэн хувь нэмэр оруулж байгааг харуулахдаа дараахтай төстэй жишээнүүдийг ашиглаарай:

- Цэргүүдийг хоол хүнс, хоргодох байраар хангаж буй эмэгтэй
- Төмрийн үйлдвэр
- Зарим оюутнуудыг цэрэгт бэлтгэдэг их сургууль

*48 дугаар зүйл*

*Мөргөлдөөнд оролцогч талууд энгийн хүн ам болон иргэний объектуудыг хүндэтгэн хамгаалах явдлыг хангах зорилгоор энгийн хүн амыг байлдаж байгаа хүмүүсээс, түүнчлэн иргэний объектуудыг цэргийн объектуудаас цаг ямагт зааглан ялгаж байх ёстой бөгөөд зөвхөн цэргийн объектуудын эсрэг байлдааны ажиллагаа явуулна.*

*— Женевийн Конвенцийн Нэмэлт Протокол 1—ийн 48 дугаар зүйл.1977*

*50 дугаар зүйл*

*Ямар нэгэн хүнийг энгийн иргэн байх эсэх тухайд эргэлзэх тохиолдолд түүнийг энгийн иргэнд тооцно.*

*— Женевийн Конвенцийн Нэмэлт Протокол 1—ийн 50 дугаар зүйл.1977*

**Хаалт** (10 минут)

➤ Хэн нь энгийн иргэн болохыг мэдэхгүй байснаас үүдэн ямар үр дагаврууд гарах вэ? Тэдгээр нь өөр ямар үр дагавруудыг үүсгэх вэ?

➤ Зэвсэгт мөргөлдөөн дэх хүмүүнлэгийн зан үйлийг хүндрүүлдэг өөр бусад хүчин зүйлүүд юу вэ?

➤ Энгийн иргэдтэй дайсны цэрэг мэт харьцдагийн шалтгаан нь юу вэ?
(Жишээ нь: дайсанд туслах, аль нь цэрэг аль нь энгийн иргэд болохыг цэргүүд хэлж мэдэхгүй байх, дайсны цэргүүдийн байгаа газарт байх)

➤ Цэргүүд дайны үед өөрийн талын энгийн иргэдтэй хэрхэн харьцаж байгаад яаж нөлөөлж чадах вэ?

Мөргөлдөөнд оролцогч талуудын хариуцлагад анхаарлаа хандуулна:

- Энгийн иргэдийг бай болгож болохгүй.
- Байлдагчид энгийн иргэдийн дүрд хувирснаар энгийн иргэд эрсдэлд орж болохгүй.
- Шархдагсад болон хоригдлуудад санаа тавих ёстой.

*Бид хүүхдүүд байтугай, хэнд ч итгэхгүй байхыг сурсан. Шар айраг, ундааны бүх лаазуудыг эвдэлж хаях ёстой байлаа — хэрэв лаазыг эвдлэхгүй хаявал босогчид тэднийг нутгийн хүүхдүүдээс худалдаж аваад гар бөмбөг хийхдээ ашигладаг байв. Бид сэжигтэй байсныхаа ачаар амьд үлдсэн.*

*— нэгэн цэргийн дурсамжаас*

*Нэг өдөр хүмүүс чам руу гүйж ирээд чамайг тэвэрч байна, дараагийн өдөр нэг жаахан хүүхэд чам руу тэсрэг бөмбөг шидэж байна. Иим байдалд чи ямар шийд гаргана гэж бодож байна? Юу мэдэрнэ гэж бодож байна? Би мэдэхгүй байна.*

*— нэгэн цэргийн дурсамжаас*

**ГОЛ САНААНУУД**

- Зэвсэгт мөргөлдөөний үед ОУХЭЗ—н дүрмүүдийг дагаж мөрдөхөд янз бүрийн дилемма учирдаг.
- Энгийн иргэд болон байлдагчдыг ялгахад хэцүү учраас олон дилемма үүсдэг.
- Заримдаа хүмүүс энэ ялгааг санаатайгаар бүрхэг болгодог бол бусад тохиолдолд хүмүүс суурьшсан газар байлдах үед энэ ялгаа нь өөрөө тодорхой бус болдог.
- Ямар нэгэн хүнийг энгийн иргэн байх эсэх тухайд эргэлзэх тохиолдолд түүнийг энгийн иргэнд тооцно.

## Нэмэлт дасгал

**Дайны үеийн энгийн иргэдийн оролцооны түүх**

Түүхийн хичээлтэйгээ холбогдуулан, энгийн иргэдийг хэрхэн дайнд явагсад гэж үздэг байсныг судална. Босогчдын дайн энгийн иргэдэд хэрхэн нөлөөлсөн бэ? Байлдааны стратегийн өөрчлөлт болон технологийн дэвшил нь тэдний энгийн иргэд байх байр суурь болон энгийн иргэд ба байлдагчын хоорондын ялгаанд хэрхэн нөлөөлсөн бэ?

**Дүрд тоглох**

Дилеммануудын нэгээр жүжигчилсэн тоглолт бэлтгэнэ. Шийдвэр гаргагчийн дүрээс гадна "Анхаарч үзэх бусад саналууд" —д дурдсан дүрүүдээс мөн оруулах хэрэгтэй. Жишээ нь, хэсэг бүлэг цэрэгт тулгарсан дилеммаг харуулахын тулд шийдвэр гаргагч өөрт нь хандаж тайлагнадаг офицероос гадна өөр өөр цэргүүдийн дүрийг бүтээж болно.

# Зарим дилемманы төгсгөл

**“Би одоо яах вэ?" нэмэлт**

Энэхүү дэслэгч өөрийн талын эмнэлгийн тусламжийн нисдэг тэргийг дуудахаар шийдсэн бөгөөд ирж дайсны шархадсан цэргийг эмнэлгийн нэгж рүү зөөхийг хүлээж байв. Тэр өөрийн энэ шийдвэрийнхээ тухай хожим өгүүлэхдээ:

> *Би ухаан санаанаасаа илүү зүрх сэтгэлээ дагасан байсан. Бага нэгжийн тактикийг хэрэглэн завиуд руу дайран, хурдхан шиг ашигтай төхөөрөмж эсвэл мэдээлэл хайгаад, тэндээс хурдхан зайлж болох байсныг би мэдэж байлаа. Гэтэл би энд Флоренс Найтингеил болж, үйл явцдаа өөрсдийн хүмүүсийн амь насыг эрсдэлд оруулж байлаа.*

Нисдэг тэрэг ирэх үед шархадсан хоригдол нас барлаа.

> *Тэр үхчихэж! Би цээж рүүгээ хүчтэй цохиулах шиг болсон.(...) Би балмагдсан байсан. "Чиний төлөө бид энд хүлээж хүлээсний дараа чи одоо үхэж болохгүй ээ, энэ чинь шударга бус!" (...) Бид тэрнийг түүний нөхөд эсвэл тас шувууны аль эхэлж олсонд нь үлдээгээд явсан. Харанхүй нөмөрч байсан учраас бидэнд түүнийг оршуулах цаг ч байсангүй.*

**“Тэр эмэгтэйн хэлж байгаа зүйл үнэн бол яах вэ?" нэмэлт**

Энд нэгэн дэслэгч юу хийсэн тухайгаа ярьж байна.

> *Би саяхан юу хийж байсан тухайгаа санаад чичирлээ. (...) Буруу зүйл хийсэндээ харамсах сэтгэл гэнэтхэн төрөв. Би үнэхээр хачин зан гаргасан санагдаж, энэ байдлаасаа аль болох хурдхан гарахыг хүсэв. Би олзны хүмүүсийг харахыг, тэдний тухай бодохыг ч хүсэхгүй байлаа. Би тэднийг харахгүй байхыг хичээж байсан юм. Секундын дотор би тэднийг үнэхээр бүгдээрээ гэм буруутнууд гэж бодож, өчүүхэн эргэлзэх сэтгэл төрмөгц бүгдээрээ гэмгүй хүмүүс гэж бодогдоод байлаа. (...) Би үнэхээр юу хийх, яахаа мэдэхгүй байлаа. Надад ямар ч барьц байсангүй, би үнэндээ айж байлаа. Өөрийгөө аврах ганц арга бол асуудлыг хаях явдал л байлаа. Тэгээд би тэр олзны хүмүүсийг бүгдийг нь суллан явуулсан юм.*

Хоёр долоо хоногийн дараа, тэдний харуулууд руу гэнэт дайрсан байна. Нэг нь алагдаж, хоёр нь шархаджээ. Тэдэн рүү дайрсан хоёр босогч мөн алагдсан байна. Тэдний талын нэг нь эргэж ирээд алагдсан босогчдын нэг нь “загасчны эгч" байсан тухай хэлэхэд түүнд ямар санагдаж байсныг дэслэгч эргэн санаж байна. Тэр эмэгтэй буугаа барьсан хэвээр, бууны хүхээ нь бараг хоосон байлаа.

> *Түүний нүдэнд намайг, нөхдийнхөө болон хамтран ажиллагчдынхаа аюулгүй байдлыг бодохоосоо илүү олзны эмэгтэйчүүд болон хаа байсан дүрэм журамд илүү анхаарч алуурчдыг хайхрамжгүйгээр тавьж явуулсанд зэмлэн буруушааж буй харц илэрхий байлаа. Тэр гурван олзны хүнийг тавьж явуулснаар өөрсдийнхөө аюулгүй байдлыг байж болшгүйгээр хүнд байдалд оруулсан гэж тэд бодож байгааг би мэдэж байлаа.*
>
> *Гэвч тэр үед мөн л; тэр эмэгтэй бидэнд баригдахаасаа өмнө бидний дайсан байсан уу эсвэл дараа нь уу? гэсэн бодол надад төрсөн юм.*

Эх сурвалж: Девид Донованаас авсан, “Нэгэн цагт Байлдагчдын Хаан байсан нь" хэмээх *Вьетнамд байсан офицерийн дурсамжаас иш татав. МкГроу—Хилл, Нью—Йорк, 1985.*

## Судалгаа 3 В. Байлдагчийн байр сууринаас харахад — Эх сурвалж 1

# Би одоо яах вэ?

Дөрвөн жижиг завь бүхий дайсны харуул манаанаас хүмүүсийг нь барьж эд материалыг нь хураах даалгавар авсан дэслэгч, нэгэн жижиг багийг хариуцдаг байв. Тэдний багийнхан хоёр эвдэрсэн завь олж хараад дөхөж очиход гал нээв. Эргүүлж гал нээсээр улам дөхлөө. Гэтэл сувгийн захаар нуугдаж байсан хэдэн хүн гараа өргөсөөр гарч ирэн түүний дэргэд ирлээ. Тэр олзны хүмүүсийг баривчилсан боловч, нөгөө хоёр завь нь хаачсаныг мэдэхгүй байлаа.

Багийнхны нэг нь сувгийн тэндээс нэг дайсныг чирэн гаргаж ирэв. Түүний гэдэс тэсрэх бөмбөгний хэлтэрхийд зүсэгдсэн байлаа. Түүний нүд аниастай, газар хэвтээд аяархан ёолж байлаа. Гэдэс нь урсан цуварч байв. Түүний дэргэд өвдөглөн суугаад "Бурхан минь, би одоо яах вэ?" гэж дэслэгч дотроо бодож байв.

Тэр шархадсан хүнийг өгч явуулахаар өөрийн талын тусламжийн нисдэг тэргийг радиогоор дуудсан боловч багийнхны хувьд тэнд үлдэх нь хэр их аюултай байх билээ. Дайснууд тэр газрыг орхин явсан уу эсвэл тэд модон дунд суугаад боломж гармагц дайрахаар зэхэж байна уу. Дайсны шархадсан цэргийг буцааж байранд нь аваачихад хэцүү үнэхээр хүнд шархадсан байлаа.:

*Шархтай цэргийг эзгүй хээр орхиод явж чадсангүй. Гэтэл зөөврийн нисдэг тэргийг хүлээвэл асуудал үүсч болзошгүй байв. Зугтсан завинд хичнээн хүн байсныг бид мэдэхгүй байв. Бид 7 хүнийг олзолсон. Хэрэв бусад нь зугтсан бол тэд магадгүй модон дунд нуугдаад шүдээ хүртэл зэвсэглээд сууж байгаа. Хэрэв тэд нөхрөө аврахаар эргэж ирвэл бид хүнд байдалд орохоор байлаа. Бид ердөө л 15—уулаа 7 олзны хүнийг хараад сууж байлаа. Бүрэнхий болов. Бидэнд зөвхөн хувийн зэвсэг бас нэг сум цэнэглэгч л байв. Аюул тулгарах үед бидэнд агаарын дэмжлэг, тэр байтугай хоногийн хоол хүнсч байхгүй байлаа.*

**Дэслэгчийн оронд байсан бол юу хийх вэ.**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Багийн нэгэн цэрэг
- Шархадсан цэрэг
- Дэслэгчийн удирдагч офицер
- Нисдэг тэрэгний нисгэгч
- Нуугдаж буй дайсны

Эх сурвалж:: Девид Донованаас авсан, "*Нэгэн цагт Байлдагчдын Хаан байсан нь*" хэмээх Вьетнамд байсан офицерийн дурсамжуудаас ишлэв. МкГроу—Хилл, Нью—Йорк, 1985 он.

## Судалгаа 3 В. Байлдагчийн байр сууринаас харахад — Эх сурвалж 1

# Би үүнийг зогсоох хэрэгтэй юу?

Энэ босогч түүнийг бараг л хороох гэж байлаа. Дэслэгч хүчтэй урсгалд цохигдон хөл алдахдаа бүсэлхийнээсээ дээгүүр татсан усанд байлаа. Дайсан зэгстэй ус руу үсрэн түүн рүү хутга барин дайрлаа. Тэр энэ хооронд 2 зүйлийг олж харсан юм: түүний хэрцгий догшин харц, гартаа барьсан хутга.

Усанд удтал тулалдсаны эцэст дэслэгч түүний гарыг барьж өөрийн хүмүүс ирж түүнийг баривчлах хүртэл тавилгүй хүлээж байлаа... Залуу офицер эрэг дээр сөхрөн унав.

Гэвч одоо тэр ухаан орон баригдсан босогчийг хүрээлэн олон хүн байгааг мэдэв. Тэд олзны хүнийг байцааж хутга тулган сүрдүүлж байлаа. Хариуцсан офицерийн хувьд юу болж байгааг шалгахаар очив. Түүнийг очиход баригдсан хүний цээжийг хөндлөн зүссэн байлаа. Нэгэн түрүүч тэнд байсан хэрцгий байцаагчийг зогсоохыг оролдож:

– *Та нар ингээд хэрчээд байвал бид түүнийг олзны хүнээр авч явж чадахгүй. Түүнийг ахиж битгий ингээрэй. Бид түүнийг завь руу оруулж ирэхэд тэр ийм шархтай байсан гэж хэлэх болно. Харин одоо түүнийг ахиж битгий зүс, тайвширцгаа!* гэж хашгирав.

Түүнийг сонсоод байцаагч дурамжханаар больсон боловч, босогч мэдээлэл өгөхийг эсэргүүцсээр байсан тул тэрээр ахин хутгаа гаргаж ирээд түүний цээжинд зоов.

**Дэслэгчийн оронд байсан бол юу хийх вэ.**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Олзны хүн
- Байцаагч
- Түрүүч
- Дэслэгчийн салааны бусад цэргүүд
- Төв штаб дээр байгаа түүний удирдагчид

Эх сурвалж:: Девид Донованаас авсан, *"Нэгэн цагт Байлдагчдын Хаан байсан нь"* хэмээх Вьетнамд байсан офицерийн дурсамжуудаас ишлэв. McGraw–Hill, Нью–Йорк, 1985

# 700 хоригдлууд ба идэх юм маш бага үлдсэн

Хотоос буюу иргэдийн гэрээс хол, эзгүй цөлд амжилттайгаар тулалдсан дайн эцэстээ дууссан байлаа.

Ялсан талын нэгэн цэрэг энэ бүхнийг эргэн дурсаж байна.

*Өлсгөлөн биднийг ухаан мэдрэлээс маань салгасан байлаа. Манай талын 500 хүн дээр нэмэгдээд бидэнд 700 олзны хүн байлаа. Бидэнд ямар ч мөнгө (үнэндээ бол дэлгүүр) байгаагүй бөгөөд хамгийн сүүлд 2 хоногийн өмнө хоол идсэн байлаа. Унаж явсан тэмээнүүд маань 6 долоо хоногт хүрэлцэхүйц мах болох боловч энэ нь тун тааруу бөгөөд өртөг ихтэй хоол юм. Мөн ингэж дурааараа аашлах явдал нь биднийг цааш хөдлөх боломжгүй болгох байлаа.*

**Тэд яах хэрэгтэй вэ?**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- *бусад ялсан цэргүүд*
- *олзны хүмүүс*
- *ялсан офицер*



Эх сурвалж: Т.Э. Лоренс, "*Элсэн цөл дэх тэмцэл*", Жорж Х. Дораны компани, Нью–Йорк, 1927 он.

# Тэр эмэгтэйн хэлж байгаа зүйл үнэн бол яах вэ?

Галаа зогсооход бид тэр нуувчийг хүрээлж авлаа. Хэн нэгэн тэнд байсаар байв. Бид бууж өгөхийг шаардав. Эрэгтэй, эмэгтэй 2 хүн гараа өргөөд гарч ирэв. Нуувч дотор зэвсэг болон баримт бичгүүдээс гадна дөрвөн үхсэн цэрэг байлаа. Бид тэр эрэгтэй эмэгтэй хоёрыг дайсны цэргүүд гэдэгт итгэлтэй байсан юм. Тэд нуувчнаас бидэн рүү буудаж манай хоёр цэргийг хөнөөсөн бөгөөд буу нь одоо болтол халуунаараа байлаа. Манайхан тэднийг хариуд нь хороох шинжтэй байв. Хариуцсан офицерийн хувьд надад өөрийн цэргүүддээ тэднийг гэмтээлгүйгээр төв рүүгээ аваачихыг шаардана гэдэг хэцүү байлаа.

Дараа нь би түрүүчээ тэднийг байцааж байхдаа доромжлохыг нь болиулах ёстой болсон юм. "Чи дайны дүрэм журмыг мэдэхгүй юу?" гэж би чанга дуугаар хэлэв. Тэр над руу хялалзан харлаа. "Би ердөө л түүнээр үнэнийг хэлүүлэх гэсэн юм" гэж тэр хэлэв. "Тэд зүгээр л худлаа яриад байна. Бидэнд хэрэгтэй өчүүхэн ч мэдээлэл өгөхгүй байна" гэв.

Түүний зөв байсныг би мэдэж байлаа. Бид тэднээс мэдээлэл авах хэрэгтэй байлаа. Тэднийг олзлогдогсдын хуаран руу явчихаар бид тэднээс мэдээлэл авч чадахгүй болох байлаа. Бид мэдээлэл авах ёстой байлаа. Би өөрийгөө хязгаарлахаа болив. Би эрэгтэйг нь аваад байшингийн ард очив. Тэр татгалзсаар л байлаа. "Чи ярь, үгүй бол үх" гэж би хашгирлаа. Би мод руу хий буудаад тэр эрэгтэйг нууж орхив. Тэгээд би эмэгтэйг гаргаж ирээд духанд нь буугаа тулгаад:
*Найз чинь худлаа ярьсан; тиймээс би түүнийг буудсан. Чи үнэнийг хэлэхгүй бол би чамайг ч мөн буудах болно. Танай босогч найз нар хаана байна? Тэд зэвсгээ хаана нуудаг вэ?*

Тэд зүгээр л загасчилж явсан, тэгээд автомат буунаас зугтаж нуувчинд орсон гэж тэр хэлэв. Би гэмгүй хүн гэсэн шиг харж буй түүний нүднээс нулимс бөмбөрч байлаа.
*Бид энэ эмэгтэйг болон түүний зэвсэглэсэн найзыг барьж авсан. Гэм буруу тэдний нүүрэн дээр бичээтэй байлаа. Тэд гэм буруутай байх ёстой. Гэвч би гэнэтхэн тийм ч итгэлтэй байхаа болив.*

*Дэслэгчийн оронд байсан бол юу хийх вэ?*

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- *Олзлогдогчдын нэг*
- *Тэднийг байцаасан түрүүч*
- *Энэ бүгдийг харж буй бусад цэргүүд*
- *Найз нь энгийн иргэний дүрд хувирсан байлдагчид алуулсан цэрэг*
- *Армийн зурагчин*
- *Төв штаб дээр байгаа дэслэгчийн удирдагч*
- *Дайсны цэргийн удирдагчид*

Эх сурвалж:: Девид Донованаас авсан, *"Нэгэн цагт Байлдагчдын Хаан байсан нь"* хэмээх Вьетнамд байсан офицерийн дурсамжуудаас ишлэв. МкГроу – Хилл, Нью – Йорк, 1985 он.

# Энэ машиныг бид яах вэ?

Бидний найман эрх чөлөөний тэмцэгчид, жижиг оврын Тоёота жийпэнд хилийн зурвасаар оруулж ирсэн зэвсгүүдтэйгээ хамт чихцэлдэн явж байлаа. Тосгоны ойролцоо очиход 12 орчим насны нэг хүү биднийг тосоод сандран гүйж ирэв. Тэр өглөөжин тосгоны дээгүүр онгоцнууд эргэлдэн ойролцоох газруудыг бөмбөгдсөн тухай бидэнд хэлэв.

Бид машинаа агаараас харагдахааргүй газар модон дунд тавилаа. Тэгээд 4 онгоц дээгүүр эргэлдэж байгаад 2 км хиртэй газар тосгоны дээрээс бөмбөгдөхийг харав. "Тэнд миний гэр байгаа шүү дээ" гэж дарга маань хэлж байлаа. "Дайснууд хилийн зурвасыг хааж, юу ч үлдээхгүйн тулд бүгдийг газартай тэгшлэхийг оролдож байна. Тосгоны зарим хүмүүс уул руу дүрвэсэн, гэвч олон хүн гэртээ үлдсэн байгаа."

Дайсны онгоцнууд эргэлдэн улам доогуур ирэв. Энэ удаа 500м—н зайд бөмбөг дэлбэрлээ. Тосгоноос 2 хүн бидэн рүү хашгирсаар гүйж ирлээ.

*Та нар явах хэрэгтэй, хүүхдүүд маань энд байна. Хэрэв онгоцнууд та нарын машиныг харчихвал биднийг бөмбөгдөх болно. Тэд чамайг энд байгааг мэдэх болно, яагаад гэвэл эсэргүүцэн тэмцэгчид л жийптэй байдаг.*

Тэмцэгчдийн маань нэг тайвшруулан ингэж хариулав.

*Чи хүүхдүүдээ аваад талбай руу яв. Бид яг одоо машиныг эндээс хөдөлгөж чадахгүй. Хэрэв тэгвэл онгоцнууд харчихна. Бид машинаа тэднээс нуун модон дунд тавьсан байгаа. Бид танд туслахаар тэмцэж байна — Таны аюулгүй байдал, таны эрх чөлөөний төлөө.*

*Хэрэв чи биднийг одоо явуулж бид алагдвал чи дайсанд тусалсан болно. Чиний үүрэг бол орогнох байр эсвэл бөмбөгний халхавч ухаж эмэгтэйчүүд хүүхдүүдээ аюулгүй байлгах явдал юм.*

**Эсэргүүцэн тэмцэгчдийн оронд байсан бол юу хийх вэ.**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Тосгоны удирдагч
- Тосгоны бусад иргэд (залуучууд, хүүхэд, хөгшид)
- Эсэргүүцэн тэмцэгч—дийн ахлагч

Эх сурвалж::Жан Гүүдвинээс авсан, "*Тулааны гал дунд гарцгүй хоцорсон нь*", Е. П. Даттон, Нью—Йорк, 1987 он.

# Би тосгон руу гал нээнэ гэж үү?

Өглөө эрт, манай танкны цуваа болон бусад машин тэрэг хотын олон хүнтэй хэсгийн зам руу ороод явж байлаа. Бидний зүүн талаар нисэх баазын төмөр хашаанууд, баруун талд урт нарийн тосгоны байшингууд үргэлжилж байлаа. Бид байдлыг ажиглахаар зогсов. Энд нэг л бишээ гэж хэлэн найз маань дотогшоо оров. Холбоочин маань над руу эргээд энэ газарт маш олон босогчид нуугдаж байгааг мэдээгээр ярьж байсан тухай хэлэв.

Дотор, танкны буучин болохоор надад бүх юм тодорхой харагдаж байлаа. Тоос шороо, өглөөний бүрхэг манан байсан хэдий ч манай салаа, машинуудын эсрэг талд тосгоны байшингууд дунд байгаа зүйлсийг харж байлаа. Тэдгээр нь яах аргагүй зэвсэглэсэн биетүүд байсныг тод харж байв.

Хэн нэгэн гал нээхийг тушаав.

**Танкны буудагчийн хувьд юу хийх вэ?**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Тосгон дахь дайсны цэргүүд
- Тосгоныхон
- Буудагчийн цэрэг нөхөд
- Түүнийг удирдагч офицерууд

Эх сурвалж: Дваит В. Бөрдуэлээс авсан, *"Зуун милийн бартаат зам"*, 1967 – 68, Пресидио, Сан Франциско, 1985 он.

# Дилемманы дасгалын хүснэгт

| | |
|---|---|
| **Асуудал:** | |
| Үйлдэл: | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| Үйлдэл: | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| Үйлдэл: | |
| Дэмжих нь: | Эсэргүүцэх нь: |
| Шийдвэр болон түүнийг сонгосон шалтгаан: | |

Хүснэгтийн ар талыг ашиглаж болно.

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**1** Аливаа халдлага нь байлдагчид болон цэргийн байнуудаар л хязгаарлагдах ёстой.

1.1 Энгийн иргэд рүү дайрч болохгүй.
1.2 Энгийн иргэдийн обьектууд руу (байшин, эмнэлэг, сургууль, мөргөлийн газар, соёлын буюу түүхийн хөшөө дурсгал гэх мэт) дайрч болохгүй.
1.3 Цэргийн байны бамбай болгон энгийн иргэдийг ашиглахыг хориглоно.
1.4 Байлдагчдыг энгийн иргэдийн дүрд хувирахыг хориглоно.
1.5 Энгийн иргэдийн өлсгөлөнг дайтах арга болгон хэрэглэхийг хориглоно.
1.6 Энгийн иргэдийн амьд үлдэхэд зайлшгүй шаардлагатай обьектүүд рүү (хоол хүнс, тариалангийн талбай, ундны усны байгууламж гэх мэт) дайрахыг хориглоно.
1.7 Хэрэв энгийн иргэдэд ихээхэн хэмжээний хохирол учруулах бол усны далан, хаалт буюу атомын цахилгаан станц руу дайрахыг хориглоно

**2** Энгийн иргэд ба цэргийн обьектууд болон хүмүүсийг ялгаварлахгүйгээр хөнөөдөг, үлэмж хохирол, зовлон учруулах аливаа дайралт буюу зэвсгийг хориглоно.

2.1 Химийн болон биологийн, нүд сохлогч лазерын зэвсэг, хүний биед рентгений туяагаар илэрдэггүй хэлтэрхийнүүдээр гэмтэл учруулах зэвсэг, аливаа хорт бодис, хүний эсрэг газрын мина зэрэг тодорхой төрлийн зэвсгүүдийг хориглоно.
2.2 Амьд хүн үлдээхгүйгээр устгахыг заналхийлэх болон тушаахыг хориглоно.

**3** Энгийн иргэд, шархадсан байлдагчид болон хоригдлуудыг өршөөн хамгаалж, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.

3.1 Ямар ч хүн биеийн болон сэтгэл санааны тамлал, бие махбодийн шийтгэл буюу харгис эсвэл гутаан доромжилсон харьцаа эдлэх ёсгүй.
3.2 Сексийн хүчирхийллийг хориглоно.
3.3 Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрдсийн эрхшээлд байгаа эсрэг талын шархадсан болон өвчтэй дайсанд халамж үзүүлэх, тэднийг хайж олох ёстой.
3.4 Бууж өгсөн буюу дайнд оролцохооргүй болсон дайсныг хороох буюу шархдуулахыг хориглоно.
3.5 Хоригдлуудыг хүндэтгэн, тэдэнтэй хүнлэг ёсоор харьцах ёстой.
3.6 Хүн барьцаалахыг хориглоно.
3.7 Энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. —"Үндэстэн угсаатны цэвэрлэгээ"—г хориглоно.
3.8 Дайсны гарт байгаа олзлогдсон хүмүүс нь гэр бүлийнхэнтэйгээ мэдээлэл солилцох, хоол хүнс, эмнэлгийн халамж болон сэтгэл санааны дэмжлэг гэх мэт хүмүүнлэгийн тусламж авах эрхтэй.
3.9 Жирэмсэн эмэгтэй, нярай эх, харгалзагчгүй хүүхэд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэн тусгай хамгаалалтанд байх ёстой.
3.10 ОУХЭЗ нь 15—аас доош насны хүүхдүүдийг цэргт татах буюу цэргийн үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
3.11 Хүн бүр шударгаар шүүгдэх эрхтэй (шударга шүүх, хэвийн процедур гэх мэт). Хамсруулан шийтгэхийг хориглоно.

# Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүд юу вэ?

**4 Эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс, байгууламжуудыг (эмнэлэг, клиник, түргэн тусламж гэх мэт) хүндэтгэн үзэж хамгаалан, тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь боломжит бүхий л тусламжаар хангах ёстой.**

**4.1 Улаан Загалмай буюу Улаан Хавирган Сарын эмблем, таних тэмдгүүд нь эрүүл мэндийн үйлчилгээний хүмүүс болон байгууламжуудын хамгаалалтыг билэгдэнэ. Ийм тэмдэгтэй хүмүүс буюу обьект руу дайрахыг хориглоно. Түүнчлэн энэхүү тэмдгүүдийг хуурамчаар ашиглахыг хориглоно.**

**4.2 Эрүүл мэндийн нэгжүүд болон тээвэрлэлт нь дайсны талд хор уршиг учруулах аливаа үйлдэл хийхийг хориглоно.**

**4.3 Шархадсан болон өвчтэй хүмүүсийг эмчлэхэд, эрүүл мэндийн байдлаас нь бусад тохиолдлоор давуу эрх олгохыг хориглоно.**

## Тодорхойлолтууд

**Дагалдах хохирол**: энгийн иргэд амь насаа алдах, бэртэх, эд зүйлсийн хохирол амсахаас хамгаалах, түүнчлэн хохирлыг аль болох багасгах урьдчилсан арга хэмжээ авсан хэдий ч үйлдсэн довтлогооноос тохиолдлоор үүссэн гарз хохирол

**Байлдаанд оролцохоorгүй болсон этгээд:** олзлогдсон, шархадсан, өвчтэй эсвэл хөлөг онгоц нь сүйрэлд өртсөний улмаас дахин байлдах боломжгүй болсон байлдагчд

**Энгийн иргэд:** байлдагч бус бүх хүмүүс. (Сэжиглэгдсэн үед ч гэсэн тухайн хүн энгийн иргэнд тооцогдоно.) Хэрэв энгийн иргэд, дайсагнагч талуудын аль нэгний талд орж, ямар нэгэн дайсагналын үйлдэл хийвэл дайтагч болж хувирах ба хамгаалагдах эрхээ алдана.

**Энгийн иргэдийн обьектууд:** цэргийн бай болоогүй бүх обьектууд. Хэрэв энгийн иргэдийн обьект нь цэргийн үйл ажиллагаaг дэмжих зорилгоор ашиглагдвал тэдгээр нь цэргийн бай гэж тооцогдох ба хамгаалалтаа алдана.

**Байлдагч:** зэвсэгт хүчний гишүүн буюу цэргийн үйл ажиллагаанд шууд оролцож буй хүн

**Цэргийн бай**: Шинж чанар, байрлал, ашиглагдах зорилгоороо цэргийн үйл ажиллагаанд үр ашигтай хувь нэмэр оруулж буй, учруулсан хор хөнөөл нь тодорхой зэвсэгт хүчний давуу талыг олгож байгаа байлдагчид болон обьектууд

# Судалгаа 3 С. Хэн хариуцлага хүлээх вэ?

3А ба 3В бүлгүүдэд сурагчид ОУХЭЗ—г байлдагчид яагаад зөрчдөг тухай болон нэг зөрчил хэрхэн зөрчлөө төрүүлдэг тухай судалсан. 3С бүлэг нь хөтөлбөрийн эхэн үеэс л яригдаж эхэлсэн асуулттай холбоотой: ОУХЭЗ—н мөрдөгдөж байгаа эсэхэд хэн хариуцлага хүлээх ёстой вэ? Хариултыг олохын тулд сурагчид 3 тивийн цэргийн удирдагчдаас олж авсан мэдэгдэл, баримтуудыг судлах болно.

**Зорилго:**

- Байлдагчдын дундаас хэн нь уг дүрмүүдийг мөрдөгдөж байгаа эсэхэд хариуцлага хүлээх үүрэгтэйг мэддэг болох
- Уг үүргийг хэрхэн биелүүлэхийг тодорхойлох

**Ашиглах мэтериалууд**

- Унших: Хэн хариуцлагыг хүлээх вэ?

**Хугацаа:**

- 45—60минутын нэг хичээл

**1. Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх**
(5 минут)

Асуултад хариулахтай холбоотой санал бодлоо жагсааж бичнэ үү:

➤ Байлдагчид уг дүрмийг сахихын тулд юу хийх хэрэгтэй вэ?

*(Жишээ нь: уг дүрмийн тухай мэдлэг, дүрмийн сургалт, хууль бус даалгавар өгдөггүй, үлгэр дууриал болдог удирдагчид, шархадсан олзны хүнийг зөөх тусламжийн нисдэг тэрэг зэрэг тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг бааз, дүрэм зөрчигчид шийтгэгддэг гэдгийг мэдэх гэх мэт)*

Тэгээд жагсааж бичсэн хувилбар бүрт дараах асуултыг тавина:

➤ Түүнийг хэн хийх ёстой вэ?



**2. Дүрэм журмыг сахин мөрдөх үүрэг.**
(3 бүлэг) (20 минут)

"Хэн хариуцлага хүлээх вэ?" унших сэдэвт дүн шинжилгээ хийхийн тулд бүлэг бүрт дараах зүйлсийн аль нэгийг даалгана:

- Офицеруудын үүрэг хариуцлагыг жагсааж бичих
- Цэргүүдийн үүрэг хариуцлагыг жагсааж бичих
- Засгийн газрын үүрэг хариуцлагыг жагсааж бичих

Бүлэгүүдийг олж мэдсэн зүйлүүдийх нь талаар дахин хэлэлцүүлнэ.

Уншсан зүйлтэйгээ уялдуулан тэдний дэвшүүлсэн саналуудыг ярилцана.

**Цэргийн дарга 1**: *ОУХЭЗ—н үндсэн дүрмүүдийг сахин мөрдөхгүй байх нь* бидний үйл хэргийг *доголдуулах бөгөөд ноцтой* үр дагаваруудыг *үүсгэдэг.*

Гол ойлголтууд: Хүрэх арга зам ба үр дүн, учир шалтгааны найдвартай байдал, хувийн сонирхол, олон нийтийн санаа бодол, төсөөлөл.

**Хурандаа 2:** *Бид байлдааны үед* үйл ажиллагааны тушаал *өгөхдөө хүмүүнлэгийн бүх талыг тооцож үзэх ёстой.*

Гол ойлголтууд: Цэргийн төлөвлөлт, олзны хүмүүс, шархадсан дайсанд үзүүлэх эмнэлэгийн тусламж, дагаж мөрдөх байдал

**Хурандаа 3:** *Цэргийн дарга нар* дүрмүүд ёсчлон мөрдөгдөж байгаа эсэхийг хянах *үүрэгтэй. Үүний тулд* бэлтгэл сургууль, нарийн чанд сахилга бат *шаардлагатай.*

Гол ойлголтууд: Хэрэгжүүлэлт, үүрэг хариуцлага, бэлтгэл сургууль, сахилга бат

**3. Орон нутгийн байдал.** (10 минут)

Хэлэлцүүлэг:

➤ Эдгээр цэргийн удирдагчдын саналууд нь цэргээс гадуур байгаа хүмүүсийн аж байдалтай нийцэж байгааг харуулсан ямар жишээнүүд байна вэ? Сайн болон муу удирдлагын тухай жишээ гаргаж чадах уу?

➤ "Хүрэх арга зам" нь зөвшөөрөгдөхөөргүй байхад "үр дүн" зөвшөөрөгдөж болох уу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад? Хэн нэг удирдагчийн зорилго нь түүний хүмүүсийн юу хийснээс нь шалтгаалан үгүйсгэгдэж болох уу?

**4. ОУХЭЗ–д харшлах даалгавар авсан цэрэг яах вэ?** (5 минут)

Энэ бол дараагийн хичээлүүдэд ярилцах хүндэвтэр асуулт юм. Хэдий тийм боловч тиймэрхүү үүрэг даалгавар нь хууль бус бөгөөд цэргүүд ОУХЭЗ–г зөрчиж буй тушаалыг дагахгүй байх үүрэгтэй гэдгийг сурагчид мэдэж байх хэрэгтэй.

**Хаалт:** (5 минут)

Цэргийн дарга нарын хэлсэн эдгээр мэдэгдлүүдийг бодолцоно уу:

*Дайн бол эцсийн найдвар. Хүмүүнлэгийн эрх зүйгүй бол хонгилын үзүүрт гэрэл харагдахгүй гэсэн үг.*

➤ "Хонгилын үзүүрт гэрэл харагдахгүй" гэдгээр юу хэлж байна вэ? Яагаад энэ чухал гэж?

*Хэрэв чи дайсандаа нэр төртэйгээр ялагдах боломж олговол, тэд эцсийн хүнтэй нь тулалдах хүртлээ байлдах хэрэггүй гэдгийг мэдэрнэ. Үүнд дүрмүүдийн утга учир оршино.*

➤ Дайсандаа нэр төртэйгээр ялагдах боломж олгох нь эргээд энх тайван байдалд шилжихэд яаж нөлөөлдөг вэ? Энэ санаа нь өдөр тутмын амьдрал дахь хэрүүл маргаанд хэрэгжих үү? Тийм бол, яаж? Үгүй бол, яагаад?

**ГОЛ САНААНУУД:**

- ◆ ОУХЭЗ–г хүндэтгэн сахихад олон хүний гүйцэтгэх ёстой үүрэг хариуцлага гэж бий. Хэдийгээр ганц хүн дангаараа ОУХЭЗ–г зөрчиж чадах боловч, уг эрх зүйг хүндэтгэн сахиж буйг баталгаажуулахад засгийн газрын түшмэлүүд, цэргийн удирдагчид, байлдагч зэрэг хүмүүсийн хамтын хүчин чармайлт шаардлагатай.
- ◆ ОУХЭЗ–г хөхиүлэн дэмжих нь аливаа үндэстний эрхэм дээд эрх ашигт нийцнэ.

## Нэмэлт дасгал

**Эссэ бичих**

Дараах асуултын дагуу 2 ба 3—р бүлэгт үзсэн зүйлсээ ашиглан товч эссе бичнэ үү:

➤ Улс орнууд ба цэргийнхэн яагаад ОУХЭЗ—н дүрмүүдийг дагаж мөрдөхийг зөвшөөрдөг вэ?

**Байлдагчийн гарын авлага**

Байлдагчид биедээ авч явахад тохирсон жижигхэн "Сануулагч" гарын авлага зохионо. Тэдний сахиж мөрдөх ёстой ОУХЭЗ—н үндсэн дүрмүүдийг энгийн зургаар илэрхийлээрэй.

(зурагнууд)









# Хэн хариуцлага хүлээх вэ?

Зэвсэгт мөргөлдөөний үед болж буй үйл явдлуудын гол үүрэг хариуцлага нь дайн тулааныг үүсгэж буй байлдагчид болон тэдний удирдагчдын (улс төрийн болон цэргийн) гарт байдаг. Аливаа улс ОУХЭЗ—н гэрээнд нэгдэхдээ, өөрийн хүмүүсийг ОУХЭЗ—г сахиж мөрдөхийг шаардсан өөрийн хууль дүрмээ батлан хэрэгжүүлэх тухай саналыг хүлээн зөвшөөрдөг. ОУХЭЗ—н үндсэн дүрмүүдийн дагуу цэргүүдээ сургаж бэлтгэх болон өөрсдийн цэргийн үйл ажиллагааны удирдлага ба төлөвлөгөөндөө ОУХЭЗ—г чандлан баримтлахаа амладаг байна.

Гурван өөр тивийн ижил түвшний 3 цэргийн удирдагчдын үзэл бодлыг бодолцож үзнэ үү.

**Цэргийн дарга 1 (Эл Сальвадор):**

*Бид цэргүүддээ тэдгээрт үндсэн зарчмыг баримтлах, зөрчсөн хүмүүст сахилгын хатуу шийтгэл оногдуулж байхыг заавар болгосон. Ямар нэг алдаа бидний үйл хэргийг доголдуулж болохыг бид мэдэж байсан. Хэрэв би, цэргийн даргынхаа хувьд, тийм алдаа хийсэн бол энэ нь илэрхий ноцтой үр дагаваруудыг бий болгох байсан. Бид ямарч хүнд хэцүү нөхцөлд дүрмээ сахиж байхыг бүх цэргүүдээсээ шаарддаг байв.*

- ➤ ОУХЭЗ—г баримтлаагүйгээс босогчдын үйл ажиллагаа хэрхэн нурж болох вэ?
- ➤ "Хүрэх арга зам" нь үл зөвшөөрөгдөхөөр бол "үр дүн" зөвшөөрөгдөх боломжтой юу? Яагаад тийм, яагаад үгүй вэ?
- ➤ Удирдагчийн зорилго гүйцэтгэгчиддээ ямар үүрэг өгснөөс хамаараад үгүйсгэгдэж болох уу?
- ➤ ОУХЭЗ—г зөрчихөөс зайлсхийх явдалд түүний гаргасан саналууд ямар хувь нэмэр үзүүлэх вэ?

**Хурандаа 2 (Иордан):**

*Биднийг дайнд явахад бүхий л үйл ажиллагааны зааврыг бичсэн цаас өгдөг байлаа. Бид өөрсдийн үүрэг даалгавартаа бүхий л талын хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой үүргүүдийг оруулах ёстой байлаа. Жишээ нь, дайны хоригдлуудыг хааш нь нүүлгэн шлжүүлэх, яаж харьцах, тэднээс юу авах, шархдагсдыг хааш нь шилжүүлэх вэ зэрэг орно.*

- ➤ Яагаад цэргийн удирдагчид цэргийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд хүмүүнлэгийн энэ асуудлуудыг тусгах шаардлагатай байдаг вэ?
- ➤ Тийм төлөвлөгөөний ямар жишээнүүд байна вэ?

**Хурандаа 3 (Зимбабве):**

*Дайны үед уг дүрмүүд дагаж мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт тавих хүмүүс нь ахлах дарга нар байдаг. Тэд, дүрмүүд мөрдөгдөж, нарийн чанд сахилга бат, бэлтгэл сургуулийн дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.*

*Цэргүүд хэрэв зөв бэлтгэгдсэн бол ёс суртахуун өндөр, сахилга бат сайн байх хэдий ч — тэд энгийн иргэдийг хөнөөх байлаа, яагаад гэвэл энэ нь дайны нөхцөл дэх амьдралын үнэн юм. Гэвч энэ нь утга учиргүй аллага болохоос өмнө үүнийг зогсоодог туслах удирдагчидын хяналт юм. Хэрэв таны дарга нар дүрмүүдийг ойлгохгүй, хэрэгжүүлэхгүй байгаа бол, мөн цэргүүдээс үүнийг дагаж мөрдөхийг шаардахгүй байгаа бол чамд зэрлэг амьтдын сүрэг шиг дайны талбар дахь ёс журамгүй бүлэг хүмүүсээс өөр юу ч байхгүй гэсэн үг.*

*Сайн дарга нар сайн цэргүүдтэй байдаг. Энэ нь сайн цэргүүд сайн даргатай байдаг гэсэн үг биш юм. Чамд энэ дэлхий дээрх хамгийн сайн цэргүүдийг өгсөн ч чи тэд нарыг тэнэгүүд болгож чадах бөгөөд тэд ч 7 хоногийн дотор ёс журамгүй хүмүүс болон хувирч чадна. Харин ямар ч чадваргүй цэргүүдэд маш сайн дарга өгвөл тэд өдрийн дотор л сайжирч эхэлнэ.*

- ➤ Тэр яагаад бэлтгэл сургууль, нарийн чанд сахилга бат хэрэгтэй гэж байна вэ? Ямар бэлтгэл, ямар дэг журам?
- ➤ Офицерийн зан байдал нь яагаад чухал байдаг вэ?

## Хэргийн судалгаа: Ми Лай – Юу нь буруутсан? юу нь зөвтсөн?

Энэхүү сонголтот ажил нь ОУХЭЗ–г ноцтой зөрчсөн түүхэн үйл явдлын тухай судалж үзэх бөгөөд энэ дуулиант хэрэг явдлыг судалснаар сурагчид ОУХЭЗ–н хүрээнд аль нь зөв, аль нь буруу байсныг ойлгох болно. Сурагчид болсон үйл явдалд нөлөөлсөн байж болзошгүй хүчин зүйлүүд, цэргүүдэд тулгарсан дилемманууд, тэдний гаргасан янз бүрийн шийдвэрүүд болон тэдгээрийн үр дагаваруудыг шинжлэн судлах болно.

Ерөнхий ойлголтуудыг 3С бүлэгт товч танилцуулсан бол энэ судалгаагаар хэрэгжилтэнд саад болж буй бодит байдлуудын тухай (байлдагчдын бэлтгэл бургууль, сүүлийн үеийн дайны эргэн тойрны мөн чанар, "ердөө л энгийн иргэн" гэж хэн болох тухай, хууль бус тушаал өгөх зэрэг) баримт материалыг ашиглан тэдгээр ойлголтуудыг улам нарийвчлан тайлбарлана. Энэхүү судалгаагаар хэрэгжүүлэх асуудлуудыг хууль схиулах үйл хэрэгтэй холбож өгөх бөгөөд аль нэг улс өөрийн цэргүүдээс хэн нэгэнд зохих шийтгэлийг оногдуулах үед тулгарч буй хүндрэлүүдийг олж мэдэх болно.

**Зорилго:**

- Хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчилтэй тулгарсан үед жирийн хүмүүсийн аж байдалд гарч болох олон янзын нөлөөллийг мэдэж авах
- ОУХЭЗ–г хэрэгжүүлэх ба сахиулахтай холбогдсон зарим асуудлууд, дилеммаг ойлгох

*146–р зүйл.*

*Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд нь дараагийн зүйлд тодорхойлсон энэхүү конвенцийн ноцтой зөрчлийг үйлдэж байгаа буюу үйлдэхийг тушаасан этгээдэд үр дүнтэй эрүүгийн ял хүлээлгэхэд шаардлагатай аливаа хууль тогтоомжийг батлан гаргах үүрэг хүлээнэ.*

*Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр ийм ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан гэж буруутгагдаж байгаа хүмүүсийг эрж олох, түүний харъяаллыг үл харгалзан өөрийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээнэ.*

Женевийн 4–р Конвенц

**Ашиглах материалууд:**

- Мэдээллийн хуудас: Ми Лай дахь үйл явдал – Түүх
- Танилцуулах картууд
- MACV халаасны карт ба тушаалын шуурхай хэлхээ
- Дүрс бичлэг: Ми Лай–д бид юу хийчихэв?
- "Юу болсон" картууд
- Мэдээллийн хуудас: Ми Лай дахь үйл явдал – хожим нь
- Ерөнхийлөгчид бичсэн захидлаас
- Дилемманууд:

Өршөөл энэрэл байсангүй
Би юу хийх ёстой вэ?
Би юу гэж тайлагнах вэ?

**Хугацаа:**

45–60 минутын 2–3 хичээл

**Бэлтгэл ажил:**

"Танилцуулах" карт болон "Юу болсон" картуудыг хүн бүрт тарааж өгөхөөр бэлтгэнэ.

**1–Р ХЭСЭГ**

**1. Өөрийн биеэр тэнд байх нь** (15 минут)




Сурагчдад 1968 оны Вьетнамын дайны үед байна гэж төсөөлөхийг даалгана.

"Ми Лай дахь үйл явдал – Түүх"–ийн 1–р хуудсыг сурагчдад танилцуулна.

# Хэргийн судалгаа: Ми Лай – Юу нь буруутсан? юу нь зөвтсөн?

**Боломжит асуултууд:**

➤ Энэ мэдээллээс Чарли бүлгийн цэргүүдийн тухай юу мэдэж авав?

➤ Дараагийн өдрийн төлөвлөгөөг сонсоод тэдгээр цэргүүд юу бодож, мэдэрч байсан гэж бодож байна? Яагаад?

Сурагчдаар 1968 оны 3–р сарын 15–ны тэр шөнө Чарли бүлгийн нэг хэсэг нь байна гэж төсөөлүүлнэ. Танилцуулах картуудыг тарааж өгнө.

**2. Цэргүүд хэрхэн бэлдсэн тухай** (20–30 минут)

Сурагчдаар 3–р сарын 16–ны дайралтын урьд шөнө цэргүүдийн тэмдэглэлдээ бичсэн байж болох зүйлсийг харуулсан танилцуулах картуудаас 2 асуултанд хариулт бичүүлнэ. Уг явдалд оролцогч байх талаас нь судлахад зориулж сурагчдад хангалттай цаг гаргаж өгнө үү.

Тэр шөнө цэргүүдийн бодож байсан зүйлсийг сурагчид хэрхэн төсөөлж буй тухай ярилцаарай. Сурагчид уг цэргүүдийн дүрд тоглож болно.

Вьетнамд байсан Америк цэргүүдэд өгдөг байсан "MACV халаасны карт" – Картыг үзүүлээд, картны агуулга болон зорилгын тухай ярилцана.

➤ Тэднийг ямар байх хэрэгтэй талаар өөр ямар заавар цэргүүдэд өгсөн байж болох вэ?

**3. Цэргүүд хэрхэн давж гарсан бэ?** (40–60 минут)

"Ми Лай дахь үйл явдал – Түүх" хэсгийн 2 дахь хуудас болох "3 сарын 16–ны өглөө"–г уншуулна. Тэгээд "Ми Лай–д бид юу хийчихэв?" дүрс бичлэгийг үзүүлээрэй.

Уг кино нь тэнд байсан 8 цэргийн дурдатгал, Ми Лай дахь туршлагыг харуулна. Сурагчид тэдгээр цэргүүд энгийн иргэдийг юу гэж бодсон, тушаал даалгаврын нөлөө болон хяналтаа алдах явдал, цэргүүдийн хийсэн сонголт зэргийг энэ киноноос үзэх болно. Мөн цэргүүд тулаанд хэрхэн бэлтгэгдэж байгааг харна. (30 жилийн дараах бэлтгэгдэж байгааг харуулсан зураг ч байгаа.)

Кино үзсэний дараа юу гарсан, юу болсон тухай ярилцана.

> Жич: Уг кинонд 5 сэдэв гарах бөгөөд эдгээр нь болсон зүйлд үзүүлж буй оролцогчдийн хариу үйлдэл, үүнтэй холбогдсон байдлуудыг тусгаж буй 5 хэсэгт задарч байна. Хэсэг бүрийн эхэнд нисдэг тэргээр зөөгдөж буй цэргүүд гарна.

1. Бэлтгэл (Түрүүч Ходжесийн дуу хоолой)
2. Бид, дайснууд болон хэн нь дайсан болохыг тодорхойлох (Бернард, Видмер, Симпсон)
3. Өөрийгөө хянах чадвараа алдах, ёс суртахууны самуурал, үүрэг тушаалуудын утга учир (Бернард, Видмер, Ходжес)
4. Цэргүүдийн хийсэн сонголт (Видмер, Симпсон, Ходжес, Станли, Хайберл)
5. Хөндлөнгөөс ажиглагчид (Томпсон, Колбөрн, Хайберл)

**Хэлэлцэх сэдвүүд:**

- Хохирогчдод тохиолдсон эмгэнэлт явдал
- 3–р сарын 16–ны ажиллагааны өмнөх цэргүүдийн сэтгэл зүйн байдал
- Цэргүүдийн зан үйлд үзүүлж буй нөлөө (Жишээ нь: Бэлтгэл сургууль, дайснууд болон үүрэг даалгаврын тухай ойлголт, өмнөх туршлага)
- Удирдлагын дүр, үүрэг
- Хувь хүн бүрийн өөрийн үйлдэлдээ хүлээх хариуцлага
- Хэрэв энгийн иргэд байлдагчид байсан бол гарч ирэх асуудлууд
- ОУХЭЗ болон Америкийн цэргүүдэд олгогдсон халаасны картууд Ми Лай дахь ажиллагаанд хэрхэн холбогдсон тухай. (төлөвлөгдсөн болон гүйцэтгэгдсэн байдал)



Сурагчдад тэдний сонгож авсан цэргүүдэд зориулсан "Юу болсон" картыг өгөөд тэдний өмнө нь бичсэн тэмдэглэл болон кино, картнуудаас олж мэдсэн зүйлсээ хооронд нь харьцуулах даалгавар өгөөрэй.

*Өөрсдийгөө тийм нөхцөл байдал дунд байгааг төсөөлж харах сэтгэл санааны бэлтгэлтэй, өөрийн гэсэн хүч чадалтай цөөхөн хэдэн хүн л тэр нөхцөлд байж чадсан юм. Миний мэдэх ихэнхи хүмүүс тийм байж чадаагүй. Би тэднийг буруу сонголт хийсэнд гайхаж байлаа. Тэд энэ бүхэнтэй цуг амьдрах ёстой байсан. Би ч ялгаагүй, бид бүгд ч гэсэн.*

– Рон Риденхаур
– Вьетнамын партизан

**Боломжит асуултууд:**

- Яагаад энэ цэргүүд тэдгээр иргэдэд энэ аймшигт хор хөнөөлийг учруулсан бэ?
- Яагаад зарим цэргүүд оролцохоос татгалзсан бэ?
- Хөндлөнгөөс ажиглагч ямар ялгааг бий болгосон бэ?
- Үүрэг даалгаврыг үг дуугүй биелүүлэх нь илүү чухал үе байсан уу?
- Дайны үед хүлцэнгүй байх нь яагаад асуудал үүсгэж байна вэ? Цэргүүд хууль бус тушаалыг биелүүлэх хэрэгтэй юу?
- Цэргүүд хууль бус гэж юу болохыг хаана / яаж сурдаг гэж бодож байна вэ? (Жишээ нь: гарын авлага, бэлтгэл бургууль, бусад цэргүүдээс, дайны талбарт хийсэн ажиглалтаас гэх мэт.)
- Ми Лай–д 3 сарын 16–нд болсон эмгэнэлт явдал шиг үйл ажиллагаанаас хэрхэн сэргийлж болох вэ?

**4. Одоо юу болох ёстой вэ?** (10–15 минут)

Сурагчдад 2 дахь тэмдэглэлээ бичихийг даалгана. Энэ удаа 3 сарын 16–ны шөнийн тухай үүрэг даалгавар авсан хүний талаас нь сурагч бүр алан хядлага болсны дараа юу хийх байсан тухайгаа бичих хэрэгтэй.

Хэлэлцэнэ үү:

- Сурагчид юу бичсэн талаар
- Янз бүрийн хүмүүс хожим нь үнэхээр юу хийсэн тухай
- Хувь хүмүүс юу хийх, яагаад хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ? (Бүх хүмүүс, үүрэг даалгаварын гинжин хэлхээ)

Судална уу:

- Алан хядах үйл ажиллагааны байлдагчдад үзүүлэх богино болон урт хугацааны нөлөө
- Америкийн нэгдсэн улсын цэрэг дайны хүчин чармайлт дахь богино болон урт хугацааны нөлөө
- Хууль зөрчигчдийг шүүхэд чиглэгдсэн арми доторх үндэслэл, сэдэл
- Үйл явдлыг нуун далдлахад чиглэгдсэн арми доторх үндэслэл, сэдэл

**2–Р ХЭСЭГ**

### 1. Шударга ёсыг эрэлхийлэх нь (20–30 минут)

"Ми Лай дахь үйл явдал – хожим нь"–ын тухай ярилцана. Арми дотор юу болсон бэ? (Хуудас 1)

Америкын Нэгдсэн Улсын цэргийн удирдамж №20–оос авсан дараах ишлэлийг танилцуулж хэлэлцүүлнэ үү.

> *Мэдээлэл сайтай байх буюу ямар нэгэн үйл явдлын эсвэл удирдаж буй офицертоо аль болох түргэн мэдээлж болохуйц дайны үйл хэрэгтэй холбоотой гэж үзсэн үйлдлүүдийн тухай мэдээллийг олж авах нь бүхий л цэргийн ажилтнуудын үүрэг юм. Ажилтан (... ) үүргээ гүйцэтгэж байхдаа дайны үйл хэрэгтэй холбоотой гэмт хэргүүдийг олж илрүүлэхэд бүх хүчээ дайчлах бөгөөд гол баримт мэдээг дарга нартаа илтгэж байна. Дайны гэмт хэргийг илрүүлсэн хүмүүс биет нотолгоог хадгалах, гэрчүүдийн мэдүүлсэн зүйлсийг тэмдэглэж авах, орчин байдлыг нь хуулбарлаж авах (Зургийн аппарат, үлгэрчилсэн зураг, тайлбар зэргээр) гэх мэт ажлуудын хүрээнд боломжит бүхий л арга хэмжээг авах болно.*
>
> – Пеерсийн тайлан

Сурагчдийн хооронд ОУХЭЗ–г сахиулахад чиглэсэн дүрмүүд яагаад мөрдөгдөхгүй байгаа боломжит шалтгаануудын тухай брейнсторминг хийнэ. Уг дүрмийг хэн мөрдөж байгаа болон Ми Лай–д болсон явдлыг "нуун далдлах" ажилд хэн илт оролцсон, ямар учраас тэд үүнийг хийх болсон талаар тэдэнтэй ярилцана.

### Боломжит асуултууд:

➤ Хурандаа Хендэрсон, Ахмад Медина эсвэл зурагчин буюу энэ үйл явдлын тухай мэдэж байгаа хүмүүст хандаж юу хэлэх вэ?
➤ Хэнийг буруушааж, шийтгэх хэрэгтэй гэж бодож байна вэ? Ямар хэргийн улмаас, яагаад?
➤ Алан хядлагын тухай цуу ярианууд Вьетнамд байсан бусад цэргүүдэд яаж нөлөөлөх байсан бэ? Тэд энэ талаар юу хийж болох байв?

Тайлбарлах зүйлс:

- *Хувь хүний хариуцлага*
- *Удирдлагын хариуцлага*

**507. Хуулийн эрх мэдлийг бүх нийтийн болгох нь**
(Б) Дайны гэмт хэргээр яллагдсан хүмүүс:
. . . АНУ–ын цэргийн командлагч офицерууд нь дайсны эсрэг өөрсдийн хүчний гишүүдийн үйлдсэн дайны гэмт хэрэгт шуурхай бөгөөд зүй ёсоор шийтгэл оногдуулна.

**508. Эрүүгийн эрх зүйн шийтгэл**
Дайны хуулийг зөрчсөн тохиолдолд оногдуулах шийтгэл нь гэмт хэргийн хүнд хөнгөнд тохирсон байх ёстой. Цаазаар авах ялыг хуулийн ноцтой зөрчлүүдэд оногдуулна.

**509. Удирдлагын тушаал зааврын хамгаалалт**
(А) Дайны хууль нь цэргийн буюу иргэний дээд удирдлагын тушаалыг дагаж мөрдсөнөөр зөрчигдсөн тохиолдолд, тушаал хууль бус гэдгийг мэдээгүй ба мэдэх ямар ч боломжгүй байгаагүй л бол, яллагдаж буй үйлдлийг цэргийн гэмт хэргийн шинж чанараас хасахгүй бөгөөд шүүгдэж буй этгээдийг хамгаалахгүй болно...

*–АНУ–ын армийн Хээрийн удирдлага*

### 2. Хуулийн сахиулалт – Юу нь зөвдсөн? Юу нь буруудсан? (20–30 минут)

"Ми Лай дахь үйл явдал – хожим нь" (Хуудас 2) –н мэдээллийн хуудаснаас "Үр дүнгийн он дараалал"–г үзүүлнэ.

Бүлгийн хагаст нь Ми Лай дахь үйл явдлаас ОУХЭЗ–г сахиулах ажиллагаа ямар байдлаар ХЭРЭГЖИХГҮЙ байгаа жишээнүүдийг, нөгөө хагаст нь ХЭРЭГЖИЖ буй жишээнүүдийг цуглуулан эмхэтгэх даалгавар өгнө.

# Хэргийн судалгаа: Ми Лай – Юу нь буруутсан? юу нь зөвтсөн?

*Тэдний тушаал зөв шударга үед*
*Би дарга нартаа үнэнчээр зүтгэдэг*
*Гэвч, хорон санаа агуулсан бол би тэднийг дагахгүй*
*Трой–д, би өөрийн төрөлх чөлөөтэй байдлыг харуулж*
*Дайсантайгаа нэр төртэйгээр тулалдана.*

– Юрипидесийн Акиллесийн үгнээс

Сурагчдаар ойлгосон зүйлсийг нь яриулна.

*. . . яс үндэс харгалзахгүйгээр хүн дайнд оролцохоороо зэрлэг догшин зан авирт ямар амархан автдагийг бид мэднэ. Тийм зэрлэг догшин авир нь голдуу арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үйлдлүүдэд ажиглагддаг шиг бусдыг үзэн ядах сэтгэлээс үүдэлтэй байдаг. Ямар нэг цэргийн гэмт хэргийг авч үзэхэд хамгийн гол, үндсэн асуудал бол цэргүүдийн үзэж туулсан үхлийн талаарх гүн айдас юм. Дайны үед энэ айдсыг давж гарахын тулд хүмүүс хүч хэрэглэхэд хүрдэг бөгөөд энэ нь эргээд тэдний ёс суртахууныг доройтуулж, улмаар энэ нь хэрцгий догшин зан авир болж илэрдэг байна.*

*– Японы судлаа ч Юки Танака*

Эдгээрийн үйл явдал дахь үүргийг тодорхойлуулна:

- Элсэгчид (Риденауэр, сэтгүүлчид, Томпсон ба түүний баг, мөн Чарли бүлгийн цэргүүд)
- Офицерууд (генерал Пеерс болон армийн прокурорууд)
- АНУ дахь хэвлэл мэдээллийнхэн
- Улс төрчид
- Олон нийтийн санаа бодол
- Цэргийн шүүхийн тангарагтны гишүүд (хэрэгтнүүдтэй ойролцоо түвшний АНУ–н цэргийн офицерууд)

**Боломжит асуултууд:**

- Хүмүүс хууль сахиулалттай холбогдуулан ямар сонголт хийсэн бэ? Яагаад?
- Сонголтуудад өөр үзэл бодлууд ямар нөлөө үзүүлсэн бэ?

**Хаалт :**

Та нар ОУХЭЗ–г хэрэгжүүлэх болон сахиулах ажлын чухлыг болон ярвигтай байдлыг мэдэж авлаа.

– Цаашид үүнээс илүү "зөв хийх"–ийн тулд юу хийж болох талаар ямар саналууд байна вэ?
*(Жишээ нь: Хүмүүнлэгийн эрх зүйг олон нийтэд ойлгуулах ажлыг сайжруулах, дайны гэмт хэргээр шүүгдэгсдийг шүүх ажиллагаандаа олон улсын шүүхийг оролцуулах, зөрчлүүдийг илтгэсэн цэргүүдэд үзүүлэх эерэг хандлага гэх мэт)*

Ми Лай–н тухай хэнд захидал бичих байсан бэ?

Захидлынхаа зорилгыг тодорхойлоод, түүнийг тодотгож өгөхүйц маргаан хэлэлцүүлгийг оролцуулан захидал бичнэ.

**ГОЛ САНААНУУД**

- Байлдагч хүмүүс эрх зүйн бус тушаалыг биелүүлэх албагүй.
- Орчин үеийн байлдааны бодит нөхцөл байдал нь ОУХЭЗ–г хэрэгжүүлэхэд төвөг учруулдаг.
- Хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн өөрийн цэргийн хүчний гишүүдийг шударгаар шүүхэд улс орнуудад бэрхшээл тулгарч болдог.

# Нэмэлт дасгал

**Ятгалгын бичлэг**

АНУ–ын зэвсэгт хүчний прокурор улсынхаа ерөнхийлөгчид бичсэн захидалыг уншина.
➤ Түүний захидлын зорилго нь юу вэ?
➤ Тэр үзэл бодлоо бататгахын тулд ямар баримтуудыг ашигласан бэ?

**Хууль сахиулалтын үед тулгарч буй дилемма**

Хууль зөрчигчдийг яах вэ гэсэн асуултын дагуу офицеруудын тулалдааны үеийн дурсамж дээр тулгуурлан 3 дилемманы нэгийг эсвэл түүнээс олныг судална уу.

➤ Өршөөл энэрэл байсангүй
➤ Би юу хийх ёстой вэ?
➤ Би юу гэж тайлагнах вэ?

**Хэн буруутай вэ? – мэтгэлцээн.**

Дараах саналын талаар мэтгэлцүүл.

*Үйлдэгдсэн дайны гэмт хэргийн талаар мэдэж байгаа хэдий ч илчлэхгүй байгаа хүмүүс уг хэргийн хамсаатан болно.*

**Судалгаа**

Хууль зөрчигчид өөрийн улсын шүүхэд очихоос зайлсхийдэг үү? АНУ–ын цэргүүдтэй холбогдсон байна. Өөрийн улсын ОУХЭЗ–г зөрчигчдыг шүүн шийтгэж байсан тухай АНУ болон бусад улсын жишээ гаргана уу.

**Сэтгэл зүй/түүх**

Ямар нэг үйл явдалд гарч буй хэрцгий явдлуудыг бий болгосон хүчин зүйлсийг шинжилсэн Виллиам Голтийн судалгааг хар.

**Хэрцгий явдлуудыг үүсгэгч хүчин зүйлс ба ойлголтууд**

1. Дайснууд газар сайгүй байна.
(эргэн тойронд нь аюул заналхийлж буй сандарч тэвдсэн цэргүүд)

2. Дайсан бол хүн биш.
("Төлөг" гэх мэтийн нэр томъёо нь дайсны талынхныг хүн бусаар үзэж байсан хандлагуудыг илтгэнэ.)

3. Хувийн хариуцлага гэж байхгүй.
(ямар нэг нэгжийн тодорхой хэсэг нь байж, үүрэг даалгаврыг дагаж мөрдөх нь хэн нэгний биш хамтын хариуцлагыг илтгэнэ.)

4. Дарамт шахалт
(тулалдаанд оролцоогүй байлдааны нэгжүүд ялангуяа мина болон мэргэн буучид шархтануудыг нэмэгдүүлэхэд тэсч чадахгүй болов. Улайрсан цэргүүд утга учиргүй өс хонзон л бодож байна.)

5. Хэрцгий догшин хүмүүсийн ноёрхол
(харгис дайн нь хийсэн үйлдлээ үргэлж магтуулж, удирдлагыг гартаа атгаж байхыг хүсдэг тийм хүмүүст л тохирно.)

6. Галын хүч
(Хөнгөн жингийн M16 секундэд 10 сум буудна. Айн сүрдсэн эсвэл уурлан хилэгнэсэн цэрэг дайсан руу зүгээр л баримжаагаар онилоод аадар бороо шиг гал нээж чадна.)

*– Виллиам Голт "Алан хядлагын тэмдэглэлүүд", сэтгэл судлаачийн сэтгүүл,*

1971 оны 10–р сарын 4, 128–р боть, №4

# Ми Лай дахь үйл явдал – түүх: 3–р сарын 15–ны бэлтгэл

Чарли бүлэг (Ч бүлэг) Вьетнамд 1967 оны 12 сард ирсэн билээ. Тэрээр АНУ–ын цэргийн удирдах ажилтнуудын Вьет Конг бааз болгохоор төлөвлөсөн Куан Нгай муж руу томилогдсон байлаа. Ч бүлэг нь дэслэгч хурандаа Франк Баркерийн удирддаг Баркерийн онцгой хүчний нэг хэсэг юм. АНУ–ын цэргүүдийг газрын мина, далдалж нуусан тэсрэх бөмбөг, мэргэн буучид зэргээр хөнөөж байгаа Вьет Конгийн "Ягаан тосгон" хэмээн алдаршсан газрыг тэд чөлөөлөхөөр ирсэн юм. Ч бүлгийн 120 хүн бүгд АНУ–аас ирсэн бөгөөд тэдгээрийн дундаж нас нь 20 байв. Тэдний бэлтгэлийн 2 цаг нь олзны хүмүүсийн эрх болон "Чиний гарт буй дайсан" хэмээх халаасны картын талаар суралцахад зориулагдаж байв. Вьетнамд байсан эхний 3 сард тэдний 4 хүн алагдаж, 38 хүн шархадсан байв.

3–р сарын 14–нд далдалж нуусан тэсрэх бөмбөгт тэдний нэг алдартай түрүүч өртөн амь үрэгдэж, зарим цэрэг хараагүй болж зарим нь шархадсан юм. Оршуулгын үеэр ахмад Медина дараагийн өдрийн төлөвлөгөөний тухай заавар өгч тэдэнд урам зориг оруулах яриа хийсний дараах 3–р сарын 15–ны орой цэргүүд өширхөх сэтгэлд маш их автагдсан байсан. "Ягаан тосгон" буюу Вьет Конгийн хүчирхэг 48–р суманг оролцуулж, Ми Лай тосгоныг сөнөөх өргөн хүрээтэй довтолгоо хийхээр зэхэж байв.

Түүний яг юу хэлсэн нь маргаантай байгаа билээ. Медина, түүний зорилго нь "Тэднийг устгаж, тийшээ орох замыг чөлөөлөх байсан; би тосгоны хүүхэд, эмэгтэйчүүдийг хэрхэх талаар ямар нэгэн заавар өгөөгүй байсан" гэдгээ санаж байлаа. Зарим цэргүүд түүнтэй санал нэг байсан. Бусад нь түүнийг тэдэнд тосгон дахь бүх хүнийг хөнөөх үүрэг өгсөн гэж байлаа.

Дайралтын төлөвлөгөөнд 1 ба 2–р салаа газардах бүсийг аюулгүй болгоод тосгон руу орохыг шаардсан байв. Ахмад Медина, армийн сурвалжлагч болон зурагчин 3–р салаатай хамт ирэх байв. Дэслэгч хурандаа Баркер нисдэг тэргээр 1000 метрийн өндрөөс, генерал Оран Хендерсон 2500 метрийн өндрөөс уг ажиллагааг удирдах байв.



# Ми Лай дахь үйл явдал – түүх: 3–р сарын 16–ны бэлтгэл

Үүр цайх үеэр Вьет Конгийг хайж буй довтолгооны нисдэг тэргүүд газардах талбарыг их буугаар шүршлээ. Цэргийн нисдэг тэргүүдийг газардах үед тэнд байсан ВьетКонгчууд бараг л үгүй болсон байлаа. Цэргүүд тосгон руу ороход ямар ч саадтай тулгарсангүй.

2– салааны хүмүүс хэсэг Вьетнам зугтаж байгааг олж хараад тэдэн рүү гал нээв. Тэд жагсаад цааш тосгон руу хөдлөв. 1–р салаа дайсны ширүүн галтай тулгарна гэж бодсоор тосгон руу нэвтрэв. Хэн нэг нь тэнд "төлөг" байна гэж заахад түрүүч Майкл "түүнийг бууд" гэж хэлэв. Хэн нэгэн нь түүнийг буудав.

Алан хяпдлага эхэлсэн байлаа. Нэг цэрэг нэгэн буурай хөгшнийг цохиж унаган хоолойг нь зүсээд худаг руу шидэж орхив. Аллага эхлээд маш түргэн газар авлаа. Тэдний зарим нь зэвсэглээгүй, эсэргүүцэл үзүүлэхгүй байгаа энгийн иргэдийг хөнөөх хүсэлгүй байсан хэдий ч бусад цэргүүд нь тэгж байгааг хараад мөн л тэгж байлаа. Дөрвөн цаг ч хүрэхгүй хугацаанд 500 гаруй Вьетнамийн энгийн иргэд алагдаж, тэдний тосгон бүхэлдээ сүйтгэгдсэн байлаа.



# Танилцуулах картууд

**Майкл Бернхард**

Бернхард цэргийн хамгийн аюултай ажлуудын нэг болох "хонгилийн харх" ажлийг хийж байсан. Яагаад гэвэл дайснууд газар доогуурх хонгилоор эд материал олноор зөөдөг байлаа. "Хонгилийн харх" хонгилд нуун далдалсан тэсрэх бөмбөгийг үл хайхран тэдгээр зүйлсийг хайдаг билээ.

Хэдийгээр тэр цэрэгт сайн дураараа элссэн ч, Бернхард бол "24 настай, дарангуйлагчдын эсрэг үзэлтэй, өмнө нь удирдагч нартайгаа маргалдаж байсан бөгөөд өөрийн конгрессийн гишүүнд Америкийн армид юу буруу байгааг бичих дуртай нэгэн байлаа. Нэг болон хоёрдугаар сард Ч. Бүлгийн хүмүүс олзлогсдод хэрхэн хандаж байгааг хараад тэрээр санаагаар унасан байлаа.

Бернхард: *Хэрэв биднээс өөр хүмүүс байсан бол аймшигт аллага гэж хэлж болохоор үйлдлүүдийг харж байхдаа, би магадгүй буруу бодож байж ч болох (...) магадгүй бодит байдал тийм байгаа ч юм билүү. Би тэгж бодохгүй байхыг хичээсэн. Би өөрийн үзэл бодлоо хэвээр хадгалахыг хичээсэн, гэвч энэ нь амаргүй байлаа. Тэдгээр хүмүүсийг аажим аажмаар ямар ч хяналтгүй болж байгааг би харж эхэлсэн.*

- Маргааш юу болно гэж бодож байна?
- Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Дэслэгч Виллиам Калли:**

Дэслэгч Калли 24–н настай, Ч бүлгийн 3–р салааг хариуцдаг байв. Түүний удирдлаганд байсан цэргүүд түүний тухай "дайн болж тоглох гэж байгаа хүүхэд" гэж ярьдаг байв. Түүний Вьетнамчуудад хандах хандлагыг нь нэгэн цэрэг дүгнэн хэлэхдээ, "Каллигийн цэргүүд муу юм хийхийг хүссэн ч Калли зөвшөөрнө" гэжээ.

Калли: *"Ягаан тосгон"–д ойртоход, алхам тутам мина байрлуулсан талбарт байна гэсэн үг. Бас Ми Лай дахь "энгийн иргэд" урдаас араас гал нээж байна. Тэр батальонд байсан хөгшид, хүүхэд, эмэгтэйчүүд үнэхээр зүй бус юм. Тэд гал нээж, мина тавьж, бууны гох дарж байлаа. Хэрэв тэд чиний олзны хүмүүс байлаа гэхэд мөн л чиний хараал идсэн гранатуудын гол дэгээг мулталж байлаа. Тэгээд чи ердөө л ялаа шиг үхэх болно. Альфад ийм л зүйл тохиолдсон, Бравод ч мөн адил. Маргааш Чарьлид ч тохиолдож болно.*

*"Ягаан тосгон" одоо Вьет Конгийн үндсэн бааз болсон гэж Медина хэлсэн. Миний санаж байгаагаар "Бид ардаа хэнийг ч үлдээх ёсгүй " гэж Медина хэлсэн. Альфа , Браво нар ардаа Вьет Конгийн хэн нэгнийг үлдээсэн учраас амь үрэгдсэн. Тэд шархадагсдыг авч яваад хөдлөх хүчээ алдсан, энэ бол тэдний сүйрэл байсан. Медина, бидний ажил бол хурдан нэвтэрч ороод бүх зүйлийг саармагжуулах буюу бүгдийг устгах гэж байсан.*

- Маргааш нь юу болно гэж бодож байна?
- Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

# Танилцуулах картууд

**Ларри Колбөрн:**

Колбөрн 17 настайдаа армид элсэхээр сургуулиас завсарджээ. Жилийн дараа тэрээр 123–р агаарын хэсгийн скаутын нисдэг тэрэгний их буучин байлаа. 3–р сарын 16–нд түүний хийх ажил бол газарт буй цэргүүдийг Ми Лай тосгон руу нэвтрэн ороход нь туслах байсан юм.

➤ Маргааш юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Түрүүч Рон Хайбэрл :**

Түрүүч Хайбэрл нь армийн сонинг эрхлэхээр томилогдсон 2 хүний бүрэлдэхүүнтэй хэвлэлийн албаны зурагчин байлаа. Тэдний ажил нь эх орондоо байгаа сонинд дайны тухай зураг, үйл явдлуудын тухай материалууд бэлдэж явуулах байлаа. Тэрээр нэг буу, 2 камер авч явсан бөгөөд нэг нь армийн, нөгөө нь өөрийн авахыг хүссэн албан бус зураг авахдаа хэрэглэдэг хувийн камер байв.

➤ Маргааш юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Хурандаа Оран Хендерсон :**

Армид 25 гаруй жил алба хаасан хурандаа Хендерсон генерал болохыг хүсдэг байлаа. Үйл явдлын үеэр тэрээр хэдийгээр идэвхтэй тулаанд оролцож байгаагүй ч, нийт 3500 хүнтэй гурван явган цэргийн суман болон 11–р суманг хариуцаж байлаа. Ми Лай түүний анхны дайнд оролцсон явдал байлаа. Түүнийг томилсон, түүний удирдагч Генерал Костер түүнийг тодорхойлохдоо, “зоригтой, би түүнийг нилээн сайн удирдагч гэж боддог. Миний удирдаж байсан хүмүүсээс тэр гарцаагүй хамгийн ухаантай нь байсан байж болох юм “ гэжээ. 3–р сарын 16–нд тэрээр уг ажиллагааны талаар бааз дээр радиогоор шуурхай холбоотой байх үүрэгтэй байв.

➤ Маргааш нь юу болно бодож байна вэ?
➤ Хэрэв тэр түүний хүмүүс гэмгүй хүмүүсийг чөлөөлж байгаа тухай мэдээ авбал яах байснийг төсөөл?

**Роберт Мейплс:**

Тэр 19 настай, пулемётчин байлаа.

➤ Маргааш нь юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

# Танилцуулах картууд

**Түрүүч Кеннэд Ходжес:**

Түрүүч Ходжес бол цэргүүдийг Вьетнам явахаас өмнө бэлтгэж байсан, тэднээр бахархдаг хүн байлаа. Түрүүчийн хувьд тэрээр Ми Лай дахь ажиллагааны үеэр цөөн тооны бүлэг цэргийг ахалж байв.

Ходжес: *Өгөгдсөн үүрэг даалгаварын утга нь тосгон дахь бүх хүнийг устгах байсан. Зарим нь эмэгтэйчүүд, хүүхдүүдийг ч бас уу гэж асууж байв. Тушаал бол "тосгон дахь бүх хүмүүсийг" гэж байлаа. Яагаад гэвэл тосгонд байсан хүмүүс ——— эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшид — бүгд Вьет Кончууд эсвэл тэдэнтэй сэтгэл зүрхээрээ нэг хүмүүс байсан. Тэд өмнөд Вьетнамын армид ч, Америкчуудад ч дургүй байсан юм. Тэд бидэнд дайны үед тусалж байгаагүй. Энэ бүхэн нь тосгоныхноос хэн ч өршөөгдхөөргүй байсныг харуулна.*

- ➤ Маргааш нь юу болно гэж тэр бодож байна?
- ➤ Тэр Ми Лай—н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Харри Станлей:**

Станлей зэвсэг зөөгч, гранат цэнэглэгч хийдэг байлаа. Тэр өөрөө бие дааж Вьетнам хэл сурсан бөгөөд ирснийхээ дараа цэрэгт сурсан бусад хүмүүсээс илүү сайн ойлгож, ярьдаг байлаа.

- ➤ Маргааш юу болно гэж бодож байна?
- ➤ Тэр Ми Лай—н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Ахмад Эрнест Медина:**

Чарли бүлгийг хариуцсан офицер, 33—н настай Медина өөрийн цэргүүд дундаа алдартай нэгэн байлаа. Тэр цэрэгт 16—н настайдаа насаа худлаа хэлж элссэн ясны цэрэг байв. Ми Лай дахь дайралтын өмнөх шөнө тэрээр өөрийн цэргүүддээ хандаж үг хэлсэн юм.

Медина: *Би тэдэнд бас ингэж (...) бидэнд тосгоныг устгах эрх мэдэл байна, гэж хэлсэн. Тэд байшингуудыг шатааж, мал сүргийг устгаж, хүнсний тариа ногоог сүйрүүлж, мөн ундны усны худгуудыг хааж чадахаар байлаа.*

*Би мөн тэдэнд энэ бол биднийг буудаж байсан, бидний үйл ажиллагаа явуулж буй газар нууц бөмбөг, мина тавьж байсан 48—р Вьет Конгийн суманг устгах тэдэнтэй нүүр тулан байлдаж тэднийг ялах бидний боломж гэдгийг хэлсэн юм.*

- ➤ Маргааш юу болно гэж бодож байна?
- ➤ Тэр Ми Лай—н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

# Танилцуулах картууд

**Варнадо Симпсон:**

Цэрэг Симпсон Вьетнамд ирэхдээ 19 настай байлаа.
Симпсон: *Би 4–р зэргийн мэргэшсэн буудагч байлаа. Би байг алдалгүй онохоод бэлтгэгдсэн байсан ч, бууны гохыг дарж хэн нэгнийг хороонo гэдэг бодит байдал бэлтгэл сургуулиас шал өөр байлаа.*

*Бидний хувьд тэнд энгийн иргэд гэж байгаагүй. Тэнд Вьет Конгийг дэмжигчид байсан. Тэднийг энгийн иргэд гэхгүй. Бидний хувьд тэд бол Вьет Конгчууд байсан. Чамд ямар ч сонголт байхгүй. Чи ямар нэг зүйл хийх л ёстой байсан. Хэрэв тэд Вьет Конг байж байгаад, зугтсан бол тэд эргэж ирээд чамайг алах болно. Чи тэгснээрээ амь насаа эрсдэлд оруулж байгаа хэрэг.*

➤ Маргааш юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Хью Томсон:**

25–тай Томсон өөрийн нисдэг тэрэг жолоодох ажилдаа дуртай, гарамгай цэрэг байлаа. 1965 онд тэрээр Армийн бэлтгэл офицерийн нислэгийн хөтөлбөрт Вьетнам дахь тулаанд оролцохоор бүртгүүлжээ. Ч. Бүлгийн хэсэг биш ч түүний нисдэг тэрэг Вьет Конгийн 48–р сумангийн орогнож буй газрыг ажиглах үүрэгтэй агаарын нисэх хүчинд зүтгэж байлаа. Ажиглалтын нисдэг тэрэгнүүдийн үүрэг бол дайснуудын нээж буй галыг тэмдэглэн, түүгээр тэдний байршлыг тогтоож Вьет Конг–руу нэвтрэн, тэдний дайралтыг сөнөөх Америкийн агаарын хөлгүүдийн замыг чөлөөлж өгөх байлаа.

➤ Маргааш юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

**Фред Вайдмер:**

3–р сарын 16–ны өдөр Вайдмерийн гүйцэтгэх үүрэг бол өглөөгүүр Мn Лэй–д Ахмад Мединаг холбооны ажилтнаар дагалдан явах байлаа. 3–р сарын 16–ны өмнө Вайдмер ойролцоох тосгоны Вьетнам хүүхдүүдтэй хамт цагийг зугаатай өнгөрөөж байлаа.
Вайдмер: *Бид анх тэнд очоод , тосгонуудад төв замаар нь нааш цааш явдаг байлаа. Харуулын үүргээ гүйцэтгэж байхдаа хүүхдүүдтэй тоглоно. Тэдэнд үргэлж чихэр, энэ тэр зүйлс өгнө. Тэдэнтэй зургаа авхуулна. Цэргүүд хүүхдүүдтэй хамт чи олон хүнтэй уулзах болно. Бид бүлгийн хүмүүсээ алдаж эхэлсэн үед, тэдгээр нь ихэнхдээ нууц бөмбөг, мэргэн буудагчидаас болж байсан юм. Чам руу хэн нэгэн буудаж, чи мөн эргүүлэн буудаж байсан тийм тулалдаанд бид үнэндээ хэзээ ч ороогүй байсан.*

Бид тийшээ зорилготой очсон байсан бөгөөд үнэндээ бидний хийж байгаа зүйлс зөв санагдаж байлаа.

➤ Маргааш юу болно гэж бодож байна?
➤ Тэр Ми Лай–н оршин суугчидтай өөрийн биеэр тулгарсан бол юу хийх байсан бэ?

## Хэргийн судалгаа: Ми Лай – Юу нь буруутсан? юу нь зөвтсөн? Эх сурвалж 3

**Вьетнамын Цэргийн Тусламжийн Команд (MACV)**

**(MACV) – халаасны карт**

ТҮГЭЭХ – Вьетнамд байгаа Америкийн зэвсэгт хүчний гишүүн бүрт нэгийг (1967 оны 9–р сар)

**Чиний гарт буй дайсан:**

Америкийн цэргийн хүчний гишүүний хувьд танай улсын чанд баримталж буй 1949 оны дайны хоригдлын тухай Женевийн Конвенцийг дагаж мөрдөх болно. Энэхүү Конвенцийн хүрээнд:

Та дараах зүйлсийг хийх болно:

- Олзлогдогчийнхоо зэвсгийг хураах
- Шуурхай нэгжин шалгах
- Дуугүй байхыг шаардах
- Бусад олзны хүмүүсээс тусгаарлах
- Анхааралтай хянаж цагдах
- Даргынхаа заасан газар түүнийг аваачих

Та дараах зүйлсийг хийх ёсгүй:

- Олзлогдогчтой буруу харьцах
- Түүнийг басамжлах, гутаан доромжлох
- Цэргийн онцгой ач холбогдолгүй амины эд хөрөнгийг нь авах
- Шаардлагатай бөгөөд боломжтой үед түүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах

ОЛЗНЫ ХҮНТЭЙГЭЭ ҮРГЭЛЖ ХҮНИЙ ЁСООР ХАРЬЦ

### Ми Лай дахь командын хэлхээ график



# Ми Лай – д бид юу хийчихэв?

*Өгүүлэгч: 3–р сарын 15–нд тагнуулын мэдээгээр бол Вьет Конгийн сумангийн штаб гэгдэх Ми Лай–д хийх дайралтын төлөвлөгөө хийгдэж байлаа. Чарли бүлэг гол дайралтыг хийх байсан бөгөөд аймшигт тулалдаан болох магадлалтай байлаа. Ми Лай руу дайралт өглөөний 7–н цагт эхэлсэн. Хагас сайн өдөр байв. Тагнуулын мэдээгээр бол бүх энгийн иргэд зах руу явсан байх байлаа. Тэр үеэр тосгонд үлдэгсэд нь бүгд Вьет Конгчууд байх байв. Гэвч уг мэдээлэл худлаа байсан юм.*

**Варнадо Симпсон, Буудагч байсан – Чарли бүлэг**

Энэ бол миний амьдрал, миний өнгөрсөн түүх, өнөөгийн байдал, миний ирээдүй. Тэгээд би үүнийг надад "би хэн байсан бэ гэдгийг минь"сануулж байхын тулд дурсаж явах болно. Энэ бол намайг ийм болгосон зүйл юм.

**Кенед Ходжес, түрүүч байсан – Чарли бүлэг**

Энгийн иргэнээс цэрэг болох шилжилт бол маш онцгой бөгөөд нарийн чанд бэлтгэл сургууль юм. Цэргүүд эхний хэдэн өдрүүд, долоон хоногт сайн цэрэг байхын тулд тэдний мэдэж байх ёстой бүхий л зүйлсийг үндсэн бэлтгэл сургуулилтын үеэр заалгадаг.

Тэд зэвсэг хэрэглэхийг, зэвсгээр бусдыг хэрхэн хөнөөхийг заалгадаг. Яаж сургууль хийхийг, зэвсэгтэйгээ хэрхэн жагсахыг заалгадаг. Энэ бүх олон янзын бэлтгэл сургуулилтууд нь тушаал зааврын дагуу хийгддэг.

Бид цэргүүдийг хүсэл зоригтой байхыг хүсч байлаа. Бэлтгэгчдийн тэднийг зоригжуулах арга нь команд өгч цэргүүдээс хариу сонсох байлаа. Тэр "Жадны сүр жавхаа нь юу вэ?" гэж асуун, "Хөнөөх, түрүүчээ, хөнөөх!" гэсэн хариу авна. Тиймээс цэргүүд ийм замаар өдөөгддөг байлаа. Тэр тэднийг яриагаараа, өнөөх сүр жавхлангийн тухай заасныгаа хэзээд бэлэн байдалд байхыг сургадаг байв.
Би Чарли бүлгийн цэргүүдийг бэлтгэгч түрүүчдийн нэг нь байсан юм. Тэднийг ямар хүмүүс болсонд би их баяртай байсан. Тэд сайн цэргүүд болж чадсан юм.

●●●●●●●●●●●●●●●

**Фред Видмер, холбоочин байсан – Чарли бүлэг**

Бид анх тэнд очоод , тосгонууд руу хурдны замаар нааш цааш явдаг байлаа. Харуулын үүргээ гүйцэтгэж байхдаа хүүхдүүдтэй тоглоно. Тэдэнд үргэлж чихэр, энэ тэр зүйлс өгнө. Тэдэнтэй зургаа авахуулна. Америк цэргүүд хүүхдүүдтэй хамт. Олон хүнтэй уулзах хэрэгтэй байлаа.

**Майкл Бернхард, "Хонгилын харх" байсан – Чарли Бүлэг**

Тэнд биднээс өөр хэн ч байгаагүй. Бид энэ бүлэгт, энэ газар ганцаархнаа байсан. Бид нэг улс, нэг ижил соёл заншлаас 10000 милийн алс холоос ирсэн бүлэг хүмүүс, өөр дотносох хүн байгаагүй учир бие биетэйгээ л дотно, тийм л хүмүүс байлаа.

**Фред Видмер:**

Бид ихэнхдээ нууц бөмбөг, мэргэн буудагчдаас болж бүлгийн хүмүүсээ алдаж байлаа. Чам руу хэн нэгэн буудаж, чи мөн эргүүлэн буудаж байсан тийм тулалдаанд бид үнэндээ хэзээ ч ороогүй байсан. Далдалж нуусан тэсрэх бөмбөгүүд л гол асуудал байсан юм.

# Ми Лай – д бид юу хийчихэв?

**Варнадо Симпсон :**

Би дайсныг харсан, гэвч тэр хэн байв? Жаахан хүүхдүүд чам руу буудна эсвэл явсны чинь дараа араас чинь хутгална. Хэн нь дайсан бэ? Би дайснуудын хооронд сайн мууг нь ялгахгүй байлаа, тэд бүгд л адилхан харагдаж байсан. Уг дайн тийм онцгой байсны учир нь тэр. Германчууд энд, Японччууд тэнд гэдэг шиг биш байсан юм. Тэд Хойд, Өмнөд Вьетнамчууд ялгаагүй бүгд адилхан харагдаж байсан. Яаж ялгаж салгах вэ дээ?

●●●●●●●●●●●●●●●

**Майкл Бернхард**

Хэрэв биднээс өөр хүмүүс байсан бол аймшигт аллага гэж хэлж болохоор үйлдлүүдийг харж байхдаа, би магадгүй буруу бодож байж ч болох (...) магадгүй бодит байдал тийм байгаа ч юм билүү. Би тэгж бодохгүй байхыг хичээсэн. Би өөрийн үзэл бодлоо хэвээр хадгалахыг хичээсэн, гэвч энэ нь амаргүй байлаа.Тэдгээр хүмүүсийг аажим аажмаар ямар ч хяналтгүй болж байгааг би харж эхэлсэн.

**Кеннед Ходжес**

Өгөгдсөн үүрэг даалгаварын утга нь тосгон дахь бүх хүнийг устгах байсан. Зарим нь эмэгтэйчүүд, хүүхдүүдийг ч бас уу гэж асууж байв. Тушаал бол "тосгон дахь бүх хүмүүсийг " гэж байлаа. Яагаад гэвэл тосгонд байсан хүмүүс — — — эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшид — бүгд Вьет Конгчууд эсвэл тэдэнтэй сэтгэл зүрхээрээ нэг хүмүүс байсан. Тэд өмнөд Вьетнамын армид ч, Америкчуудад ч дургүй байсан юм. Тэд бидэнд дайны үед тусалж байгаагүй. Энэ бүхэн нь тосгоныхноос хэн ч өршөөгдхөөргүй байсныг харуулна.

**Фред Видмер**

Миний ойлгосноор бид тулааны там руу явж байсан, бид хэсэг тэнэгийг цохиж унагахаар явж байсан. Бид түүнийгээ хийсний дараа хэн ч тэнд үлдээгүй байх байсан.

●●●●●●●●●●●●●●●

**Варнадо Симпсон**

Би Вьетнамд ирэхдээ 19 настай байлаа. Би 4—р зэргийн мэргэшсэн буудагч байлаа. Би байг алдалгүй онохоод бэлтгэгдсэн байсан боловч бууны гохыг дарж, хэн нэгнийг хорооно гэдэг бодит байдал дээрээ бэлтгэл сургуулиас шал өөр байлаа.

Би тийм зүйл хийнэ гэдгээ мэдээгүй. Би тэнд эмэгтэйчүүд, хүүхдүүд байгааг мэдэж байсан ч би тэднийг хөнөөнө гэдгээ бүхнийг болох хүртэл мэдээгүй байсан юм. Би хэн нэгнийг хөнөөнө гэдгээ мэдэхгүй байсан. Би алахыг хүсээгүй. Би хүн хөнөөхийн тулд бэлтгэгдээгүй.

Тэр эмэгтэй модны захаас гүйж байв. Гэвч тэр нэг юм авч явж байлаа, зэвсэг байсан эсэхийг мэдэхгүй. Түүнийг эмэгтэй хүн гэж мэдэж байсан, би түүн рүү гал нээхийг хүсээгүй, гэвч буудах тушаал авсан байсан. Тиймээс би түүнийг зэвсэг зөөж байгаагаар бодоод буудсан. Би түүнийг эргүүлэн харахад тэр нь нялх хүүхэд байлаа. Би түүнийг 4 удаа буудсан бөгөөд сумнууд нэвт гарч хүүхдийг мөн оносон байлаа. Эргүүлэн харах үед хүүхдийн нүүрний тал нь байхгүй болсон байсан. Дотор харлаад л явчихсан. Бэлтгэл сургууль бусдыг хөнөөх хөтөлбөр намайг дийлсэн байсан. Би бусдыг хөнөөж эхэлсэн байлаа.

# Ми Лай – д бид юу хийчихэв?

Ми Лай дахь тэр өдөр би хувьдаа 20—25 хүнийг хороосон байлаа. Ийм зүйлийг хийсэн хүн нь ганц би биш. Олон хүн үүнийг хийж байсан, тиймээс би зөвхөн олонд нийцүүлж байлаа. Би ердөө л зүг чиг, зорилгоо алдсан байсан. Хөнөөж болох ямар ч хамаагүй аргаар би тэднийг хороож байсан. Энэ бүгд миний дотор байсан гэдгийг би мэдээгүй, гэвч би тэр хүүхдийг хөнөөснийхөө дараа би бүхий л ухаан санаагаа алдсан. Хамгийн хүнд хэсэг нь алах, гэвч чи нэг л алчихвал дараа дараагийнхыг нь хөнөөх амархан байдаг. Яагаад гэвэл, надад зүрх сэтгэл, сэтгэл хөдлөл, зүг чиг байгаагүй, зөвхөн л ална гэсэн бодол байлаа. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг бүгдийг нь араас нь буудаж алах.

Энэ бол миний амьдрал, би энэ цуглуулгын номоо нээхгүй байсан ч, би үүнийг хар дарсан зүүдэндээ хардаг — би энэ номыг сөхөхгүй байсан ч энэ бүгд тэнд байж л байдаг.

**Фред Видмер**

Миний харсан хамгийн аймшигтай зүйл бол нэг хүү гараа буудуулсан байсан. Тэгээд унжсан гараа хараад тэрээр "би юу хийсэн юм бэ, яагаад ингэж байгаа юм бэ" гэх шиг гайхсан харцаар харж байлаа. Үүнийг тайлбарлах хэцүү, тэр юу ч ойлгохгүй байсан юм.

Би түүнийг буудаж алсан. Би үүнийгээ энэрэнгүй аллага гэж бодохыг хүсдэг, учир нь эцэстээ хэн нэгэн тэгэх л байсан. Гэвч энэ нь буруу юм.

**Кенед Ходжес**

Мэргэжлийн цэрэг хүний хувьд би тушаалыг биелүүлэх ёстой гэж заалгасан, хэзээ ч удирдлагын өгсөн тушаалыг эсэргүүцэх буюу биелүүлэхээс татгалзах тухай бодол надад төрж байгаагүй.
Хэрэв манай хүмүүсийн нэг нь буудахаас татгалзвал тэднийг яах бол гэж бодохоос дотор арзайна. Миний хувьд юу хийх байсан бол гэдгийг одоо хэлэхэд хэцүү. Тэр үед татгалзсан хүн хэцүү байдалд орох нь дамжиггүй байсан. Тэр цэргийн шүүхэд ч очиж болох байлаа. Тэр, дайсны галын өмнөөс, дайсны нэрийн өмнөөс, тушаал биелүүлэхээс татгалзсаныхаа төлөө газар дээрээ ч буудуулж болох байлаа. Хэдийгээр тэр үед дайсан гал нээгээгүй байсныг бид мэдээгүй байсан юм.

Тэдгээр цэргүүд хүүхэд, эмэгтэйчүүдийг хөнөөх өгөгдсөн үүрэг даалгаварыг гүйцэтгэж чадах байсан. Учир нь тэд цэргүүд байсан болохоор. Тэд дайнд оролцож байх үед чи, эсвэл дайсны аль нэг нь байх болно гэж бэлтгэгдсэн байсан. Уг тосгонд байгаа хүмүүс — эмэгтэйчүүд, жаахан хүүхдүүд хөгшин хүмүүс — бүгд дайсанд тооцогдож байв.

Бид тушаалыг ёс суртахуунтайгаар гүйцэтгэж байсан шиг санагдана. Тосгоныг сөнөөх, тосгоны хүмүүсийг хөнөөх тушаалууд. Бид ёс суртахууны хэм хэмжээг зөрчөөгүй мэт санагдана.

**Харри Станлей, Америкийн цэрэг байсан – Чарли Бүлэг**

Дэслэгч Калли тодорхой хүмүүст тэдгээр хүмүүсийг алахыг тушаасан бөгөөд би тэдний нэг нь билээ. Би татгалзсан бөгөөд тэрээр намайг буцаж төвдөө ирэхээр цэргийн шүүхэд өгнө гэв. Тэр үед миний толгойд юу байсныг би түүнд хэлэв. "Надад гэмгүй хүмүүсийг хөнөөхийг тушаах нь тушаал биш, солиорсон хэрэг. Тиймээс би түүнийг биелүүлэх ёстой гэж бодохгүй байна. Намайг цэргийн шүүхэд өгвөл өг, хэрвээ та арыг нь дааж чадах юм бол."

Аймшигтай муухай санагдаж байлаа. Америк хөвгүүд энэ бүхнийг хийж байгаа нь аймаар байлаа. Би тэнд байсан бусад хөвгүүдийн адил улаан цуст Америк хөвгүүн байсан юм. Би хар арьстан ч бай, цагаан арьстан ч бай ялгаагүй, зөв буруугийн тухай ярьж байна. Тэд бүгд адил, ямар ч ялгаагүй байлаа. Энэ бол зүгээр л аймшигтай зүйл шиг санагдсан.

Бид бүгд нэг газраас ирсэн бөгөөд тэдэнд надад байсан шиг ижил үзэл бодол, үнэ цэнэ байсан гэдгийг би мэднэ. Хэрэв тэд үүнийг сургуульд байхдаа сурч аваагүй бол, хэн нэгэн танихгүй хүнээс сурч авч болох юм. Гэвч ийм зүйл хийх нь миний хувьд ёс суртахуунгүй асуудал. Миний бодож, мэдэрч байсан зүйлс ийм л байлаа.

# Ми Лай – д бид юу хийчихэв?

**Рон Хайберл, Америкийн армийн зурагчин байсан**

Би тэдгээр хүмүүсийг тойрон зогсч буй хэсэг Америк цэргийн зургийг авсан юм. Америк цэргүүдийн нэг нь "Хүүе, тэр камертай байна" гэж хашгирав. Тэд бага зэрэг тойргоо тэллээ. Би тэнд галзуурсан охин, бас нэгэн эмэгтэй жаахан хүүхдийг хамгаалахыг хичээж байхыг олж харлаа. Наана нь нэг настай эмэгтэй өвдөг сөхрөн гуйж, хүүхэд тэвэрсэн хүн цамцыг нь товчилж байлаа.

Би зургийг нь авав. Цэргүүд тэднийг байцаах гэж байна гэж би бодсон юм. Гэвч намайг явсны дараахан буун дуу сонсогдов. Намайг эргэж харахад тэд газарт унасан байлаа. Би цаашаа алхсан.

●●●●●●●●●●●●●●●

**Хью Томпсон,  Ажиглалтын нисдэг тэрэгний нисгэгч байсан.**

Үйл ажилагааны үеэр бид олон цогцос харсан. Дайсан бидэн рүү огт галлахгүй байсан мөртлөө яагаад тэдгээр хүмүүс алагдаад, шархдаад байгааг ойлгосонгүй. Тэнд маш олон шархдагсад байлаа. Тэдний байсан газар их буу үүнийг хийж чадахааргүй байсан. Яагаад гэвэл, цогцсууд их буугаар буудсан газар байгаагүй юм.

**Лоренс Колбөрн,  Нисдэг тэрэгний буучин байсан.**

Бэлтгэл офицер Томпсон өөрийн энгийн иргэд гэж үнэмшсэн хүмүүсийг нуувчнаас гарган аюулгүй газар хүргэх гэж цөхрөнгөө барж байлаа. Тэрээр энгийн иргэдэд туслахын тулд хийхийг оролдсон газар дээрх оролдлого бүтэхгүй байгааг харж байв. Тэр газарт буй тэдгээр хүмүүсийг эхэлж авахгүй бол тэдний газрын хүчин бүгдийг нь устгах байлаа. Тэр онгоцоо нуувчинд байгаа Вьетнамчууд болон Америкийн хүчний дунд газардуулав. Тэр нисдэг тэрэгнээсээ биднийг өөрийгөө хамгаалуулахаар дагуулан гарлаа. Тэр яваад тэнд байсан дэслэгчтэй ярилцав. Тэрээр дэслэгчээс тэдгээр хүмүүсийг нуувчнаас яаж гаргах тухай асуув. Дэслэгч хэлэхдээ цорын ганц арга бол гар бөмбөгүүд гэлээ.

Тэгээд бэлтгэл офицер Томпсон нисдэг тэрэг рүү буцаж ирэхдээ маш ууртай байлаа. Тэр тэдгээр хүмүүсийг нуувчнаас гаргахын төлөө арга ядсан байсан. Бидэнд  хэлэхдээ, тэр өөрөө нуувчинд очиж тэднийг гаргаж ирж чадах үгүйг харна гэж байв. Би түүнийг буу авч явсан гэж бодохгүй байна. Хэрэв түүнийг тэндээс Вьетнамчуудыг гаргаж байх үед Американууд гал нээвэл Американууд руу эргүүлэн гал нээхийг бидэнд даалгасан байлаа.

**Хью Томпсон**

Би багийн дарга болон буучиддаа хэрэв манайхан дахин энгийн иргэдийг хөнөөвөл өөрсдийнхөө цэргүүд рүү гал нээхийг зааварласан, гэхдээ хэрвээ тэд гал нээвэл би яаж хүлээж авахаа ч мэдэхгүй байлаа. Гэвч тэр нэг  өдөр би энэ тухай нэг секунд ч бодолгүй заавар өгөх байлаа.

**Рон Хайберл**

Тэр үед би ердөө л хариу үйлдлийг зургандаа буулгаж байлаа. Гэвч сүүлд нь зургийг харж байхад одоо тэдгээр хүмүүс үхсэн, буудуулсан гэж бодохоор бие эвгүй оргидог юм. Би энэ бүхнээс сэргийлж чадах байсан бил үү, яаж сэргийлэх байсан бэ гэж эргэн бодно.

# "Юу болсон" картууд

**Юу болсон: Дэслэгч Майкл Бернхард**

Бернхард: Энэ бол эрс шийдэмгий алан хядлага байсан. Би ердөө энд хамаагүй, түүнийг хийхгүй гэдгээ тэдэнд хэлсэн. Хууль бус тушаал гэж бодсоноос тэр. Бернхард хэлэхдээ, түүний удирдагч Ахмад Медина түүнийг оролцоогүйг мөн тэр угаасаа л төвөгтэй хүн гэдгийг мэдэж байсан. Тэр аллагын маргааш нь ирээд Бернхард–д "Энэ тухай дуугүй явсан чинь дээр шүү" гэж хэлсэн.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Ларри Колбөрн**

Колбөрн, нисгэгч Хью Томпсонтой хохирогч Вьетнамуудыг аюулгүй газар зөөхөөр газардахтай нь санал нийлж байсан. Газарт буухын өмнө тэдний аврах гэж байсан хүмүүсийг Америк цэргүүд хөнөөж байхыг харжээ. Цэргүүд хэсэг энгийн иргэдийг айлгаж сүрдүүлж байсан нуувчны дэргэд Томпсон нисдэг тэргээ буулгав. Томпсоныг энгийн иргэдийг аврахаар явах үед Колбөрн болон бусад буучид автомат буугаа өөрсдийн Америк цэргүүд рүү чиглүүлсэн байлаа. Томпсон хэрэв Америк цэргүүд түүнийг эсвэл Вьетнамын энгийн иргэдийг буудвал, буучдыг эргүүлээд Америк цэргүүд рүү гал нээ гэж Колбөрнд хэлсэн байлаа. Колбөрн ч тэгэхээ амласан юм.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Дэслэгч Виллиам Калли**

Дэслэгч Калли салааны цэргүүддээ энгийн иргэдийг бүслэн аваад, гал нээхийг тушаасан. Энгийн иргэдийг буудах түүний тушаалыг цэргүүд эсэргүүцэхэд тэр өөрөө тэднийг буудаж эхэлсэн. Тэрээр нэгэн ламыг бууны бөгсөөр толгой руу нь цохиж алсан.

Калли: Бид Ми Лай–д хүмүүсийг алах гэж очоогүй. Бид тэдний үзэл суртлыг устгахаар очсон. Мэдэх юм алга. Шатрын хүүнүүд. Жижиг чөтгөрүүд. Махны хэлтэрхийнүүд, би Ми Лай–д ухаантай хүмүүсийг сөнөөх гэж очоогүй. Би тэнд ойлгомжгүй үзэл санаа, коммунизмыг устгахаар л очсон.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Роберт Мейплс**

Хэдэн арван Вьетнам энгийн иргэдийг хүчээр нүх суваг руу шахаж байхад тэдний олонхи нь цурхиран уйлж, амь өршөөхийг гуйж байв. Тэд гэр бүлийнхэн болон хөршүүдийнх нь цогцсыг овоолсон газар зогсч байлаа. Дэслэгч Калли одоо тэднийг буудах цаг болсныг зарлахад зарим цэргүүд эсэргүүцэв. Калли Мейплст цэнэглээд буудахыг шууд тулгав. Мейплсийг татгалзахад Калли түүн рүү буугаа онилоод тушаал дагахгүй байгаад нь буудна гэж сүрдүүлж байлаа. Өөр хоёр, гурван Америк цэрэг урагшаа алхан Мейплсийн талд оров. Калли сувагт байгаа хүмүүс рүү өөрөө гал нээв.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

# "Юу болсон" картууд

**Юу болов: Рон Хайберл**

Өөрийн хувийн камераараа яллагдсан энгийн иргэдийн зургийг авч эхэлсэн юм. Тэрээр нас барсан ээжийнхээ гарыг атгахаар өвдөг сөхрөн суугаа 4 настай шархадсан хүүхдийн зургийг авахаар зэхэж байтал ойрхоноос 3 удаа буун дуу тас хийн жаалхүү цогцсон овоон дунд үхдэл болон унав. Зурагчинг эргээд хартал 18–19 орчим насны цэрэг хоосон хөндий харцаар ширтэж байлаа.

Дараа нь нэгэн түрүүч Хайберлийг алан хядлагын зургуудыг аваад байгаад нь уурлаж загнасан юм.

Хайберл: *Би эргээд боддог юм, би энэ бүгдээс сэргийлж чадах байсан бил үү? Би яаж сэргийлэх байсан юм бэ? Энэ асуултыг би одоо ч гэсэн өөрөө өөрөөсөө асуудаг.*

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Хурандаа Оран Хендерсон**

Нисдэг тэргийн нисгэгчид зөрчлүүдийн тухай гомдол мэдүүлснээр хурандаа Хендерсон ахмад Мединад тэр өдөр тосгон руу эргэн ирж яг хэдэн энгийн иргэд алагдсан тухай нарийн тодруулахыг даалгав. Гэвч генерал Костер түүний тушаалыг хүчингүй болгов. Тиймээс Хендерсон Чарли бүлгийн цэргүүдийг цуглуулаад бүгдэд нь хандан үл ялгаварласан аллага хийсэн эсэхийг асуув. Тэр дараа нь удирдлагадаа бүх цэргүүд "Үгүй, ноёнтон" гэж хариулсан тухай мэдэгдсэн байна. Тэдгээрээс олон хүн "Хэлэх үг байхгүй" гэж мэдүүлсэн байсан.

3 өдрийн дараа Хендерсоны байцаалт дуусч, тэнд ямар нэгэн үл ялгаварласан алан хядлага гараагүй гэдгийг мэдэгдэв. Сүүлд нь нотлох баримтад тэрээр түүний цэргүүд дэггүйтэн олон тооны энгийн иргэдийг хороосон тухай сонсч байгаагүй хэмээн үгүйсгэсэн байна.

➤ Түүний өгсөн командын үүрэг хариуцлагыг бодолцож үзвэл, хурандаа Хендерсон одоо юу хийх байсан бэ? Яагаад?

# "Юу болсон" картууд

**Юу болов: Кенед Ходжес**

Ходжес: Мэргэжлийн цэрэг хүний хувьд би тушаалыг биелүүлэх ёстой гэж заалгасан, хэзээ ч удирдлагын өгсөн тушаалыг эсэргүүцэх буюу биелүүлэхээс татгалзах тухай бодол надад төрж байгаагүй. Хэрэв манай хүмүүсийн нэг нь буудахаас татгалзвал (...) тэд цэргийн шүүхэд ч очиж болох байлаа. Тэр, дайсны галын өмнөөс, дайсны нэрийн өмнөөс, тушаал биелүүлэхээс татгалзсаныхаа төлөө газар дээрээ ч буудуулж болох байлаа.

Тэдгээр цэргүүд хүүхэд, эмэгтэйчүүдийг хөнөөх өгөгдсөн үүрэг даалгаварыг гүйцэтгэж чадах байсан. Учир нь тэд цэргүүд байсан болохоор. Тэд дайнд оролцож байх үед чи, эсвэл дайсны аль нэг нь байх болно гэж бэлтгэгдсэн байсан. Уг тосгонд байгаа хүмүүс – эмэгтэйчүүд, жаахан хүүхдүүд хөгшин хүмүүс – бүгд дайсанд тооцогдож байв. Бид тушаалыг ёс суртахуунтайгаар гүйцэтгэж байсан шиг санагдана. Тосгоныг сөнөөх, тосгоны хүмүүсийг хөнөөх тушаалууд. Бид ёс суртахууны хэм хэмжээг зөрчөөгүй мэт санагдана.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Ахмад Эрнест Медина**

Үхсэн хүмүүс дундаас ээжийгээ хайж байсан бяцхан хүүг Медина буудсан гэж цэргүүд хэлж байв. Мөн өөр нэг эмэгтэйг буудаад түүнийг гүйцээхээр ойртож очсон тухай ч тэд ярьж байлаа. Өөр нэг нь, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүдээс бүрдсэн бүлэг хүмүүстэй тааралдахад Медина бүгдийг нь хөнөө, хөл дээрээ зогссон хүн нэгийг ч бүү үлдээ гэж хэлж байсан тухай хэлж байлаа.

Өөрийгөө 40–өөс олон энгийн иргэдийг хороосон гэж тооцоолох нэгэн цэрэг Ахмад Мединагийн тухай хэлэхдээ, "Энэ бүхнийг болох үед тэрээр тэнд байж л байсан. Тэр яагаад үүнийг зогсоосонгүй вэ? Медина бүгдийг командалж байлаа. Тэр хүссэн цагтаа үүнийг зогсоож чадах байсан."

➤ Ахмад Медина алан хядлагын талаар юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Варнадо Симпсон**

Тэр энгэртээ нэг юм тэврээд зугтааж яваа эмэгтэйг харав. Тэр нь буу байсан уу эсвэл тэсрэх зүйл байсан уу? Тэр гал нээв. Түүний амьгүй бие газар унав. Тэрээр нууц тэсрэх бөмбөг зөөж байсан ВьетКонг байж магадгүй тул түүнийг болгоомжтой эргүүлэв. Түүний доор толгойных нь тал нь зад үсэрсэн нялх хүүхэд байлаа.

Симпсон: Би тэнд эмэгтэйчүүд, хүүхдүүд байгааг мэдэж байсан ч би тэднийг хөнөөнө гэдгээ бүхнийг болох хүртэл мэдээгүй байсан юм. Би хэн нэгнийг хөнөөнө гэдгээ мэдэхгүй байсан. Би алахыг хүсээгүй. Би хүн хөнөөхийн тулд бэлтгэгдээгүй. Би ердөө л зүг чиг, зорилгоо алдсан байсан. Хөнөөж болох ямар ч хамаагүй аргаар би тэднийг хороож байсан. Энэ бүгд миний дотор байсан гэдгийг би мэдээгүй, гэвч би тэр хүүхдийг хөнөөсний дараа энэ бүгд ердөө л алга бочихсон.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Фред Видмер**

Видмер, Ахмад Медина хоёр 3–4 орчим насны бяцхан хүү дээр очиход тэрээр хуруунаас нь цус урсч байгаа гараа тэвэрсэн байв. Видмер түүнийг буудав.

Видмер: Миний харсан хамгийн аймшигтай зүйл бол нэг хүү гараа буудуулсан байсан. Тэгээд унжсан гараа хараад тэрээр "би юу хийсэн юм бэ, яагаад ингэж байгаа юм бэ" гэх шиг гайхсан харцаар харж байлаа. Үүнийг тайлбарлах хэцүү, тэр юу ч ойлгохгүй байсан юм. Би түүнийг буудаж алсан. Би үүнийгээ энэрэнгүй аллага гэж бодохыг хүсдэг, учир нь эцэстээ хэн нэгэн тэгэх л байсан. Гэвч энэ нь буруу юм.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

# "Юу болсон" картууд

**Юу болов: Харри Станлей**

Дэслэгч Калли Станлейд шуудуу руу түрж оруулсан энгийн иргэдийг буудахыг тушаасан боловч Станлей татгалзав. "Би ингэж өсч торниогүй, эмэгтэйчүүд хүүхдийг хөнөөхөөр ирээгүй, би үүнийг хийхгүй" гэж эрс шударга хэлэв. Калли М—16 буугаа Станлейгийн гэдсэнд тулгаад түүнийг ална гэж сүрдүүлэв. Калли түүнийг зүгээр айлгаж байгаа юм биш гэж хашгирав. Станлей ч мөн адил хариу хэлэв: "Бид бүгд л үхэх болно. Би яг одоо эндээс явна. Гэвч би эмэгтэйчүүд хүүхдүүдийг хөнөөхгүй. "

Станлей: Дэслэгч Калли намайг буцаж төвдөө ирэхээр цэргийн шүүхэд өгнө гэв. Тэр үед миний толгойд юу байсныг би түүнд хэлэв. "Надад гэмгүй хүмүүсийг хөнөөхийг тушаах нь тушаал биш, солиорсон хэрэг. Тиймээс би түүнийг биелүүлэх ёстой гэж бодохгүй байна. Намайг цэргийн шүүхэд өгвөл өг, хэрвээ та арыг нь дааж чадах юм бол." Аймшигтай муухай санагдаж байлаа.

➤ Энэ алан хядлагын талаар тэр юу хийх вэ? Яагаад?

**Юу болов: Хьюю Томпсон**

Томпсон шархадсан энгийн иргэдийг авч явахаар нисдэг тэргээ газардуулав. Тэр Каллитай уулзаад түүнтэй ууртайгаар маргалдав. Калли түүнийг нисдэг тэрэгтээ буцаж очоод өөрийнхөө амийг хичээ гэжээ. Агаараас Томпсон болон түүний багийнхан хэсэг Америк цэргүүд айн сүрдсэн тосгоны бүлэг хүмүүс рүү дайрч байхыг харсан юм. Тэр тэднийг аврахаар шийдсэн. Тэр газарт буугаад өөрийн багийн 2 хүндээ түүнийг тэр энгийн иргэдийг гаргаж авах үед Америк цэргүүд буудвал тэд нар луу гал нээхийг даалгасан.

Томпсон: Би багийн дарга болон буучиддаа хэрэв манайхан дахин энгийн иргэдийг хөнөөвөл өөрсдийнхөө цэргүүд рүү гал нээхийг зааварласан, гэхдээ хэрвээ тэд гал нээвэл би яаж хүлээж авахаа ч мэдэхгүй байлаа. Гэвч тэр нэг өдөр би энэ тухай нэг секунд ч бодолгүй заавар өгөх байлаа. Тэр үед тэд дайсанууд байсан гэж би таамагладаг.

Томпсон төв штабдаа Ми Лай—д тэр болон түүний багийнхан энгийн иргэдийг их хэмжээгээр хөнөөж байгааг харсан тухай мэдэгджээ.

➤ Тэр одоо юу хийх вэ? яагаад?

# Ми Лай дахь үйл явдал – хожим нь: Арми дотор юу болсон тухай

Армийн албан ёсны мэдээгээр 128 дайсан алагдаж, нэг Америк шархдаж, 3 зэвсэг хураагдсан байна.

Бригадын командлагч, хурандаа Хендерсон өчүүхэн төдий байцаалт явуулсан. (Тэр Ч. Бүлгийхнээс ямар нэгэн зөрчил гарсан тухай буюу үйлдсэн эсэхийг асуусан. Тэр радио холбоогоор нотлогдсон баримтыг үл ойшоосон.) Мөн түүний байцаалт үл ялгаварласан алан хядлага болоогүй гэж мэдэгдсэн.

Томпсон, Колбөрн 2 удирдлагадаа харсан зүйлсээ хэлсэн. Томпсон албан ёсоор гомдол мэдүүлсэн.

Амьд үлдэгсэдтэй ярилцсан Өмнөд Вьетнамын цэргийнхэн Сайгон дахь Ерөнхийлөгч Тиө–гийн засгийн газарт мэдээ илгээсэн боловч ямар ч арга хэмжээ аваагүй бөгөөд мэдээллүүд авч хэлэлцэгдээгүй.

Америк цэргүүдийн дунд тархсан дам яриагаар бол энгэл жирийн биш ямар нэг зүйл үнэхээр Ми Лайд болсон.

Томпсоны албан ёсны мэдээ, радио холбооны бичлэгүүд, дам ярианууд нь Вашингтон дахь Америкийн армийн удирдлагуудыг Вьетнам дахь хэлтэс рүү лавлагаа илгээхэд хүргэсэн.

Хошууч Генерал Костер албан ёсны байцаалт явуулахыг тушаасан. Түүндээ тулгуурлаад тэрээр их буу болон агаараар хэсэн тэнүүчилсэн сумнаас болж энгийн иргэд амь үрэгдсэн гэж мэдэгдсэн.

Ч. Бүлэг үүрэг даалгавраа урьдын адил гүйцэтгэсээр байв.

Калли Ч. Бүлгээс өөр газар шилжихийг хүсч, зөвшөөрөгдсөн.

Сайгоны засгийн газар болон Америкийн армийн эзэмшилд байсан үйл явдалтай холбоотой бүх мэдээ баримтууд алга болсон.

Ч. Бүлгийн гишүүд ярилцлага өгөөгүй.

**Рон Риденауэр**

22–той Рон Риденауэр Вьетнам дахь 2 жилийн хугацаат томилолтоо дуусгах гэж байлаа. Тэр уг алан хядлагын тухай сонсоод тэр талаар ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй гэж бодсон. Вьетнамд байх үлдсэн хугацаандаа тэрээр уг газар байсан хүмүүсийг олж уулзан мэдээ цуглуулж байлаа.

*Би ямар нэг байцаалт хийх хэрэгтэй гэж бодсон. Би хүүхэд байсан болохоор үүнийгээ яаж хийх тухай сайн мэдэхгүй байлаа. Гэвч надад хамгийн түрүүнд шаардлагатай зүйл бол баримтууд байсныг би мэдэж байсан юм.*

Түүнд мэдээлэл өгөхийг хүссэн, байдлыг нүдээр үзсэн гэрч хэрэгтэй байсан. Рон Риденауэрын юу хийх гэж байгааг мэдсэн цэрэг найз нь түүнийг Майк Бернхардтай уулзуулсан. Бернхард хэлэхдээ өөрийгөө армиас гарсны дараа Ми Лай–тай холбоотой бүхий л шатны офицеруудыг судлан илрүүлж, тэднийг нууцаар хөнөөхийг төлөвлөж байгаагаа хэлжээ. Рон Риденауэр Бернхардыг санаагаар унасан байсныг мэдэж байсан тул ийнхүү санал болгов:

*"Чи армиас гарах хараахан болоогүй байна. Тиймд миний төлөвлөгөөг оролдож үзэхэд яагаад болохгүй гэж, би байцаалт хийх гэж байна. Хэрэв би хийвэл чи надад үнэнийг хэлэх үү?" гэхэд "Чи үнэнийг л өгүүлээрэй. Би чамд бүх үнэнийг хэлнэ."* гэж тэр хэлсэн.

Түүнийг армиас явахад Риденауэр Ми Лай–н тухай юу мэдсэнээ захидал болгон бичжээ. Тэр уг захидлаа цэргийн удирдлагууд, Конгрессийн гишүүд болон АНУ–ын ерөнхийлөгчид илгээжээ.

# Ми Лай дахь үйл явдал – хожим нь: Хэрэг явдлын он дараалал

## 1969 он

3–р сар: Риденауэр захидлаа Конгрессийн 30 гишүүн, ерөнхийлөгч Никсон, АНУ–ын гадаад хэргийн яам болон цэргийн дээд удирдлагуудад илгээсэн.

4–р сар: Армийн дээд удирдлага уг хэргийг ерөнхий хянан шалгах хороонд шилжүүлсэн.

9–р сар: Арми Дэслэгч Каллиг Америкийн цэргийн шүүхийн нэгдсэн хуулийн 18–р зүйлээр чимээ шуугиангүй шийтгэсэн.

10–р сар: Нэгэн сурвалжлагч үйл явдлын мөрөөр судалж, цуврал өгүүлэл нийтлүүлсэн.

11–р сар: Америкийн хэвлэл мэдээллийнхэн Хайберлийн авсан аймшигт зурагнууд болон энгийн иргэдийг хороосон, тэнд байсан цэргүүдтэй ярилцлага хийж олон нийтийн анхаарлыг уг телевиз, алан хядах ажиллагаанд чиглүүлсэн.

Дэслэгч Каллиг цэргийн шүүхээр шүүх ажиллагаа эхэлсэн. Тэр 109 аллага үйлдсэн хэргээр шийтгэгдсэн.

Зарим улс төрчид бие даасан байцаалт нээлттэй хийхийг шаардаж, зарим нь үүнийг Америкийн дайны хүчин чармайлт, зэвсэгт хүчний Вьетнам дахь золиослолыг үгүйсгэх гэж оролдсон оролдлого гэж маргаж байв.

Ерөнхийлөгч Никсон, 3 одтой нэр бүхий генерал Виллиам Пеерсээр ахлуулан Америкийн армийг хаалттай байцаалт хийхийг тушаасан.

## 1970 он

3–р сар: Пеерс–ийн тайлан 28 офицерийг, үүн дээр нэмээд Хайберлийг Ми Лай дахь зөрчлүүдийг нуун дарагдуулах ажилд оролцсон хэргээр шүүхийг шаардсан.

Ахмад Медина 175 Вьетнамын энгийн иргэдийг хөнөөсөн хэргээр шийтгэгдсэн.

Ми Лай–д байгаагүй өөр 14 офицер алан хядах ажиллагаатай холбоотой мэдээллийг нуун дарагдуулсан хэргээр шийтгэгдсэн. Тэдний шийтгэл нь үүргээ умартсан, хууль ёсны дүрмийг дагаж мөрдөөгүй, худал мэдүүлэг өгсөн зэргийг багтаасан байна.

11–р сар: Түрүүч Дэвид Митчел цэргийн шүүхээр цагаатгасан.

## 1971 он

1–р сар: Түрүүч Чарлиз Хүтто болон Юүжийнэ Котуак нарыг шүүх ажиллагаа цагаатгалаар төгссөн.

2–р сар: Ми Лай–д өөрийн биеэр байгаагүй офицеруудын шийтгэл хүчингүй болсон.

Хурандаа Хендерсон Ми Лай дахь дайны гэмт хэргийг нуун дарагдуулах ажилд оролцсон хэргээр шийтгүүлсэн.

# Ми Лай дахь үйл явдал – хожим нь: Хэрэг явдлын он дараалал

3–р сар: Дэслэгч Калли 22 “нярай хүүхэд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, хөгшдийг хөнөөсөн болон 2 настай хүүхдийг алахыг завдсан гэм буруутай нь тогтоогдсон.”

Тэр гутамшигтайгаар шийтгүүлж, бүх насаараа чанга дэглэмтэй хорих ангид хоригдох болов.

4–р сар: Ерөнхийлөгч Никсон (Америкийн зэвсэгт хүчний ерөнхий командлагч) Каллиг шоронгоос суллаж, гэрийн хорионд байлгахыг тушаасан.

8–р сар: Ахмад Мединаг шүүх ажиллагаа эхэлсэн.

Мөн хурандаа Хендерсоныг шүүх ажиллагаа эхэлсэн.

3–р армийн Генерал, Каллигийн бүх насаар нь хорих ялыг 20 жил болгож бууруулав.

9–р сар: Ахмад Медина бүх ялнаас хэлтрүүлэгдэв.

12–р сар: Хурандаа Хендерсон бүх ялаас чөлөөлөгдөв.

## 1973 он

12–р сар: Америкийн Цэргийн Давж Заалдах шүүх Каллигийн ялыг дэмжив.

## 1974 он

2–р сар: Каллид 1000$–н батлан даалт олгогдов.

4–р сар: Армийн ерөнхий нарийн бичгийн дарга Каллигийн ялыг 10 жил болгон бууруулав.

6–р сар: Америкийн цэргийн давж заалдах шүүх батлан даалтын тушаалыг эргүүлэн Каллиг сахилгад суулгав.

11–р сар: Армийн Ерөнхий нарийн бичгийн дарга Каллиг хугацаанаас нь өмнө суллав.

# Ерөнхийлөгчид бичсэн захидлаас

*Ахмад Обри Даниел (Каллигийн цэргийн шүүхэд АНУ–ын армийн прокуророор ажилласан)*

*Каллиг шоронгоос суллагдсаны дараа Ерөнхийлөгч Никсонд захидал бичжээ.*

Эрхэм ноёнтон:

Би эсэргүүцлийн захиа бичиж дадаагүй болохоор энэ захиагаа хаанаас нь эхэлж бичихээ мэдэхгүй байна. (...) Дэслэгч Каллиг шүүх ажиллагаа манай хуулийн системийн тэргүүний уламжлал ёсоор хэрэгжлээ. Энэ бол дэслэгч Каллигийн хууль ёсны эрх нь бүрэн хамгаалагдсан, шударга шүүх болсон. (...) Шүүгчдийн бүрэлдэхүүн баталгаа, нотлох баримтуудад тохирсон хуулийн заалтыг дагаж мөрдөх хэрэгтэй байсан бол тэд тэгсэн. Тэд үнэхээр бидний шударга ёсны систем болон Америкийн армийн удирдах офицерын байр суурьт тохирч байгаа билээ. (...)

Оногдуулах ялыг тогтоох үед би маш их цочирдож, улс орон даяар олон хүний яаж хүлээж авч байгааг хараад гайхсан. Олон нийтийн энэхүү эсрэг нөлөөний ихэнхийг би баримт нотолгоо байгаа гэдгийг мэдэхгүй, мөн энэ улсын хууль цааз дайны зан үйлийг журамлаж байгаа байж магадгүй гэдгийг бодолгүйгээр сэтгэл хөдлөлөөр асуудалд хандаг хүмүүс гэж бодож байлаа.

Гэвч хамгийн аймшигтай нь ёс суртахууны асуудлыг энд олж харж чадаагүй, эсвэл харсаар байтал улс төрийнхөө амбицаар тангарагтны шийдвэрийг урам хугаран хүлээж авах олон нийтийн үзэл бодол гэдэг нэрийдлээр бууж өгсөн олон тооны улс төрийн удирдагчид байсан явдал юм. (...)

(...) Би ялангуяа олон нийтийн дунд шуугиан тарьж буй эдгээр мэдээнүүдэд хөндлөнгөөс оролцсон таны шийдвэрт маш их цочирдон байсан. (...) Миний бодлоор таны оролцоо цэргийн шүүхийн системийг эрэмдэглэж, уг мэдээллийн үр дүнд олж авсан нэр хүндийг нь бууруулсан. (...)

Таны шийдвэр дараа дараагийн шүүх ажиллагаа, ялангуяа цэргийн шүүхэд ямар нөлөө үзүүлэх вэ?.

Хууль эрх зүйн үйл явцыг эрхэмлэн сахих явдал суларснаар зогсохгүй (...) хамгийн багадаа л ямар ч эсэргүүцэлгүй, цэргийн бус 22 хүнийг санаатайгаар хөнөөсөн дэслэгч Каллигийн дүр төрхийг үндэсний баатар мэт болгож, өөрсдийн шүүгчийн үүргээ бахархалтайгаар гүйцэтгэж энэ улсад агуу том гавъяа байгуулсан тэрхүү 6 үнэнч шудрага, хүндэт офицерийг шудрага бусаар шүүмжлэн буруушаах хүмүүст дэмжлэг өгсөн болж байна. (...)

Энэ үндэстний хувьд дэслэгч Каллигийн үйлдлүүдийг уучилж өршөөх явдал нь биднийг бидний дайснуудаас илүүгүй болгож, өөрсдийн олзны хүмүүст үзүүлэх хүнлэг харьцааг шаардах үндэсний гуйлтыг утгагүй болгож байна. (...)

Ми Лай–д болсон явдал бидний түүхэн дэх гашуудлын өдөр болохын зэрэгцээ, хариуцлага хүлээгчдэд ямар нэг арга хэмжээ авахгүй бол энэ улсын хувьд хичнээн олон эмгэнэлт явдал гарах байсан билээ?

Тэр үйлдэл болж өнгөрсөн. Гэвч энэ бүхний дундаас хамгийн том эмгэнэл нь улс төрийн ашигтай байдал нь гэмгүй хүмүүсийг хөнөөх явдал угаас байдаг гэсэн хууль бус зүйл болгон ёс суртахууны үндсэн зарчим болгон зөвшилцөхөд хүргэх явдал юм...

➤ Ахмад Даниелийн үзэл санаанууд болон учир шалтгааныг юу гэж бодож байна вэ?

# Тэнд ямар ч өршөөл энэрэл байсангүй

### ХЭСЭГ А

Германы нэгэн цэргийн батальон 1914 онд Оросын цэргүүдийг буулган авч цааш амжилттайгаар давшиж байлаа.

*Их бууны нүсэр дуу чимээний хажуугаар Оросуудын "Пруссууд аа!" гэсэн зүрх зүсэм орилолдоон сонсогдож байлаа. Гэвч тэдэнд ямар ч өршөөл байгаагүй. Манай ахлагч " бүгд үхэх ёстой, зогсолтгүй галла" гэж тушаав. Сонсож байхнээ манайхны 5 цэрэг, нэг офицер энэ уйлаан орилолдооноос болоод солиорсон байв. Гэвч манайхны ихэнхи цэргүүд болон офицерууд арга ядан өршөөл эрсэн энгийн Орос иргэдийн намагт шигдэн буудуулан үхэж байгаагаар нь зугаа хийж байлаа.*

**Тэр цэргийн хувьд уг явдлын талаар юу хийхийг шийд.**

**Анхаарч үзэх бусад зүйлс**

- Тэр цэргийн нөхөд
- Түүний дарга
- Бууж өгсөн Орос цэрэг
- Германы цэргийн шүүх

### ХЭСЭГ Б

1914 онд Америк улс төвийг сахиж байсан учраас их дайны 2 тал Америкийг шударга үзэл баримталсан орны хувьд дайнд хохирогчдын нэрийн өмнөөс зуучлах үүрэг гүйцэтгэнэ гэж харж байв. А хэсэгт өгүүлэгдсэн үгсийг Герман цэрэг Берлин дэх Америкийн элчинд бичиж илгээжээ. Түүний захиа ингэж төгсч байна.

– *Би өөрийн нэр болон хороогоо бичмээр байвч энэ үгс намайг цэргийн нууц задруулсан хэргээр цэргийн шүүхэд аваачиж болох юм.*

– Дэлхийн 1 – р дайнд оролцсон Герман цэргийн дурсамж

**Төвийг сахисан ЭСЯ–ны дипломатын хувьд юу хийх**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Дипломатын өөрийн засгийн газар
- Оросын засгийн газар
- Германы засгийн газар
- Захидал бичсэн цэрэг
- 2 талын бусад цэргүү

# Би юу хийх ёстой вэ?

## ХЭСЭГ А

1916 онд Соммийн дайны гунигт өдрүүдэд нэгэн залуу офицер түүний цэргүүдийг нэг, Теренс Блейк–г маш их санаагаар унасан байсныг ярьж байна. Тэр түүнээс зөвлөгөө авахаар иржээ.

– *Блейк царай нь унжийж цонхийсон байлаа. Гэхдээ ядарснаас болоогүй юм. Надтай ууртайгаар мэндлээд чимээгүй суув. (...) Юу болов Теренс гэж би асуулаа.*

– *Мэдэхгүй ээ, юу ч болоогүй ээ. Бид өчигдөр өглөө гуу жалгуудаас олон хүнийг барьж олзолсон.(...) Нүхнээс нэг офицер гарч ирсэн. Тэр нэг гартаа нүдний дуран барьж нөгөө гараа толгой дээрээ өргөсөн байсан. Тэр дурангаа С руу сарвайн "Түрүүчээ би бууж өглөө" гэж хэлсэн. С баярлалаа гэж хэлээд түүний дуранг зүүн гараараа авсан. Тэр яг тэр үед тэр буугаа түүний суганд тулгаад офицерийн толгойг нэвт буудсан. Би яах юм бэ?*

**Тэр офицерийн хувьд Блейк–д хандаж юу хэлэх вэ?**

**Анхаарч үзэх бусад зүйлс:**

- Уг офицерийн удирдлагад байгаа бусад цэргүүд
- Түүний ард буй цэргийн удирдлагууд
- Түрүүч С
- Цэрэг Блейк
- Бууж өгсөн офицер

## ХЭСЭГ Б

Энд офицер юу гэж хариулснаа санаж байна.

*Би чамайг ямар нэг зүйл хийж чадах байсан гэж бодохгүй байна. Чи юу хийж чадах юм бэ? Мөн С үнэхээр зэмлүүлэх юм хийсэн гэж бодохгүй байна. Тэр нүхэнд ороод айж сүрдсэндээ хагас ухаантай байсан байх. Түүнийг юу хийж байгаагаа мэдэж байсан гэж би бодохгүй байна. Чи нэг л хүн алаад эхэлчихвэл, түүнийг машин шиг буцааж эргүүлж чадахгүй. Ер нь бол тэр сайн хүн. Тэр үнэхээр ухаан санаагаа алдсан байх. Тэгээд ч одоо ямар нэг зүйл хийхэд хэтэрхий оройтсон байна. Чи түүнийг газар дээр нь буудах хэрэгтэй байсан байж магадгүй. Одоо энэ бүхнийг мартсан нь дээр.*

– Англи офицерийн дурсамж. Дэлхийн 1–р дайнд оролцсон.

Офицерийн Блейк–д хэлсэн зүйлийн талаар та нар юу гэж бодож байна вэ?

# Би юу гэж тайлагнах вэ?

**ХЭСЭГ А**

Цэргийнхэн, энгийн иргэдэд тусалж байсан 5 офицертой хамт миний амьдарч байсан тосгоны эргэн тойронд босогчид идэвхитэй байлаа. Манай ахлагч ба 2 Түрүүч бүлэг босогчид руу гэнэт дайрч зэвсэг авчран тэр хэсэгт тарааж өгөв. Ахлагч багийн байранд 2 цэрэг барьж авчран байцааж эхлэв. Тэд өөрсдийгөө дайралтын үед баригдсан зүгээр л тариачид гэж байлаа. Гэвч тэдний авч явсан баримтууд тэднийг дайсны байлдагчид болохыг батлав.

Ахлагч буугаа аваад тэднийг зориуд онолгүй буудав. Сум хаалганаас цаана байсан хийн савыг онов. "Хий!" гэж би хашхираад "Гүй" гэв. Байшин дүрэлзэн асч, бид ойролцоох зэвсгүүдийг дэлбэрэхээс өмнө хүмүүсийг гаргахыг хичээв. Дараа нь аюулгүй болсон хойно би эргэж ирээд хоёр шатсан цогцос буюу энэ бүхнийг үйлдээгүй хүлээстэй олзны хүмүүсийг олж харлаа. Тэднийг харж байхдаа би бодов:

*Миний ахлагч бол гэм буруутай алуурчин. Тэд олзны хүмүүс байсаөн, түүний үйлдэл нь тэднийг алсан, зориуд биш ч тэднийг айлгахын тулд хажуугаар нь буудсан нь хууль бус. Айлган сүрдүүлэх замаар мэдээлэл өгөхийг хүчлэх нь дайны дүрмийг зөрчиж буйхэрэг.*

Өөр мөн хоёр офицер шатсан байлаа. Ахлагч цочролд орсон байдалтай, өөрт нь юу болохыг асуун алхаж байлаа. Армийн удирдлагууд юу болсон тухай мэдээ авахаар хариугүй ирж байлаа. Ахлагч аюултай бөгөөд чадваргүй хүн шиг санагдаж байв. Гэвч тэр манай "багийн гишүүн." Тэр бидэнтэй хамт олон сараар байнгын аймшиг, муу муухай нөхцөлд дайтаж байсан зовлонг хуваалцсан. Цэрэг нөхдийн тэр холбоо амархан эвдрэхээргүй байсан юм. Ядахад, нөгөө түрүүч маань "Тэр уг газрыг дэлбэлье. гэж бодоогүй. Тэдэнд бид юу гэж хэлэх вэ?" гэв.

Би армийн уургай хурандаад бүрэн илтгэх ёстой байлаа.

**Офицерийн хувьд, илтгэлдээ юу гэж хэлэх вэ?**

Анхаарах бусад зүйлс:

- Буудсан ахлагч
- Алагдсан хүмүүс
- Ирж байгаа армийн удирдлагууд
- "Бид юу гэж хэлэх вэ?" гэж асуусан түрүүч

**Хэсэг В [Болсон зүйл]**

"Ах дүүгийн холбоо" өөрийн ахлагчаасаа нүүр буруулахгүй байхыг шаардаж байлаа. Гэвч түүний дайны хуулийг зөрчсөн явдлаас болж зөвхөн хоёр олзны хүн ч биш, манай багийн хоёр хүн амь үрэгдсэн байлаа. Энэ бол миний түрүүчид хэлсэн үг.

– Бид тэдэнд энэ бол осол байсан гэж хэлнэ. Тэр буугаа цэвэрлэж байсан, гэнэт ослоор буудагдсан. Түүнийг олзны хүмүүстэй ярьж байсан гэж битгий хэлээрэй.

Түүний шийдвэр түрүүчид ямар нөлөө үзүүлнэ гэж бодож байна вэ?
Түүнд өөрт нь?
Түүний армид?

**Олон жилийн дараа түүний бичсэн нь:**

*Анхнаасаа л миний үүрэг хариуцлага "Ах дүүгийн холбоо"–нд байсныг эргэлзэх зүйлгүй мэдэж байв. Би мөн түүнийг илчилсэнээр ямар сайн юм болох вэ гэж өөрөөсөө асуусан. Хэрэв тэр гэм буруутай болж шийтгүүлбэл энэ нь мөн л дайны уршигаар өөр нэг амьдрал хорлогдож байгаа хэрэг байсан.*

> *...Би түүнийг үнэхээр хөнөөе гэж бодоогүй байсныг ойлгосон. Энэ бол бохир дайн байсан, тиймээс өнгөрсөн юм өнгөрсөндөө (...) Би заримдаа дахин өөр алдаа гаргахад бэлэн ямарч гэмшсэн төрхгүй, хяналтгүй ахлагчийг зүүдэлж сэрдэг байв. Би тэр зүүд юун тухай байсныг ердөө ч санадаггүй юм. Гэхдээ олон хүн алагах байснаг сайн мэдэж байна. Яагаад гэвэл тэр дахин өөр алдаа, илүү тэнэг, илүү аймшигтай алдаа хийсэн юм.*

– Вьетнамд байсан Америк цэргийн дурсамж

# Хэвлэлийн хуудас

**Зорилго:** ОУХЭЗ—н хэрэгжиж буй арга замууд болон зөрчлөөс зайлсхийх хүчин чармайлтуудыг мэддэг болох

1. ОУХЭЗ—н ямар нэг дүрмүүдийн хэрэгжилтийн тухай жишээ гаргасан мэдээлэл ол.
   (Жишээ нь: олзны хүмүүсийг солилцох, шархадсан дайсныг халамжлах, энгийн иргэдийг хамгаалах)

2. Ямар дүрмүүд хэрэгжиж байна вэ? Үр дүн нь юу вэ?

МӨН

1. Зөрчлийг зогсоохыг оролдож буй чармайлтыг өгүүлсэн мэдээлэл ол.
   (Жишээ нь: Байлдагчдад зориулсан ОУХЭЗ—н сургалт, ямар нэг удирдагчийн хэлсэн үг, үйл хэрэг)

2. Ямар үйл явдлууд энэ хүчин чармайлтыг бий болгосон бэ?

3. Энэ хүчин зүтгэлүүд ямар үр дүнд хүргэсэн эсвэл хүргэж болох вэ?

Чиний бодлоор өөрийн орон нутагт болсон хэн нэгний хүний нэр хүндийг нь зөрчсөн явдлууд болон тэдгээрийг зогсоох хүчин чармайлтуудыг олж ярилц.

**Үнэлгээний аргууд:**

- Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:

"*Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь*" хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх бололцоог олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

- Сурагчдын ажлын хавтас:

Энэхүү бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

- Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

3—р бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20—30 минут), эсвэл 2—3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно. (25 минут)

   - **Хүмүүс яагаад ОУХЭЗ–г зөрчдөг вэ? Дэлгэрэнгүй жишээ дурдана уу.**
   - **Дайны нөхцөлд аливаа цэрэгт тулгарч болох хүнд хэцүү сонголтыг дүрсэлнэ үү. Дилемма нь юу байсан бэ? Үр дагаврууд нь юу вэ?**

2. Товч хариулах асуултууд: Хоёр асуулт сонгоно. (Тус бүр 10 минут)

   - Зөрчил нь зөрчлөө төрүүлсэн 3 жишээ дурдана уу.
   - Хэн нь энгийн иргэн бэ гэдгийг мэдээгүйгээс ямар нөлөө гарч болох вэ?
   - Үргэлж зөрчигдөж байдаг шударга хуультай байхын үнэ цэнэ юу вэ ?
   - Ми Лай дахь цэргүүдийн тулгарсан 2 дилемма юу вэ?

Сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

## Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- үзэл санаагаа бататгах тодорхой бодитой жишээ гаргах
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

## Хүмүүнлэгийн эрх зүйн хэрэгжилт/ерөнхий

- Зэвсэгт мөргөлдөөний үед мөрдөх хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн дүрмүүд. (Женевийн Конвенц ба түүний Нэмэлт Протоколууд)
  http://www.icrc.org/eng/ihl

Дараах эх сурвалжуудын хувьд хайлт хийхдээ "ОУХЭЗ" болон "Хүмүүнлэгийн эрх зүй" нэр томёъоны хажуугаар "Дайны гэмт хэргүүд" томъёог хэрэглэхийг санал болгож байна.

- Амнести Интернейшнл номын сан – сэдэвчилсэн индекс
  http://web.amnesty.org/web/contents.nsf/pagesbycountrytitle/gbrthemeshome

  "Хүмүүнлэгийн эсрэг гэмт хэргүүд" хэсэг нь ОУХЭЗ—н сүүлийн үеийн мэдээг агуулна.

- Yahoo
  http://dailynews.yahoo.com/full_coverage/

  Yahoo нь Reuters агентлагийн мэдээг оруулдаг бөгөөд бүс нутгийн болон үндэсний мэдээллийн агентлагуудыг хооронд нь холбож өгдөг.

- Улс орнуудын хэвлэл мэдээллийн Yahoo сан.
  http://dir.yahoo.com/news_and_media/by_region/countries/

- Бүс нутгийн хэвлэл мэдээллийн Yahoo сан
  http://dir.yahoo.com/news_and_media/by_region/regions/

- Online хэвлэлүүд
  http://www.newspaper.com

### Хэргийн судалгаа – Ми Лай

- Америкийн алдарт шүүх үйл ажиллагаанууд – Ми Лай цэргийн шүүх, 1970 он
  hhtp://www.law.umkc.edu/faculty/projects/ftrials/mylai/mylai.htm

- Вьетнамын дайн Интернет төсөл
  http://www.lbjlib.utexas.edu/shwv/shwvhome.html
  Вьетнамын дайны тухай Online эх сурвалжууд.




# 4 Бүлэг

# Шударга ёсны баталгаа

(Жич: Ахлах ангийнханд зориулав)

**(4 Хичээл)**

## СУДАЛГААНУУД:


Судалгаа 4А: Шударга ёсны суурь шалтгаан (2 хичээл) . . . 209

Судалгаа 4В: Олон улсын шүүхийн хувьсал (2 хичээл) . . . 225


## ОЙЛГОЛТУУД:

Хэрэгжүүлэлт
Хууль сахиулалт
Энгийн иргэн/байлдагчийн ялгаа
Хууль бус захирамж, тушаал
Нийгмийн дарамт
Хувь хүний хариуцлага
Удирдлагын хариуцлага
Дайны гэмт хэрэг
Шүүх ажиллагаанд оролцох эрх, тавигдах шаардлага

**Нийт бүлгүүдэд:**
Хүний нэр хүнд
Хүмүүнлэг зан үйлд учрах саад тотгорууд
Үр дагаврууд
Олон талт төлөв байдал
Диллема

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Төлөвшил
Үр дагавруудыг тодорхойлох
Эрх зүйн үндэслэл (гэм буруу, хариуцлага)

***Яагаад шударга ёс хэрэгтэй байдаг вэ?***

***Шударга ёсонд яаж хүрэх вэ?***

***Яллагдагчийг хэн шүүх ёстой вэ?***

# Судалгаа 4 А. Шударга ёсны суурь шалтгаан

2—р бүлэгт сурагчид ОУХЭЗ—н үндсэн дүрмүүд болон дэлхий даяар өөр цаг үед янз бүрийн соёлд бий болсон тэдгээрийн зарим эх сурвалжыг судалж мэдсэн. Тэд анхаарлын төвд байгаа шинэ сэдвүүдийг судалж, хүмүүнлэгийн эрх зүйн хөгжилд нөлөө үзүүлж болох хүмүүс болон үйл явдлуудыг мэдэж авсан. 3—р бүлэгт уг дүрмүүдийг дагаж мөрдөгдөж байгааг хэн хариуцах ёстойг суддахын зэрэгцээ мөн тэдгээрийн нийтлэг зөрчил шалтгааныг авч үзсэн.

4—р бүлэгт дүрмүүдийг бүрэн дүүрэн хүндэтгэн сахиж буй эсэхийг бататгахын тулд ОУХЭЗ—г хэрэгжүүлэх болон сахиулахтай холбогдсон зарим асуудлуудыг суддах болно. Хүмүүнлэгийн эрх зүйг баримтлах, дагаж мөрдөх талаар тэдний мэдлэгийг дэмжих арга хэмжээнүүдийн тухай энд бас яригдана.

Ахлах ангийн сурагчдад зориулсан зарим материалыг агуулж буй 4А судалгаа нь зөрчлийн үеийн шударга ёсны үндэслэлүүдийг хэлэлцэж, мөргөлдөөний хор уршгийг амссан улс орнуудын жишээн дээр Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комиссыг нэгэн арга зам болгон танилцуулж, сурагчдыг шударга ёсыг бататгахын тулд улс орнууд юу хийж болох тухай бодоход хүргэнэ.

---

**Зорилго:**
- Хууль зөрчигчдийг шүүн хэлэлцэх нь зэвсэгт мөргөлдөөний дараах нийгмийн сайн сайханд хэрхэн нөлөөлж болохыг ойлгох

**Ашиглах материалууд:**
- Дайны гэмт хэрэгт хүлээлгэх шийтгэлийн тухай саналуудын график
- Шударга ёсыг умартах буюу эрэлхийлэх үзэл санаанууд
- Баримт хуудас: Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комиссын тухай
- Уншлага: Гэмт хэргийн талаархи нийгмийн чимээгүй байдал.
- Уншлага: Хэтэрхий оройтсон гэж үү? Алжир/Франц



**Багш нарт:**
- Шударга ёсонд хүрэх гурван арга зам
- Хүмүүнлэгийн эрх зүйн ямар зөрчлүүд дайны гэмт хэрэг болдог вэ?

**Бэлтгэл ажил:**
- Сурагчдыг хичээлийн өмнө "Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс"—ын тухай нэгдүгээр хэсгийг уншсан эсэхийг лавлана. Ишлэлүүдтэй ажиллуулахын тулд сурагчдыг яаж бүлэгт хуваахаа төлөвлөнө.

**Хугацаа:**

45—60 минутын 2 хичээл

---

**1. Хууль дүрэм зөрчигдсөн үед яах ёстой вэ?**
(15—20 минут)

Сурагчдад ойр дотно нөхцөл байдлаас танилцуулж эхэлнэ.

**Боломжит асуулт:**

➤ Өдөр тутмын амьдралд хулгай, хүн амины хэрэг зэрэг эрүүгийн гэмт хэргээр яллагдаж буй хүмүүст юу тохиолддог вэ? (Өөрийн орны сүүлийн үеийн жишээнээс ашиглана уу.)

Хэлэлцүүлэгийг хүмүүнлэгийн эрх зүйтэй холбогдуулан өрнүүлнэ.

**Боломжит асуултууд:**

➤ Дайны гэмт хэргээр яллагдаж буй хүмүүсийг яадаг тухай та нар юу мэдэх вэ?
➤ Өдөр тутмын гэмт хэргүүд ба дайны гэмт хэргүүдийн нөхцөл байдал дахь ижил төстэй зүйл болон ялгаатай талууд нь юу вэ?

Доорхи хүснэгтэнд байгаа хоёр асуултын нэгийг сонгоно. Сурагчдаар аль нэг хариултыг сонгуулж, түүний учир шалтгааныг бичүүлнэ.

| | |
|---|---|
| **Асуулт1:**<br>Дайны гэмт хэрэг үйлдсэн хүмүүс шийтгүүлэх ёстой юу?<br><br>⅄ Тийм<br>⅄ Үгүй<br>⅄ Мэдэхгүй | **Асуулт2:**<br>Зэвсэгт мөргөлдөөн дууссаны дараа дайны гэмт хэрэг үйлдсэн хүмүүс:<br>⅄ Шүүгдэх ёстой юу?<br>⅄ Олон нийтэд шүүгдэлгүйгээр таниулагдсан байх ёстой юу?<br>⅄ Өршөөгдсөн байх ёстой юу?<br>⅄ Мөргөлдөөн дууссан үед мартагдсан байх ёстой юу? |

Асуулт болон тэдний санал бодлыг хэлэлцэнэ. Таны сонгосон асуултад харгалзах графиктай бүлгийн өгсөн хариултыг харьцуулна уу.




**Боломжит асуулт:**

➤ Зэвсэгт мөргөлдөөн дунд амьдарч байсан нь тухайн хүний хариултад яаж нөлөөлөх талаар юу гэж бодож байна вэ?

**2. Шударга ёсыг умартсаны буюу эрэлхийлэхийн үр дагаврууд** (20—25 минут)

"Шударга ёсыг умартах буюу эрэлхийлэх тухай үзэл бодлууд" тараах материалыг танилцуулж, хос хос буюу цомхон бүлэг сурагчдад хэсэг ишлэлийг даалгана.




Сурагчдаар шударга ёсыг умартах буюу эрэлхийлэхтэй холбоотой ишлэлүүдээс асуудлуудыг гаргаж ирэхийг даалгана. Тэд юу олж харсныг хэлэлцэнэ.

**Боломжит асуултууд:**

➤ Сонгосон шийдвэр нь дараах хүмүүст ямар үр дагаврууд үзүүлж болох вэ?
⅄ Хохирогчид
⅄ Зөрчигчид
⅄ Нийгэм бүхэлдээ болон сэргээн босголтын үйл явц

➤ Хэн нэгэн чамд хор хөнөөл учруулсан үед чиний үзүүлэх хариу үйлдлүүд юу вэ?

Сурагчдаар дараах хүснэгтийг бөглүүлнэ:

| **Хүмүүнлэгийн эрх зүй зөрчигдсөний дараа...** | | | |
|---|---|---|---|
| **Үзүүлэх нөлөө** | Хохирогчдод | Зөрчигчдөд | Нийгэмд |
| | | | |
| **Шударга ёсыг эрэлхийлэхийн**<br>**Шударга ёсыг умартахын** | | | |



**3. Үнэнийг Тогтоох Комиссоор дамжуулан шударга ёсыг эрэлхийлэх нь** (15—20минут)

Үнэнийг Тогтоох Комисс хэрхэн ажилладаг тухай "Үнэнийг Тогтоох Комиссын тухай" баримт хуудсыг ашиглан тодруулна.

**Боломжит асуултууд:**

➤ Үнэнийг Тогтоох Комисс шүүхээс юугаараа ялгаатай вэ?
➤ Ишлэлүүд болон бусад мэдээлэлд ямар давуу талууд болон хязгаарлалтууд байна вэ?
➤ Ямар нөхцөл байдалд Үнэнийг Тогтоох Комисс хамгийн сайнаар ажиллаж чадна гэж бодож байна вэ? Яагаад?
➤ Зэвсэгт мөргөлдөөний үеэр Үнэнийг Тогтоох Комисс ажиллуулах талаар та дэмжих үү? Ямар хүндрэлүүд буюу үр ашиг гарч болох вэ?

**4. ОУХЭЗ—н зөрчлийн шийтгэлүүд** (20—25 минут)

Женевийн Конвенцын дараах ишлэлийг танилцуулна:

*Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн ноцтой зөрчлийг үйлдэж байгаа буюу үйлдэхийг тушаасан этгээдэд үр дүнтэй эрүүгийн ял хүлээлгэхэд шаардлагатай аливаа хуулв тогтоомжийг батлах үүрэг хүлээнэ...*

— Бүх 4 Женевийн Конвенцид нийтлэг 49, 50, 129, 146—р Зүйл

Энэхүү зүйл ангийн юу гэсэн утгатай болох талаар хэлэлцэнэ үү.

**Боломжит асуултууд:**

➤ Ял шийтгэл гэж юу вэ? Яаж оноогддог вэ?
➤ Зэвсэгт мөргөлдөөний үед юуг ноцтой зөрчил буюу дайны гэмт хэрэг гэж үзэх вэ?

*[Сурагчдаар түүхийн мэдлэг болон өнөөгийн үйл явдлуудаас тийм зөрчлийн жишээ гаргуулна. Байлдааны үед нэг байлдагч нөгөө талын байлдагчийг гэмтээх буюу хөнөөх явдал нь ОУХЭЗ—г зөрчсөн гэмт хэрэг биш гэдгийг сануулахад илүүдэхгүй.]*

➤ Ноцтой зөрчлийг биеэр үйлдэгч ба түүнийг хийхийг тушаагч хоёрыг ОУХЭЗ ялгаж үздэг үү? Энэ асуултын талаар өөрийн үзэл бодлоо сурагчидтай хуввалцана.

(Хэргийн судалгаа болох Ми Лай ба 4В судалгаанууд хоёуланг нь гэм буруутай гэж заасан байгаа.)

**5. Шударга ёсыг бататгах хариуцлага** (20 минут)

Женевийн Конвенцүүд дайны гэмт хэрэг үйлдэгсдийг шударгаар шүүхийг нэгдэгч улс орнуудад өөрсдөд нь хариуцуулахаар тогтсон байдгыг сурагчдад дахин тодотгож хэлж өгнө. ОУХЭЗ—г хүндэтгэн сахиж, ноцтой зөрчлийн гэм буруутныг шүүн хянаж байгааг бататгахын тулд зарим арга хэмжээг мөргөлдөөний өмнө, болж байх үеэр болон дараа нь авсан байх хэрэгтэй.

Сурагчдаас дараах асуултуудад бичгээр хариулт авна:

Ямар арга хэмжээнүүдийг мөргөлдөөний өмнө, ид дунд болон дууссаны дараа . . . . . . . . . . . . . . . . —ны зүгээс авч хэрэгжүүлж болох вэ?

- Цэргийн хүчин?
- Засгийн газар?
- Шүүх, хуулийн байгууллага?

| | Энх тайван цагт | Зэвсэгт мөргөлдөөний үед | Зэвсэгт мөргөлдөөний дараа |
|---|---|---|---|
| Цэргийн хүчин | | | |
| Засгийн газар | | | |
| Шүүх, хуулийн байгууллага | | | |

Сурагчдыг бодлоо цаасан дээр буулгасны дараа тэдний санаа бодлыг хэлэлцэж ярилцана.

Дор жагсаасан алхам бүрийн чухал ач холбогдлыг тодорхойлно уу:

- Энх тайван цагт: ОУХЭЗ—н дүрмүүдийг аль болох өргөн хүрээтэйгээр, ялангуяа байлдагчид болон тэдний удирдлагад заан, түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй; зөрчилтэй холбогдсон шийтгэлүүд нь тодорхой заагдсан байх ёстой; хууль, шүүхийн аппарат нь ноцтой зөрчил үйлдэгсдэд хуулийн хариуцлага хүлээлгэхэд бэлэн байх ёстой.

- Зэвсэгт мөргөлдөөний үед: улс төрийн эрх мэдэлтэн болон удирдагчдын зүгээс байлдагчдад өгч буй тушаал даалгавар тодорхой байх хэрэгтэй. Дүрмүүдийг даган мөрдөж байгааг хянан удирдаж, цэргийн болон энгийн иргэдийн удирдагчид зөрчлүүдийг зогсоож байх ёстой; Үндсэн хэрэгцээ, шаардлагууд нь хангагдсан байх ёстой.

- Зэвсэгт мөргөлдөөний дараа: Үндэсний ба/буюу олон улсын хэмжээнд шударга шүүх зохион байгуулагдсан байх ёстой. Хэлмэгдэгсдэд нөхөн төлбөр олгогдох ёстой.

**Хаалт** (5 минут)

Хэлэлцэнэ үү:

- Зэвсэгт мөргөлдөөний дараа шударга ёсыг бататгахад жирийн иргэд ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?
- Зэвсэгт мөргөлдөөнд гарах үед хүмүүнлэгийн эрх зүй зөрчигдөхгүй байгааг бататгахад тэдний гүйцэтгэж чадах үүрэг юу вэ?

**ГОЛ САНААНУУД**

- Хүмүүнлэгийн эрх зүй нь уг хуулийг ноцтойгоор зөрчигч буюу зөрчихийг тушаасан этгээдийг шударгаар шүүхийг шаарддаг.
- Женевийн Конвенцид нэгдсэн улс бүр ОУХЭЗ—г түгээн дэлгэрүүлэх, хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Нэмэлт дасгал

### Нам гүмийн цуурай

“Дайны гэмт хэргийн талаарх нийгмийн чимээгүй байдал" эссег уншаад түүхийн баримтаас улс орнууд өнгөрсөн гутамшигт явдлаа мартахаар шийдсэн жишээг сонгоно. Эрдэмтэн Ариех Найерийн хэлсэн үгэнд хариулах эссе бичнэ үү:
Энх тайван байдалтай харилцан орших явдал нь хэлмэгдсэн хүмүүс, хохирогчид тэдний зовлон шаналлын учрыг тайлбарлах хэн нэгнийг олж харахгүй бол биелэхэд хялбар бус болов уу.



*Түүхээс сонгож авсан жишээ тань Найерийн мэдэгдлийг дэмжиж байна уу, үгүйсгэж байна уу?*

### Хууль дүрэм зөрчигч үйлдэлтэйгээ нүүр тулгарав

Дараах ишлэлийг уншина уу:

*Өмнөд Африкийн Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комиссын шүүх хуралдаан дээр цагдаа Жейфрей Бензиен олзлогдогчийн ард сууж түүний толгойг уутаар боож бүтэж үхэхэд хүргэх явдал буюу “нойтон уут” тамлах аргыг батлан харуулжээ. Хуучин түр саатуулагч байсан Тони Енгени Бензиений өмнө очоод “Ямар хүн тийм зүйл хийж чаддаг байнаа” гэж асуув.*

*“Би (...) өөрөөсөө ч тийм асуулт асууж байсан. Би сайн дураараа сэтгэлзүйч дээр очиж өөрийгөө ямар хүн болохыг шалгуулж байсан.” гэж Бензиен хариулав.*

➤ Хохирогчид ба хууль зөрчигчидийн бие биетэйгээ ярилцах боломжтой байхын үр ашиг нь юу вэ?

*Чанга дэглэмтэй хорих ангид 10—аад жил хоригдсон Оросын зохиолч Сольженицений хэлсэн үгийг энэ байдалтай харьцуулж харна уу:*
*Хэрэв тамлагчид бидний оронд байсан бол тэд бидэн шиг аашлах байсан. Хэрэв бид тэдний оронд байсан бол тэдэн шиг болж чадах байсан.*

➤ Хуульч Денис де Бешион энэ хуулийг хүмүүнлэг нигүүлсэнгүй бус байхын эсрэг босгосон далан гэж тодорхойлсон. Дараах мэдэгдлийн хүрээнд хүмүүнлэгийн эрх зүйг хэлэлцэнэ үү:

*Энэхүү эрх зүй бол хүнийг тодорхой хүрээнд барихыг, түүний тэсрэлт болон тэдний бодит байдал дээр хэрэгжих хоёрын хооронд ямар нэгэн зүйл оруулахыг зорьдог, тэр нь саад тотгор юм.*

### Түүх:

Танай бүс нутгийн түүхэнд ямар хүн зэвсэгт мөргөлдөөний үед хүнлэг бус зан үйлээсээ болж буруутгагдаж байсан бэ? Энэ талаар юу хийгдсэн бэ? Үр дүн нь юу байв?

## Нэмэлт дасгал

**Хэтэрхий оройтсон гэж үү?**




“Хэтэрхий оройтсон гэж үү? – Алжир/Франц" хэмээх 40 жилийн өмнөх Алжирын тусгаар тогтнолын дайны үед гарч байсан тамлан зовоох үйлдүүдийн тухай сүүлийн үед гарсан Францын мэтгэлцсэн хэлэлцүүлгийг уншина. Дараах асуултанд хариулт болох богино өгүүлбэрүүд бэлтгэнэ.

➤ Ийм их хугацаа өнгөрсөний дараа энэхүү нөхцөл байдал дахь зөрчлүүдтэй холбогдуулан юу хийж болох байсан бэ? Ямар зорилгоор?

Өөрийнхөө үзэл бодлыг хамгийн тод харуулж байгаа ишлэлийг сонгож аваарай.

Өөрийн шийдвэрийг танилцуулж, энэ нь цаашид гарах зөрчлүүдээс хэрхэн сэргийлэх, хохирогчдын сэтгэл санааг засахыг хэрхэн хөхиулэн дэмжих, улмаар Франц болон Алжирын хувьд хэрхэн үр ашигтай байх тухай тайлбарлана.

Хамтрагчдынхаа санал бодолтой өөрийнхийгөө харьцуулна.

Дэлхийн 2–р дайны дараа Женевийн Конвенцид заасны дагуу олон улсад маш олон тооны дайны гэмт хэрэгтнүүд шийтгэгдсэн билээ. Жишээ нь, Франц, Голланд, Израйль, АНУ, Англи, Хятад зэрэг улсад цэргийн болон энгийн иргэд зөрчигчид болсон хэргүүд гарч байлаа.

1990–ээд оны үед дэлхийн 2–р дайнд үйлдэгдсэн гэмт хэргүүдийг шүүн хэлэлцүүлж байсан тодорхой улсуудад төдий их хугацааны дараа ялаас хэлтрүүлэн өршөөх тухай ярих хэрэгтэй гэж маргаж байв.

➤ Санал нэгтэй байна уу? Хэдий хэр цаг хугацаа өнгөрсөн байх хэрэгтэй вэ?

Өөрийнхөө байр суурийг илэрхийлсэн эссе бичээрэй.

# Шударга ёсонд хүрэх 3 арга зам

ОУХЭЗ нь бусад бүхий л хууль эрх зүйн системийн нэгэн адил хууль хэрэгжүүлэх болон сахиулах механизмыг шаарддаг. Улс орнууд Женевийн Конвенцийн зөрчлүүдийг таслан зогсоох үүрэгтэй бөгөөд дайны гэмт хэрэг зэрэг ОУХЭЗ—н хамгийн ноцтой зөрчлүүдтэй холбоотой тусгай үүрэг хариуцлага хүлээнэ. ОУХЭЗ нь хувь хүн бүрийг гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдүүлэхээр тушаасных нь төлөө хариуцлага ногдуулна. Тэдгээрт уг ноцтой зөрчлүүдэд эрүүгийн гэмт хэргийн хуулийн хариуцлага болон шийтгэл оногдуулахыг шаарддаг. Энэ нь үндэсний хэмжээнд буюу зарим тохиолдолд олон улсын түвшинд хийгдэж болно. Зарим улс орнууд шударга үнэн ба зөвшилцлийн комисс байгуулах замаар шударга ёсыг эрэлхийлэх гуравдагч арга замыг бий болгосон байна.

### 1. Үндэсний дотоод хууль дүрэм, шүүхээр дамжуулан хууль сахиулах нь

Женевийн Конвенц нь нэгдэн орсон улс орнуудад ОУХЭЗ—н ноцтой зөрчлүүдэд хариуцлага хүлээгсдийг шийтгэх эрүүгийн хууль тогтоомжийг хуульчлан батлахыг даруй даалгасан байдаг.

Ерөнхийдөө улс орнуудын дотоод эрүүгийн хууль зөвхөн өөрийн орны иргэний үйлдсэн эсвэл уг орны нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн гэмт үйлдлүүдэд үйлчилдэг. ОУХЭЗ цааш нь өргөжүүлээд, улс орнуудыг ноцтой зөрчил үйлдэгсдийг үндэс угсаа буюу гэмт хэргийн хаана үйлдсэнийг харгалзахгүйгээр эрж хайх, шийтгэл хүлээлгэхийг шаарддаг. Энэ зарчмыг бүх нийтийн шүүх эрх мэдэл гэдэг. Олон орон (Канад, Бельги, Швейцарь, Орос, Энэтхэг, Кени, Австрали зэрэг) хэрэг хаана үйлдэгдсэн, хэн холбогдсон зэргийг нь авч үзэлгүйгээр дайны гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг өөрсдийн шүүх системээр шүүн хэлэлцэж байхын тулд эрүүгийн хэргийн хууль цаазуудаа дахин засварласан.

Дайны гэмт хэргээр тухайн этгээдүүд шүүгдсэн. Жишээ нь, Австралид (Дэлхийн 2—р дайны үед Украйнд Европчуудын эсрэг үйлдсэн гэмт хэрэг), Канадад (Дэлхийн 2—р дайны үед Европт үйлдсэн гэмт хэрэг), Швейцарь, Дани, Бельги улсуудад (Хуучин Югославт, 1994 онд Руандад үйлдсэн гэмт хэрэг).

Улс орнууд нь мөн ноцтой зөрчлүүдээр яллагдаж буй хүмүүсийг эрж хайн тэднийг өөрийн улсын шүүхийн өмнө авчрах, эсвэл тэднийг шүүн хэлэлцэхийг хүсч буй өөр улсын шүүхэд шилжүүлэн өгөхийн аль нэгийг гүйцэтгэх үүрэгтэй.

Улс орнууд ноцтой зөрчилд хамаарах эрүүгийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаан дээр бие биендээ тусална.

ОУХЭЗ—г зөрчигчдийг улс орнууд өөрсдийн шүүхээр шүүн хэлэлцэх тохиолдолд үүнийг үндэсний хууль сахиулалт гэнэ.

Үндэстнүүд дайны гэмт хэргээр яллагдаж буй өөрийн орны иргэдийг шүүх явдлыг хэд хэдэн шалтгааны улмаас өөр орны шүүхээр хэлэлцэхээс илүүд үздэг байна:

- Шүүгдэгч хэрэг үйлдэгдсэн газрын шүүхээр шүүгдсэнээс өөрийн орны шүүхээр шүүгдсэн тохиолдолд шударга шүүхээр (буюу өөрийн ашиг сонирхлыг баримталсан шүүхээр) шүүгдэх илүү боломжтой байх болно гэж үздэг.
- Шүүн таслах ажиллагаа нь төрөлх хэл дээр бөгөөд танил хууль эрх зүйн системд шүүгдэх явдал нь шүүгдэгчид хялбар байх талтай.
- Шүүх ажиллагаа явуулах нь засгийн газар өөрсдийн хүмүүсийн үйлдэлд (ялангуяа цэргийн албан хаагчийн үйлдэлд) хариуцлага хүлээж байгааг харуулна.

Засгийн газрууд мөн тодорхой шалтгаанаар өөрсдийн хүмүүсийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн өөр улсын иргэдийг өөрсдийн шүүхээр шүүхийг илүүд үздэг:

- Тэд өөр улсын засгийн газар тэр улсад амьдардаггүй хүмүүст учруулсан ёс бус үйлдлийг шийтгэх асуудалд бага анхаарал хандуулна гэж боддог.
- Тэгснээрээ уг засгийн газар хүчирхэг, үр нөлөөтэй бөгөөд өөрсдийн хүмүүсийн эрх ашгийн төлөө ажилладаг гэдгээ харуулна гэж боддог.
- Гадаад орны иргэдийг шүүх ажиллагаа нь олон нийт, ялангуяа уг гэмт хэргийн хохирогчдын хувьд чухал ач холбогдолтой.

Гэсэн хэдий ч үндэсний хууль сахиулалт зарим асуудлуудыг бий болгодог. Өөр оронд болсон гэмт хэргийг мөрдөн байцаах нь маш хүндрэлтэй байдаг. Дайны гэмт хэргээр яллагдагчийг олж тогтоон, тэднийг шүүхээр хэрэг болсон газар авчрах нь нэн хүндрэлтэй байдаг. Өөр нэг асуудал бол үндэсний хууль сахиулалт заримдаа шударга бус болдог. Заримдаа дараах нөхцөл байдалтай тулгардаг:

- Шүүх өөрийн үндэстний эсрэг үйлдэгдсэн дайны гэмт хэргийн төлөөх өс хонзонгийн нөлөөгөөр хүмүүст шударга бусаар ял оноож болох талтай. Эсвэл шүүх нь олон нийтийн үзэл бодлоос эмээж байж болно. Нөгөөтэйгүүр, засгийн газар нь өөрийн иргэддээ үр өгөөжтэй үйлдэл хийж байгааг харуулах зорилгоор хүмүүст ял оноохыг шүүхэд шахалт үзүүлэх замаар хийж болох юм.
- Гэмт хэрэг үйлдсэн яллагдагчийн талыг барьдаг бүлгүүд буюу улс оронтой зөрчилдөөнд орохгүйн тулд аливаа засгийн газар нь дайны гэмт хэргийг мөрдөн байцаадаггүй байж болно.
- Дотоодын мөргөлдөөний үед гарсан гэмт хэргүүдийг шүүх ажиллагаа нь уг мөргөлдөөнд холбогдсон илүү хүчирхэг улс төрийн буюу угсаатны бүлгүүдийг өмгөөлж болзошгүй.

Түүний дээр, засгийн газар нь дайны гэмт хэргээр яллагдаж буй буюу сэжиглэгдэж байгаа өөрийн үндэстнүүдийг мөрдөн байцаах хүсэлгүй байдаг. Тухайн засгийн газар дараах зүйлд санаа зовж болно:

- Уг мөрдөн байцаалтаар тухайн хэрэгт оролцсон буюу оролцохыг тушаасан засгийн газар, цэргийн дээд албан тушаалтнуудыг илрүүлж болно.
- “Дайсан” гэж үзсэн хүмүүсийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн улмаас үндэсний цэргүүдийг шүүх ажиллагааг олон нийт эсэргүүцэж байх
- Хэрэв хүмүүс үйлдсэн (эсвэл үйлдэх даалгавар авсан) хэргийнхээ төлөө шоронд хоригдохоос айж байвал зэвсэгт хүчинд цэрэг элсүүлэхэд хүндрэлтэй байх болно.

Дайны гэмт хэрэгтэй холбогдуулан тэмдэглэж хэлэхэд, улс орнуудын удирдлагууд халдашгүй эрхтэй байдаггүй; тушаал дагах нь шалтаг биш; командлагч болон бусад удирдагчид тодорхой нөхцөлд өөрсдийн доод албан тушаалтнаа хариуцдаг; мөн хууль зөрчигчид шүүгдэгдээгүйгээс хойш цаг хугацааны хязгаар байхгүй.

## 2. Олон улсын эрүүгийн шүүхээр дамжуулан хууль сахиулах нь

Женевийн Конвенцид зааснаар, үндэстнүүд “ноцтой зөрчил үйлдсэн буюу үйлдэх тушаал өгсөн хүмүүсийг эрж хайн үндэс угсааг нь харгалзалгүйгээр өөрийн шүүхэд өгөх үүрэгтэй” хэдий ч, дэлхийн нийгэмлэг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг сахиулахыг зөвхөн хувь үндэстэнд даалгаж болохгүй гэж шийджээ.

### Тусгай шүүх

20 дугаар зууны дунд үе хүртэл дайны хуулиуд нь зөвхөн үндэстэн бүрийн цэргийн шүүхүүдээр гүйцэтгэгддэг байв. Анхны олон улсын эрүүгийн шүүх дэлхийн 2−р дайны дараа Англи, Франц, АНУ болон ЗХУ олон улсын эрх зүйг ноцтойгоор зөрчсөн Нацист хэрэгтнүүдийг шүүхийн тулд Олон Улсын Цэргийн Шүүх (ОУЦШ) нэртэйгээр байгуулагдсан юм. Уг шүүхийг шүүх ажиллагаа явагдсан Герман хотын нэрээр Нюрнбергийн шүүх гэж нэрлэсэн. Мөн Токиод Алс Дорнодын Олон Улсын Цэргийн Шүүх, 11 улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр олон улсын эрх зүйг ноцтой зөрчсөн Японы хэрэгтнүүдийг шүүхээр байгуулагджээ.

40−өөд жилийн дараа дахин хоёр олон улсын эрүүгийн шүүх НҮБ−ын Аюулгүйн Зөвлөлөөс дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн болон геноцидийн эсрэг гэмт хэргүүдийг шийдвэрлэхээр байгуулагджээ. Эхнийх нь хуучин Югославын дайны үед 1991 оноос хойш үйлдэгдсэн хэргийг хянан шийдвэрлэхээр 1993 онд, удаах нь Руанда болон Руандагийн иргэд хөрш оронд үйлдсэн дайны хэргийг шийдвэрлэхээр 1995 онд байгуулагджээ.

Зарим хүмүүс эдгээр 4 тусгай шүүх нь, тус бүр байгуулагдахдаа олон улсын хэмжээний улс төрийн хүсэл эрмэлзэл, их хэмжээний цаг хугацаа болон үйл ажиллагаа явуулахын тулд нүсэр их санхүүгийн эх сурвалж шаардаж байдаг учраас ОУХЭЗ−г сахиулах хамгийн үр өгөөжтэй арга биш гэж үздэг.

### Олон Улсын Эрүүгийн Шүүх

Байнгын олон улсын эрүүгийн шүүхтэй байх санал олон арван жилийн турш байсан. Сүүлд байгуулагдсан хоёр тусгай шүүх нь уг үзэл санааг олон улсын хэмжээнд улам тод гаргаж ирсэн.

Удаан үргэлжилсэн бэлтгэл хэлэлцүүлгийн үр дүнд 1998 онд Ром хотноо олон улсын дипломат уулзалт хуралдаж, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийг (ОУЭШД) баталсан. Энэ нь гэмт хэргийн 4 категорийн хүрээнд шүүх эрх мэдэлтэй — геноцид, хүн төрөлхтний эсрэг, дайны, түрэмгийллийн гэмт хэргүүд орно.

> *Бүх дэлхийн хүмүүс, хэзээ ч юу ч болсон геноцид, дайны гэмт хэрэг буюу бусад зөрчил гарсан тохиолдолд уг гэмт этгээдийг хянан байцаах, ялаас чөлөөлөгдөөд байгаа нийтлэг үзэгдлийг эцэс болгох, төр засгийн болон цэргийн шатлан захирах түвшинд байгаа хувь хүн бүр, удирдагчдаас энгийн цэрэг хүртэл, ямар ч ялгаваргүйгээр үйлдэлд нь хариу өгөх тийм шүүх байгаа гэдгийг мэдэж авахыг хүсдэг.*

— Кофи Аннан, НҮБ—ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга асан

Уг Дүрэм 60 улсаар соёрхон батлагдсаны дараа хүчин төгөлдөр болж, 2002 оны 7—р сарын 1—нээс ОУЭШ үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. 2002 оны 4—р сарын байдлаар Дүрмийг 139 орон үзэглэж, 66 улс соёрхон баталжээ.

Уг Шүүх нь геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг гэсэн 4 төрлийн гэмт хэргийг шүүх эрх мэдэлтэй.

Цөөн тооны үндэстэн байнгын дэлхий нийтийн шүүх байгуулахын эсрэг байсан юм. Зарим нь уг шүүхийг хэт их эрх мэдэлтэй, улс төрийн зорилгоор буруу ашиглагдаж магадгүй гэж сэрэмжилж байлаа. Нөгөө хэсэг нь ОУЭШ—ийн эрх зүйн бүрэн чадамжийн хүрээнд тодорхой дадал, туршлагууд үгүй болно гэж санаа зовсноос гарын үсэг зурахаас татгалзсан. Зарим нь мөн уг шүүхийг тэдний хүчний хилийн чанадад томилогдсон зэвсэгт хүчний гишүүдийг өөрийн улсад шүүгдэх давуу талыг хангалгүйгээр хянан шалгах болно гэж сэрэмжилж байсан.

Байнгын дэлхийн нийтийн шүүх нь олон улсын эрх зүйг хэрхэн сайн сахиулахыг үнэндээ хэн ч мэдэхгүй. Английн улс төрийн нэгэн алдартай сэтгүүлийн хууль эрх зүйн редактор тэмдэглэн хэлэхдээ, төр засгууд дайны гэмт хэргийг хуулиас гадуур хэмээн тооцож гэрээнүүдэд гарын үсэг зурсан гэжээ. Төр засгууд гэрээнд гарын үсэг зурахдаа заримдаа ёжилсон байдлаар, заримдаа сайн санаж зурдаг хэдий ч, уг гэрээ хэтийн ирээдүйд хэрэгжихгүй гэдгийг мэдсээр байж зурдаг явдал ч байж магадгүй. Олон Улсын Эрүүгийн Шүүх энэ бүхнийг өөрчилсөн нь хууль эрх зүй хангалттай үйлчлэхгүй байсан газруудад түүнийг түгээн дэлгэрүүлэх ажлын эхлэл болсон юм. Энэхүү Шүүх нь олон улсын эрх зүйд хувьсгал мэт байлаа. Амжилттай болох эсэхийг хэлэхэд хэцүү. Энэ бол туршилт юм.

Олон улсын шүүхүүд нь ОУХЭЗ—н зөрчлүүдтэй хариуцлага тооцдог, тэднээс сэрэмжлэх оролдлогуудыг дэмждэг хэдий ч, үндэсний шүүх байгууллагуудын үүргийг бүхэлд нь нөхөн орлож, үр өгөөжтэй үндэсний эрүүгийн эрх зүйн системийн шаардлагыг хангаж чадахгүй гэдэг нь тодорхой. Улс орнууд ОУХЭЗ—г хүндэтгэн сахих, зөрчлүүдээс сэргийлэх, тэдэнд хариуцлага тооцох зэрэг үндсэн үүргүүдээ үргэлжлүүлэн гүйцэтгэх болно. Үндэсний хэмжээн дэх үр өгөөжтэй үйл хөдлөлөөр л ОУХЭЗ—г бүхэлд нь хүндэтгэн сахих нь бататгагдана.

### 3. Үнэнийг тогтоох комиссоор дамжуулан шударга ёсыг эрэлхийлэх нь

Латин Америкийн орнууд шударга үнэний комисс гэсэн хуулиар хүлээх хариуцлагын өөр нэг загварыг бий болгосон. Аргентинд анхны үнэнийг тогтоох комисс 1983 онд өмнөх дэглэмийн үед сураггүй алга болсон мянга мянган хүний бодит байдлыг судлуулахаар байгуулсан. Зуу зуун гэрчийн мэдүүлэг дээр үндэслэн комисс, нууц хорих лагерь байсныг болон 8900 гаруй хүн "сураггүй алга болсон" баримтыг тогтоосон юм. Энэ нь хариуцлага хүлээлгэх хэргүүдийн эхлэл болсон юм. Уг комиссоос 1984 онд гаргасан, номны урттай адил хэмжээний, тэдний олсон мэдсэн зүйлсийн тайлан, Nunca Mas (Хэзээ ч Дахин Болохгүй) нь хүний эрхийн холбогдолтой тайлангууд дундаа сонгодог нь билээ.

Үнэнийг тогтоох комисс нь шүүх биш юм. Энэ нь өнгөрсөн хүчирхийлэл, гэмт хэргүүдтэй холбоотой баримтуудыг тодорхойлох хүсэлтийг шүүн таслах ажиллагаа явуулдаг. Зарим Үнэнийг Тогтоох Комисс нь олон нийтийн эрх мэдэл бүхий байгууллагаар, бусад нь хувийн хэвшлийн байгууллагаар үүсгэн байгуулагддаг. Болгоомжтой бөгөөд төвийг сахисан процессоор гүйцэтгэсэн тохиолдолд, эдгээр комисс нь дайны гэмт хэрэгтэй (жишээ нь, Эл Сальвадор, Никарагуа) ба өмнөх засгийн газрын дэглэмийн үйлдсэн хүний эрхийн зөрчилтэй (жишээ нь, Аргентин, Чили, Бразил ба Хайти) холбоотой баримтыг түргэн шуурхай, шууд аргаар бүрдүүлдэг. Уг комисс нь ерөнхийдөө тайлан, мэдээлэл нийтэлж, тухайн улсын засгийн газар гэмт хэрэгт ямар хариу үзүүлэх болон цаашид зөрчлүүдийг өргөн дэлгэр тархахаас хэрхэн зайлсхийх талаар санал өргөдөг байна.

**Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс**

Өмнөд Африк шударга ёсыг эрэлхийлэх энэхүү арга замыг цааш нь улам өргөжүүлжээ. Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс нь Өмнөд Африкийн улс төрийн болон эдийн засгийн системд ноёрхсон цагаан арьст цөөнхийн үзэл болох апартейд буюу арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг гарсан мөргөлдөөний үеэр болж үйлдсэн гэмт хэргүүдийг байцаан шалгах зорилгоор байгуулагдсан. Арьс өнгөөр ялгаварлах үзлийн хүрээнд, Ази болон холимог гарал үүсэлтэй хүмүүсийн зэрэгцээ хар арьст Африкчууд Европын өвөг дээдэстэй Өмнөд Африкчуудад олгогдож буй олон давуу эрх, ашиг сонирхлыг эдэлж чадахгүй байлаа. Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх комисс Өмнөд Африкийн Засгийн газар болон арьс өнгөөр ялгаварлагч Засгийн газрын эсрэг гарсан зэвсэгт бослогыг өдөөсөн Африкийн үндэсний конгресс (АҮК) зэрэг бүлгэмүүдийн нэгэн адил арьс өнгөөр ялгаварлах үзлийг дэмжигчдийн үйлдсэн гэмт хэргүүдийг шинжлэн судалсан байна.

Өмнөд Африкийн үнэнийг тогтоон эвлэрүүлэх комисс нь хууль зүйн системийн нэгэн хэсэг болж байгуулагдсанаараа өмнөх үнэнийг тогтоох комиссоос ялгаатай. Үүний зорилго нь хариуцлага хүлээлгэн шийтгэхдээ бус, хувийн болон улс төрийн зөвшилцлийг тогтоох явдал юм. Комисс нь хэрэв хууль зөрчигчид юу хийсэн тухайгаа дэлгэрэнгүй бөгөөд үнэнч шударгаар мэдүүлбэл хууль эрх зүйн дагуу уучлах (өршөөл үзүүлэх явц) боломжийг олгосон. Комисст бүрэн гүйцэд, шударгаар мэдүүлэг өгөөгүй гэмт буруутнууд үндэсний эрх зүйн хүрээнд хариуцлага тооцогдсоор байх болно.

Мянга мянган хүн өршөөл хүсч үнэнийг тогтоох комисст ханджээ. 1999 оны эцсээр үнэнийг тогтоон эвлэрүүлэх комисс нь нийт 6309 хэрэг шийдвэрлэснээс 568 хүнд өршөөл үзүүлж, 5287—д нь татгалзаж, 21—д нь хэсэгчилсэн өршөөл үзүүлж, 161 нь хүсэлтээ татан авсан байна. Түүнчлэн 272 хэргийг шийдвэрлэлгүй орхижээ.

Өршөөл үзүүлэх шалгуурын ихэнх нь хэрэгтэн хэргийн баримтаа өөрөө илчлэн уг үйлдлүүдийг улс төрийн шалтгаанаар үйлдсэн, хувийн ашиг сонирхол, хорон санаа агуулаагүй байсан гэдгээ батлахтай холбоотой байна. "Үйлдлийн хүнд хөнгөн, ноцтой байдал" ба "Пропорциональ байдлыг" үйлдэл болон түүний хүлээгдэж буй үр дүнтэй уялдуулан тооцдог байна.

Өмнөд Африкийн Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх комисс дайны гэмт хэрэгт хохирогчдод туслах зорилгоор тэднийг уг түүхээ дэлхий дахинд дуулгах боломж олгох, нийгмийн үйлчилгээгээр хангах, мөнгөн төлбөр олгох зэрэг ажлуудыг хийдэг. 20000—аас илүү хүний эрх нь зөрчигдсөн хэлмэгдэгчид комисст хандсан байна.

Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисст мөн дутагдалтай талууд бий. Мэдүүлэг өгсөн олон хүн үйл явдлын шууд гэрч биш байлаа. Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх комисс нь зөвхөн тэдний өмнө гэрчийн мэдүүлсэн хэргүүдийг шалгаж мөрдсөн байна. Хэрэв гэрч сайн дураар мэдүүлээгүй бол хэрэг шалгагдахгүй байлаа. Тэд үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн байсан ч гэмгүй хүмүүсийг хөнөөж, тамлаж байсан хүмүүс ял шийтгэлгүй явж байх уу гэдэг гол асуудал гарч ирдэг. Мөн хэлмэгдэгсдэд олгож буй нөхөн төлбөр тэдний зовлонг нимгэлж чадахуйц хангалттай байж чадах уу гэсэн асуултууд ч байдаг (эмчилгээний төлбөр, гэр бүлийн нэг гишүүн алагдсанаас болсон орлогын алдагдал зэрэг орно).

## Хүмүүнлэгийн эрх зүйн ямар зөрчлүүд дайны гэмт хэргийг үүсгэж болох вэ?

Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрэм нь аливаа хамгаалагдсан хүний эсрэг үйлдэгдсэн дайны гэмт хэрэгт хүргэдэг ОУХЭЗ—н ноцтой зөрчлүүдийг жагсаан гаргасан юм. Хамгаалагдсан хүмүүс гэдэг нь шархадсан буюу өвчтэй байлдагчид, олзлогсод, энгийн иргэд юм. Заримаас нь дор тоймлон үзүүлэв:

- Санаатайгаар хүний амь насыг хороох
- Эрүүдэн шүүх ба хүнлэг бусаар харьцах (...)
- Их хэмжээний гарз хохирлыг санаатайгаар бий болгох (...)
- Энгийн иргэд, энгийн иргэдийн объект эсвэл хүмүүнлэгийн тусламжтай холбоотой хувь хүн, байгууламж, материал, нэгж буюу авто хэрэгсэл рүү санаатайгаар шууд халдах
- Цөллөх, энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэх
- Угийн үл ялгаварлах буюу хэрэгцээгүй зовлон шаналал учруулах хориглогдсон зэвсэг, материал, дайны арга барилыг хэрэглэх
- Энгийн иргэдийн хоол хүнсний хомсдолыг байлдааны арга барилд ашиглах, амьд үлдэхэд зайлшгүй шаардлагатай объектыг санаатайгаар хомсдуулах
- Хот газрыг дээрэмдэн тонох
- Хүн барьцаалах
- Хүчин, сексийн боолчлол, албадсан бие үнэлэлт болон бусад хэлбэрийн сексийн хүчирхийлэл үйлдэх
- Зэвсгээ хураалгасан, эсвэл өөрийгөө хамгаалах чадваргүй, өөрийн саналаар бууж өгсөн байлдагчийг шархдуулах буюу хороох
- 15—аас доош насны хүүхдүүдийг зэвсэгт хүчинд элсүүлэн авах буюу дайчлах, цэргийн үйл ажиллагаанд идэвхитэйгээр оролцуулах
- Хэтэрхий их, тохиолдлын хор хохирол амь насанд учруулах, энгийн иргэдийг гэмтээх, энгийн иргэдийн объектыг устгах, байгалийн хүрээлэн буй орчинд удаан хугацаанд үргэлжлэх хор хөнөөл учруулах үр нөлөөг мэдэж байсан ч санаатайгаар халдан дайрах
- Энгийн иргэд болон бусад хамгаалагдсан хүмүүсийг тодорхой цэг, газар буюу цэргийн хүчинг цэргийн үйл ажиллагаанаас холдуулахад ашиглах
- Хууль ёсны шүүхээр тогтоогдсон, ерөнхийдөө чухал шаардлагатай гэж тооцогдох шүүхийн баталгааг олгох өмнөх ялын тогтоолгүйгээр оногдуулсан ялыг гүйцэтгэхгүй, хэрэгжүүлэхгүй байх

— Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрэм, 8 дугаар зүйлээс.

# Дайны гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн талаархи санаа бодол

Дайны гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэх ёстой юу?




Мөргөлдөөн дууссан үед дүрэм зөрчигчид . . . . . . . . . . . . ёстой юу?




1998—1999 онд 16 улсад хийгдсэн судалгаа (түүний дотор 12 улс нь сүүлийн үед зэвсэгт мөргөлдөөнтэй тулгарсан). Эдгээр графикт хариулт өгсөн хүмүүсийн үзэл бодлыг тусгав.

# Шударга ёсыг умартах буюу эрэлхийлэхтэй холбогдсон үзэл бодлууд

Иргэний дайн нэгэнт дууссан бол уучилж, мартах ёстой.
— Пол Тибо, эссе нийтлэгч

Хэтэрхий их өршөөл уучлалт нь шарх эдгэрэхийг зогсоодог.
— Луйс Жойнет, төрийн түшмэл бөгөөд ялаас чөлөөлөх асуудал дээрх НҮБ—ын тусгай илтгэгч

**Камбож: хоёр хохирогчийн үзэл бодол**

**Дуу хоолой 1:**
Түүний тайван байдал, түүний хөндий байдал нь тэр өөрийн хувийн эмгэнэлт явдлаа давж гарсан мэт санагдуулна. Гэвч тийм биш юм. Тэр одоо ч тэр аймшигт дууг сонссоор л байгаа, тамлан зовоож байгаа дүр зургууд түүний ой ухаанд нэвт шингэсэн. Тэр шударга ёсыг л хүссэн. Өшөө хорсолыг биш.

*Би яаж мартаж чадах билээ. Би тэр үед 30 настай байсан бөгөөд энэ бүхэн миний ой ухаанд арилшгүйгээр бичигдсэн юм. Бүх хохирогчид миний адил бодож байлаа. Бид Кхмер Ружийн удирдагчийг хийсэн хэргийнхээ хор уршигийг үүрэхийг хүсдэг.*

— Ванн Нат, 18000 хүн амь үрэгдсэн Камбожийн тарчлаан зовоох төвөөс — Амьд үлдсэн нэгэн.

**Дуу хоолой 2:**
Хэрэв Та Мок (Кхмер Ружийн удирдагч) шүүхэд шилжсэн байлаа гэхэд дундаж Камбожийн иргэдийн амьдралд ямар өөрчлөлт гарах байсан юм бэ? Миний хүсч буй зүйл бол Камбож энх тайван байдалтай хэвээр үлдэх л явдал юм.

— Таван ах эгч, аавыгаа алдсан таксины жолооч

**Чили: 2 үзэл бодол**

**Дуу хоолой 1:**
Улс төрчдийг шүүхэд өгөх нь өөрийн ухамсар, зөнгөөрөө гэмт хэргийг шалган шүүдэг нийгмийг яаруулах болно. Чилид Пиночетийг шүүхэд татсан явдал нь зүй ёсны байсан бөгөөд учир нь Чилийн ард түмэн тэдний тал хувь нь түүнийг төрийн эргэлт хийхийг дэмжсэн гэдгийг мэддэг юм.

— Пол Тибо, эссе нийтлэгч

**Дуу хоолой 2:**
Үнэн шударга, шударга ёсгүйгээр зөвшилцөл үүсэхгүй. Бидэнд "сураггүй алга болсон" хүмүүсийн бие цогцос хаана байгааг мэдэх хэрэгтэй байна.

— Гладис Диаз, сэтгүүлч, 2 жил гаруй улс төрийн хоригдол байсан

## Сьерра Леоне:
## 3 үзэл бодол Сьерра Леонийн иргэдээс

**Дуу хоолой 1:**

*Өршөөл энэ улсын асуудлыг шийдэж чадахгүйгээр зогсохгүй. Энэ нь хүчирхийлэл, ялын хэлтрүүлгийн согогтой тойргийг хэвээр хадгалан үлдэх болно. Өршөөлд ямар ч үр нөлөө байхгүй.*

— Абдул Тежан—Көүл, хуульч

**Дуу хоолой 2:**

Намайг тамлан зовоогчидтой би гудамжинд тааралдвал яах вэ? Би зүгээр л нэг өдөр Бүхнийг Чадагч тэдний гэр бүл, эсвэл миний гэр бүл хоёрын аль нэгийг сонгоно гэж хэлнэ. Хэрэв бид өршөөхгүй юм бол олон хүн гаргүй болох юм.

— Лөман Жусу Жарка
Босогчид охидоо оргуулсных нь төлөө
түүний 2 гарыг нь тайрсан юм

Дуу хоолой 3: Би журмыг баримталдаг хүн, гэмт хэрэгт шийтгэл оноох ёстой гэж боддог. Гэвч хэн нь хэнийг шүүх гэж байна вэ? Хэн нь ч үнэхээр хяналтанд байхгүй байна. Хэрэв засгийн газар "Бид та нарыг шүүхэд татаж байна" гэж хэлбэл босогчид дахиад л дайтаж эхлэх байсан.

— Алимани Корома, пастор

## Сьерра Леоне
## Гадаадын 2 иргэний үзэл бодол

**Дуу хоолой 1:**

Өршөөл бол ердөө л ялаас хэлтрүүлэх тойргийг дахин эхлүүлж байна. (...) Гэмт хэргүүд арай дэндүү муухай байсан болохоор бид урт удаан үргэлжлэх энх тайван байдалд найдахгүй л байна.

— Корринь Дувка, Хүний эрхийн манаанд

**Дуу хоолой 2:**

Өршөөл бол тэр чигээрээ байж боломгүй зүйл. Би тэвчиж чаддаггүй. Гэвч би бидний тэжээсэн хүүхдүүдийг хараад би энэ бүхнийг зөнд нь орхисон. Сьерра Леонийн хүмүүс юу хүсч байгаагаа мэддэг юм — Энх тайван, шударга ёсноос илүү энх тайван. Өршөөл бол нэг талаараа олон түмнийг шуугиулсан явдал. Магадгүй ухаалаг явдал ч байж болох юм.

— Хүмүүнлэгийн ажилтан

# Баримт хуудас: Үнэнийг тогтоох комиссын тухай

## Нэгдүгээр хэсэг: Нийтлэг үндэслэл

Түүхэн дэх тодорхой хэмжээний дарамт бүхий цуст үйл явдлын дараагаар улс орнууд ерөнхийд нь ОУХЭЗ, хүний эрх, дотоодын эрх зүйн зөрчлүүдийн тухай баримтуудыг батлан тогтоох зорилгоор үнэнийг тогтоох комиссыг байгуулжээ. Үнэнийг тогтоох комисс нь шүүх биш юм. Энэ нь өнгөрсөн хүчирхийлэл, гэмт хэргүүдтэй холбоотой баримтуудыг тодорхойлох хүсэлтийг шүүн таслах ажиллагаа явуулдаг. Уг комисс нь ерөнхийдөө тайлан, мэдээлэл нийтэлж, тухайн улсын засгийн газар гэмт хэрэгт ямар хариу үзүүлэх болон цаашид зөрчлүүдийг өргөн дэлгэр тархахаас хэрхэн зайлсхийх талаар санал өргөдөг байна.

Зарим Үнэнийг Тогтоох Комисс нь олон нийтийн эрх мэдэл бүхий байгууллагаар, бусад нь хувийн хэвшлийн байгууллагаар үүсгэн байгуулагддаг.

Комисс нь засгийн газрын радикал өөрчлөлтийн дараа (жишээ нь, Чили ба Өмнөд Африк), иргэний дайныг эцэс болгосон энхийн гэрээний хүрээнд (жишээ нь, Сальвадор, Гуатемал) буюу цэргийн удирдлагаас энгийн иргэдийн удирдлага руу шилжих шилжилтийн үед (жишээ нь, Аргентин, Уругвай) байгуулагдсан байна.

**Аргентин:** Анхны үнэнийг тогтоох комисс 1983 онд өмнөх дэглэмийн үед сураггүй алга болсон мянга мянган хүний бодит байдлыг судлуулахаар байгуулсан. Зуу зуун гэрчийн мэдүүлэг дээр үндэслэн комисс, нууц хорих лагерь байсныг болон 8900 гаруй хүн "сураггүй алга болсон" баримтыг тогтоосон юм. Энэ нь хариуцлага хүлээлгэх хэргүүдийн эхлэл болсон юм. Уг комиссоос 1984 онд гаргасан, номны урттай адил хэмжээний, тэдний олсон мэдсэн зүйлсийн тайлан, Nunca Mas (Хэзээ ч Дахин Болохгүй) нь хүний эрхийн холбогдолтой тайлангууд дундаа сонгодог нь билээ.

**Өмнөд Африк:** Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс нь Өмнөд Африкийн улс төрийн болон эдийн засгийн системд ноёрхсон цагаан арьст цөөнхийн үзэл болох апартейд буюу арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг гарсан мөргөлдөөний үеэр болж үйлдсэн гэмт хэргүүдийг байцаан шалгах зорилгоор байгуулагдсан. Арьс өнгөөр ялгаварлах үзлийн хүрээнд, Ази болон холимог гарал үүсэлтэй хүмүүсийн зэрэгцээ хар арьст Африкчууд Европын өвөг дээдэстэй Өмнөд Африкчуудад олгогдож буй олон давуу эрх, ашиг сонирхлыг эдэлж чадахгүй байлаа. Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс Өмнөд Африкийн Засгийн газар болон арьс өнгөөр ялгаварлагч Засгийн газрын эсрэг гарсан зэвсэгт бослогыг өдөөсөн Африкийн үндэсний конгресс (АҮК) зэрэг бүлгэмүүдийн нэгэн адил арьс өнгөөр ялгаварлах үзлийг дэмжигчдийн үйлдсэн гэмт хэргүүдийг шинжлэн судалсан байна.
Өмнөд Африкийн үнэнийг тогтоон эвлэрүүлэх комисс нь хууль зүйн системийн нэгэн хэсэг болж байгуулагдсанаараа өмнөх үнэнийг тогтоох комиссоос ялгаатай. Үүний зорилго нь хариуцлага хүлээлгэн шийтгэхдээ бус, хувийн болон улс төрийн зөвшилцлийг тогтоох явдал юм. Үнэнийг тогтоон эвлэрүүлэх комисс нь хэрэв зөрчигчид юу хийсэн тухайгаа дэлгэрэнгүй бөгөөд үнэнч шударгаар мэдүүлбэл хууль эрх зүйн дагуу уучлах (өршөөл үзүүлэх явц) боломжийг олгосон. Комисст бүрэн гүйцэд, шударгаар мэдүүлэг өгөөгүй гэмт буруутнууд үндэсний эрх зүйн хүрээнд хариуцлага тооцогдсоор байх болно.

Мянга мянган хүн өршөөл хүсч уг комисст ханджээ. 1999 оны эцсээр үнэнийг тогтоон эвлэрүүлэх комисс нь нийт 6309 хэрэг шийдвэрлэснээс 568 хүнд өршөөл үзүүлж, 5287—д нь татгалзаж, 21—д нь хэсэгчилсэн өршөөл үзүүлж, 161 нь хүсэлтээ татан авсан байна. Түүнчлэн 272 хэргийг шийдвэрлэлгүй орхижээ.

**Сүүлийн үед** Үнэнийг Тогтоох Комисст Нигер, Панам зэрэг улсад ажиллаж эхэлсэн бөгөөд Сьерра Леоне болон Зүүн Тиморт ч гэсэн ажиллаж эхлэх төлөвлөгөөтэй байна. Мексик, Босни, Серб, Гана мөн уг улсын уугуул иргэддээ хандах хандлагыг хянан шалгахаар Канад зэрэг орнуудад ийм хороо байгуулах асуудал нь хэлэлцүүлгийн шатандаа явж байна.

## Хоёрдугаар хэсэг: Үнэнийг тогтоох комиссын тухай

# хүмүүс юу гэж хэлж байна.

Бид өнгөрсөн цаг руугаа нүдээ аниад байж байх ёстой гэж хэлэхгүй. Гэвч шударга ёс хүн бүхнийг дагаж чадахгүй. Энэ нь эцэс төгсгөлгүй байх болно.

– Дэсмонд Туту, Нобелийн энх тайвны шагналт,
Өмнөд Африкийн Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх
Комиссыын дарга

Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комиссын зүй зохистой үүргийн тухай хэлэлцүүлгүүд нь Руанда дахь тусгай нөхцөл байдлыг бодолцох юм бол, Комисс нь ялаас чөлөөлөх явдлыг арилгах болон улс төрийн тогтвортой байдлын суурийг тавих хамгийн сайн арга биш юм. Руандагийн засгийн газар үндэсний сэргээн босголтод хүрч, Руандагийн ард түмэнд байнгын энх тайвныг авчрах цорын ганц арга бол шударга ёс баримтлагдсанаар, мөн аливаа гэмт хэрэгт холбогдогсод ба хариуцлага хүлээгчид юуны өмнө шийтгэл хүлээхгүй л бол харилцан ойлголцол болон эв найртайгаар зэрэгцэн орших нь найдаад ч үл бүтэх зүйл гэдгийг урьдчилан харах явдал юм.

– Фаустин Нтезияаё, Хууль эрх зүйн яамны сайд,
Руанда, 1998 он

Хохирогчид болон амьд үлдэгсэд өөрсдийн хэлмэгдлийн тухай өөр өөрийн хувилбараар, түрэмгийлэгч талыг тодруулан түрэмгийллийг нарийвчлан тайлбарлаж, тэгснээрээ гүн гүнзгий уур хилэн, ёс суртахууны үзэн ядалт болон шударга ёсыг эрэлхийлэх сэтгэлийн дуу хоолойгоо түүх болгон ярих хэрэгтэй. Яагаад гэвэл буруутгагдсан үед тэд зөвхөн бие махбодиороо зовох биш, ухаан санаагаараа айж сандардаг бөгөөд өөрийгөө хүндлэх явдал өчүүхэн төдий л үлддэг. Тэд мөн өөрийгөө үнэлэх үнэлэмжээ эргүүлэн шаардах хэрэгтэй байдаг. Үнэнийг тогтоох комисс энэ бүхэнд хүрэхэд туслах бөгөөд энэ бол ноцтой шударга бус явдлын нэгэн эриний төгсгөл дахь итгэл үнэмшлийг бий болгож, бэхжүүлэх хэрэгсэл болж байдаг.

– Ражийв Баргава, Улс төр судлалын төв
Нью Дели, 1998 он

Аливаа нийгэм бүрэн бүтэн байдлаа хожим нь сэргээхийн тулд юу болж өнгөрснөө таньж мэдэн хохирогчдыг дахин амьдруулж, буруу зүйл үйлдэгчдийг шийтгэх ёстой. Энэ нь гэм буруутныг шоронд хийх ёстой гэсэн үг биш бөгөөд ядаж тэднээс гэм нүглээ наминчлан уучлал гуйхыг шаардах хэрэгтэй гэдгийг илтгэнэ.

– Мартин Абрегү, Хууль зүй нийгэм
Судлалын төв, Аргентин 1998 он

Хохирогчийн буюу түүний гэр бүлийн өмнө алуурчин хэн нэгнийг зориуд санаатайгаар хөнөөсөн, алах зорилгоор сүм эсвэл хаа нэгэн газар тэсрэх бөмбөг нуусан гэдгээ өөрөө мэдэж ойлгодог байна. Энэ бол шударга ёсны эхлэл юм. (...) Олон хохирогчид сэтгэл зүйн ханамжтай байдаг, яагаад гэвэл тэд эргээд нэр хүндээ олж авсан бөгөөд тэдний зовж шаналсныг хүмүүс мэдэж авсан. Бусад хохирогчид сэтгэл госгор байдаг, учир нь алуурчид хэтэрхий хөнгөн шийтгүүлж байдаг.

– Ричард Голдстоун, Өмнөд Африкийн шүүгч,
хуучин Югослав болон Руандагийн
Олон Улсын Эрүүгийн Шүүхийн прокурор байсан

# Дайны гэмт хэргүүдийн талаарх нийгмийн дуугүй байдал

Дайны зэр зэвсэг нам гүм болж, аллага, тамлалт, хүчирхийлэл ба айдас зогссон үед өнгөрсөн хүчирхийлэл болон болж өнгөрсөн байж болох зэвсэгт мөргөлдөөний дүрмийг ноцтой зөрчсөн гэмт үйлдлүүдтэй засгийн газар хэрхэн тулгаран яаж шийдэх вэ? Гол асуудал бол "ой ухааны улс төр" хэмээх зүйлийг хэрхэн яаж хамгийн сайнаар шинэ, эрүүл нийгмийн бүтэц рүү уялдуулж өгөх вэ гэдэг явдал юм. Зарим хүмүүс болон төр засаг өнгөрсөн зүйл бол дууссан зүйл, нийгэм ирээдүйгээ цогцлон бүтээхийн тулд үүнийг ардаа орхих хэрэгтэй гэдэг.

Өнгөрснийг мартах буюу төр засгаар зөвшөөрөгдөн сайшаагдсан "бүх нийтээрээ ой ухаанаа алдах" явдал нь засгийн газрын дэмжлэгтэйгээр явагдах ёстой хариуцлага хүлээх ёсны үйл явц байхгүй; үйлдэгдсэн дайны гэмт хэргүүд буюу энгийн иргэдийг хорлон сүйтгэх үйл ажиллагааны үр дагаврыг хариуцах улсын хяналт байхгүй тийм нөхцөл байдлуудыг далдалсан хэрэг болно. Нийгмийн энэ идэвхгүй, нам гүм байдал нь илт тодорхой сонголтын шууд бүтээгдэхүүн байдаг бөгөөд үндэстнүүд нэгэнт мөргөлдөөн дууссан тул төр засгаа дахин барих ажлаа үргэлжлүүлэх хэрэгтэй байгаагаас үүдэлтэй. Илэрхий сонголт нь идэвхгүй, дуугүй байх явдал бол энэ нь голдуу хуучин засаглалын гишүүдийг тэдний удирдлагын үед гарч байсан дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн зөрчлүүдтэй холбоотой хууль эрх зүйн асуудлаас далдлан хамгаалах халхавч болж буй уучлал, өршөөлүүдтэй холбоотой байдаг байна.
Богино хугацааны хувьд, өнгөрсөн гэмт явдлыг мартах буюу үл ойшоох нь ялагдсан дайны цаг үе, эсвэл тоталитари буюу түгээмэл дэглэмээс удирдлагын шинэ хэлбэрт шилжих хамгийн хурдан зам болдог.

Тэр идэвхгүй, дуугүй байдлыг сонгох явдал нь олон хохирогчдын айдас бөгөөд энэ нь цаанаа хувь хүмүүс болон зорилтот бүлгийн туулж ирсэн зовлон шаналлыг хүндэтгэх үзэл дутагдаж байгааг илэрхийлнэ. Дуугүй байх нь үгүйсгэл мэт санагдана. Тина Розенберг, хэн нэгэн тарчлаан зовоох болон бусад гэмт үйлдлийнхээ төлөө ял шийтгэл аваагүй бол "энэ бүхэн болж өнгөрсөн байх ёсгүй." гэсэн бодол төрдгийг ажигласнаа, 1989 он хүртэл коммунист үзэл суртлыг тулгаж байсан Стасид (хуучин зүүн Германы нууц цагдаа) оногдуулах шийтгэлийн дутмаг байсан талаар хийсэн хэлэлцүүлэгтээ өгүүлсэн байдаг. Эрдэмтэн Ариех Найер хэлэхдээ, "Энх тайван байдалтай харилцан орших явдал нь хэлмэгдсэн хүмүүс, хохирогчид тэдний зовлон шаналлын учрыг тайлбарлах хэн нэгнийг олж харахгүй бол биелэхэд хялбар бус болов уу" гэжээ. Мартана гэдэг бодлого нь уур хилэнг хохирогчдын зүрхэнд булж, эдгэрэх боломж олгохгүйгээр түүнийг буглуулна гэсэн үг юм.

— Эх сурвалж: Кристал К.Кампбил
Хэвлэгдээгүй материал

# Хэтэрхий оройтсон гэж үү? – Алжир/Франц

**Франц дахь олон нийтийн мэтгэлцээний түүхэн суурь үндэс**

1954–1962: Франц Алжирт тусгаар тогтнолын тэмцэгчидтэй дайн хийв.
1962: Франц Алжирын хоорондын Эвианы зөвшилцөл дайныг эцэс болгосон. Хоёр тал хоёулаа харгис хэрцгий гэмт хэрэг үйлдэгсдэд ерөнхий өршөөл үзүүлэхээр тохирсон.
1962–1999: Францын армийн эрх мэдлээ хэтрүүлсэн явдлыг Францын ард иргэд, хувь хүмүүс зэмлэн буруушаах нь газар авав. Хэдийгээр ном, нийтлэл, хэвлэгдэж байсан ч, том хэмжээний олон нийтийн мэтгэлцээн явагдаагүй байна.
2000: 1957 онд 3 сарын турш тамлагдан зовж байсан хуучин Алжир дайтагч Луйсет Игхиларизолон түмэнд хандаж үг хэлэв. Түүний мэдүүлсэн баримтад Франц генералууд олон нийтээр дамжуулан хариу үйлдэл хийж, өөр түүх, улс төрчдийн хийсэн мэдэгдлүүдийг гаргаж ирэн өргөн олныг хамарсан мэтгэлцээн хийсэн байна. Үүнд:

- Олны мэдэх 12 эрдэмтэн Францын засгийн газарт хандаж Алжирт болсон дайны үеэр гарч байсан тамлан зовоох ажиллагааг таньж мэдэн зэмлэн буруушаасан баримт түүхийг албан ёсоор гаргаж тавихыг олон нийтээр дамжуулан уриалсан.
- Ерөнхий сайд Жоспан "Үнэнийг ил гарах явдал нь үндэстний хүчийг сулруулна гэдэгт би итгэхгүй байна. Эсрэгээр нь, өнгөрснөөс суралцсан зүйл дээрээ тулгуурлан ирээдүйгээ байгуулах боломж олгож байгаагаараа энэ нь үндэстнийг хүчирхэгжүүлнэ" гэж хэлэв.
- Ерөнхийлөгч Ширак "Хуучин шархыг сэдрээх зүйлс бид хийх шаардлагагүй" гэж хэлэв.
- Францын хэсэг улс төрчид Францчуудын үйлдсэн хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг болон тамлаж зовоох ажиллагааг судлан харах комисс байгуулахыг санал болгов. Тус комиссын зорилго нь үнэнийг тогтооход туслах, хохирогчид болон тэдгээр гэмт хэрэгт оролцохоос татгалзагчдад нөхөн төлбөр олгох арга замуудыг санал болгох зэрэг болно.

**Дуу хоолой:**

**Алжирт болсон үйл явдлын үеэр үүргээ гүйцэтгэж явсан хоёр ахлагч генералын үзэл бодлоос:**

*Үгүй ээ, тамлан зовоох нь дайны үед үнэхээр шаардлагагүй юм. Хэн нэгэн үүнгүйгээр зохицуулж чадах л болно. Алжирийн тухай эргэж бодохоор надад их гунигтай санагддаг, яагаад гэвэл тамлан зовоох нь тэр үеийн хүмүүсийн нийтлэг санаа байсан. Бид өөрөөр байж чадах л байсан.*

– Генерал Жак Масу

*Би ер нь тамлан зовоох дургүй, гэвч би Алжирт ирээд үүнийг хэрэглэх ёстой болж байна гэж бодсон. Энэ бол тэр үед аль хэдийнэ стандарт хэрэглээ болчихсон байсан. Ижил төстэй нөхцөл байдалд би адилхан л тамлан зовоох байсан, үүнээс өөр сонголт байсан гэж бодохгүй байна. Энэ дашрамд хэлэхэд би урьд нь тамлан зовоохгүйгээр аливаа юманд сайн үр дүнд хүрдэг байсан. Миний хамгийн том амжилт бол байцаалтанд байгаа хүн рүүгээ ганц ч үлээхгүйгээр олдсон гэж би ярьдаг. Гэвч зарим тохиолдолд цаг маш бага байгаа үед энэ бүхэн хэрэгждэггүй байв.*

*Би өнөөдөр Франц улс уучлал гуйж байгаа явдлын эсрэг байдаг. Бидэнд уучлал гуйх зүйл байхгүй. Онцгой баримтуудыг зөвшөөр, гэхдээ бүхэлд нь биш. Би хувьдаа гэмшиж харамсдаггүй.*

–Генерал Пол Оссарес

# Хэтэрхий оройтсон гэж үү? – Алжир/Франц

### Цэргүүдийн тухайд

Тамлан зовоох ажиллагааны ял цээрлэл нь энэ дайнд оролцож байсан 2 сая хүнд чиглэж байгаа нь ахмад дайчдад гүтгэгдэж байгаа мэт мэдрэгддэг бөгөөд асуудлын талаар тэд тодорхой ухамсартай байгаа.

– Владислас Марек 1960–1962 онд Алжирт бага дарга байсан Одоо Алжир Тунисын Ахмад Дайчдын Үндэсний Холбооны Ерөнхийлөгч

Цөөн хэдэн шинэ цэрэг тамлах ажиллагаанд оролцож байсан. Гэвч тэдний ихэнх нь энэ тухай мэддэг, үүнийг харсан байсан бөгөөд юу ч хэлдэггүй байлаа. Яагаад гэвэл цэргийн сахилга батыг эсэргүүцэх нь илүү дээд түвшний зүрх зориг шаарддаг байв. Ерөнхийдөө арьс өнгөөр ялгаварлах үзэл болон түүнээс ч илүүтэйгээр колоничлох дайны үеэс улбаатай үл хүндэтгэх үзэл нь хүчирхийллийн эсрэг идэвхигүй хандлагыг бий болгосон юм.

– Жорж Дуссан Францын Ахмад Дайчид болон Дайнд Хэлмэгдэгсдийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч

Шинэ цэргүүд хэрэв тэд үүрэг даалгаврыг ялангуяа тамлан зовоохтой холбогдсон тушаалыг биелүүлэхгүй, эсэргүүцвэл тэдэнд юу тохиолдохоос айдаг байв. Тэд бүгд эрүү шүүлт, тамлалтыг ядаж л харсан, сонссон байгаа. Тэд надад тэдний жинхэнэ сэтгэл санааны шарх нь тэр үед үгүй гэж хэлдэггүйгээс үүсдэг байсныг хэлж байв. Тэр үед тэд 20 настай, хөлөө ч олж чадаагүй байж.

– Мари–Одил Годар, Сэтгэл зүйч

### Хариуцлагын тухайд

Үндсэн хариуцлага нь юу болж байгааг бүгдийг мэдэж байгаа бөгөөд цэргийхэнд нөхцөлгүй эрх мэдэл өгөх ёсгүй гэдгийг мэддэг улс төрийн эрх мэдэлтнүүдэд ногдох юм.

– Хью Даллө
Ахмад Дайчдын Үндэсний Эвлэлийн Ерөнхийлөгч

Хэрэв Францын Засгийн газар тамлал явуулахыг хүсээгүй байсан бол үүнийгээ албан ёсоор тодорхой мэдэгдэх хэрэгтэй байсан юм. Хэрэв тодорхой заавар байхгүй байсан бол, цэргийнхэн өөрсдийн буюу Франц улсын нэр хүндийг хадгалахын тулд тамлан зовоох ажиллагааг хүсэхгүй гэдгийг шатлан захирах ёс маш тодорхой хэлэх ёстой байсан юм.

– Рожер Монье, нөөц хүчний Дэслэгч

Тэр үед Францад тамлах зовоох ажиллагааг үндсэндээ Алжирийн үндсэрхэг үзэлтнүүдийн үйлдэж буй алан хядах ажиллагаанд тохирсон хариулт гэж үзэж байв.

– Бенжамин Стора, Түүхийн ухааны профессор

### Шударга ёс ба шударга үнэнийг умартах тухайд

Одоо бодоход би шийтгэлийн шийдвэрт нэг их дуртай биш юм. Энэ бүх дурсамжанд үлдсэн дайнуудыг үүрд амьд сэрүүн хадгалж байснаас эцэслэх нь дээр. Хуулчид, нэр хүндтэй шударга хүмүүс, улс төрийн зүтгэлтнүүд болон түүхчдээс бүрдсэн шударга үнэн ба зөвшилцлийн комиссыг юу болсныг янз бүрийн бүлэг хүмүүст сануулж байх зорилгоор байгуулах боломжтой юм.

– Бенжамин Стора, Түүхийн ухааны профессор

Хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүлийхэнд шударга үнэн ил гарч ирэхээс илүү чухал зүйл байдаггүй. Үүнийг гарч ирэхээс нааш гомдол нь барагдахгүй. Ямар ч тайтгарал хэрэггүй. Бүхэл бүтэн үндэстний хувьд ч мөн ийм байдаг. Хэдийгээр эмгэнэлтэй, шаналалтай хэдий ч өнгөрснийг мэдэж байх нь ирээдүйд чухал шаардлагатай, яагаад гэвэл үндэстэнүүд ч гэсэн хүмүүсийн нэгэн адил үүрд худал хуурмагтай амьдарч чадахгүй. Франц болон Алжирын хувьд хоёуланд нь юу хэрэгтэй байгаа нь маш энгийн, Алжирын дайсны үед 2 талын үйлдсэн гэмт хэргүүдийг жинхэнэ байдлаар нь гаргаж тавих л асуудал юм.

– Роберт Бадинтер, Францын хууль эрх зүйн яамны сайд байсан

Тэдгээр ичгүүртэй явдлын талаар ярилцах хэрэгтэй. Архивийг нийтэд дэлгэн харуулж, гэрчүүдээс мэдээ баримт цуглуулж, олон янзын үзэл бодлыг сонсох хэрэгтэй. Аливаа улс өөрийгөө хүч зоригтой баатар, эсвэл гэм буруугүй хэлмэгдэгчийг тодотгосон дүр зургаас илүү түүхийн бараан хуудаснуудаасаа их зүйлийг мэдэж авч чадна.

– Цветан Тодоров, Философич

# Хэтэрхий оройтсон гэж үү? – Алжир/Франц

### Шударга ёс, үнэн шударга байдлыг умартсан нь

*Миний цорын ганц санаа зовдог зүйл бол орчин үеийн иргэншилт хүмүүс бүдүүлэг балмад үе рүүгээ буцан шилжин орж байгааг хэрхэн ойлгох явдал юм. Хэрвээ бид иймэрхүү ичгүүртэй явдлыг болохоос нь сэргийлье гэвэл уг хэрэг явдлын жинхэнэ мөн чанар буюу улс төрийн дарамт шахалтын тухай үнэнийг хэлэх ёстой. Бид өөрсдийн үр хүүхдүүдээ аав нь худлаа ярьсаны төлөө бүхий л амьдралынхаа турш айдастай, зүрх сэтгэлдээ ямар нэгэн ичгүүртэй яваасай гэж хүсэхгүй нь мэдээж.*

Жак Жүллиар, Алжирт ажиллаж байсан офицер

*Дайны төгсгөлд ард түмэн мартахыг үнэхээр их хүсч байлаа. Энэ бол ямар нэгэн хэмжээгээр хүмүүс эрүүл сэтгэж байгааг харуулж байгаа юм. Хэн нэгний оюун ухаанд үлдсэн мартагдашгүй шархыг хэзээ ч эдгээж чадахгүй, эрүүл бус зүйл болно. Гэхдээ нөгөө талаас үзэхэд үнэн бодит байдлыг мэдэж танилгүйгээр мартана гэдэг нь эрүүл бус байж болно. Францын ард түмэн бүхэлдээ тамлан зовоох явдлыг ёс суртахууны хувьд буруушаах ёстой.*

Лорен Шварц, математикч

**Олон улсын эрх зүй ямар ч нөхцөл байдалд эрүү шүүлтийг хориглодог. Жишээ нь:**

**Зэвсэгт мөргөлдөөний үед**

*... дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хэзээ ч, хаана ч хийхийг хориглоно:*
*(а) Амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх...*

Женевийн 4 Конвенцийн нийтлэг 3-р зүйл (1949 он)

Ямар ч үед

1. *Нэгдэгч улс бүр шүүх эрх мэдлийн хүрээнд аль ч нутаг дэвсгэр дээр эрүүдэн шүүх үйлдлээс сэрэмжлэх үр нөлөөтэй удирдлагын, хууль зүйн, шүүхийн болон бусад арга хэмжээ авах ёстой.*
2. *Дайн байлдаан, дайны заналхийлэл, дотоодын улс төрийн тогтворгүй байдал буюу нийтийн онцгой байдал зэрэг аль ч тохиолдлыг эрүү шүүлтийг зөвтгөсөнд тооцно.*
3. *Дээд тушаалын офицер буюу эрх мэдэлтний өгсөн тушаалыг эрүү шүүлтийг зөвтгөсөн хэмээн үзэж болохгүй.*

Эрүү Шүүлтийн эсрэг НҮБ-ийн Конвенци 2-р зүйл (1984 он)

# Судалгаа 4 B. Олон улсын шүүхийн хувьсал

Энэхүү 4B судалгаанд гүнзгий шатанд суралцаж буй сурагчдад зориулсан материалыг багтаасан бөгөөд хорьдугаар зууны II хагаст олон улсын хэмжээнд шударга ёсны талаар авсан арга хэмжээний хөгжил дэвшлийн талаар дурдсан байгаа. Сурагчид дэлхийн 2—р дайны дараа, дайны гэмт хэрэг болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчил үйлдсэн хүмүүсийг шүүхээр анх удаа улс үндэстнүүд нэгдэн шүүсэн талаар үзэх болно.

Олон улсын эрүүгийн шүүхийн системийг судлахдаа хууль сахиулахад тулгарах зарим үндсэн асуудлуудыг судлах бөгөөд жишээлбэл, хууль зөрчигч нь дээд албан тушаалтны тушаалыг биелүүлсний улмаас буруу хүлээх үү үгүй юу, түүнийг өөрөөр хэрхэн шийтгэх вэ болон улс үндэстнүүд яагаад олон улсын эрүүгийн шүүх байх ёстой гэж үзсэн зэрэг асуудлуудыг судална.



**Зорилго:**

- Дайны гэмт хэрэг үйлдэгсдийг олон улсын хэмжээнд хэрхэн шүүж ирсэн хувьсал дэвшлийг ойлгож авах
- Дайны гэмт хэргийг шүүхэд тулгарах зарим асуудлуудыг авч үзэх

**Ашиглах материалууд:**

- Нюрнбергээс ирсэн дуу хоолой:
  Нюрнбергийн зорилгын талаар
  Шүүгдэгчийн эцсийн мэдэгдэл
  Шүүхийн тогтоолоос
- Нюрнбергийн Зарчмууд, 1946 он
- Баримт хуудас: Олон улсын тусгай шүүх
- Баримт хуудас: Олон Улсын Эрүүгийн Шүүхийн тухай зарим асуултуудад хариу өгөх нь

**Багш нарт:**

- Нюрнбергийн тухай товч
- Шударга ёсонд хүрэх 3 арга зам (Судалгаа 4А—г үзнэ үү)

**Хугацаа:**

2 удаагийн 45—60 минутын хичээл

**Бэлтгэл ажил:**

Хичээлээс өмнө сурагчид "Нюрнбергийн тухай товч" мэдээллийг унших хэрэгтэй эсэхийг шийднэ.

Өөрийн сурагчдын чадварт тохируулан "Нюрнбергээс ирсэн дуу хоолой" унших материалыг хэрхэн ашиглах талаар төлөвлөнө.

Хоёр дахь хичээлийн өмнө сурагчдаар баримт хуудсыг уншуулах эсэхээ шийднэ.

**1. Нээлттэй хэлэлцүүлэг** /5—10 минут/

- Руандагийн (1994) буюу хуучин Югославийн (1993) Олон Улсын Эрүүгийн Шүүхийн талаар болон дэлхийн 2—р дайны дараа үүсгэгдсэн Токиогийн, эсвэл Нюрнбергийн Олон Улсын Цэргийн Шүүхийн талаар та нар юу мэдэх вэ?
- Олон улсын шүүх ямар учраас бий болсон гэж бодож байна вэ?

**2. Нюрнбергийн угтвар үйл явдал**
(Цомхон бүлгээр) (30—40 минут)

1945 онд Германы Нюрнбергт хуралдсан олон улсын цэргийн анхны шүүхийн зарим гол материалуудыг танилцуулна:

- 1945 онд Дэлхийн 2—р дайн олон сая хүний амь нас эрсдсэнээр төгсгөл болсон бөгөөд түүний дотор олон сая Еврэйчүүд ба бусад үндэстний цөөнхийг хорих лагерьт хүйс тэмтэрсэн; олон сая энгийн иргэд алагдсан, бөмбөгдөлтөнд нэрвэгдсэн, гэр орноосоо дүрвэн хөөгдсөн; олон сая цэргүүдийг баривчлан хорьсон; хотуудыг ноцтой, дэс дараалсан бөмбөгдөлтөөр бөмбөгдөн устгасан; хамгийн анхны цөмийн зэвсгээр Нагасаки болон Хирошима хотуудыг бүхэлд нь устгасан байна.
- Ялалт байгуулсан холбоод (Их Британи, ОХУ, АНУ, Франц) Германы Нюрнбергт 1945 оны намар Нацистын 22 удирдагчдыг шүүх хурал хийв. Дээрх 4 улсаас тус бүр хоёр шүүгч, прокурорын баг оролцов.
- Германы өмгөөлөгчдийн баг яллагдсан Херманн Гөринг (Герман Маршал), Вилгелм Кайтель (Германы Зэвсэгт Хүчний Дарга), Жоахим вон Риббентроп (Германы Гадаад Хэргийн Яамны сайд) болон засгын газрын бусад доод албан тушаалтнуудыг өмгөөлсөн байна.
- Гэмт хэрэгтнүүдийг энх тайвны эсрэг гэмт хэрэг (эзэрхийлэн түрэмгийлэх дайныг төлөвлөгөөтэйгээр санаачлан зохион байгуулж явуулсан), дайны гэмт хэрэг (олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн), болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг (алан хядлага, хүйс тэмтрэх, боолчлол, цөллөг болон хүн төрөлхтөний эсрэг үйлдсэн бусад хүнлэг бус хэрцгий үйлдэл) үйлдсэн хэмээн буруутгасан.
- Эдгээр 22 хүмүүсээс 19 нь шийтгэгдэж, 3 хүний ялыг хэрэгсэхгүй болгосон.

> Алс Дорнодын Олон Улсын Цэргийн Шүүх 1946 онд Токиод хуралдсан. 11 орны төлөөлөл дэлхийн 2—р дайны үед Японы 27 өндөр албан тушаалтны үйлдсэн энх тайвны эсрэг, дайны, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдийг шүүхээр хүрэлцэн иржээ. 7 нь цаазар авах ял сонсч, бусад нь шоронд орсон байна.

Ангийг хэдэн бүлэг болгон хувааж тус бүрдээ “Нюрнбергээс ирсэн дуу хоолой” тухай доорх 3 мэдээллээс нэг нэгийг сонгон авч хэлэлцэнэ.

- “Нюрнбергийн зорилго”—т прокуроруудын түүхэн үүргийг харуулсан.
- “Шүүгдэгчдийн эцсийн мэдэгдэл” нь 4 гэмт хэрэгтний мэдэгдлээс иш татсан хэсэг.
- “Шүүхийн тогтоол” хэсэгт Шүүх хурлын шүүгчид маргаантай асуудлуудад хэрхэн хариулсан тухай өгүүлсэн.

Бүлэг тус бүрийг нийт ангид бүлгийн хэлэлцүүлэг хийлгэхээр тайлагнуулна. (20 минут)

**Боломжит асуултууд:**

➤ Өмгөөлөгчид өөрсдийн үйлчлүүлэгч нь тэдэнд тулгасан ялыг хүлээх ёсгүй, учир нь:
(1) Тэд дарга нарын тушаалыг гүйцэтгэж байсан.
(2) Энэ шүүх танхимд сууж буй бусад бүх үндэстнүүд ижил гэмт хэрэг үйлдсэн.

➤ Таны уншсан сэдэвт эсрэг маргаантай асуудал байсан уу?

➤ Дайны дараа Германы шинэ засгын газар байгуулагдсан үед энэ шүүх хурал болсон бол прокурорууд, шүүгдэгсэд болон шүүгчдийн үзэл бодол өөр байх байсан гэж үзэж байна уу? Хэрвээ тийм бол юу нь өөр байх байв? Яагаад?

**3. Өсч буй олон улсын ашиг сонирхол** (30—45 минут)

Женевийн Конвенц нь нэгдэгч улсуудаас шударга ёс зөрчигчдийг шүүхийн өмнө аваачих үүрэгтэй гэж шаарддаг тухай сурагчдад дахин сануулна. Олон улсын энэхүү үүрэг хариуцлага нь 3 арга замаар хэрэгждэг. Хамгийн эртнийх нь үндэсний хэмжээний шүүхээр хэрэгжинэ.

### А. Гадаадын үндэсний шүүхүүд

### Боломжит асуултууд:

➤ Та нар өмнө нь бусад улс орнуудад хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн буюу хүний эрхийн хуулийг зөрчсөн хүмүүс шийтгүүлж байсан тухай сонссон уу?

Дор зарим нэгэн жишээг дурдав. Хэрвээ хүсвэл өөрийг сонгож болно:

> Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр ийм ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан гэж буруутгагдаж байгаа этгээдийг эрж олох, түүний харъяаллыг үл харгалзан өөрийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээнэ.
>
> Женевийн Конвенцийн нийтлэг үндэслэлийн 49/50/129/146—р зүйл

Жишээ 1: Мушубати хотын (Руандагийн нэгэн дүүрэг) даргыг Швейцарьт баривчилж, Швейцарийн цэргийн шүүхэд өгсөн. Түүнийг 1994 оны геноцидийн үед (төрлөөр нь устгах) улс төрийн аллага хийсэн ба аллагыг өдөөн хатгаж хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн хэргээр 1999 онд бүх насаар нь хорих ял оноосон. Харин давж заалдсанаар хорих ялыг 14 жил болгож хөнгөрүүлэв. Түүний сүүлийн давж заалдах шүүх өнөөг хүртэл шийдэгдээгүй байгаа.

Жишээ 2: 2000 оны 2—р сард, Сенегальд цөллөгдөж байсан Чадын ерөнхийлөгч асан Хабрег 1982—1990 оны хооронд Чадад хүний эрхийг зөрчсөн хэргээр ял тулгасан. 2001 онд Сенегалийн дээд шүүх Сенегалийн газар нутагт үйлдэгдээгүй гэмт хэргийг шүүх эрх мэдэл байхгүй гэсэн үндэслэлээр уг ялыг хүчингүй болгосон. Нэхэмжлэгчид болон тэдний өмгөөлөгчид нь энэ хэргийг Сенегалийн газар нутгаас гадуур шийдвэрлэхээр төлөвлөж байна. Хэдэн сарын дараа Хабрегийн хохирогчид болон тэдний хуульчид нь Бельги улсад дарангуйлагчийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр гомдол гаргажээ. Бельги шүүгч Чадад очиж хэдэн арван хохирогчдоос болон тэдэнд эрүү шүүлт тулгасан гэх этгээдүүдээс мэдүүлэг авсан.

Жишээ 3: Чилийн ерөнхийлөгч асан Пиночетийг Нэгдсэн Вант улсаас Испанийн шүүхийн шийдвэрээр алан хядлага үйлдсэн хэмээн 1998 онд баривчлан нутагт нь эргүүлэн аваачихыг шаардсан. Гэвч шүүх хурал болохоос өмнө түүнийг эрүүл мэндийн шалтгаанаар суллан Чили рүү шилжүүлсэн ба Чилийн үндэсний шүүх ч түүнд адилхан ял тулгасан байна. 2000 оны 8—р сард Чилийн Дээд Шүүх Пиночетийг парламентаар олгогдсон халдашгүй дархан эрхээсээ түдгэлзэн шүүхийн өмнө зогсох ёстой гэж үзжээ. Гэвч 12—р сард Сантиагогийн давж заалдах шүүх Пиночетийг баривчилсан тухай эрх зүйн үндэслэгээг тодруулахаар шүүхэд шилжүүлэх захирамж гаргасан бөгөөд 7—р сард түүний эсрэг эрүүгийн гэмт хэргийг түр хүчингүй болгосон байна. 2001 оны 8—р сард Чилийн Дээд Шүүх хуучин дарангуйлагчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас үндэслэн ямар ч байсан дээрх шийдвэрийг хянаж үзэх хүсэлт гаргасан байна.

➤ Зарим хүмүүс нэг улсын шүүх өөр улсад үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө хэн нэгийг яллан шүүх нь тухайн улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байна гэж үздэг. Санал нийлж байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй вэ? Иймэрхүү "гадаад хэргийг" шүүхэд шүүх ямар шалтгаан гаргаж болох вэ?

➤ Зарим хүмүүс дайны гэмт хэргийг шударга шүүхийн тулд прокурор болон шүүгчид гэмт хэрэг болсон улс орны соёл, ёс заншил гэх мэтийг судалж мэдсэн байх ёстой гэж үздэг. Энэ талаар юу гэж бодож байна вэ?

### Олон улсын тусгай шүүх

Нюрнберг болон Токиогийн шүүхээс хойш хагас зууны дараа хуучин Югослав ба Рвандад хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн асуудал дээр олон улсын ямар арга хэмжээ авсан тухай "Олон улсын тусгай шүүх" баримт хуудаснаас харж болно.

# Судалгаа 4 В. Олон улсын шүүхийн хувьсал

**Боломжит асуултууд:**




➤ Женевийн Конвецид улс орон бүр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг чандлан сахиулах үүрэгтэй гэж заасан байдаг мөртлөө яагаад эдгээр Шүүхүүдийг байгуулах шаардлагатай байсан бэ?
*[Жишээ нь: Хуучин Югославт хуулийн зөрчлийг хүн болгон мэддэг, илт байсан. Гэсэн хэдий ч үндэсний шүүх иймэрхүү хэргийг шийдвэрлэх чадал болон хүсэл байгаагүй. Рвандад шүүх засаглалын систем мөхсөн. Олон улсын нийгэмлэг дайны гол гэмт хэрэгтнүүд шударга ёсноос мултрахгүй, шударга шүүхээр шүүгдэн Рвандад үндэсний зөвшилцөл, энх тайван, эв нэгдлийг хадгалж үлдэхэд Шүүх тус нэмэр болох талаар итгэлтэй байхыг хүссэн юм.]*




➤ Энэхүү олон улсын шүүх оршин тогтнож байгаа нь дайны гэмт хэрэгтнүүд бүгдээрээ шүүгдэнэ гэсэн үг үү?
*[Жишээ нь: Саяхан Камбож болон Сьерра Леонед шударга ёсонд хүрэх олон улсын болон үндэсний холимог арга замыг нэвтрүүлэх оролдлого хийсэн. Рвандагийн хувьд 4 өөр өөр арга зам бий. Гэхдээ олон улсын шүүх гол төлөв томоохон гэмт хэрэгтнийг шүүхээс бус гэмт хэрэг үйлдсэн болгоныг шүүдэггүй юм.]*

**В. Олон Улсын Эрүүгийн Шүүх (ОУЭШ)**
"Олон Улсын Эрүүгийн Шүүхийн тухай асуултуудад хариу өгөх нь" баримт хуудсын талаар хэлэлцэнэ үү.

**Боломжит асуултууд:**

➤ Нюрнберг/ Токиогийн шүүхүүд, олон улсын тусгай шүүх болон байнгын олон улсын эрүүгийн шүүхийн хооронд ямар ялгаа байна вэ?
*[Жишээ нь: Нюрнберг ба Токиогийн шүүхийг дайнд ялалт байгуулсан улс орон ялагдсан улс үндэстний гэмт хэрэгтэнг шүүх зорилгоор үүсгэн бий болгосон. Харин тусгай шүүхүүд болон ОУЭШ нь аль алиныг нь шүүж болно. Нюрнберг/Токио болон Хуучин Югослав, Рвандагийн олон улсын эрүүгийн шүүх нь түр шүүх ба ОУЭШ нь байнгын үйл ажиллагаа явуулдаг, ямар ч үед ажиллаж эхлэхэд бэлэн байдаг шүүх юм. ОУЭШ—ийн статус нь гарч болзошгүй зөрчлийг арилгах дэлхийн нийтийн оролдлогын үүрэгтэй ажиллана.]*

Иймэрхүү шүүхийн хэмжээ хязгаар, итгэл найдварын тухай тусгасан дараах мэдэгдэл тус бүрийн талаар ярилцана.

*ОУЭШ боломжит зандалчдын замыг хаагаад зогсохгүй барууны засгийн газруудад илүү их ойлгомжтой гадаад бодлого явуулахыг үүрэг болгохуйц гайхамшигт боловсролын давуу талтай гэдэгт би итгэж байна.*
—Виллиам Вурдон, Олон улсын хүний эрхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, хуульч

*Олон улсын шүүх (...) жилд 50—аас доошгүй гамт хэрэгтний хэргийг шүүх чадалтай. Бүхий л улс орныг хамран үйл ажиллагаа явуулдаг байнгын шүүх нь яг адил асуудалтай тулгардаг бөгөөд үүнийгээ хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу өндөр төвшинд хийж гүйцэтгэхийн тулд хязгаарлагдмал тооны хэргийг сонгож авдаг байна. Тийм ч учраас шийтгэл хүлээхгүй байх явдлын эсрэг тэмцлийг зөвхөн олон улсын шүүн таслах үйл ажиллагаанд тохоох нь төсөөлөхөд хэцүү юм. Ядаж үндэсний шүүх шийдвэр гаргахад идэвхитэй оролцож, ажиллах ёстой гэдэг нь тодорхой.*
Луис Жуанет, шүүгч, НҮБ—ын ялаас чөлөөлөх асуудал хариуцсан тусгай илтгэгч

Энэхүү гэгээрүүлэх алхам хийсэн засгын газрууд зохион байгуулалт бүхий эрүүгийн шүүх засаглалын системтэй олон улсын эрүүгийн шүүх нь улс орнуудад ямар ч дарамт, заналхийлэл учруулахгүй гэдгийг сайтар ойлгодог. Нөгөө талаар, энэ шүүх засгийн газар нь, хэрвээ байдаг бол, хүний хамгийн үндсэн эрх зөрчигчдийг шийтгэж чадахгүй буюу шийтгэх хүсэлгүй байдаг эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах зорилгоор л байгуулагдсан юм.

Кофи Аннан, НҮБ—ын Ерөнхий Нарийн Бичгийн дарга асан

**Хаалт** /10 минут/

- Ямар учраас Олон Улсын Эрүүгийн Шүүх үүсэн байгуулагдахад 50 жил болсон гэж бодож байна вэ?
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, геноцид үйлдсэн гэмт хэрэгтнийг шийтгэх зорилго бүхий олон улсын байнгын үйл ажиллагаа явуулах шүүх бий болсон нь ямар давуу талтай вэ? Яагаад зарим улс орон олон улсын эрүүгийн шүүхийн дүрэмд гарын үсэг зурахдаа дурамжхан ханддаг вэ?

Дэлхий нийтийн шүүх засаглал, зарим гэмт хэрэг нь гэмт хэрэгтэн бүх ард түмний дайсан байдаг хэмээн түгээмэл буруушаагдаж байдаг гэсэн таамагнал дээр үндэслэгдсэн байдаг. Энэ нь аль ч улсад баривчлах эрх, зарим нэгэн гэмт хэргээр тэр этгээдийг шүүх эрх олгодог.

**ГОЛ САНААНУУД:**

- Дайны гэмт хэргийг шүүж шийтгэх эрх мэдлийг хэнд хариуцуулахтай холбоотой олон асуудлуудыг шийдэх явцад олон улсын эрүүгийн шүүх үүсч хөгжсөн.
- Шүүгчид гэм буруутайг тогтоохдоо шүүгдэгч этгээд яллагдаж буй зөрчлийг санаатайгаар үйлдсэн эсэхийг харгалзан үздэг. Бусдын тушаалаар үйлдсэн буюу ижил төстэй зөрчил дээр гаргасан жишиг шийдвэр нь хууль зөрчигчийг гэм буруугаас чөлөөлөх шалтгаан болж чадахгүй.

## Нэмэлт дасгал

**Түүх, уран зохиол, өнөөгийн үйл явдлууд**

Түүх, уран зохиол буюу сүүлийн үеийн үйл явдлуудаас (таамагласан үйл явдал ч болно) жишээ татан Нюрнбергийн Зарчим тус бүрийн утгыг тодруулан тайлбарлана уу.

**Нюрнбергийн гол шүүмжлэлтэй асуудлыг хэлэлцэх нь**

Дараахь асуултанд хариулах эссе бичнэ (эрдэм шинжилгээний ажил ч болно):

- Дайнд ялсан холбоод ялагдсан дайсныг шүүх хуралд оролцсон явдал Шүүхийн итгэл үнэмшил, нэр хүндийг бууруулахад хүргэсэн үү?

Энэ сэдвээр мэтгэлцээн хийгээрэй.

**ОУЭШ–ийн дэвшил хөгжлийг судлах нь**

Сонин сэтгүүл болон интернетээс ОУЭШ—ийг үүсгэн байгуулах дүрэмд гарын үсэг зурсан болон соёрхон баталсан үйл явцын тухай мэдээллийг ашиглана. Танай улс энэ талаар ямар байр суурьтай байгаа болон ямар үйл ажиллагаа явуулж байгааг олж тогтоо.

## Нюрнбергийн тухай товч

Хэдийгээр дайны гэмт хэрэг нь олон улсын хуулийн эсрэг гэмт хэрэг боловч 1945 оныг хүртэл иймэрхүү хэргийг зөвхөн үндэсний шүүхээр авч хэлэлцдэг байв. Гэмт хэрэгтэнг хэрэг үйлдсэн улс орны аль эсвэл хэрэгтний өөрийнх нь улсын шүүх байгууллагад хэргийг нь мөрдөн арга хэмжээ авдаг байв. Харин 20—р зуун эхлэхэд, жишээлбэл, АНУ өөрийн цэргүүдээ Филиппин дахь зөрчлийн үед үйлдсэн харгис гэмт хэргийнх нь төлөө шийтгэн шүүж байжээ.

Дэлхийн 2—р дайны дараа Германы хүчний эрхшээлд ороод байсан улс орнууд болох Голланд, Франц ба Польшид цэргийн болон үндэсний шүүх байгууллага дайны гэмт хэргийг шүүх хурлыг хийсэн. Канад, Хятад, Австрали, Британи, АНУ, Голланд ба Филиппин зэрэг улс орнууд дайны бусад талбарт гэмт хэрэг үйлдсэн Нацист болон Японыхуудад ял сонсгосон. Дайны төгсгөлөөс 1950 оны хооронд 10000 орчим хүнийг дайны хуулийг зөрчсөн хэргээр шүүсэн бөгөөд түүнээс хойш хэдэн зуун хүмүүс Германы шүүхэд очжээ.

Гэвч энх тайвны эсрэг, дайны болон хүн төрөлхтний эсрэг олон улсын гэмт хэргийг төлөвлөсөн, тушаасан хэмээн яллагдсан дээд удирдлагуудыг хэн шүүх болж байна вэ? 1945 онд Британи, Франц, ОХУ болон АНУ Нюрнбергт дээд албаны Нацистуудыг шүүх олон улсын цэргийн тусгай шүүхийг байгуулав. Мөн 11 гишүүд бүхий Алс Дорнодын олон улсын цэргийн шүүх Токиод Японы томоохон гэмт хэрэгтнүүдийг шүүхээр бий болов.

Нюрнберг ба Токиогийн шүүхээс өмнө дайны гэмт хэрэг үйлдсэнд шийтгэгдсэн хүмүүс нь ихэвчлэн дунд албан тушаалтнууд болох энгийн цэргүүд болон офицерууд байлаа. Эдгээр олон улсын шүүх нь тухайн улс орны цэргийн болон энгийн хүмүүсийн албан тушаалын шаталсан систем дахь дээд удирдлагыг шүүхэд татан авчирч, шүүсэн явдал нь томоохон өөрчлөлт байлаа. Тэдэнд ял тулган шийтгэсэн явдал нь дайны гэмт хэргийг үйлдэх тушаал өгсөн аливаа хүн гэмт хэргийн хамгийн гол хариуцлагыг хүлээнэ гэдгийг харуулснаараа үеэ элээсэн хуучин хориглолтод жинхэнэ утгаараа нөлөөлж чадсан юм.

Түүний дээр, эдгээр шүүхүүд тухайн хувь хүний зан үйл нь дотоодын эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдөх байсан ч, олон улсын хуульд захирагдах зарчмыг өргөжүүлэн дэлгэрүүлсэн.

Токиогийн шүүх зөвхөн энх тайвны эсрэг гэмт хэрэгт (түрэмгийллийн дайныг төлөвлөн эхлүүлсэн) анхаарлаа төвлөрүүлсэн байхад Нюрнбергт 22 шүүгдэгчийг хүн төрөлхтний эсрэг ба дайны гэмт хэргээр шүүсэн. Эдгээр шүүх хурлын үр дүнд одоо хамгийн чухалд тооцогдоод байгаа олон улсын хуулиар хувь хүн үүрэг хариуцлага хүлээх тухай багц журам гарахад хүргэсэн бөгөөд энэ нь Нюрнбергийн Зарчим гэж нэрлэгдээд байгаа юм.

Асуудалтай үйлдлүүд аль хэдийнэ үйлдэгдснийг нотлох баримт олон байгаа нь сэртхийлгэж байлаа. (Нюрнбергийн шүүхийн нотолгоо, баримт бичиг болон бүртгэлүүд 25000—аас их хуудаснууд бий.) Үүний үр дүнд, өмгөөлөгчдын баг гэмт хэрэгтнүүдийг цагаатгах 3 гол шалтгаан байна гэж үзсэн. Үүнд:

1) Гитлер шийдвэр гаргаж түүний туслахууд дарангуйлагчийн хүслийг биелүүлэхээс өөр арга зам байгаагүй.

2) Дээрх хүмүүсийн яллагдаж буй зарим нэгэн гэмт хэрэг (жишээ нь, геноцид) үйлдсэн тухайн үед олон улсын эрх зүйд гэмт хэрэгт тооцогддогүй байсан.

3) Шүүх хуралд суусан хүмүүс ижил төстэй гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шийтгэл амсч буй хүмүүсээс дээрдээд байх зүй байхгүй.

Эх сурвалж: Телфорд Тэйлор, Нюрнбергийн Шүүхийн Анатоми, Литтл Браун, 1992 он
Юки Танака, Нуугдмал Айдас, Вествью Пресс, Оксфорд, 1996 он
Австралийн Улаан Загалмайн нийгэмлэгийн сургалтын хөтөлбөр

Судалгаа 4 В. Олон улсын шүүхийн хувьсал

Эх сурвалж 1

# Нюрнбергээс ирсэн дуу хоолой: Нюрнбергийн зорилго

**Дээд прокурор, шүүгч Роберт Жаксоны хийсэн нээлттэй мэдэгдэлээс:**
*Энх тайвны эсрэг үйлдсэн гэмт хэргийг шүүх түүхэн анхны хурал их үүрэг хариуцлагыг ногдуулж байна. (...) Ялан гялалзсан, шархдан хатгуулсан аугаа 4 үндэстэн өшөө хорслоо гүйцээх хүсэлтэй хоцорсон бөгөөд олзлогдсон дайснаа шүүх хуулийн байгууллагад сайн дураараа өгсөн нь Хүч нь Учир Шалтгаандаа төлсөн хамгийн чухал гувчуур болж байгаа юм.*
*....Ял тулгагч болон яллагдагч хоёр этгээдийн нөхцөл байдлын хооронд чанарын ялгаа байгаа бөгөөд хэрвээ бид шудрага байр сууринаас хандахгүй бол бидний ажил үгүйсгэгдэх болно. Бид тэдгээр гэмт хэрэгтнүүдийг шүүсэн бичиг баримтыг хэзээ ч мартаж болохгүй, учир нь өнөөдрийн баримт маргаашийн түүх болон үлдэнэ.*
*....Соёл иргэншил биднээс хууль гэдэг чинь энэхүү том хэмжээний хэрэг, чухал тушаалаар гүйцэтгэсэн гэмт хэрэгтнүүдийн өмнө юу ч хийж чадахгүй арчаагүй зүйл биш биз дээ гэж асууна. Энэ нь та бүхэн [Шүүх] дайныг боломжгүй болгохыг хүсэн хүлээж байна гэсэн үг биш, харин олон улсын хууль, эрх зүйн заалт, хориг, хамгийн чухал нь, хориг арга хэмжээ, энх тайвны талд зогсох зэргийг хэрэгжүүлж эхлэх шүүх үйл ажиллагааг тань хүсэн хүлээж буй л хэрэг юм (...).*

**Дээд прокурор ноён Хартли Шокроссийн шүүхийн нээлт дээр хийсэн мэдэгдэлээс:**
*Нэгдсэн Вант улс, Британий хамтын нийгэмлэгийн улс орнууд, АНУ, Оросын Холбооны улсууд болон Францын засгын газар энх тайвныг хүсэгч ард олны тусын тулд, тэдний дэмжлэгтэйгээр нэгдэн олон улсын харилцааны энэхүү Нацист үзлийг санаачлагчид, зөрчигчдийг Шүүхийн индрийн өмнө авчирсан билээ. Тэд ингэснээрээ эдгээр шүүгдэгчдийг хийсэн хэргийнх нь төлөө шийтгэх боломжтой болж байгаа юм.*
*Тэд мөн ингэснээрээ балмад явдлыг тэр чигээр нь ил гарган харуулна. Тэд ингэснээрээ дэлхий дахины сайн сайхан байдал, ухамсарт чанар нь тэрхүү зан үйлийн үр дагаврыг олж харан эцэстээ ямар ч эргэлзээгүйгээр тэр үр дагавартаа хүрнэ гэж найддаг.*

**Дээд прокурор Роман Руденкогийн шүүхийн нээлт дээр хийсэн мэдэгдэлээс:**
*Фашист дарангуйлалд өртсөн гэм зэмгүй олон сая хохирогчдын гэгээн дурсгалд зориулж, мөн дэлхий дахины энх тайван, эв нэгдлийн төлөө, үндэстэн ястны ирээдүйн аюулгүй байдлын төлөө, бид шүүгдэгчдэд байвал зохих шударга бөгөөд бүрэн гүйцэд хариуцлагыг хүлээлгэж байна. Энэхүү хариуцлага нь бүх хүн төрөлхтний тусын тулд билээ.*

**3 дээд прокурорийн хэлсэн зүйлсийн гол санаа нь юу байв? Тэд ямар шалтгаануудыг дурдав?**

Эх сурвалж: Тэйлор Телфорд, Нюрнбергийн Шүүхийн Анатоми, Литтл Браун, 1992 он

# Нюрнбергээс ирсэн дуу хоолой: Шүүгдэгчдийн сүүлчийн мэдэгдэлээс

**Херман Гөрин**
(Гитлерийн 2—р туслагч, Гестапо болон хорих лагерийг үүсгэн байгуулсан хүн)

Би энэ бүхнийг зөвхөн өөрсдийн хүмүүсийн аз жаргал, эрх чөлөө, амь амьдралынх нь төлөө, тэднийг гэсэн гал халуун хайрынхаа төлөө хийсэн юм.

**Рудолф Хэсс**
(Гитлерийн 3—р туслагч, үнэнч дагагч)
Миний ард түмний мянган жилд ганцхан удаа төрүүлэн өгсөн гайхамшигт хүүгийнх нь удирдлага дор амьдралынхаа олон сайхан жилүүдэд ажиллах боломж надад олдсон юм.

**Вильгелм Кайтель**
(Германы Зэвсэгт хүчний дарга)
Би өөртөө итгэж байсан, гэвч надад алдсан зүйл байжээ. Би сэргийлэх ёстой зүйлээсээ сэргийлж чадаагүй нь миний алдаа байж. Би цэрэг хүний хувьд дуулгавартай, үнэнч шударга байх ёстой байтал тэр үед хүний санаанд орохооргүйгээр өөр зорилгоор урвуулан ашигласнаа одоо ухаарч байгаа нь тун эмгэнэлтэй. Цэргүүд үүргээ гүйцэтгэх явцдаа ч хэмжээ хязгаартай байдаг гэдгийг мэддэггүй явж.

**Алберт Спиер**
(зэвсгийн үйлдвэрлэл болон "хүн төрөлхтнийг албадан хөдөлмөрлүүлэхэд дайчилж" байсан хүн)
Энэ дайн санаанд оромгүй сүйрэл авчирсан бөгөөд үнэндээ дэлхий ертөнцийн сүйрлийн эхлэлийг тавьжээ. Би энэ явдалд Германчуудын өмнө хариуцлага хүлээх үүрэгтэй хүн. (...) Би Райхын удирдлагуудын гол гишүүдийн нэг учраас, 1942 оноос эхэлсэн энэ хэрэг явдалд бүхий л үүрэг хариуцлагыг хүлээнэ.

...Энэхүү шүүх хурал ирээдүйд иймэрхүү сүйтгэгч дайн дахин дэгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх, хүн төрөлхтөнийг эв нэгдэлтэй амьдрахад тус дөхөм үзүүлэх дүрэм журам гаргахад хувь нэмэр оруулах ёстой.

**➤ Эдгээр хүмүүс тус бүр ямар үүрэг хариуцлага хүлээсэн бэ? Тэд өөрсдийн үйл ажиллагаа, үзэл бодлын талаар ямар шалтгаан хэлж байна вэ?**

# Нюрнбергээс ирсэн дуу хоолой: Шүүхийн тогтоолоос

◆ ◆ ◆

*Санаачилсан нь нэг хүн байлаа ч гэсэн, үйл ажиллагааны төлөвлөгөөнд олон хүн гар бие оролцож байгаа учраас, энэ бол төлөвлөгөө мөн. Гитлер ганцаараа энэ түрэмгий дайныг хийгээгүй нь мэдээж. Түүнд улс төр, цэрэг, бизнесийн хүрээний удирдагчид болон дипломатуудтай хамтран ажиллах шаардлагатай байв. Эдгээр хүмүүс Гитлерийн санаачилсанаар хамтран ажиллаж энэхүү төлөвлөгөөнд гар бие оролцсон. Тэд дарангуйлагчийн өгсөн даалгаврыг биелүүлсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой.*

◆ ◆ ◆

*Бидэнд олон улсын эрх зүйг зарчсөн, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн ямар хүчнүүд байх нь гол бус, тухайн гэмт хэргийг үйлдсэн хүмүүсийг шүүх нь чухал.*

◆ ◆ ◆

*Тэд олон сая эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг зовлон шаналалд унагасныхаа хариуцлагыг хүлээх ёстой. Тэд мэргэжлийн армийн нэр хүндийг гутаасан. (...)*

*Тэдний ихэнх нь цэрэг эрчүүдийн армидаа үнэнч дуулгавартай байна хэмээн өргөсөн тангаргыг доог тохуу хийж байна. Тэд өөрсдийгөө хамгаалах үе ирэхэд өргөсөн тангаргаа дагах ёстой хэмээнэ, харин Гитлерийн үйлдсэн аймшигт гэм хэргийг шүүх үе ирэхэд (...) үл дагасан хэмээнэ. Үнэн хэрэг дээрээ тэд энэ бүх гэмт хэргийг гардан үйлдчихээд чимээгүй дуулгавартай маяг гарган сууж байгаа нь гэмт хэргийн цар хүрээ дэлхий дахиныг цочирдуулам байгааг харуулж байна. (...) Баримт нотолгоон дээрээ хүрвэл (...) энэ гэмт хэргийг үйлдсэн хэн боловч шийтгэлээс зугтаж үл болно.*

> ➤ **Шүүх маргаантай асуудал бүрт ямар хариулт өгсөн бэ? Эдгээр гаргасан шийдвэрүүдийн шалтгаан нь юу байв?**

Эх сурвалж: Тэйлор Телфорд, Нюрнбергийн Шүүхийн Анатоми, Литтл Браун, 1992 он

# Нюрнбергийн Зарчим, 1946 он (өөрчлөлт оруулсан)

I. Олон улсын эрх зүйд зааснаар гэмт хэрэгт тооцогдох хэрэг үйлдсэн хэн боловч хариуцлага, шийтгэлийг хүлээнэ.

II. Олон улсын эрх зүйг зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн нь тухайн улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй байсан ч олон улсын хуулиар шүүж, шийтгэл хүлээлгэнэ.

III. Гэмт хэрэг үйлдсэн этгээд улсын тэргүүн, засгын газрын хариуцлагатай ажилтан байсан ч хувь хүний хувьд хийсэн үйлдлийнхээ хариуцлагыг хүлээнэ.

IV. Хэрвээ тухайн этгээд гэмт хэргийг засгын газар болон дээд байгууллагын тушаалаар үйлдсэн байсан ч, ёс суртахууны сонголт үнэхээр боломжтой байсан тохиолдолд, хариуцлага хүлээнэ.

V. Олон улсын эрх зүйд зааснаар гэмт хэрэгт тооцогдох хэрэг үйлдсэн этгээд хуулийн дагуу, баримт нотолгоон дээр үндэслэсэн шударга шүүхээр шүүгдэх эрхтэй.

VI. Олон улсын эрх зүйд зааснаар доорх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцно:

a) Энх тайвны эсрэг гэмт хэрэг: Олон улсын гэрээ хэлэлцээрийг зөрчсөн дайныг төлөвлөх, бэлтгэх, улмаар дайныг эхлүүлэх болон эдгээр үйлдлүүдийг үйлдэхэд оролцсон бүх үйлдэл.

b) Дайны гэмт хэрэг: алан хядлага, зүй бусаар харьцах, энгийн иргэдийг эзлэгдсэн газар нутагт боолийн хөдөлмөр эрхлүүлэхээр цөлөх, дайны хоригдлуудыг хөнөөх буюу зүй бусаар харьцах, барьцааны хүнийг хөнөөх, хот, суурин газар, тосгодыг дур мэдэн сүйтгэх, цэргийн хэрэгцээгээр зөвтгөгдөөгүй хор хөнөөл, сүйрэл гэх мэт үйлдлүүд орно.

c) Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт: алан хядлага, олноор нь хүйс тэмтрэх явдал, боолчлол, цөллөг болон энгийн иргэдийн эсрэг үйлдсэн бусад хүмүүнлэг бус үйлдлүүд; энх тайвны эсрэг, дайны гэмт хэрэг зэрэг аливаа гэмт хэрэгтэй холбоотой гүйцэтгэсэн үйлдлүүдийг улс төр, арьс үндэс, шашны учир шалтгаанаар шийтгэх гэх мэт үйлдлүүд орно.

VII. 6—р зарчимд тоочсон гэмт хэргүүдийг хамтран үйлдсэн тохиолдолд олон улсын эрх зүйг зөрсөн гэмт хэрэг гэж үзнэ.

# Баримт хуудас: Олон улсын тусгай шүүх

## Хуучин Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх (ЮОУЭШ)

1992 оны 4—р сараас 1995 оны 11—р сарын хооронд үргэлжилсэн Босни— Герцеговины мөргөлдөөн нь дэлхийн 2—р дайнаас хойш Европт болсон хамгийн зэрлэг, аймшигтай үйл явдал байсан бөгөөд бөөнөөр нь устгах, тамлах, энгийн иргэдийг албадан цөлөх, хүчирхийлэх болон олноор нь лагерьт хорих гэх мэт олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн олон зөрчлүүд гарсан юм.

**Эх үндэс:**

ЮОУЭШ—ийг 1993 оны 5—р сард НҮБ—ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрээр Нидерланд улсын Гааг хотод байгуулсан.

**Шүүх үйл ажиллагаа:**

1991 оноос хойш хуучин Югославын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн доорх хэргүүдэд хариуцлага хүлээх этгээдүүдийг шүүн шийтгэх болсон. Үүнд:

- 1949 оны Женевийн Конвенцийн ноцтой зөрчлүүд
- Хуулийн зөрчлүүд буюу дайны зан үйл
- Геноцид
- Хүн төрөлхтний эсрэг үйлдсэн гэмт хэрэг

Эдгээр хэргүүдийг үндэсний шүүхээс өмнө шүүн хэлэлцэнэ.

**Шүүх бүрэлдэхүүн, тэдний иргэншил:**

(2002 оны 4—р сарын хувьд)

Тэргүүлэх улс орон: Франц, Гияна
Тэргүүлэх шүүгчид: Нэгдсэн Вант улс, Герман, Хятад
Шүүгчид: Замби, Египет, Австрали, Ямайка, Турк, Шри Ланка, Итали, Малт, Нидерланд, Өмнөд Солонгос, АНУ

# Баримт хуудас: Олон улсын тусгай шүүх

## Рвандагийн Олон Улсын Эрүүгийн Шүүх (РОУЭШ)

1994 оны 4—р сард засгийн газрын цэрэг болон Рвандагийн эх орончдын фронтын хооронд болсон мөргөлдөөний үеэр томоохон хэмжээний алан хядлага буюу геноцид болсон.

7—р сард засгийн газар ялагдан унаж алан хядлагыг эцэс болгосон. Хэдэн сарын дараагаар шинэ засгын газар байгуулагдаж, энэхүү алан хядлагад оролцсон хэргээр 120000 орчим хүмүүсийг баривчлан хорьсон. Ямар ч шүүхийн аппарат байхгүй улсад шинэ засгийн газар үндэсний шүүх байгуулж, ирээдүйн шүүгчдийг сургаж эхэлсэн. Гэвч энэ шүүхийг хүлээж буй хүмүүс олон байсан ч, шүүх арга хэрэгсэл ховор байв.

Геноцидийн үйлдэл, газар авч олныг хамарсан олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчилд цочирдсон НҮБ—ын Аюулгүйн Зөвлөл 11—р сард РОУЭШ—ийг байгуулсан.

**Эх үндэс:**

РОУЭШ—ийг 1994 оны 11—р сард НҮБ—ын Аюулгүйн Зөвлөл Танзани улсын Аруша хотод байгуулсан.

**Шүүх үйл ажиллагаа:**

1994 оны 1—р сарын 1—нээс 12—р сарын 31—ны хооронд Рвандагийн нутаг дэвсгэрт (буюу хөрш зэргэлдээ улс орнуудад Рвандачуудын) үйлдсэн доорх хэргүүдэд хариуцлага хүлээлгэн шүүн шийтгэх болсон. Үүнд:

- Геноцид
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг
- Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэгдэх ОУХЭЗ—н дүрмүүдийн зөрчил

Эдгээр хэргүүдийг үндэсний шүүхээс өмнө шүүн хэлэлцэнэ.

**Шүүх бүрэлдэхүүн, тэдний иргэншил:**

(2001 оны 10—р сарын хувьд)

Давж заалдах шүүхийн тэргүүлэх танхим: Франц
Шүүх танхимийн тэргүүлэгчид: Өмнөд Африк, Норвеги, Танзани, Сейнт Киттс ба Невис
Шүүгчид: Сенегал, Лесото, Мадагаскар, Орос, Словени, Гияна, Австрали, Турк, Шри Ланка, Итали, АНУ

# Баримт хуудас: Олон улсын тусгай шүүх

## Рвандагийн шүүхийн хүчин чармайлт

### Үндэсний төвшинд

- Рвандад геноцид болон дайны гэмт хэргийг үйлдсэнд сэжиглэгдэгчид үндэсний шүүхээр шүүгдэнэ.
- Сэжиглэгдсэн этгээдүүдийн тоо 100000—аас хэтэрсэн тул засгийн газар шүүх хурлыг хурдавчлахын тулд шүүхийн уламжлалт систем болох "Гакака"—аар шийдэхээр болсон. 11000 Гакакагийн шүүхийг Рвандагийн ард түмнээс сонгогдсон энгийн иргэд ахална. Гэвч энэ шүүх нь хүнд гэмт хэрэгт яллах болон цаазаар авах ял оноох эрхгүй. Засгийн газар ирээдүйн Гакака шүүгчдийг зүй ёсоор бэлтгэсний дараа 2002 онд Гакака шүүхийг нээхээр төлөвлөж байна.

### Олон улсын төвшинд

- Рвандагийн олон улсын эрүүгийн шүүх
- Рвандагийн хэдэн иргэд Рвандагийн газар нутгаас гадна буюу Кения, Өмнөд Африк, Кот д'Ивуар, Того, Бенин, Намиб, Мали, АНУ, Бельги болон Данийн газар нутагт алан хядлага үйлдсэний улмаас баривчлагдсан. Рванда буюу РОУЭШ—д хэрэг нь шилжээгүй хүм үүс тухайн улсын шүүхээр шүүгджээ.

# Баримт хуудас: Олон Улсын Эрүүгийн Шүүх (ОУЭШ)−ийн тухай асуултуудад хариу өгөх нь:

1998 оны 7−р сард 160 орны үндэстнүүд дэлхий нийтийн анхаарлын төвд буй хамгийн ноцтой гэмт хэрэг болох геноцид, дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг шүүх зорилгоор Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулахаар шийдсэн. НҮБ−ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Кофи Аннан энэхүү хэрэг явдлыг "дэлхий нийтийн хүний эрх ба хуулийн дүрэм журмын төлөөх парадын асар том урагшилсан алхам боллоо" хэмээн дүгнэсэн. Гэвч зарим шүүмжлэгчид ОУЭШ нь үр ашиггүй байгууллага, үндэсний тусгаар тогтнолд аюул авчрах муу талтай хэмээн дүгнэж байна. Энэхүү баримт хуудсаар зарим нийтлэг асуултууд болон буруу ойлголтуудад хариу өгнө.

**Эх үндэс:** ОУЭШ нь олон улсын их хурлын дараа 1998 оны 7−р сард Ромын гэрээгээр үүсгэн байгуулагдсан. 2002 оны 4−р сарын 11−ны Ромын Дүрмийн 60−р батламжаар Нидерланд улсын Гааг хотод Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулан мөн оны 7−р сарын 1−нээс үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Нийт 139 улс орон уг Дүрэмд гарын үсэг зурсан байна.

**Шүүгчид:** Шүүх 18 гишүүнээс бүрдэх бөгөөд олонхийн саналыг гуравны хоёроос дээш авсан бол сонгогдох бөгөөд тухайн улс нь Шүүхийн гишүүн орон байна.

**Шүүх үйл ажиллагаа:** ОУЭШ нь дэлхий нийтийн анхаарлын төвд буй ноцтой гэмт хэрэгт хариуцлагатай этгээдүүдийг шүүнэ. Бүрэн эрхийн дэлгэрэнгүй хязгаартай шүүхийн үйл ажиллагаа нь тодорхой нөхцөл байдалд ерөнхий ба хязгааргүй (ЮОУЭШ ба РОУЭШ−тэй нэгэн адил) байна.

**Эрх мэдэл:** Шүүх доорх 4 төрлийн гэмт хэргийг шүүх эрх мэдэлтэй.

- Геноцид
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг
- Дайны гэмт хэрэг
- Түрэмгийлсэн гэмт хэрэг

Энэ нь үндэсний шүүхэд нэмэлт болон хамрагдана.

### Улс орнууд ямар учраас Олон Улсын Эрүүгийн Шүүхийг үүсгэн байгуулахаар болов?

Дэлхийн 2−р дайны дараахь Нюрнберг, Токиогийн шүүхийн дараа 1948 онд НҮБ−ын Ерөнхий Ассемблей иймэрхүү Шүүхийг бий болгох хэрэгтэй хэмээн үзэж үүнээс хойш энэ талаар хэлэлцэж байсан юм. Гэвч саяхан хуучин Югослав болон Рвандад гарсан аймшигт хэргийн улмаас НҮБ−ын Аюулгүйн Зөвлөл тусгай шүүхийг бий болгосон бөгөөд хүмүүсийг олноор нь алан хядсан болон дайны гэмт хэрэгтнүүдийг шүүх байнгын механизм хэрэгтэй болсныг харуулсан. Байнгын шүүх нь тусгай шүүхээс илүү хурдан бөгөөд хүчирхэг байж чадна.

# Баримт хуудас: Олон Улсын Эрүүгийн Шүүх (ОУЭШ)−ийн тухай асуултуудад хариу өгөх нь:

### Шүүх хэзээ хаана үүсгэн байгуулагдсан вэ?

Шүүхийн Дүрэм 60 улс орон соёрхон батлаж, гарын үсэг зурсны дараа 2002 оны 7−р сарын 1−нд хүчин төгөлдөр болсон. 2002 оны 4−р сарын байдлаар олон улсын байнгын эрүүгийн шүүх байгуулахыг албан ёсоор дэмжин нийт 66 орон соёрхон баталж, 139 орон гарын үсэг зурсан байна. Шүүх Нидерландын Гаагт байрлах ба тохиромжтой бол өөр газар ч хэргийг шүүж болно.

### Шүүх ямар хэргүүдийг шүүн шийдвэрлэх вэ?

Энэхүү Шүүх нь геноцид, дайны гэмт хэрэг болон энгийн иргэдийг олноор нь системтэй хүйс тэмтрэх, боолчлох, эрүүдэн шүүх, хүчирхийлэх, хүчээр жирэмслүүлэх, улс төр, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэгээр нь ялгаварлан шийтгэх, алга болгох гэх мэт хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг шүүнэ. Шүүх тодорхойгүй хоёрдмол байдлаас зайлсхийх үүднээс гэмт хэргийг нэг бүрчлэн жагсаан тодорхойлдог.

### Шүүх сексийн хүчирхийллийг шүүх үү?

Тийм ээ, шүүнэ. Шүүхийн Дүрэм нь энгийн ард иргэдийн эсрэг өргөнөөр болон системтэйгээр үйлдэгдсэн бол хүчирхийлэл, сексийн боолчлол, хүчээр жирэмслүүлэх гэх мэт сексийн хүчирхийллийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт багтаадаг. Мөн олон улсын болон дотоодын мөргөлдөөний үед үйлдэгдсэн бол дайны гэмт хэрэгт тооцогдоно.

### Иймэрхүү гэмт хэргийг шүүхэд бидэнд яагаад олон улсын эрүүгийн шүүх хэрэгтэй вэ?

### Дотоодын шүүх энэ асуудлыг шийдэж болохгүй гэж үү?

Үндэсний шүүх шүүн таслах үйл ажиллагаа явуулна. "Харилцан бие биенээ нөхөхүйн" зарчмаар, Олон Улсын Эрүүгийн Шүүх үндэсний шүүхийн шийдэж чадахгүй буюу хүсэхгүй байгаа хэргийг шийднэ. Харамсалтай нь, зарим улс орнуудад нийгмийн ба улс төрийн мөргөлдөөн, сүйрэл болоход эдгээр гэмт хэрэгт тохирсон шийтгэлийг оноох чадвартай шүүх тэр болгон байдаггүй. Засгийн газар өөрийн иргэдийг, ялангуяа тухайн хүн өндөр албан тушаалтан бол шийтгэж чаддаггүй байж болно. Ихэвчлэн 2 улсын хил дамнан гэмт хэрэг үйлддэг учир тухайн улсууд гэмт хэрэгтнийг баривчлан шүүхэд хамтрах шаардлага гардаг. Иймэрхүү тохиолдолд Олон Улсын Эрүүгийн Шүүх санал болгон тусална.

### Олон Улсын Шүүхийн хувьд?

НҮБ−ын салбар байгууллага болох Олон Улсын Шүүх нь хувь хүний үйлдсэн эрүүгийн гэмт хэргийг бус улс хоорондын маргааныг шийдвэрлэдэг.

# Хэвлэлийн хуудас

**Зорилго:** Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг дотооддоо болон гадаадын улс орнуудад сахиулах талаар мэдэж авах

**Хууль сахиулалт**

1. ОУХЭЗ буюу хүний эрхийн хууль зэрэг хүмүүнлэгийн хууль сахиулахтай холбоотой телевиз, радио, сонин, сэтгүүлийн мэдээ хайж олно.

   /олон улсын шүүх, үндэстний шүүхээр дамжуулан хийгдэх хууль ёсны үйл ажиллагаа, цэргийн шүүх/

2. Өмнө нь мөрдөн байцаагдаж байсан нөхцөл байдал болон шүүгдэж байсан хүний талаар дүрсэлнэ.

- Буруутгагдаж байгаа хүн нь хэн бэ? Ямар зөрчил буюу зөрчлүүдийн улмаас?
- Хууль ёсны ямар үйл ажиллагаа болов? Хэн тэр үйл ажиллагааг явуулав?
- Тухайн хэргийн өнөөгийн нөхцөл байдал, статус ямар байна вэ?
- Дараагийн шатанд юу болно гэж бодож байна вэ? Яагаад?

3. Өөрийн сонгосон хэргээ үргэлжлүүлэн судлан илтгэл тавина.

**Үнэлгээний аргууд:**

- Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:

"*Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь*" хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх бололцоог олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

- Сурагчдын ажлын хавтас:

Дөрөвдүгээр бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

- Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

4—р бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20—30 минут), эсвэл 2—3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно. (25 минут)

   ➤ ОУХЭЗ—г хэрэгжүүлэхэд тулгарах зарим бэрхшээлүүд юу вэ? Тодорхой жишээнүүд дурдана уу.

   ➤ Ирээдүйд ОУХЭЗ—г хэрэгжүүлэхэд хэцүү буюу амархан талаар юу гэж бодож байна вэ? Шалтгаан болон жишээ дурдана уу.

2. Товч хариулах асуултууд: Хоёр асуулт сонгоно. (тус бүр 10 минут)

   ➤ Нюрнбергийн шүүхээс, дайны гэмт хэргээр шүүгдэгсдийг өмгөөлсөн хуульчдын 3 маргаанаас нэгийг дурдана уу.

   ➤ Одоогоор ОУХЭЗ—г сахиулахад хэрэглэгдэж буй 3 арга замын нэг нь юу вэ?

Сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

**Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:**

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- үзэл санаагаа бататгах тодорхой бодитой жишээ гаргах
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

**Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс**

- Гватемала: Нам нүм байдлыг эргэн дурсахуй
  http://hrdata.aaas.org/ceh/report/english/toc.html
  Англи, Испани хэл дээр
- Үнэнийг Тогтоох Комисс (АНУ—ын Энх Тайвны Номын Сангийн Институт)
  http://www.usip.org/library/truth.html
- Үнэнийг Тогтоон Эвлэрүүлэх Комисс (Өмнөд Африк)
  http://www.truth.org.za/

**Нюрнбергийн Цэргийн Шүүх**

- Нюрнбергийн Дайны Гэмт Хэргийн Шүүх: Йелийн Хуулийн Сургуулийн Авалон төсөл
  http://www.yale.edu/lawweb/avalon/imt/imt.htm
  Шүүхийн гол эх сурвалж, баримтууд
- Томас Ж. Доддын ажлууд: Нюрнберг http://www.lib.uconn.edu/DoddCenter/ASC/dodp—main.htm#Nuremberg
  Нюрнбергийн шүүх ажиллагааг өдөр өдрөөр судалсан Америк хуульчийн ажил
- Дайны гэмт хэрэгтнүүдийн шүүх нь: Хэвлэл Мэдээллийн Сургалтын Төвийн Музей
  http://motlc.wiesenthal.org/pages/t003/t00398.html
- Дайны гэмт хэргийн шүүх (АНУ—ын Холокостын Дурсгалын Музей)
  http://wlc.ushmn.org/

**Тусгай шүүх**

- Хуучин Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх
  http://www.un.org/icty/
- Руандагийн Олон Улсын Эрүүгийн Шүүх
  http://www.ictr.org/
  Англи, Франц хэл дээр

**Олон Улсын Эрүүгийн Шүүх**

- Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Эвсэл
  http://www.i ccnow.org/
  Англи, Франц, Испани хэл дээр
- Олон Улсын Шүүх
  http://www.icj—cij.org/icjwww/icj002.htm
  Англи, Франц хэл дээр
- Олон Улсын Эрүүгийн Шүүх (НҮБ)
  http://www.un.org/law/icc/index.html
- Олон Улсын Эрх Зүй (НҮБ)
  http://www.un.org/law/index.html
  Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэл дээр



# 5 Бүлэг

# Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь

***(6 Хичээл)***

***Дайны үр дагаврууд гэж юу вэ?***

***Тэдгээрт хариу үзүүлэхэд ямар хүчин чармайлт шаардагддаг вэ?***

***Хүмүүнлэгийн үйл ажиллагааны явцад ямар дилемма гардаг вэ?***

## СУДАЛГААНУУД:


Судалгаа 5A: Дайны хор хөнөөлөөс үүдэн гарах хэрэгцээ (1 хичээл). . . 241
Судалгаа 5B: Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх (1 хичээл). . . 250
Судалгаа 5C: Хоригдлуудыг хамгаалах (2 хичээл). . . 267
Судалгаа 5D: Гэр бүлийн холбоог сэргээх (1 хичээл). . . 281
Судалгаа 5E: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй (1 хичээл). . . 287


## ОЙЛГОЛТУУД:

Үндсэн хэрэгцээ
Материаллаг бус хэрэгцээ
Дүрвэгсэд ба шилжин нүүсэн хүмүүс
Төвийг сахих
Шударга байх

**Нийт бүлгүүдэд:**
Хүний нэр хүнд
Хүмүүнлэгийн зан үйлд учрах саад тотгорууд
Дилемма
Үр дагаврууд
Олон талт төлөв байдал

## ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Төлөвшил
Хамрах хүрээг тооцоолох
Хүчин чармайлтыг тооцоолох
Дилеммад анализ хийх
Үр дагаврыг илрүүлэх
Бүлгээр ажиллах

# Судалгаа 5 А. Дайны хор хөнөөлөөс бүрэлдэн гарах хэрэгцээ

5–р Бүлэгт дайны үр дагаврууд болон түүнд хариу үзүүлэхэд шаарлагатай хүчин чармайлтыг тодорхойлно. Эхний судалгаагаар сурагчид нэгэнтээ үгүй болсон арга боломжийг олж харахын тулд фото зураг үзэн энэ бүхнээс үүдэн гарах хэрэгцээний талаар бодолцоно. Тэгээд дараа нь энэхүү хэрэгцээг хангах зарим нэгэн хариу үйлдлүүдийг олж илрүүлнэ. Дүрс бичлэгээр дайны улмаас шилжин нүүсэн хүмүүсийн туулж өнгөрөөсөн туршлагыг үзүүлнэ.

> Би гэртээ буцаж харимаар байна. Гэвч зарим тохиолдолд тосгон тэр чигээрээ сүйрсэн байдаг учраас хэн нэгэн тосгондоо буцаж очих боломж огтхон ч байхгүй болсон.
>
> И. Иванкович, Босни–Герцеговини, 1999 он

**Зорилго:**

- Дайн дажин амьдралын суурь хэрэгцээг хэрхэн бусниулж сүйтгэдэг талаар ойлгож авах
- Зэвсэгт мөргөлдөөний улмаас үүсэх гай зовлонгоос сэргийлэх, зовлонг нимгэлэхэд шаарлдлагатай хүмүүнлэгийн үйл ажиллагааны цар хүрээг мэдэж байх

**Ашиглах материалууд:**

- Судалгаа 2А–д ашигласан фото зургын эвлүүлэг – номын хавтсанд хавсаргав
- Зэвсэгт мөргөлдөөний нөлөө – Афганистан 1999 он
- Дүрс бичлэг ба тайлбар: Гэрээсээ албадлагаар хөөгдөв

**Багш нарт:**

- Афганистан дахь Олон Улсын Улаан Загалмайн Хорооны үйл ажиллагаанаас, 1999 он

**Хугацаа:**

45–60 минутын нэг хичээл






**1. Зэвсэгт мөргөлдөөний улмаас үүдэн гарах хэрэгцээ**
(цомхон бүлгээр) (15 минут)

Сурагч бүр *Фото зургийн эвлүүлэг 2А*–аас нэг зураг сонгож, тэдгээр зурган дээр байгаа тухайн нөхцлийг даван туулсан хүмүүст чухам юу хэрэгцээтэй байгааг жагсаан бичнэ.

Цомхон бүлэг болон хуваагдаж, сонгож авсан зургынхаа талаар хэлэлцэнэ:

- Тэдний харсан сүйрсэн буюу үгүй болсон арга боломжууд
- Жагсааж бичсэн хэрэгцээнүүдийн тухай болон яагаад сонгов?

Сүйрсэн барилга байшин гэх мэт харагдахуйц сүйрлээс гадна хэрэглэгдэхүүн, хувийн эд зүйлс, үхэл зовлон, гэр бүлийн гишүүдээсээ хагацаж салсан болон нийгмийн үйлчилгээний хомсдол зэрэг бусад гарз хохиролд анхаарлаа хандуулахыг хүснэ.

Нийт бүлгүүдийг цуглуулан зэвсэгт мөргөлдөөний улмаас сүйдсэн арга боломжуудыг бичсэн жагсаалтаа нэгтгэнэ. Дараа нь тэдгээр үр дагавраас үүдэн гарсан хүмүүсийн хэрэгцээг жагсаан бичээрэй.

**Боломжит асуултууд:**

- Сүйдсэн арга боломжийн үр дагаварт хүмүүс цаашид ямар алдагдлыг амсах вэ?

> Хүн бүр зовж шаналж байлаа. Зовж шаналагсдын дотроос эмэгтэйчүүд илүү их зовж байв. Учир нь тэд нөхөр, хүүхдүүд болон эд хөрөнгөө алдаж, дээр нь амьд үлдсэн үр хүүхэд, хамаатан садангаа тэжээх боллоо. (...) Ихэнхи эрчүүд дайнд нас барцгааж, эмэгтэйчүүд нуруун дээрээ эдийн засгийн хүнд ачааг үүрэн хоцорлоо.
>
> Шилжин нүүсэн эмэгтэй, Сомали

- Зэвсэгт мөргөлдөөний үр дагавартай нүүр тулах эдгээр хүмүүст туслах ямар төрлийн үйл ажиллагаанууд байж болох вэ?
- Зарим үйл ажиллагаа бусдаасаа нэн яаралтайгаар шаардлагатай байна уу? Яаралтай байдлын түвшинг тогтооход ямар шалгуур үзүүлэлтүүд байна вэ?
- Иймэрхүү яаралтай байдалд ямар бүлгийнхэн ерөнхийдөө тусгай анхаарал хүртэх эрхтэй байдаг вэ? Яагаад?

2. **Хэрэгцээг хэрхэн хангах тухай (цомхон бүлгээр)** (15—20 минут)

Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд олон тооны байгууллагууд хамтран хэрэгцээ шаардлагатай хохирогчдод хариу үзүүлдэг. Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос гадна идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг олон байгууллагууд байдаг. Жишээ нь: НҮБ—ын салбар байгууллагууд болох НҮБ—ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ), НҮБ—ын Дүрвэгсдийн асуудлыг хариуцсан Дээд Комисс болон Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, олон улсын төрийн бус байгууллагууд болох Хил Хязгааргүй Эмч нар (MSF), Хүний Эрхийн Манаа, Хүүхдийг Хамгаалах Байгууллага, Олон Улсын Тахир Дутуучуудад туслах болон орон нутгийн бусад байгууллагууд.

*Зэвсэгт мөргөлдөөний нөлөө — Афганистан 1999 он*—ыг ашиглан зэвсэгт мөргөлдөөний улмаас үүдэн гарах хэрэгцээнд хариу болгон зохион байгуулах ёстой янз бүрийн үйл ажиллагааг авч хэлэлцэнэ. 1999 оны Афганистаны нөхцөл байдлыг танилцуулна.

Сурагчдаар хүмүүст учирсан хор уршгийн талаар төсөөлөн бодуулна.

Хуваагдсан бүлэг бүр хөтөлбөрийн нэг категориор ямар тодорхой хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах талаар брейнсторм хийнэ. (5минут) [шаардлагатай бол "Афганистан дахь Олон Улсын Улаан Загалмайн Хорооны үйл ажиллагааны жишээ"—г ашиглан сурагчдыг эхлэхэд нь тусална]
Ангиараа санал бодлоо хуваалцана.

### Боломжит асуултууд:

- Үйл ажиллагаа явуулах явцад хүмүүнлэгийн байгууллагууд ямар саад бэрхшээлтэй учирч болох вэ? Яагаад?
  *[Жишээ нь: аюулгүй байдлын асуудал, байлдааны бүст буй тусламж хэрэгцээтэй хүн ам, хөрш улс орон зөвшөөрөл олгодоггүйгээс тусламж хүргэх хамгаалалтынхан орж ирэхэд бэрхшээл тулгарах, дайсанд тооцогдож байгаагаас хүн амд очих тусламж гарцгүй болох, богино хугацаанд олон мянган хүмүүсийг шилжин нүүлгэсэн үед гүйцэтгэх ёстой олон зорилтууд байгаа байдал, зэвсэглэсэн байлдагчидтай холилдсон тусламж хэрэгцээтэй энгийн иргэд, санхүүжилтын гачигдал, гэх мэт]*
- Иймэрхүү хүмүүнлэгийн онцгой байдалд, төлөвлөх буюу гүйцэтгэх явцад юунд анхаарлаа хандуулах ёстой вэ?
  *[Жишээ нь: төлөвлөсөн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, дэмжиж буйг нягтлахаар зэвсэгт бүлгүүдтэй холбоо барих, хохирогчдод тэдний хэрэгцээтэй зүйлээр хангаж өгч байгаа эсэх болон энэ тусламж нь ирээдүйд тэднийг аливаа зүйлээс хамааралтай болгохгүй байх талаар болгоомжтой үнэлгээ хийх, хамгийн яаралтай хэрэгцээ, шаардлагатай нөхцлийг олж тогтоон төлөвлөх, тулгамдааг байгаа гол асуудлуудыг хамра, жишээ нь: хуурай хоол авчрахаас өмнө хоолоо хэрхэн хийхээ шалгах, халдварт өвчнөөс сэргийлэн усны чанар сайн эсэхийн шалгах, боломжтой бол нутгийн мэргэжилтнүүдээс асууж лавлах, гэх мэт]*

Би юун дээр гишгэснээ ч мэдээгүй. Гүйж явтал гэнэт бөмбөг дэлбэрэх сонсогдсон.

Кабулын эмнэлэгт хэвтэж байгаа 14 настай охин

Тэр хөвгүүний хөлийг тайрч байхад надад өөрийнхөө хөлийг тайруулж байгаа мэт сэтгэгдэл төрсөн.

Хүүг эмчилсэн эмч / Олон Улсын Улаан Загалмайн Хорооны хэвлэл

**Женевийн Конвенцийн Нэмэлт II Протокол**
**14—р зүйл (...) Энгийн хүн амын өлсгөлөнг дайтах ажиллагаа явуулах арга болгохыг хориглоно. Иймд энэ зорилгоор хүнсний нөөц, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хөдөө аж ахуйн бүс, тариалан, мал, ундны усны төхөөрөмж, түүний нөөц, түүнчлэн усалтын байгууламж зэрэг энгийн хүн амд шаардагдах объектыг довтлох, устгах, зөөвөрлөх, эсхүл ажиллагаагүй болгохыг хориглоно.**

**Женевийн Конвенцийн Нэмэлт I Протокол**
**70—1—р зүйл (...) Хүмүүнлэгийн болон шударга тусламжийг талуудын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу ямар нэг ялгаваргүйгээр хэрэгжүүлнэ. Дээр дурдсан тусламжийг үзүүлэх тухай санал дэвшүүлснийг зэвсэгт мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцсон, эсхүл найрсаг биш үйлдэд гэж үзэхгүй. (...)**

**81—1—р зүйл. Мөргөлдөөнд оролцогч талууд дайн, мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах, тэдэнд тусламж үзүүлэх явдлыг хангах зорилгоор Конвенцууд болон энэхүү протоколоор Олон Улаан Загалмайн Хороонд хүлээлгэсэн хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулахад боломжтой бүхий л талаар тусламж үзүүлнэ. (...)**

# Судалгаа 5 А. Дайны хор хөнөөлөөс бүрэлдэн гарах хэрэгцээ

➤ Цаашид хор уршиг буюу хохирогчид гарахаас сэргийлэхэд чиглэгдсэн ямар үйл ажиллагаанууд байна вэ?
*[Жишээ нь: ОУХЭЗ–г хүндэтгэн сахиагүйгээс гарч болох үр дагаврыг байлдагчдын удирдлагуудад ойлгуулах, хоригдлууд болон ард иргэдийн нөхцөл байдлын талаар эрх мэдэлтнүүдэд мэдээлж, асуудлыг шийдвэрлэхэд нь туслалцах, хохирогчдод хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаар, тэдний үзүүлэх тусламжын талаар мэдээлэх, цэргийн болон армийн удирдлагуудад байлдагчдад зориулж олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дүрмүүдийг хүндэтгэн сахиулах талаар сургалт хийхэд нь туслах]*

➤ Эдгээр үйл ажиллагааг удирдан явуулахад ямар ажил мэргэжилтэй хүмүүс шаардлагатай вэ?
*[Жишээ нь. Эмч сувилагчид, хүнс тэжээл судлаач, эрүүл ахуй ба орчин тойрны инженер, аж ахуйн мэргэжилтэн, нисгэгч, нарийн бичиг, захиргааны ажилтан, ачааны машины жолооч, механикч, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, хуульч, хамгааллын мэргэжилтэн, орчуулагч, мэдээлэл–системийн техникч]*

> Цэргүүд ирэнгүүт бид явцгаасан. Бид тэр үед тортия хийж байлаа. Гэртээ байсан бүх л зүйлээ орхиод зугтаасан. Биднийг буцаж ирэхэд бүх зүйлийг сүйтгэсэн байсан бөгөөд бид өлсөж үхэх гэж байсан.
>
> Шилжин нүүсэн эмэгтэй, Эл Салвадор

**Хаалт:** Ямархуу байдаг вэ? (15 минут)

Хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь бүхэлдээ зөвхөн хүмүүнлэгийн ажилчдын бус, зэвсэгт мөргөлдөөний улмаас зовж шаналсан хүмүүсийн төлөө ажил юм. Одоо *албадлагаар гэрээсээ хөөгдсөн нь* дүрс бичлэгийг (тайлбартай) үзнэ үү. Үүнд Мэдин, Дамир (12 ба 13 настай) хоёр гэрээсээ зугтах нь ямар байсан талаар болон 3 хүүхдийн эх 30 настай Саба дүрвэгсдийн лагерь луу яаж явсан тухай өгүүлнэ.

Тэдний амьдралд дайн хэрхэн нөлөөлсөн болон үр дүнд нь ямар хэрэгцээ гарч байгаа талаар ярилцана уу.

**Боломжит асуултууд:**

➤ Хөвгүүд дүрвэгчид болсноор амьдрал нь хэрхэн өөрчлөгдөв?
Тэдэнд юу хэрэгтэй байна вэ?
Тэдний хэрэгцээг хангахын тулд ямар төрлийн хүмүүнлэгийн үйл ажиллагаа хэрэгтэй байна вэ?

➤ Саба ямар гарз хохирол амссан бэ?
Дүрвэгсдийн лагерь дахь амьдрал түүний өмнөх амьдралаас ямар ялгаатай гэж бодож байна вэ?
Түүний гэр бүлд хүмүүнлэгийн ямар үйл ажиллагаа тусламж үзүүлж чадах вэ?

> Там гэр бүлийхнийгээ аваад өдөр гэрээсээ явсан. Түүний эхнэр 2 бага хүүхэдтэйгээ эхний дугуйн дээр, 3 өөр хүүхэд 2 дахь дугуйн дээр, Там өөрөө 3 дахь дугуйг унаад биедээ боодол хувцас, 700 пиастр аван будаан талбай, байшин, тавилга болон хоол хийдэг бүхий л хэрэгслүүдээ орхин явсан юм.
>
> Сьюзан Шийан, "Арван Вьетнам"

**ГОЛ САНААНУУД**

♦ Зэвсэгт мөргөлдөөн их хэмжээний эд баялагийн хохирол авчирч, амьдралын ердийн хангамжийг алдагдуулдаг.

♦ Зэвсэгт мөргөлдөөний үед хүний амь нас, нэр хүндэд аюул учирч, улмаар тусгай хамгаалалт хэрэгтэй болдог.

♦ Хүмүүнлэгийн байгууллагууд хамтран ажилласнаар амьдралын ердийн хангамжийг нөхөн сэргээж чаддаг.

## Нэмэлт дасгал

**Чухал хэрэгцээтэй зүйлсийн жагсаалт**

Амьдралдаа хамгийн чухал хэрэгцээтэй байгаа зүйлсээ жагсаан бичнэ үү.

➤ Боломжийн ая тухтай амьдарья гэвэл чамд юу хэрэгтэй вэ?

Хэвийн амьдрахад хамгийн чухал гэж үзэж байгаа зүйлсээ дугуйлна.

Хүний нэр хүндээ мэдрэхэд тусалж болох зүйлсийг нь тэмдэглэнэ үү.
➤ Эдгээр хэрэгцээнд дайн хэрхэн нөлөөлж байна вэ?

Өөрийн жагсаалтаа бусад хүмүүсийнхтэй харьцуулан ярилцана.

**Дүрвэн зугтах нь**

Хүмүүс гэр орноо орхиход хүргэдэг янз бүрийн хүчин зүйлээс (гэр орон, эд хөрөнгө, ус, цахилгаан, боловсролоо алдах гэх мэт) илүүтэйгээр аюулгүй байдлаа алдах нь хүмүүсийг зугтах үедээ түргэн шуурхай шийдвэр гаргахыг шаарддаг. Аюул нүүрлэж ирэхэд шийдвэр гаргах цаг тун бага байдаг. Хүмүүс гэр орноо орхин явахад хэзээ буцаж ирэх нь тодорхойгүй байдаг бөгөөд буцаж ирэхгүй ч байж болох магадлал бий. Энэ дасгал нүүлгэн шилжүүлэлт нь хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлдэг болохыг таниулах зорилготой юм.

Жижиг бүлэгт хуваагдаж, доорх нөхцөл байдлыг төсөөлөн бодоцгоогоорой.

> Та нар нэгэн гэр бүл буюу хөрш айлын бүлэг хүмүүс.
> Та нарын амьдардаг газар дайралтанд өртсөн.
> Та нар амьралаа аврахын тулд яг одоо гэрээсээ зугтан явах ёстой.
> Та хаашаа ч явж байгаагаа, мөн хэзээ буцаж ирэхээ ч мэдэхгүй байгаа.
> Танд 10—хан минут л байна.

1. Ганцаараа юу авч явахаа бичнэ.
2. Дараа нь бүлгээрээ юу авч явахаа, яагаад үүнийг авах болсноо, мөн яаж авч явахаа шийднэ.
3. Бүлгээрээ гаргасан шийдвэрээ бичнэ.

Өөрийн бүлгийн төлөвлөгөөг бусад бүлгийнхэнтэй харьцуулаарай.

➤ Танай бүлэг юу авч явахаар төлөвлөсөн бэ, яагаад?
➤ Эдгээр шийдвэрийг гаргаж байхад танд ямар бодол, мэдрэмж төрсөн бэ?
➤ Хэрвээ танай бүлэгт өндөр настан, нярай эсвэл мөлхөө хүүхэд байсан бол танай төлөвлөгөөнд ямар өөрчлөлт гарах байв?
➤ Зэвсэгт мөргөлдөөний эмх замбараагүй байдал та нарыг шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлөх вэ?

*[нэгэн ангид сурагч "би банканд хадгалуулсан бүх мөнгөө авна" гэхэд багш "тэгвэл банканд хэн ажиллаж байх юм бэ?" гэж асуув.]*

## Нэмэлт дасгал

**Дүрвэгчид болон шилжин нүүсэн хүмүүс – өнгөрсөн ба одоо**

Түүхэнд зэвсэгт мөргөлдөөний улмаас хүмүүс гэр орноо орхин дүрвэсэн, нүүлгэн шилжүүлэгдсэн тухай бусад хүмүүстэй ярилцана.

Жишээ нь, Моше, Францын Гүгинотууд, тухайн газар нутгийн уугуул оршин суугчид, Шотландын 2—р Жеймс болон түүний бараа бологчид, Карл Маркс, Марк Шагал, Пабло Пикассо, 1940—өөд оны Энэтхэгт ноёрхож байсан хинду болон лалын шашинтнууд, Аяатолла Хомени, Далай Лам.

Өөрийн сонгосон хүмүүс болон бүлгийн талаар илтгэл тавьж, судалгаа хийнэ.

➤ Тэд ямар учраас зугтах болов?
➤ Саба болон Боснигийн үеэлүүдэд тохиолдсон үйл явдлуудаас ялгагдах болон ижил төстэй тал юу байв?
➤ Тэд өөрсдийн амьдралаа хэрхэн сэргээж чадсан бэ? Тэд дараа нь ямар амжилтанд хүрч чадсан бэ?

**Ярилцлага**

Танай нийгэмд дүрвэгсэд буюу шилжин нүүсэн хүмүүс байгаа эсэхийг олж мэднэ. Гэр орноосоо ямар нэгэн нөхцөл шалтгааны улмаас албадлагаар дүрвэсэн хүмүүстэй ярилцлага хийнэ.

➤ Тэр хэнтэй хамт явсан бэ?
➤ Орхисон зүйлүүдээсээ хамгийн их санаж байгаа нь юу вэ?
➤ Дүрвэж явахдаа юугаа алдаж зовж шаналсан бэ?
➤ Түүний амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ?

# Афганистан дахь Олон Улсын Улаан Загалмайн Хорооны үйл ажиллагааны тойм, 1999 он

[Тухайн *үед Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос (ОУУЗХ) гадна олон хүмүүнлэгийн байгууллагууд, Афганистанд идэвхитэйгээр ижил төстэй үйл ажиллагаа явуулж байсныг бодолцох хэрэгтэй.]*

**Тусламж: Хүнсний ба хүнсний бус**

- Хөдөө аж ахуй, газар тариаланг нөхөн сэргээх энэхүү хөтөлбөрийн зорилго нь газар тариаланчдад газраа сайжруулахад нь туслах, ингэснээр гадны тусламжаас хамаарахыг нь буруулах явдал юм. Одоогоор ОУУЗХ—ны 12 агрономичид 50000—аас илүү халамжлуулагчидтай янз бүрийн арга замаар хамтран ажиллаж байна.

- Шамалийн тал, Панжширийн хөндий, Тахар, Кундуз, Бамяан ба Кабулд ОУУЗХ, шилжин нүүсэн гэрийн бүлийнхэн болон буцан ирэгсдэд хоол унд, байр байшин барих материалыг тараасан.

- Туршлагын төслөөр төлөөлөгчид "Сило" хэмээх тэжээллэг хар талх тараасан боловч үндэсний уламжлалт талхаараа алдартай АФганчуудад сайн зохицсонгүй. Өөр сонголтгүй болсон хүмүүст чиглэгдсэн энэхүү *өөрийгөө бай болгосон стратеги* нь хамгийн их хэрэгцээтэй хүмүүсийг автоматаар сонгож байгаа хэрэг юм.

- Гадаадын тусламжанд хамаарч амьдрахгүй байхыг дэмжихийн тулд улс орон даяар хөдөө аж ахуйн төслийг улам өргөжүүлж байна.

- Афганистан дахь ОУУЗХ Кабулын хойд хэсэгт орших Парван мужын хүн амын тархалт шигүү газар 5 километр урт усжуулалтын сувгийг цэвэрлэсэн бөгөөд энэ нь олон мянган хүмүүсийг усаар хангаж байдаг юм. Панжшир голоос эх авах энэ сувгийн засвар 3 долоо хоног үргэлжилж, ойр хавийн тосгоны 1100 оршин суугчид тусалсан. 1999 онд ОУУЗХ орон нутгийн байгууллагуудтай хамтран 166 суваг буюу карезийг сэргээж, 60000 га газар усжуулах боломжийг бүрдүүлж өгсөн.

**Тусламж: Ус ба эрүүл ахуй**

- ОУУЗХ хотын эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үүднээс бие засах газар, худаг болон Кабулын 5 дүүрэгт хаягдлын чингэлгийг шинээр барих буюу хуучныг нь засч янзалсан. Хөрш зэргэлдээх болон хотын захиргааны түвшний эрх мэдэлтэн, дарга нарт бие засах газрыг зүй зохистойгоор хэрэглэх талаар олон нийтэд мэдээлэхийг уриалсан.

**Эмнэлгийн**

- Төвийг сахисан зуучлагчийн хувьд ОУУЗХ нь Кабулын хойд хэсэг, Парван мужид хэдэн жилийн дараа хэрэгжүүлэх анхны вакцинжуулах хөтөлбөрт хэрэгцээтэй зүйлсийг нийлүүлсэн. Үүгээрээ 50000 хүүхдүүд, 66000 эмэгтэйчүүдийг дархлаажуулах боломжтой бөгөөд НҮБ—ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ) болон нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулсан кампанит ажлын нэг хэсэг болох өргөн тархсан өвчнүүдээс сэргийлсэн явдал болох юм.

- ОУУЗХ нь нийслэл болон Шамалийн тал, Панжширийн хөндийд эмнэлгийн багаж хэрэгсэл авчрахад үзүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлэн дайнд шархагдагсдад тохирох эмчилгээг хийхийн тулд дайны шугамын ойролцоо анхан шатны тусламж үзүүлэх постуудыг байгуулав.

- Улаан Загалмайн хороо Кабулаас хойш 80 километрт орших Гулбахард хиймэл хөл хийх төвийг Афганистаны зүүн хойд мужийн газрын минийн хохирогчид болон дайнд шархагдагсдыг эмчлэх зорилготойгоор байгуулсан. Одоогийн байдлаар Афганистанд ОУУЗХ—ны байгуулсан ийм төрлийн төв 5 байна.

**Хамгаалалт ба саатуулалт**

- Зарим шоронгуудад ОУУЗХ ус, эрүүл ахуйн тоног төхөөрөмжийг засч, шинээр барьж, хоригдлуудыг эм болон бусад зүйлээр ханган эмнэлгийн үйлчилгээ үзүүлснээр эрүүл мэндийн нөхцөл байдлыг сайжруулсан. ОУУЗХ энгийн ард иргэдийн нөхцөл байдлыг үргэлжлүүлэн анхаарч, эрх мэдэлтнүүдэд хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлийн талаар мэдэгдэл хийсээр ирсэн.

- 2—р сарын 13, 14—нд Афганистан дахь ОУУЗХ—ны төлөөлөгчийн газар Талибанчуудын хорьсон 20 хоригдол, Хойд Эвслийн хүчний командлагч Массудын хорьсон 20 хүнийг нэг дор сулласан. Эдгээр хүмүүсийг суллах хэлэлцээр 1 сард эхэлсэн бөгөөд тэр үед тал бүрийн элчүүдийг хоригдлуудтай уулзуулах боломж олгож байжээ. Төвийг сахисан зуучлагчийн энэхүү үүрэг нь мөргөлдөөнд оролцогч бүх талуудыг оролцуулсан хоёр талын идэвхтэй ярилцлагыг хийснээр боломжтой болсон юм.

**Гэр бүлийн хэлхээ холбоог сэргээх**

- Түр саатуулагсдад гэртээ харихад нь санхүүгийн болон ойр зуурын тусламж үзүүлсэн бөгөөд ОУУЗХ саатуулагсдыг алс холоос эргэж ирж буй гэр бүлийнх нь хүмүүст санхүүгээр дэмжлэг үзүүлсэн.

- Афганы Улаан Хавирган Сар Нийгэмлэгтэй хамтарч ажилласны ачаар, хоригдлууд болон тэдний гэр бүлийнхний хооронд Улаан Загалмайн мэдээ цуглуулан тараадаг байв. 1998 онд 24000 мэдээ цуглуулж, 16500—г тараасан байна.

**Мэдээлэл ба боловсрол**

- ОУУЗХ—ны эмчилгээний төвд минийн улмаас шархадсан талаарх мэдээллийг нэгбүрчлэн бүртгэж авдаг "Минийн талаарх Мэдээллийн Төсөл"—ийг Мазар—и—Шариф болон Пул—и—Хумрид эрүүл мэндийн бүтцэд оруулан өргөжүүлсэн. Цаашид минийн устгах үйл ажиллагааг төлөвлөхөд туслах үүднээс бусад байгууллагуудтай мэдээллээ солилцсон.

- Нийгмийн бүхий л давхаргад хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн зарчмуудыг хүндэтгэн сахиулах үүднээс хүмүүнлэгийн эрх зүй болон зарчмуудыг шалган нэвтрүүлэх цэгүүд, цэргийн бааз, сургуулиуд дээр хичээлээр заасан бөгөөд орон нутгийн удирдлагууд, шилжин нүүсэн хүмүүс, оюутнууд, хоёр талын камандлагчид болон байлдагчдыг хамруулсан байна.

- Хэвлэл мэдээллийнхэнтэй холбоотой ажилласан ба хүмүүнлэгийн тулгамдаад байгаа чухал асуудлын тухай ард иргэдэд хэвлэл мэдээллээр мэдэгдэл хийсэн.

— ОУУЗХ—ны хэвлэл мэдээлэлд гарсан нийтлэл болон жилийн тайлангаас хэсэгчлэн авав

## Судалгаа 5 А. Дайны хор хөнөөлөөс бүрэлдэн гарах хэрэгцээ — Эх сурвалж 1

# Зэвсэгт мөргөлдөөний нөлөө – Афганистан 1999 он

1999 онд Афганистанд болсон мөргөлдөөний үед энгийн иргэдийг олон тоогоор шилжин нүүхэд хүргэсэн бөгөөд бүх талуудын үйлдсэн хүмүүнлэгийн эрх зүйн зөрчил ч ихэд гарсан юм. Үүнтэй зэрэгцэн Мазар–и–Шарифын бүс нутагт партизануудын гэнэтийн дайралт болж, ард иргэдийн амийг хөнөөж, тухайн орон нутгийн аюулгүй байдлыг аюулд учруулсан.

Дайтагч талуудын туйлшрал нь нийгэмд үндэстэн ястны хурцадмал байдлыг нэмэгдүүлж, дайн байлдаан болоогүй газар нутагт хүртэл хариу арга хэмжээ болон эрхийн зөрчил гарах аюултай болгож байлаа.

20 гаруй жил үргэлжилсэн дайн нь улс орны нийгмийн болон эдийн засгийн амьдралыг зогсонги байдалд оруулж, дайнд сүйтгэгдэж доройтсон дэд бүтэц, байгууллагуудыг сэргээн засварлах ажлын нөөцийг үгүй болгосон. Кабулд иргэдийг усаар хангах систем дайны өмнөх үеийн чадамжтай харьцуулбал 20 хувь ч хүрэхгүй байлаа. Хөдөөд ус сувгийн системийг эвдэж сүйтгэсний улмаас боломжит тариалангийн талбай ашиглагдааргүй болов. Гэсэн хэдий ч эдийн засгийн ерөнхий уналт хотын иргэдийн амьдралд илүү хүнд цохилт болсон.

ОУУЗХ–ны Жилийн Тайлан 1999 он

**Зүүн талд дүрслэгдсэн нөхцөл байдалтай холбоотой хүмүүнлэгийн ямар тодорхой үйл ажиллагаа явуулах хэрэгтэй вэ?**

| Хүмүүнлэгийн хөтөлбөр | Санал болгосон тодорхой хүмүүнлэгийн үйл ажиллагаа |
|---|---|
| Хоол хүнс ба хөдөө аж ахуй | |
| Эмнэлгийн тусламж | |
| Ус ба эрүүл ахуй | |
| Мал эмнэлэг | |
| Энгийн иргэд ба хоригдлуудыг хамгаалах | |
| Гэр бүлийн холбоог сэргээх | |
| Мэдээлэл ба боловсрол | |

# Гэрээсээ албадлагаар хөөгдсөн нь

Дайн энгийн иргэдийн амьдралыг сүйтгэдэг.
Мөн олон хүмүүс шилжин нүүдэг.

**Дамир, Медин хоёр**

Өгүүлэгч: Дамир, үеэл Мединтэй хамт дүрвэгсэд байсан бол саяхан тэд Босни, Герцеговини дахь гэртээ эргэн иржээ.

> *Үнэхээр хэцүү байлаа. Би гэрээсээ явж байхдаа уйлсан. Бид автобусанд суугаад хамгийн эхний газар очсон. Бид тэнд очиход их өлссөн байлаа. Бид гэртээ бүх юмаа орхисон учраас бидэнд идэх юм байсангүй. Хүмүүс бидэнд дараагийн хотод очихыг зөвлөж байв. Харин бид дараачийн газар ирэхэд бидэнд амьдрах газар байхгүй хэмээн хүмүүс хэлсэн.*

Хуучин Югославын дайны үеэр олон сая хүмүүс гэрээсээ зугтан харсан зүгтээ дүрвэцгээж байлаа. Бусадтай нэгэн адилаар Дамир, Медин хоёр гэрээ хэзээ ч дахин харахгүй хэмээн бодож байв.

*Бид гэртээ дахин ирэх боломж гарахгүй гэж бодож байсан. Учир нь тэд хоёр цагийн дотор юмаа бэлд, автобус ирээд биднийг аваад явна гэж хэлсэн.*

*Би явахдаа радио, фото зургануудаа, мөн орой унтахдаа нөмөрнө гээд хэдэн хөнжил авсан.*

*Миний хувьд хамгийн ичгүүртэй зүйл нь хүүхдүүд бид нарыг "дүрвэгч" гэж шоолж, сургуульдаа очиход "Хараач, Дүрвэгч ирж байна" гэж хэлж байсан явдал байлаа.*

**Саба**

Намайг Саба гэдэг. Би 30 настай. Би тосгоноосоо 50 километр газар алхсан. Би хүүхдүүдтэйгээ хамт энд ирсэн. Бид тосгондоо газар тариалан эрхэлдэг байсан бөгөөд манай тосгонд бороо хур орохгүй ган гачиг болж, үр тариа ч ургахгүй болсон.

Би нөхрөө алдаад одоо хүүхдүүдтэйгээ л үлдсэн. Би түүнийг санаж байна. Нөхөр маань хаана байгааг би мэдэхгүй. Хүмүүс түүнийг хужний наймаа хийхээр хол явчихсан гээд байгаа.

Гэвч би үүнд итгэхгүй байна. Түүнийг цэргүүд авч явсан. Тэр өдрөөс хойш нөхрийн маань сураг тасарсан. Үхсэн ч байж магадгүй. Би мэдэхгүй байна.

Бид энд хүлээгээд л байж байна, гэвч чухам юу хүлээгээд байгаагаа ч мэдэхгүй юм. Тосгонд минь үргэлжилдэг шиг, өдөр шөнө ээлжлэн амьдрал үргэлжилсээр, өдөр болгон өөр байдаг ч шөнө бүр уйлж дэрээ норгох миний амьдрал бас л үргэлжилж байна.

# Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх

Дүрвэгсдэд хоргодох байр бэлтгэж өгөх ажил нь сурагчдад амьдралын энгийн тулгуур дэмжлэг болох зүйлсийг нь сэргээхэд шаардлагатай хүчин чармалтын хэм хэмжээг танилцуулж, хүмүүнлэгийн нэгэн чухал үйл ажиллагааг дүрслэн харуулахад чиглэгдсэн. Сурагчид хүмүүнлэгийн ажилтны дүрд хувиран хүмүүст чухал хэрэгцээтэй байгаа зүйлийг олж тогтоох, түүнийг хэрхэн хангах зорилт, ажлыг төлөвлөнө. Тэд наад зах нь нэг эх сурвалжид тулгуурлан шаардлагатай зүйлсийн тоо хэмжээ, тээвэрлэлт болон энэхүү зорилтдоо хүрэхэд хэрэгтэй бусад зүйлсийг тодорхойлно.

> Мөргөлдөөн болон дарангуйллын улмаас нийт ард иргэдийн гуравны нэг нь дүрвэн зугтдаг. НҮБ—ын Дүрвэгсдийг Хариуцсан Дээд Комисс үлдсэн гуравны хоёр нь өөрсдийн улс орондоо нүүлгэн шилжүүлэгдсэн хэмээх тооцоо гаргасан байна. Дотооддоо шилжин нүүсэн хүмүүс дүрвэгсэдтэй адил хэцүү замыг туулдаг боловч тусламжын байгууллагуудын үзүүлэх тусламжаас гадуур байдаг юм.
>
> Үндэстнүүдийн Дэвшил (ЮНИСЕФ), 1997 он

> Бид бяцхан үрээ нуруундаа үүрэн, хүүхдүүдээ хөтлөн, хөгшин хүмүүсээ дагуулаад тарианы талбай дээгүүр, бут сөөгний дундуур, намагтай газраар айдас хүйдэстэй зугтааж явсан. Цэргүүд хөрш тосгонд аль хэдийнэ ирээд эмэгтэйчүүдийг хулгайлан авч явсан байлаа.
>
> 60 настай эмэгтэй, Нигери

**Зорилго:**

- Аюулгүйн байдлаас болон бусад шалтгаанаар нүүлгэн шилжүүлснээс үүдэн гарсан хэрэгцээг хангахад хир хэмжээний хүчин чармайлт шааррдлагатай байдгийг мэдэж авах
- Зэвсэгт мөргөлдөөнөөс улмаас гэрээсээ шилжин нүүсэн хүмүүсийг хамгаалах болон тэдэнд туслах зарим үзэл санааг мэдэж авах

**Ашиглах материалууд:**

- Зургийн эвлүүлэг 5В — номын хавсанд бий
- Хоргодох байрыг төлөвлөх нь — тайлан
- Төлөвлөгчдөд зориулсан зааварчилгаа ба мэдээлэл
- Дасгалын хуудас: Төлөвлөлтийн тайлан

**Бэлтгэл ажил:**

"Төлөвлөгчдөд зориулсан зааварчилгаа ба мэдээлэл" болон дасгалын хуудсыг жижиг бүлгүүдэд хэрхэн өгөхөө төлөвлөнө.

**Хугацаа:**
45—60 минутын нэг хичээл

**1. Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ** (10—15 минут)

Гэр орноосоо дайжин дүрвэгсдийн хоргодох байр хайж буй хүмүүсийн хэрэгцээтэй зүйлсийн талаар брейнсторминг хийнэ үү.

Дараахь гарчгууд хариуг цэгцтэй болгоход тус болно. Үүнд:

- Ус (хамгамж ба бохир усны хоолой орно)
- Хоол хүнс
- Орон байр
- Эмнэлгийн тусламж
- Цахилгаан энерги (хоол хийх, халаах, гэрэлтүүлэх орно)
- Эрүүл ахуй ба ариун цэврийн хэрэгслүүд
- Аюулгүй байдал
- Сэтгэл санааны дэмжлэг
- Харилцаа холбоо (мэдээлэл ба боловсрол орно)

*[Хариулт өгөхдөө биологийн, нийгмийн, сэтгэл санааны хэрэгцээг хамруулж болно]*

# Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх

**Боломжит асуултууд:**

- Эдгээр зурагт байгаа хүмүүст юу хэрэгцээтэй байна гэж бодож байна вэ?
- Хоргодох байранд байгаа хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд хүмүүнлэгийн ажилчид юуг бодож санаачлах ёстой вэ?




"Хоргодох байрыг төлөвлөх нь — тайланг" танилцуулаад сурагчдаар төлөвлөгчид тэдгээр хэрэгцээний заримыг нь хангахын тулд юу хийснийг тодорхойлуулна уу.




**2. Хоргодох байрны эх сурвалжыг тооцоолох нь**
(Цомхон бүлгээр) (30—35 минут)

*Төлөвлөгчдөд зориулсан зааварчилгаа ба мэдээллийг* танилцуулна. Хайрцганд бичээстэй хүн амын тооны талаар ярилцана.




Энэхүү хоргодох байранд амьдардаг шилжин нүүсэн хүн амын хэрэгцээтэй зүйлийн талаар нэг категори сонгон авч төлөвлөгөөгөө боловсруулна. Бүлэг тус бүр хэрэгцээтэй байгаа зүйлсийн тоо хэмжээг гаргаж, үүнийгээ хэрхэн олж тараах талаар ярилцана. (10 минут)




Бүлэг бүр өөрсдийн хийсэн ажлын талаар ангийнхандаа танилцуулна. (15 минут) Танилцуулга бүр нь доорх зүйлсийг заавал агуулсан байна. Үүнд:

- Хэрэгцээтэй зүйлсийн төрөл (хоол хүнс, ус, орон байр г.м.)
- Хангамжийн тоо хэмжээ, хэрэгцээтэй үйлчилгээ
- Хангамж, үйлчилгээг олж авах төлөвлөгөө
- Хагнамж, үйлчилгээг хүртээх төвөвлөгөө
- Хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийг хэрэгцээт зүйлсээр нь хангах тусгай төлөвлөгөө (Ганцаараа хоцорсон хүүхдүүд, эмэгтэйчүүд, охид, жирэмсэн болон нярай эхчүүд, хөгшид, г.м.)

Олон тооны дүрвэгсдийг багтаах чадалтай дэлхийн янз бүрийн хоргодох байрыг бодолцсоны үндсэн дээр, 10000 хүнд байр төлөвлөх үйл ажиллагаагаар юу сурснаа хэлэлцэнэ.

**Боломжит асуултууд:**

- Хэрвээ хоргодох байр нь 300000 хүнийг багтаах шаардлагатай байсан бол хийсэн төлөвлөгөөгөө яаж өөрчлөх хэрэгтэй болох вэ?

**3. Хүний нэр хүнд, хувийн шинж тэмдгийг баталгаажуулах нь**

Шилжин нүүсэн хүмүүсийг хэвийн байдалдаа ороход нь туслах, үүрэг хариуцлагаа ухамсарладаг болгох, хүний нэр хүндийг нь хамгаалахад хүмүүнлэгийн ажилчдын бодолцох ёстой, биологийн хэрэгцээнээс бусад хэрэгцээний талаар ярилцана.

> Дүрвэгсэд болон шилжин нүүсэн хүүхдүүдийн хувьд, хийх юмгүй гиюүрэх, боловсрол эзэмших боломжгүй байна (...) гэдэг нь аймшигтай зүйл. Энэ нь тэднийг үр бүтээлгүй өдрүүдийг өнгөрөөхөд хүргэдэг бөгөөд тэгснээр сэтгэл зовниулсан дурсамж бодогдон, айдас улам хүчээ аван тэр байтугай хүчирхийлэл ч боломжтой болдог (...) Охидуудыг хүчиндэхээр, хөвгүүдийг бүлэг дээрэмчид эгнээндээ элсүүлэхээр заналхийлнэ. Өсвөр насныхан залуугаараа жирэмсэлнэ. Хүүхдүүдийн амьдрал ерөнхийдөө утга учиргүй болон нурж эхлэнэ...
>
> — Марк Соммерс, Хүүхдүүдэд Зориулсан Онцгой Боловсрол, 1999 оны 8—р сар

## Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх

Хил дээр их халуун байлаа. Хөл дороос чулуу шатаж байх шиг санагдаж байв. Гэтэл дөнгөж сая өнгөрсөн хүүхдүүд хөл нүцгэн байсан. Тэд Афганы уулаар 3 хоног алхаж байгаа аж. Тэд нар хүүхдүүд шүү дээ. Тэд надад дэгдээхэй шиг санагдсан. Тэд гайхсан янзтай харж байлаа.

Байлдагч

Дайны үед гэр бүлээсээ хагацсан эмэгтэйчүүд, охидууд хүчирхийлэлд өртөмтгий байдаг. Дайны үед гэр орноосоо дайжсан 53 сая хүмүүсийн 80 хувь нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байсан. Аав, нөхөр, ах дүү нар нь байлдааны талбарт байлдахаар эмэгтэйчүүдийг орхин явахад хөгшин залуу гэлтгүй эмэгтэйчүүд өөрсдийгөө бие даан үлдсэн юм. Дүрвэгсдийн гэр бүл хүчирхийлэлд автах, хүчирхийллийн аюулыг дүрвэх үед шийдвэр гаргахад гол хүчин зүйл гэжээ.

Дэлхийн
Хүүхдүүдийн Байдал, 1996 он

Дэлхийн 2—р дайнаас хойш 50 сая дүрвэгсэд өөрийн улс орондоо буцсан, эсвэл өөр улс оронд гэр оронтой болсон юм.

НҮБ—ын Дүрвэгсдийн Асуудлыг
Хариуцсан Дээд Комисс

Би тосгондоо эргэн очвол цөөнх болно. Хэн ч буцаж очихыг хүсдэггүй, би ганцаараа буцаж очмооргүй байна. Ямар ч байсан танай гэрт дүрвэгчид амьдарч л байгаа.

Шилжин нүүсэн эмэгтэй,
Босни—Герцеговини

**Боломжит асуултууд:**

- Нийгмийн, сэтгэл зүйн болон оюун санааны ямар хэрэгцээг дурдаж болох вэ? (боловсрол, мэдээлэл, чөлөөт цаг өнгөрөөх, шашны дадал зуршил г.м.)
- Хэрвээ та өөрөө шилжин нүүх нөхцөл байдалд байсан бол бусад дүрвэж буй хүмүүсийн адил ямар сэтгэгдэлтэй байх вэ?
- Шилжин нүүж буй хүмүүсийн 80 хувь нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг. Яагаад?
- Шилжин нүүсэн хүмүүсийн хоргодох байранд эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшдөд ямар эрсдэл тулгарч болзошгүй вэ? Түүнээс хэрхэн зайлсхийх вэ?

**Хаалт − хоргодох байрыг орхин явсны дараах хэрэгцээ** (10 минут)

Хоргодох байрыг орхин явсны дараа хүмүүст чухам юу хамгийн их хэрэгцээтэй байдаг талаар сурагчдаар хэдэн минут дэвтэрт нь бичүүлнэ. Сурагчдыг дөрвөн бүлэгт хуваан бүлэг тус бүр доор дурдсан хоргодох байранд байрлаж болох хүмүүсийн тухай ярилцана. Үүнд:

- 6—аас доош настай хүүхдүүд
- залуучууд
- насанд хүрэгчид
- хөгшид

Дараа нь тэдний дурдсан хэрэгцээ болон шалтгааны талаар ярилцана.

**Боломжит асуултууд:**

- Хүүхдүүд болон насанд хүрэгчдийн хэрэгцээнд ямар ялгаа байна вэ?
- Ямар хүнд тусгай үйлчилгээ хэрэгтэй вэ? Яагаад? [Жишээ нь: биеийн болон сэтгэл санааны хүнд шарх авсан хүнд удаан хугацааны зөвлөгөө, эмчилгээ шаардлагатай байдаг; гэр бүлийнхээ гишүүдээс салсан хүмүүст тэднийгээ хайж олоход нь туслах г.м.]
- Энгийн хүмүүс дүрвэгсдэд хэрхэн тусалж болох вэ? [Жишээ нь: Дүрвэгсдийг буцаж ирэхэд нь халуун дотноор угтах, хүмүүнлэгийн байгууллагад мөнгөн тусламж үзүүлэх, улс төрийн төлөөлөгчдөд ард түмэн дүрвэгсдэд туслах хүсэлтэй байгаа талаар хэлж ойлгуулах, г.м.]

**ГОЛ САНААНУУД:**

- Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахад асар их төлөвлөлт, хүчин чармайлт шаардагддаг.
- Ус, хүнс, орон байр, эмнэлгийн тусламж зэрэг зайлшгүй биологийн хэрэгцээнээс гадна нийгэм, сэтгэл зүйн хэрэгцээг хангах шаардлага гардаг. Эдгээр нь хүнийг аль болох бие даасан байдлаа даруй сэргээхэд нь туслах зорилготой.

## Нэмэлт дасгал

**Оршин суух газрынхаа ойролцоох хүмүүст туслах**
Дүрвэгсдийн хоргодох байр олсон бол тэдэнд юу хэрэгцээтэй байгаа талаар олж мэднэ. Эдгээр хэрэгцээний талаар ангидаа буюу бүлэгтээ ярьж туслах ажиллагааг зохион байгуулна. Жишээ нь: хоол хүнс, хувцас хунар, хэлний сургалт, уншлага.

**Холбоотой ажиллах байгууллагууд**
Сүүлийн жилүүдэд онцгой байдал болон хөгжлийн үйл ажиллагааны хоорондын хамаарлыг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдэн энэ нь хүмүүнлэгийн тусламжанд хүрэх арга замыг өргөн хүрээтэй болгож байгаа билээ. Хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагаа, хаана ажлаа явуулдаг, юу хийдэг болон бусад байгуууллагуудтай хэрхэн хамтарч ажилладаг талаар судална уу. Үүнд:

- Мэдээлэл олж авахын тулд хүмүүнлэгийн байгууллагууд руу бичих
- Интернет ашиглах
- Номын сангийн эх сурвалжуудыг ашиглах
- Хэвлэл мэдээллээр цацсан мэдээлэл, сонин сэтгүүл дээр гарсан нийтлэл өгүүллэгийг шалгах
- Иймэрхүү үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтанг урьж авчран ангидаа уулзалт зохиох

Эдгээр хүчин чармайлтыг төлөвлөхөд Олон Улсын Улаан Загалмай Улаан Хавирган Сар Холбооноос 1995 онд гаргасан "Хэрэгцээнээс Үйл Ажиллагаа руу" гэсэн товхимол хэрэг болно.

Үйл ажиллагаагаа явуулахын тулд Олон Улсын Улаан Загалмайн Хороо дэлхий даяар 3000 ачааны машин болон тээврийн хэрэгсэл, 950 агуулахыг тусламжанд өгсөн. Мөн 15 онгоц, 2–5 усан онгоц үйл ажиллагаа явуулахад бэлэн байгаа юм.

Америк Найзууд Үйлчилгээний Хороо
http://www.afsc.org/
Америкын Дүрвэгсдийн Хороо
http://www.archq.org/index.shtml
Хил давсан Төсөл
http://www.acrossborders.org/
Амнести Интернейшнл – Дүрвэгсэд
http://www.refuge.amnesty.org/
Халамж
http://www.care.org/
Данийн Дүрвэгсдийн Консул
http://www.drc.dk/indexeng.htm
Хил хязгааргүй Эмч нар
http://www.doctorswithoutborders.org/
Дүрвэгсэд ба Цөллөгсдийн Асуудлыг хариуцсан Европын Консул
http://www.ecre.org/
Нүүдэл Дэлхийн Үйлчилгээ
http://www.e–w–s.org/
Хүний Эрхийн Манаанд
http://www.hrw.org/
Олон Улсын Улаан Загалмайн Хороо
http://www.icrc.org/
Олон Улсын Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо
http://www.ifrc.org/
Олон Улсын Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгийн Хөдөлгөөн
http://www.redcross.int/
Олон Улсын Авран хамгаалах Хороо
http://www.intrescom.org/
IOM буюу Цагаачдын төлөө Олон Улсын Байгууллага
http://www.iom.int/
Жесүитийн Дүрвэгсдэд Үйлчлэх Байгууллага
http://www.jesref.org/
Хүний Эрхийг хамгаалах Хуульчдын Хороо
http://www.lchr.org/home.htm
Цагаачлал, Дүрвэгсдэд зориулсан Үйлчилгээ
http://www.nccbuscc.org/mrs/
Хөгжлийн Төлөө Түншүүд
http://www.interaction.org/members/pfd2.html
Дүрвэгсдийн Олон Улсын Байгууллага
http://www.refintl.org/
Хүүхдийг Хамгаалах Байгууллага
http://www.savethechildren.com/
Зүүн Өмнөд Азийн Эх Сурвалж Үйл Ажиллагааны Төв
http://www.searac.org/
Тусламж үзүүлэх Нэгдсэн Арга зүйчдийн Хороо
http://www.gbgm–umc.org/units/umcor/
НҮБ–ын Хүүхдийн Сан
http://www.uniceg.org/
НҮБ–ын Дүрвэгсдийн Асуудал Хариуцсан Дээд Комисс
http://www.unhcr.ch/
АНУ–ын Дүрвэгсдийн Хороо
http://www.refugees.org/
Дэлхийн Зовнил
http://www.worldconcern.org/
Дэлхийн Хүнсний Хөтөлбөр (НҮБ)
http://www.wfp.org/index.htm
Дэлхийн Тусламж
http://www.worldrelief.org/
Дэлхийн Зөн
http://www.worldvision.org/worldvision/master.nsf/

**Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх** **Эх сурвалж 2**

# Хоргодох байр төлөвлөх – Тайлан

1990 оны 8–р сарын эхээр Персийн булангийн хямрал эхлэхэд Египет, Энэтхэг, Пакистан, Бангладеш, Шри Ланк, Филлипин, Тайландын олон мянган гадаад ажилчид Кувейт, Иракаас дүрвэн гарсан. Иорданы хилээр машинтай, автобустай, ачааны машинтай олон мянган хүмүүс замын бөглөрөл үүсгээд байв. Гэр бүлүүд маргааш нь юу болохыг мэдэхгүй хүлээн сууна. Олон мянган хүмүүс Ирак, Иорданы хил дээр цөлд ямар ч хоол хүнс, усгүй гацаанд орсноо мэдэв.

### Шууд хариу өгөх

Эрх мэдэлтнүүд Ирак, Иорданы хилийн зааг дээр түр орогнох байр барих хэрэгтэй болов. Йорданы Улаан Хавирган сар, ОУУЗХ хүмүүст ундны ус, орон байр, эмнэлгийн тусламж үзүүлэхээр яаралтай тусламжийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү үйл ажиллагаанд зарим төрийн бус байгууллагууд оролцож, тухайн хүнд нөхцлөөс үүдсэн хэрэгцээг хангахад хүчин зүтгэв.

Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх пост байгуулагдав. Хүнд өвчилсөн хүмүүсийг Рувайшидийн эмнэлэг рүү илгээж байв. Удахгүй тэр газар хүмүүсээр дүүрэв. Өдөр 50 хэмээс дээш халуун, нар шатаж, ус их ховор болов.

Энэ хүнд хэцүү байдалд ус хамгийн чухал зүйлийн нэг байлаа. Хүмүүс гэр бүлийнхэндээ ундны ус олж өгөхийн тулд хэдэн цагаар дараалан зогсох боловч уух ус нь хүрэлцэхгүй болж тэмцэл гардаг байв. Хоол хүнс ч мөн дууслаа.

Шилжин нүүсэн хүмүүсийн зөвхөн 30 хувь нь тохиромжтой орогнох байранд амьдарч, зарим хүмүүс нь нар салхинаас өөрсдийгөө хамгаалах төдий л сууж байв. Ихэнхи хүмүүс орох орон ч үгүй байсан бөгөөд хүчтэй салхи, шороо шуурга нөхцөл байдлыг улам хүндрүүлж байлаа.

Энэ бүс нутагт хоргодох байр барихад тохиромжгүй газар байлаа. Цооногоос орогнох байр хүртэл 35 километр газар усны цистернээр 40 удаа ус зөөхөөр байсан бөгөөд тэгэх бүрдээ ус цистернд, цистернээс усны хоолойд, усны хоолойноос гоожуур руу урсгаж хүмүүс хэрэгцээтэй ус авахаар дараалан зогсч байв. Халуун наранд дараалан зогсч буй хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд усны хоолой олныг суурилуулах хэрэгтэй.

### Асуудлыг шийдвэрлэх өөр арга хэрэгтэй

Инженерүүд илүү тохиромжтой газар хайж олох хэрэгтэйг ойлгов. Иорданы эрх мэдэлтнүүд Азракийн ойролцоо 30000 хүний хоргодох байр барихыг зөвшөөрөв.

Шинэ хоргодох байр барихад хэрэгцээтэй зүйлсийн ихэнхийг Амман руу агаараар зөөв. Амманы онгоцны буудал дээр хэрэгцээтэй зүйлсийг ялган ачааны машинд ачин явуулдаг байв. Майхан барих бэлтгэл хийн тусгай багийг сургаж эхэлсэн.

Хоргодох байрыг төлөвлөгч ажлаа ийнхүү тайлбарлав:

*Бидний энэ хоргодох байрыг барихад хамгийн хүндрэлтэй асуудал нь их богино хугацаанд хийж гүйцэтгэх явдал байлаа.*

*Эхний шатанд бид газраа сонгох хэрэгтэй болсон. Бид жорлонгийн үнэрийг салхи байрнаас өөр зүг рүү туухаар налуу газар сонгож авах хэрэгтэй байсан.*

Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх Эх сурвалж 2

# Хоргодох байр төлөвлөх нь – Тайлан

*Дараа нь бид ус хангамжийн системийг суурилуулах ёстой байв. Бид гол замаас 2 километр хоолой татав. Иордан улсын гол шугамаас бидний суурилуулсан цистернд ус гоожин орох болно. Цистернээс ус (390000 литр ус агуулах багтаамжтай) доошоо урсан ус түгээх 30 цэгт хүрнэ. Байшингуудыг бага зэрэг налуу газар барих шаардлагатай байсан нь хаягдал ус доошоо бидний ухах нүх рүү урсах ёстой байсан учраас юм.*

*Лагерьт 30000 хүн суурьших учраас хэд хэдэн хэсэгт хуваах шаардлагатай болов. Нэг квадрат газар 500 хүн амьдарч болох хэд хэдэн талбайгаас бүтсэн хэсэг газар олгов. Бид талбай хооронд машин тэрэг явж, хог зөөх, хоол хүнс тараах зорилгоор зам гаргаж өгөв. Тэдэнд зориулж жорлон суулгаж өгсөн ба түүнд гэрэл суурилуулсан учраас хүмүүс шөнийн цагт жорлонг ашиглаж болохоор болов.*

**ХОРГОДОХ БАЙР БАЙГУУЛАХАД:**

- Газраа сонгох, схем хийх
- Орох гарц ба агуулах
- Барилгын материал ба багаж хэрэгсэл
- Гол үйлчилгээг зохион байгуулах

**ГОЛ ҮЙЛЧИЛГЭЭ ГЭДЭГ НЬ:**

- Усаар хангах, муу усны хоолой
- Орон байр
- Хоол хүнсээр хангах
- Хог хаягдал, ялгадсыг янзлах
- Эмнэлгийн тоног төхөөрөмж
- Гэрэл цахилгаан
- Дотоод аюулгүй байдал
- Холбоо харилцаа

1– р зүйл
Дүрвэгсэд гэдэг нь хууль ёсны тодорхойлолтоор арьс өнгө, шашин шүтлэг, яс үндэс, улс төрийн үзэл бодол буюу тодорхой бүлгийн гишүүнчлэлийн шалтгаан дээр үндэслэн мөрдөлт мөшгилтийн улмаас өөрийн улс орноо орхин гарсан бөгөөд гэртээ буцаж очихыг хүсэхгүй, улмаар буцаж чадахгүй байгаа хүмүүсийг хэлнэ.

Дүрвэгсдийн статустай холбогдох Конвенцоос авав, 1951 он

# Төлөвлөгчдөд зориулсан мэдээлэл ба зааварчилгаа

- Энэхүү хоргодох байранд ирэх дүрвэгсдийн тоо: 10000

(3000 эмэгтэй, 1000 эрэгтэй, 5000 хүүхэд залуучууд болон 5—аас доош насны 1000 хүүхэд)

Ганцаараа хоцорсон хүүхдүүд: 5000
Жирэмсэн ба нярай эхчүүд: 800
Өвчтэй ба шархадсан: 1000
Бэлэвсэрсэн ба нөхөр нь алга болсон эмэгтэйчүүд: 2000
Хөгжлийн бэрхшээлтэй: 500
Хөгшид: 2000

- Хоргодох газрын байршил: ойролцоох хотоос 200 километрийн зайтай өндөрлөг газар, нээлттэй талбай
- Жилийн аль улирал: намар
- Дүрвэгсдийг байраар хангаж болох хугацаа: 6 сар
- Дүрвэгсдийн соёлын болон шашны дадал зуршил: эрэгтэй, эмэгтэй, хүүхэд зэрэг гэр бүлийн гишүүдтэй хэрхэн өөрөөр харьцаж байгаа эсэх, идэж буй хоолны төрөл (зарим хориотой хоол хүнс), шашны нэгдлээс улбаатай ёс заншил

**Ус**

Насанд хүрсэн хүн өдөрт дунджаар 20 литр ус хэрэглэдэг. (өдөрт 3 литр ус = амьд үлдэхэд л шаардлагатай уух ус)

- Хэдий хэмжээний ус хэрэгтэй вэ?
- Ундны усыг цэвэршүүлэх хэрэгтэй юу?
- Дүрвэгсэд яаж ус олж авах вэ?
- Усыг хэрхэн түгээх вэ?

**Эмнэлгийн хангамж, эмчилгээ**

Өдөрт 100 өвчтөнд зөвлөгөө өгнө гэж тооцоолно.

- Хоргодох байранд өвчтэй, шархадсан, хөгшин, жирэмсэн эхчүүд хэд байна вэ?
- Эмнэлгийн ямар хангамж хэрэгтэй байна вэ?
- Хэрэгцээтэй эмнэлгийн хангамжийн тоо ширхэгийг тооцоолно уу.
- Эмнэлгийн ямар хүн хэрэгтэй байна вэ?
- Ямар үйл ажиллагаа, процедур явуулах шаардлагатай байна вэ?
- Хүмүүст эмнэлгийн ямар аюул тулгарч болох/байна вэ?

**Хоол хүнс**

Насанд хүрсэн хүн өдөрт 2250 калори авч байх ёстой.

1 өдрийн байх ёстой хэмжээ = ойролцоогоор 0.6 кг. Үүнд:

500 грамм улаан буудай
30 грамм хүнсний тос
30 грамм хуурай сүү
20 грамм сахар
3 грамм цай

- Хичнээн хэмжээний хүнс хэрэгтэй вэ?
- Тараах гэж байгаа хоол хүнсний жагсаалтыг гаргана уу.
- Тусгай хоол хэрэгтэй тэжээлийн дутагдалд орсон хүүхдүүд байна уу?
- Хэрэгцээтэй байгаа хоол хүнсээ хэрхэн олж авах вэ?
- Хоол хүнсийг хэрхэн тараах вэ? ("Гэрээсээ албадлагаар хөөгдсөн нь" дүрс бичлэг болон зарим фото зурган дээр хоол хүнс хэрхэн тарааж байгааг хараарай. Ажлаа хэрэгжүүлэх төлөвлөгөө зохионо.)
- Хоол хийх шаардлагатай юу? Хэрэв шаардлагатай бол яаж хийх вэ? Юу шаардлагатай вэ?

## Судалгаа 5 В. Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хоргодох байр төлөвлөх — Эх сурвалж 3

# Төлөвлөгчдөд зориулсан мэдээлэл ба зааварчилгаа

### Эрүүл ахуй

Ариун цэвэр бохир бол эрүүл ахуйн асуудал гарч болно. Янз бүрийн өвчин гарахаас сэргийлж эрүүл ахуйн хэрэгцээг төлөвлөх хэрэгтэй.

- ➤ Нийтийн бие засах газар хэдийг барих шаардлагатай вэ?
- ➤ Хаана барих вэ?
- ➤ Барихад ямар багаж, материал хэрэгтэй вэ? (мод, мөчир, цайр гэх мэт)
- ➤ Хэрхэн цэвэрлэх болон цаашид цэвэрхэн байлгах тал дээрх төлөвлөгөө юу вэ?
- ➤ Хичнээн хэмжээний өтгөн ялгадас гарах вэ?
- ➤ Өтгөн ялгадсыг хэрхэн хаях вэ?

### Хувцас хунар

- ➤ Ямар хувцас хэрэгтэй вэ?
- ➤ Нялх өлгийтэй хүүхэд байгаа тохиолдолд хичнээн живх хэрэгтэй болон түүнийг юугаар орлуулж болох вэ?
- ➤ Ор хэрэгтэй юу? Юу ашиглаж болох вэ?
- ➤ Хүмүүс хувцсаа хэрхэн угаах вэ?

### Орон байр

Нэг хүнд ногдох газар 30 хавтгай дөрвөлжин метр. Хэрвээ ийм хэмжээний газраар хангаж чадахгүй бол 10 хавтгай дөрвөлжин метр болтол багасгаж болно. Уул хадтай эсвэл хот газар мэтийн байрлал муутай газарт нэг хүнд ногдох газрыг 3 хавтгай дөрвөлжин метр хүртэл бууруулж болно.

- ➤ Та нарт хэрэгтэй байгаа нийт газрын хэмжээгээ тооцоолно.
- ➤ Хэрвээ майхан нь 150 хавтгай дөрвөлжин метр бол, хэдэн майхан хэрэгтэй болох вэ?
- ➤ Орогнох байр барихад цаг агаар хэрхэн нөлөөлөх вэ?

### Шатахуун

- ➤ Шатахуун хэрэглэх ямар хэрэгцээ байна вэ? (Хоол хийх, халаах, гэрэлтүүлэх, генератор асаах, г.м.)
- ➤ Ямар шатахуун хэрэглэх вэ? Яаж шатахуунаар хангах вэ?
- ➤ Зайлсхийх шаардлагатай ямар аюул гарч болох вэ? Анхааруулгын талаар та нар юу төлөвлөж байна вэ?

---

Зэвсэгт мөргөлдөөний улмаас дүрвэсэн хүмүүсийн тоо 1974 онд 2.4 сая байсан бол өнөөдөр 27.4 сая болон өсч, түүнээс гадна 30 сая хүн дотооддоо шилжин нүүсэн гэсэн тоо баримт байна.

— НҮБ – ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ) – ийн тайлан, 1999 он

---

НҮБ – ын Дүрвэгсдийн Асуудлыг Хариуцсан Дээд Комисс буюу НҮБ – ын дүрвэгсдийн байгууллага нь дэлхий нийтийн дүрвэгсдийг хамгаалах болон тэдний асуудлыг шийдвэрлэх олон улсын үйл ажиллагааг зохицуулах буюу удирдан зохион байгуулахаар итгэмжлэгдсэн байдаг. Энэхүү байгууллага хүн бүр орогнох байр хайх, өөр улс оронд аюулгүй дүрвэн гарах, мөн гэртээ сайн дураараа буцаж ирэх эрхийг нь бататгахыг зорьдог. Дүрвэгсдийн асуудлыг хариуцах байгууллага нь дүрвэгсдийн арьс өнгө, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон хүйсээр үл ялгаварлан хэрэгцээтэй үед нь шударгаар тусламж, хамгаалал үзүүлдэг.

НҮБ – ын Дүрвэгсдийн Асуудлыг Хариуцсан Дээд Комиссын элчийн мэдэгдэл

# Төлөвлөлтийн тайлан

Хэрэгцээтэй зүйлсийн төрөл: ____________________ ____________________

| Хэрэгцээтэй хангамж, үйлчилгээ: | Тоо хэмжээ | Хэрхэн олж авах төлөвлөгөө ____________<br><br>Хүргэх/түгээх төлөвлөгөө: |
|---|---|---|
| Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хэрхэн хангах талаар тусгайлан бодолцох нь:<br><br>Бусад бодолцох зүйлс: | | Хэрхэн олж авах төлөвлөгөө ____________<br><br>Хүргэх/түгээх төлөвлөгөө: |

# Судалгаа 5 С. Хоригдлуудыг хамгаалах

Зэвсэгт мөргөлдөөний нэг үр дагавар бол хоригдлуудын асуудал билээ. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй (ОУХЭЗ) нь хоригдлуудыг хамгаалахыг онцгойлон заадаг. Олон Улсын Улаан Загалмайн Хорооны (ОУУЗХ) үүрэгт ажлын нэг бол шоронгуудаар явж олон улсын эрх зүйн эдгээр заалтыг хэрхэн дагаж мөрдөж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх явдал юм. Энэхүү хичээлийн дүрс бичлэгийг үзсэнээр сурагчид зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэн гарсан хүмүүнлэгийн хэрэгцээний бас нэгэн дүр зураг болон түүнд хэрхэн хүмүүнлэгийн үйлдлээр хариу өгдөг болохыг ойлгоно. Мөн энэхүү ажлыг хийх явцад хүмүүнлэгийн ажилчдад тулгарах дилеммаг сурагчид судлах болно.

Энэхүү материалд “хоригдол” гэсэн ойлголтыг зэвсэгт мөргөлдөөний үр дүнд саатуулагдсан энгийн иргэн буюу байлдагч хэмээн ойлгоно.

**Зорилго:**

- Хоригдлуудын амь нас, нэр хүндийг олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хэрхэн хамгаалдаг зарим арга замыг мэдэж авах
- Хоригдлуудыг хамгаалахад хүмүүнлэгийн ажилчдад тулгарах зарим дилеммаг ойлгох

**Ашиглах материалууд:**

- Хоригдлуудыг хамгаалах
- Дүрс бичлэг ба тайлбар: Харанхуй дахь гэрэл гэгээ
- Дилемма: Би эдгээр хоигдлуудыг хэрхэн хамгаалах вэ?
- Дүрс бичлэг ба тайлбар: Нэгэн хоригдлын дурсамж
- Бүртгэлийн карт
- Улаан Загалмайн мэдээний маягт
- Хоригдлуудын нүдээр

**Багш нарт**

- Хоригдлуудыг хамгаалах нь: Хуулинд юу гэж заасан байна вэ?
- Хоригдлуудыг эргэж очих

**Хугацаа**

45—60 минутын 2 хичээл

**1. Яагаад хоригдлуудад хамгаалалт хэрэгтэй байдаг вэ?** (15 минут)

Асуултын хариунд ямар учир шалтгаан санал болгож байгаа талаар сурагчидтай ярилцана:

➤ Зэвсэгт мөргөлдөөнд оролцсоны улмаас шоронд хоригдож буй хэн нэгэн яагаад ялангуяа эрсдэлд орж болзошгүй байдаг вэ?

*[Эдгээр шалтгаануудад чухал мэдээлэл мэдэж байгаа хэмээн сэжиглэгдсэн, дайсанд тооцогдсон, дайсантай хүн ёсоор харьцах ёсгүй гэж үздэг хандлага, хоригдлуудыг хариуцаж буй хүмүүсийг эмх замбараагүйгээр, хангалтгүйгээр хянах, хоригдлуудыг зүй ёсоор байрлуулах хэрэгсэл байхгүй гэх мэт орно.]*

Дараа нь сурагчдыг жижиг бүлэгт хуваан доорх асуултын хариултыг жагсаан бичүүлээрэй:

➤ Эдгээр хоригдлууд хоригдож байх үедээ ямар аюул болон бэрхшээлтэй тулгарч болох вэ?

Бүлгийн ярилцлагаар гаргаж ирсэн санаануудаа жагсаан бичнэ.

*[Жишээ нь: алга болох аюул, хялбаршуулсан журмаар ногдуулсан шийтгэх тогтоолыг гүйцэтгэх, байцаалтын үеэр эрүүдэн шүүлгэх аюул буюу гэм буруугаа хүлээхээр гарын үсэг зурахыг тулган шаардах, хоол хүнс, ус, хувцас хунар, орогнох байр, бие засах газар, болон цэвэр агаараар хангаж өгөхгүй байх, эмнэлгийн халамж, тусламж үзүүлэхэд бэрх, гэр бүлийнх нь талаар мэдээлэл өгөхгүй байх (гэр бүлийнхэн нь түүний амьд эсэхийг мэдэхгүй байх), суртал нэвтрүүлэгт автах болон хамтран ажиллахаар дарамт шахалтанд оруулах, бусад түр саатуулагсадтай үл зохицох, хоригдож байх үед сэтгэл санааны хямралд орох, гэр бүлийнхнийхээ төлөө санаа зовних гэх мэт.]*

Сурагчдын жагсааж бичсэн асуудлууд дээр тулгуурлан зэвсэгт мөргөлдөөний үед хоригдлуудын нэр хүнд, эрүүл мэндийг хамгаалахын тулд юу хийх ёстой талаар жижиг бүлгүүдээс асууна. Тусгай дүрэм журам зохиоход зориулж тэдний үзэл бодлыг нь бичүүлнэ. Мөн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг ч шоронд хорьдог гэдгийг санах хэрэгтэй. Тэдэнд зориулж тусгай хамгаалалтыг санал болгож байна уу?

Сурагчдын санал болгосон санаануудыг авч хэлэлцэнэ үү.

**Боломжит асуултууд:**

➤ Та нарын гаргасан дүрэм журам бүлгийн тавьсан асуудлуудыг шийдэж байна уу?

**2. ОУХЭЗ хоригдлуудыг хэрхэн хамгаалах вэ? (**20 минут)

"Хоригдлуудыг хамгаалах нь" материалыг үзүүлээд сурагчдын гаргасан санаа олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хамгаалалтай дүйцэж байгаа эсэхийг судална.

**Боломжит асуултууд:**

➤ Олзлогч талын хувьд хоригдлуудад үзүүлэхэд хүндрэлтэй байж болох хамгаалалт юу вэ? Яагаад?
➤ Хоригдлуудыг ийнхүү хамгаалж байгааг нягтлахын тулд юу хийх ёстой вэ?

**2001 онд ОУУЗХ дэлхийн 1988 саатуулах төв болон шоронгуудаар явж 346807 хоригдлуудыг эргэсэн байна.**

Сурагчид брейнсторминг хийж байх хооронд тэднийг доорх 4 гол сэдвүүдээр бүлэг болгон хувааж болно.

| **Хоригдлуудын амь нас, нэр хүндийг хүндэтгэж буй эсэхийг нягтлах арга** |
|---|
| 1. Олзлогч талын үүрэг хариуцлага: Хуульд зааснаар хоригдлуудыг хариуцагчид өөрсдийн дагаж мөрдөх дүрмээ сургалтаар сурч мэдсэн байх бөгөөд тэдний зааварчилгааг хянах ёстой. Хэрвээ аливаа зөрчил гарсан бол тэр дор нь зогсоож засах ба хариуцлагатанд шийтгэл хүлээлгэх болно. Эрх мэдэлтэн, удирдлагууд шоронд хангалттай хэмжээний хөрөнгө, мөнгө олгох ёстой. |
| 2. Шоронгийн эргэлт: ОУХЭЗ нь ОУУЗХ зэрэг төвийг сахисан хүмүүнлэгийн байгууллагуудад хоргодох байр болон шоронд байгаа хоригдлуудыг эргэх, тэдэнтэй хэрхэн харьцаж байгааг хянах боломж олгодог. Шоронгуудаар явж үзсэний дараа ОУУЗХ холбогдох эрх мэдэл бүхий хүмүүст санал тавина. Хорооны олж харсан зүйлс нь нууцыг хадгалах чанартай бөгөөд энэ талаар зөвхөн холбогдох удирдлагуудтай л хэлэлцдэг байна. |

| |
|---|
| 3. Олон нийтийн эсэргүүцэл: Олон улсын хүний эрхийн байгууллагууд болох Амнести Интернейшнл, Хүний Эрхийн Манаа болон орон нутгын хүний эрхийг хамгаалах байгууллагууд ард иргэдэд олзлогчид хоригдлуудын эрхийг хэрхэн зөрчиж байгаа талаар мэдээлдэг. Энэ нь дайтагч талуудыг олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, хүний эрхийг хүндэтгэн сахихад хүргэдэг боловч дайтагч талуудын хувьд ихэвчлэн олон нийтийн өмнөх өөрсдийн төсөөлөл, дүр царайгаа хадгалж үлдэхийн тулд л хуулийг хүндэтгэн сахидаг. Гэсэн хэдий ч, иймэрхүү олон нийтийг үгүйсгэж буй явдал нь хүмүүнлэгийн байгууллагуудыг хорих нөхцөл байдлыг сайжруулах шаардлагатай хоригдлууд болон хоригдлуудын удирдлагуудтай шууд холбогдож ажиллахаас сэргийлдэг. |
| 4. Шүүхээр яллах: Шүүх тогтолцооны нэг зорилго бол гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд эрүү шүүлт болон хялбаршуулсан журмаар яллах зэрэг зөрчлийг шийтгэхгүйгээр орхихгүй гэдгийг ил тод харуулснаар ирээдүйн зөрчлөөс сэргийлэх явдал юм. |

> Бид Улаан Загалмай олон улсын хэвлэл мэлээллийнхэнд нөхцөл байдлын талаар мэдэгдээсэй гэж хүсч байна. Бид үүнийг маш ихээр хүсч байгаа билээ. Гэвч бүхнийг ил гаргачихвал эрх мэдэлтнүүд тэднийг хоригдлуудтай дахин уулзуулахгүй болгочихож болох юм. Хэрвээ ийм зүйл болвол бид хохирон үлдэх болно.
>
> Нэгэн хоригдол

Хоригдлуудыг хамгаалах дээрх 4 арга замын талаар ярилцаарай.

**Боломжит асуултууд:**

➤ Дээр санал болгосон арга зам тус бүрийн давуу тал болон сул тал нь юу вэ?
➤ Эдгээр аргууд хоорондоо зохицож байна уу, эсвэл зөрчилдөж байна уу?
➤ Шоронгуудаар эргэж очсон байгууллага бас олон нийтийн эсэргүүцэл хийж болох уу? Яагаад? Эсвэл яагаад үгүй гэж?

### 3. Хоригдлуудыг эргэх (20—30 минут)



"Харанхуй дахь гэрэл" дүрс бичлэгээс ОУУЗХ—ны төлөөлөгчид шоронд хоригдож буй дайсан хэмээн баригдсан буюу олзлогдсон хүмүүстэй хэрхэн уулзаж байгаа талаар үзэх болно. Бичлэгэн дээрх дуу хоолой бол хоригдлуудын жинхэнэ дуу хоолой юм.




Дүрс бичлэг үзэхээс өмнө сурагчдын хагаст доорх асуултуудын нэгийг тавьж тэмдэглэл хөтлүүлээд, нөгөө хэсэг сурагчдад үлдсэн асуултыг тавина:

➤ ОУУЗХ—ны төлөөлөгчид шоронд эргэлт хийхээр очихдоо юу хийдэг вэ?
➤ ОУУЗХ—ны шоронд очсоноор хоригдлуудад хэрхэн тусалж чадах вэ?

Сурагчид дүрс бичлэг үзсэнээр юу ойлгосон тухайгаа илтгэнэ.

**Боломжит асуултууд:**

➤ Та нарын санал болгосон дүрэм журам дүрс бичлэгэнд үзсэн зүйлтэй хэрхэн холбогдож байна вэ? Үзсэн зүйл чинь ОУХЭЗ—н хамгаалалтай холбогдож байна уу?
➤ Шоронд эргэлтээр очиход хүний ямар зан чанар, ур чадвар хэрэгтэй гэж бодож байна вэ?

ЖИЧ: Хэрвээ дүрс бичлэг үзэх боломжгүй бол тайлбарт бичээтэй байгаа хоригдлуудын мэдүүлэг болон фото зурган дээрээс асуултын хариуг олж болно. Мөн шоронгийн эрх мэдэлтнүүдийн үзүүлэхийг хүсээгүй газруудад төлөөлөгчид үзлэг хийхэд ямар байдалтай байж болох талаар төсөөлөн бодоорой.

# Судалгаа 5 С. Хоригдлуудыг хамгаалах

ОУУЗХ—ны саатуулагсдыг эргэгч төлөөлөгчдөд өгсөн зөвлөгөө:

> Та нар хоригдлуудтай уулзахдаа доорх зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:
> 1) Хоригдолтой яриагаа хэрхэн эхлэх талаар бод.
> 2) Доорх зүйлсийг анхааран ажигла:
> - ялгаварлан гадуурагдаж байгаа шинж байдал (эдийн засгийн, бизнесийн, ангийн ялгаа)
> - шоронгийн "ширэнгэ" буюу эмх замбараагүй байдал ноёрхож байгаа эсэх (бүлгүүд, овгордолт)
> - анхааруулах дохионууд
>
> 3) Хоригдлуудын хэн нэгнийг гутаан доромжилж буй эсэх
> - Шоронг бүхэлд нь харснаар бүхнийг ойлгосон хэрэг биш гэдгийг сана.
>
> Тамлан зовоолт, хавсралт, 1997 он

**Боломжит асуулт:**

- Зөвлөгөө тус бүрийн учир шатгааны талаар юу гэж бодож байна вэ?

**4. Шоронд эргэж очих төлөөлөгчдөд тулгарах дилемма**
(Цомхон бүлэг) (20—30 минут)

*Эдгээр хоригдлуудыг бид хэрхэн хамгаалах вэ* гэсэн хэсэгт гарч буй ОУУЗХ—ны нэгэн төлөөлөгчид тулгарч байгаа дилемманы талаар ярилцана.

Ангийн хэсэг сурагчдад (1—р хэсэг) хүчирхийллийн тухай шоронгийн даргад ярьж байгаа хэсгийг авч үзэн судлах даалгавар өгнө.

**Энэ бүлэгт тавих асуултууд:**

- Хоригдлуудад ямар давуу тал болон боломжит эрсдэл байна вэ?
- Шоронгийн дарга болон хуягуудын авах арга хэмжээнээс хэрхэн зайлсхийх вэ?
  [Жишээ нь: Шоронд дахин ирж хоригдлуудад ямар нэгэн зүйл тохиолдсон эсэхийг шалгах тухайгаа шоронгийн даргад сануулна. Хоригдлуудтай зүй бусаар харьцаж байгааг нь ганц хоёр хоригдол болон бүлэг хүн дээр жишээ авалгүйгээр ерөхийлөн ярих хэрэгтэй]

Нөгөө хэсэг сурагчдад (2—р хэсэг) шоронгийн даргад зүй бусаар харьцаж байгаа талаар хэлэхгүй байгаа хэсгийг авч үзэн судлах даалгавар өгнө.

**Энэ бүлэгт тавих асуултууд:**

- Хоригдлуудад ямар давуу тал болон боломжит эрсдэл байна вэ?
- Хоригдлуудад туслахын тулд юу хийх вэ?
  [Жишээ нь: Зүй бусаар харьцаж буй байдлын талаар ярилцахаас өмнө хоригдлыг өөр шоронд шилжүүлэхийг хүлээнэ. Дээд албан тушаалтанд хоригдлын нэр, шоронг дурдахгүйгээр нөхцөл байдлын талаар ярина]

Үүний дараа бүлгүүдийн сонгосон асуулт тус бүр дээр ярилцана.

> Иран, Иракийн хооронд 10 жил орчим болсон зэвсэгт мөргөлдөөний үед ОУУЗХ хоёр талын дайны хоригдлуудыг хамгаалах талаар чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэдний төлөөлөгчид Иранд баривчлагдаад байсан Иракийн 56925 цэргүүдтэй, Иракт баривчлагдсан Ираны 39588 цэргүүдтэй уулзан бүртгэл хийсэн байна. Тэдгээр хоригдол болон тэдний гэр бүлийнхний хооронд 13 сая Улаан Загалмайн мессеж дамжуулагдсан байна. 1980 онд Иран, Иракийн мөргөлдөөн эхэлснээс хойш 2 талд хоригдож байсан 98000 дайны хоригдлуудыг сулласан.
>
> ОУУЗХ—ны хоригдлуудын төлөө хийсэн үйл ажиллагаанаас, 2000 он

Ийм нөхцөл байдалд сурагчид юу хийх байсан талаар шийдвэр гарган чухам юу хийх болон яагаад гэдэг сэдвээр бичнэ.

Тэдний хийсэн сонголтын талаар ярилцана. Иймэрхүү шийдвэр доорх зүйлсээс шалтгаалдгийг хэлж өгнө. Үүнд:
- Жинхэнэ агуулга
- Төлөөлөгчид хоригдлуудыг тогтмол хугацаанд эргэж очих баталгаа
- Хоригдлуудын ашиг сонирхол

*Нэгэн хоригдлын дурсамж* дүрс бичлэгээс шоронд хоригдож буй залуутай уулзсан тухай гарна.

Сурагчид ямар сэтгэгдэлтэй байгаа талаар ярилцана.



**Боломжит асуултууд:**
- Энэ хоригдлын дурсамж ямар мэдрэмж төрүүлж байна вэ?
- Хаалга нь онгорхой байгааг хараад гайхсан уу? Яагаад шоронгийн эрх мэдэлтнүүд хаалгыг онгорхой орхисон гэж бодож байна вэ?
- Шоронд эргэж очиход хүмүүнлэгийн ажилтнуудаас ямар ур чадвар шаардагддаг гэж бодож байна?




**Хаалт**

Хоригдлуудыг хамгаалах талаар ОУХЭЗ—н шаардлагыг жагсааж бичсэн тараах материал руу анхаарлаа хандуулна.

**Боломжит асуултууд:**




- Жагсаалтанд байгаа зарим нэгэн хамгаалалтын хэлбэрийг хараад гайхаж байна уу? Яагаад? Энэ нь дайны хоригдол буюу улс төрийн шалтгаанаар түр саатуулагсдын нэр хүндийг хэрхэн хамгаалах вэ?
- Энэ жагсаалтанд өөр нэмэх санал (хамгаалалтын хэлбэр) байна уу? Яагаад?

Дүрс бичлэг, бичлэгийн тайлбар болон дилеммаг ашиглан доорх сэдвээр ярилцан хичээлээ өндөрлөнө:
- Жагсаалтанд бичсэн олон төрлийн хэрэгцээний тухай
- Шоронд эргэж очихын үүрэг роль

**ГОЛ САНААНУУД**

- Зэвсэгт мөргөлдөөний үеэр олзлогдон хоригдсон хүмүүсийн амь нас, нэр хүнд эрсдэлтэй байдаг.
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хоригдлуудыг хамгаалахыг, мөн дээрх хамгаалалтыг баталгаажуулах зорилгоор хүмүүнлэгийн төлөөлөгчид тэднийг шоронд эргэж очихыг үүрэг болгодог.
- Хоригдлуудыг эргэж буй хүмүүнлэгийн ажилчдад шийдэхэд хэцүү дилемма олон тулгардаг.

# Нэмэлт дасгал

**Баримтууд: Та нар баримтаас юу сурч болох вэ?**

**Бүртгэлийн карт:**
Хоригдлуудын бүртгэх картыг үзнэ үү

- Ямар учраас мэдээллийг нарийвчлан асуудаг вэ?
- Эдгээр мэдээллийг хэн хэзээ, ямар учраас ашиглах вэ?




> Энэ өчүүхэн цаасанд итгэхийн аргагүй асар их хүч бий, учир нь дайны улмаас зовж шаналж буй хэн нэгэн, гэр бүлийнхэн нь чухам юу болж байгаа талаар учрыг нь ч олохгүй зовж шаналж буй хүмүүсийг холбох гүүр болж өгдөг юм.
>
> — Улаан Загалмайн эрэн сурвалжлагч төлөөлөгч

**Улаан Загалмайн мэдээ:**

Маягтыг хуулбарлан авна.
Хоригдол болон хүснэгтийг бөглөнө.




Энэ картыг нэг хоригдол хүлээн авч байгаагаар эхэлж, картыг тэр өдрөө 3 өөр хоригдол авч дуусч байгаагаар тэмдэглэлээ дуусгана.

**Урлагийн төсөл**
ОУУЗХ—ны төлөөлөгчид эрх чөлөө нь хязгаарлагдсан хоригдлуудыг эргэж очсоноор тэдэнд ямар жинхэнэ нөлөө үзүүлснийг дүгнэхэд хэцүү бөгөөд хэрвээ ОУУЗХ—ны хувьд нөхцөл байдал ямар ч байсан үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байсан бол юу болох байсныг ч хэлэх аргагүй.

Дараах текстийг уншина уу. Нельсон Манделагийн хэлсэн үгийг өөрийнхөөрөө урлагын хэлбэрт оруулаарай.

> *Олон Улсын Улаан Загалмайн Хороо сайн үйл хэргийг авчирсан төдийгүй муу явдлыг мөн сануулан сэрэмжлүүлсэн.*
>
> — Нельсон Мандела (Бүртгэлийн дугаар № 220/80, Роббен Айландын шорон, 1962—1990 он)

**Хоригдлууд суллагдсаныхаа дараа ямар хүндрэл бэрхшээлтэй тулгарч болох вэ?**

*Хоригдлуудын нүдээр* материалыг ашиглан шоронгоос суллагдсаны дараах хоригдлын амьдралыг харуулсан жүжиг бичнэ. Та нар уг үзэгдэлдээ зэвсэгт мөргөлдөөнөөс болж өөрийн амьдралын хэдэн жилийг шоронд өнгөрөөсөн хүний тухай өгүүлнэ.




Мөн энэ бичсэн өгүүллэгээрээ жүжигчилсэн тоглолт хийнэ.

# Хоригдлуудыг хамгаалах нь – Хуулинд юу гэж заасан байдаг вэ?

**Дайнд олзлогдогчидтой харьцах тухай**
**Женевийн (III) Конвенцийн хэсгээс**

**Ерөнхий заалт**

**13–р зүйл.** Дайд олзлогдогчидтой үргэлж хүнлэг энэрэнгүй харьцах ёстой. Түүнчлэн дайд олзлогдогчид нь хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, эсхүл тэднийг элдвээр доромжлох, олны өмнө гутаах зэргээс үргэлж хамгаалагдсан байх ёстой.
Дайнд олзлогдогчдын эсрэг хонзогносон арга хэмжээ авахыг хориглоно.

**14–р зүйл.** Дайнд олзлогдогчид нь бүх нөхцөл байдалд нэр төр болон хүнийхээ хувьд хүндэтгэл хүлээх эрхтэй...

**23–р зүйл.** Ямар үед дайнд олзлогдогчдыг байлдааны талбар, галын шугаманд өртөж болох газар руу явуулах, эсхүл тэнд албадан саатуулж болохгүй...

**Эрүүл ахуй, эмнэлгийн тусламж**

**29–р зүйл.** ...Дайнд олзлогдогчид өдөр шөнийн аль ч цагт ашиглах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр хангагдсан байна. Эмэгтэй олзлогдогчид байрладаг лагерьт тэдэнд зориулсан ариун цэврийн өрөөг тусгайлан гаргаж өгнө...

**30–р зүйл.** Дайнд олзлогдогчдод эмнэлгийн тусламж үзүүлэх буюу тэдэнд хоолны дэглэм сахиулах зорилгоор лагерь бүр өөртөө тохирсон эмчилгээний тасагтай байна...

**Дайнд олзлогдогчдын орон байр, хоол хүнс, хувцас**

**25–р зүйл.** Эрэгтэй, эмэгтэй олзлогдогчид хамтдаа байгаа лагерьт тэднийг унтах байраар тусад нь хангана.

**26–р зүйл.** Өдөр тутмын хоол хүнс, түүний найрлага бүтэц нь дайнд олзлогдогчдыг эрүүл байлгах, тураал болон хүнс тэжээлийн дутагдлаас үүсэх хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх үүднээс тоо, чанар, төрлийн хувьд хангалттай байх ёстой. (...)
Дайнд олзлогдогчдыг ундны усаар хангалттай хэмжээнд хангах хэрэгтэй. (...)
Хоол хүнсийг хөндсөн аливаа сахилгын хамтын шийтгэл ногдуулахыг хориглоно.

**27–р зүйл.** Дайнд олзлогдогчдод гадуур, дотуур хувцас, гутал зэргийг хангалттай тоогоор тавьж олгоно...

**38–р зүйл.** Олзлогдогчид нь ил гадаа биеийн тамирийн дасгал хийж, элдэв төрлийн спорт, спортын тоглоомоор тоглох болоимтой байх ёстой. Бүх лагерьт үүнд зориулж хангалттай хэмжээний задгай талбай бэлттгэнэ.

**Гэр бүлийн холбоо.**

**71–р зүйл.** Дайнд олзлогдогчдод захидал, ил захидал илгээх буюу хүлээн авахыг зөвшөөрнө...

**Шашны үүрэг**

**34–р зүйл.** Дайнд олзлогдогчид өөрсийн шүтэн биширдэг шашныхаа зан үйлийг гүйцэтгэх эрхтэй (...) Шашны зан үйл гүйцэтгэхэд тохиромжтой тусгай өрөө тасалгаа бэлтгэж өгнө.

**Шүүхийн баталгаа.**

**99–р зүйл.** ...Шүүгдэж буй хэргийг өөрт нь тулгаж хүлээлгэх зорилгоор дайнд олзлогдогчдод сэтгэл санааны талаар буюу биед нь хүч хэрэглэж, дарамт шахалт үзүүлж болохгүй. Өөрийгөө өмгөөлөх боломж олгохгүйгээр, эсхүл мэргэжлийн өмгөөлөгчгүйгээр дайнд олзлогдогчдыг шийдтгэж болохгүй.

**Олзлолтын хугацаа дуусах**

**109–р зүйл.** ...мөргөлдөөнд оролцогч талууд хүнд өвчтэй буюу хүндээр шархадсан дайнд олзлогдогчдыг тэдний цол хэргэм, тоог үл харгалзан эх оронд нь шууд буцаах үүрэг хүлээнэ.
**118–р зүйл.** Дайнд олзлогдогчдыг дайтах ажиллагаа зогсмогц шууд чөлөөлөх буюу эх оронд нь буцаана.

**Дайнд олзлогдогчдод туслах нийгэмлэгүүд болон бусад байгууллагууд**

**125–р зүйл.** ...Шашны байгууллагын төлөөлөгчид, тусламжын нийгэмлэгүүд, эсхүл дайнд олзлогдогчдод тусламж үзүүлэх өөр аль нэг байгууллагад, түүнчлэн тэдний бүрэн эрхт төлөөлөгчдөд дайны олзлогдогчидтой уулзах, тэдэнд (...) төрөл бүрийн материалуудыг хуваарилах ажилд шаардлагатай бүх боломжийг олгоно. Энэ салбар дахь Олон Улсын Улаан Загалмайн Хорооны онцгой үйл ажиллагааг үргэлж хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандана.

*Дээрх хууль нь олон улсын шинж чанартай дайн байлдааны үед баривчлагдсан хоригдлуудад үйлчлэх болно. Хэдийгээр цөөн тооны боловч, Женевийн Конвенцийн Нэмэлт 2–р протоколд дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед олзлогсон хоригдлуудын талаар заасан болно.*

**Дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеийн хоригдлуудын тухай журам: II Протоколоос**

**4.1–р зүйл.** Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй, эсхүл оролцохоо больсон этгээдийн эрх чөлөө нь хязгаарлагдсан эсэхээс үл хамааран бие хүн, нэр төр, үзэл бодол болон шашны зан үйлийг нь хүндэтгэнэ. ...
**4.2–р зүйл.** ...Дараахь үйлдлийг хэзээ ч, хаана ч хийхийг хориглох бөгөөд цаашид ч хориглох болно:

a) хүмүүсийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйн байдалд халдах, ялангуяа амийг нь хөнөөх буюу эрүүдэн шүүх зэрэг хүнлэг бус харьцах, эсхүл бие махбодийг зовоон тарчлаах аливаа бусад үйлдэл;
b) хамтын шийтгэл; ...
e) хүний нэр хүндийг гутаах, ялангуяа басамжлан доромжлох, хүчиндэх, биеэ үнэлэхийг албадах болон бусад аливаа хэлбэрээр зүй бусаар халдах; ...

**5–р зүйл.** *Эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээд*

**5.1 ...**

a) шархдсан болон өвдсөн хүмүүсийн эмчлэх
b) хоол хүнс, уух усаар хангах, зэвсэгт мөргөлдөөний аюул болон байгалын аливаа гамшигаас хамгаалах, эрүүл мэнд, эрүүл ахуйн талаар арга хэмжээ авах.
c) хувь хүний болон хамт олны тусламж авахыг зөвшөөрөх
d) шашны үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулахыг зөвшөөрөх (...) ...

**5.2. ...**

a) нэг гэр бүлийн эрэгтэй, эмэгтэйг хамт байлгахаас бусад тохиолдолд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусад нь байрлуулж, эмэгтэй хүний шууд хяналтын дор байлгана;
b) захидал болон ил захидал илгээх, хүлээн авахыг тэдэнд зөвшөөрнө (...);
c) албадан саатуулагдсан, эрх чөлөө нь хязгаарлагдагсдыг байлдааны бүсэд ойрхон байрлуулахгүй (...); ...
e) тэдний бие махбодь буюу сэтгэл зүйн эрүүл мэнд, халдашгүй байдалд хохирол учруулж болохгүй (...).

# Хоригдлуудыг эргэж очих нь

**Хоригдлуудыг эргэж очихдоо ОУУЗХ–ны төлөөлөгчид юу хийдэг вэ?**

- Эхний шатанд шоронгийн даргатай уулзан түүний санал бодлыг сонсох, уулзалтаа зохион байгуулан ОУУЗХ нь хоригдлуудтай хувийн яриа өрнүүлж болохыг нягтлах, хоригдлуудыг бүртгэх, шоронг тал бүрээс нь шалгах, бүртгэлийг шалгах, нас барсан хүмүүсийн бүртгэлийн хуулбарыг авах болон хоригдлуудыг дахин эргэж ирэх.
- Хоригдлуудын байраар явж үзэх (ялангуяа шоронгийн камерь, бие засах газар, шүршүүрт орох газар, дасгалын талбай, гал тогоо, тусгай камерь, эмнэлгийн тасаг).
- Бүлэг хоригдлуудтай эмзэг бус асуудлаар ярилцах: ус, хоол хүнс, бие засах газар болон шүршүүрт орох газрын тухай, эмнэлгийн тусламж үзүүлж байгаа байдал, биеийн тамирын дасгал, цэвэр агаар болон чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгаа талаар ярилцах
- Нэг хоригдолтой эмзэг болон хувийн асуудлаар ярилцах: байцаалтын үеэр хэрхэн харьцаж байсан, харуул хуягуудын зан ааш, өөр хоригдол нууж байгаа эсэх, бусад хоригдлуудын зүгээс дарамт шахалт үзүүлж байгаа эсэх, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байгаа болон эмнэлгийн буюу хувийн асуудлын талаар ярилцана.
- Шоронгийн даргатай сүүлийн уулзалт хийгээд ОУУЗХ—ны төлөөлөгч өөрийн олж илрүүлсэн зүйлийн талаар мэдээлэх ба байдлыг сайжруулах талаар санал тавина.

  Эрх мэдэлтнүүдэд ихэвчлэн тавигддаг саналаас:

  — хоригдлуудтай зүй ёсоор харьцах талаар харуулуудад хэлж сануулах;
  — өдөрт 1 цаг биеийн тамирын дасгал хийлгэхээр цагийг нэмэх;
  — өдөрт ядаж нэг удаа хоригдлуудыг жимс, ногоогоор хангаж байх;
  — цэвэр усны хангамжийг ихэсгэх;
  — эмнэлгийн тусламжийг сайжруулах;

  Олон Улсын Улаан Загалмайн Хороо шаардлагатай үед онцгой тусламж үзүүлнэ: усны болон эрүүл ахуйн багаж төхөөрөмжийг засаж янзлах, Улаан Загалмайн мэдээ солилцох, ердийн хэрэглээний эм болон ариун цэврийн хэрэглээгээр хангах, чөлөөт цагаа өнгөрөөх зүйлээр хангах, суллагдсан нэгэнд нь хэрэгцээтэй бол нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх.

**ОУУЗХ–ны төлөөлөгчид хоригдлуудтай уулзсанаар тэдэнд ямар тус нэмэр болох вэ?**

- Хоригдлуудыг бүртгэх, илрүүлэх ажил нь хоригдлуудыг "алга болох" болон хялбаршуулсан журмаар ногдуулсан шийтгэх тогтоолыг гүйцэтгэхийн эсрэг хамгаалалт болдог.
- Төлөөлөгчидтэй дарамт шахалт, тусад нь хорих талаар аминчлан ярих нь сэтгэл санааны дарамтыг нимгэлж өгнө.
- Хоригдлууд Улаан Загалмайн мэдээ гэр бүлийнхэндээ бичиж, хаана байгаагаа мэдэгдэн боломжтой тохиолдолд захианы хариу авдаг. Заримдаа гэр бүлийнхэн нь шоронд эргэж ирнэ.
- Төлөөлөгчид шоронгийн даргад хоригдлуудаас хүлээн авсан харьцаа болон материаллаг нөхцөл байдлын талаарх мэдээлэлдээ тулгуурлан зарим өөрчлөлтүүдийг хийх санал гаргах буюу цэвэрлэгээний материалаар хангах, эсвэл эрүүл ахуйн системийг засах зэргээр туслахыг санал болгоно.

# Хоригдлуудыг хамгаалах

**(зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой хоригдогсод)**

- Эмнэлгийн тусламж
- Биеийн тамирийн дасгал хийх боломж
- Гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байгаа эсэх
- Эрүүл мэндийн баталгаа болох хоол хүнс, усаар хангаж байгаа эсэх
- Аюулгүй байдал хангасан, тав тухтай байр
- Эрүүл ахуйн тоног төхөөрөмж тохиромжтой эсэх
- Нээлттэй шударга шүүх хурал явуулж буй эсэх
- Хууль мөрдөж буй эсэхийг хянах бие даасан байгууллага

- Хүчирхийлэл, айлган сүрдүүлэх явдлын эсрэг хамгаалалт
- Нэр, цол хэргэм, төрсөн он сар өдөр, цэргийн үнэмлэхний дугаараас цааш мэдээлэл өгөх албагүй
- Зэрлэг, хүнлэг бусаар харьцахгүй байх
- Боолчлон хөдөлмөрлүүлэхгүй байх
- Шашин чөлөөтэй шүтэх
- Олзлолтын нөхцөл байдлын талаар санал гомдлыг хүлээн авах эрхтэй

### ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ОНЦГОЙ НӨХЦӨЛ, ЗААЛТ:

- Эмэгтэй хоригдлууд эмэгтэй харгалзагчтай тусгаарласан байранд байх
- Эмэгтэй хоригдлуудыг зөвхөн эмэгтэй хүмүүс л шалгах ёстой
- Эмэгтэй хоригдлууд сексийн хүчирхийллээс хамгаалагдах ёстой.

### ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН ОНЦГОЙ НӨХЦӨЛ, ЗААЛТ:

- Хүүхдүүд гэр бүлийнхэн нь биш л бол насанд хүрэгчдээс тусдаа байрлана
- Хүүхдүүдийн насанд тохирсон хоол хүнс, эрүүл ахуй болон эмнэлгийн тусламж үзүүлнэ
- Хүүхдүүд сурч байсан хичээл номоо үргэлжлүүлэн үзнэ

# Харанхуй дахь гэрэл

Анх удаа бидэнтэй уулзахаар хүмүүс эргэж ирлээ. Би Женевт, ядуу зүдүү, дарамт шахалтанд өртсөн хүмүүст тусалдаг нэг байгууллага байдаг гэдгийг мэдэх төдий л байлаа. Миний мэдэх зүйл ингээд л гүйцээ. Би тэднийг шоронд орж ирж болдог гэдгийг мэддэггүй байсан юм.

Тэд шоронгийн эрх мэдэлтнүүдийн харахыг зөвшөөрсөн газруудаар бус бүхий л тийшээ харж, шинжиж байлаа. Тэд бүхий л нөхцөл байдлын талаар мэдэхийг хүсч байсан нь бидний итгэлийг олж чадав.

Тэд идэвхитэй бөгөөд бодлоготой хүмүүс байв. Тэд хоёр талын итгэлийг олж чаджээ, эрх мэдэлтнүүд хэн ч явдаггүй тийм газраа үзүүлж байсан бөгөөд хоригдлууд тэднийг хараад "харанхуй дахь гэрэл" хэмээн нэрийдэх болов.

Бидний шоронд байсан 6 сарын турш Улаан Загалмайнхан бидэнтэй ирж уулздаг байв. Тэд биднийг хэзээ ч гомдоогоогүй. Тэд 7 хоногт 2 удаа, заримдаа түүнээс ч олон удаа эргэж ирнэ.

Тэд бидний нэрийг жагсаан бичнэ. Шоронд шинэ хоригдлууд байнга ирдэг учраас шинэ ирсэн хүмүүсийн нэрийг аль болох хурдхан жагсаалтанд оруулахыг хичээдэг болов. Учир нь нэрсийн жагсаалт гаргах нь тэд биднийг хамгаалж байгаа хэрэг билээ.

Өнөөдөр миний амьд байгаа шалтгаан нь Улаан Загалмайн төлөөлөгчид нэрээ бүртгүүлсэн явдал юм.

"Чи үүнийг тэр хүнд тайлбарлан өгч болох юм уу? Үүнийг чамд, харин түүнийг чиний хамаатанд чинь өгнө."

Би энэ мөчийг хэзээ ч мартахгүй ээ. Тэр төлөөлөгч надад их урам хайрлаж намайг чөлөөтэй ярихад сургасан. Тэр надаас миний тухай, манай гэр бүлийнхний тухай зэрэг олон асуултуудыг тавьдаг байлаа. Тэр аль нэг байр сууринаас хандахгүй, намайг зөвхөн сонсдог л байв.

Бид шоронд зовж шаналдаг байсан. Бид Улаан Загалмайнхан энэ бүгдийн тухай олон улсын хэвлэл мэдээллийнхэнд хэлээсэй гэж хүсдэг байсан. Бид үүнийг чин сэтгэлээсээ хүснэ.

Гэвч тэд харсан бүхнээ дэлгэвэл шоронд орж ирэх эрхгүй болох биззээ. Хэрвээ ийм зүйл болвол бид ялагдагч болон үлдэх болно.

# Би эдгээр хоригдлуудыг хэрхэн хамгаалах вэ?

Та нар өөрсдийгөө хоригдлуудтай уулзах Олон Улсын Улаан Загалмайн Хорооны (ОУУЗХ) төлөөлөгч гэж төсөөлнө.

Та нар очсон өдрөө долоон хоригдлуудтай нэг нэгээр нь уулзаж ярилцсан. Хоригдлуудын 3 нь 2 долоо хоногийн өмнө байцаалтын үеэр офицерүүд зодсон тухай хэлэв. Тэд хүчинд автагдан төрийн эсрэг гэмт хэрэг хийсэн хэмээн буруугаа хүлээхэд хүрчээ.

Хоригдлууд маш их айж байна. Шоронгийн дарга тэдэнд, хэрвээ энэ байдлын талаар үнэн зөвөөр хэлбэл шийтгэл хүлээлгэн зодно хэмээн айлган сүрдүүлсэн талаар та нарт хэлэв.

Одоо та нар шоронгийн даргатай ярих цаг ирлээ.

Та нарт тулгарах дилемма: Та нар эдгээр 3 хоригдлуудтай зүй бусаар харьцсан тухай шоронгийн даргад хэлэх үү?

—Төлөөлөгчдийн тайлангаас жишээ авч бичив.

**Эргэцүүлэн бодох зарим асуудлууд**

- даромт шахалтанд өртсөн хоригдол
- шоронгийн дарга
- бусад хоригдлууд
- тухайн хоригдлын гэр бүлийн гишүүд
- төлөөлөгчийн дарга

## Та нар юу хийхээр шийдсэн бэ?

# Хоригдол дурсан ярьж байна

Намайг улс төрийн шалтгаанаар сар хагасын хугацаанд түр саатуулсан.

Би шоронд байх хугацаандаа юу ч идэж уугаагүй. Би амьд үлдэхийн тулд өөрийнхөө шээсийг ууж байсан бөгөөд энэ нь шингэн алдахаас сэргийлэх арга юм.

Хэрвээ та нарт ийм зүйл тохиолдвол чамайг "алга болохоос," эсвэл зүгээр л алуулахаас хэн ч хамгаалахгүй. Заримдаа бид хүмүүсийн орлих дууг сонсоно, дараа нь буун дуу гарч хэсэг хугацааны дараа чив чимээгүй болно.

Би өөр камеруудын хаалга тогших чимээг сонсоод бидэн дээр зочин иржээ гэж бодлоо. Би гэнэтхэн зөнгөөрөө камерийн хаалганы дотор талаас тогшиж эхлэв.
Миний өрөөний хаалганы өмнө хэсэг хүмүүс зогсоод *энд хүн байх шиг байна* гэх сонсогдов. Өөр нэг хүн *үгүй ээ, энд хэн ч байхгүй* гэхэд нөгөө хүн *энэ хаалгыг онгойлгоод өгөөч* хэмээн өөриинхөөрөө зүтгэв.
Тэдний яриа үргэлжилсээр арай гэж хаалга онгойлоо. Хаалга онгойход би шоронд орсноосоо хойш анх удаа гэрэл болон хүний царай харсан юм. *Сайн байна уу, би Улаан Загалмайн төлөөлөгч байна* гэж хэлэхийг сонслоо.

Тэдний анхны айлчлал шууд үр дүнтэй болсон. Удалгүй надад жижиг савтай бохир ус өгөх болов. Энэ нь уух ус байлаа. Удалгүй тэд биднийг ална хэмээн айлгахаа больсон юм.

# Бүртгэлийн карт

Олон Улсын Улаан Загалмайн Хороо №: ..................

Овог..........................................................................................................................................................

Нэр..........................................................................................................................................................

Эцгийн нэр..............................................................................................................................................

Эцгийн овог нэр.......................................................................................................................................

Хоч................................................................................................................Хүйс: Эрэгтэй/ эмэгтэй

Төрсөн газар, он сар өдөр........................................................................................................................

Иргэншил......................................................................................үндэс угсаа................................................

Мэргэжил......................................................................................Анги/ хэсэг................................................

Статус.........................................................................................Категори......................................................

Шийтгэл..................................................

Түр саатуулагдсан газар..........................................................................................................................

Саатуулсан эрх мэдэлтэн........................................................................................................................

Баривчлагдсан газар, он сар өдөр.............................................................................................................

Баривчилсан эрх мэдэлтэн:.......................................................................................................................

Гэр бүлийн гишүүдийн нэр, хаяг

Овог нэр ..................................................................................................................................................

Хаяг..........................................................................................................................................................

..............................................................................................................Утас:..............................................

Гэр бүлийн холбоо.........................................................................Тэмдэглэл.......................................

Он сар өдөр.......................................................

# Улаан Загалмайн мэдээний маягт

1. /эмблем/ **УЛААН ЗАГАЛМАЙН МЭДЭЭ**

---

2. Илгээгч

Овог нэр (бичиг баримтан дээрх)
.............................................................................................................
Төрсөн он сар өдөр..............................................................................
.......................Хүйс: Эрэгтэй/Эмэгтэй
Эцгийн нэр..........................................................................................
Эхийн нэр............................................................................................
Бүрэн гүйцэд хаяг................................................................................
Муж, улс орон......................................................................................

---

3. Хүлээн авагч
Овог нэр (бичиг баримтан дээрх)
.............................................................................................................
Төрсөн он сар өдөр..............................................................................
.......................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй
Эцгийн нэр..........................................................................................
Эхийн нэр............................................................................................
Бүрэн гүйцэд хаяг................................................................................
Муж, улс орон......................................................................................

---

4. Олон Улсын Улаан Загалмайн Хороо

5. **Мэдээ**
**(гэр бүлийн ба/буюу хувийн мэдээ)**

---

---

6. Он сар өдөр:.................................. Гарын үсэг:..........................

Хүлээн авагч бол миний .................................................................

# /хариу захиа/

7. Улаан Загалмайн мэдээ

8. Илгээгч:

Овог нэр (бичиг баримтан дээрх) ..........................................................................................................

Төрсөн он сар өдөр.........................................................................

.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй

Эцгийн нэр...............................................................................

Эхийн нэр.................................................................................

Бүрэн гүйцэд хаяг...................................................................

Муж, улс орон.........................................................................

9. Хүлээн авагч

Овог нэр (бичиг баримтан дээрх) .......................................................................................

Төрсөн он сар өдөр.........................................................................

.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй

Эцгийн нэр...............................................................................

Эхийн нэр.................................................................................

Бүрэн гүйцэд хаяг...................................................................

Муж, улс орон.........................................................................

10. Олон Улсын Улаан Загалмайн Хороо

11. ..................................– өдрийн мэдээний хариу

(гэр бүлийн ба/буюу хувийн мэдээ)

12. Он сар өдөр:........................................ Гарын үсэг:..........................................

Хүлээн авагч бол миний...................................................................

# Хоригдлуудын нүдээр

*Би 5 жил 8 сарын турш эхнэр, хүүхдээ орхин явсан. Үүний үр дүнд нийгмийн болон сэтгэл санааны хүнд байдалд орсон. Бид хоёулаа өөрчлөгдсөн. Намайг шоронд байх хугацаанд охин бид хоёрын хооронд ан цав үүссэн.*

—10 жил хагас шоронд суусны эцэст 1998 онд суллагдсан түр саатуулагдагч



/зураг/ Зэвсэгт мөргөлдөөний үед түр саатуулагдсан хоригдлуудын зурсан зураг



Шоронгоос гарах нь шоронд орж байгаатай адил гайхаж болохоор зүйл. Энэ бол үнэхээр цочролд орохоор зүйл. Одоо чи чөлөөтэй боллоо. Гэхдээ чи энэ эрх чөлөөг хэрхэн эдлэхээ мэдэхгүй байгаа. Чи одоо хэрхэн амьдралаа дахин шинээр эхлэх гэж байна вэ?

— Шоронд 6 жил хоригдон 1997 онд суллагдсан түр саатуулагдагч

Эх сурвалж: Эрх чөлөөтэй нүүр тулгарсан нь, ОУУЗХ, 2001 он

# Судалгаа 5 D. Гэр бүлийн холбоог сэргээх

Судалгаа 5D–д зэвсэгт мөргөлдөөний улмаас салсан гэр бүлүүдийн зовлон гуниг болон салж сарнисан гэр бүлийн холбоог сэргээх, хэвээр нь хадгалах хүчин чармайлтын талаар авч үзнэ. Фото зургуудаас сурагчид тэрхүү шаналж буй гэр бүлүүдийн зовлон бэрхшээлийг харж ойлгох болно. Сурагчид "алга болсон" гэр бүлийн гишүүдийг эрэн сурвалжлах хүснэгтийг бөглөн хүмүүст гэр бүлийнх нь гишүүнийг олж илрүүлэхэд туслах даддлагат суралцана. Сурагчид энэхүү хүчин чармайлтын цар хүрээ, түүний олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн (ОУХЭЗ) үндэслэгээг мөн судлах болно.

---

**Зорилго:**

- Дайны улмаас гэр бүлээсээ салсан гэр бүлүүдийн зовлон гунигийг мэдэх
- Гэр бүлийн гишүүдийн холбоог сэргээх, хэвээр нь хадгалах ажлыг хийхэд шаардлагатай хүчин чармайлтын цар хүрээг ойлгох

**Ашиглах материалууд:**

- Зургийн эвлүүлэг 5D – номын хавтсанд бий
- Эрэн сурвалжлах асуултын хүснэгт
- Улаан Загалмайн мэдээний маягт
- Баримт хуудас: Рванда хүүхдүүд



**Багш нарт:**

- Гэр бүлийн гишүүдийг эрэн сурвалжлах, дахин нэгтгэх – хуулийн заалтууд
- Гэр бүлийн холбоог сэргээх нь

**Бэлтгэл ажил:**

Сурагчдад эрэн сурвалжлах ба мэдээний маягтыг хувилан тараана.

**Хугацаа:**

45–60 минутын нэг удаагийн хичээл

---

**1. Зэвсэгт мөргөлдөөний улмаас салсан нь (10 минут)**

Зэвсэгт мөргөлдөөний эмх замбараагүй байдлын үеэр хүмүүс гэрээсээ дүрвэн явдаг бөгөөд ихэнх тохиолдолд бие биенээсээ салдаг. Бид одоо гэр бүлийн холбоог хэрхэн сэргээх талаар авч үзэх болно.

Зэвсэгт мөргөлдөөний үеэр гэр бүлээсээ салсан хүүхдүүдийн талаар доорх статистикийн мэдээллийг сурагчдад өгч уншуулна.

> Дэлхий дээрх 50 сая дүрвэгсэд, шилжин нүүсэн хүмүүсийн хагасаас илүү хувийг бага болон өсвөр насны хүүхдүүд эзэлдэг байна. Үүнээс 2–оос илүү сая нь гэр бүлээсээ салсан хүүхдүүд байна. Хараа хяналтгүй хүүхдүүд хүчирхийлэл, сексийн дарангуйлалд автах бөгөөд цэрэгт ч дайчлагдаж байна.

Энэхүү тоо баримтын цар хүрээг сурагчдад ойлгуулахын тулд доорх асуултуудыг тавина:

- Манай ангид хэдэн хүүхдүүд сурдаг вэ? 2 сая хүмүүст хэдэн анги хэрэгтэй вэ?

Эсвэл

- 50 сая хүмүүсийг багтаахад хэдэн спортын талбай хэрэгтэй вэ?

Зэвсэгт мөргөлдөөний улмаас гэр бүлээсээ сална гэдэг нь ямар утга учиртай болохыг ярилцана.

**Боломжит асуулт:**

- Гэр бүлийн холбоог сэргээхэд гэр бүлээсээ салсан хүүхдүүдээс гадна эмзэг бүлгийн ямар хүмүүст онцгой анхаарал тавих шаардлагатай вэ?
  [Жишээ: ганц бие хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ямар ч харилцаа холбооны хэрэгсэлгүй хоригдлууд]

**2. Гэр бүлээсээ салсан нь** (20 минут)

Гэр бүлээсээ салсан, эргэн нэгдсэн болон эрэн сурвалжлахад орж буй хүчин чармайлтыг харуулсан "Фото зургын эвлүүлэг 5D"—г үзүүлнэ. Сурагчдаас доорх асуултуудыг асууна:

**Боломжит асуултууд:**

- Та өмнө нь төөрч байсан уу? Энэ талаар юу санаж байна вэ? Тэр үед хэдэн настай байсан бэ? Таныг хэрхэн олсон бэ?
- Гэр бүлийнхнийхээ талаарх мэдээллийг ямар хүмүүс ихэвчлэн хүсдэг вэ? Яагаад?
- Гэр бүлээсээ салсан хүмүүст ямар асуудал тулгарч болох вэ? Ялангуяа хүүхдүүдэд? Хоригдлуудад? Хөгшин хүмүүст?
- Гэр бүлийг дахин нэгтгэхээр оролдож буй хүмүүнлэгийн ажилтанд ямар хүндрэл тулгарч болох вэ?
  [Жишээ: хүүхэд холбоо барихад хэтэрхий балчир болон сэтгэл нь шархдсан байх, хэл ойлголцохгүй байх, дайн үргэлжилж байгаа, гэр бүлийн гишүүдийг салгасан дайны талбарт очиж чадахгүй байх, томоохон газар нутгаар тарсан байх, дүрвэсэн хамаатнууд нь шилжин нүүсэн болон нас барсан байх]

**3. Эрэн сурвалжлах болон дахин нэгтгэх зорилт**
(15—20 минут)

Ихэнх мөргөлдөөний үед, гэр бүлийн холбоог сэргээх хүсэлтэд хариу өгөх боломжгүй байдаг. Хүмүүнлэгийн ажилтанд тулгарч болох дараах нөхцөл байдлын талаар ярилцана. Сурагчид хэзээ, хаана гэр бүлийн холбоог сэргээх шалгуурын талаар юу гэж санал болгохыг асууна:

- 18—аас дээш насны эрчүүдийг байлдуулахаар хөдөлгөж байгаа газар нутагт 30 настай эрэгтэйчүүдийг гэр бүлтэй нь нийлүүлж болох уу?
- Шилжин нүүгсдийн лагерьт амьдарч байгаа хүүхдийг дайнд нэрвэгдсэн хотод амьдарч буй гэр бүлийнх нь гишүүдтэй уулзуулж болох уу?




[Шалгуурын жишээ: хэр зэрэг эмзэг байдалд байгаа эсэх, бодит буюу боломжит байлдагчдад туслахаас зайлсхийх үүднээс эрчүүдэд насны хязгаар тогтоох, аюулгүй байдал болон хүмүүсийн нөхцөл байдлыг одоогийн байгаагаас илүү доройтон муудуулахаас сэргийлэх]

**Боломжит асуултууд:**

- Алга болсон, төөрсөн хүмүүсийг эрэн сурвалжлахад хүмүүнлэгийн ажилчид ямар үйлдэл, алхам хийж болох вэ?
  [Жишээ нь: оршин сууж байсан хамгийн сүүлийн газар очих, эмнэлэг болон оршуулгын газарт хайх, шилжин нүүсэн ба дүрвэсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтаас хайх, шоронгуудаар явж асууж сураглах, орон нутгийн удирдлагуудад мэдэгдэж хөдөө тосгодуудаар явж мэдээлэл цуглуулах, сонин, радио, интернет, зурагт хуудас, зарлалын самбар дээр нэрсийн жагсаалтыг бичиж цацах, хүүхдийн зургийг самбарт хадах, эцэг эхчүүдийг хүүхдийн төвүүдээр дагуулан явж хүүхдийг нь тогтоох]




ЖИЧ: Эрэн сурвалжлах ажил хувь хүний хувийн нууцыг хүндэтгэнэ.

- Зэвсэгт мөргөлдөөний үед алга болсон хүмүүсийн талаар мэдээлэл хайж олоход яагаад хэцүү байдаг талаар хэдэн хэдэн шалтгааныг дурдана уу?

*Улаан Загалмайн мэдээний маягт*—ыг ашиглан мэдээлэл хэрхэн дамжуулдаг талаар ярилцана.

**Боломжит асуултууд:**

- Энэ мэдээнд ямар мэдээлэл бичигдэх ёстой вэ?
- Улаан Загалмайн ажилчид Улаан Загалмайн мэдээ тараахаасаа өмнө ямар учраас агуулгыг нь шалгадаг вэ?
  [Энэхүү мэдээгээр мөргөлдөөн болон улс төрийн хэрэгтэй холбоотой чухал мэдээллийг дамжуулахаас зайлсхийж шалгадаг байна. Агуулга нь зөвхөн хувийн шинж чанартай байх ёстой.]
- Мэдээн дээр бичсэн зүйл ямар учраас хамаатай байдаг вэ?
  [Дайтагч талууд гэр бүл хоорондын мэдээг дамжуулахаас сэргийлэхийн тулд]




**4. Хараа хяналтгүй хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэх** (10—15 минут)

*Рванда хүүхдүүд* баримт хуудсыг уншин зэвсэгт мөргөлдөөний үед хараа хяналтгүй болсон хүүхдүүдийн талаар ярилцана.

**Боломжит асуулт:**

- Дараах дилеммагаас аль болох зайлсхийхийн тулд та нар ямар сануулга өгөх вэ?

  Зарим улс орнуудад хүүхдүүд дүрвэхэд тэдний ойрын болон холын хамаатнууд нилээд хэдэн жилийн дараа хүүхдээ хаана байгаа талаар асууж сураглан буцаахыг шаарддаг. Тухайн улс оронд хүүхдийг хүнд үрчлүүлдэг бөгөөд нэгэнт тэдгээр хүүхдүүд тэр айлдаа дассан учраас буцааж авах нь утгагүй юм. Зарим хүмүүс дайны үед улс орон дамнан хүүхэд үрчлүүлэх нь утгагүй хэрэг гэж үздэг, учир нь хүүхдүүд үнэхээр хаягдсан эсэхийг олж тогтооход хэцүү юм.

### 4. Ор сураггүй алга болсон хүмүүс

Гэр бүл, хамаатан садныхаа талаар ямар нэг мэдээлэл байхгүй зовж шаналж байгаа хүмүүсийн зовлон дайны төгсгөл ирсэн ч дуусахгүй. Тэдний хайртай хүмүүс шархдсан уу, шоронд хоригдсон уу, аль эсвэл нас барсан уу?

**Боломжит асуултууд:**



- Ор сураггүй алга болсон хүмүүсийн талаар мэдээлэл олдохгүй байгаа бол эрэн сурвалжлах хүчин чармайлтаас гадна ямар нэмэлт үйл ажиллагаа явуулж болох вэ? [Багш нарт зориулсан эх сурвалжаас жишээнүүдийг хар.]
- Зэвсэгт мөргөлдөөний үеэр ор сураггүй алга болсон хүмүүсийн тухай мэдээлэл цуглуулахад ямар учраас хүндрэлтэй байдаг вэ?

**Хаалт**

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн нэгэн нийтлэл болох *Гэр бүлийн хүмүүсийг эрэн сурвалжлах, дахин нэгтгэхтэй холбоотой хуулийн заалтууд*—ын хэсгийг уншаад гэр бүлийн гишүүдийг эрэн сурвалжлах, тэдний холбоог сэргээх явцад эдгээр хууль дүрэм хэрхэн тус нэмэр болох талаар сурагчдаас юу бодож байгааг нь асууж ярилцана.

[Жишээ нь: Удирдлага, эрх мэдэлтнүүд хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллаж өөрсдөд байгаа бүхий л мэдээллээр хангах, тухайлбал, саатуулагсдын нэрсийн жагсаалтыг өгөх, мөн хүмүүнлэгийн ажилчдыг Улаан Загалмайн мэдээ тараах болон шалгахыг зөвшөөрөх, олзлогчид хоригдлуудыг гэр бүлийнхэнтэй нь холбоотой байлгах]

**ГОЛ САНААНУУД**

- Зэвсэгт мөргөлдөөний улмаас олон тооны хүмүүс гэр бүлийнхнээсээ холбоо барих ямар ч аргагүйгээр хагацдаг.
- Хүмүүнлэгийн эрх зүй нь тарж бутарсан гэр бүлийнхнийг дахин нэгтгэх зэргээр гэр бүлийн холбоог сэргээх, хэвээр үлдээх үйл ажиллагааг шаарддаг.
- Гэр бүлийн гишүүдийг олж тогтоон дахин нэгтгэх нь олон үе шаттай.

## Нэмэлт дасгал

### Гэр бүлийн гишүүд алга болсонд зовж, шаналж буй хүмүүс

Ор сураггүй алга болсон гэр бүл, хамаатан садныхаа талаар ямар нэг мэдээлэл байхгүйд зовж шаналж байгаа хүмүүсийн талаар, тэдний хайртай хүмүүс шархадсан, шоронд хоригдсон, алга болсон, өлссөн, аль эсвэл нас барсан эсэх нь тодорхойгүйд шаналж байгаа хүмүүсийн талаар эргэцүүлэн бодно.

Тэдгээр хүмүүсийн зовлон шаналлыг харуулсан богино хэмжээний шүлэг, эссе бичнэ.

> Би одоо хүртэл миний нөхөр амьд бөгөөд бидэндээ эргэн ирж урьдын адил хэвийн амьдрах болно гэж итгэсээр байгаа. Гэвч би түүнийг одоо хаана яаж амьдарч яваа талаар мэдмээр байна. Над шиг хүмүүс мянга мянгаараа бий. Бид асуултандаа зохих хариултыг авах ёстой.
>
> — Нөхөр нь Боснийн Армид хурандаа байсан, алга болоод хэдэн жил болж байгаа хүний эхнэр

**Итгэлийн зурвас**
Дараах өгүүллийг уншина уу.

> **Манилаас Багдад хүртэл: Гэр бүлийн мессэж дахь итгэл найдвар**
>
> Мариа өглөө бүр радиогийн мэдээ сонсдог байлаа. Персийн булангаас ирсэн өнөөдрийн мэдээ их түгшүүртэй байв. Багдадыг бөмбөгдөж эхэлжээ. Мариа ойрд сураг чимээ ирээгүй Иракт сувилагч хийдэг эгчийнхээ төлөө ихэд санаа зовно. Филиппин Багдад хоёрын хоорондох утасны шугам тасарч, шуудангийн үйлчилгээ байхгүй боллоо. Мариа эгчийгээ харахгүй бололтой хэмээн цөхрөнгөө барна.
>
> Хэд хоногийн дараа Манила дахь Филиппиний Улаан Загалмай эрэн сурвалжлах ажил хийж байгаа талаар сонсов. Энэ мэдээг сонсоод Мариа тэр даруй гүйн очив. Тэрээр Ирак дахь ОУУЗХ—ны төлөөлөгчдөөр дамжуулан эгчид нь хүргэж өгөх гэр бүлийн мэдээний талаар сонсоод ихэд урам орлоо. Сар болоо ч үгүй байхад Улаан Загалмайгаас түүний захианд хариу ирсэн болохыг мэдэгдэн ярилаа. Тэр баярын нулимс унагаав — хайртай эгч нь амьд байжээ.

Мариа эгчдээ юу гэж бичсэн болон эгч нь түүний захианд хэрхэн хариу бичсэн талаар ярилцаж, бичнэ.

# Нэмэлт дасгал

**Гэр бүлийн холбоог сэргээх**

Зургийн эвлүүлгийг дахин үзнэ үү. Сэтгэл хөдлөл ямар олон янзаар илэрхийлэгдсэн байгааг олж харна.

Гэр бүлийн гишүүдийг эрэн сурвалжлах болон дахин нэгтгэх талаар мэдээлсэн зурагт хуудас хийнэ. Ямар мэдээ хэрэглэх вэ?

ЭСВЭЛ

Дараах өгүүллийг уншаад гэр бүлийнхэн нэгдэж байгаа сэтгэл хөдлөлийг харуулсан ямар нэгэн урлагийн бүтээл туурвина.

**Улаан Загалмайн мэдээг хүсэн хүлээсэн гурван эмэгтэй**

Хойд Албанид байх хуучирсан зуны байшингийн том өрөөнд зүү унах нь сонсогдом нам гүм. Тосгоны хөгшин Андие Корточи, Улаан Загалмайн мэдээг уншиж эхлэв. Хуудсууд түүний шир болсон гарт үрчийх боловч хэн ч анзаарсангүй. Түүнийг хүрээлэн зогссон гурван эмэгтэй үг нэг бүрийг нь амьсгаа даран чагнана.

Тэд бүгдээрээ мэдээ авсан байлаа, нэг нь дүүгээсээ, нэг нь нөхрөөсөө, тэгээд бас нэг нь хүүгээсээ авсан байсан бөгөөд тэд нар нь Косовогийн мөргөлдөөнд байлдаж байгаад Сербид түр саатуулагдсанаас хойш 2 жил өнгөрчээ.

3 саатуулагсад бүгдээрээ Михежан тосгоноос гаралтай ба тэдний эзгүй байгаа нь гэр бүлийнхэнд нь хүнд тусч байгаа билээ. Тэдний тариалангийн ажил, мал маллах зэрэг бас бус ажлыг тосгоныхон ээлж дараалан гүйцэтгэнэ. Заримдаа хүүхдүүд ч туслалцана.

Албаний Улаан Загалмайн ажилтан Селим Муса 3 сард нэг удаа салаар Михежан тосгонд ирж, Тиранаар дамжин Сербээс ирсэн Улаан Загалмайн мэдээг тараана. Михежан руу цөөн тооны хүмүүс ирдэг болохоор тосгоныхон холоос барааг нь хараад л хэн ирж байна гэдгийг хэлж мэднэ. Селим Муса бол Албанид үлдсэн цорын ганц саатуулагсад болон тэдний гэр бүлийнхний хоорондын гүүр юм.

– ОУУЗХ – ны Мэдээ, 2001 оны 3 – р сар

# Гэр бүлийн хүмүүсийг эрэн сурвалжлах болон тэднийг дахин нэгтгэхтэй холбоотой хуулийн заалтууд

### 1949 оны 8–р сарын 12–ны Женевийн Конвенцуудын нэмэлт 1–р протоколоос 78–р зүйл

1. **Хүүхдийг нүүлгэн шилжүүлэх**

   Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлын шаардлага, түүнчлэн тэдний эрүүл мэндийн болон эмчлэх зорилгоор түр хугацаагаар нүүлгэх шаардлага байгаагаас бусад тохиолдолд мөргөлдөөнд оролцогч аль ч тал харъяат бус орны хүүхдүүдийг гадаад улс руу нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. Хүүхдийн эх эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч нь олдвол хүүхдийг нүүлгэн шилжүүлэх талаар тэднээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. Хэрэв ийм хүмүүс олдохгүй бол хууль буюу зан заншлийн дагуу хүүхдийг асран хамгаалах гол хариуцлагыг хүлээж байгаа хүнээс нүүлгэн шилжүүлэх тухай бичгээр зөвшөөрөл авах хэрэгтэй...

### 1994 оны 6–р сарын 24–нд ОУУЗХ, НҮБ–ын Дүрвэгсдийн асуудлыг хариуцсан Дээд Комисс болон Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооноос Рванда дахь хараа хяналтгүй хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэх талаар хийсэн хамтарсан мэдэгдэлээс

Рвандагийн өнөөгийн нөхцөл байдалд салж хагацсан гэр бүлийн хүмүүсийн талаар баттай мэдээлэл авна гэдэг боломжгүй зүйл. Хамаатан садных нь хүмүүсийг олж илрүүлэх боломж олдтол, Рванда дахь хараа хяналтгүй хүүхдүүдийн ойрын хамаатан садан Рвандад болон хөрш зэргэлдээ улс орнуудад байх ёстой хэмээн үзнэ.

Хүүхдүүд болон тэдний хамаатан садны хүмүүсийг аль болох эртхэн нэгтгэх ажлыг хийхтэй холбогдуулан нүүлгэн шилжүүлэх, хүлээн авах болон халамж үйлчилгээг төлөвлөх хэрэгтэй.

Онцгой нөхцөл байдалд байгаа хүүхдийг үрчлүүлж болохгүй. Хараа хяналтгүй ихэнх хүүхдүүд өнчин биш учраас тэднийг үрчлүүлэх бус, гэр бүлийнх нь гишүүдтэй дахин нэгтгэх үүднээс тохиромжтой түр зуурын халамж үйлчилгээ үзүүлнэ.

### Холбогдох хуулийн заалтыг тоймлон дүгнэх нь:

**Сарнисан гэр бүлийн гишүүдийг нэгтгэх**
Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд зэвсэгт мөргөлдөөний уршгаар сарнисан гэр бүлийг нэгтгэхэд бололцоотой бүх арга хэлбэрээр дэмжлэг үзүүлэх бөгөөд, тухайлбал, энэ зорилтыг хэрэгжүүлж байгаа хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагааг Конвенцууд болон энэхүү протоколын заалтууд, өөрсдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмын дагуу хөхиүлэн дэмжинэ. (Нэмэлт 2 – р Протокол, 74 – р зүйл)

**Ор сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах**

Мөргөлдөөнд оролцогч тал бүр дайны уршгаар сарнисан гэр бүлтэйгээ холбоо тогтоох зорилгоор хайхад хөнгөвчлөх, хэрэв боломжтой бол тэднийг нийлүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Энэхүү үйл хэрэгт ажил үйлсээ зориулж байгаа болон тэр гүрний хувьд хүлээн зөвшөөрсөн, түүний аюулгүй байдалд нийцсэн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ. (4 – р Конвенцийн 26 – р зүйл)

Гэр бүлийн гишүүд ор сураггүй алга болсон хамаатан садныхаа тухай мэдээлэл авах эрхтэй. Мөргөлдөөнд оролцогч талууд эсрэг талынхан алга болсон хэмээн мэдээлсэн хүмүүсийг хайж олох үүрэгтэй. ( Нэмэлт 1 – р протоколын 32, 33 – р зүйл)

# Гэр бүлийн холбоог сэргээх

**Хараа хяналтгүй хүүхдүүд болон бусад эмзэг хүмүүс**

Зэвсэгт мөргөлдөөн, олноор нь нүүлгэн ши лжүүлэх, хямралын нөхцөл байдал зэрэг онцгой үед хүүхдүүд эцэг эх, гэр бүлийнхэн болон бусад хариуцлагатай насанд хүрэгчдээсээ салдаг. Тэдний статус нь ихэвчлэн тодорхой бус боловч, "өнчин" гэхээсээ илүү "салсан буюу хараа хяналтгүй хүүхэд" гэж хэлдэг.

Мөн өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мөргөлдөөний үед хүнд байдалд орж болзошгүй. Тэд гэр бүлийнхээ гишүүдийн ард хоцорч, хамаатан садангаасаа тусгаарлагдах буюу салах бөгөөд өөрсдөдөө анхаарал халамж тавьж чаддаггүй. Эдгээр эмзэг байдлын улмаас ОУУЗХ гэр бүлийн холбоог нь сэргээх ба тэднийг хамгаалах талаар тусгай арга хэмжээ авдаг.

**Хоригдлууд болон тэдний гэр бүлийн хоорондын сүлжээ**

Үүрэг даалгаврынхаа дагуу ОУУЗХ нь мөргөлдөөний улмаас эрх чөлөө нь хасагдсан хүмүүсийн талаар мэдээлэл олж, түр саатуулагдаж байгаа газар нь эргэж очихын тулд бүхий л талаар хүчин зүтгэдэг. Эдгээр уулзалтаар ОУУЗХ—ны төлөөлөгчид, гэр бүлийнхэнд нь тэдний хамаатан садны талаар мэдээлэх боломжтой болж, Улаан Загалмайн мессэжний сүлжээгээр дамжуулан хоригдлууд болон тэдний гэр бүлийнхнийг хооронд нь холбох ажлыг хийдэг байна.

**Гэр бүлийн холбоог сэргээхэд компьютерийн технологийг ашиглах**

ОУУЗХ дайны хоригдлуудын тухай цуглуулсан бүхий л мэдээллийг мэдээллийн сан болгон эмхлэн дэлхий даяар тархсан төлөөлөгчийн газраа төвлөрүүлэн компьютерт оруулдаг. Энэхүү ажлын гол зорилго нь Улаан Загалмайгаар дамжуулан онцгой анхаарал тавих шаардлагатай халамжлуулагчдын нөхцөл байдлыг, алга болсон хүмүүсийн хаана байгааг тодорхой болгох, гэр бүлийн холбоог сэргээх, хамгаалалтыг нь баталгаажуулахын тулд цаг үргэлж тэдний мэдээллийг шинэчилснээр хянах явдал юм. Олон нийтэд мэдээлэл түгээх, хуваалцахдаа болгоомжтой байж, нууцлалыг эрхэмлэнэ.

ОУУЗХ 70 орчим мэдээллийн сантай бөгөөд голчлон Рванда (448000 хувь хүмүүсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл), Персийн Булангийн дайн (123000), Израйль, эзэлсэн болон өөртөө засах улсууд (152000), Хуучин Югослав (140000), Шри Ланк (37000), Сомали (31000), Перу (27000), Колумб (24000) болон Афганистан (25000) зэрэг орнуудын тухай байдаг байна.

**Тоо баримт**

- Зүүн Тиморт 1999 оны мөргөлдөөнөөс хойш Улаан Загалмайн 55000 гаруй мэдээг 8 сарын дотор тараасан.
- 2000 онд Арчилсан Конго улсад 200000—аас илүү мэдээг улс даяар ажиллах 120 үйлчилгээний байгууллагаар илгээж, хүлээн авсан байна.
- 2001 онд нийт 1 сая гаруй Улаан Загалмайн мэдээ дэлхий даяар солилцсон байна.

### Гэр бүлийн холбоог сэргээх үйл ажиллагаа

Энэхүү үйл ажиллагаа нь зэвсэгт мөргөлдөөн буюу бусад хүчирхийллийн нөхцлийн улмаас гэр бүлээсээ салсан хүмүүсийн холбоог сэргээж, сэтгэл санаа нь зовниж буй түр саатуулагсдын зовлонг нимгэлэхэд чиглэгдэнэ. Тухайлбал:

- Гэр бүлийнх нь талаар мэдээллээр хангах (Улаан Загалмайн мэдээ, радио нэвтрүүлэг, утас, интернетээр) дэлхий нийтийн Улаан Загалмай Улаан Хавирган Сарын сүлжээрээр (Үндэсний Нийгэмлэгүүд болон ОУУЗХ—ны төлөөлөгчид);
- Нутагт нь буцаах, гэр бүлийг нэгтгэх ажлыг зохион байгуулах;
- Гэр бүлийнхнийг нь түр саатуулагсадтай уулзуулах буюу байлдааны зурваст очих боломжтой болгох;
- Мөргөлдөөний улмаас биеийн байцаалт, үнэмлэх огт байхгүй болсон, удахгүй нутагтаа буцах гэж байгаа, эсвэл 3—дагч оронд суурьших гэж байгаа хүмүүст аялалд зориулсан бичиг баримтыг ОУУЗХ—ноос олгоно.

### Ор сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах үйл ажиллагаа

Энэхүү үйл ажиллагаа нь ор сураггүй алга болсон хүмүүсийн хаана ямар газар байгааг эрэн сурвалжлах, хайж олоход чиглэгдэнэ. Тухайлбал:

- Алга болсон хүмүүсийн гэр бүлээс нь эрэн сурвалжлах хүсэлтийг хүлээж аваад, түр саатуулагдаж буй хүмүүс, алга болсон, нас барсан хүмүүсийн талаар мэдээлэл цуглуулж, түүнийгээ удирдлага, эрх мэдэлтнүүдэд өгнө;
- Цогцсыг тодруулах, ухаж гаргаж ирэх зэргээр эрэн сурвалжлах ажлыг түргэвчлэх үүднээс алга болсон хүмүүсийн гэр бүлийн гишүүн, эрх мэдэлтнүүдийг холбох механизмыг бий болгоно;
- Алга болсон хүмүүсийн гэр бүлийн гишүүдийг дэмжих, тэдэнд мэдээлнэ.

— ОУУЗХ—ны жилийн тайлангууд, 1999, 2000 он

### Жишээнүүд

1999 оны Косовогийн дайн дууссаны 18 сарын дараа ч, 3600 гаруй хүмүүсийг гэр бүл, хамаатан садан нь хайж байгаа билээ. Эдгээр алга болсон хүмүүсийн талаар эрэн сурвалжлах хүсэлт олон тоогоор ирсэн боловч, ОУУЗХ ямар ч сураг чимээ гаргаж чадсангүй. Тэдгээр алга болсон хүмүүсийн талаар нэмэлт мэдээлэл олж авахын тулд интернетэд нэрсийн жагсаалтыг нтавьсан байгаа.

Босни—Герцеговинид ОУУЗХ 344 хэн нь тогтоогдоогүй нас барсан хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлсийн зурагтай ном хэвлүүлж гаргасан. Энэхүү номыг ар гэрийнхэн нь үзэхэд их хүндрэлтэй хэцүү байсан боловч олон хүмүүст алга бологсдыг олоход тус болсон. Дайн дуусаад 5 жил өнгөрсөн одоо ч гэсэн 18000 хүний ор сураг тодорхойгүй хэвээр байсаар байна.

Ойрхи Дорнодод, ОУУЗХ—гоор удирдуулсан Гурван Талт Зөвлөл 1991 оны Персийн Булангийн дайны үед алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах ажлыг хийж байна. Гэсэн хэдий ч эдгээр хүмүүсийг хайж олоход нилээд бэрхшээлийг амсч байна.

# Эрэн сурвалжлахыг хүссэн өргөдөл

/эмблем/ Эрэн сурвалжлуулах хүсэлт

**1. Эрэн сурвалжлах хүн.**
ОУУЗХ – ны ...

Овог нэр (бичиг баримтан дээрх)......................................................
Хоч болон бусад нэр.........................................................................
Төрсөн он сар өдөр............................................ Хүйс: эрэгтэй/ эмэгтэй
Төрсөн газар.......................................................................................
Эцгийн овог нэр..................................................................................
Эхийн овог нэр....................................................................................
Яс Үндэс.................................................Гарал....................................
Мэргэжил......................................................................Гэрлэлтийн байдал
Анхны нэр...........................................................................................
Эхнэр, нөхрийн нэр.............................................................................

Анги.........................................................................Бүлэг.................. ..........
Үйлчилгээний дугаар................................................хэрвээ байгаа бол

**2. Хүсэлтийн тухай**

Сүүлд сонссон мэдээ, он сар өдөр
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................

Сүүлд амьдарч байсан газрын хаяг
..............................................................................................................
Холбоо тасрах болсон шалтгаан, нөхцөл байдал
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................

**3. Алга болсон хүнийг эрэн сурвалжлуулах гэр бүлийн гишүүд**

| | |
|---|---|
| Овог нэр | Төрсөн он сар өдөр |
| Хүйс | Ямар хамаатан болох |

..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................

**4. Нэмэлт мэдээлэл**

Эрэн сурвалжлахад тус болох бүхий л мэдээллийг өгнө үү. Жишээлбэл: Өмнө нь амьдарч байсан газрын хаяг, хэр удаан амьдарч байсан, өмнө нь ажиллаж байсан газрын хаяг, хамгийн сүүлд ажиллаж байсан газрын хаяг, ямар шашин шүтдэг, гэх мэт.

.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................

---

**5. Тухайн хүний талаар мэдээлэл өгч чадах хүмүүсийн нэр хаяг**

Гэр бүлийн гишүүд, найз нөхөд, ажлын холбоотой танилууд, гэх мэт.

.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................

---

**6. Хүсэлт гаргагч**

Овог нэр
.............................................................................................................

Анхны нэр
.............................................................................................................
Төрсөн он сар өдөр.........................................................................................
...........Хүйс: эмэгтэй/ эрэгтэй
Төрсөн газар, орон
.............................................................................................................
Хаяг
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
Утас.........................................................................................................
И—мэйл.....................................................................................................
Эрэн сурвалжлуулах гэж байгаа хүн бол миний...........................
.............................................................................................................
Хүсэлт гаргагчийн гарын үсэг.........................................................
.............................................................................................................
Хүсэлт гаргасан газар, он сар өдөр

**Олон Улсын Улаан Загалмайн хороо**

# Улаан Загалмайн мэдээний маягт

1. /эмблем/ **Улаан Загалмайн мэдээ**

2. Илгээгч

Овог нэр (бичиг баримтан дээрх)
..........................................................................................................
Төрсөн он сар өдөр.....................................................................
.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй
Эцгийн нэр...................................................................................
Эхийн нэр....................................................................................
Бүрэн гүйцэд хаяг........................................................................
Муж, улс орон..............................................................................

3. Хүлээн авагч

Овог нэр (бичиг баримтан дээрх)
..........................................................................................................
Төрсөн он сар өдөр.....................................................................
.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй
Эцгийн нэр...................................................................................
Эхийн нэр....................................................................................
Бүрэн гүйцэд хаяг........................................................................
Муж, улс орон..............................................................................

4. Олон улсын Улаан Загалмайн хороо

5. **Мэдээ**
**(гэр бүлийн ба/буюу хувийн мэдээ)**

6. Он сар өдөр:................................ Гарын үсэг:...............................

Хүлээн авагч бол миний... .................................................................

**Судалгаа 5 D. Гэр бүлийн холбоог сэргээх** **Эх сурвалж 3**

# /хариу захиа/

1. Улаан загалмайн мэдээ

---

8. Илгээгч:

Овог нэр (бичиг баримтан дээрх)
..........................................................................................................
Төрсөн он сар өдөр..........................................................................
.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй
Эцгийн нэр.........................................................................................
Эхийн нэр.........................................................................................
Бүрэн гүйцэд хаяг...............................................................................
Муж, улс орон.....................................................................................

---

9. Хүлээн авагч
Овог нэр (бичиг баримтан дээрх)
..........................................................................................................
.....................
Төрсөн он сар өдөр..........................................................................
.........................Хүйс: Эрэгтэй/ Эмэгтэй
Эцгийн нэр.........................................................................................
Эхийн нэр.........................................................................................
Бүрэн гүйцэд хаяг...............................................................................
Муж, улс орон.....................................................................................

---

10. Олон улсын Улаан Загалмайн хороо

---

11. ....................................өдрийн захианы хариу

(гэр бүлийн ба/буюу хувийн мэдээ)

---

---

13. Он сар өдөр:................................. Гарын үсэг:..........................

Хүлээн авагч бол миний ..................................................................

# Баримт хуудас: Рванда хүүхдүүд

Рвандад 1994 онд болсон геноцид болон дайн хүмүүсийг олноор нь дүрвүүлж, хүүхдүүд алагдан шархдаж, гэр орноо орхин явсан ба эцэг эх нь алагдсан хүүхдүүд ч гэр орноосоо дайжсан байна. Эдгээр хүүхдүүдийн амь насыг аврахын тулд зарим байгууллага, хувь хүмүүс ойролцоох улсууд болох Африк, Европ руу аваачиж байв.

Жишээ татвал, Франц цэргүүд 1994 оны 4—р сард 72 хүүхдийг Францад өөрсдийн бүсийн захиргааны эзэмшил газарт аваачсан. *Эдгээр хүүхдүүд гэртээ харина гэдэг нь тодорхой байлаа. Бид тэдэнд аль болох л гэртээ байсан шиг амьдруулахыг хүсч, гэртээ харих боломж гарна хэмээн ойлгуулахыг хичээдэг байв. Бид хүүхдүүдэд Рванда болон Франц хэл заан сургаж байсан* хэмээн Франц офицер ярилаа.

1996 оны 7—р сард эдгээр хүүхдүүдийн 46 нь Рванда руу буцаж явсан юм. Улаан Загалмай 20 хүүхдийн гэр бүлийнхнийг олж тогтоон, 26 хүүхдүүдийн гэр бүлийхнийг эрэн сурвалжилж байлаа. *Хэрвээ хайлт амжилтгүй болвол тэднийг асран хүмүүжүүлж чадах айлд үрчлүүлэн өгнө. Тэдэнд үзүүлэх тусламцаа амьдралын үндсэн хэрэгцээг нь хангах гэсэн хэлбэртэй байна* хэмээн Улаан Загалмайн нэгэн ажилтан ярилаа.

Рвандад болсон үйл явдлаас 6 жилийн дараа 2000 оны сүүлээр, Рвандад буюу гадаадад байгаа хэмээн хүмүүнлэгийн байгууллагуудаар бүртгэгдсэн 74700 хараа хяналтгүй хүүхдүүдийн 67000—г нь гэр бүлийнхэнтэй нь нэгтгэсэн байна.

**1949 оны 8—р сарын 12—ны Женевийн Конвенцуудын нэмэлт 1—р протоколоос 78—р зүйл**

1. Хүүхдийг нүүлгэн шилжүүлэх

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлын шаардлага, түүнчлэн тэдний эрүүл мэндийн болон эмчлэх зорилгоор түр хугацаагаар нүүлгэх шаардлага байгаагаас бусад тохиолдолд мөргөлдөөнд оролцогч аль ч тал харъяат бус орны хүүхдүүдийг гадаад улс руу нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. Хүүхдийн эх эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч нь олдвол хүүхдийг нүүлгэн шилжүүлэх талаар тэднээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. Хэрэв ийм хүмүүс олдохгүй бол хууль буюу зан заншлийн дагуу хүүхдийг асран хамгаалах гол хариуцлагыг хүлээж байгаа хүнээс нүүлгэн шилжүүлэх тухай бичгээр зөвшөөрөл авах хэрэгтэй...

**1994 оны 6—р сарын 24—нд ОУУЗХ, НҮБ—ын Дүрвэгсдийн асуудлыг хариуцсан Дээд Комисс болон Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооноос Рванда дахь хараа хяналтгүй хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэх талаар хийсэн хамтарсан мэдэгдэлээс**

Рвандагийн өнөөгийн нөхцөл байдалд салж хагацсан гэр бүлийн хүмүүсийн талаар баттай мэдээлэл авна гэдэг боломжгүй зүйл. Хамаатан садных нь хүмүүсийг олж илрүүлэх боломж олдтол, Рванда дахь хараа хяналтгүй хүүхдүүдийн ойрын хамаатан садан Рвандад болон хөрш зэргэлдээ улс орнуудад байх ёстой хэмээн үзнэ.

Хүүхдүүд болон тэдний хамаатан садны хүмүүсийг аль болох эртхэн нэгтгэх ажлыг хийхтэй холбогдуулан нүүлгэн шилжүүлэх, хүлээн авах болон халамж үйлчилгээг төлөвлөх хэрэгтэй.

Судалгаа 5D—д хүмүүнлэгийн ажилчдад тулгарч болох зарим дилеммаг авч үзнэ. Сурагчид хүмүүнлэгийн үйл ажилагааны хоёр зарчим болох төвийг сахих болон шударга байдлын тухай судална. Тэд мини—загварчилсан судалгаагаар дээрх зарчмуудын утгыг ойлгох ба хүмүүнлэгийн ажилчдад жинхэнэ тулгарах дилеммад анализ хийснээр амьдралд хэрхэн хэрэгждэгийг мэдэж авах болно. (Энэ хичээлд дурдсан судалгааны дагуу загварчилсан судалгаануудыг нэг дор бүгдийг нь, эсвэл тусад нь судлан үзэж болно.)

**Зорилго:**

- Хүмүүнлэгийн үйл ажиллагааны удирдамж болох "төвийг сахих" болон "шударга байх" зэрэг зарим зарчмуудыг мэдэж байх
- Хүмүүнлэгийн ажилтан үүрэгт ажлаа явуулж байх үед тулгарах зарим дилеммаг ойлгох

**Ашиглах материалууд:**

- Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ажиллах зарчмууд

**Хугацаа:**

45—60 минутын нэг удаагийн хичээл

*Төвийг сахих (аль нэг талыг барихгүй байх)*

Аливаа хүний итгэлийг олж авах, хадгалахын тулд, хүмүүнлэгийн ажилтан мөргөлдөөн, зөрчилдөөний үед аль нэг талыг барьдаггүй.

*Шударга байх (хүмүүсийн шаардлага хэрэгцээнд тулгуурлахыг эрхэмлэх)*

Хүмүүнлэгийн ажилтан аливаа хүнийг яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, нийгмийн анги давхарга болон улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлаж үл болно. Тэд зөвхөн хувь хүний шаардлага хэрэгцээний дагуу хамгийн хэрэгцээтэй үед нь туслах ёстой.

*Бие даасан (дарамт шахалтыг эсэргүүцэх)*

Хүмүүнлэгийн байгууллага хүмүүнлэгийн шаардлага хэрэгцээний дагуу идэвхитэй үйл ажиллагаа явуулах үүднээс олон улсын байгууллага, засгийн газар, хандивлагчид гэх мэт бусад гадныг байгууллагын нөлөөнд орохгүй байх, үзүүлэх дарамт шахалтыг эсэргүүцэх ёстой.

**1. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ажиллах зарчим**
(5 Минут)

Хүмүүсийн ажлаа явуулахад удирдлага болгож байгаа зарчмын талаар ярилцана.

**Боломжит асуултууд:**

- Хүмүүсийг мэргэжлийн ажлаа хийж гүйцэтгэхэд зан үйлийг нь бүрдүүлдэг ямар нэгэн онцгой хууль дүрмийн талаар мэдэх үү?
  *[Жишээ нь: Эмч нарын дагаж мөрдөх ёстой дүрэм журам болох Хиппократын тангараг, сэтгүүлчдийн ёс зүйтэй холбоотой хуулийн тогтоомжууд, тухайлбал, сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн хүнд мэдээллийг өгсний улмаас аюул тулгарах тохиолдолд нууцыг чандлан хамгаалах гэх мэт.]*

- Хүмүүнлэгийн ажилчид зэвсэгт мөргөлдөөний хохирогчдод туслах ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд ямар зарчмыг дагах ёстой гэж бодож байна вэ?

**2. Ажиллах зарчмыг амьдралд нэвтрүүлэх**
(15—20 минут)

Ихэнх хүмүүнлэгийн байгууллагууд төвийг сахих, шударга байх, бие даасан зэрэг зан үйлийн дүрэм журамтай байдаг.

1—р эх сурвалжид дурдсан зарчмыг зарим нөхцөлд хэрэглэх талаар ярилцана.

Тохиолдол бүрт доорх асуултуудыг тавина. Үүнд:

- Хэрвээ тэд хүмүүнлэгийн ажилчид байсан бол үүнд хэрхэн хариулах байсан бэ?
- Тэдний хариултын цаана ямар зарчим үйлчилж байна вэ?
- Эдгээр тохиолдлуудад хүмүүнлэгийн ажилтны хамгаалах ёстой гол бодолцож үзэх зүйл юу вэ?

Тэдний санал бодлын талаар бүгдээрээ ярилцана. Бүлэг тус бүр хүмүүнлэгийн ажилтан шийдвэр гаргахад төвийг сахисан болон шударга байдал хэрхэн нөлөөлдөг талаар эргэцүүлэн бодно. Ихэнх нөхцөл байдалд дээрх хоёр зарчим хамтдаа хэрэгжиж байдгийг сурагчдад ойлгуулна.

Төвийг сахих, шударга байх нь дангаараа зорилго биш бөгөөд энэ нь хүмүүнлэгийн зорилтод хүрэх арга хэрэгсэл, хэрэгцээтэй хүмүүст туслах, тэднийг хамгаалахад л гол зорилго нь оршиж байгаа юм.

> ОУУЗХ—ны төвийг сахих (нэг талыг барихгүй), шударга байх (хэрэгцээн дагуу хохирогчдод үйлчлэх), бие даасан (улс төрийн нөлөөнд автахгүй) байх зарчмууд нь ОУУЗХ—оос, эрх ашгийн сонирхол бүхий өрсөлдөгч бүлэг үйл ажиллагааг нь өөрсдийн болгох буюу эсрэг талд үзүүлэх тусламж, үйлчилгээг нь няцаах гэсэн оролдлогыг эсэргүүцэхийг шаарддаг. Энэхүү эсэргүүцэл нь хүчирхийлсэн бус, нэг талын намын байр суурийг үл баримталсан байна. (...) Үр дүнд нь, ОУУЗХ—ны төлөөлөгчид тэвчээртэй, болгоомжтой, хүчирхийлсэн бус (...) байж, дилемматай эвлэрч чадахаар байх ёстой.
>
> — Никола Бери, Дайн ба Улаан Загалмай

**3. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүйн дилемма**
(15—20 минут)

Хүмүүнлэгийн үйл ажиллагаа зарим тохиолдолд шүүмжлэл, асуудалд өртдөг. Шүүмжлэгчид ихэнх тохиолдолд хүмүүнлэгийн ажилчдын үүрэгт ажлаа явуулж байх үед тулгарах ёс суртахууны дилеммаг шүүмжилдэг.

Сурагчдаас доорх нөхцөл байдалд тулгарах ёс зүйн дилеммаг олж илрүүлээд ямар хариу үйлдлээр арга хэмжээ авахыг шийдэж, шүүмжлэлд өртөхгүйн тулд ямар маргааныг боловсруулахыг нь асууна.

**A. Бид дайныг удаашруулж байна уу?**
Дайны хөлд нэрвэгдсэн бүс нутгийн цөхөрсөн энгийн иргэдэд туслахаар тусламжийн байгууллагынхан ирсэн. Тусламжийнхан энгийн иргэдийг амьд үлдэхэд туслахаар гадны дэмжлэг үзүүлсэн болохоор дайн эхлүүлсэн тал иргэдийнхээ хэрэгцээг үл ойшоох боломжтой болов. Энэхүү гадны тусламж нь цэргүүдээ хангахын тулд өөрсдийн улсын бүхий л нөөцөө шавхан дайчлах бололцоо олгосон юм. Энэ нь дайныг үргэлжлүүлэхэд тус болсон.

**B. Бид үндэстнийг бутаргах бодлогыг дэмжиж байгаа юу?**
Энгийн иргэд "үндэстэн угсаатны цэвэрлэгээ" бодлогын хохирогчдод зориулан байгуулсан орогнох байр болох Хамгаалалтын Бүс рүү дүрвэн зугтсан. Хүмүүнлэгийн ажилчид уг бүсээс хүмүүсийг дүрвэгсдийн байр луу гадаад шилжүүлсэн байна. Энэхүү хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь хохирогчдыг эх орноос нь нүүлгэн шилжүүлснээр үндэстэн угсаатны цэвэрлэгээнд хувь нэмэр оруулсан юм.

**C. Хүмүүнлэгийн үйл ажиллагаа улс төрчдийн үл оролцооны далим болж байна уу?**
Хоёр улс дайн байлдааны байдалтай байхад шархдаж алагдсан хүн тоо томшгүй олон байдаг. Зарим орны дуу хоолой дайнд золиос бологсдын хүнд хэцүү байдлыг буруушаах боловч, ямар ч гадны засгийн газар тэмцэлдэж буй хоёр талыг зогсоох, тэдэнд шахалт үзүүлэх болон энгийн иргэдийг чөлөөлөх бодлого явуулах төлөвгүй байв. Хүмүүнлэгийн нэгэн ажилтан харамсан ийнхүү өгүүлж байна: "Бид хүмүүнлэгийн тусламжийг *далайн ганцхан дусал* мэт өчүүхэн гэдгийг мэдсээр атлаа тусламж үзүүлсээр байдаг нь ямар утгатай вэ. Гадны улс төрийн дарамт буюу цэргийн оролцоогүйгээр хүмүүнлэгийн байгууллагууд дэлхий ертөнцөд зөвхөн зөв ухамсрыг л төлөвшүүлж чадна."

**D. Бид энгийн иргэдийн албадан нүүлгэн шилжүүлэлтэд хориг тавьж байна уу?**
Боcлого гаргагчид орогнож байсан тулалдааны бүст тосгоны хяналтыг бэхжүүлэхийн тулд энгийн иргэдийг гэрээс нь 30 километрийн зайд албадан суурьшуулав. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэгсдээс хоол хүнс, эм тариа лагерь луу авчрахыг гуйсан. Ингэснээрээ энгийн иргэдийн албадан нүүлгэн шилжүүлэлтэд хориг тавьж байгаа хэрэг юм.

**Дөрөв. Нууц хадгалалтын зарчим** (15–25 минут)
Сүүлийн 2 жилийн турш Олон Улсын Улаан Загалмайн Хорооны (ОУУЗХ) төлөөлөгчид Непалийн шоронгуудаар явж 600 гаруй түр саатуулагсадтай уулзаж байснаас ихэнх нь Маоистуудын хөдөлгөөнд оролцож байсан хүмүүс байв. Бид тэдгээр саатуулагсдын талаар, тэд ямар нэгэн дарамт шахалтанд байдаг эсэх талаар Непал дахь байгууллагын төлөөлөгчдийн ахлагч Жан–Жак Бовэй–ээс асуухад тэрээр: "Ингэх нь ОУУЗХ–ны зарчмыг зөрчсөн хэрэг болно. Бид нөхцөл байдлын

Ёс суртахууны дилеммаг аливаа эрхэм зорилгын эрмэлзэл нь өөр эрхэм зорилготой харшилдах, эсвэл хор уршиг болон эерэг үр дүнд хүргэх нөхцөл байдал хэмээн тодорхойлж болох юм.
Бид бусад хүмүүсийн нэгэн адил эгэл жирийн амьдрах эрхтэй. Одоо дэлхий ертөнцийн хийж байгаа зүйл өчүүхэн байна. Хэрвээ хүссэн л бол эхэн үед нь энэ бүхнийг зогсоож болох байсан юм.

– 6 жилийн турш вагончикт амьдарч байгаа эмэгтэй, Босни–Герцеговинад болсон зэвсэгт мөргөлдөөний дараа

ЖИЧ: Сурагчид хүмүүнлэгийн хүчин чармайлтыг үргэлжлүүлэх үү үгүй юу, яагаад, яагаад үгүй гэсэн сэдвээр мэтгэлцэж болно.
Эсвэл 3 цомхон бүлэгт хуваагдан тус бүр нэгэн нөхцлийг сонгон авч юу хийх талаар шийдсэний дараа бусад бүлгийн хүмүүстэй өөрсдийн сонгон авсан нөхцөл байдлаа, мөн ямар шийдвэр гаргах тухайгаа ярилцана.

талаар хэвлэл мэдээллийнхэнд мэдэгдэж чадахгүй, харин засгийн газрын албаны хүнд л шоронд юу үзэж харснаа мэдэгдсэн " гэлээ. Алга болсон 60 гаруй босогчдын талаар Маоистууд засгын газраас ард иргэдэд мэдэгдэл хийхийг шаардаж байгаа тухай мэдээлэл байгаа эсэхийг асуухад, Бовэй ОУУЗХ—нд "мэдээлэл байж болох юм" хэмээгээд энэ талаар хэвлэл мэдээлэлийнхэнтэй ярилцахгүй гэдгээ дахин илэрхийллээ.

Эх сурвалж: Nepalnews.com—ын Катманду Пост, 2003—03—23

ОУУЗХ—ны хувьд зан үйлийн хатуу хууль тогтоомжийг чандлан сахих нь хэцүү. Учир нь шоронд хоригдлуудыг эргэж очих, дайтагч хоёр талын хооронд төвийг сахин зуучлах гэх мэт мэдрэмтгий үүрэг гүйцэтгэдэгт оршино.

**Боломжит асуултууд:**

➤ Хүмүүнлэгийн ажилчид хохирогчидтой холбогдоход нууцыг хадгалах зарчим хэрхэн тус болж болох вэ?

➤ Энэ нь төвийг сахих болон шударга байх зарчимтай ямар холбоотой байна вэ?

**Хаалт**

Төвийг сахих, шударга байх, бие даасан болон нууц хадгалах зарчмыг бүгдэд харагдах газар бичнэ. Сурагчид эдгээр зарчмууд нь тэдний гаргасан шийпвэрт хэрхэн үйлчилж буйг ярилцана.

➤ Яагаад хүмүүнлэгийн үйл ажиллагаанд шударга байх болон төвийг сахисан байдал шаардлагатай байдаг вэ?
[Төвийг сахиснаар хүмүүнлэгийн ажилчид дайны талбарт мөргөлдөөний аль аль талын хохирогчдод туслах бололцоотой юм. Шударга байснаар хохирогчдод зөвхөн тэдний шаардлага хэрэгцээний дагуу үйлчилнэ.]

**ГОЛ САНААНУУД**

◆ Хүмүүнлэгийн байгууллагуудад зан үйлийн зарим төрөлжсөн хууль дүрэм шаардлагатай байдаг.

◆ Хүмүүнлэгийн ажилтан мөргөлдөгч талуудын итгэлийг олж авахын тулд төвийг сахиж, шударга ёсыг эрхэмлэх ёстой.

◆ Хүмүүнлэгийн ажилтнууд ажиллаж байх үедээ ёс зүйн дилемматай тулгардаг. Хэдийгээр хамгийн оновчтой хариулт, шийдвэр олдохгүй байж болох авч, юу ч хийхгүй байна гэдэг бас л үр дагавартай шийдвэр гэдгийг ойлгох нь чухал юм.

Жич: Сурагчид магадгүй зарим нөхцөл нь "ялалт гэж байхгүй" гэж үзэж болох юм. (Энэ нь ямар ч шийдвэр гаргасан шийдвэртээ сэтгэл хангалуун бус байгааг хэлж байна) Гэсэн хэдий ч хүмүүнлэгийн ажилчид сонголт хийхээс зайлсхийх боломжгүй. Юу ч хийхгүй байх нь бас л ямар нэгэн сонголт хийсэнтэй адил юм.

## Нэмэлт дасгал

**Эргэн тойронд үйлчилж буй шударга байх ба төвийг сахисан байдал**

Төвийг сахих зарчим өдөр тутмын амьдралд хэрхэн өөрөөр хэрэгжиж байгаа тухай ярилцана. (Ихэнх тохиолдолд бид аль нэг талыг барих хэрэгтэй болдог. Хүмүүсийн улс төрд оролцох оролцоог төвийг сахисан байдалтай үл нийцэх талаар бодож үз.)

Түүх, шашин буюу уран зохиолоос төвийг сахисан болон үл сахисан байдлын талаар өгүүлэл олно.

Эсвэл удирдлага, эрх мэдэлтэн зарим хүмүүстэй харьцахдаа шударга байх зарчмыг эрхэмлэхгүй байхад бид яагаад уурладаг талаар эссе бичнэ.

**Хэрвээ та – байсан бол – дилемма**

Та өөрийгөө эдгээр нөхцөл байдлын дунд ажиллаж буй хүмүүнлэгийн ажилтан хэмээн төсөөл.

Цомхон бүлэг болон хуваагдаж доорх нөхцөл байдлын нэгийг дүрд тоглон жүжигчлэн үзүүлнэ:

- Ямар нэгэн асуудал тулгарсан үед хэрхэн шийдвэрлэх талаарх маргаан
- Чиний гаргасан шийдвэрийг шүүмжлэн хэлэлцэх хэвлэлийн ярилцлага
- Сэтгэл хангалуун бус байгаа дүрвэгсэд болон хамтран ажиллагсдын санал гомдолд хариу өгөх

**Нэг ангид сурагчид тусламж үзүүлэх ажилтан дүрвэгсдийн хоргодох газрын хаалган дээр байна гэж төсөөлөн жүжигчилсэн тоглолт хийнэ. Тэрээр орохыг хүсч байгаа боловч дотор байгаа дайснуудаас айж буй нэгэн гэр бүлийн хүмүүстэй тааралдав. Аав нь өвчтэй эхнэр, хүүхдээ хамгаалахын тулд буугаа өөртөө хадгална гэж зүтгэнэ. Мөн энэ гэр бүл салж хагацах вий гэхээс ихэд айж эмээнэ.**

**Энэхүү үзэгдлийг тоглож дууссаны дараа энэ нөхцөлд тусламж үзүүлэх ажилтан ямар зарчмыг бодолцох хэрэгтэй болсон ба зарчмууд хоорондоо зөрчилдсөн эсэх талаар ярилцана.**

# Хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах зарчмууд

**Нөхцөл байдал бүрт: Хэрвээ та хүмүүнлэгийн ажилтан байсан бол ямар хариулт өгөх байсан бэ? Хариулт бүрт өгөх зарчмыг тайлбарлана.**



1. Ган гачиг болон удаан хугацааны дайны улмаас өлсгөлөнд нэрвэгдсэн бүс нутаг. Хүмүүнлэгийн агентлаг нь мал аж ахуй эрхлэн аж төрөх эдгээр нүүдэлчдэд зориулж мал эмнэлгийн төсөл боловсруулав. Овгийн хүмүүс хүмүүнлэгийн ажилчдад үргэлж "Та нар өөр овгийнхон дээр очиж болохгүй ээ, тэд бидний дайсан. Та нар тэдэнд туслах гэж байгаа бол бидэнд яаж тусалж болох билээ" хэмээн хэлдэг.

2. Нэгэн бослого гаргагч маш хүнд шархдан эмнэлэгт ирж эмчлүүлж байна. Дараа нь арай гайгүй шархадсан засгийн газрын 2 цэрэг эмнэлэгт мөн хүргэгдэн ирлээ. Эмнэлгийн ажилчид босогчийг эмчилж байх үед цэргүүд эсэргүүцэл үзүүлэн "Хэрвээ та нар биднийг хүлээлгэн тэдэнд тусалж байгаа бол тэдний талд орж байна гэсэн үг. Та нар тэр юу хийснийг мэдэхгүй байгаа юм уу? Бид та нарыг төвийг сахигчид гэж бодож байсан юм" гэлээ.



3. Зэвсэгт мөргөлдөөний үеэр орон нутгийн нэгэн хүмүүнлэгийн байгууллага дайнд нэрвэгдсэн улсын Хойд хэсэг рүү нүүлгэн шилжүүлэгдсэн олон мянган хүмүүст туслахаар санхүүжилт хайж байна. Гэтэл нэр хүндтэй олон улсын бизнесийн төлөөлөгч өөрийн үйлдвэрлэл эрхэлж буй хэсэг болох Өмнөдөд амьдарч буй хүмүүст тусламж үзүүлэхийг хүссэн бөгөөд энэ нь өөрийнх нь үйлдвэрийн ажилчид урьдын адилаар ажлаа хийж байх үүднээс хямралаас сэргийлсэн явдал байв. Энэ саналыг хүмүүнлэгийн байгууллага хүлээн авсангүй.

- Энэхүү хүлээн авахгүй байр суурийг дэмжин юу хэлэх вэ?

# Хэвлэлийн хуудас

**Зорилго:** дэлхий дахинд хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн үйл ажиллагааг мэдэж авах

1. Юу болж байна вэ?

➤ Олон улсын хүмүүнлэгийн байгууллага юу хийж байгаа талаар хэвлэл мэдээллийн нийтлэлээс олж авна.

➤ Дэлхийн аль нэг хэсэгт явуулж буй үйл ажиллагааных нь талаар мэдэх хүсэлтэй байгаа тухайгаа бичнэ (эсвэл Вебсайтнаас нь энэ тухай мэдээллийг авч болно).

➤ Өөрийн судалсан хөтөлбөр болон байгууллагыг жагсааж бичнэ. Тус бүрийнх нь үйл ажиллагааны талаар товч бич.

2. Хүмүүнлэгийн ажилчид ямар дилемматай тулгарч байна вэ?

➤ Өөрийн судалгаагаар буюу сонин сэтгүүлээс олж авсан мэдээнд байгаа хүмүүнлэгийн үйл ажиллагаан дахь дилеммаг тодорхойлно.

➤ Үүндээ анализ хийнэ.

Сонголт: Ямар хариу үйлдэл хийх боломжтой вэ?
Үр дүн: Үйлдэл тус бүрийн боломжит үр дүн юу вэ?
(төлөвлөгдсөн/төлөвлөгдөөгүй, эерэг/сөрөг, богино/урт хугацааны)
Хэтийн төлөв: Бусад хүмүүс энэхүү нөхцөл байдал болон хариу үйлдлийн сонголтын талаар юу гэж үзэж байна вэ?
Шийдвэр: Хүмүүнлэгийн байгууллага болон ажилчдад ямар зүйл хийхийг санал болгож байна вэ?

**Үнэлгээний аргууд:**

- Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:

*"Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь"* хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх бололцоог олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

- Сурагчдын ажлын хавтас:

Энэхүү бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

- Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

5—р бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20—30 минут), эсвэл 2—3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно. (25 минут)

   - Хүмүүнлэгийн ажилчдад тулгардаг зарим дилемма юу вэ? Тодорхой жишээнүүд дурдана уу.

   - Шударга байх болон төвийг сахих зарчмуудын утгыг тайлбарлаад тус бүрийн жишээ дурдана уу.

2. Товч хариулах асуултууд: Хоёр асуулт сонгоно. (тус бүр 10 минут)

   - Дайны улмаас салсан гэр бүлийг холбоход шаардлагатай 4 алхмыг тодорхойл.

   - Дайн амьдралын ердийн хангамжийг үгүй болгодон 5 арга замыг дурдана уу.

   - Хүмүүнлэгийн ажилчид нүүлгэн шилжүүлэгдсэн хүн амд хоргодох байр төлөвлөхөд хэрэгтэй 3 зүйлийг дурдана уу.

Сурагчдыг бичил бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

**Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:**

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- үзэл санаагаа бататгах тодорхой бодитой жишээ гаргах
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

**Дүрвэгсэд:**

- Дүрвэгч (Амнести Интернейшнл)
  http://www.refuge.amnesty.org/htm/home.htm

- НҮБ—ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан Дээд Комисс
  http://www.unhcr.ch/

- АНУ—ын Дүрвэгсдийн Хороо
  http://www.refugees.org/

**Хүмүүнлэгийн тусламж**

- Хил хязгааргүй Эмч нар
  http://www.doctorswithoutborders.org/

- Хүмүүнлэгийн ёс болон Дайны Төсөл
  http://www.brown.edu/Departments/Watson_Institute/H_W/mission.html

- Интеракц (Олон улсын Сайн дурын Үйл ажиллагааны Америк Консул)
  http://www.interaction.org/index.html

- Олон Улсын Улаан Загалмайн Хороо
  http://www.icrc.org/eng

  Англи, Франц, Испани хэл дээр

**Дайны болон улс төрийн хоригдлууд**

- Дайны Хоригдлуудтай хэрхэн Харьцахтай холбоотой Женевийн Конвенци
  http://www.icrc.org/ihl

  Англи, Франц, Испани хэл дээр

- Ор сураггүй алга бологсдын Төсөл (Аргентин)

  http://www.desaparecidos.org/arg/eng.html

  Англи, Испани хэл дээр



Photo: Jonathan O'Hanlon

# Дүгнэлт Судалгаа

## Цаашид юу хийх хэрэгтэй вэ?

***(1 Бэлтгэл хичээл, төлөвлөлт төслийн хугацаа, үнэлгээний хурал)***

***Хүний нэр хүндийг эрхэмлэн дээдлэх явдлыг та хэрхэн түгээн дэлгэрүүлж чадах вэ?***

***Өөрчлөлт гаргахын тулд та юу хийж чадах вэ?***

***Бусдын мэдлэгийг та хэрхэн дээшлүүлж чадах вэ?***

### СУДАЛГААНУУД:

Цаашид юу хийх хэрэгтэй вэ?....................................................303

### ОЙЛГОЛТУУД:

Залуучуудыг дайчлах нь
Зорилтот хүн ам
Төслийн зорилго
Нийгмийн хүчин чадал ба баялаг
Хүний нэр хүнд

### ДАДЛАГАЖИХ УР ЧАДВАРУУД:

Асуудлыг тодорхойлох
Хэрэгцээг тодорхойлох
Үйл ажиллагааг төлөвлөх
Тэмдэглэл хөтлөх
Төслийг үнэлэх

# Дүгнэлт судалгаа: Цаашид юу хийх хэрэгтэй вэ?

Сургалтыг тогтвортой хөгжүүлж, дэмжих зөв зүйтэй аргуудын нэг бол сурагчдад сурч авсан ухагдахуун, зан үйлээ бодит амьдрал дээр хэрэгжүүлэх боломж олгох явдал юм. Сурагчид бусдад хичээл зааж, хамтран материалаа боловсруулан төслөөс мэдэж авсан бүхнээ хэрэгжүүлэх явцад агуулгыг өөрийн болгодог.

"Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийг үзэж буй сурагчид энэхүү төслийг өөрийн гэр бүл, найз нөхөд, улмаар олон нийтэд дэлгэрүүлж болно. Сурагчид балчир хүүхдүүдэд болон бусдад өөрсдийн сурсан мэдсэнээ зааж сургах, аль эсвэл эмзэг бүлгийнхэнд туслах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож болох юм. Иймэрхүү үйл ажиллагаа нь анхан шатны боловсрол эзэмшиж байгаа болон эзэмшиж амжаагүй хүүхдүүдэд энэхүү төслийг ойлгуулахад тус дөхөм болно. Сурагчид өөр бусад хэлбэрээр хүмүүнлэгийн үзэл санааг дэлгэрүүлж хөхиүлэн дэмжинэ.

**Зорилго:**

- Хүний нэр хүндийг түгээн дэлгэрүүлэх төслийн төлөвлөлтийн талаар сурсан мэдлэгээсээ амьдралд хэрэгжүүлэх
- Хүний нэр хүндийг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий төсөл хэрэгжүүлэх



**Ашиглах материалууд**

- Дүрс бичлэг ба тайлбар: Жүжигчилсэн тоглолтоор дайныг судлах нь.

**Хамт олны үйл ажиллагааны төрлүүд**

Сурагчид төслийг дараах байдлаар боловсруулна. Үүнд:

- бусдад Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг (ОУХЭЗ) зааж ойлгуулах
- тэдний амьдарч буй газрын хүмүүнлэгийн тодорхой хэрэгцээг авч үзэх
- улс төр, хуулийн судалгаа хийх үйл ажиллагаа явуулснаар ОУХЭЗ—г хөхиүлэн дэмжих

ТӨСЛИЙН САНААНУУД:

А. Хүүхэд залуучуудад ба/буюу олон нийтийн бусад бүлэгт хүрч очиж ажиллах (өгүүлэгийн ном, хошин шог сэтгүүл, богино хэмжээний жүжигчилсэн тоглолт, үзэсгэлэн, танилцуулга, жүжиг, хэвлэл мэдээллийнхэнд захиа илгээх, радио нэвтрүүлэгт оролцох, гарын авлага хийх гэх мэт.)

В. Сайн дурын үйл ажиллагаа
(гэр оронгүй хүмүүс, дүрвэгсэд, шилжин нүүсэн хүмүүс, өнчин, өвчтэй хүмүүс болон хөгшдөд туслах гэх мэт.)

С. Судалгааны ажлаас практик ажиллагаанд
(ОУХЭЗ—н хэрэгжилтийн талаар буюу үндэсний түвшинд ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг ямар арга хэмжээ авч байгаа эсэхийг судлах, эсвэл хүмүүнлэгийн болон хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагад орох, гэх мэт.)

**Хэрэгжиж болохуйц төсөлд үнэлгээ өгөх асуултууд:**

- Уг төсөл нь сурагчдад сэдэвтээ хувийн үзэл бодлоор холбогдох боломж олгож байна уу?
- Уг төсөл нь ОУХЭЗ—н зорилгыг дэмжих үйл ажиллагааны мөн чанарыг сурагчдад эргэцүүлэн бодох боломж олгож байна уу?
- Сурагчид ОУХЭЗ—н талаарх мэдлээ тэлэхэд төсөл хүч нэмж өгч байна уу?

**Эхнээс нь эцэс хүртэл**

1. Төсөл төлөвлөх

Энэхүү төслийг хэний төлөө боловсруулах вэ?
Төслийн зорилго юу вэ?
Тэдгээр хүмүүсийн төлөө хийж буй ажлын зорилгод хүрэхийн тулд юу хэрэгтэй вэ?

2. Хэрэгжүүлэх

Төлөвлөгөөг биелүүлэхэд тохиолдсон өдөр тутмын үйл явц юу байв?
Бид энэхүү төслийг хэрэгжүүлэхийн тулд юуг тохируулах хэрэгтэй байна вэ? Яагаад?

3. Дүгнэлт хийх

Бидний төслийн үр дүн юу байв?
Хүмүүс хандлага ямар байна вэ?
Энэ төсөл хэрэгжүүлснээр надад ямар өөрчлөлт гарав?
Би одоо юу хийх вэ?

Бичиж тэмдэглэх, хэлэлцэн ярилцах зэрэг хэлбэрээр үйл явцыг албаны болгох нь сурагчдад аливаа нэг зүйлийг амжилттай хийж дуусгах сэтгэлгээг төрүүлэхэд тус нэмэр болж өгнө.

**Олон нийттэй ажиллахын тулд бэлтгэл хийх**

Хамгийн эхний чухал алхам бол зорилтот олон нийтийн төсөлтэй холбоотой ач холбогдлыг ойлгох явдал юм. Дараах материал нь ялангуяа сайн дурынхны төсөлтэй холбоотой. Гэвч төслийн цаад санаа нь хүрч очих ажил буюу судалгаанаас—үйл ажиллагаа—руу төрлийн төслийн төлөвлөлтөд хэрэглэгдэж болох юм.

Сайн дурынхны төслийг эхлүүлэхээс өмнө сурагчид зорилтот олон нийтийн давуу тал болон сул талыг мэдэж авах хэрэгтэй. Зарим хүмүүс эмзэг бүлгийнх болоод тусламж дэмжлэг хэрэгтэй байсан ч тэдний хэрэгцээг хангах үүднээс чадвар, боломжийг нь аль болох судалж, төсөлдөө татан оруулах нь зүйтэй. Сурагчид үнэхээр олон нийтийн тухай мэдээллийг олж цуглуулах боломжгүй байж болно. Хамгийн гол нь тэдгээр хүмүүст туслахдаа тэдэнтэй ярилцаж зөвшилцөн хамтран ажиллах нь чухал. Олон Улсын Улаан Загалмай Улаан Хавирган Сар Хөдөлгөөн олон нийттэй ажиллахад шаардлагатай үндсэн 4 алхмыг гаргаж ирсэн. Үүнд:

1. Олон нийтийн давуу талыг тодорхойлохын тулд хүмүүстэй хамтарч ажилла.
2. Тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлага болон аюулыг тодорхойлохдоо хамтарч ажилла.
3. Хэнд тусламж, дэмжлэг хамгийн их хэрэгтэй байгааг болон өгөгдсөн ур чадвар, эх сурвалжаа бодолцож үзвэл хэнд нь эн тэргүүнд тусламж үзүүлэх хэрэгтэйг олж тогтоо.
4. Хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулахын тулд олон нийттэй хамтарч ажилла.

— Олон Улсын Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдий Холбоо,
"Хэрэгцээнээс Үйл Ажиллагаа руу"—аас иш татав, 1995 он

Сурагчид хэрэгжүүлэх төслөө бодолцохдоо олон нийтийн оролцоо, тэдний оруулах хувь нэмэр, эх сурвалжыг хэрхэн багтаан хамруулах талаар бодох хэрэгтэй.

**ГОЛ САНААНУУД**

- Хүний нэр хүндийг идэвхтэй дэмжихийн төлөө хийгдэх ажил олон байгаа бөгөөд ур чадвар, сонирхолдоо тохирсон төсөлд оролцох боломжтой юм.
- Бусдын нэрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэх үед тэдний байр суурийг харгалзаж үзэх нь чухал байдаг.
- Төсөл хэрэгжих явцад тогтмол хугацаанд үр дүнд үнэлгээ өгөх, ирээдүйн төлөвлөгөө тоймлон гаргах нь тустай байдаг.

## Нэмэлт дасгал

Жүжигчилсэн тоглолтоор дамжуулан хүрч очиж ажиллах

Хойд Ирландын драмын бүлгийн залуучууд зэвсэгт мөргөлдөөний үед зовж шаналж буй хохирогчдын тухай үзүүлсэн "Жүжигчилсэн тоглолтоор дамжуулан дайныг судлах нь" дүрс бичлэгийг үзнэ. Эдгээр залуучууд хамт ажиллаж эхлээд хэдхэн жил болж байгаа ч, тэдний энэхүү жүжиг нь сурагчдыг өөрсдийн жүжигчилсэн тоглолт хийхэд урам зориг, шинэ санаа өгөх болов уу.



Үүний дараа "Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь" хичээлээс жүжигчлэн үзүүлэх  сонирхолтой байгаа сэдвээ сонгож авна. Бусад сурагчидтай хамтран өөрсдийн жүжгийн үзэгдлээ зохионо.

Үзэгчдээ (сургууль буюу шашны болон олон нийтийн байгууллага гэх мэт) ямар байхыг дотроо төсөөлөн тоглолтын үзэгдлээ төлөвлөнө.



# Жүжигчилсэн тоглолтоор дамжуулан дайныг судлах нь

Хүү: Афганистан
Охин: Сомали
Хүү: Чечень
Охин: Рванда
Охин: Сьерра Леоне
Охин: Шриланк
Охин: Уганда
Охин: Өмнөд Африк
Хүү: Колумб
Охин: Израйль
Хүү: Хойд Ирланд
Хүү: Зүүн, зүүн, зүүн, зүүн,
Хүү: Зогс. Баруун тийш эргэ.
Охин: Тэд намайг гэрээс минь явахад хүргэсэн.
Хүү: Тэд намайг гэр бүлээс минь хагацахад хүргэсэн.
Охин: Тэд намайг улс орноо орхин явахад хүргэсэн.
Бүлгийн гишүүд дараагаар нь нэгэн охин гэр бүл нь 24 цагийн дотор гэрээсээ явах болсон өдрийн тухайгаа дурсан санаж байгааг жүжиглэн үзүүлнэ. Эхнэр нь нөхрөө энэ бүх явдалд буруутган гэр бүлээ нүүлгэн шилжүүлэхэд хүргэсэн буруу юм хэлсэн гэх боловч нөхөр нь эсэргүүцэл үзүүлж байна. Харин тэд охиндоо богино хугацаагаар амралтаар явах болсон гэж хэлнэ.
Энэ зуур охин, бяцхан охин байсан үеийн явдлуудаа эргэн дурсана. Охин хамгийн сайн найзаа орхиж явах болсон тухайгаа, мөн *Малибу барби* хүүхэлдэйгээрээ тоглож амжаагүй байсан болон *Бананас* хэмээн нэрлэгдэх нэгэн онцгой газар төрсөн өдрөө тэмдэглэх гэж байсан тухайгаа дурсана.
Харин 18 настай хүү нь гэрийнхэнтэйгээ дүрвэн явахыг хүсэхгүй бөгөөд энэ бүх сүйрлийг аавынхаа буруу гэж үзнэ.

[Энэ үзэгдлийн дараа найрал дуу үргэлжилнэ.]

Охин: Би 72 настай, Чеченээс ирсэн эмэгтэй
Охин: Өмнөд Африк
Охин: Сомали
Хүү: Афганистан
Охин: Израйль
Охин: Хойд Ирланд
Охин: Ирак
Охин: Энэ бол миний нөхөр, харин энэ бол үеэс үед уламжлан өвлөгдөж ирсэн гэр маань байна.
[Цэргүүдийн байшин барилгыг сүйтгэж, оршин суугчдыг нь зодож байгаа дуу чимээ гарна.]
Охин: Би 72 настай, Чеченээс ирсэн эмэгтэй [уйлна]
Охин: Өмнөд Африк
Охин: Сомали
Хүү: Афганистан
Охин: Израйль
Охин: Хойд Ирланд

# Хэвлэлийн хуудас

**Зорилго:** төслөө сонгоход тус болохуйц мэдээллийг цуглуулах
олон нийтээ таньж мэдэхэд тус болохуйц хэвлэл мэдээллийг олж тогтоох
судалгааны мэдээлэлд ашиглаж болох хэвлэл мэдээллийг олж тогтоох

1. Хүний нэр хүнд эрсдэлтэй байх ба та энэ асуудалд оролцохыг хүсч байгаа нөхцөл байдалтай мэдээ, нийтлэл олно.

➤ Нөхцөл байдал ямар байна вэ?

2. Хэрвээ таны олон нийт, нийгэмд энэхүү нөхцөл байдал тохиолдсон бол:

➤ Энэ талаар мэдээлэл өгч чадахуйц сонин ба телевизийн сувгийг хайж олно.
➤ Танд мэдээний эх сурвалжууд хэрхэн хэрэг болох арга замуудыг жагсаан бичнэ.

3. Энэ нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал бол:

➤ Энэ талаар судалж байгаа хүмүүсийн жагсаалт, ерөнхий мэдээлэл болон мэдээний эх сурвалжийн хайж олно.
➤ Өөрийн олсон эх сурвалжуудыг жагсаан бичнэ.

**Үнэлгээний аргууд:**

- Одоо хэрэгжүүлж буй үнэлгээ:

"*Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь*" хичээл багш нарт, сурагчдынхаа юу сурч байгааг болон юуг буруу ойлгож байгаа талаар өдөр тутам мэдэх боломж олгодог. Анги доторх хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг, дүрд тоглох зэрэг сургалтын эрчимтэй арга барилууд нь дээрх боломцоог олгодог байна.

Хичээлийн сүүлийн 5 минутад сурагчдаар "Өнөөдөр би юу олж мэдэв?", "Надад ямар асуулт байна вэ?" гэсэн асуултын дагуу ганц, хоёр өгүүлбэр бичүүлнэ. Хариултуудыг уншиж, буруу ойлголтуудыг дараагийн хичээлээс өмнө залруулан сурагчдын мэдлэгийг бэхжүүлэхэд ашиглана.

- Сурагчдын ажлын хавтас:

Энэхүү бүлгийн турш, сурагчдад хүмүүсээс ярилцлага авах, ямар нэг асуудалд тодорхой байр сууринаас хандах, түүнийгээ баримт жишээгээр хамгаалах, ойлголт, ухагдахуунуудыг шүлэг зохиол буюу урлагийн бүтээл зэргийг ашиглан илэрхийлэх, мөн түүнчлэн тодорхой сэдвээр судалгааны материал бичих зэрэг олон үүрэг даалгаврууд оногдсон билээ.

Сурагч бүрт тус тусад нь тусгай хавтас нээж, тэдний хичээлд нэмэрлэсэн бичгийн ажил, төсөл ноорог, ярилцлага, цуглуулсан мэдээлэл зэргийг нь нэгтгээд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай тэдний ойлголтонд ямар дэвшил гарч байгааг хянахын тулд тухайн сурагчтай хамтран уг хавтаст байгаа ажлуудыг тодорхой хугацааны дараа эргэн харж, дүгнэх хэрэгтэй.

Сурагчдын хийсэн ажлыг ханын самбарт өлгөж тавина уу

- Бүлэг бүрийн төгсгөлийн асуултууд:

Бүлгийг судалж дуусгаад, сурагчид юу сурсан талаараа бичгээр үнэлгээ хийх ажилд сүүлийн хичээлээ зориулж болно. Үүнийг, эссэ бичүүлэх (20—30 минут), эсвэл 2—3 товчхон асуулт тавих (тус бүр 10 минут) замаар хийж болно.

1. Эссэ бичих асуултууд: Нэгийг сонгоно.

   - Ямар талаар төслийн зорилгодоо хүрч чадсан гэж бодож байна вэ? Дараагийн удаа юуг өөрөөр хийх вэ? Төслийн зорилгоо цааш нь үргэлжлүүлэх ямар алхмууд байна вэ?
   - Энэхүү туршлагаас хүмүүнлэгийн эрх зүй, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, олон нийтийн давуу тал, эх сурвалж болон өөрийнхөө талаар юу сурч авсан бэ?
   - Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой үйл ажиллагаа, судалгааны талаарх хэвлэл мэдээллээс юу сурч авсан бэ?

2. Товч хариулах асуултууд:

Сурагчдыг бичил бүлгүүдэд хуваан бүлэг бүрт асуулт бэлтгэх даалгавар өгч, тэдгээрийн аль нэгийг сонгон ангийн нийт сурагчдаар бичүүлэх эссэний асуулт болгож болох юм. Эсвэл сурагч бүр нэг нэг асуулт санал болгоод түүнийгээ тестээр хариулж бас болно. Энэ тохиолдолд сурагч өгсөн хариулт болон асуултынхаа чанараар үнэлэгдэнэ. Мөн ямар нэгэн сонины өгүүлэл болон аль нэгэн материалын хэсгээс иш татаж болно. Сурагчдаар энэ асуудлын гол санааг тодорхойлуулж, санал нийлж байгаа эсэхийг нь асууна уу.

**Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:**

Идэвхтэй сурагчийн хариултанд дараах зүйлс ажиглагдана:

- хөндлөнгөөс ажиглагч, байлдагч, диллема, гинжин нөлөө болон бусад ойлголт, ухагдахуунуудыг материалдаа ашигласан байх
- хэвлэл мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг болон хичээлээс гадуур уншиж мэдсэн зүйлс зэрэг олон янзын эх сурвалжаас жишээ татсан байх

Дээрх аргачлалууд нь "Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлийн материалууд дээр хийсэн сурагчдын ажлыг үнэлэх үнэлгээнд тус нэмэр болох үүднээс зөвхөн санал болгож буй арга барилууд юм. Багш нар та бүхэн, эдгээр шаардлагуудыг өөрсдийн хэрэгцээндээ чөлөөтэй нийцүүлэн хэрэглэж болно.

### Үйл ажиллагааны төслүүд

- **ЮНИСЕФ Залуучуудын дуу хоолой:** Дэлхийн олон хүүхэд залуучууд өөрсдийн оролцож буй төслийн талаар бичсэн байгаа.

  http://www.unicef.org/young

### Олон нийтийн үйлчилгээний төслүүд

Хэрвээ та өөрийн олон нийт, нийгэмд үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх хүсэлтэй бөгөөд веб хуудаснаас ямар нэгэн санаа оноо, боломж хайхыг хүсч байгаа бол, Үндэсний Улаан Загалмай Нийгэмлэг болон бусад сайн дурын байгууллагуудын вебсайтуудыг шалгаарай.

### Судалгаа буюу хэвлэн нийтлүүлэх төслүүд

"Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь" хичээлд үзсэн аль нэг сэдвээр судалгаа буюу хэвлэн нийтлүүлэх төсөл хийх хүсэлтэй байгаа бол, бүлэг бүрийн төгсгөлд дурдсан энэ сэдэвтэй холбоотой Вебсайтын жагсаалтыг үзнэ үү. Сүүлийн үеийн үйл явдлын талаар доорх 2 вебсайтнаас харж болно. Үүнд:

http://www.oneworld.org

Та энэхүү вебсайтнаас дэлхийн өнцөг булан бүрээс цуглуулсан өнөөгийн болон архивын нийтлэлүүдийн талаар арвин их мэдээллийг доорх хэл дээр уншиж болно. Үүнд: Англи, Голланд, Финланд, Герман, Норвеги, Испани болон Швед

http://www.un.org/cyberschoolbus

Энэхүү вебсайтнаас та хүний нэр хүндтэй холбоотой хүүхэд залуучуудад зориулсан янз бүрийн товч мэдээлэл, хураангуйг доорх хэл дээр авч болно. Үүнд: Араб, Хятад, Англи, Франц, Орос болон Испани